

Улсын бүртгэлийн
дугаар

Аравтын бүрэн
Ангиллын код

Нууцын зэрэглэл:
Б

Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар : ШуУз 2020/07

БАТЛАН ХАМГААЛАХЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХАД “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН
БОДЛОГЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Захиалгат төслийн тайлан
2020-2022

Төслийн удирдагч:

О.Үржин - БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор

Төслийн зөвлөх:

Д.Уламбаяр - ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал, доктор, профессор,

Төслийн гүйцэтгэгч:

Б.Эрдэнэчимэг - БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, доктор (Ph.D), профессор,
Д.Энх-Амгалан - ҮБХИС-ийн Цэргийн дээд сургуулийн сургалтын албаны арга зүйч, доктор (Ph.D),

О.Машбат - ТЕГ-ын Аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал, докторант,

Л.Бямбаханд - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант

Санхүүжүүлэгч байгууллага:

БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

БХЯ-ны ШУТЗ
БШУЯ-ны ШУТБИХХЗГ

Тайлан өмчлөгч:

Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн. 13300
Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо,
Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран.
Утас: 453942, Факс-70150173, Цахим хаяг:
<http://www.mids.gov.mn>; mids@mndu.gov.mn

Улаанбаатар. 2023 он

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ БОЛОН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ҮНДЭС БА МОНГОЛ УЛС	
1.1 Аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйн үндэс	15
1.2 Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс	35
1.3 Аюулгүй байдлын орчны үнэлгээний арга зүйн үндэс	47
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН БОДЛОГЫН ОНОЛ, ПРАКТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭ	
2.1 Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, практик	57
2.2 Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: хоёр хөршийн судлаачдын судалгаа, дүн шинжилгээ.....	92
ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧИН, “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН ХАРИЛЦАА, ХЭТИЙН ТӨЛӨВ	
3.1 Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хэтийн төлөв	111
3.2 Их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын хэтийн төлөв дэх Монгол Улсын аюулгүй байдлын болзошгүй хэтийн төлөв.....	123
3.3 Монгол Улс, Япон Улсын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв.....	138
3.5 Монгол, БНСУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв.....	163
3.6 Монгол, Энэтхэг улсын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв.....	184
3.7 Монгол, БНТУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв	199
ЗӨВЛӨМЖ	212

УДИРТГАЛ

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ, шаардлага:

Аюулгүй байдал нь хүн төрөлхтний үйл ажиллагаагаар үүссэн аюулаас хүмүүс ба хүрээлэн буй орчны хамгаалагдсан байдлын тухай мэдлэгийн систем бөгөөд бие даасан шинжлэх ухааны салбар ухаан байх ёстой гэдэг дүгнэлтэд улс орнууд хүрч байна. Энэ ололтын үр дүнд аюулгүй байдлын янз бүрийн чиглэлийг хамарсан түвэгтэй цогц асуудал, тухайлбал “гуравдагч хөрш”-ийн бодлого, салбар дундын судалгааны сэдэв болох талаар тодорхой ойлголт бий болсон боловч олон тооны хэлэлцүүлэг, нийтлэл, судалгааны тайлан, ном бүтээлээс харахад аюулгүй байдлын ерөнхий болон үндэсний аюулгүй байдлын системийн хүрээнд дэх ерөнхий асуудлын шинжилгээ, түүний онолын загварын байгуулалт, практик зохицуулалтын тодорхой үүргийн томъёололд зааг ялгаа үүссэн байна. Шинжлэх ухааны хэлэлцүүлэгт олон салбарын төлөөлөл оролцож байгаа үед ихэвчлэн аюулгүй байдлын ойлголт-категорийн аппаратын томъёолол болон онотолог¹ шинжтэй хамгийн ерөнхий тулгамдсан асуудал орхигдох нөхцөл байдал бий болсон. Тиймээс ч аюулгүй байдлын загварыг байгуулах санал болгож байгаа хувилбар нь голдуу эмпирик өгөгдлүүд дээр тулгуурлаж байгаа бөгөөд өөртөө онолын мэдлэгээр дутмаг прагматик бүтцийг агуулж байна.

Аливаа асуудлыг, түүнчлэн “гуравдагч хөрш”-ийн бодлогыг боловсруулахад эхний ээлжинд гүнзгий судалсан, шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын суурь бааз шаардлагатай байдаг. Зөвхөн онолын үндэслэлтэй тодорхойлолт л аливаа асуудалд харилцан ойлголцол болон нэгдсэн хандлага бий болгодог.

Өнөө үед манай улсад эрдэмтэн судлаачид өөр өөрсдийн хүрээнд аюулгүй байдал, “гуравдагч хөрш”-ийн сэдэвтэй ном бүтээл бичиж хэвлүүлж ирсэн боловч аюулгүй байдал, түүнийг хангах талаарх мэдлэгийн систем бүрэн бүрэлдээгүйн улмаас үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд алдаатай томъёолол, ойлголтууд орж, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл явцыг системийн хандлагаар авч үзэх, үнэлэхэд саад болж байна. Тухайлбал, “аюулгүй байдал” гэсэн хамгийн ерөнхий суурь ойлголтын талаар янз бүрийн томъёолол бий болж, цэгцрээгүйтэй холбоотойгоор үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “үндэсний аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал” гэсэн анхдагч чухал суурь ойлголтыг агуулгын алдаатай томъёолоход хүргэсэн байдаг.

Хэдийгээр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд *“Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.”*, *“Болзоишгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна”*, *“Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байна.”*, үндэсний аюулгүй байдлын тухай хуульд *“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл залгамж чанарын үндэс болно.”* гэх зэргээр аюулгүй байдал судлалын системийн хандлагын арга зүйг илэрхийлсэн зарчим, заалтууд тодорхойлогдсон боловч “гуравдагч хөрш”-ийн бодлого, түүний хэрэгжилтэд мөрдөгдөхгүй явж ирсэн.

¹ Онотолог нь танин мэдэхүйн онол ба логиктой нэгдмэл оршин буй ахуйн ерөнхий категорууд болон зүй тогтлуудын тухай философийн сургааль мөн. Онотологийн үндсэн ойлголтууд нь: ахуй, ахуйн бүтэц, шинж чанар, хэлбэр, орон зай, цаг хугацаа, хөдөлгөөн.

Мөн түүнчлэн “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон “Алсын хараа 2050” зэрэг хөгжлийн бодлогыг боловсруулахад холбогдох салбарын мэргэжилтнүүд болон эрдэмтэн судлаачдын хамтарсан ажлын хэсэг томилогдож, өнөөгийн байдлын үнэлгээг богино хугацаанд голдуу эдийн засгийн талаас тоо баримт дээр тулгуурлан гүйцэтгэж, зөвхөн зорилгын хандлагад суурилсан шийдвэр гаргаж ирсэн учир урьдчилсан үнэлгээний судалгааны хандлага, үндэсний аюулгүй байдлыг хангах системийн гадаад, дотоод орчны өнөө, өнгөрсөн, ирээдүй гэсэн логик холбоос бүхий үнэлгээ дутагдаж, стратегийн төлөвлөлтийн үр дүн цогц болж чадахгүй байх нөхцөл бүрдэж байсан.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын асуудлыг аюулгүй байдлын онол, арга зүйн үүднээс судалсан ажил хомс байна. Энэ бүгд нь аюулгүй байдал болон түүний урьдчилсан үнэлгээ хийх онол, арга зүйг хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх”, “Төр иргэний хамтын ажиллагаа”, “Аюулгүй байдлын бодлого цогц байх”, “Мэдлэгт суурилах”, “Бодитой хандах”, “Даяаршлын хүчин зүйлийг харгалзах” зарчмууд дээр тулгуурлан системийн хандлагаар аюулгүй байдлын болон “гуравдагч хөрш”-ийн хэтийн төлөв хандлагыг судалж, төлөвлөлт хийж байх хэрэгцээ, шаардлагыг нөхцөлдүүлж байгаа бөгөөд энэхүү төслийг хэрэгжүүлэх үндэслэл болсон юм.

Судлагдсан байдал:

Судлагдсан байдлыг *нэгд*, аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээтэй холбоо бүхий бүтээлүүд, *хоёрт*, “Гуравдагч хөрш”-ийн талаарх бүтээлүүд гэсэн хоёр чиглэлээр тодорхойллоо. Үүнд:

Нэгд. Аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээтэй холбоо бүхий бүтээлүүд:

1. *Аюулгүй байдлын хэтийн төлөвийн үнэлгээтэй холбоо бүхий гадаад улс орнуудын болон судлаачдын дараах бүтээлүүд байна.* Үүнд:

- АНУ-ын Тагнуулын Үндэсний Хорооны “Даяар хандлагууд 2030: Альтернатив ертөнцүүд” (“Global Trends 2030: Alternative Worlds”) судалгаа².

Энэ судалгаа нь өмнөх хэвлэлүүдийн адил чухал хандлага ба далд аюулуудыг илрүүлэн стратегийн сэтгэлгээнд түлхэц өгөхөд чиглэсэн байна. Судалгааны тайланд байгаа мега хандлагууд дундаас *нэгдүгээрт*, аливаа нөхцөл байдлын хөгжлийн үеийн хамгийн их магадлалтай, *хоёрдугаарт*, үзэгдлүүдийн явцыг гэнэт өөрчлөх чадвартай, *гуравдугаарт*, тэдгээрийн зам нь бусдаас хүндрэлтэй шинжилгээнд авагдах хямралт хувьсагч бүхий хүчин зүйлүүдийг онцлон гаргажээ. Түүнчлэн бүх хүчин зүйлүүдийн олон янз болон ээдрээг ойлгосноор тулгарч болох сценарууд эсвэл альтернатив ертөнцөд онцгой анхаарал хандуулсан байна. Мега хандлагын тоймыг *хүний эрх ба боломжуудын өргөжилт; нөлөөллийн хувиарлалт; хүн ам зүйн загварууд; хүнсний бүтээгдэхүүн, ус ба эрчим хүчний нөөц* гэсэн дөрвөн агуулгаар төсөөлсөн байна.

- ОХУ-ын Москвагийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Цэрэг-улс төрийн судалгааны төвийн хамтлагийн “Гадаад болон батлан хамгаалах бодлогын стратегийн прогнозчилол ба төлөвлөлт” “Стратегическое прогнозирование и планирование внешней и оборонной политики” судалгаа³.

² <https://globaltrends2030.files.wordpress.com/2012/11/global-trends-2030-november2012.pdf>

³ Стратегическое прогнозирование и планирование внешней и оборонной политики: коллективная монография. В 2 т. / [А.И. Подберезкин и др.]; МГИМО (У) МИД России, Центр военно-политических

Судалгаа нь Москвагийн олон улсын харилцааны хүрээлэнгийн дэргэдэх цэрэг-улстөрийн судалгааны төвийн хамт олны олон жилийн турш гүйцэтгэж, профессор А.И.Подберезкиний ерөнхий удирдлага дор хэвлэлд бэлтгэж гаргасан 2 боть бүтээл юм. Стратегийн үнэлгээний санал болгож буй арга зүйн логикоор ирээдүйн олон улсын байдал нь: бүх орон нутгийн соёл иргэншилд хамаарах дэлхий нийтийн хөгжлийн даяар хандлагуудаар; орон нутгийн соёл иргэншлийн хөгжлийн хандлагуудаар; даяар хандлагууд болон орон нутгийн соёл иргэншлийн хөгжил дэх хандлагуудын хоорондын харилцан хамаарлуудаар; үндэстнүүдийн эрх ашгууд ба үнэт зүйлсүүд болон дэлхий дэх тэдгээрийн хоорондын харилцаануудаар; улсуудын эрх ашгууд ба дэлхий дэх тэдний хоорондын харилцаануудаар; нийгмийн, бүлэглэлүүдийн болон хувь хүмүүсийн эрх ашгаар тодорхойлогдоно гэж үзсэн байна.

- Дэвид Миллер- “Батлан хамгаалах 2045: Батлан хамгаалах бодлого боловсруулагчдад зориулсан Ирээдүйн аюулгүй байдлын орчны үнэлгээ ба ойлголт” стратеги, олон улс судлалын төвийн судалгааны тайлан (David Miller- “Defense 2045: Assessing the future security environment and implications for Defense Policymakers” CSIS report) ⁴.

Судалгааны тайлан нь АНУ-ын батлан хамгаалах салбарын шийдвэр гаргагчдад зориулж олон улсын аюулгүй байдлын орчныг үнэлэх зорилгоор хийжээ. Тэгэхдээ АНУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй, сүүлийн жилүүдэд боловсруулсан баримт бичгүүд бодит чиг хандлагатай хэрхэн нийцэж буйд дүн шинжилгээ хийсэн байна. Энэхүү судалгаа нь 2045 он хүртэлх аюулгүй байдлын орчныг үнэлэхдээ *нэгд*, хүн ам зүйн байдал; *хоёрт*, эдийн засаг ба үндэсний хүчин чадал; *гуравт*, хүчний тархалт, *дөрөвт*, хөгжиж буй технологиуд, *тавд*, хэлхээ, холбоо, *зургаад*, геополитик гэсэн зургаан үндсэн хүчин зүйл дээр тулгуурласан байна.

- Жорген Рандерс “Даян дэлхийн тухай ирэх дөчин жилийн таамаглал (A Global Forecast for the Next Forty Years) 2052”⁵.

Энэхүү ” бүтээл нь “Үндэслэл”, “Даян дэлхийн тухай миний таамаглал”, “Дүн шинжилгээ” гэсэн гурван хэсэг арван хоёр бүлэгтэй бүтээл юм. 2052 он хүртэлх таамаглалыг: *хүн ам ба хэрэглээ*; *эрчим хүч болон хүлэмжийн хий*; *хоол хүнс ба түүний ул мөр*; *материаллаг бус ирээдүй*; *Zeitgeist буюу мөн чанар ямар байх вэ* зэрэг чиглэлүүдээр дэвшүүлсэн. Энэхүү номонд: Хүн ам зүйн асуудал: НҮБ, Эдийн засаг болон нийгмийн департамент. Хүн ам зүйн хэлтэс. Дэлхийн хүн ам зүйн төлөв: 2010 оны хувилбар. CD-ROM. (<http://esa.un.org/unpd/wpp/Excel-Data/population.htm>;) ДНБ, хэрэглээ, хөрөнгө оруулалт. Олон улсын бүтээмж, орлого, мөн үнэ харьцуулалтын төв, Пенсильванийн их сургууль. 2011 оны 5 сар. (http://pwt.Econ.upenn.edu/php_site/pwt70/pwt70_form.php;) Эрчим хүчний хэрэглээ: Дэлхийн эрчим хүчний Бритиш Петролиум (BP) статистик дүгнэлт, 2011. ([http://www.bp.com/sectionbodycopy.do? categoryId=7500&contentId=706481](http://www.bp.com/sectionbodycopy.do?categoryId=7500&contentId=706481) эсвэл <http://www.bp.com/statisticalreview>;) Хүлэмжийн хийн ялгарал: Эрчим хүч судалгаа, шинжилгээний хүрээлэн, Оак Ридже Ассошиэтэд Их Сургууль, Оак Зидже, Теннесси, АНУ,

исследований МГИМО (У) МИД России; ОАО "Концерн ПВО "Алмаз-Антей". Москва: МГИМО-Университет, 2015. 796 с.

⁴ David Miller- “Defense 2045: Assessing the future security environment and implications for Defense Policymakers” CSIS report

https://espas.secure.europarl.europa.eu/orbis/sites/default/files/generated/document/en/151106_Miller_Defense2045_Web.pdf

⁵ Жорган Рандерс “Даян дэлхийн тухай ирэхдөчин жилийн таамаглал 2052”, 2012., 361 х.

2011. (http://cdiac.ornl.gov/trends/emis/meth_reg.html;) Эрчим хүчний бус экологийн ул мөр: Дэлхийн ул мөрийн сүлжээ, Оакланд, Калифорни, АНУ, 2011. (http://www.footprintnetwork.org/images/uploads/2010_NFA_data_tables.xls) зэрэг олон эх сурвалжууд дээр тулгуурласан байна.

- Параг Ханна “Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАР ЗҮЙ”⁶,

Энэхүү бүтээлийн агуулгын чухлыг “... эдийн засаг, улс төр, технологийн газар зүйг судалсан бөгөөд XXI зууны жинхэнэ зэвсэглэлийн төлөөх тэмцэл нь хотууд болон нийлүүлэлтийн суваг зангилгаа нь болж байгаа “өрсөлдөөнд холболт”-ын төлөө явагдахыг харуулсан байна. Түүний энэ зураглал эдүгээ өрнөж буй геополитик болон даяаршлын хэтийн чиг хандлагын талаарх хэлэлцүүлэг, мэтгэлцээнд баримтлах өөр нэгэн чухал байр суурь юм” гэж McKinsey & Company – ийн ерөнхий захирал Доминик Бартан үнэлэлт өгсөн бол “... Уг ном өргөн цар хүрээг хамрахын хамт нарийн тодорхой мэдээлэл шигтгэжээ. Дэд бүтэц бол хөгжлийн ирээдүй гэсэн санаагаараа Параг Ханна ирээдүй хааш чиглэж буйг ойлгохын тулд энэ номд өгүүлсэн нийлүүлэлтийн сувгийн судсыг дагах хэрэгтэйг сануулжээ” гэж Wired сэтгүүлийн хамтран үүсгэн байгуулагч Кэвин Кэлли онцолсон байна.

- Даниел Вихелнс- “2050 онд ус, хүнсний аюулгүй байдалд хүрэх нь: Хэтийн төлөв, бодлого, хөрөнгө оруулалт” судалгааны өгүүлэл. (Daniel Wichelns- “Achieving Water and Food Security in 2050: Outlook, Policies, and Investments” article.)⁷.

Судалгааны өгүүлэлд бүс нутгуудад хүнс, хоол тэжээлийн хүрэлцээ хэр байхыг өнөөгийн хүнс, хоол тэжээлийн өсөлт дээр тулгуурлан тооцсон байна. Мөн Бүс нутгуудад хүнс, хоол тэжээлийн түвшин жил тутамд хэдий хэмжээгээр нэмэгдэж байгаа дээр тулгуурлан хүнс, хоол тэжээлийн хомсдол аль бүс нутагт түлхүү тулгамдаж болохыг тусгажээ. Тухайлбал, Сахарын цөлөөс урагш байрлах Африкийн орнуудад ядуурлаас шалтгаалсан өлсгөлөн нүүрлэсэн хэвээр байх болно гэсэн. Тэрээр хамгийн өөдрөгөөр харахад 2030 он гэхэд 300 сая хүн нэн ядуу гэсэн ангилалд багтах төлөв харагдаж байна гээд хүнсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг судлан үзээд ядуурал хүнсний хомсдолын гол шалтгаан байна дүгнэсэн.

- Фүүддринк Европ– “2030 оныг хүртэлх хүрээлэн буй орчны тогтвортой байдлын алсын хараа: ололт, сорилт, боломж” (Fooddrink Europe- “Environmental Sustainability Vision Towards 2030: Achievements, challenges and opportunities”)⁸.

Судалгаанд хоол, хүнс үйлдвэрлэл тогтвортой хөгжилд хэрхэн нөлөөлдөг болохыг тусгаад, хоол, хүнс үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэхэд шаардлагатай хүчин зүйлс нь хүнсний тогтвортой нөөц; хүрэлцээтэй байдал; тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл гэж үзсэн. Энэ төрлийн үйлдвэрлэл нь улс орнуудад харилцан адилгүй байгаа нь нэгдсэн нэг шийдлийг олоход хүндрэл учруулж байна гэж дүгнэсэн. Мөн энэ тайланд дурдсанаар тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг хангахад нийгмийн бүхий л түвшнийхний оролцоо

⁶ Параг Ханна “Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАР ЗҮЙ”. УБ., 2018, 427 х.

⁷ Daniel Wichelns- “Achieving Water and Food Security in 2050: Outlook, Policies, and Investments” article. P.O. Box 2629, Bloomington, IN 47402, USA; E-Mail: dwichelns@csufresno.edu
https://www.researchgate.net/publication/276131175_Achieving_Water_and_Food_Security_in_2050_Outlook_Policies_and_Investments

⁸ Fooddrink Europe- “Environmental Sustainability Vision Towards 2030: Achievements, challenges and opportunities”
https://www.fooddrinkeurope.eu/uploads/publications_documents/temp_file_FINAL_SustainabilityReport_LD_JUL_Y_20121.pdf

хэрэгтэй бөгөөд Европын орнуудад энэ төрлийн нэлээд хэдэн санал, санаачилгууд хэрэгжиж эхлээд байгааг тэмдэглэсэн байна.

- “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 2050 он хүртэлх хүрээлэн буй орчны хэтийн төлөв” (OECD Environmental Outlook to 2050)⁹.

Судалгааны тайланд дөрвөн хүчин зүйлсийн нөлөөнөөс шалтгаалан 2050 он гэхэд хүн төрөлхтөнд хүрээлэн буй орчны ямар сорилт тулгарч болохыг багтаажээ. Ирэх дөч орчим жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт, био-тархалт, ус болон хүрээлэн буй орчны бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл гэсэн дөрвөн гол хүчин зүйлийг судалжээ.

- Канадын БХЯ “Ирээдүйн аюулгүй байдлын орчин: 2008-2030” (“The future security environment: 2008-2030”)¹⁰.

Судалгаанд геополитик, нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй орчин, технологи, цэргийн салбарын чиг хандлагыг багтаан 2030 он хүртэлх аюулгүй байдалд хамгийн ихээр нөлөөлж болох хүчин зүйлсийг дедукцийн аргаар судалсан. Ирээдүйд өөрчлөгдөх хүчин зүйлсийг тохиох өөрчлөлтүүд; тохиох магадлалтай өөрчлөлтүүд; тохиох боломжтой өөрчлөлтүүд; тохиох магадлал багатай өөрчлөлтүүд гэж дөрвөн үндсэн ангилалд хуваан авч үзсэн байна. Цаашдаа улс орнуудын хооронд эдийн засгийн өрсөлдөөн, үндсэрхэг үзэл үндэсний бахархал, сэтгэл хөөрөл, гэнэтийн шийдвэр, тогтворгүй удирдагчид зэргээс үүдэн өрсөлдөөн бий болох магадлал өндөртэй байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

- Евро Комисс- “Дэлхийн хүнсний аюулгүй байдал 2030” (ЕС- “Global Food Security 2030”)¹¹.

Судалгааны үндсэн агуулга нь 2030 он гэхэд ямар зорилтод хүрч байж хүнсний аюулгүй байдал хангагдсан байхыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний системийн зохимжтой өөрчлөлтөөр; орон нутагт хүнсний хүрэлцээг хангах орчныг бүрдүүлэхээр; дотоодын, бүс нутгийн, олон улсын түвшинд үйлдвэрлэл, хэрэглээний тэнцвэр хангагдсан хүнсний тогтолцоогоор; хэрэгцээнд суурилсан хүнсний системээр дүгнэж авч үзэхээр заасан.

2. Манай судлаачдын аюулгүй байдлын үнэлгээ, баримт талдаа хамааруулан авч үзэж болох бүтээлүүд:

- Т.Намсрай, Д.Нанжид Иргэншилд учирч буй 100 аюул занал¹².

Энэ ном нь олон улсын цэрэг-улс төрийн байдал; орчин үеийн эдийн засгийн байдал; орчин үеийн нийгмийн асуудал; зууны өвчнүүдийн асуудал; хүнсний нөөцийн асуудал; эрчим хүчний асуудал; даяаршсан гэмт хэргийн асуудал; хүрээлэн буй орчны асуудал; орчин үеийн шинжлэх ухаан ба иргэншил; соёл ба боловсролын асуудал; сансрын асуудал гэсэн 11 бүлэгт эдгээр асуудалд хамаарах өнөө үеийн болон ирээдүйн болзошгүй түвшинг харуулсан зарим тоо баримтыг агуулсан, өөрийн орны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 -ын зорилт дээр тулгуурласан материалуудыг авч үзсэн байна. Энэхүү номонд аюулгүй байдлын онол, арга зүй, үнэлгээ талын материал авч үзэгдээгүй байна.

- Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого (төсөл) 2015-2040.¹³

⁹ “OECD Environmental Outlook to 2050” <https://www.oecd.org/env/indicators-modelling-outlooks/49846090.pdf>

¹⁰ The future security environment: 2008-2030” http://publications.gc.ca/collections/collection_2011/dn-nd/D4-8-1-2010-eng.pdf

¹¹ ЕС- “Global Food Security 2030”

<http://publications.jrc.ec.europa.eu/repository/bitstream/JRC94867/1bna27252enn.pdf>

¹²Т.Намсрай, Д.Нанжид. Иргэншилд учирч буй 100 аюул занал. УБ., 2018., 466 х., т. 397.

¹³ Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого төсөл 2015-2040. УБ., 2015, 206 х.

Судалгааны бүтээл нь Монгол Улсын Их Хурлын ажлын хэсэг, мэргэжил арга зүйн дэд ажлын хэсэг болон Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн хамтран явуулсан, Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын эхний үе шатны хэрэгжилтийг үнэлж, өнөөгийн нөхцөл байдлыг эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны өнцгөөс шинжилж, 2040 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогын гол зорилтуудыг монгол хүмүүний бүтээх чадварыг дэлхийн түвшинд хүргэх, хүмүүний хөгжил амьдралын чанарыг сайжруулах; эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлж, төрөлжүүлэх, баялгийг тэнцвэртэйгээр хуваарилах; мэдлэг оюун, өв соёлын баялаг хуримтлал бүрдүүлж, технологи, инновацын хүчтэй чадавхыг бий болгох; хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө, байгалийн баялгийн нөөцийг хамгийн үр өгөөжтэйгөөр ашиглах; хүрээлэн байгаа амьдрах орчноо эрүүл байдлаар нь хадгалах; гадаад орчинтойгоо харилцан үр ашигтайгаар хамтран ажиллах хүрээнд авч үзсэн судалгааны бүтээл байна. Гагцхүү хөгжлийн бодлогыг богино хугацаанд ажлын хэсгийн хүчээр гүйцэтгэх үүрэгтэй байсан нь үнэлгээг голлон зорилгын хандлага дээр тулгуурлан хийхэд хүргэсэн байна. Тиймээс олон улсын болон цэрэг, улс төрийн харилцаа талаас үнэлгээ хийж, аюулгүй байдлын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх боломж хомс байсан.байдал ажиглагдаж байна.

- Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа.¹⁴

ОБЕГ-ын Гамшиг судлалын хүрээлэнг түшиглэн гүйцэтгэгдсэн Шинжлэх ухаан, технологийн төслийн ажил. Энэ бүтээлд стратегийн эрсдэлийг улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, шинжлэх, ухаан технологийн, байгалийн аюулт үзэгдэл, үйлдвэрийн осол зэрэг талаас нь авч үзсэн байна. Энэхүү судалгаанд “Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин үүний үр дагавраар НАТО, АНУ болон ШХАБ-ын хооронд бие биеийн эсрэг хүчээр заналхийлсэн зөрчил, сөргөлдөөн үүсэж үүнд Монгол Улс татагдан орох аюул занал (эрсдэл) учирч болзошгүй юм”, “Ойрын жилүүдэд учирч болзошгүй үйл явдлын таамаглалаар бол дотоод улс төрийн амьдралд нөлөөлж болохоор хамгийн хүчтэй эрсдэл нь нийгмийн шударга ёсны төлөөх иргэдийн зүй ёсны тэмцэл хэт хувьсгалжсан, улс төрийн экстремизмийн хэлбэрт шилжиж болзошгүй байгаа явдал юм”, “Нийгэм дэх авлига, шударга бус байдал, гэмт хэргийн өсөлт, төр засгаас тэдний эсрэг явуулж буй тэмцлийн үр дүн төдийлөн сайн биш байгаа нь Монголын нийгэмд анхаарал татсан асуудал болсон хэвээр байж нийгэм дэх эрсдэлийг нэмэгдүүлэх нэг гол нөхцөл, үзүүлэлт болсоор байгаа нь судалгаанаас харагдаж байна” гэсэн чухал дүгнэлтүүдийг хийсэн байна.

- Монгол Улсын байгалийн болон техногенийн гаралтай гамшгийн эрсдэлийн үнэлгээ, таамаглал¹⁵.

Судалгааг Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн байна. Энэхүү ажилд “Байгалийн гамшгийн стратегийн эрсдэлийн үнэлгээ” бүтээлийн эхний хэсэгт: дэлхийн байгалийн гамшгийн эрсдэл; монгол орны байгалийн гамшгийн эрсдэл; байгалийн гамшгийн стратегийн эрсдэлийн үнэлгээний аргачлал; байгалийн гамшгийн стратегийн эрсдэлийн үнэлгээ (цасан болон шороон шуурга, үер, зуд, ганба цөлжилт, газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин, шинэ дэд хэвшлээр үүсгэгдсэн хүний томуу, өвчин, ой хээрийн түймэр, нэгдсэн үнэлгээ); байгалийн гамшгийн эрсдэлийн

¹⁴ “Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа” үнэлгээ ба таамаглал. ОБЕГ, ГСХ., УБ., 2012. 310 х.

¹⁵ Монгол Улсын байгалийн болон техногенийн гаралтай гамшгийн эрсдэлийн үнэлгээ, таамаглал. УБ., 2013, 272 х.

үнэлгээний нэгдсэн дүгнэлт; байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах нэгдсэн зөвлөмж зэргийг авч үзсэн бол “Техногенийн гаралтай гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хэмээх хоёрдугаар хэсэгт цөмийн болон цацрагийн үүсгүүртэй холбоотой цацрагийн осол; химийн бодисын эрсдэлийн судалгаа; эрчим хүчний салбарын стратегийн эрсдэлийн үнэлгээ; газрын тосны бүтээгдэхүүний гал түймрийн эрсдэлийн үнэлгээ; Монгол Улсын үйлдвэрлэл, уул уурхайн салбарт гарч буй ослын эрсдэл; тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эрсдэл; техногенийн гаралтай гамшгийн эрсдэлийн нэгдсэн үнэлгээ; техногенийн гамшгийн эрсдэлийн нэгдсэн дүгнэлт; техногенийн гаралтай гамшгийн эрсдэлийг бууруулах талаар өгөх нэгдсэн зөвлөмж гэсэн агуулгаар судалгааг авч үзсэн байна. Энэ бүтээлд судалгаа зөвхөн байгалийн гамшгийн эрсдэлийн үнэлгээн дээр төвлөрсөн тул гадаад орчны үнэлгээ бүрэн хийгдээгүй байна.

Хоёрт. “Гуравдагч хөрш”-ийн талаарх бүтээлүүд:

1. Эрдэм шинжилгээний хурал, төслийн үр дүн:

- Стратегийн судалгааны хүрээлэнгээс Конрад Аденауэрын сантай хамтран зохион байгуулсан "Гуравдагч хөршийн бодлого" эрдэм шинжилгээний цуврал бага хурал (2011¹⁶, 2012¹⁷, 2013¹⁸).

Стратегийн судалгааны хүрээлэнгээс Конрад Аденауэрын сантай хамтран зохион байгуулсан "Гуравдагч хөршийн эрдэм шинжилгээний цуврал бага хурлаас 2011 онд "Их гүрнүүдийн хүрээлэлд орших улсын бодлого: Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого", 2012 онд "Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого Монгол-Европ: Бодлого, зорилт", 2013 онд "Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого: Хамтын ажиллагаагаар аюулгүй байдлаа хангах нь" эмхэтгэл тус тус гарчээ. Энэхүү эрдэм шинжилгээний цуврал бага хурал “Гуравдагч хөрш”-ийн тухай ойлголт, томъёолол, “гуравдагч хөрш”-ын онолын үндэслэл, Европын улсуудын туршлага, сургамж зэрэг онол, практикийн суурь асуудлуудыг хэлэлцсэн. Тухайлбал, “гуравдагч хөрш”-ийг "сөрж тэнцвэржүүлэх (hard balancing)" биш, зөөлөн тэнцвэржүүлэх (soft balancing)" онолоор тайлбарлах далайд гарцгүй орнуудын давуу тал, Европын стандартыг нэвтрүүлэх боломж, "гуравдагч хөрш"-үүдтэй эдийн засгийн интеграцид нэгдэх асуудлыг чухалчилжээ.

Чингэхдээ "олон талт хамтын ажиллагааны механизмд элсэх замаар “гуравдагч хөрш”-ийн дэмжлэгийг "институцчилах"-д “гуравдагч хөрш”-ийн бодлогын цаашдын зорилго чиглэх ёстой"-г дээрх цуврал хуралд тэмдэглээд, “гуравдагч хөрш”-ийн бодлогод эдийн засгийн хүчин зүйл чухал үүрэгтэй, гэхдээ “гуравдагч хөрш” буюу холын түншүүддээ хандсан бодлого хэт өндөр хүлээлт үүсгэх нь оновчтой биш, мөрөөдөл, бодит байдал хоёрын жорыг тааруулах"-ыг сануулжээ.

- Ж.Энхсайхан нарын Монгол улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого: Гуравласан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж" сэдэвт судалгааны ажил (2017)¹⁹.

Энэ судалгааны ажлыг "Монгол Улсын гадаад бодлогын лаборатори" төслийн хүрээнд Конрад Аденауэрын сантай хамтран хэрэгжүүлсэн. "Монгол Улсын гадаад

¹⁶Их гүрнүүдийн хүрээлэлд орших улсын бодлого: Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого" ССХ, КАС. УБ., 2011

¹⁷"Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого Монгол-Европ: Бодлого, зорилт" ССХ, КАС. УБ., 2012

¹⁸"Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого: Хамтын ажиллагаагаар аюулгүй байдлаа хангах нь" ССХ, КАС. УБ., 2013

¹⁹"Монгол Улсын гадаад бодлогын лаборатори" төслийн хүрээнд хэрэгжсэн "Монгол улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого: Гуравласан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж" сэдэвт судалгааны ажил. Цэнхэр Сүлд ТББ, КАС. УБ., 2017

бодлогын лаборатори" төслийн хүрээнд хэрэгжсэн "Монгол улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого: Гуравласан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж" сэдэвт судалгааны ажилд "гуравдагч хөрш"-ийн бодлогыг эдийн засгийн агуулгатай болгох шаардлага байгаа" гэж үзээд, "гуравласан" хамтын ажиллагаанд хөрш хоёр орныг ямар нэгэн хэмжээгээр татан оролцуулах боломжийг хайхад анхаарсан" байна. Чингэхдээ "Монгол Улсын хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах бодлого, "гуравдагч хөрш"-ийн бодлого, гуравласан хөршийн хамтын ажиллагаа, олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус нь тус тусдаа бие даасан бодлого биш, харин харилцан бие биеэсээ хамааралтай, харилцан нягт уялдаа холбоотой" гэдгийг онцлон тэмдэглээд, "гуравдагч хөрш"-ийн бодлого бол "хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого биш, харин хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах бодлогын логик үргэлжлэл юм. Монгол Улс хоёр хөрштэйгөө стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон бөгөөд урт хугацаанд найрсаг харилцаатай байх агуулгатай" болохыг тодотгожээ. Түүний зэрэгцээ Монгол Улс "гуравдагч хөрш"-тэй аль салбарт илүү харилцахаа бодлогоор зохицуулах, түүнийгээ хэлбэрэлтгүй мөрдөх явдал доголдолтой явсаар өдий хүрснийг", "Монгол Улсын хууль эрхзүйн болон улс төрийн орчин зарим талаар тогтворгүй, бодлогын залгамж чанар, уялдаа холбоо алдагддаг, хариуцлагын тогтолцоо сул" байгаа нь эдийн засгийн хамтын ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулж, энэ байдал нь Монгол Улсын "нэр хүндийг олон улсын тавцанд унагах, гадаад түншүүддээ нэр нүүрээ алдахад хүргэж байгаа"-г цохон тэмдэглээд, "гуравдагч хөрш"-ийн бодлого тууштай явуулахын тулд хоёр хөрш орондоо байнга тайлбарлаж, төр-засагт нь байр сууриа албан ба албан бусаар (I суваг, I хагас суваг, II суваг) илэрхийлж байх", "Гуравдагч хөршийн талаар хоёр хөрш улсын төр-засагт нь байнгын хөдөлшгүй үзэл бодол төлөвшүүлэх"-ийг тус тус анхааруулжээ.

- "Гурван хөршийн хоорондох Монгол Улс: Монголын улс төрийн үйл явцад нөлөөлөх гадаад хүчин зүйлс" сэдэвт судалгааны ажил (2018)²⁰.

Энэхүү судалгааны ажлыг ОХУ-ын Буриадын Улсын Их Сургууль, МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль хамтран Засгийн газар хоорондын суурь судалгааны төслийн хүрээнд хэрэгжүүлсэн байна. Судалгааны ажилд "Монгол Улс нь өрнөдийн орнууд, юуны өмнө "гуравдагч хөрш"-ийн орнуудаас газарзүйн байршлын хувьд ихээхэн алслагдмал, түүний эдийн засгийн гадаад хамтын ажиллагаанд том байр эзэлдэггүй боловч Өрнөд ба түүний холбоотнууд нь Монголын дотоодын улс төрийн үйл явцад харьцангуй өндөр нөлөөтэй. Түүгээр ч үл барам АНУ бусад өрнөдийн томоохон орнууд алс оршдог нь зэргэлдээ БНХАУ, ОХУ-аас "илүү зөөлөн харьцах" боломжийг бүрдүүлж, харин монголчууд нь өрнөдийн давамгайлж буй байр суурийг шүүмжлэхийн оронд Вашингтон, Брюссель, Токио, Сөүл, Дели, Анкара нь Монголд ашиг сонирхлоо алдахгүй байгаасай гэж хүсдэг болжээ." (В.А.Родионов, Б.Санжмятав, 2019: 133) гэж дүгнэжээ.

2. "Гуравдагч хөрш"-ийн талаарх ном:

- С.Баттулга нарын "Монгол Улсын гуравдагч хөрш". УБ., 2021, 339 х.

Энэ бүтээлд зохиогчид "Гуравдагч хөрш"-ийн онол, практикийн үндэслэл, бодлого, стратегийн баримт бичигт дэхь Монгол Улсын байр суурь, "Гуравдагч хөрш"-ийн харилцааны эдийн засгийн шинжилгээ, улс төр, эдийн засаг, соёл-хүмүүнлэгийн харилцаа болон "гуравдагч хөрш" улсуудын бодлого, стратегийн асуудлыг авч үзсэн байна. Энэхүү ажил дахь нэг онцлог нь "гуравдагч хөрш"-ийн бодлогыг хэрэгжүүлэх явцад буй зөрчил,

²⁰ "Гурван хөршийн хоорондох Монгол Улс: Монголын улс төрийн үйл явцад нөлөөлөх гадаад хүчин зүйлс" сэдэвт суурь судалгааны ажил. ОХУ-ын МУИС, МУИС-ийн ОУХНУС. 2018

эрсдэлүүдийг зургаан чиглэлээр тодорхойлж, арван хоёр санал, зөвлөмжийг боловсруулсан байна.

- Д.Уламбаяр “Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого: хоёр ба олон талт хамтын ажиллагаа” УБ., 2022, 356 х.

Энэхүү бүтээлд зохиогч “гуравдагч хөрш”-ийн бодлогын үндэс суурь, үзэл санаа, гурван хөршийн хамтын ажиллагааны шинэ парадигмыг дэвшүүлж, хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд Монгол АНУ, Монгол Япон, Монгол Европын холбоо, Монгол БНСУ, Монгол Энэтхэг, Монгол Турк, Монгол Британи, Монгол Австралийн харилцааны асуудлыг авч үзсэн байна. Мөн тэрээр Ази-Европын дээд түвшний уулзалт АСЕМ ба Монгол Улс болон Зүүн Ази-Латин Америкийн хамтын ажиллагааны форум ба Монгол Улс гэсэн олон талт хамтын ажиллагааны сэдвүүдийг хөндөж судалгаа хийсэн байна.

- Түүнчлэн судлаач Ц.Батбаяр²¹ Гуравдагч хөршийн бодлогыг түүхэн талаас нь тайлбарлан нэг сэдэвт бүтээл туурвисан бол Монгол Улсын “Гуравдагч хөрш” орнуудтай тогтоосон харилцаа, түншлэлийн талаар АНУ-аас Монгол Улсад сууж байсан Элчин сайд Ж.Эдлтон²², Монгол Улсаас Турк Улсад суух Элчин сайдын яам²³, судлаач, Д.Уламбаяр²⁴, Д.Золбоо²⁵, Р.Болд²⁶, О.Нямдаваа²⁷ зэрэг судлаачид нэг сэдэвт бүтээл бичиж хэвлүүлж, Ч.Цэрэннадмидын²⁸ докторын зэрэг горилсон бүтээл туурвисан байна.

3. “Гуравдагч хөрш”-ийн талаарх илтгэл, өгүүлэл:

Ж.Баясах²⁹, Д.Уламбаяр³⁰, Д.Мягмар, А.Түвшинтөгс, Ж.Чойнхор³¹, О.Машбат³² нарын эрдэмтэн судлаачид Монгол Улсын гуравдагч хөршийн бодлогын талаар илтгэл, өгүүлэл хэвлүүлсэн байна. Дээрх судалгаанууд нь Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг олон тулгуурт гадаад бодлогын талаас нь тодорхой авч үзэж судалсан байна.

²¹ Ц.Батбаяр- “Богд хаант Монгол Улс Гуравдахь хөршийн эрэлд” УБ., 2011.

²² Ж.Эдлтон- “АНУ-Монгол Улсын дипломат харилцаа 1987-2012” УБ., 2012

²³ Embassy of Mongolia in Ankara- “Outlook for Mongolia-Turkey relations” Ankara., 2019

²⁴ Д.Уламбаяр. “Монгол Улс, Өрнө дахин: Харилцаа, хамтын ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн. УБ., 2010, Д.Уламбаяр. “Монгол Улс, Алс Дорно дахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. Тэргүүн боть. УБ., 2013

²⁵ Д.Золбоо-“Монгол, Британий харилцаа” УБ., 2012

²⁶ Р.Болд- “Монголын тусгаар тогтнол ба Америкийн Нэгдсэн Улс” УБ., 2008, “Гуравдагч хөрш”-ийн бодлого: Зарим эргэцүүлэл”-Монголын геополитикийн зарим асуудлууд. УБ., 2018

²⁷ О.Нямдаваа- “Монгол-Энэтхэг: Өнө эртний, өнөөгийн түншүүд”. УБ., 2010.

²⁸ Ч.Цэрэннадмидын “Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого дахь Монгол, Туркийн харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт докторын диссертаци. 2020

²⁹ Ж. Баясах- “Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал (Түүвэр зохиол)” УБ. 2010.

³⁰ Д.Уламбаяр. “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: Онол-түүх, орчин үеийн зангилаа асуудал”- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2014, Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Гурамсан боть. (Нэмж засварласан 2 дахь хэвлэл) УБ., 2016 (Ж.Бортой хамт), «Монгол Улсын “гуравдагч” гүрнүүдэд хандсан бодлого, үйл ажиллагаа: XX зууны тэргүүн хагаст»- Рах Mongolia” сэтгүүл, ШУА, ОУХХ, 2017, Vol.3 №2 (7) Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын онолын үндэс”-“Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого, гурвалсан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж. (Конрад Аденауэрын сан) УБ., 2017, “Монгол Улс, ЕХ-ны түншлэл, хамтын ажиллагааны шинэ үе шат: Асуудал ба шийдэл” “Европ судлал- 2” №2. 2018, “Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын парадигм”-Геополитик судлал сэтгүүл, Геополитик судлалын хүрээлэн. №1, 2018, “Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого, гурвалсан хөршийн хамтын ажиллагааны парадигм ба зөөлөн тэнцвэржүүлэхүй”- ХИС. УБ., 2019

³¹ Д. Мягмар, А. Түвшинтөгс, Ж. Чойнхор- “Гуравдагч хөршийн бодлого: Түүхэн уламжлал, өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” Д. Мягмар “Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал (түүвэр эмхэтгэл)”

³² О. Машбат- “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын баримтлал ба гуравдагч хөршийн бодлогын хязгаар”-“Их гүрнүүдийн хүрээлэлд орших улсын бодлого: Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого” эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ. 2011.

Тухайлбал: доктор Д.Уламбаяр "Монгол Улсын "гуравдагч хөрш"-ийн бодлого: Онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудалд" өгүүлэлдээ, "Монгол Улсын "гуравдагч хөрш"-ийн үзэл баримтлалын гол агуулга нь Монгол улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн геополитик, геоздийн засаг, стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрхзүйн орчинг бүрдүүлэхэд оршино.", "хоёр хөршөөс Монголын тухайд явуулж буй геоздийн засгийн бодлого нь "гуравдагч хөрш"-ийн эрх ашгийг ямар нэг хэмжээгээр давхар хөндөж байх явдал болно." гэсэн дүгнэлт хийжээ.

Доктор Р.Болд "Монголын геополитикийн зарим асуудлууд" өгүүлэлдээ: "Гуравдагч хөрш"-ийн бодлогын талаарх үзэл баримтлалаа геополитикийн онол-аргазүйн үүднээс тодорхойлох мэтгэлцээнийг идэвхтэй явуулж, энэ талаарх ойлголт нь өрнөдийн тодорхой хэдэн улстай хоёр талын харилцаагаа хөгжүүлэх, хамтран ажиллах явдлаар хязгаарлагдахгүй гүнзгий ухагдахуун гэдгийг гаргаж ирэх шаардлагатай байна." гэснээс гадна "гуравдагч хөрш"-ийн бодлого гэдэг нь бодлогын "дагуул" шинжийг арилган бие даасан гадаад бодлогод шилжүүлэх явдал байв.

"Гуравдагч хөрш"-ийн бодлого нь улс төрийн энэхүү үүргээ биелүүлсэн боловч харамсалтай нь хөрсжүүлж чадсангүй, эдийн засагжуулах дараагийн шатанд хэрхэн шилжихээ тодорхойлж чадалгүй будилсаар Монгол "дагуул" болох шинж төлөв бүрэлдэж байна. Нэгэнтээ Монголын сонголт хязгаарлагдмал тул эдийн засгийн "дагуул" болох нь ойлгомжтой, харин ядаж улс төрийн "дагуул" болохгүй байх нь дараагийн зорилт юм. Монголын геополитикийн бодлогын тулгамдсан болон хэтийн зорилт нь амьдрах эдийн засгийн орон зайгаа бусдад алдсан ч оршин тогтнох улс төрийн орон зайгаа алдахгүй байхад л оршино. Дахин "дагуул" болохгүйн тулд "гуравдагч хөрш"-ийн бодлого Монголд хэрэгтэй болно." хэмээн Р.Болд хатуухан дүгнэлт хийсэн нь ихээхэн анхаарал татаж байна.

Дээрх судалгаануудаас үзэхэд, *нэгд*, "гуравдагч хөрш"-ийн бодлогын асуудал олон хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, харилцан уялдаа хамааралтай авч үзэх шаардлагатай, нарийн түвэгтэй, зангилаа асуудал байна., *хоёрт*, "Гуравдагч хөрш"-ийн бодлогод хоёр хөршийн хүчин зүйлийн үзүүлэх нөлөөлөл, түүний эрсдэлийг үндэсний аюулгүй байдлыг хангах системийн шинжилгээгээр авч үзэж байх шаардлагатай, *гуравт*, судлагдсан байдлын нэгд авч үзсэн урьдчилсан үнэлгээний гол үр дүнгүүдийг өөрийн орны нөхцөл байдалтай холбосон шинжилгээ хийж, "гуравдагч хөрш" гол улсууд болон хоёр хөршийн харилцааны динамик өөрчлөлтийг төсөөлөх нь чухал байна.

Төслийн судалгааны зорилго:

Аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээ болон "гуравдагч хөрш"-ийн бодлогын онол, арга зүйн судалгаа хийж, түүн дээрээ үндэслэн Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хэтийн төлөв, их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн дундах Монгол Улсын аюулгүй байдлын орчин болон "гуравдагч хөрш"-тэй харилцах харилцааны хэтийн төлөвийг төсөөлж, үндэсний аюулгүй байдлаа хангахад чиглэсэн арга зүйн санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилтууд:

1. Аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйг судлах.
2. Үндэсний аюулгүй байдлын онол, арга зүйг судлах.
3. Аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээ хийх онол, арга зүйг судлах.
4. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын онол, арга зүйг судлах.

5. Монгол Улсын аюулгүй байдлын орчны болон “гуравдагч хөрш”-ийн харилцааны хэтийн төлөвийг төсөөлөх,
6. Үндэсний аюулгүй байдлыг “гуравдагч хөрш”-ийн бодлогоор хангахад чиглэсэн арга зүйн санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны объект:

Аюулгүй байдлын орчин дахь “гуравдагч хөрш”-ийн бодлого

Судлах зүйл:

Монгол Улсын аюулгүй байдалд “гуравдагч хөрш”-ийн бодлогын үзүүлэх нөлөө.

Судалгааны арга:

Мэдээллийг харьцуулан жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сценар зохиох, системийн хандлагын аргуудыг хэрэглэв.

“Аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, орчны үнэлгээний онол, арга зүйн үндэс ба Монгол улс” хэмээх нэгдүгээр бүлэг бүтцийн хувьд “Аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйн үндэс”, “Үндэсний аюулгүй байдлын онол, арга зүй ба Монгол Улс”, “Аюулгүй байдлын орчны үнэлгээний арга зүй ба Монгол Улс” гэсэн гурван зүйлтэй. Агуулгын хувьд тэдгээрт аюулгүй байдлын ерөнхий онолын мөн чанар, судалгааны арга зүй, ойлголтын суурь бааз, аюулгүй байдлын хувьсал өөрчлөлтийн чиг хандлага, үндэсний аюулгүй байдлын онол, арга зүй, аюулгүй байдлын хэтийн төлөвийн урьдчилсан үнэлгээний мөн чанар, стратегийн үнэлгээ ба стратегийн төлөвлөлтийн харилцан уялдаа, тэдгээрт нөлөөлөгч хүчин зүйлс, аюулгүй байдлын ирээдүйн хэтийн төлөвийн урьдчилсан үнэлгээний арга зүй, арга зэргийг цогцоор судалж, “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, арга зүйг зөвхөн аюулгүй байдлын системийн хандлагын арга зүйн хүрээнд авч үзэх шаардлагатайг үндэслэсэн. Мөн онол, арга зүйтэй холбоо бүхий Монгол Улс дахь өнөөгийн ойлголт, шийдлийн баримтуудын агуулгыг шигтгээгээр системийн хандлагын өнцгөөс “гуравдагч хөрш”-ийн бодлоготой холбон тайлбарлан харуулсан болно.

“Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, практик, дүн шинжилгээ” гэсэн хоёрдугаар бүлэг “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, практик”, “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: хоёр хөршийн судлаачдын судалгаа, дүн шинжилгээ” хэмээх хоёр зүйлтэй. Агуулгын хувьд: “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь *нэгд*, их гүрнүүдийн геополитикийн орчинд зөөлөн хүчээр тэнцвэрийн хүчийг барих цогц бодлого, *хоёрт*, онолын үндэс нь монголчуудын “тулгын гурван чулуу” хэмээх үзэл баримтлал-орчин үеийн гурван тулгуурт хөгжлийн онолын баримтлал, *гуравт*, эвсэл, холбоотны бодлого биш, хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого ч биш, харин зөвхөн энхтайван цагийн геополитик, *дөрөвт*, газарзүйн хязгаарлагдмал байдлаа даван туулж, нэмэлт шинэ боломжийг нээж, хөгжингүй, ардчилсан улс гүрнүүдтэй нээлттэй түншлэлийн харилцааг хөгжүүлснээр үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгийн аргаар баталгаажуулах бодлого болохыг онол, арга зүйн талаас тодорхой судалгаа, түүхэн баримт дээр тулгуурлан үндэслэсэн. Түүнчлэн Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн талаарх хоёр хөршийн эрдэмтэн судлаачдын судалгааг: *Хятадын хувьд*: Хятадын Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн ухааны академи, ХКН-ын хятад, англи хэлээр гардаг өдөр тутмын төв хэвлэл *Global Times* сонин, БНХАУ-ын Бээжингийн Ардын их сургуулийн Олон улс судлалын сургууль, Бээжингийн Гадаад судлалын их сургууль, ӨМӨЗО-ын Нийгмийн ухааны академийн Орос, Монгол судлалын хүрээлэн, Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын салбар, Өвөр Монголын Багшийн их сургууль, Шанхайн Хуадун их сургуулийн Ойр орчны орнуудын судлалын хүрээлэн, *Оросын хувьд*: ОХУ-ын

тухайд ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн, Алс Дорнодын судлалын хүрээлэн, Москвагийн ОУХИС, Дипломатын академи, Олон улсын асуудлаарх Оросын Зөвлөл, Санкт-Петербургийн их сургууль, Эрхүүгийн их сургууль, Улаан-Үдийн их сургууль дээр гол төлөв төвлөрч байгаад тулгуурлан дүн шинжилгээ хийсэн.

“Монгол Улсын аюулгүй байдлын орчин, “гуравдагч хөрш”-ийн харилцаа, хэтийн төлөв” хэмээх гуравдугаар бүлэг “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хэтийн төлөв”, “Их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын хэтийн төлөв дэх Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөв”, “Монгол Улс, Япон Улсын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв”, “Монгол, БНСУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв”, “Монгол, Энэтхэг улсын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв”, “Монгол, БНТУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв” гэсэн зургаан зүйлийн бүтэцтэйгээр бичигдлээ. Энэхүү бүлэгт олон улс, дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс хийсэн урьдчилсан үнэлгээнүүд болон эрдэмтэн судлаачид ирээдүйг таамаглах судалгаа хийж үр дүнгээр нь бүтээсэн ном зэргийн агуулгын дүн шинжилгээнд тулгуурлан Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хэтийн төлөвийг АНУ ба ОХУ, АНУ ба Хятад, ОХУ ба Хятад гэсэн их гүрнүүдийн хоорондын харилцааны болзошгүй сценарууд болон энэхүү сценарууд дээр үндэслэсэн Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөв, манай улстай стратегийн түвшингийн түншлэлийн харилцаатай “гуравдагч хөрш” орнуудын харилцааны байж болох хувилбаруудыг гаргаж, тодорхой санал, зөвлөмж боловсруулсан.

“Арга зүйн санал, зөвлөмж”-ийг аюулгүй байдлын удирдлага зохицуулалт болон сэтгэлгээний хандлагын өөрчлөлт тулгамдаж буйд үндэслэн *нэгд*, үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлага, зохицуулалтын чиглэлээр; *хоёрт*, “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, арга зүйн суурь ойлголтын чиглэлээр боловсрууллаа.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Энэхүү судалгааны ажлын шинэлэг тал нь анх удаа *нэгд*, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээ, “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, арга зүйг системийн хандлагаар цогцоор судалсан, *хоёрт*, Ази, Номхон далайн аюулгүй байдлын хэтийн төлөв болон их гүрнүүдийн хоорондын харилцааны хэтийн төлөвийн болзошгүй сценаруудыг боловсруулсан; *гуравт*, эдгээр сценаруудын Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт болон стратегийн түвшний түншлэлийн харилцаатай “гуравдагч хөрш”-үүдийн харилцаа хамтын ажиллагаанд үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлсон, *дөрөвт*, Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга зүйн санал, зөвлөмжийг “гуравдагч хөрш”-ийн бодлоготой уялдуулан тодорхойлсонд оршиж байна.

Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол:

Энэ ажлын онол, практикийн ач холбогдол *нэгд*, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээ болон “гуравдагч хөрш”-ийн онолын үндэслэлтэй суурь ухагдахуун, ойлголтын талаар харилцан ойлголцол болон нэгдсэн хандлага бий болгох, *хоёрт*, аюулгүй байдал судлалыг шинжлэх ухааны олон салбаруудын уулзвар дээр синергетикийн тусламжтай хөгжүүлэхэд системийн хандлагын арга зүйгээр хандах хэвшлийг бий болгох, *гуравт*, “гуравдагч хөрш”-ийн бодлого, түүний хэрэгжилтийг олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлттэй зохицон Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах улс төр дипломатын хэрэгсэл болгоход чиглэсэн арга зүйн зөвлөмж нь практикт нэвтрэх боломжтойд тус тус оршиж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ОНОЛ БОЛОН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ҮНДЭС БА МОНГОЛ УЛС

1.4 Аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйн үндэс

Аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйн үндсийг дараах хоёр гол асуудлын харилцан холбоосын өнцгөөс авч үзэх шаардлага байна. Үүнд:

Нэгдүгээрт. Аюулгүй байдлын ухааныг эрдэмтэн судлаачид хүн төрөлхтний үйл ажиллагаагаар үүссэн аюулаас хүмүүс ба хүрээлэн буй орчны хамгаалагдсан байдлын тухай мэдлэгийн систем бөгөөд бие даасан шинжлэх ухааны салбар ухаан байх ёстой гэдэг дүгнэлтэд хүрч байна. Энэ ололтын үр дүнд аюулгүй байдлын янз бүрийн чиглэлийг хамарсан төвөгтэй цогц асуудал нь салбар дундын судалгааны сэдэв болох талаар тодорхой ойлголт бий болсон боловч энэ сэдвийн талаарх олон тооны хэлэлцүүлэг, нийтлэлээс харахад аюулгүй байдлын систем дэх ерөнхий асуудлын шинжилгээ, түүний онолын загварын байгуулалт, практик зохицуулалтын тодорхой үүргийн томъёоллын хооронд зааг ялгаа үүссэн байна.

Шинжлэх ухааны хэлэлцүүлэгт олон салбарын төлөөлөл оролцож байгаа үед ихэвчлэн аюулгүй байдлын ойлголт-категорийн аппаратын томъёолол болон онотолог шинжтэй хамгийн ерөнхий тулгамдсан асуудал орхигдох нөхцөл байдал бий болсон.

Тиймээс ч аюулгүй байдлын загварыг байгуулах санал болгож байгаа хувилбар нь голдуу эмпирик өгөгдлүүд дээр тулгуурлаж байгаа бөгөөд өөртөө онолын мэдлэгээр дутмаг прагматик бүтцийг агуулж байна. (Шигтгээ-1).

ШИГТГЭЭ-1

Монгол Улсад аюулгүй байдлын судалгааг цогцоор явуулдаг “аюулгүй байдал судлал”-ын судалгааны байгууллага байхгүй. ҮАБЗ-ийн дэргэд Стратеги судлалын хүрээлэн, БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төв, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ОБЕГ-ын харьяа Гамшиг судлалын хүрээлэн, Үндэсний тагнуулын академийн дэргэдэх Аюулгүй байдал судлалын хүрээлэн зэрэг олон нэгж өөр өөрсдийн чиглэлээр салангид үйл ажиллагаа явуулж, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар янз бүрийн сэдэвтэй олон улсын хурал, семинар зохион байгуулж байгаа боловч “аюулгүй байдлын ухаан”-ы онол, арга зүйн талаар нэгдсэн ойлголтод хүрэх алхам хийгдэхгүй байна.

Олон их сургуульд аюулгүй байдлын чиглэлийн сургалт явуулах өрсөлдөөн өрнөж, нэгдсэн зохицуулалт, хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эрдэмтэн, судлаачид зөвхөн өөр өөрсдийн мэргэшсэн чиглэлээр бүтээл туурвиж байна. ҮБХИС-ийн дэргэд аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар докторын зэрэг хамгаалуулах салбар дундын зөвлөл байгуулагдсан нь нэгдсэн ойлголт руу ойртуулах нэг алхам юм.

Салбар дундын гүнзгийрүүлсэн судалгааны зорилго нь аюулгүй байдлын системийн тулгамдсан асуудлын бүх цогцыг олон талаас нь зөвхөн зохицуулалтын өнцгөөс бус, эцсийн үр дүнд илүү тусгай асуудлын шинжилгээнд хэрэглэгдэх найдвартай арга зүйн үндсийг бий болгох өнцгөөс судлагдах ёстой. Өөрөөр хэлбэл, өнөөдөр аюулгүй байдлын талаарх хамгийн ерөнхий төсөөллийн тогтвортой систем ба түүний шинжилгээний арга зүйн өөрийн гэсэн “аюулгүй байдлын философи” буюу аюулгүй байдлын тухай шинжлэх ухаантай байх асуудал юм.

Хоёрдугаарт. Аливаа асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө гүнзгий судалсан, шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын суурь бааз шаардлагатай байдаг. Энэ шаардлага зөвхөн шинжлэх ухааны боловсруулалтад бус бас үндсэн томъёолол болон ойлголтын онолын үндэслэлтэй тодорхойлолтыг агуулсан норматив, эрх зүйн баримт бичгүүд хамаарна. Зөвхөн онолын үндэслэлтэй тодорхойлолт л аливаа асуудалд харилцан ойлголцол болон нэгдсэн хандлага бий болгож чаддаг.

Өнөө үед “аюулгүй байдал” гэсэн хамгийн ерөнхий суурь ойлголтын талаар янз бүрийн томъёолол бий болж байна. Энэ нь улмаар “үндэсний аюулгүй байдал” гэдэг ойлголтын аппаратыг бий болгож мөрдөхөд зарим талаар сөрөг үр дагавар авчирч байна. Гол шалтгаан нь тухайн асуудлыг хариуцан боловсруулсан хүмүүсийн дунд аюулгүй байдлын онол, арга зүйн танин мэдэхүйн ойлголт цэгцрээгүйтэй холбоотойгоор агуулгын алдаатай дүгнэлт хийгдэж байна. (Шигтгээ-2).

ШИГТГЭЭ-2

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын анхны үзэл баримтлалд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал (цаашид “үндэсний аюулгүй байдал” гэх) гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна.”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” гэж тус тус тодорхойлсон.

Эдгээр тодорхойлолтод “аюулгүй байдал” гэдгийг “... *хангах* ...” гэж урьдчилсан байдлын гадаад, дотоод нөхцөл хангагдсан, бүрдсэн байх утгаар ойлгон хэрэглэсэн нь “аюулгүй байдал” гэсэн суурь танин мэдэхүйн ойлголттой зөрчилдөж байна.

Аюулгүй байдал ерөнхий хүн төрөлхтний үйл ажиллагаанаас ангид өөрөө оршин тогтнохгүй. Тэр нь өөрийгөө хамгаалах ба хөгжих үүрэгтэй нийгмийн амьдралын бүх талтай нягт холбоотой.

Өнөө үед хүн, нийгэм, улс зэрэг хөгжиж байгаа объектын зохион байгуулалт болон үйл ажиллагааны хөгжлийн дотоод механизмыг судлахад онцгой анхаарал хандуулж байна. Тиймээс аюулгүй байдал судлалын үүрэг нь судалж буй бодит байдал, түүний мөн чанар, хөгжлийн болон тэдгээрийг практикт хэрэгжүүлэх ажиллагааны хуулийн тухай бодит мэдлэгийг гаргаж авах, онолын ерөнхий дүгнэлт хийх ба системчлэхэд оршино. Түүний

хавсрага зорилго нь хүн төрөлхтөн ба хүний амьдрал ажиллагааг хангах талаарх үзэл баримтлал болон зөвлөмжийг боловсруулах явдал юм.

Аюулгүй байдал судлалын оршин тогтнох үндэс нь өөрийн аюулгүй байдлыг хангах талаарх хүмүүс, улс болон дэлхийн хамтын нийгэмлэгийн ажиллагааны туршлагын судалгаа, аюулгүй байдлын системийн байгуулалтын зүй тогтол, харилцан холбоос ба зарчмын илрүүлэлт, янз бүрийн улсын дотоод ба гадаад аюулгүй байдлаа хангах өвөрмөц үндэсний онцлогийн харьцуулсан шинжилгээ, даяар, бүс нутгийн ба улсын доторх аюулгүй байдлын ирээдүйн системийн үндсэн аюул занал, хувьслын хандлага болон загварын хэтийн үнэлгээ, тэдгээрийн бүтэмжийн үзүүлэлт болон шалгуурын боловсруулалт зэрэг болох ёстой. Түүнчлэн дээр тэмдэглэсэн аюулгүй байдал судлал янз бүрийн орны аюулгүй байдлын үзэл баримтлал, номлол, бодлого ба стратегийн, мөн энэ салбар дахь шинжлэх ухааны судалгааны системийн шинжилгээ ба ерөнхий боловсруулалтыг хийх ёстой.

Аливаа шинжлэх ухаан нийгмийн ухамсрын нэг хэлбэрийн хувьд хүний ажиллагааны хүрээтэй холбогддог учраас бүх шинжлэх ухаан, шинжлэх ухааны болон практик чиглэл нь хүний амьдрал үйл ажиллагааг хангахад чиглэдэг зүй тогтлын дагуу хүн төрөлхтний хөгжлийн явцаар аюулгүй байдлыг хангах асуудал хэмжээний илэрхийллийн хувьд хүн, нийгэм, улс, дэлхийн аюулгүй байдал болж өргөжсөн бөгөөд XXI зуунд аюулгүй байдал гариг ертөнцийн асуудал болоод байна.

Аюулгүй байдал судлалын гол зорилго нь ноосферийн аюулгүй хөгжлийн зүй тогтлуудыг илрүүлэх, хүмүүс ба хүн төрөлхтний амьдрал үйл ажиллагааны аюулгүй байдлын салбар дахь ээдрээтэй тохиолдол, үйл явц, үзэгдлийг судлах, журамлах, ангилах ба системчлэх болон тэдгээрээс сэргийлэх, саармагжуулах ба арилгах талаарх тохирсон арга хэмжээг боловсруулах явдал юм.

Аюулгүй байдлын асуудлын талаарх нэрт сэтгэгчид, эрдэмтэд, улс төрчдийн үзэл санааг судлах нь энэ шинжлэх ухааны хөгжилд чухал ач холбогдолтой.

Аюулгүй байдал судлалын үндсэн үүргүүд нь:

- хүн болон хүн төрөлхтний амьдрал үйл ажиллагааны янз бүрийн хүрээн дэх аюулгүй байдлыг хангах үйл явцын тухай мэдлэгийг олж авах ба эдгээр мэдлэгийн онолын боловсруулалтыг хийх;
- аюулгүй байдлын судалгааны тусгай чиглэл болон хэсгийн харилцан холбоосыг илрүүлэх ба тэдгээрийн үндсэн дээр мэдлэгийн нэгдсэн систем, аюулгүй байдлын ерөнхий онолыг бий болгох;
- амьдрал үйл ажиллагааны цогц аюулгүй байдлыг хангах үзэл баримтлал, хөтөлбөр болон саналыг боловсруулах;
- хүн болон хүн төрөлхтний тогтвортой, аюулгүй хөгжлийн зүй тогтол ба хандлагыг илрүүлэх, үзүүлэлт ба шалгуурыг үндэслэх явдал юм.

Аюулгүй байдал судлалын үүсэн тогтнох чухал үүргүүдийн нэг нь түүний бүтцийн боловсруулалт, түүний үндсэн элементүүдийн үүрэг, байрыг үндэслэх болон тэдгээрийн хоорондын харилцан холбоосыг илрүүлэх явдал юм.

Аюулгүй байдал судлалын судалгааны үндсэн чиглэлүүд нь:

- хүн, нийгэм, улс, хүн төрөлхтөнд заналхийлсэн аюул занал;
- хүн ба нийгмийн амьдралыг хангах объект;
- аюулгүй байдлын ба хамгаалалтын объект;
- аюул заналын субъект;
- аюул занал, тэдгээрийн шинж чанар, үүсэх онцлог, үзүүлэх хохирол;
- аюул заналын эх сурвалж, тэдгээрийн онцлог;
- аюулгүй байдлыг хангах систем, хүч хэрэгсэл, бүрэлдэхүүн ба бүтэц, зорилго ба үүрэг, үйл ажиллагааны горим.

Хүн болон хүн төрөлхтний үйл ажиллагааны ноосферийн болон түүний элементүүд (биосфер болон хүн төрөлхтний бүлэглэл)-ийн бифуркацид³³ хүргэж болох хязгаарын түвшинг таслан зогсоохын тулд үнэлгээний үүрэг гарч ирсэн. Аюулгүй байдлын төрөл бүрийн объектууд болон үзэл санааны төлөвийн судалгаануудын салангид шинжлэх ухааны чиглэлүүдийг хүн төрөлхтнийг гадаад болон дотоод аюул заналаас хамгаалах тухай шинжлэх ухаанд нэгтгэх зайлшгүй шаардлага бий болсон. Ийм нөхцөл байдлууд нь аюулгүй байдал судлалын арга зүйг хэм хэмжээ, дүрэм, хууль болон зааврын тухай сургаалд хамаарах шинжлэх ухааны судалгааны арга зүй шиг явцуу практик талаас нь бус, харин дараах нэгдмэл шинжлэх ухааны танин мэдэхүйн ойлголтыг зохицуулсан ертөнцийг үзэх үзэл, шинжлэх ухааны үзэл санааны систем, өөрийн төрхтэй философи шиг өргөн утгаар ойлгох хэрэгцээг бий болгосон:

- судалгааны аргуудыг сонгох;
- мэдээ баримтуудыг тайлбарлах, тодорхойлох, тайлбар хийх;
- цогц, системийн хандлагын үндсэн дээр загварыг боловсруулах;
- онолыг томъёолох;
- аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулах.

Аюулгүй байдал судлалын өвөрмөц онцлог нь түүний үйл явдал, үзэгдлийг салангид шинжлэх ухааны аргуудаар буюу тэдгээрийн аргуудын энгийн нийлбэрээр судалж болохгүйд оршиж байна. Түүний асуудал нь хүн төрөлхтний мэдлэгийн эдийн засаг, социологи, философи, сэтгэл зүй, экологи ба бусад олон салбарыг хамрах ба тэдгээрийн харилцан ажиллагаа, бүхэл харилцан холбоос бүхий илрэлийн үр дүн юм. Тиймээс судалгааны зарчмын шинэ арга зүй, олон шинжлэх ухааны өөрийн төрхтэй синтез шаардагдах ба тэдгээрийн хоорондын нийтлэг зүй тогтлуудыг илрүүлэхэд синергетик, чухал ач холбогдолтой. Тиймээс аюулгүй байдал судлалд синергетикийн тусламжтайгаар шинжлэх ухааны олон салбарын ололт амжилт, эрдэмтэд мэргэдийн мэдлэг авьяас, оюуны чадавхыг аюулгүй байдлын системийн онол, арга зүйн зүгт чиглүүлж, аливаа үзэгдлийн зүй тогтлыг хамтын хүчээр илрүүлэх боломжтой юм.

³³ Синергетикт бифуркаци/bifurcation – нэг зүйл хоёр болон хуваагдах/ гэсэн ойлголт бий. Энэ нь үзэгдэл үйл явцын явах зам мөр салаалан, салбарлах замаар үргэлжлэн өрнөх жам ёсыг харуулдаг. Бифуркаци орчлонгийн тэгш хэмийн/тэнцвэр, эсрэг тэсрэгийн нэгдэл/ хууль үзэгдлийн өрнөн үргэлжлэх зам мөрийн хувьд ч биелдэгийг харуулдаг.

Аюулгүй байдал судлалд синергетикийг арга зүйн үндэс болгохын чухлыг “Синергетик нь тэнцвэрийн нөхцөлөөсөө алслагдсан төрөл бүрийн систем дэх үйл явцыг судлана. Тэнцвэрийн нөхцөл гэдэг нь түрүүчийнхээс илүү бага энтропи бүхий тогтвортой төлөв байдалд шилжих явдал буюу цэгцрэлийн тодорхой түвшинд хүрээд харьцангуй тогтонги байдалд орох явдал юм. Энэ нь систем нэгэнт тогтвортой байдалд орсон бол дахин өөрчлөгдөхгүй гэсэн үг биш юм. Учир нь аливаа нээлттэй систем гадаад орчинтойгоо байнгын эрчим, масс, онч дохио буюу мэдээллийн солилцоонд орших тул систем түр зуур цэгцэрсэн ч гадаад орчны өөрчлөлтөд зохицох хэрэгцээ шаардлага аяндаа тулгардаг. Өөрөөр хэлбэл, тэнцвэрийн нөхцөл хугацааны тодорхой үед л хангагдах боломжтой бөгөөд хэсэг хугацааны дараа энэ нь тэнцвэрийн шинэ нөхцөлийн хувьд харьцангуй алслагдмал нөхцөл байдал болж хувирдаг. Эндээс үзэхэд ямар ч систем тэнцвэрт төлөв, тэнцвэрийн цэгээс алслагдмал байдлаас гарах өөрчлөлтийн үе шатуудыг ээлж дараалан өнгөрөөдөг байна. Синергетикийн тусламжтайгаар бид энэ ерөнхий зүй тогтол, ялангуяа цэгцрэх үйл явцыг судлах болно.” гэж синергетикийн судлах зүйл, тэнцвэрт нөхцөлийн мөн чанарыг тодорхойлсон байдгаас харж болно. Синергетикийг өргөн утгаар нь “өөрөө аяндаа цэгцрэх тогтолцооны онол” гэж нэрлэсэн байдаг.

Аюулгүй байдал судлал нь нэгдсэн салбар ухаан учраас түүний судалгаанууд цогц шинж чанарыг агуулах бөгөөд эдгээр судалгааны үр дүнд илрүүлсэн баримт болон зүй тогтол нь заавал системийн байр сууринаас томъёологдсон байх ёстой. Энэ нь зөвхөн тодорхой аюулгүй байдлын судалгааны үр дүнд тодорхой нөхцөлүүдэд яг ямар номинац давуу байхыг тогтоож болохыг илэрхийлж байна.

Аюулгүй байдал судлалын онолын ба арга зүйн үндэс нь байгаль, нийгэм болон техникийн салбар ухаануудын уулзвар дээр үүсэж байгаа ба хүн, нийгмийн хамгаалалтын ухамсар дахь гол зүйл, үзэгдэл, зүй тогтол ба механизмийг судалж байгаа цогц шинжлэх ухаан болох түүний мөн чанараас бүрддэг. Аюулгүй байдал судлалын суурь зарчмын дагуу аливаа аюулгүй байдлын судалгаа үргэлж зөвхөн тухайн салбар ухаануудын уулзвар дээр оршиж байгаа бус мөн түүнтэй харилцан ажиллаж байгаа бусад салбар ухаануудтай нягт холбогдоно. Тиймээс аюулгүй байдал судлалын ойлголтын аппарат бусад хэд хэдэн шинжлэх ухаануудтай тодорхой хэмжээний адил талтай байна.

Аюулгүй байдал судлал нь олон салбар ухааны уулзвар дээр оршдогийг тэдгээртэй холбогдох дараах ерөнхий чиг баримжаануудаас харж болно. Үүнд:

- Аюулгүй байдал судлал дахь **байгалийн шинжлэх ухааны чиг баримжаа** нь энэ шинжлэх ухаан мэдлэгийн бие даасан салбарыг бүрдүүлэхээр эрмэлзэхдээ арга зүйн хувьд сонгодог байгалийн шинжлэлд аль эрт тогтсон стандартууд дээр тулгуурладгаар илэрхийлэгдэнэ.
- Аюулгүй байдал судлал дахь **нийгмийн чиг баримжаа** нь улс төр судлал, философи, сэтгэл судлал, социологи ба бусад тийм хүрээг багтаасан бүр илүү олон төрхөөр илэрч байна.
- Аюулгүй байдал судлал дахь **технологийн чиг баримжаа** нь информатик, кибернетик хүртэл ба бусад хамгийн янз бүрийн чиглэлийн техникийн салбар ухаануудтай холбогдох харилцан холбоосоор илэрч байна.

Аюулгүй байдал судлал нь өөрийн ерөнхий шинжлэх ухааны статусаар суурь-хавсарга шинж чанарын орчин цагийн цогц шинжлэх ухаан мөн.

Аюулгүй байдал судлалын *суурь судалгааны утга санаа* нь тэрээр өнөөгийн байгаа шинжлэх ухааны аль ч салбарын авч үзэхгүй байгаа тийм салбарын зүй тогтлыг судалж, танин мэдэхэд оршиж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засаг, философи, социологи, сэтгэл судлал, улс төр судлал, бусад тусгай шинжлэх ухааны чиглэл хүн, нийгмийн амьдрал үйл ажиллагааг цогц аюулгүй байдлыг хангах өнцгөөс судлахгүй байна.

Аюулгүй байдал судлалын *хавсарга шинж чанар* нь суурь судалгааны үндсэн дээр бусад тусгай шинжлэх ухаанд тулгуурласан тийм практик боловсруулалтууд хийгддэгт оршиж байна.

Аюулгүй байдлын судлалын судалгааны дараах *гурван арга зүйн суурь зарчмууд* байна. Үүнд: *нэгд*, системлэг байх зарчим; *хоёрт*, харилцан холбоо ба харилцан хамаарлын зарчим; *гуравт*, тодорхойлогч хүчин зүйлсийн зарчим орно.

1. Аюулгүй байдал судлалын үндсэн суурь арга зүйн зарчим нь *системлэг зарчим* мөн. Системлэг зарчмын үндсэнд бүхэл ба хэсгүүдийн харьцаа оршдог. Бүхэл нь өөрийн үндсэн шинжээр, ач холбогдол болон үүргээр, түүнд шингэсэн боломжоор түүний хэсгүүдийг бүрдүүлэгчдийн нийлбэрээс ялгаатай байна. Бүхэл нь системийн хэсгүүдэд байхгүй бөгөөд тэдгээрийн харилцан ажиллагааны үр дүнд бий болсон шинэ чанарыг эзэмшинэ. Өөрийн ээлжинд хэсгүүд нь өөрсдийн шинж чанарын онцлогийг агуулсан харьцангуй бие даасан байх бөгөөд өөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд бүхэл гэж авч үзэгдэнэ. Ийм маягаар хэсэг бүр бүхлийн мөн чанарт ба түүний хөгжилд тодорхой нөлөө үзүүлнэ. Иймд нэг талаас аюулгүй байдлын хүрээнд аливаа үзэгдлийг харьцангуй бие даасан, бага масштабын хэд хэдэн үзэгдлүүдийг агуулсан бүхэл гэж судлах хэрэгтэй. Нөгөө талаас бүхэл нь өөрөө том үзэгдлийн хэсэг байж, түүний нөлөөнд өртөж, түүнд нөлөөлнө. Иймээс үзэгдэл бүр түүний элементүүдийг бүрдүүлж байгаа тодорхой систем, харилцан уялдаатай ба харилцан ажиллаж байгаа юмс, үйл явц, харилцааны нэгдэл гэж судлагдах ёстой.

Бүхэл ба хэсгүүдийн харьцаа анализ, синтезийн нийтлэг шинжлэх ухааны аргуудаар судлагдана. Анализ нь судлагдаж буй үзэгдэл, үйл явдлын мөн чанарыг нээх зорилгоор нь бүрэлдэхүүн хэсгүүдэд, элементүүдэд, шинж тэмдгүүдэд, эсрэг байдлуудад хуваах ба тэдгээрийг судлах үйл явц юм. Синтез нь ялгаж гаргасан бүрэлдэхүүн хэсгүүд, элементүүд, шинж тэмдгүүд, эсрэг байдлуудын хоорондын холбоог тогтоох, тэдгээрийг нэгтгэх болон судалж байгаа үзэгдэл, үйл явдлыг түүний гол чухал шинж тэмдгүүд ба харилцаануудын хувьд нөхөн сэргээх үйл явц юм. Анализ ба синтез нь эсрэг тийш чиглэсэн (анализ - бүхлээс хэсэг рүү, синтез - хэсгүүдээс бүхэл рүү) байхын зэрэгцээ танин мэдэх салшгүй холбоотой аргууд байна.

2. Аюулгүй байдал судлалын дараагийн арга зүйн зарчим нь *харилцан холбоо ба харилцан хамаарлын зарчим* юм. Дэлхий нэгдмэл бүхэл. Түүний бүх хэсгүүд өөр хоорондоо салшгүй холбогдсон. Байгальд ч, нийгмийн амьдралд ч огт тусгаарлагдсан үзэгдлүүд ба зүйлс байхгүй. Бодит байдалд үзэгдэл болон үйл явц, тэдгээрийн бүх талуудын харилцан ажиллагаа, нийтлэг харилцан холбоос байгаа нь чухамхүү энэ зарчмаар нөхцөлдөнө.

3. Аюулгүй байдал судлалын *арга зүйн тодорхойлогч хүчин зүйлсийн зарчим* нь аюулгүй байдалд шийдвэрлэх нөлөө үзүүлэх гол холбоо ба харилцаануудыг ялгаж өгөхөд оршино. Энэ зарчим нь аливаа судлагдаж буй системийн үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлэхгүй байгаа хоёрдугаар зэргийн нөлөөллүүдийг ялгах боломж олгоно.

Дээрх суурь зарчмуудад суурилсан аюулгүй байдал судлалын судалгааны гол арга зүй бол системийн хандлага юм. Аюулгүй байдал судлалын судалгаанд системийн хандлагын чухал ач холбогдолтой болох нь түүний дараах онцлогуудаар илэрнэ. Үүнд:

- тэр нь асуудал шууд хялбар, математик аргын тусламжтайгаар шийдвэрлэгдэх боломжгүй, өөрөөр хэлбэл асуудлын нөхцөл байдлын анхны ихээхэн тодорхой бус байдал ба олон шалгууртай байдаг тохиолдолд хэрэглэгдэнэ;
- тэр нь асуудлын зохион байгуулалтын үйл явцад анхаарал хандуулах ба зөвхөн хялбар аргуудыг бус чанарын шинжилгээний аргуудыг ашиглана;³⁴
- тэр нь системийн онолын үндсэн ойлголтууд болон нийгмийн зүй тогтлуудын судалгааны үндсэнд орших философийн үзэл баримтлалуудад тулгуурладаг;
- тэр нь мэдлэгүүдийн янз бүрийн салбаруудын мэрэгжилтэнгүүдийг нэгтгэсэн хамтын шийдвэр гаргалтын үйл явцыг зохион байгуулахад тусална;
- тэр нь судалгааны үйл явц ба шийдвэр гаргалтыг зохион байгуулахын тулд судалгааг явуулах үе шатуудыг тодорхойлсон системийн шинжилгээний аргачлалын албан журмын боловсруулалт болон тэдгээрийг биелүүлэх аргуудыг шаардана;
- тэр нь ихээхэн тодорхой бус байдлыг судалгаанд илүү сайн нээлттэй (шинжилгээний ойлголтод тохирсон) байлгах илүү харагдах хэсэгт хэсэгчлэн хуваахыг үндсэн аргад санал болгоно.

Аюулгүй байдал судлалд ашиглаж буй системийн хандлага нь макро түвшингээс микро түвшинд судалгааны объектыг харуулахыг шаарддаг.

Макро хандлагын үед хамгаалалтын объект нэг бүхэл гэж авч үзэгдэнэ. Энэ нь түүний дотоод байгууламж, дотоод холбоосыг авч үзэхгүй, харин зөвхөн орц, гарцууд ба тэдгээрийн харилцан хамаарал судлагдахыг харуулж байна.

Микро хандлагын үед хамгаалалтын объект дотроосоо авч үзэгдэж, түүний дотоод бүтэц болон элементүүдийн холбоо судлагдана. Нөгөө талаас системийн хандлага хамгаалалтын дурын объектыг олон тооны дотоод, гадаад холбоосуудтай системийн түвшинд авч үзэж байна. Энэ нь *мезохандлага* юм. Системийн хандлага ер нь систем дэх бүх бүрэлдэхүүн хэсэг ба үйл явц өргөн хүрээнд нягт харилцан уялдаатай, тэдгээрийг бие биеэс нь хамааралгүйгээр авч үзэж болохгүй гэдэгт оршиж байна. Систем дэх дурын хүчин зүйл, параметрийн өөрчлөлт түүний бусад хувьсагчдын өөрчлөлтийг (агшин зуур, удалгүй эсвэл хангалтай урт хугацааны дараа) дагуулна. Түүгээр ч үл барам бусад хувьсагчдын байдал шууд биш, үсрэлтээр биш, харин аажмаар, хувьслаар өөрчлөгдөж болно. Янз бүрийн өөрчлөлтүүд янз бүрийн хугацаанд явагдаж болох учраас систем хугацааны хамааралд янз бүрээр өөрчлөгдөж болно.

³⁴ Теория системы и системный анализ в управлении организациями: Справочник: Учеб. пособие\ Под ред. В.Н.Волковой. –М.: Финансы и статистика, 2006. –с13

Системийн хандлагын төв ойлголт “систем” нь үндсэн арга зүйн ачааллыг үүрэх бөгөөд объектыг бүхэлд нь түүний талууд, шинжүүд ба харилцааны нэгдэлд илэрхийлнэ. Үлдэж байгаа ойлголтууд нь судалж байгаа объектын тусгай талууд ба шинжүүдийг зөвхөн дам илэрхийлнэ. *Систем нь ерөнхий зорилгод хүрэх зориулалттай харилцан холбоо бүхий элементүүдийн цогц юм.* Аливаа систем нь өөрөө илүү өндөр түвшингийн системийн элемент байна.

Системийг тодорхойлогч шинж тэмдгүүдийн тоонд:

- элементүүдийн олонлог байгаа;
- тэдгээрийн хооронд тогтсон холбоо ба харилцаа;
- дотоод ба гадаад харилцан ажиллагаа;
- боломжит байдлуудын олонлог;
- төвөгтэй зорилгод чиглэлийн функц байгаа;
- зан явдлын тодорхой шугам зэрэг орно.

Системийн үндсэн хэсгүүдийн нэг нь элемент юм. Элемент гэж бүхий л системтэй харьцангуйгаар түүний бие даасан, системийн бусад элементүүдтэй тодорхой харилцаагаар холбогдсон хэсгийг ойлгоно. Системийн өөр чухал шинж тэмдэг бол холбоо юм. Системийн хандлагад холбоо нь системийн бүтэц, түүний цаг хугацаа, орон зай дахь үйл ажиллагааг нөхцөлдүүлсэн, системийн элементүүдийн өөр хоорондын нөлөөлөл, харилцан ажиллагаа эсвэл харилцааны аргууд юм. Энэ нь системийг үүсгэгч холбоо гэж нэрлэгддэг. Тодорхой системүүдэд холбооны төрлүүд нь удирдлагын, мэдээллийн, үйл ажиллагааны ба бусад байж болно. Том систем дэх, ялангуяа “аюул занал – хамгаалалт” хэлбэрийн эсрэг сөргөлдөгч талуудын системүүд дэх холбооны судалгаа нь өөртөө хамгийн ээдрээтэй үүргийг агуулдаг. Сөргөлдөгч талуудын системийн үйл ажиллагааны үйл явц нь өөртөө зүгээр л хохирол учруулах эсвэл түүнээс хамгаалах харилцан нөлөөллийг илэрхийлдэггүй. Түүнд талуудын удирдлагын үйл явцууд болон хангалтын үйл явцууд орно.

Системийн дараагийн үзүүлэлт нь бүтэц юм. Бүтэц гэдэгт системийн бүрэлдэхүүнийг харуулсан бүрэлдэхүүн хэсгүүдийн тодорхой харилцан холбоо, харилцан байрлалыг ойлгоно. Бодит системүүд дэх элементүүдийн байрлалын журам, элементүүдийг тодорхой байдалд хүргэх ажиллагаанууд, системийн чиглэсэн өөрчлөлтийн үйл явц системийн зохион байгуулалт мэт тийм үзүүлэлтэд тусгалаа олдог.

Судалгаанаас үзэхэд “аюулгүй байдал”-ын хамгийн ерөнхий ухагдахуун³⁵ харилцан хамаарал бүхий гурван төлөв байдлыг илэрхийлж байна. Үүнд:

1. аюулаас ангид, өөрөөр хэлбэл аюул байхгүй байдал;
2. аюулаас хамгаалагдсан байдал;

³⁵ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х., ШУА., УБ., 2008, 2650 х., т.2269. “Ухагдахуун- ухахад өртөх юм, мэдэгдэхүүн, хэрэг бодосын мөн чанарын ерөнхий онцлогийг тусгадаг сэтгэхүйн хэлбэр; ухагдахууны багтаамж-ухагдахууны агуулгад хамаарах шинж бүхий юмсын олонлог; логикийн ухагдахуун-тухайн ангийн юмс, үзэгдлийг тэдгээрийн ерөнхий, нийтлэг өвөрмөц шинжээр нь нэгтгэж дүгнэсэн санаа; философийн ухагдахуун-юмс, үзэгдлийн гол шинж, холбоо харилцааг тусгасан сэтгэхүйн хэлбэр; хэлний ухагдахуун-үгийн ахуй амьдралтай холбоотой хүний сэрэлд буух ойлголт; ойлголт ухагдахуун-юмс үзэгдлийн талаарх ерөнхий төсөөлөл, мэдэгдэхүүн.”

3. хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал.

Эхний төлөв байдлыг хэл шинжлэлийн философи утга талаас өгсөн тодорхойлолтын өнцгөөс авч үзвэл: *нэг талаас* “аюулгүй-аюул байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй; аюулгүй байдал-осол, түгшүүргүй байх төлөв”³⁶ гэж зөвхөн аюул байхгүй байдлыг илэрхийлсэн бол *нөгөө талаас* “аюулгүй байдал-аюул байхгүй, бүтэн байлгах, найдвартай байдал”³⁷ гэж аюул байхгүй, хамгаалагдсан байдал, хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал зэргийг аль алинийг нь багтаасан илүү өргөн цогц хүрээгээр илэрхийлэгдэж байна.³⁸

Судалгаанаас үзэхэд 1970, 1980-аад оны эдийн засаг, байгаль орчны талаарх шинэ санаачилгууд, 1990-ээд оны үндэстэн дамнасан гэмт хэргийн талаарх асуудлууд нь аюулгүй байдлыг дахин тодорхойлох, үндэсний аюулгүй байдал болон үндэстэн дамнасан үйл явдал, хөгжил хоорондын уялдаа холбоонд анхаарах шаардлагыг бий болгожээ.

XXI зуун хүн төрөлхтний амьдрахын төлөөх тэмцлийн үе шат байх нь ойлгомжтой болсон. Яагаад гэвэл өнгөрсөнд ер нь зөвхөн гадаад ба дотоод, хамтын, цэргийн аюулгүй байдлын тухай ярьдаг байсантай харьцуулбал одоо түүний эдгээр төрлүүд дээр эдийн засгийн, экологийн, хүн ам зүйн, хүнсний, мэдээллийн ба бусад аюулгүй байдлын асуудал нэмэгдсэн. Анх 1983 онд Барри Бузан “Ард түмэн, улс орнууд ба айдас” бүтээлдээ ***уламжлалт аюулгүй байдлын ойлголт халагдаж, орчин цагт аюулгүй байдал нь цогц ойлголт болсон*** гэж үзсэн³⁹ нь уламжлалт бус аюулгүй байдлын ойлголт болон аюулгүй байдалд хандах хандлагын өөрчлөлтийн үндсийг тавьсан бөгөөд түүний аюулгүй байдлын цогц ойлголтын онол (Security complex theory)-ын дагуу цэрэг, улс төрийн хүчин зүйлээс гадна нийгэм, эдийн засгийн, экологийн, мэдээлэл технологийн хүчин зүйлс нь аюулгүй байдлыг цогцоор тодорхойлдог болсон. Түүнчлэн Хятадын судлаач Ван Изоугийн “***бараг бүхий л ээдрээтэй асуудлууд энэхүү уламжлалт бус аюулгүй байдлын сагсанд багтаж болох юм шиг байна***”⁴⁰ гэж тэмдэглэсэн бол Хятадын эрх баригчид болон эрдэмтэн, профессорууд “дэндүү олон янзын шаардлага бүхий уламжлалт бус аюулгүй байдлын аюул заналыг шийдвэрлэх эсвэл багасгахын тулд эн тэргүүнд хийх зүйлийг тодорхойлох нь маш бэрхшээлтэй, бас ашиглаж болох эх сурвалж нь харьцангуй хязгаарлагдмал”⁴¹ хэмээн уламжлалт бус аюул заналуудын өргөн хүрээ, тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Дээрх хувьсал өөрчлөлтийн үр дүнд үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголтыг улам өргөжүүлж, “Хүний аюулгүй байдал”-ын асуудлыг авч үзэх болсон байна. Аюулгүй байдлын талаарх уламжлалт бус асуудлуудыг нэгтгэн “хүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёонд багтаах болсон. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь хувь хүний аюулгүй байдалд төвлөрөх ёстой гэж үзэх болсон. Энэ нь төр төвтэй үзэл

³⁶ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г., ШУА., УБ., 2008, 594 х., т.176.

³⁷ Далийн тайлбар тольд байгаа ухагдахууны “бүтэн байлгах” гэдгийг хамгаалагдсан байдал, найдвартай байдал гэдгийг тогтвортой хөгжлийн ойлголттой дүйцүүлэн тайлбар хийсэн болно.

³⁸ Энд –бүтэн байлгах” гэдгийг хамгаалагдсан байдал, “найдартай байдал” гэдгийг хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал гэдгээр тайлбар гаргалгаа хийсэн болно.

³⁹ Barry Buzan. People, States, and Fear: The National Security Problem International Relations. Wheatsheaf Books, 1983 Barry Buzan. Ole Waver. Jaap de Wilde. Securit: A New Framework for Analyses. Lynne Rienner Publishers.1998

⁴⁰ Wang Yizhou, China Facing Non-Traditional Security: A report on Capacity Building., In Ralf Emmers, Mely Caballero-Anthony and Amitav Acharya. Eds., Studying Non-Traditional Security in Asia: Trends and Issues (Singapore: Marshall Cavendish, 2006), pp. 58-81, 60-61

⁴¹ Wang Yizhou, Defining Non-Traditional Security and its Implications for China., China and World Economy (Beijing) 12, no.5 (September-October 2004), p.60.

баримтлалаас татгалзсан эрс өөрчлөлт байв. Хүмүүсийн сайн сайхны төлөөх хамгийн том аюул бол харь орны цэрэг, арми бус харин эдийн засгийн уналт, улс төрийн дарангуйлал, бүтээгдэхүүний хомсдол, хэт их хүн ам, үндэстэн хоорондын өрсөлдөөн, байгалийн гамшигт үзэгдэл, терроризм, гэмт хэрэг, өвчин гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч эхэлжээ. Түүнчлэн ажилгүйдэл, өсөлтийн удаашрал зэрэг эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн тааруу байдал нь эргээд цэрэг, армийн чадавх сул байхад нөлөөлнө гэж үзэх хандлага ч давамгайлах болсон. Үндэсний аюулгүй байдлын хүний аюулгүй байдалд илүү анхаарсан тайлбар нь эдийн засгийн сул чадавх амьжиргааны түвшин буурах, хүмүүсийн өөрөө өөрийгөө бие даан авч явах чадварыг сулруулна гэж үздэг.

Олон улсын байгууллага болон улс орнууд аюулгүй байдлын орчны өөрчлөлт, хандлагыг зөвхөн цэргийн аюулгүй байдлын өнцгөөс харах нь өрөөсгөл, учир дутагдалтай болсон бөгөөд уламжлалт бус аюул занал тулгамдсан асуудал болж, түүнд хамаарах хүчин зүйлсийн тоо улам өсөн нэмэгдэж байгааг харуулсан байна.

Нэгдсэн ойлголтын суурь үндэс аюулгүй байдал нь: *нэгд*, дэлхий нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудал нь бүх хүн төрөлхтнийг бүхэлд нь хамарсан аюул заналд сөрөн зогсох тухай асуудал бөгөөд улс төвтэй бүс, улс дамнасан олон улсын харилцааны хүрээнд яригдаж байгаа аюулгүй байдлын асуудал;⁴² *хоёрт*, олон улсын болон бүсийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлыг улс хоорондын харилцаагаар хангах тухай асуудал;⁴³ *гуравт*, хүний аюулгүй байдал нь шинэ үзэл хандлага бөгөөд хувь хүнийг цэргийн болон цэргийн бус аливаа аюул занал, эрсдэл, айдсаас хамгаалах, өндөр чанартай амьдралын нөхцөлөөр хангах, хувь хүний иргэн, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах тухай улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлыг цогцоор нь багтаасан ухагдахуун⁴⁴ болох зэрэг ойлголтын цогцоор илэрхийлэгддэгт оршиж байна.



1.1 дүгээр зураг. Аюулгүй байдлын түвшингийн хамаарал

Эх сурвалж: “Олон улсын харилцааны үндэс ба ДАЯАРШИЛ” бүтээл

Эндээс дүгнэлт хийхэд: *нэгдүгээрт*, “аюулгүй байдал” гэсэн категори буюу ухагдахуун нь “аюул”, хамгаалалт”, “хөгжил” гэсэн түгээмэл нийтэд хамааралтай ухагдахуунуудыг агуулж байна; *хоёрдугаарт*, “аюулгүй байдал” ухагдахуун нь тодорхой нэр томъёоны ойлголтын агуулга, хэрэглээ талаасаа тухайлбал, “тодорхой объектын

⁴² Al-Rodhan Nayef.R.F. The Five Dimentions of Global Security:Multi-sum Security Principle,Berlin, 2007

⁴³ Г.Баасанхүү Олон улсын аюулгүй байдлын загваруудын түүхэн хөгжил, харьцуулалт\ Стратеги судлал 2006, №4, х. 89-100

⁴⁴ “Современные международные отношения” под ред. А.В.Торкунова и А.В.Мальгина, М.,2014, с.544

аюулгүй байдал”, “үндэсний аюулгүй байдал”, “олон улсын аюулгүй байдал” гэх зэргийн хувьд илүү оновчтой, бодит байдлыг тусгасан шинж чанартай байх шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын үндсэн суурь ухагдахуун, тодорхой нөхцөл байдалд хамаарах түүний ойлголт хоёрын хоорондох зааг ялгааг ойлгож хэрэглэх ёстойг харуулж байна. Тиймээс аюулгүй байдал судлалын үүднээс түүний суурь ойлголтын аппаратыг үндсэн ухагдахуун болон түүний хэрэглээний ойлголт талаас нь: ухагдахууныг хэл шинжлэлийн үүднээс, ойлголтын агуулгыг үзэгдэл, үйл явдал, үр дүн тайлбар гаргалгааны өнцгөөс авч үзэх шаардлагатай юм.

“Аюул” гэсэн үг буюу ухагдахууныг хэл шинжлэлийн хувьд “гамшиг зовлон учруулж болох хор хөнөөл, гай”⁴⁵ гэж мөн чанарыг нь илэрхийлсэн байдаг. Харин ойлголт хэрэглээ талаас нь авч үзвэл “Аюул-хүн амын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааг тасалдуулах эсвэл хүрээлэн буй орчинг доройтуулах ноцтой үйл явдал, үзэгдэл, эсвэл хүний үйл ажиллагаа юм. Аюулд ирээдүйд гамшиг учруулах нуугдмал нөхцөл байдал хамрагдаж болох бөгөөд янз бүрийн гаралтай: байгалийн (геологийн, ус, цаг уурын, биологийн) эсвэл хүний үйл ажиллагаанаас үүссэн (хүрээлэн буй орчны доройтол, технологийн аюул) байж болно”⁴⁶ гэж олон улсын хамтын нийгэмлэгээс тодорхойлсон байна. Түүнчлэн манай зарим судлаачдын бүтээл⁴⁷ болон хуулинд⁴⁸ ойролцоо томъёолол өгөн шинжлэх ухааны эрхзүй, онолын эргэлтэд оруулсан байна.

“Хөгжил” гэсэн категори буюу ухагдахууныг хэл шинжлэлийн хувьд “давшил, дэвшил, цэцэглэл, бадрал”⁴⁹ гэж мөн чанарыг нь илэрхийлсэн. Ойлголтын агуулгын хувьд их өргөн хүрээтэй тайлбар гаргалгаа шаардаж байж аюулгүй байдлыг хангах асуудлын агуулгатай холбогдоно. Хөгжил – тодорхой материаллаг объектыг үүсэхэд эсвэл тэдгээрийг чанарын шинэ байдалд, эсвэл бүтэн өвөрмөц систем болох зарчмын шинэ объект рүү хөтөлсөн эргэлтгүй, чиглэлтэй, зүй тогтолтой өөрчлөлт юм. Зөвхөн эдгээр гурван шинж гурвуулаа байгаа нь бусад өөрчлөлтөөс хөгжлийн үйл явцыг ялгадаг. Энэ нь өөрчлөлтийн харих чанар (хуучин байдалдаа орох) нь үйл ажиллагааны үйл явц, өөрөөр хэлбэл функцийн байнгын системийн мөчлөгийн нөхөн үйлдвэрлэл; сүйрлийн төрлийн санамсаргүй үйл явцын шинжтэй зүй тогтлын байхгүй байдлыг тодорхойлно. Харин зорилгын чиглэл байхгүй үед – өөрчлөлт хуримтлагдаж чадахгүй бөгөөд хөгжлийн хувьд үйл явц нэгдмэл, дотоод харилцан холбооны замын (траекторын) шинжээ алдана⁵⁰. Аливаа объектын хөгжлийн ойлголт бол үр дүнд нь тухайн объектод байгаа бүх тал, шинж, төрх, холбоо, харилцаа илүү бүрэн дүүрэн илрэх түүний тийм өөрчлөлт юм.

⁴⁵ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г., ШУА., УБ., 2008, 594 х., т.175.

⁴⁶ Гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ. УБ., 2016, 58 х., т. 4.

⁴⁷ О.Үржин, П.Цэдэв Гамшгаас хамгаалах үндэс /Ажилтан албан хаагчдад зориулав/. УБ., 2017, 163 х. “Байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн доройтол, хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, мал амьтан хорогдох, эд хөрөнгө сүйрэх, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй аливаа үзэгдэл, тохиолдол, хүний буруутай үйл ажиллагаа зэргийг аюул гэнэ”.

⁴⁸ Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2003, заалт 4.1.5. ““Аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг хэлнэ”

⁴⁹ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х., ШУА., УБ., 2008, 2650 х., т.2597.

⁵⁰ Философский энциклопедический словарь. М., 1983. С. 516.

Аюулгүй байдлын ерөнхий онолын үүднээс авч үзвэл хөгжлийн үүрэг болон аюулгүй байдлын хангалт хоёр өөрийн мөн чанар болон агуулгаар үргэлж эсрэг чиглэлтэй байдаг. Хөгжил нь нийгмийн үйл ажиллагааны бүхий л хүрээнд байнгын өргөжилт, шинэчлэл, инновацыг шаардана. Харин аюулгүй байдал нь байгаа тогтвортой байдлыг хадгалж, аливаа төрлийн ялангуяа эрсдэлтэй шинэ санаануудыг хязгаарлахыг шаарддаг. Гэсэн хэдий ч нийгмийн идэвхтэй ажиллагааны эдгээр хоёр чухал функц өөр хоорондоо нягт холбоотой бөгөөд зарчмын хувьд нэг медалийн хоёр тал учраас салангид хэрэгжиж чадахгүй. Тиймээс хөгжил болон аюулгүй байдлын хоорондох бодит харилцан холбоо ээдрээтэй диалектик шинжтэй байдаг.

Аюулгүй байдал болон хөгжил хоёрын харилцан холбооны энэхүү ээдрээтэй диалектик шинжийг илэрхийлж буй аюулгүй байдлын чухал ухагдахуун бол “эрсдэл”⁵¹ юм [О.Ү]. Ойлголтын хувьд эрсдэлийн талаар одоогоор бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй бөгөөд түүнийг аль салбарт хэрэглэж байгаагаас шалтгаалаад олон янзаар тодорхойлогддог байна. Тухайлбал, эрсдэлийг хамгийн ерөнхий утгаар нь “Эрсдэл зорилтыг тодорхой бус (аливаа тохиолдол, түүний үр дагавар болон тохиолдох магадлалын талаарх ойлголт, мэдлэгтэй холбоотой мэдээлэл зарим нэг талаар хангалтгүй байх) болгож байгаа үр нөлөө (хүлээгдэж буй үр дүн хазайх)”⁵², “эрсдэл бол объект дэх тодорхой бус нөлөөлөл”⁵³ гэсэн тодорхойлолтыг дэлхийн 30 гаруй орны олон салбарт хэрэглэдэг болохыг зарим бүтээлд онцолсон бол “*эрсдэл нь аюул учрах магадлал түүнээс үүсэх сөрөг үр дагавар*”⁵⁴ гэсэн тодорхойлолт бас байна.

Эрсдэл судлалын үүднээс аюулгүй байдал ба хөгжлийн харилцан холбооны зохицуулалтыг нөхцөлдүүлсэн синергетикийн үйл явцын хоёр тодорхой баримтын жишээ бол *нэгд*, “эрсдэлгүй амьдрах” гэсэн бүтэцгүй оролдлогоос татгалзаж “эрсдэл дунд амьдарч сурах” асуудал дэвшигдэж, үр дүнд нь аюулгүй байдлыг хангах систем дэх эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулах удирдлагын параметрийг өөрчлөх замаар тогтвортой хөгжлийг хангах хэрэгцээ, шаардлага бий болсон; *хоёрт*, аюулгүй байдлыг хангах системийн хүрээнд дэлхийн нийтээр хамтын хөгжлийн механизмыг бий болгох эхлэл тавигдаж, үр дүнд нь: Бразилийн нийслэл Рио де Жанейро хотноо 1992 онд болсон “Хөгжил, хүрээлэн буй орчин” сэдэвт дэлхийн бага хурлаар “Тогтвортой хөгжил” загварыг баталсан явдал юм.

Аюул заналын геополитик, соёл иргэншлийн шинж чанар

Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, ойрын ирээдүйн төлөв байдлыг урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болсон ба олон улсын хамтын ажиллагаанд олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг хангах, олон улсын харилцаа геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг хадгалах явдал тулгамдсан асуудал болсон байгааг болон хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих

⁵¹ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я., ШУА., УБ., 2008, 3278 х., т.3211. Эрсдэл-эрсдэх үйлийн нэр, эрсдэл багатай-эрсдэх нь бага, эрсдэлтэй-эрсдэл ихтэй.

⁵² Эрсдэлийн менежмент – Зарчим ба заавар. MNS ISO 31000:2011

⁵³ Судалгааны ажлын эмхэтгэл 2015. ОБЕГын дэргэдэх гамшиг судлалын хүрээлэн. УБ., 2015, 272х., т. 9.

⁵⁴ Д.Сэржмядаг Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. УБ., 2017, 206 х., т.16

гэдэг маш чухал болсныг доктор Д.Уламбаяр⁵⁵ тэмдэглэсэн байгаа нь аюулгүй байдлын систем дэх бас нэг онцлог хүчин зүйл юм.

Улс орнуудын гадаад бодлогын чиглэл нь хэрэгжих орон зайгаараа дэлхийн хэмжээний, эх газрын хийгээд хэсэгчилсэн буюу дэд бүс нутгийн, бүс нутгийн гэсэн геополитикийн орон зайд хэрэгжиж байна.

Өнөө үед цагаачдын урсгал жилээс жилд нэмэгдэж байгаа болон олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагаа өргөжин тэлснээр дэлхийн геополитикт ихээхэн өөрчлөлт гарлаа. Хамгийн гол нь дайн, түрэмгийллийн аргаар шинэ газар орныг эзэмдэх эрмэлзэл хумигдаж, орчин үед эдийн засгийн аргаар дагавар, дайвар нутаг орныг олж авах шинэ арга бий болж хөгжсөөр байна. Шинэ аргыг хэрэгжүүлэхэд даяаршил, хамтын ажиллагаа эергээр үйлчилж эхэллээ. Ийм учраас даяаршил хамтын ажиллагааны явцад бий болсон гадаадын сөрөг нөлөөллийг бууруулах асуудал улс орнуудын өмнө тулгарах болов. Тиймээс “Геополитикийн аюулгүй байдал” гэдэг шинэ томъёо бий болж, түүнийг “Үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг олон улсын аюулгүй байдлын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд найдвартай хадгалан хамгаалах, бусад орон, улс орнуудын улс төр, эдийн засаг, цэргийн эвсэл холбоотой найрсаг харилцаа хамтын ажиллагаатай байх болон гадаад ертөнцөд тодорхой хэмжээгээр нөлөө бүхий байр суурь эзлэх нөхцөл бололцоог олгосон, олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдсөн, өөрийн гэсэн геополитикийн өндөр статус, нэр хүндтэй байх улс орны чадамжийг геополитикийн аюулгүй байдал гэнэ” хэмээн тодорхойлох нь нэлээд түгээмэл тохиолддог болсныг эрдэмтэн судлаач Д.Мягмар өөрийн бүтээлд⁵⁶ онцолсон нь аюулгүй байдлын систем дэх бас нэг онцлог хүчин зүйл мөн.

Аюулгүй байдлын систем дэх геополитикийн аюулгүй байдлын ойлголтын аюул заналын эрчимтэй өөрчлөлттэй уялдсан өргөжилтийг дараах агуулгаас харж болно.⁵⁷ Үүнд:

- Улс орны аюулгүй байдалд хамаарах геополитикийн хүчин зүйлст тухайн улс орны газар зүйн байршил болон эдийн засаг, улс төрийн хийгээд төр улс, нийгэм хүн ардын нууцлаг, хаалттай байх онцлог хүчин зүйлс хамаарах бөгөөд эдгээр нь тухайн улс орны аюулгүй байдлыг сэргийлэн хамгаалах нийгэм, улс орон, хүн амын эрх ашиг сонирхлыг тусган илэрхийлнэ.
- Геополитикийн аюулгүй байдалд дараах нийтлэг асуудлуудын онцлог, мөн чанарыг хамааруулна. Үүнд:

а. Дэлхий дахины болон тухайн тив, бүс нутгийн улс орнуудын нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцоо, тэдгээрийн хувьсал өөрчлөлт;

б. Дэлхий дахины болон тухайн тив, бүс нутгийн орнуудын хоорондын байдал, түүний хувьсал өөрчлөлт, улс хоорондын болон олон улсын чанартай байгууллагуудын үйл ажиллагаа, цаашдын чиг хандлага;

⁵⁵ Д.Уламбаяр “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын орчны хувьсал, судалгаа, дүн шинжилгээ”. ХСИС., Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд. ЭШХ-ын эмхэтгэл. УБ., 2016, х. 20-31

⁵⁶ Д.Мягмар “Геополитикийн аюулгүй байдал Монгол Улсад хамаарах нь”. ХСИС., Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд. ЭШХ-ын эмхэтгэл. УБ., 2016, х. 5-11

⁵⁷ Г.С.Вечканов Эдийн засгийн аюулгүй байдал. УБ., 2011, 214 х., т. 17-18

в. Тив, бүс нутгийн улс орнуудын зүгээс баримталж ирсэн тухайн үеийн улс үндэсний улс төр, эдийн засгийн хүрээний хуваарилалт, аль нэг орны улс үндэсний гадаад бодлого, түүний хүрээ хязгаар;

г. Тухайн бүс нутгийн орнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, энх тайван, хөршийн харилцаа ямар түвшинд байсан ба байсаар байх төлөв байдал;

д. Тухайн улс орны оршиж буй тив, бүс нутгийн хэмжээний бүсчлэл, түүний чиг хандлага, хамрагдах улс орнуудын эзэлж буй орон зай, нөхцөл боломж, онцлог, тухайн улс орон, бүс нутаг дэлхий дахины бүсчилсэн хийгээд даяаршил, дэлхийжилтийн үйл явцад ямар хамааралтай байж болох зэрэг асуудлуудыг оруулсан байна.

Дэлхийн геополитик буюу “газрын бодлого”-ын талаар ярьж байгаа учраас Европын геополитикийн онолыг Европын соёл, иргэншилтэй холбон тайлбарлах хэрэгтэй. Энд Германы геополитикч Фридрих Ратцель өөрийн “Улс төрийн газар зүй” гэдэг бүтээлдээ орон зайн өсөлтийг улс орны хөгжилтэй холбон авч үзсэнийг онцлон тэмдэглэх шаардлагатай юм. Түүний онолоор бол улс орон бүр өөрийн газар нутагтай бие, сэтгэлийн холбоотой байдаг ба тэрээр дараах долоон зүй тогтлыг дэвшүүлжээ Үүнд: *нэгд*, улс орны орон зай нь соёлын хөгжилтэй хамт өсч байдаг; *хоёрт*, улс орны өсөлт нь хөгжлийн бодлого, худалдаа, идэвх санаачилга, бусад салбарын хөгжилтэй нягт холбоотой; *гуравт*, улс орны өсөлт нь жижиг орныг залгих, өөртөө нэгтгэх замаар өсдөг; *дөрөвт*, улсын хил бол түүний өсөлт, хүч чадал, сул дорой байдлыг илтгэх байгууламж; *тавд*, улс орнууд орчин тойрноосоо хамгийн ашигтай зүйлийг өөртөө шингээхийг оролддог жишээ нь байгалийн баялаг, ашигт малтмал, газар нутаг, хөлөг онгоц зогсох боломжтой далайн эрэг, гол мөрний голдирол гэх мэт; *зургаад*, гаднаас орж ирж байгаа өндөр соёл иргэншил нь буурай хөгжилд түлхэц болдог; *долоод*, улс орны хүчин чадал өсөхийн хэрээр бусад улс орныг дагуулан татах хүч нь нэмэгддэг гэж тэрээр үзсэн байна. Том орон зай амьдралыг илүү сайн тэтгэдэг гэж тэр үзээд ХХ зуунд том газар нутагтай Хойд Америк, Орос, Австрал, Өмнөд Америкийн орнууд илүү хурдан хөгжинө гэсэн таамаглал дэвшүүлж байжээ. Тэрээр мөн Номхон далайд гарцтай орнууд ирээдүйд хөгжлөөр давамгайлна гэсэн ба улс орон сулрах нь түүний орон зайн мэдрэмж суларсны шинж гэж тэр үзжээ.

Америкийн улс төрч эрдэмтэн З.Безжинский Евразийг холбож Атлантын далайгаас Оросын нутгаар дайран Номхон дөлгөөн гадаад далай хүрч байгаа геополитикийн шугам, түүн дээгүүр урсаж байгаа Атлантизм хэмээх улс төр, эдийн засаг, соёл, иргэншлийн урсгалыг⁵⁸ зөвхөн өрнөөс дорно зүгт урсана гэж хэлсэн байдаг. Амьдрал дээр орчин цагт сөрөг урсгал гарч ирсэн. Энэ нь хятад хүний нүүдэл юм. Энэ нь Төв Азийн орнууд болон Оросоор дамжин Европод нөлөөлөх их гүрний бодлого хэрэгжиж байгаагийн илрэл юм.

Аливаа хүчирхэг гүрэн, дэлхийн бодлогыг тодорхойлогч их гүрнүүд түүхэн тодорхой үед олон улсын харилцааг тодорхойлж байхдаа өөрийн соёл иргэншлийн хэм хэмжээнд бусдыг тэнцүүлэх, бусад улс орныг уях бодлого явуулсаар ирсэн. Өнөө үеийн том орнуудын геополитикийн бодлого нь улс төр, эдийн засгийн нөлөөлөл тогтоох, цэргийн стратегийн давуу байдал бий болгоход чиглэгдэж байна. Хүний шилжилт суурьшилтын

⁵⁸ Атлантизмын урсгал нь үндсэндээ Европын соёл, боловсрол, иргэншил, эдийн засаг, хөрөнгө санхүү, үйлдвэр, аж ахуй, амьдралын хэв маягийг хэлж байна.

асуудал “хүн ам зүйд нь нөлөөлөх” хүчин зүйл учир эдийн засгийн нөлөөлөл тогтооход хамаарагдана.

Геополитик нь өнөө үед дараах байдлаар салбарлан хөгжих болсныг эрдэмтэн судлаачид тодорхойлсон байна: уламжлалт геополитик - улс үндэстэн оршин тогтнохуйн төлөө тэмцэл, шинэ геополитик буюу гео-эдийн засаг - энэ нь эдийн засгийн хувьд оршин тогтнохуйн төлөө тэмцэл, шинэхэн геополитик буюу гео-философи - энэ нь соёл иргэншил, оюун санаагаа хадгалахуйн төлөө тэмцэл тус тус болно.⁵⁹

Монголын аюулгүй байдлын гадаад орчинд геополитикийн далд өрсөлдөөн байсаар байна. Геополитикийн тодорхой үзэл баримтлалтай байж, түүнийгээ улс төр, батлан хамгаалах үйл ажиллагаандаа баримтлах нь холч, мэргэн, төрийн гадаад бодлого явуулах нөхцөл мөн. Хоёр хөршийн бодлого: Орос Ази, Европ, Африкийн агаар, мандлын орон зайг хяналтдаа авсан, Хятадын хүн ам нутгаасаа хальж Ази, Европ, Америк тивийг дүүргэх хандлагатай байна. Энэ хандлага Монгол Улсын хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй байна. Хөрш гүрнүүд нийгмийн хөгжлийн өндөр түвшинд хүрч, дэлхийд тэргүүлэх цэргийн хүчин чадалтай болохын төлөө өрсөлдөж байна. Энэ өрсөлдөөний гол зорилго нь бие биеэсээ өрсөн дэлхийн өнцөг булан бүрд стратегийн давуу байдал бий болгоход оршиж байна. Дэлхийн аль нэг газар нутагт стратегийн давуу байдал бий болгосноор тухайн бүс нутгийн орнуудад “нөлөөлөл” бий болгох үндэс тавигдана.

Геополитикийн онолчид “газрын бодлогын “ салшгүй хэсэг бол улсын хил хязгаар, аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхол гэж номлодог. Тийм учраас Монголын геополитикийн гадаад орчныг мөн энэ өнцгөөс харах нь зүйтэй юм. “Түүхэн хөгжлийн явцад эдийн засаг, нийгэм, соёл иргэншил, шашин зэрэг хүчин зүйлүүд өөрчлөгдөж, газар нутаг хэвээрээ үлддэг” гэсэн ойлголт өнөө үед бүдгэрч байна. Орчин үед газар нутаг ч үгүй саармагжсан үндэстэн үлдэх магадлал улам өндөр болсон. Дэлхийн улс орны 95 орчим хувь нь олон үндэстэн ястнаас бүрдсэн байдаг. Энэ нь олон зууны тэртээгээс хөгжилтэй нь дорой буурайгаа нэгтгэх замаар улсаа томруулж, нутаг дэвсгэрээ тэлсний үр дүн юм. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи 40 жилд 120 гаруй зэвсэгт мөргөлдөөн үүссэнээс 100 шахам нь үндэстний зөрчлөөс улбаатай байсан агаад 36 сая хүн дүрвэж, олон сая хүн амь насаа алдсан байна.

Стратегийн ач холбогдол бүхий чухал газар нутаг, орон зайн төлөөх дэлхийн том гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр зах зээл, соёл иргэншлийн орон зайн дахин хуваарилалтын утга агуулгатай болж, дэлхий нийтийг бүхэлд нь хамрах, улам бүр хурцдах төлөвтэй байгаа нь аюул заналын геополитик, соёл иргэншлийн шинж чанарыг нөхцөлдүүлж буй гол үндэс болж байна. (Шигтгээ-3⁶⁰⁽¹⁾).

⁵⁹Удирдлагын Академиас хэвлүүлсэн "Нээлттэй лекц: 2016-2017 оны хичээлийн жил", УБ ,2017 эмхтгэлд хэвлэгдсэн лекц

⁶⁰ “Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа.” Үнэлгээ ба таамаглал. ШУТ-ын төсөлт ажлын тайлан. УБ., 2012, 310 х., т.7

ШИГТГЭЭ-3

Монгол Улсын геополитик, соёл иргэншлийн онцлог: 2 их гүрний хооронд, 3 том иргэншлэлийн дунд, далайд гарцгүй байршилтай. Том газар нутагтай (дэлхийн газар нутгийн 1-ээс илүү хувь). Байгалийн баялаг ихтэй боловч түүнийгээ дангаар ашиглах чадваргүй. Хүн ам цөөн. Үндэс угсаа, хэл, соёл иргэншил аль ч талаас авч үзсэн аливаа соёл иргэншил, бүлэглэлээс гадуур сондгой орон. Иймд Монгол Улсын Ази тивийн геостратегийн чухал түшиц нутаг, өрнө, дорнын соёл иргэншил, их гүрнүүдийн геополитик, эдийн засаг, цэрэг-стратегийн ашиг сонирхлын уулзвар, улс төр, нийгмийн эсрэг тэсрэг тогтолцооны болон дэлхийн том шашнуудын нөлөөллийн зах нийлсэн байдал нь монголын ард түмний хувь заяанд хүчтэй нөлөө үзүүлж, зарим тохиолдолд эмгэнэлт явдал хүргэж байсан удаатай. Өнөө үед манай улсын эзэлж буй геополитикийн орон зай дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирах магадлал мэдрэгдэж байна.⁽¹⁾

Аюулгүй байдалд даяаршлын үзүүлэх нөлөөлөл

Аюулгүй байдлын анхаарал татсан асуудал бол даяаршил юм.

Даяаршлын гол тулгуурууд нь эдийн засаг (гадаад худалдаа, капитал, хөрөнгө оруулалт, үндэстэн дамнасан корпорацууд өргөжин тэлэх), мэдээллийн сүлжээ, шинжлэх ухаан-технологи байна.

Даяаршил дан ганц эерэг талуудыг бий болгохгүй бөгөөд Эрнандо дэ Сатогийн хэлсэнчлэн "... даяаршил бол хоёр үзүүрт зүү юм"⁶¹ гэснийг үндэс болговол түүний сөрөг тал, эргүүлгэд нь зүг чигээ алдахаас сэргийлэх шинжлэх ухааны болоод төр засгийн чадвар нэн чухал юм. Үнэхээр даяаршил нь дэлхийн хөгжилд эерэг давуу тал ба сөрөг зөрчилтэй байдлын аль алиныг нь бий болгох замаар аюулгүй байдалд нөлөөлж байна.

Даяаршлын давуу талууд:

- Олон улсын шинжтэй өрсөлдөөн улам бүр хурцдаж байна. Үр дүнд нь зах зээл өргөжин тэлж, олон улсын хөдөлмөрийн зах зээлийн төрөлжих ба дагнах үйл явцыг хурдасгаж, энэ нь зөвхөн үндэсний хэмжээнд ч бус дэлхийн түвшинд бүтээмж хурдан өсөх угтвар нөхцөл болсон.
- Зохих үйлдвэрлэл, үйлчилгээг буй болгох хөдөлмөр, түүхий эдийн зарцуулалтыг бууруулж үр дүнд нь үнэ буурах, эдийн засгийн өсөлт түргэсэх нөхцөл бүрдсээр байна. Гэвч энэ нь бүх улсуудад хэрэгжихгүй зөвхөн өөрийн эдийн засгийн бүтцийг зохистой өөрчилж чадсан эдийн засгуудад хамаарч буй бөгөөд эдийн засаг нь түүхий эдийн олборлолт, борлуулалтаас ихээхэн хамааралтай орнуудад сөрөг үйлчлэл үзүүлж буйг ихэнх судлаачид хүлээн зөвшөөрч байна.
- Хүйтэн дайны үед тэргүүний техник, технологийн шилжилт, түүнийг ашиглах явдал харьцангуй хязгаарлагдмал байсан бол даяаршлын үед технологийг нэвтрүүлэх

⁶¹ Эрнандо дэ Сато. Капиталын нууц. УБ., 2004, т.3

нөхцөл эрс өөрчлөгдөж, үр дүнд нь хөдөлмөрийн бүтээмж эрс нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг түргэсгэх нэгэн эх сурвалжийг бүрдүүлсэн.

- Даяаршил онолын хувьд түүнд оролцогч бүх талуудад үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, бодит цалин, амьжиргааны түвшинг өсгөх боломж олгож байгаа ч энэ бүхнийг хүртэх боломж харилцан адилгүйн дээр сөрөг талуудыг ч мөн агуулж байна.

Даяаршлын давуу талуудыг улс орны бодлогоос хамаарах бөгөөд түүнээс шалтгаалан зарим тохиолдолд сөрөг хүчин зүйл болж хувирах боломжтой байна.

Даяаршлын сөрөг талууд ба түүнээс үүдэлтэй зөрчлүүд:

- Даяаршлын үр ашиг буюу түүнээс үүдэлтэй орлогын өсөлт, амьжиргааны түвшин нэмэгдэх боломж нэн тэгш бус хуваарилагдаж буй нь зөвхөн үндэсний юм уу оролцогч талуудын түвшнээр зогсохгүй олон улсын хэмжээнд зөрчлийг үүсгэх магадлал ихтэй болсон.
- ХБО (хөгжил буурай орон)-ын эдийн засгийн өсөлт баян орнуудтай харьцуулахад илүү хурдацтай өсөж байгаа нь орлогын ялгааны бууралт нийтлэг болж байна гэж зарим судлаачид, ялангуяа барууны тодорхой улс төрийн хүрээнийхэн үзэж үздэг. Гэвч энэ нь цөөхөн хэдэн орон, зарим бүс нутагт (Азийн барууд, ЗӨА-ийн бүс нутаг) л хамааралтай бөгөөд ХБО-ын хөгжлийн хурдац дээрх улсынхаас ихээхэн доогуур хэвээр байна. Бодит байдал дээр түргэн хөгжиж буй цөөхөн орнууд л баян улсуудын түвшинд ойртож харин олонх буурай улсууд тэднээс улам хоцорсоор байна. Энэ нь сэтгэл ханамжгүй байдал, даяаршлын эсрэг үзэл санааг хөөрөгдөх суурь болоод зогсохгүй эдийн засаг, худалдааны болон санхүүгийн цаашлаад улс төрийн ноцтой зөрчилд хүргэж болзошгүй юм.
- Дэлхийн хэмжээнд улс үндэстнүүдийн эдийн засгийн харилцан хамаарал эрс өргөжсөнтэй холбоотойгоор бүс нутгийн болон даяар хэмжээнд тогтворгүй байдал үүсэх магадлал ихэслээ. Бүс нутгийн эдийн засгийн хэлбэлзэл юм уу хямрал нь зөвхөн тухайн бүс нутгаар тогтохгүй даяар үр дагавар авчирч болохыг сүүлийн үед болж өнгөрсөн олон үйл явдлууд харууллаа. Жишээ нь: Америкийн санхүүгийн хямрал, газрын тосны үнийн хэлбэлзэл, түүнийг тойрсон зөрчлүүдийг энд дурдаж болох юм.
- Тусгаар улс орнуудын засгийн газрууд өөрийн эдийн засгийг хянах боломжоо алдаж, хөгжингүй орнууд, ҮДК (үндэстэн дамнасан корпарац) мөн олон улсын байгууллагуудад энэ эрх мэдэл шилжинэ гэсэн болгоомжлол даяаршлын үйл явцтай уялдан гарах боллоо. Зарим судлаачид даяаршлыг буурай үндэстнүүдийн тусгаар тогтнолд учирч буй заналхийлэл гэж үздэг.
- Буурай улсын Засгийн газрууд шинээр тулгарч буй олон таагүй үзэгдлүүд, тухайлбал, уур амьсгал, экологи г.м., тодорхойгүй байдлын өмнө улам бүр хүчин мөхсөдөж байна.
- Хөгжингүй орнууд юуны өмнө өөрийн эрх ашгийг хамгаалсан бодлогыг олон улсын хамтын нийгэмлэгт тулган хүлээлгэдэг нь энэ хандлагыг улам хөөрөгдөж байна. Энэ үзэл санаа, хандлага нь олон нийтийн дургүйцэл болон туйлширсан үндэсний үзлийг

хөөрөгдөж, улмаар эдийн засгийн протекционизм, улс төрийн хөдөлгөөн, үндэстэн хоорондын болон эдийн засгийн хурц зөрчлүүдийг даамжруулах аюултай.

Эдийн засгийн үр дагаврууд нь даяаршлын нөлөөллийн зөвхөн нэг чиглэл бөгөөд үүний хамт маш олон талтай эрсдэл, зөрчлүүд цаашлаад томоохон хямралт байдалд хүргэх магадлалтай юм.

Бүс нутгийн төдийгүй даяар хэмжээний зөрчлүүдийг (ялангуяа улс төрийн) зүй зохистой, цаг тухайд нь шийдвэрлэхгүй бол тааж хэлэхийн аргагүй, түвэгтэй, аймшигтай үр дагаварт хүргэх аюул тулгараад байна. Үүнтэй холбоотойгоор ядуурал, олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, далд эдийн засгийн өсөлт зэрэг нь зөвхөн улс төрийн болон эдийн засгийн бус, нийгэм, сэтгэл зүйн гүн гүнзгий хөрс суурьтай асуудал гэдгийг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрөх болжээ.

Соёлд даяаршлын үзүүлэх нөлөөлөл өнөөдөр олон давхар утга, олон давхар нүүр царайтай байна. Тухайлбал:

1. Соёлын утгаараа хүн төрөлхтний харилцан хамаарал, шүтэлцээ, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, харилцан мэдээлэл нэмэгдэх үйл явцад нөлөөлж байна.
2. Улс төрийн явцуу утгаар үзвэл дэлхийн олон ард түмний үндэсний ухамсрыг соёл, оюуны довтолгоогоор дарах гэсэн алсын зорилготой их гүрний улс төрийн бодлого, үзэл суртлын зэвсэг болж байна.

Даяаршил нь эерэг ба сөрөг олон үр дагаврыг тээн ирж болзошгүй байна. Даяаршил нэг талдаа хүний хөгжлийн бололцоог өргөтгөж, хөмөрсөн тогоон дотор байгаа мэт хязгаарлагдмал, хоцрогдмол ахуйг үндсээр нь өөрчилж, хүний мэдлэг сэтгэлгээний бололцоог өргөтгөж байна. Нөгөө талдаа хүмүүн өөрөө гүн рүүгээ хөгжих, өөрөө өөрөөрөө байх, өөрийн соёл, улс орны онцлогийг хадгалах, өөрийн чөлөөт сонголт, бодитой эрх чөлөөг хэрэгжүүлэх бололцоог хязгаарлаж байна.

Хүний ухамсарт гадаад мэдээллийн нөлөө, хөтөлбөржилт буюу хөндлөнгөөс өгөгдсөн даалгавар мэт нэгэн загвар, үнэлэмж, онцгой нөлөөтэй “халдвар тараагч вирус” мэт нөлөөлөх үйл явц улам бүр өргөжих болов. Иймд болзошгүй байдлыг тунгаан үзэх шаардлагыг зүй ёсоор төрүүлж байна. (Шигтгээ-4 ⁶² (1)).

“Бүх улс орныг эдийн засгийн харилцан хамаарал тодорхойлж байгаа энэ эрин үед нийт хүмүүс олон төрхөт байдлыг хүндэтгэж, нийтлэг хүмүүнлэг чанарын үндсэн дээр эв нэгдэлд суралцахгүй бол ертөнц цаашид оршин тогтнох бололцоогүй болно” гэж судлаачид дүгнэж байна.⁶³ Мөн хүрээлэн буй орчин болон эрүүл мэндийн асуудлууд нь технологийн эрчимтэй хөгжил, даяаршлаас үүдэлтэй үндэстэн хоорондын хамаарал хүчтэй болсноор экологи, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хохирол улам бүр даамжрах нэгэн шалтгаан болж байна.

⁶² (1) Г.Чулуунбаатар нарын. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013, 499 х., т.185

⁶³ Доклад о развитии человека. 2004, Культурная свобода в современном многообразном мире. С.2

ШИГТГЭЭ-4

Гадаад орнуудаас зориуд бодлогоор хэрэгжүүлж байгаа соёлын нөлөөлөлд манай нийгэм, үүний дотор залуу үе ихээхэн автамхай байна. Үүний нэгэн тод жишээ бол Өмнөд Солонгосын телевизийн олон ангит киногоор дамжуулж байгаа солонгос маяг, хэв загварын нөлөө юм.

Судлаачид нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт эрхэмлэлтэй зарим талаар зөрчилдөж байгаа хэдий ч Монголын соёлд Өрнөдийн үнэт зүйлс нэвтрэх бололцоо бүрдсээр байна. Мөн эрхэмлэлийн тодорхой баримжаалалгүй, тогтсон чиг хандлагагүй хүмүүс ч байгааг тэмдэглээд нийгмийн сэтгэл зүйд үндсэн гурван хандлага бий болсон гэж үзсэн байна.⁽¹⁾

1. “Монголыг монголоор нь байлгах” буюу үндэснийхээ эрхэмлэлийг нээлттэй нийгмийн нөхцөлд ч хадгалан хамгаалах гэсэн хандлага. Энэ хандлагыг баримтлагчид үндэсний гэсэн бүхнээ сэргээн хэрэглэх үзлийг голлон номлодог. Тухайлбал, хуучин монгол бичгийг төрийн бичгийн хэмжээнд сэргээн хэрэглэх, уламжлалт шашин соёлоо төрийн болон үндэсний шашнаар тунхаглан сэргээх үзэл баримтлал зарим улс төрийн намын баримт бичгүүдэд тусч байсан байна.

2. Үндэсний эрхэмлэлээс нийт хүн төрөлхтний үнэт зүйлсийг дээдэлж хөгжүүлэх буюу монголын нийгмийг эрс шийдэмгий баруунжуулах чиглэл. Энэ хандлагыг баримтлагчид өнгөрсөн үедээ нэн шүүмжлэлтэй хандаж, ялангуяа монголийн нийгмийн сүүлийн далан жилийн хөгжлийн ололтыг үгүйсгэж, нийгмийн үнэт зүйлийн тогтолцоонд өрнөдийн нийгмийн үнэт зүйлийг хуулбарлан дагаж мөрдөх чиглэл барьдаг. Тухайлбал тэд латин үсгийг авч хэрэглэх, уламжлалт шашин шүтлэгээсээ татгалзаж, христийн шашныг дэлгэрүүлэхийг хичээдэг.

3. Үндэснийхээ эрхэмлэлийг нээлттэй нийгмийн нөхцөлд дасган зохицуулж, өрнөдийн нийгмийн үнэт зүйлтэй хослуулан хөгжүүлэх чиг хандлага. Энэ хандлагынхан улс орныхоо түүх соёлын уламжлал, цаг үеийн шаардлагыг бодитой мэдэрч ойлгосон хэсэг нь байна.

Олон улсын харилцаа даяаршин, харилцан хамаарал хурдтай гүнзгийрэхийн хэрээр олон улсын аюулгүй байдлын талаарх үзэл хандлага бүх талаар өөрчлөгдөж эхэллээ. Үүнд:

- Цэрэг дайны бус аюул заналд анхаарал хандуулах нь ихсэв. Эхний онцлогт авч үзсэнчлэн аюулгүй байдалд эдийн засаг, санхүү, хүрээлэн буй орчин, мэдээллийн болон цахим орчны асуудал цогцоор хамрагдах болсон.
- Аюулгүй байдлын ойлголтыг өөрчилсөн дараагийн том өөрчлөлт нь шинэ технологийн салбар дахь хувьсгалууд юм. Үр дүнд нь бүрэн эрхгүй тоглогчид аюулгүй байдлын салбарт тоглолт хийх боломжтой болсон. АНУ-д 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр тохиолдсон хэрэг явдал үүний нэг тод жишээ юм.
- Даяаршлын нөлөөгөөр үндэсний аюулгүй байдлыг хангах хүчин зүйлд зөвхөн хил хязгаар, газар нутгийн аюулгүй, бүрэн бүтэн байдал бус боловсрол, шинэ технологийн хөгжил, эдийн засгийн чадавхын хөгжлийг хангах, хар тамхины тархалт, хүний наймааны өсөлт, ДОХ зэрэг халдварт өвчний тархалт зэрэгтэй тэмцэх асуудлыг чухалчлан авч үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Теория системы и системный анализ в управлении организациями: Справочник: Учеб. пособие\ Под ред. В.Н.Волковой. –М.: Финансы и статистика, 2006. –с13
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х., ШУА., УБ., 2008.
3. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г., ШУА., УБ., 2008.
4. Barry Buzan. People, States, and Fear: The National Security Problem International Relations. Wheatsheaf Books, 1983 Barry Buzan. Ole Waver. Jaap de Wilde. Securit: A New Framework for Analyses. Lynne Rienner Publishers.1998
5. Wang Yizhou, China Facing Non-Traditional Security: A report on Capacity Building., In Ralf Emmers, Mely Caballero-Anthony and Amitav Acharya. Eds., Studying Non-Traditional Security in Asia: Trends and Issues (Singapore: Marshall Cavendish, 2006)
6. Wang Yizhou, Defining Non-Traditional Security and its Implications for China., China and World Economy (Beijing) 12, no.5 (September-October 2004).
7. Al-Rodhan Nayef.R.F. The Five Dimentions of Global Security:Multi-sum Security Principle,Berlin, 2007.
8. Г.Баасанхүү Олон улсын аюулгүй байдлын загваруудын түүхэн хөгжил, харьцуулалт\ Стратеги судлал 2006, №4.
9. “Современные международные отношения” под ред. А.В.Торкунова и А.В.Мальгина, М.,2014.
10. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ. УБ., 2016.
11. О.Үржин, П.Цэдэв Гамшгаас хамгаалах үндэс /Ажилтан албан хаагчдад зориулав/. УБ., 2017.
12. Гамшгаас хамгаалах тухай хууль,. УБ., 2003.
13. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Т-Х., ШУА., УБ., 2008.
14. Философский энциклопедический словарь. М., 1983.
15. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я., ШУА., УБ., 2008.
16. Эрсдэлийн менежмент – Зарчим ба заавар. MNS ISO 31000:2011
17. Судалгааны ажлын эмхэтгэл 2015. ОБЕГын дэргэдэх гамшиг судлалын хүрээлэн. УБ., 2015.
18. Д.Сэржмядаг Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. УБ., 2017.
19. Д.Уламбаяр “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын орчны хувьсал, судалгаа, дүн шинжилгээ”.
20. ХСИС., Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд. ЭШХ-ын эмхэтгэл. УБ., 2016.
21. Д.Мягмар “Геополитикийн аюулгүй байдал Монгол Улсад хамаарах нь”. ХСИС., Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд. ЭШХ-ын эмхэтгэл. УБ., 2016.
22. Г.С.Вечканов Эдийн засгийн аюулгүй байдал. УБ., 2011.
23. Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа.” Үнэлгээ ба таамаглал. ШУТ-ын төсөлт ажлын тайлан. УБ., 2012.
24. Эрнандо дэ Сато. Капиталын нууц. УБ., 2004.
25. Г.Чулуунбаатар нарын. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013.
26. Доклад о развитии человека. 2004, Культурная свобода в современном многообразном мире.


1.2 Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс

Аюулгүй байдлын ерөнхий онол нь үндэсний аюулгүй байдлын тогтолцооны онол-үзэл санааны арга зүйн бааз суурь болж өгдөг.

“Үндэсний аюулгүй байдал” гэдэг ойлголтын хувьд хэл шинжлэлийн эхний тайлбар ухагдахуун хүрэлцээгүй юм. Учир нь аюул байхгүй гэдэг ойлголт нь туйлын аюулгүй нөхцөлийг бий болгох боломжийг хэлж байна. Бодит амьдрал дээр үндэсний аюулгүй байдлын хувьд янз бүрийн шинж чанар бүхий аюул занал байсан, байна, байсаар байх болно. Тиймээс “үндэсний аюулгүй байдал” гэдэг ухагдахууныг хэл шинжлэлийн хоёр дахь тайлбар гаргалгааны харилцан хамаарал бүхий гурвалсан утгыг агуулсан цогц өргөн ойлголтоор авч үзэх ёстой юм. Өөрөөр хэлбэл, “үндэсний аюулгүй байдал” гэдэг ойлголт нь абсолют биш, зөвхөн харьцангуй утга санааг илэрхийлсэн ойлголт юм. Иймд аюулгүй байдлын ерөнхий онолын үүднээс “аюулгүй байдал-олон улсын, улс үндэстний, хамт олны, түүгээр ч барахгүй хувь хүний хэмжээнд түгээмэл хэрэглэгддэг ажил, амьдралын амгалан тайван орчин нөхцөлийн тухай ерөнхий ойлголт”⁶⁴ гэсэн тодорхойлолттой санал нийлж болох бөгөөд ийм нөхцөл хангагдсан түвшингөөр үндэсний аюулгүй байдлын түвшин тодорхойлогдоно гэж үзэх хэрэгтэй юм.

“Үндэсний аюулгүй байдал” систем болон түүнийг хангах системийн ойлголтын агуулгыг шинжлэх ухааны танин мэдэхүйн болон системийн хандлагын өнцгөөс *нэгд*, онол арга зүйн тайлбар гаргалгаа хийж; *хоёрт*, үүн дээрээ тулгуурлан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтад ойлголтуудыг хэрхэн тодорхойлсныг авч үзэж болно.

Судалгаанаас үзэхэд үндэсний аюулгүй байдлыг түүнд учирч болох аюул заналын эх үүсвэрийн оршиж байгаа байрлал болон улс хоорондын нутаг дэвсгэрийн хил хязгаартай уялдуулан дотоод ба гадаад аюулгүй байдал гэж ангилдаг байна. Ийм ангилал нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх аливаа үзэл баримтлалын хандлагыг нарийн тодорхой ангилахад үлэмж ашиг тустай байхын зэрэгцээ дотоод болон гадаад аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр, арга зам хоорондоо тэс өөр байдагтай холбоотой юм. Түүнчлэн дотоод, гадаад аюулгүй байдал нь харилцан хамааралтай бие биендээ нөлөөлдөг зүй тогтолтой байна. Үндэсний аюулгүй байдлын ерөнхий бүдүүвчийг 1.2 дугаар зураг дээр харууллаа.



1.2 дугаар зураг. Үндэсний аюулгүй байдлын ерөнхий бүдүүвч

⁶⁴ Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014. 702 х., т.56.

Үндэсний аюулгүй байдлын энэ ерөнхий онолын ойлголтоос түүний систем болон түүнийг хангах үйл ажиллагааны системийг дараах математик бичлэгүүдээр илэрхийлж болно.

Үндэсний аюулгүй байдлын систем:

$$\Sigma S_{Yab}: \{\{S_d\}, \{S_g\}\}, \quad (1.1)$$

Энд,

ΣS_{Yab} - Үндэсний аюулгүй байдлын систем;

$\{S_d\}$ - Дотоод аюулгүй байдлын систем/үндэсний аюулгүй байдлын системийн дэд систем/;

$\{S_g\}$ - Гадаад аюулгүй байдлын систем /үндэсний аюулгүй байдлын системийн дэд систем/;

$\{\{S_d\}, \{S_g\}\}$ -Дотоод болон гадаад аюулгүй байдлын системүүд, тэдгээрийн хоорондын хамаарлыг тооцсон үр дүнгийн төлөв байдлын цогц

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны систем:

$$\Sigma S_{Yabx}: F(\{\{X_{S_d}\}, \{X_{S_g}\}, \{X_{S_d, S_g}\}\}), \quad (1.2)$$

Энд,

ΣS_{Yabx} - Үндэсний аюулгүй байдлыг хангах систем;

$\{X_{S_d}\}$ - Дотоод аюулгүй байдлыг хангах системийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;

$\{X_{S_g}\}$ - Гадаад аюулгүй байдлыг хангах системийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;

$\{X_{S_d, S_g}\}$ - Дотоод, гадаад аюулгүй байдлыг хангах системүүдийн хоорондын харилцан хамаарлын цогц;


$F(\{\{X_{S_d}\}, \{X_{S_g}\}, \{X_{S_d, S_g}\}\})$ - Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн дотоод ба гадаад аюулгүй байдлыг хангах системийн элементүүд хоорондын болон хоёр системийн хоорондын харилцан хамаарлыг тооцох үйл ажиллагааны цогцын үр дүнгийн функц.

Үндэсний аюулгүй байдлын систем болон түүнийг хангах системийн математик илэрхийллээс үндэсний аюулгүй байдлын системийн төлөв байдал нь түүнийг хангах системийн үйл ажиллагааны үр дүнгийн функцээр тодорхойлогдож байгааг харж болно. Өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлын системийн байдал түүнийг хангах системийн үйл ажиллагааны үр дүнгээс хамаарах зүй тогтолтой байна.

Бертран Рассел Афинчуудын танин мэдэхүйн онолыг шинжилснийхээ дүнд “мэдлэг гэдэг бол нотолгоогоор баталгаажсан үнэн бодомж мөн. Нотолгоо байхгүй цагт мэдлэг

байхгүй” гэсэнтэй маргах шаардлагагүйг эрдэмтэд онцолсон байдаг.⁶⁵ Үндэсний аюулгүй байдлыг хангах танин мэдэхүйд гаргасан онолын алдаа юунд хүргэдгийг ЗХУ-ын өөрийгөө сүйрүүлсэн үндсэн шалтгаануудын сургамжаас харж болох юм. Анхдагч үндсэн хоёр шалтгаан нь: *нэгд*, аюулгүй байдлыг хангах системийг байгуулагчдын мэдлэггүй байдал. *хоёрт*, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны системийн зарчмууд болон системийн зүй тогтлуудыг үл ойшоосон байдал байсан гэж судлаачид үзсэн байдаг юм.⁶⁶ Ийм сургамжийн үйл явцын зураглалыг 1.3 дугаар зураг дээр үзүүлээ.

Тиймээс үндэсний аюулгүй байдлыг хангах системийн онол, арга зүйн асуудалд онцгой анхаарал хандуулах ёстой юм.



1.3 дугаар зураг. Үндэсний аюулгүй байдлыг хангах систем дэх энтропийн үйл явцын зураглал

⁶⁵ Монголын нийгмийн өөрчлөлт. Монгол Улсын шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013, 499 х., т.9

⁶⁶ Гагаринов А. В., Кобзев П. М., Котляр А. А. Энтропийн системийн катастрофа XX века: сущность, причины, последствия. Экономика: экономическая теория бизнес информ. №5, 2015, www.business-inform.ne

Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн ерөнхий математик бичлэгийг үндэсний аюулгүй байдлыг гадаад, дотоод аюул заналын эх үүсвэрүүдийг бүрдүүлэгч элементүүдийн хувьд бичье.

$$\Sigma S_{yabx}: \{ \{E_s\}, \{X_s\}, F(\{X_s\}) \}, \quad (1.3)$$

Энд,

ΣS_{yabx} - Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн тэмдэглэгээ;

$\{E_s\}$ - Үндэсний аюулгүй байдлын системийн гадаад, дотоод аюул заналын эх үүсвэрүүдийг бүрдүүлэгч элементүүдийн цогц;

$\{X_s\}$ - Үндэсний аюулгүй байдлын системийн гадаад, дотоод аюул заналын эх үүсвэрүүдийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;

$F(\{X_s\})$ - Үндэсний аюулгүй байдлын системийн гадаад, дотоод аюул заналын эх үүсвэрүүдийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлыг хэрхэн тооцсоноос хамаарах үр дүнгийн функц. (Шигтгээ-5).

ШИГТГЭЭ-5

Үндэсний аюулгүй байдлын системийн гадаад, дотоод аюул заналын эх үүсвэрүүдийг бүрдүүлэгч элементүүдийг Монгол Улсын 1994 оны анхны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд 9 бүрэлдэхүүн хэсгээр илэрхийлж, тус бүрд нь нөлөөлөх гадаад, дотоод сөрөг хүчин зүйлс (аюул занал)-ийг тодорхойлсон нь үндэсний аюулгүй байдлыг хангах системийг зөв гольдиролоор чиглүүлсэн зохистой шийдэл байсныг тэмдэглэж байна.

Үндэсний аюулгүй байдлын хангах системийн үйл ажиллагааны үр дүн үндэсний аюулгүй байдлыг хангах системийн танин мэдэхүйн, өөрөөр хэлбэл системийн үр дүнгийн функц $F(\{X_s\})$ -ийг хангах онол, арга зүйгээс хамаарах бөгөөд түүний үр дүнд шууд нөлөөлөх зүй тогтолтой байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн удирдлага, зохицуулалтын онолын үндэс

Үндэсний язгуур ашиг сонирхол гадаад, дотоод аюул заналаас хамгаалагдсан байх нь үндэсний аюулгүй байдлыг хангах системийн нэгдмэл чанар (системийн нэгдмэл чанар нь системийн элемент бүр системийн зорилгын функцийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг илтгэнэ.)-ын шинж Q_s тул үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлагын системд үр дүнгийн $F(\{X_s\}) \rightarrow Q_s$ гэсэн үйл явцын хандлагын зүй тогтол үйлчлэх ёстой.

Энэ зүй тогтлын зохистой хэм хэмжээг тогтоохын тулд үндэсний аюулгүй байдлын системийн нэгдмэл чанарын зүй тогтлын гурван талыг харгалзан тооцоолох шаардлагатай юм. Үүнд:

Нэгд, системийн нэгдмэл чанарын шинж (Q_s) нь түүнийг бүрдүүлэгч элементүүдийн шинжүүд (q_i)-ийн энгийн нийлбэр биш байна.

$$Q_s \neq \sum_{i=1}^n q_i, \quad (1.4)$$

Хоёрт, системийн шинж нь түүнийг бүрдүүлэгч элементүүдийн шинжүүдээс хамаарна.

$$Q_s = f(q_i), \quad (1.5)$$

Гуравт, системд нэгдсэн элементүүд нэг талаас системийн гадна тэдгээрт байсан өөрсдийн шинжүүдийн зарим хэсгийг алддаг. Өөрөөр хэлбэл, систем элементүүдийн зарим шинжүүдийг дарангуйлна, харин нөгөө талаас элементүүд системд орсноор шинэ шинжүүдийг олж авч болно. Энд системийн нэгдмэл чанарын зүй тогтлын *эхний тал* нь системийн орчинтойгоо бүхэл байх харилцан хамаарлын өөрчлөлтийг харуулж байгаа бол *гуравдахь тал* нь элементүүд системийн элементүүд болох үед тэдгээрийн зарим шинжүүд алдагдахыг харуулж байна. Тиймээс системийн нэгдмэл чанарын зүй тогтлын *хоёрдахь тал* (үзэл баримтлалд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “аюулгүй байдлын бодлого цогц байх” зарчим)-д анхаарал хандуулах шаардлагатай байдаг байна.

Системийн нэгдмэл чанарын зүй тогтлын дээрх гурван талын шинжээс харахад үндэсний аюулгүй байдлыг хангах систем нь аливаа хөгжлийн системийн адил туйлын нэгдмэл чанар болон туйлын бие даасан (нийлбэр) байдлын хооронд оршдог бөгөөд үүнийг үнэлэхийн тулд А.Холл⁶⁷-ын авч үзсэн *дэвшилтэд үржвэр* гэж нэрлэсэн – илүү хамааралгүй элементүүдтэй байдал руу систем тэмүүлэх, *дэвшилтэд системчлэл* гэж нэрлэсэн – элементүүдийн бие даасан байдлыг багасгах байдал руу, өөрөөр хэлбэл илүү нэгдмэл чанар руу систем тэмүүлэх гэсэн харилцан хамаарал бүхий хоёр зүй тогтолд тулгуурлах хэрэгтэй байна. Харин арга зүйн хувьд А.А.Денисовийн бий болгосон нэгдмэл чанарын зэрэг (түвшин) α ба элементүүдийн шинжүүдийг ашиглах итгэлцүүр β -ийн харьцуулсан тоон үнэлгээнүүдийг (хүснэгтийг хар) авч үзэх нь зүйтэй юм.

Эдгээр үнэлгээг системийн ээдрээтэй байдал дах системлэг C_c , өөрийн C_0 болон харилцан C_b гэсэн байдлуудын харилцан ажиллагааг тодорхойлогч харьцааны үндсэн дээр гаргасан байна.

$$C_c = C_0 + C_b, \quad (1.6)$$

Өөрийн ээдрээтэй байдал C_0 нь системийн элементүүдийн хоорондын хамаарлыг тооцоогүй нийлбэр ээдрээтэй байдал (агуулга)-ыг өөртөө багтаана. Системлэг ээдрээтэй байдал C_c нь системийн агуулгын нэг бүхэл болохыг илэрхийлнэ. Харилцан ээдрээтэй байдал C_b нь систем дэх элементүүдийн харилцан хамаарлын зэрэг (түвшин) –ийг тодорхойлно.

1.1 дүгээр хүснэгт.

Удирдлагын системийн зохицуулалт

Хэсэг ба бүхлийн харилцан ажиллагааны зүй тогтол	Нэгдмэл чанарын зэрэг (түвшин) α	Элементүүдийн ашиглалтын итгэлцүүр β
Нэгдмэл чанар $Q_s \neq \sum_{i=1}^n q_i$	1	0
Дэвшилтэд системчлэл	$\alpha > \beta$	

⁶⁷ А.Холл. Опыт методологии для системотехники. М.,Сов. радио, 1975

Дэвшилтэд үржвэр	$\alpha < \beta$	
Энгийн нийлбэр $Q_s = \sum_{i=1}^n q_i$	0	1

Хэрэв илэрхийлэл (1.6) – ийг C_0 - д хуваавал **системийн гол хууль** гарна:

$$\alpha + \beta = 1 , \quad (1.7)$$

Энд,

$\alpha = -C_b/C_0$, (1.8) системийн элементүүдийн харьцангуй уялдаа холбоо, нэгдмэл чанар;⁶⁸

$\beta = C_c/C_0$, (1.9) системийн элементүүдийн харьцангуй бие даасан байдал.

Илэрхийлэл (1.7)-ээс системийн элементүүдийн бие даасан байдал ба системийн нэгдмэл чанарын нийлбэр нь тогтмол хэмжигдэхүүн бөгөөд 1-тэй тэнцүү байна. Системд нэгдмэл чанарыг хангахгүй бол түүнийг хадгалах, сайжруулах ба хөгжүүлэхэд ашигтай нэгдмэл чанарын, ерөнхий системийн шинжүүд бий болохгүй. Харин ихээхэн нэгдмэл чанарын үед систем элементүүдийн шинжийг дарангуйлах ба тэдгээрийн зарим, түүнчлэн ашигтай хэсэг нь ч алдагдаж болно Тиймээс системийн дарангуйлсан байдал бий болно. Мөн эсрэгээрээ элементүүдэд илүү бие даасан байдал олгох эрмэлзлийн үед зөрчил, сөргөлдөөн үүсэж болох бөгөөд элементүүдийн нийлбэрийн үед системд системийн шинж илрэхгүй байх болно. Энэ нь эмх замбараагүй, эх захгүй байдалд хүргэнэ. Эндээс диалектик логикийн дагуу системийн туйлын байдлууд доройтолд хүргэдэг ба *алтан дунджийг* олох (үзэл баримтлалд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “мэдлэгт суурилах” зарчмын “*Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.*” гэсэн агуулгыг хэрэгжүүлэх) шаардлагатай болох нь харагдаж байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлагын системийн хувьд үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг хангах системийн нэгдмэл чанарын өсөлт нь зөвхөн үндэсний аюулгүй байдлын системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бие даасан байдлыг тодорхой хэмжээгээр хязгаарласны үр дүнд биелнэ. Эсрэгээрээ бол үндэсний язгуур ашиг сонирхол хангагдах гадаад, дотоод таатай нөхцөл буурна. Иймд үндэсний аюулгүй байдлын систем үргэлж аюулгүй байдлын туйлын нэгдмэл чанар ба түүний туйлын бие даасан (замбараагүй) байдал гэсэн хоёр хязгаарын дунд оршдог бөгөөд түүнийг хангах удирдлагын системд системийн нэгдмэл чанар ба элементүүдийн бие даасан байдлын зохистой харьцааг тогтоох үүрэг хариуцлага оногдож байдаг.

Үндэсний аюулгүй байдлын системийн нэгдмэл чанарт хүрэхийн тулд зайлшгүй ухаалаг байр сууринаас харилцан ажиллагааг нягт зохицуулах ба нэгдмэл чанарын зэрэг (түвшин) α -ын болон бүрэлдэхүүн хэсгүүдийн ашиглалтын итгэлцүүр β – ийн мэдээллийн

⁶⁸ Илэрхийлэл (б) дахь хасах тэмдэг нь $C_0 > C_c$ байдаг тогтвортой системүүдэд C_b нь сөрөг тэмдэгтэй байх учир α - ийг эерэг байлгахын тулд оруулагдсан болно. Холбогч агуулга C_b нь системийн өмнө зогсож буй зорилгыг биелүүлэхэд биш системийн ажлыг өөр дээрээ тодорхойлно (үүгээр C-ийн хасах тэмдэг тайлбарлагдана).

үнэлгээн дээр тулгуурлан системийн удирдлагыг төлөвлөх шаардлагатай. Сонгосон стратегийн хувьд зайлшгүй шаардлагатай хувилбар “алтан огтлол”-ын бүсэд оносон нөхцөлд зайлшгүй эсвэл илүү нэгдмэл чанар ($\alpha > 0, 5$)-тай, эсвэл илүү өөрөө засах эрх ($\alpha < 0, 5$)-тэй байна.^{69, 70}

Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн нэгдмэл чанарыг олон шинжлэх ухааны хоорондын нийтлэг зүй тогтол дээр тулгуурлан илрүүлэхэд синергетик^{71,72} чухал ач холбогдолтой. Тиймээс синергетикийн тусламжтайгаар шинжлэх ухааны олон салбарын, түүнчлэн аюулгүй байдал, цэргийн шинжлэх ухааны ололт амжилт, эрдэмтэд мэргэдийн мэдлэг авьяас, оюуны чадавхыг аюулгүй байдлын системийн онол, арга зүйн зүгт чиглүүлж, аливаа үзэгдлийн зүй тогтлыг хамтын хүчээр илрүүлэх боломж бүрддэгийг аюулгүй байдлын ерөнхий онолд өмнө авч үзсэнийг дахин тэмдэглэж байна.

Улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндэс

Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны үндсийг тухайн улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бүрдүүлнэ. Улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь тухайн улс орны үндэсний аюулгүй байдлаа хангах үйл ажиллагааны үндэс мөн. Энэ чухал үүргийг гүйцэтгэхэд үндэсний аюулгүй байдал нь өөрөө цогц тогтолцоо болохыг сайтар ойлгох, түүний бүх бүрдэл хэсгүүд, тэдгээрийн өөр хоорондын уялдаа холбооны шинж чанарыг танин мэдэх асуудал ихээхэн ач холбогдолтой. Тиймээс үндэсний аюулгүй байдал гэдэг нь улс орон, нийгэм өөрийн бүрэн бүтэн байдал, тогтвортой байдлаа хадгалан, идэвхтэй үйл ажиллагаа явуулж хөгжих чадвар, түүнчлэн өөрийгөө болон өөрийн эрх ашгаа нийгмийн нарийн тогтолцоо, зохион байгуулалтаар хөнөөлийн гадаад, дотоод нөлөөллөөс найдвартай хамгаалах боломжоо хадгалж байх тийм байдал юм.

Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны онол-үзэл санааны үндсийн тодорхой хэсэг ихэвчлэн улсын хэмжээний бусад ерөнхий баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг. Тийм баримт бичгүүдэд тухайн улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Онц байдлын тухай хуулиуд, улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн болон оюун санааны хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө (хөтөлбөр), төрийн батлан хамгаалах бодлого, цэргийн номлол, цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, зэвсэгт хүчний байгуулалтыг боловсронгуй болгох хөтөлбөрүүд хамаарна. Эдгээр баримт бичгүүдэд нийгмийн амьдралын бүхий л хүрээний болон түүний тодорхой салбарын хууль, эрх зүйн үндсийг хэдий чинээ сайн тусгаж өгнө, үндэсний аюулгүй байдлын тогтолцооны үзэл баримтлал, онолын үндэс төдий чинээ боловсронгуй болж, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны онол-үзэл санааны үндсийг бүрдүүлэхэд НҮБ мэтийн олон улсын болон бүс нутгийн

⁶⁹ Прангишвили И.В. Энтропийные и другие системные закономерности. Вопросы управления сложными системами. М., Наука, 2003, 428с.

⁷⁰ Дежкина И. Поташева Г. Эффективность управленческой деятельности и принцип “золотого сечения”//Проблемы теории и практики управления. 2009, №1

⁷¹ 1970-аад оны эхээр физикч Герман Хакен энэхүү систем дэх хамтын үйлчлэлийг тодруулах зорилгоор шинжлэх ухаанд “синергетик” (Synergeia (грек) буюу хамтын үйлчилгээ, нөхөрлөл) гэсэн утгатай нэр томъёог оруулжээ. Синергетикийг өргөн утгаар нь ““өөрөө аяндаа цэгцрэх тогтолцооны онол” гэж ойлгохыг эрдэмтэн судлаач Лувсандэндэв жиг сэтгэлгээ номондоо тайлбарласан байдаг.

⁷² Большая советская энциклопедия. Том 23 САФЛОП –СОАН, Третье издание., 1976, 638 стр., стр 418

¹¹ Лувсандэндэв. “Жиг сэтгэлгээ”

байгууллагууд, аюулгүй байдлыг хангах асуудлаар байгуулсан хоёр талын болон олон талын гэрээ, хэлэлцээрүүдийг ашиглаж болно.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь зөвхөн онол-үзэл санааны үндэс болоод зогсохгүй, үндэсний аюулгүй байдлын тогтолцоо, түүний бүрдэл хэсгүүдийн дотор онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэр нь үндэсний аюулгүй байдлын тогтолцооны нэг гол бүрдэл хэсгийн үүрэг гүйцэтгэхийн хамт бүх тогтолцооны үйл ажиллагаа, бусад бүрдэл хэсэг нэг бүрийн эзлэх байр, гүйцэтгэх үүргийн үндэслэл болж байдагт түүний онцгой үүрэг оршино.

Үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиглэлүүд, төрийн бодлого, баримтлах зарчмууд, гол зорилго болон түүнд хүрэх арга хэрэгслүүдийг тусгасан байх ёстой. Арга зүйн хувьд ерөнхий үзэл баримтлалын үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн хэм хэмжээний тогтолцоо, түүнчлэн хэсэгчилсэн үзэл баримтлал, хөтөлбөр, номлол болоод нийгмийн амьдралын эдийн засаг, улс төр, байгаль орчин, шинжлэх ухаан, батлан хамгаалах, мэдээлэл зүйн гэх мэт тодорхой салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөнүүдийг боловсруулдаг. Гэхдээ зарчмын хувьд баримталбал зохих онолын энэ үндэслэл нь амьдралд эсрэгээр хэрэгжсэн тохиолдлууд цөөнгүй байдаг. Тухайлбал, аюулгүй байдлын тухай хуулиа гаргачихсан хойноо Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа боловсруулах эсвэл нийгмийн тодорхой салбарын аюулгүй байдлын үзэл баримтлал гарснаас хойно ерөнхий үзэл баримтлал гарч ирэх зэрэг буруу практик байдаг.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь иргэн, нийгэм ба улсын аюулгүй байдлыг хангах салбарт гадаад, дотоод улс төр, эдийн засаг, нийгэм, цэрэг-техник, байгаль орчин, мэдээллийн болон бусад төрлийн аюул, сорилтоос өөрт байгаа нөөц, боломжийг тооцон хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг агуулсан албан ёсны үзэл бодлын цогц мөн. Улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь улс, нийгмийн идэвхтэй, тасралтгүй үйл ажиллагаа хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үндэсний эрх ашгийг бодит болон болзошгүй бүх аюулаас **хамгаалахад чиглэсэн албан ёсны үзэл бодлын тогтолцоо мөн хэмээн бас тодорхойлж болно.**

Онол, арга зүйн бүтээл⁷³, гадаадын зарим улсын үзэл баримтлалд эрх ашгийг “ашиг сонирхол” (интересы,) гэсэн нэр томъёогоор илэрхийлсэн байдаг. (Шигтгээ-6)

ШИГТГЭЭ-6

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйл 4 заалт, арван зургадугаар зүйл 11 заалт, арван долдугаар зүйл 2 заалт тус бүрд “ашиг сонирхол”, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1 ба 1.1.2 заалтад “үндэсний язгуур ашиг сонирхол”, 3.2.4.4 ба 3.3.3.2 заалтад “үндэсний ашиг сонирхол”, 3.3.1.2 ба 3.3.3.5 заалтад “үндэсний нийтлэг ашиг сонирхол” гэсэн, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.2.заалт ба 9 дүгээр зүйл. 9.1. заалтад “үндэсний язгуур ашиг сонирхол” гэсэн нэр томъёог ашигласан байна.

⁷³ Общая теория национальной безопасности: Учебник / Под общ. ред. А.А.Прохожева. Изд. 2 / М.: Изд во РАГС, 2005, 344 с. (Учебники Российской академии государственной службы при Президенте Российской Федерации.); ISBN 5-7729-0239-3;

Үндэсний аюулгүй байдлыг үнэлэх шалгуурыг боловсруулах арга зүйн хувилбар

Үндэсний аюулгүй байдлын системийн үнэлгээ болон аливаа элементийн системд үзүүлэх нөлөөллийн хувийн жин болон эрсдэлийн түвшинг үнэлэхэд дараах ерөнхий математик илэрхийлэл дээр тулгуурласан арга зүйг ашиглахыг санал болгож байна.

$$\begin{cases} \sum_{i=1}^n a_i = 1 \\ a_i > 0, \quad i = 1, n \end{cases} \quad (1.8)$$

Энд, a_i - тухайн i -гэй элементийн системд үзүүлэх нөлөөллийн хувийн жин;
 i - тухайн элементийн бусад элементийн дунд эзлэх нөлөөллийн эрэмбийн дугаар;
 n - элементийн нийт тоо.

Дээрх математик илэрхийлэл дээр үндэслэн системд элементийн үзүүлэх нөлөөллийн хувийн жинг дараах аргаар тодорхойлно. Үүнд:

1. Элементийг системд үзүүлэх нөлөөллийн дарааллаар нь эрэмбэлнэ. Үүний тулд хамгийн их нөлөө үзүүлэхийг нь 1, дараагийнхныг нь 2 гэх зэргээр дугаарлана. Хамгийн сул нөлөөтэй нь n байна.
2. Фишберны дүрмээр элемент тус бүрийн системд үзүүлэх нөлөөллийн хувийн жингийн итгэлцүүрийг дараах томъёогоор тодорхойлно:

$$a_i = \frac{2(n-i+1)}{n(n+1)} \quad (1.9)$$

3. Элементүүдийг үзүүлэх нөлөөллийн хувийн жингээр нь дараах арга зүйг ашиглан бүлэглэнэ:
 - Нөлөөллийн бүлгийн тоог тогтооно. Жишээлбэл, нөлөөллийн хувийн жингийн багцаар нь маш өндөр, өндөр, дунд зэрэг, бага зэрэг гэсэн дөрвөн түвшинд ангилбал нөлөөллийн 4 бүлэг байна гэсэн үг. Нөлөөллийн хэдэн бүлэгт хувааж авч үзэхийг шийдвэр гаргагчид болон шинжээчид өөрсдөө шийднэ.
 - Хамгийн өндөр түвшингийн нөлөөллийн бүлгийн дээд хязгаарын утгад a_1 итгэлцүүрийн утгыг авна.
 - Хамгийн бага түвшингийн нөлөөллийн бүлгийн дээд хязгаарын утгыг хамгийн өндөр түвшингийн нөлөөллийн бүлгийн дээд хязгаарын утгыг нөлөөллийн бүлгийн тоонд хувааж тодорхойлно.

$$a_k = \frac{a_1}{m} \quad (1.10)$$

Энд, a_k - хамгийн бага түвшингийн нөлөөллийн бүлгийн дээд хязгаарын утга
 m - нөлөөллийн бүлгийн тоо.

- Нөлөөллийн бүлэг хоорондын алхамын утгыг дараах илэрхийллээр олно.

$$d = \frac{a_1 - a_k}{m-1} \quad (1.11)$$

Энд, d - алхамын хэмжээ.

- Нөлөөллийн бүлэг тус бүрийн завсрын хэмжээг дараах байдлаар олно:
 - Хамгийн бага түвшингийн нөлөөллийн бүлгийн завсрын хэмжээ: $\leq a_k$

- Дараагийн түвшингийн нөлөөллийн бүлгийн завсрын хэмжээ: $a_k + d$
- Түүний дараагийн түвшингийн бүлгийн завсрын хэмжээ: $(a_k + d) + d$ гэх зэргээр тодорхойлно.

Энэ арга зүйг ашиглахад нөлөөллийн хувийн жингийн агуулга хоёр хандлагаар ашиглагдаж болно. Үүнд *нэгдүгээрт*, эерэг хандлагаар үндэсний аюулгүй байдлын тухайн элементийн түүнийг хангахад зайлшгүй хангагдсан байх шаардлагын түвшингийн утгын үнэлгээнд; *хоёрдугаарт*, сөрөг хандлагаар үндэсний аюулгүй байдалд эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэх нөлөөллийн түвшингийн утгын үнэлгээнд тус тус ашиглагдаж болно.

ШИГТГЭЭ-7

Монгол Улс 1994 онд Үндэсний аюулгүй байдлын анхны үзэл баримтлалыг, 2010 онд хоёрдах үзэл баримтлалаа батлан мөрдөж байна. Анхны үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг хангах системийн 9 бүрэлдэхүүн хэсэг тус бүрд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлсон нь үндэсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэхэд чухал үр нөлөөтэй байсан. Шинэ үзэл баримтлалд болзошгүй сөрөг нөлөөллүүдийг орхигдуулж, үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдийг 6 болгож, түүний нэгээр “дотоод аюулгүй байдал”-ыг авсан нь аюулгүй байдлын онол, арга зүйн хувьд томоохон дутагдалтай алхам болсон. Хоёр үзэл баримтлалд хоёуланд нь “үндэсний аюулгүй байдал” ойлголтыг буруу тодорхойлсон (тодруулга-2-ыг харах). Сүүлийн үзэл баримтлалд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна.” гэсэн заалт байгаа ч өнөөг хүртэл шалгуур үзүүлэлт боловсруулагдаагүй байна.

Зарим бүтээлд⁷⁴ аюулгүй байдлын шаардлагыг биелүүлэх түвшингөөр стратегийн эрсдэлийг үнэлэх арга зүйд ашиглаж болох дараах хоёр аргыг санал болгосон байдаг. Үүнд:

1. Элмерийн системээр эрсдэлийг үнэлэх арга:

Эрсдэлийг дам аргаар үнэлэх Элмерийн системийг Финляндын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн яамны дэргэдэх Хөдөлмөр хамгааллын газар болон Финляндын мэргэжлийн хөдөлмөр хамгааллын хүрээлэн боловсруулсан байна. Элмерийн систем нь эрсдэлийн түвшинг аюулгүй байдлын индекс буюу Элмерийн индексээр үнэлдэг байна.

“САЙН” үзүүлэлт

Элмерийн индекс = $\frac{\text{“САЙН” үзүүлэлт}}{\text{“САЙН” үзүүлэлт} + \text{“МУУ” үзүүлэлт}}$ x 100

“САЙН” үзүүлэлт + “МУУ” үзүүлэлт

Энэхүү индекс нь хувиар илэрхийлэгдэх бөгөөд 0 - ээс 100 гэсэн тоон утгатай байна. Жишээ нь индекс 60 хувь байх нь 100 гэсэн шаардлагын 60-ийг хангаж байна гэсэн агуулгыг илэрхийлнэ. Энэ аргын дутагдалтай тал нь аюулгүй байдалд нөлөөлж буй бүх үзүүлэлт адил зиндаа, зэрэглэлтэй нэг утгатай байгаад оршдог байна. Гэсэн хэдий ч

⁷⁴ Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа. ШУТ-ийн төслийн тайлан. УБ., 2012, 310 х.% т. 39

эрсдэлийн үнэлгээг үзүүлэлт нэг бүрээр гаргахгүй, нэгтгэсэн байдлаар гаргах боломжийг олгодог.

2. Шаардлагын түвшинг зэрэглэж (ЗЧБ-ын индекс) эрсдэлийг үнэлэх арга:

Элмерийн индексийг боловсронгуй болгосон хувилбарыг Финландын Хөдөлмөрийн аюулгүй байдлын хүрээлэн боловсруулсан байна. Энэ аргыг улс төрийн салбар дахь стратегийн эрсдэлийн үнэлгээний арга зүйд ашиглаж болох юм. Элмерийн индексийн адил “САЙН” үзүүлэлтийг нь “ХАНГАЖ БУЙ” үзүүлэлтээр; “МУУ” үзүүлэлтийг “ХАНГАХГҮЙ БУЙ” үзүүлэлтээр сольж, аюулгүй байдлын бүх үзүүлэлтийг гурван түвшинд зэрэглэж тус бүрийн ач холбогдлын зэрэглэлийн коэффициентийг 3. 2. 1 гэсэн тоон утгаар илэрхийлж, зайлшгүй хангах (З), хангах нь чухал (Ч), хангаж байх (Б) гэсэн үсгээр тус тус тэмдэглэе. Үүнийг “ЗЧБ-ын индекс” гэж нэрлэе. Тэгвэл Элмерийн индексийн томъёо дараах байдалтай бичигдэнэ.

$$\text{ЗЧБ-ын индекс} = \frac{\text{“ХАНГАЖ БУЙ” х (“З” х 3 + “Ч” х 2 + “Б”)}{\text{“БҮГД” х (“З” х 3 + “Ч” х 2 + “Б”)}} \times 100$$

Энд “З”–бол аюулгүй байдлыг хангахад зайлшгүй хангагдаж байх шаардлагатай үзүүлэлтүүд юм. “Ч”–бол аюулгүй байдлыг хангахад нэн чухал, ер нь хангагдаж байх учиртай үзүүлэлтүүд юм. “Б”–бол аюулгүй байдлыг хангахад хэрэгтэй нэмэгдэл тодотгол үзүүлэлтүүд юм. ЗЧБ-ын индексийн үнэлгээ нь аюулгүй байдлын эрсдэлийн жинхэнэ түвшинг илэрхийлж, стратегийн түвшинд авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох, үр өгөөжийг тооцож үзэх үндэс болно. ЗЧБ-ын индексийн үнэлгээг тогтмол, тодорхой цаг хугацаа, үечлэлтэй хийх нь улс төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөгөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг хэмжих, аюулгүй байдлын түвшингийн өөрчлөлтийг харах боломжийг олгоно. Мөн сөрөг нөлөөллийг ч тогтоох, үр ашиггүй ажил, арга хэмжээг зогсоох боломж олгоно.

Энэхүү хэсэгт авч үзсэн аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйн болон үндэсний аюулгүй байдлын онол, арга зүйн судалгаа нь аюулгүй байдлын суурь ойлголтуудын цэгцтэй мэдлэг бий болгох, тэдгээрийг хөгжүүлэхэд салбар шинжлэх ухаануудын уялдааг синергетикийн тусламжтайгаар системийн хандлагын үүднээс нэгтгэн авч үзэхэд чиглүүлэх ач холбогдолтой. Мөн аюулгүй байдлын онол, арга зүйн гаргалгаатай Монгол Улс дахь холбогдох нөхцөл байдлыг харьцуулсан 12 шигтгээ тодруулга нь цаашид үндэсний аюулгүй байдлыг хангах талаар өргөн хэлэлцүүлэг өрнүүлэх сэдлийг бий болгох болно.

НОМ ЗҮЙ

1. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014.
2. Монголын нийгмийн өөрчлөлт. Монгол Улсын шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013.
3. Гагаринов А. В., Кобзев П. М., Котляр А. А. Энтропогенная системная катастрофа XX века: сущность, причины, последствия. Экономика: экономическая теория бизнес информ. №5, 2015, www.business-inform.ne

4. А.Холл. Опыт методологии для системотехники. М.,Сов. радио, 1975.
5. Прангишвили И.В. Энтропийные и другие системные закономерности. Вопросы управления сложными системами. М., Наука, 2003.
6. Дежкина И. Поташева Г. Эффективность управленческой деятельности и принцип “золотого сечения”//Проблемы теории и практики управления. 2009, №1
7. Большая советская энциклопедия. Том 23 САФЛОР –СОАН, Третье издание., 1976.
8. Лувсандэндэв. “Жиг сэтгэлгээ”
9. Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа. ШУТ-ийн төслийн тайлан. УБ., 2012.

1.3 Аюулгүй байдлын орчны үнэлгээний арга зүйн үндэс

Шинжлэх ухааны статуст өрсөлдөж байгаа аливаа хүрээний мэдлэг өөрийн арга зүйн талаар санаа тавьж анхаардаг зүй тогтолтой.

Түүхэн үйл явцаас харвал 1970-аад оныг хүртэл бүх улс оронд хүн, хүрээлэн буй орчны хамгаалалтыг хангах бодлого системлэг шинжлэх ухааны судалгааны үр дүн дээр тулгуурласан бус үндсэндээ тусгай чиглэлээр “эрүүл ухаан”-д тулгуурласан шийдлийн үндсэн дээр зохицуулагдаж байсан. Тухайлбал, энэ үндсэн дээр 1961 онд Карибын хямралыг даван туулсан. “Эрүүл ухаан”-д тулгуурласан шийдлийн үндсэн дээр хүнд үзүүлэх техникийн нөлөөлөл зөвшөөрөгдөх хязгаарын хэм хэмжээг давах ёсгүйг тогтоон мөрдөж байсан. Энэ тохиолдолд хэрэв байгалийн хамгийн мэдрэмжтэй объект болох хүн хамгаалагдсан бол хүрээлэн буй орчин хамгаалагдсан гэж тооцогдож байсан. Ийм маягаар “эрүүл ухаан” зэвсэглэлээр хөөцөлдөж байсан үед олон улсын мөргөлдөөнийг зохицуулах боломж олгож байсан бөгөөд хүн болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах шаардлагыг аюулгүй технологийг бий болгох замаар, өөрөөр хэлбэл, цэвэр инженерийн үүргээр шийдвэрлэхэд хүргэж байсан.

Гагцхүү өнгөрсөн зууны 70-аад оноос хүн төрөлхтний өмнө хэд хэдэн амин чухал даяар асуудлыг шийдэх шаардлага гарч ирснээр аюулгүй байдлын ийм бодлого дэлхийн хамтын нийгэмлэгийн дэвшилд тохирохоо больсон. Тэдгээрийн хамгийн хурц асуудал нь цөмийн зэвсгийн нөөцийн хуримтлал байв. Туршилтын үр дүн ийм байдал нь бүх хүн төрөлхтнийг устгах экологийн сүйрэл “цөмийн өвөл”-д хүргэж болохыг харуулсан юм.

Өөрчлөгдөж буй нөхцөл байдалд “эрүүл ухаан”-ы зохицуулалтад үндэслэсэн хүн төрөлхтний аюулгүй байдлын хангалтын “хариуцах ба залруулах” үзэл баримтлалын хандлага “урьдчилан харж, урьдчилан сэргийлэх” зарчим дээр суурилсан шинэ хандлагад байраа тавьж өгч байна.

Аюулгүй байдлын орчны ирээдүйн хэтийн төлөвийн үнэлгээний үр дүнгийн ач холбогдлыг ОХУ-ын Төрийн Думын дарга С.Е. Нарышкин: *“Өнөөдөр геополитикийн шинж чанартай мэргэжлийн бөгөөд баримтад үндэслэгдсэн урьдчилсан үнэлгээ маш тулгамдаж, шаардагдаж байна. Аливаа нөхцөл байдал ямар чиглэлд, ямар динамикаар өөрчлөгдөж болохыг урьдчилан ойлгосноор олон сорилтоос өрсөж, түүнчлэн стратегийн төлөвлөлтөнд, мөн хууль гаргах хүрээнд алдаа, хийдэл гаргахаас зайлсхийж болно”⁷⁵ гэж тэмдэглэсэн байдаг бол академич А.Дынкин “...Урьдчилсан үнэлгээ хөгжлийн мега хандлагыг харах боломж өгч, стратегийн талаар бодох ба цаг хугацааны янз бүрийн хавтгай дээрх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох боломж олгоно. Шинжлэх ухааны урьдчилсан үнэлгээний жинхэнэ (бодтой) зорилго өмнө байгаа үзэгдлүүдийг нэг бүрчлэн бичихэд оршдоггүй. Энэ нь санамсаргүй, субъектив хүчин зүйлсийн олонлог үүсдэгээс шалтгаалан маш богино хугацааны хэтийн ирээдүйн хувьд ч гэсэн туйлын хүндрэлтэй байдаг. Түүний дээд үүрэг нь хамгийн чухал, урт хугацааны чиг хандлагуудыг урьдаас мэдэх, дэлхийн хөгжлийн гол учир*

⁷⁵ Военно-политические аспекты прогнозирования мирового развития : аналитич. доклад / А. И. Подберезкин, Р. Ш. Султанов, М. В. Харкевич [и др.] ; Моск. гос. ин-т междунар. отношений (ун-т) МИД России, Центр военно-политических исследований. — М. : МГИМО–Университет, 2014. С. 3.п/

*шалтгаан болон болзошгүй эргэлтийн пунктыг илрүүлэх явдал мөн. Сүүлийнх нь – хамгийн төвөгтэй*⁷⁶ гэж үнэлгээний гол санааг илэрхийлсэн байна.

Аюулгүй байдлын үйл явцуудын урьдчилсан үнэлгээний арга зүй нь ирээдүйг судалгааны *онотлогийн, логикийн* болон *гносеологийн* чиглэлүүдээр төсөөлөхөд оршино.

Онотологийн чиглэл нь ирээдүй яаж үүсэж, бүрэлдэхийг харуулж, түүний ерөнхий зураглал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илэрхийлнэ.

Логикийн чиглэл нь урьдчилсан үнэлгээний үйл явцуудын ба үр дүнгүүдийн бодит агуулгыг илрүүлэн гаргахад үүссэн нийтлэг шинжлэх ухааны ойлголтыг илэрхийлнэ.

Гносеологийн чиглэл нь ирээдүй хүний ухамсарт түүний дүрслэлийн хэлбэрүүд ямар болох, түүний үнэн байдал яаж дүрслэгдэж байгааг илэрхийлнэ.

Танин мэдэхүйн хэлбэр болохын хувьд гносеологийн талын үнэлгээ нь урьдчилан үнэлэгдэж байгаа үйл явцууд ба үзэгдлүүдийн хөгжлийн болзошгүй замууд ба зүй тогтлуудыг тусгана.

Аюулгүй байдлын үйл явцуудын талаарх судалгааны нийтлэг арга зүйн хандлагыг диалектикийн арга тодорхойлох бөгөөд энэ арга нь судалж байгаа объектуудад хамаарах авч үзэж буй үзэгдлүүд болон баримтуудын мөн чанарт нэвтрэх, үзэгдлүүдийн хоорондын холбоог тогтоох боломж олгоно. Тэр нь судалгааны нийтлэг шинжлэх ухааны хандлагууд ба аргууд, мөн тусгай аргуудын ашиглалтын үндсэн дээр хэрэгжинэ.

Нийтлэг хандлагуудад дараах зүйлсийг ялгаж болно:

- түүхэн – үзэгдэл бүрийн хэлэлцүүлэг нь түүний түүхэн хэлбэрүүдийн харилцан холбоонд явагдана;
- системлэг-бүтцийн: нэг талаас, аюулгүй байдлын системийг эрчимтэй хөгжиж байгаа бүхлийн хувиар авч үзэх, нөгөө талаас, тэдгээрийн харилцан ажиллагааны хүрээнд системийг бүрдүүлэгч бүтцийн элементүүдэд хуваана;
- цогц – үзэгдлүүдийг тэдгээрийн холбоонд болон бусад үйл явцууд ба үзэгдлүүдтэй хамааралд авч үзнэ.

Цогц хандлага нь *судалгааны ба зорилгын* гэсэн хоёр хандлага дээр суурилна.


Судалгааны хандлагын мөн чанар нь ирээдүйн хөгжлийн боломжит чиглэлүүд ба үе шатуудыг мөрдөхийн тулд өнөөгийн эхний түвшингийн үнэлгээн дээр тулгуурлан судалгаагаар илрүүлсэн хөгжлийн зүй тогтлуудад үндэслэдэгт оршиж байна. Тухайн хандлагын үед үзэгдлүүдийн холбоо ба дараалал өнгөрсөн ба одоогоос ирээдүй рүү авч үзэгдэнэ.

Зорилгын хандлагын үед түүний амжилтын зорилго ба боломжит зам тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, тэр нь ирээдүйд хүрсэн байх ёстой тодорхой үр дүнгээс гарна. Энэ хандлагын үед үзэгдлүүдийн холбоо ирээдүйгээс өнөө рүү чиглэгдэнэ. Заасан хоёр хандлага харилцан холбоотой ашиглагдана. Тиймээс объектын хөгжлийн тухай мэдээг

⁷⁶ Дынкин А. А. Предисловие Стратегический глобальный прогноз 2030. Расширенный вариант. под ред. акад. А. А. Дынкина / ИМЭМО РАН. М.: Магистр, 2011. С. 15./

гаргаж авах, түүнд нөлөөлөхгүйгээр, зорилгыг тавих замаар түүний амжилтын замыг тодорхойлох нь чухал.

Урьдчилсан үнэлгээний хоёр хандлагын холбоосыг 1.4 дүгээр зураг дээр харууллаа. Урьдчилсан үнэлгээний хоёр хандлага хөгжлийн болзошгүй үр дүнгүүд болон хөгжлийн хэрэгцээт нөөцүүдээр дамжин хөгжлийн загваруудын байгуулалт дээр уулзаж, цаашид хөгжлийн төлөвлөлтийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Учир иймд урьдчилсан үнэлгээний үйл явц аливаа нийгэм-эдийн засгийн системийн хөгжлийн гол агшин ба эхлэлийн шат нь юм. Урьдчилсан үнэлгээний амжилтаас зөвхөн улс орны бус, мөн бүсийн түвшинд гаргаж байгаа шийдвэрүүдийн бүтэмж шууд хамаарна.



1.4 дүгээр зураг. Урьдчилсан үнэлгээний хоёр хандлагын холбоо

Урьдчилсан үнэлгээний системд тулгамдсан асуудал байгаа нь урьдчилсан үнэлгээний журмын арга зүйн болон аргын боловсруулалт зайлшгүйг баталж байна.

Иймд улс орны хөгжлийн чанартай урьдчилсан үнэлгээг хангах нөхцөлүүдийн цувааг ялгаж болно:


нэгдүгээрт, нийгэм-эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлс нь түүнд тэргүүлэгч үзүүлэлтүүд болох зохион байгуулалтын систем гэж авч үзэх хэрэгтэй. Энэ тохиолдолд хөгжлийн зорилгууд нь улс орны байгаа нөөцүүд болон боломжит чадавхтай тэнцвэртэй байна.

хоёрдугаарт, урьдчилсан үнэлгээний үед улс орны хөгжлийн хүчин зүйлсийн харилцан ажиллагааны зүй тогтлууд болон энэ хөгжлийн түвшинг илэрхийлэгч гол үзүүлэлтүүд дэх тэдгээрийн нөлөөллийг заавал тооцох ёстой.

гуравдугаарт, илрүүлсэн зүй тогтлуудын үндсэн дээр тогтвортой хөгжлийн системүүдийн үйл явдлын үнэлгээний загваруудыг гаргаж авах ёстой. Харин эдгээр загварууд хөгжлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөд улс орны системүүдийн хариу үйлдлийг урьдчилан үнэлэхийн тулд дуурайлган үзүүлж байх ёстой. Энэ нь бүхэлдээ урьдчилсан үнэлгээний бүтэмжийг хангана.

дөрөвдүгээрт, урьдчилсан үнэлгээ нь зөвхөн улс орны системийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийн олон хувилбарыг бус, мөн түүний чанарын өөрчлөлтийг тооцох ёстой.

Улс орны хөгжлийн практикт урьдчилсан үнэлгээний хэрэгслүүдийн сонголт нь бүхэлдээ арга зүйн хоёр хандлагын зарчмуудаар тодорхойлогдоно.



1.5 дугаар зураг. Арга зүйн хандлагын тооцсон урьдчилсан үнэлгээний арга хэрэгслүүдийн сонголт

Улс орны хөгжлийн системийн үнэлгээний хувилбаруудын арга зүйн байгууламжийн хоёр чиглэлийг тооцсон гол зорилго бол урьдчилсан үнэлгээний илүү тохирох хувилбарын сонголтын асуудал байна. Ийм сонголтод зориулан урьдчилсан үнэлгээний арга зүйн хоёр хандлагуудын давуу болон дутагдалтай талын харьцуулалтыг 1.2 дугаар хүснэгтэд үзүүлнэ.

Урьдчилсан үнэлгээний аргуудын олон янз болох нь сонголтын асуудлыг бий болгодог. Эхний ээлжинд “урьдчилсан үнэлгээний далайц” гэж нэрлэгдэх урьдчилсан үнэлгээний хугацааны завсрыг тооцох шаардлагатай. Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн урьдчилсан үнэлгээний далайц богино хугацааны, дунд хугацааны ба урт хугацааны гэж хуваагдана.

Дараа нь урьдчилсан үнэлгээний аргыг сонгохын тулд өнгөрсөн рүү хандсан болон өнөөгийн мэдээллийн байгаа хэмжээ ба чанарыг тодорхойлох шаардлагатай. Энэ тохиолдолд урьдчилсан үнэлгээний хувьд улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн

үзүүлэлтүүдийг судлах хүрэлцээтэй түвшинд боловсруулагдсан арга-аргачлалын аппарат шаардагдана.

1.2 дугаар хүснэгт

Урьдчилсан үнэлгээний арга зүйн хандлагуудын харьцуулсан тодорхойлолтууд

Хэрэглээний хүрээ	Урьдчилсан үнэлгээний хандлагууд	
	Судалгааны хандлага	Зорилгын хандлага
Улс орны хөгжлийн урьдчилсан үнэлгээний үзэл баримтлал	Индикатив урьдчилсан үнэлгээ	Үнэлгээнүүдийн оновчтой ба олон хувилбарт байдал.
Онолын үндэс (Урьдчилсан үнэлгээний техник)	Математикийн онолуудын хэрэглээтэй олон хүчин зүйлсийн загваруудын судалгаа	Албажсан аргуудын илүү өргөн хэрэглээний үе дэх эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамикийн тооцоо
Урьдчилсан үнэлгээний далайцууд	Нийгмийн хүрээг урьтал болгосон богино хугацааны, дунд хугацааны болон урт хугацааны үнэлгээнүүд	Ирээдүйн нийгэм-эдийн засгийн хөгжлийн динамик дэх эрсдэлүүдийн тооцоо
Бусад үнэлгээтэй хавсрах боломж	Төлөвлөгөөнүүдтэй зэрэгцэн хавсралтыг тооцсон олон хувилбарт ба олон төлөвлөгөөт байдал	Үнэлгээний хувилбаруудын хувийн онцлог даяар үнэлгээнүүдтэй хосолсон байна.

Урьдчилсан үнэлгээний аргууд

Урьдчилсан үнэлгээний арга зүй нь урьдчилсан үнэлгээний арга, системийн тухай мэдлэгийн салбар бөгөөд шийдвэрлэвэл зохих асуудлуудыг илрүүлэх, зорилготой урьдчилан харах, зорилгын тавил, төлөвлөлт, тусгал, үйл явцын ирээдүйн төлөв зэрэг категориудад хуваагдана. (Шигтгээ-8)

Улс орны тодорхой хугацааны завсар дахь хөгжлийн стратегийн чиглэлийг урьдчилсан үнэлгээний янз бүрийн хандлагууд болон аргуудыг ашиглах замаар урьдчилан хэлж болно. Хөгжлийн төвөгтэй харилцан хамаарал бүхий хүчин зүйлс байгааг илэрхийлсэн хөгжлийн үнэлгээнүүдийг боловсруулах үед янз бүрийн аргуудыг хослуулсан тодорхой арга барилуудыг ашиглах бодит шаардлага үүснэ.

Урьдчилсан үнэлгээний аргуудын тооны талаар нилээд зөрүүтэй баримтууд тааралдаж байна. Тухайлбал, өнөө үед ойролцоогоор урьдчилсан үнэлгээний 220 орчим аргууд байна, гэвч тэдгээрээс практик дээр 10-аас хэтрэхгүй нь ашиглагдаж байна.⁷⁷,

⁷⁷ Методы и приемы прогнозирования www.astronom2000.info/прогнозирование/mipp/

урьдчилсан үнэлгээний 150 орчим аргууд байна, эдгээрээс ойролцоогоор 20-30 үндсэн аргууд ашиглагдаж байна.⁷⁸, Эрдэмтдийн үнэлгээгээр урьдчилсан үнэлгээний 150 гаруй аргууд байна, практик дээр үндсэн аргаар зөвхөн 15-20 нь л ашиглагдаж байна.⁷⁹

ШИГТГЭЭ-8

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого боловсруулахдаа мэргэжил арга зүйн дараах ажил үүргүүдийг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Хөгжлийн урт хугацааны бодлогын харьцуулсан шинжилгээ хийх;
- Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын 2015 он хүртэлх эхний шатны хэрэгжилтийг үнэлэх;
- Хөгжлийн урт хугацааны бодлогыг боловсруулах арга замыг судлах;
- Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэх;
- Монгол Улсын нийгмийн өнөөгийн байдлыг шинжлэх;
- Монгол Улсын хүрээлэн буй орчны өнөөгийн байдлыг шинжлэх;
- Олон улсын эдийн засаг геополитикийн нөхцөл байдлын цаашдын хандлагыг судлах;
- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, түүний монголын цаг уурт илрэх нөлөөг судлах;
- Олон улсын зах зээл дэх технологийн хөгжлийн цаашдын хандлагыг судлах;
- Монгол Улсын хөгжлийн бодлогыг эхний байдлаар томъёолох, үндэслэх боловсруулах;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний хувилбарыг зөвлөх зөвлөл, ажлын хэсэг, орон нутагт хэлэлцүүлэх;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний хувилбарыг сайжруулах үндэслэл, тооцоог дахин боловсруулж, баримт бичгийн хэлбэрт оруулах;
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бусад хэлэлцүүлгийг зохион байгуулах, санал авах;
- Хэлэлцүүлэг, саналын дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын төслийг сайжруулах, баримт бичгийг эцэслэн боловсруулах зэрэг өргөн далайцтай ажил үүргүүд орсон байна. Эндээс судалгаа урьдчилсан үнэлгээний зорилгын бус зөвхөн судалгааны арга зүй, аргууд дээр үндэслэсэн бөгөөд тогтвортой хөгжлийн загварыг баримталсан байна. Олон улсын харилцаа, цэрэг-улс төрийн байдлын судалгаа дутмаг байна.

Тогтвортой хөгжлийн урьдчилсан үнэлгээний загваруудад улс орны байгаа байдлын зөвхөн тоон параметрууд бус, мөн зайлшгүй шаардлагатай үр дүнгүүдийг гаргаж авахын тулд улс оронд өрнөж байгаа тэдгээрийн өөрчлөлтийн үйл явцууд болон нөхцлүүдийн чанар, шинж маш чухал байна. Мөн түүнчлэн загварын сонголтод тэдгээрийн мэдээллийн хангалтын нөхцөлүүд хүчтэй нөлөө үзүүлнэ. Мэдээллийн хангалт нь үнэлгээний тооцоонуудын далайц нэмэгдэхийн хэрээр муудна.

⁷⁸ Классификация методов прогнозирования. Оценка точности прогноза, построенного методом экстраполяции www.ekonomika-st.ru/.../metodi/metodi-prognoz-1-2.html

⁷⁹ Методы прогнозирования и планирования <https://works.doklad.ru/view/tFggQhXkyLs.html>

Ийм байдлаар, хүчин зүйлсийн үзүүлэлтүүдийн олон тоог агуулсан улс орны хөгжлийн урьдчилсан үнэлгээний мөн чанарын олон хүчин зүйлстэй холбоотойгоос урьдчилсан үнэлгээний аргуудаас зөвхөн аль нэгийг нь ашиглах боломжгүй байна. Иймд стратегийн үзүүлэлтүүдийн урьдчилсан үнэлгээнд цогц хандлагын үзэл баримтлалыг хэрэглэхийг санал болгодог бөгөөд үүний тулд эхний шатанд өнгөрснөөс ирээдүй рүү хандсан нэгдсэн шалгуураар улс орны эдийн засгийн түвшний хөгжлийн явцыг тодорхой нарийвчлалтай илэрхийлэх ерөнхий математик хамаарлыг гаргах хэрэгтэй. Тухайлбал, Хакасын Бүгд найрамдах улс том хэмжээний статистик өгөгдлүүд (2500 гаруй үзүүлэлтүүд)-ийг эдийн засаг-математик загварчлалын тусламжтайгаар боловсруулах үед хөгжлийн эдийн засгийн, нийгмийн, инновацын болон экологийн ерөнхий шалгууруудын харилцан холбоо ба хамаарлыг тогтоосон.

Дараа нь улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшингийн нэгдсэн шалгуурыг гаргаж авсан⁸⁰.

$$I_{kk} = 0,35_{k1} + 0,25_{k2} + 0,25_{k3} + 0,15_{k4} \quad (1.12)$$

Энд, $k1$ - эдийн засгийн шалгуур;

$k2$ - нийгмийн шалгуур;

$k3$ - инновацийн шалгуур;

$k4$ - экологийн шалгуур.

Нэгдсэн шалгуурын тусламжтайгаар харгалзсан чиглэлүүдээр улсын хөгжлийн шаардагдах түвшинг төлөвлөж болно. Урьдчилсан үнэлгээний тодорхой үүрэг тавигдсан үед тохирох хандлагуудыг сонгохын тулд юуны өмнө урьдчилсан үнэлгээг гүйцэтгэх хязгаарлалт болон зөвшөөрөгдөх хэмжээг тодорхой томъёолох ёстой байна. Объектын урьдчилсан үнэлгээний үед үргэлж нэг биш, түүний хэд хэдэн үзүүлэлтүүдийг урьдчилан үнэлэхэд хүрдэг. Энэ тохиолдолд нэг үзүүлэлтийн хөгжлийн үнэлгээ нэг аргаар, харин өөр үзүүлэлтийнх нь өөр аргаар гүйцэтгэгдэнэ, өөрөөр хэлбэл, аргуудын хослол ашиглагдана.

Аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээний өргөн хэрэглэгдэх аргуудыг 1.3 дугаар хүснэгтэд харууллаа.

1.3 дугаар хүснэгт

Аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээний аргууд

Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх арга	Ажиглалт
	Баримтын судалгаа
	Харьцуулалт
	Контент анализ
	Ивент анализ
	Когнитив анализ
	Экспертийн үнэлгээ:

⁸⁰ Методы и приемы прогнозирования www.astronom2000.info/прогнозирование/mipp/

Аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээний аргууд	Урьдчилан дүгнэх арга	Хувийн	Сценар буюу үзэгдэл зохиох арга
			Ярилцлагын арга
			Аналитик илтгэлийн бичлэгийн арга
		Хамтын	Асуулгын анкетын арга
			“Комисс”-ын арга
			Оюуны дайралт”-ын арга
			“Дельфи” арга
	Системийн арга		
	Загварчлалын арга		
	Шийдвэр гаргалтын арга	Бихевиорал анализын арга	
Тоглоомын арга			

Дэлхийд хийгдсэн бүх үнэлгээнүүдийн 90 гаруй хувь нь экспертийн үнэлгээ болон баримт бичгийн судалгааны аргуудаар хийгдсэн байдаг. Тиймээс эдгээр арга хамгийн өргөн дэлгэрсэн аргад тооцогддог байна. Энд экспертийн үнэлгээний аргын талаар товч авч үзье.

Экспертийн үнэлгээний аргууд

Экспертийн үнэлгээний арга бол шинжилж буй объектын үзүүлэлтүүдийн динамикийн тухай эсвэл ирээдүй дэх тэдгээрийн боломжит хөгжлийн альтернатив хувилбаруудын тухай шинжээч (эсвэл шинжээчдийн бүлгийн, хүн амын)–ийн төгсгөлийн эргэцүүлэл юм. Төгсгөлийн эргэцүүлэл нь бодитой, шинжлэх ухаанчаар үндэслэсэн, мөн чанарын хувьд магадлалтай, үнэлгээний үе шатны хүрээнүүдэд шинэ мэдээлэл орж ирэхэд засварлах боломжтой, үнэлгээний үе шат дууссаны дараа хангагдах бөгөөд тодорхой, ойлгомжтой, гэнэтийн тайлбарууд оруулахгүй, үнэлгээний даалгаварт хатуу нийцсэн, баталгаатай ба нөхөн сэргээх боломжтой байх ёстой.⁸¹ Энэ арга нь тодорхой бусын үед ашиглагдана.

Экспертийн үнэлгээний аргуудын мөн чанар нь үнэлгээний үндэс сууринд мэргэжилтний эсвэл мэргэжилтнүүдийн хамтлагийн мэргэшлийн, шинжлэх ухааны болон практик туршлага дээр үндэслэсэн санаа бодолд тулгуурлана. Экспертийн хувийн үнэлгээнүүд нь тохирох мэргэшлийн шинжээчид - мэргэжилтнүүдийн санаа бодлыг ашиглахад үндэслэнэ.

Сценар буюу “үзэгдэл” зохиох арга (Scenario Building). Энэ арга нь янз бүрийн нөхцөлүүдийн үе дэх хугацаанд үйл явц эсвэл үзэгдлийн логикийг тодорхойлоход үндэслэнэ. Түүний зорилго нь үйл явдлын боломжит хөгжлийн илүү төгс загварыг зохиоход оршино.

⁸¹ Триллагийн “Удирдлагын тухай шинжлэх ухаан” ном /1911/ шинжлэл магадлалын аргын эхлэлийг тавьсан. Шинжлэл магадлалын тухай шинжлэх ухаан Оросод 1950-1960 онуудад хөгжиж эхэлсэн байна.

Бодит байдалд дүн шинжилгээ хийгээд, цаашид хөгжин хувьсаж болох бүх магадлалыг гаргана. Ингэхдээ нэгд, цаашдын хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйлсийн жагсаалт гаргана; хоёрт, дараа дараагийн 10, 15, 20 жил дэх хөгжлийн байж болох үе шатуудыг тодорхойлно; хүчин зүйлүүдийг харьцуулдаг. Энэ үндсэн дээр тэр бүрд тохирох үзэгдэл зохиогоод, эцэст нь байж болох магадлалын түвшингээр жагсаана. Ихэнх судлаачид үзэгдэл зохиох аргыг үйл явдлын боломжит ирээдүйг дүрслэх болон нөхцөл байдлын боломжит хөгжлийн загвар замыг тодорхойлох арга гэж үздэг. Үр дүнд нь объектын байгаа нөхцөл байдлаас ирээдүйн байдалд шилжих үед дэх дэлгэрэх үзэгдлүүдийн дараалал тогтоогдоно. Үнэлгээний сценар нь урьдчилан үнэлэгдэж байгаа объектын хөгжлийн стратегийг тодорхойлно. Тэр нь объектын хөгжлийн ерөнхий зорилго, “зорилгуудын мод”-ны дээд түвшингүүдийн үнэлгээний шалгуурууд, үндсэн зорилгуудад хүрэх асуудлуудын урьтал болон нөөцүүдийг тусгах ёстой. Сценарт үүргийн дараалсан шийдэл, болзошгүй саадууд тусгагдана. Иймд урьдчилсан үнэлгээний объектын хөгжлийн талаарх шаардлагатай материалууд ашиглагдана.

Урьдчилан үнэлэх граф – энэ нь хэрчмүүдээр-ирмэгүүдээр холбогдсон цэгүүд-оройнуудаас тогтсон дүрс юм.

“Зорилгуудын мод”- энэ нь оройнууд-үе шатуудын эсвэл зорилгын асуудлуудын хоорондын харилцааг илэрхийлсэн граф-мод юм. Орой бүр нь өөртөө түүний мөчүүдээс гарч байгаа бүхний хувьд зорилгыг агуулна. “Зорилгуудын мод” хэд хэдэн бүтцийн эсвэл шаталсан түвшингүүдийн ялгалтыг төлөвлөнө. “Зорилгуудын мод”-ны байгуулалт дараах олон үүргүүдийн шийдлийг шаардана: бүхэлд нь объектын хөгжлийн үнэлгээ; урьдчилан үнэлж буй зорилгын сценарыг томъёолох; “мод”-ны түвшингүүдийг ба оройнуудыг тодорхойлох; шалгуурууд болон оройнуудыг эрэмбэлэх тэдгээрийн жинг тодорхойлох. Эдгээр үүргүүд шаардлагатай үед шинжлэн магадлах үнэлгээний аргуудаар шийдвэрлэгдэж болно. Үнэлгээний объект болох тухайн зорилгод олон янзын сценаруудын олонлог тохирч болно гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм.

Сценар нь ихэвчлэн олон хувилбарт шинжийг агуулах бөгөөд зан байдлын дараах гурван шугамыг таниулна:

- өөдрөг үзлийн - илүү их тааламжтай нөхцөл дэх системийн хөгжил;
- өөдрөг биш үзлийн—илүү бага тааламжтай нөхцөл дэх системийн хөгжил;
- ажлын – илрэл нь илүү их магадлалтай сөрөг хүчин зүйлсийн эсрэг ажиллагааг тооцсон системийн хөгжил.

Үнэлгээний сценарийн хүрээнүүдэд урьдчилж хараагүй нөхцөл байдлуудын тохиолдолд ашиглах нөөц стратегийг боловсруулах хэрэгтэй.

Бэлэн төрлийн сценарууд задлан шинжлэгдэх ёстой. Өмнө зогсож байгаа үнэлгээний хувьд хэрэг болохуйц мэдээллийн шинжилгээний үндсэн дээр зорилгууд томъёологдож, шалгуурууд тодорхойлогдож, альтернатив шийдлүүд авч үзэгдэнэ.

ШИГТГЭЭ-9

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого(төсөл)-2015-2040 судалгаанд урт хугацааны хөгжлийн бодлогын гол зорилгуудыг дараах байдлаар тодорхойлж, үнэлгээ хийсэн байна:

1. Монгол хүмүүний бүтээх чадварыг дэлхийн түвшинд хүргэх, хүмүүний хөгжил, амьдралын чанарыг сайжруулах;
2. Эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлж, төрөлжүүлэх, баялгийг тэнцвэртэйгээр хуваарилах;
3. Мэдлэг оюун, өв соёлын баялаг хуримтлал бүрдүүлж, технологи, инновацийн хүчтэй чадавхыг бий болгох;
4. Хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө, байгалийн баялгийн нөөцийг хамгийн үр өгөөжтэйгээр ашиглах;
5. Хүрээлэн байгаа амьдрах орчноо эрүүл байдлаар нь хадгалах;
6. Гадаад орчинтойгоо харилцан үр ашигтайгаар хамтран ажиллах юм.

НОМ ЗҮЙ

1. Военно-политические аспекты прогнозирования мирового развития : аналитич. доклад /А. И. Подберезкин, Р. Ш. Султанов, М. В. Харкевич [и др.] ; Моск. гос. ин-т междунар. отношений (ун-т) МИД России, Центр военно-политических исследований. — М. : МГИМО–Университет, 2014. С. 3.п/
2. Дынкин А. А. Предисловие Стратегический глобальный прогноз 2030. Расширенный вариант. под ред. акад. А. А. Дынкина / ИМЭМО РАН. М.: Магистр, 2011. С. 15./
3. Методы и приемы прогнозирования www.astronom2000.info/прогнозирование/mipp/
4. Классификация методов прогнозирования. Оценка точности прогноза, построенного методом экстраполяции www.ekonomika-st.ru/.../metodi/metodi-prognoz-1-2.html
5. Методы прогнозирования и планирования <https://works.doklad.ru/view/tFggQhXkyLs.html>
6. Методы и приемы прогнозирования www.astronom2000.info/прогнозирование/mipp/

ХОЁРДУГААР БҮЛЭГ.
МОНГОЛ УЛСЫН “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН БОДЛОГЫН ОНОЛ,
ПРАКТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, практик

“Аливаа улсын гадаад бодлого нь түүний оршин буй газарзүйн байршилаар тодорхойлогдоно” гэж Наполеон Бонапарт хэлжээ.⁸² Энэ үг газарзүй, геополитикийн давтагдашгүй онцлог байршилтай Монгол Улсын гадаад бодлогод нэн их хамаатай болно. Улс гүрэн бүгд нэг нь нөгөөтэйгээ айл хөрш болж зэрэгцэн оршдог. Германы геополитикч, профессор Фридрих Ратцелийн *«хөршөө сонгодоггүй»* гэж хэлсэн нэгэн үг буй.⁸³ Энэ бол зөвхөн хил залгасан орны тухайд өгүүлж буй хэрэг юм. Харин сайн хөршийн харилцааны тухайд бол түүнийг заавал айл зэргэлдээ гэхгүй алс холын аль ч оронтой тогтоож болмой. Энэ утгаараа хөрш нь хаяа нийлсэн хэдэн ч орон байж болох бөгөөд харин *хил залгаагүй “хөрш”-өө бол сонгож болох ажгуу.*

1990-ээд оны эхнээс Монгол Улсын гадаад бодлогод *“гуравдагч хөрш”, “гуравдагч хөрш”*-ийн бодлогын үзэл санаа буй болж, эдүгээ тухайлсан төрийн бодлого хийгээд онол-практикийн түвшний судалгааны шинэ чиглэл бий болсон. Тиймээс дурдсан чиглэлд судлаачид анхаарлаа хандуулж буй нь бүрнээ зүй ёсны хэрэг юм. Зарим судлаачид *«гуравдагч хөрш»* гэж байхгүй, хөрш гэдэг нь хаяа дэрлэсэн байх ёстой, харин *«гуравдагч түнш»* гэж байж болох юм хэмээн мэтгэлцдэг. Уг нь сайхь бодлогын логик нь *«гуравдагч хөрш»*-ийн тухайд бодлого явуулж, харин тэрхүү бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг хөгжүүлэх асуудал л байгаа юм. *Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа, холбооны технологийн үсрэнгүй хөгжил, аж үйлдвэрийн IV хувьсгал, дижиталчлалын үйл явцтай уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засаг, хөршийн тухай уламжлалт stereotype улам бүр харилцан хамааралтай даяаршсан эдүгээ үед шинэчлэгдсээр буй гэдгийг энд тэмдэглэх ёстой болов уу.*

“Гуравдагч хөрш”-ийн бодлого бол их гүрнүүдийн геополитикийн орчинд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгаа дээдлэн зөөлөн хүчээр тэнцвэрийн хүчийг барих буюу зөөлөн тэнцвэржүүлэхүйн тухайд цогц бодлого болно.

Аливаа улс орон өөрийн үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгийн аргаар хангахын тулд тусгайлан томъёолсон гадаад бодлого, дипломат ажиллагааг эрхлэн явуулж, тэр нь олон улсын дэмжлэг хүлээж байсан нь цөөнгүй. Үүнд Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого ч зүй ёсоор орно.

⁸² “To know a nation’s geography is to know its foreign policy” – Napoleon Bonaparte (Emperor of France from 1804 to 1814) Luis Ritto. Diplomacy and Its Practice. VII. International Relations, Geopolitics and Diplomacy. 2015

⁸³ “Neighbors are Neighbors. Friends can be chosen, not Neighbors” Professor Ratzel, Friedrich, 1844-1904. The History of Mankind. Translated from the second german edition by A.J. Butler M.A. with Introduction by E.B.Tyler. D.C.L., F.R.S. London, Macmillan and Co.; New York, Macmillan Co., 1896, pp. 245-255

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого ба хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах бодлогын парадигм: зөөлөн тэнцвэржүүлэхүй

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын онолын үндэс, зорилго, мөн чанар, хөгжлийн шинэ үе шат

Монгол Улсын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл нь хоёр хөршөөс гадна АНУ, Япон, Өрнөд Европ зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд, олон улсын байгууллагууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон явдал мөн. Үүний үндсэн уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц байсан бөгөөд тэдгээр орнууд ч Монгол Улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, нөгөө талд урд, хойд хоёр хөршид нь шилжилтийн үеийг амжилттай даван туулж буйг жишээ болгон харуулах давхар зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Эдүгээ АНУ Монгол Улсыг ардчилал, хүний эрх харьцангуй хязгаарлагдмал, чөлөөт хэвлэл хяналттай, авторитар дэглэмтэй хоёр хөршид нь Монголоор байнга үлгэр жишээ үзүүлэхийн тулд, “ардчилалын баянбүрд” (oasis of democracy)⁸⁴ хэмээн онцолдог нь⁸⁵ хоёр хөршийг Монголоор дамжуулж шүүмжилсэн бодлого юм.

Улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалд «гуравдагч хөрш», «гуравдагч хөрш»-ийн бодлогын тухай ойлголтыг тусгайлан нэг мөр тодорхойлсон зүйл одоогоор хараахан гараагүй байгаа юм. Энэ утгаараа Монгол Улс бага, жижиг орны гадаад бодлого дахь “гуравдагч хөрш” хийгээд “гуравдагч хөрш”-ийн бодлого хэмээх шинэ ухагдахууныг буй болгон хэрэгжүүлж байгаа нь олон улсын бодлого, улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалын судлагдахууныг баяжуулж буй хэрэг гэж үзвээс зохилтой.

1994 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд «гуравдагч хөрш» хийгээд «гуравдагч хөрш»-ийн бодлого, түншлэлийн талаар тусгайлан заагаагүй, 2008 онд батлагдсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” баримт бичигт “АНУ, Япон болон ЕХ-той иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлах”-аар заасан,⁸⁶ харин 2010 онд шинэчлэн батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д «*“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ*»⁸⁷, харин 2011 онд шинэчлэн батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д «*АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх*»-ээр⁸⁸ анх удаа бодлогын хэмжээнд тус тус заажээ. Харин шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй

⁸⁴ “US Secretary of State John Kerry hails Mongolia as «oasis of democracy» in tough neighbourhood”- The Straits Times. Asia. June 5, 2016

⁸⁵ Энэ нь Монгол Улс ардчилалын оройд гарчихсан гэсэн үг биш нь мэдээж.

⁸⁶ Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ., 2008, 119 дэх тал

⁸⁷ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010

⁸⁸ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011

байдлын үзэл баримтлал”-д Холбооны [Европын Д.У] талаар заагаагүй байна. Үзэл баримтлалаас харахад Монгол Улсын «гуравдагч хөрш» гэдэгт *нэгд*, өндөр хөгжилтэй, *хоёрт*, ардчилсан улс, холбоо гэж ойлгогдож байгаа юм.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээ гэдэгт улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг хэлж байна.

Монгол Улсын гишүүнчлэлтэй, “гуравдагч хөрш” улсууд багтдаг олон улсын засгийн газар хоорондын тив дамнасан хамтын ажиллагааны форумд олон хэмжээст дипломат ажиллагаагаа идэвхжүүлэх өргөн боломжтой.

Монгол Улсын “*гуравдагч хөрш*”-ийн бодлогын ерөнхий буюу макро түвшний зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах гадаад таатай нөхцлийг хангах, гадаад харилцаанд нээгдэж буй асар их боломжийг дээд зэргээр ашиглах үндсэн дээр үндэсний хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлэх, нийт хүн төрөлхтний хамтын үнэт зүйлсийг хуваалцах, олон улсын тавцанд Монгол Улсын байр суурь, нэр хүндийг бэхжүүлэх явдалд оршино. ***Монгол Улсад нэгдүгээр хөрш гэж байхгүй, харин хоёр хөрш, “гуравдагч хөрш” гүрнүүд, бусад улс орнууд гэж буй.***

Монгол Улсын “*гуравдагч хөрш*”-ийн бодлого нь тус улс үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, нээлттэй, эвсэлд үл нэгдсэн, бие даасан гадаад бодлого явуулж буйн тод илрэл юм.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитик, гео-эдийн засгийн орчинд хэрэг дээрээ “гуравдагч хөрш”-тэй болж, түүний эрхзүйн үндсийг баттай тавьсан гэж үзэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой *«Иж бүрэн түншлэл»*, 2010 онд *«Стратегийн түншлэл»*, 1999 онд БНСУ-тай *«Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл»*, 2006 онд *«Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл»*, 2011 онд *«Иж бүрэн түншлэл»*, 2021 онд *«Стратегийн түншлэл»*, 2004, 2005 онд АНУ-тай *«хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэл»*, 2018 онд *хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, Өргөтгөсөн иж бүрэн түншлэл»*, 2019 онд *«Стратегийн түншлэл»*, 2004 онд Канадтай *«Өргөн хүрээтэй түншлэл»*, 2004 онд Турк улстай *«Иж бүрэн түншлэл»*, 2007 онд Австрали улстай *«Өргөтгөсөн түншлэл»*, 2008 онд ХБНГУ-тай *«Иж бүрэн түншлэл»*, 2011 онд Финландтай *«тэгш эрхтэй түншлэл»*, 2009 онд Энэтхэгтэй *«Иж бүрэн түншлэл»*, 2015 онд *«Стратегийн түншлэл»*, 2013 онд ЕХ-той *«Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»*-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулав.

2013 оны 9 дүгээр сард *Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр: 2013-2017»*-ийг батлан хэрэгжүүлж, 2017 оны 3 дугаар сард хоёр дахь үе шатны *«Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр: 2017-2021»*, 2018 оны 9 дүгээр сард *“Монгол Улс, АНУ-ын хоорондын эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглал”*-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна. *Дунд болон урт хугацааны хөтөлбөр бол стратегийн түншлэлийг хэрэгжүүлэх замын зураг мөн.*

Зарим улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч орчин үеийн олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг журам бүрэлдэн тогтох үйл явц өрнөж байгаа өнөө үед түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинж байх ёсгүй.

Даяаршлын одоо үед түншлэлийн эдийн засгийн утга, агуулга нь улам өргөжин тэлж байна. Нөгөө талд Монгол Улсын газарзүй, орон зайн байршил, байгалийн баялаг хоёр геополитикийн гол хүчин зүйл болов.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь эвсэл, холбоотны бодлого биш, хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого ч биш, мөн зөвхөн энхтайван цагийн геополитик гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Идэвхтэй, олон хэмжээст гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл мөн.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын амжилттай хэрэгжих үндэс нь Монгол Улсын хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах бодлого ба “гуравдагч хөрш”-ийн бодлогын хооронд стратегийн харилцаа, хамтын ажиллагааны тэнцвэрыг зохист түвшинд барих явдал (эсвэл хангагдахуйц нөхцлийг бүрдүүлэх) гэж хэлж болох байна.

Монгол Улсын үндэсний эрх ашгийг хөндөөгүй хоёр хөрш хийгээд “гуравдагч хөрш”-үүдийн хоорондын геополитикийн сөргөлдөөнд Монгол Улс оролцохгүй.

Түүнчлэн их гүрнүүдийн аливаа геополитикийн сөргөлдөөнт хэрэг явдалд Монгол Улс төвийг сахисан байр суурь баримталж буйг “төвийг сахих статус”-тэй холилж хутгаж болохгүй юм. Учир нь Монгол Улс “төвийг сахисан статус”-тай улс биш гэдгийг онцлон тэмдэглэх ёстой юм.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын онолын үндэс нь монголчуудын эртнээс инагш ахуй амьдрал, үйл ажиллагаандаа тууштай баримталсаар ирсэн **“тулгын гурван чулуу”** хэмээх үзэл баримтлал бөгөөд орчин үеийн гурван тулгуурт хөгжлийн онолын баримтлал болно. Өөрөөр хэлбэл «тогоо гурваас дээш хөлтэй байж гэмээнэ сая бат тогтвортой байдаг» хэмээх зарчим юм.

Түүнчлэн “гуравдагч хөрш”-ийн бодлого нь **зөөлөн тэнцвэржүүлэх** (soft balancing) хийгээд **зөөлөн хүчний бодлого** бөгөөд онолын үндэс нь **ухаалаг тэнцвэрын хүчин** (power of smart balance)-д суурилсан **ашиг сонирхлын тэнцвэр** (balance of interests) болно. “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь ашиг сонирхолын тэнцвэрт суурилсан ухаалаг тэнцвэрийн хүч мөний буй учир олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг баримталдаг олон улсын харилцааны идеалист онолд хамаарагдаж болохоор байгаа юм. Идэвхтэй гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл мөн.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого нь дан гагц нэг талын урсгалтай бус, тэдгээр орнууд ч Монгол Улсын “гуравдагч хөрш” гэсэн итгэл үнэмшилтэй байх явдал чухал гэдэг нь мэдээж. Гэхдээ улс орнууд бусдын өмнөөс илүү үүрэг хариуцлага хүлээх, өөрсдийн нуруун дээр илүү ачаа үүрэхээс тодорхой түвшинд зайлсхийдэг. Үндэсний аюулгүй байдлаа хангах асуудал нь бусдын аюулгүй байдлыг ямагт хөндсөөр ирсэн. “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого биш гэдгийг дахин онцлон тэмдэглэж байна.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого нь газарзүйн хязгаарлагдмал байдлаа даван туулж, нэмэлт шинэ боломжийг нээж, хөгжингүй, ардчилсан улс гүрнүүдтэй нээлттэй түншлэлийн харилцааг хөгжүүлснээр үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгийн аргаар баталгаажуулах бодлого юм. Энэ бол гадаад харилцаа, хамтын ажиллагааг бодит агуулгаар баяжуулж буйгаараа шууд ач холбогдолтой. Мөнхүү “гуравдагч хөрш”-ийн бодлогын цаана мэдээж нийгмийн шинжтэй зорилт, эрэлт хэрэгцээ оршиж ирснийг онцлон үзэх нь чухал болой.

Харилцан хамаарал гүнзгийрч, олон улсын харилцааны өөрчлөгдөн буй даяаршсан дэлхий ертөнцөд аливаа бага, жижиг улс орны оршин тогтнох, хөгжин дэвших, үндэсний аюулгүй байдлаа хангах нь гагц цэрэг-стратегийн асуудалтай холбогдохгүй, харин худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах, ардчилал, ухаалаг засаглалыг цогцлоох, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, мэдээлэл харилцаа холбоо, дижитал технологийг тууштай хөгжүүлэх, далайд гарцгүй байршлаа даван туулах болон улс орнуудын хоёр болон олон талт хамтын ажиллагаа зэрэгтэй уялдаж өргөн утгыг агуулах болсон байна. Энэ нь “гуравдагч хөрш”-ийн тухай ухагдахууныг тэлж байгаа хүчин зүйл юм.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого нь мэдээж Монгол Улсын эдийн засаг-нийгмийн хөгжлийг чанарын шинэ шатанд гаргах эрх ашгийн тухай асуудалтай холбогдох учиртай. Хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж буй өнөө үед улс орнуудын аюулгүй байдал, тусгаар тогтнол, гадаад эдийн засгийн харилцаа, түүнээс гарах үр өгөөжтэй амин чухал холбоотой. Энэ утгаараа сайхь бодлого нь гадаад харилцааг эдийн засагжуулахтай уялдах учиртай нь мэдээж. Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь гадаад харилцааны арга хэрэгслээр эдийн засгийн өгөөжийг дэмжихэд оршино. Өөрөөр хэлбэл, ДНБ-ий өсөлтөд гадаад бодлого, дипломат ажиллагааны оруулах хувь нэмрийг тууштай нэмэгдүүлж, шууд болон шууд бус үйлчлэлтэй болгох явдал юм.

Энэхүү бодлогын эдийн засгийн агуулга нь хүртээмжтэй буюу *inclusive*, тогтвортой буюу *sustainable*, тэнцвэртэй буюу *balanced*, шинэ үзэл баримтлал, технологид суурилах буюу *innovative*, эрчимтэй буюу *intensive*, далайцтай буюу *extensive* байх нь амжилтын үндэс болж байна.

Хүйтэн дайн дууссаны дараах Монголын геополитикийн гадаад, дотоод орчныг ХХ зууны сүүлийн арван жил, Шинэ мянганы эхний арван жил, хоёр дахь арван жил гэж гурав хувааж болохоор байна. Эдгээр оронзай, цаг хугацаа, таталцлын хүч өөр өөрийн өвөрмөц онцлог ялгаатай байсан хийгээд байгаа нь тодорхой байна.

Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого нь 2 үе шатыг дамжин явагдаж байна гэж үзэж болохоор байна.

Нэгдүгээр үе шат нь: Хоёр туйлт дэг тогтолцоо төгсгөл болж, Unipolarity (Pax Americana, American Primacy) буюу нэг туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо бүрэлдэн хүчирхэгжиж байсан үе. ЕЭЗХН, ЕХ болон өргөжсөн нь үүнд чухал түлхэц үзүүлсэн. Энэ үеийн гол агуулга нь олон улсын харилцаанд нөлөө бүхий өрнө, дорны хөгжингүй, ардчилсан гүрнүүдийн улс төр-дипломатын дэмжлэг, тэдний эдийн засгийн бодит ашиг сонирхлыг Монгол Улсад буй болгох чиглэлтэй байв.

1990 оны 7 дугаар сард АНУ-ын Хьюстон хотноо болсон Их Долоогийн бүлэг, ЕЭЗХН-ийн жил тутмын дээд уулзалтаас гаргасан улс төрийн Тунхаглалд Монголд өрнөсөн ардчилсан үйл явцыг тууштай дэмжих тухай заалт анх удаа тодорхой тусгагджээ. 1991 оны 7 дугаар сард Лондонд болсон Долоогийн бүлэг, ЕЭЗХН-ийн дээд уулзалтын баримт бичигт Монгол Улсад олон улсын тусламж үзүүлэх талаар заалт орсон юм. Уулзалтад Их Британий Ерөнхий сайд Жон Мейжорын урилгаар ЗХУ-ын Ерөнхийлөгч М.С. Горбачёв анх удаа оролцсоноор 7+1 хэмээх бүтэц бий болжээ. Энэ зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн Японы Засгийн газрын санаачлагаар ОУВС, Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагч орнуудын анхдугаар чуулга уулзалт 1991 оны 9 дүгээр сард Токиод зохиогдсон

юм. Энэ үед Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж, эдийн засгийн нэн хүндрэлтэй үетэй тулгарсан билээ.

Хандивлагчдын VII Зөвлөлдөх уулзалт 1999 оны 6 дугаар сард анх удаа Улаанбаатарт, IX Зөвлөлдөх уулзалт 2002 оны 7 дугаар сард Улаанбаатарт 2 дахь удаа зохиогдож нийт 600 сая, VIII Зөвлөлдөх уулзалт анх удаа Европт Парист 2001 оны 5 дугаар сард зохион байгуулагдаж, үүнд 32 орон, олон улсын байгууллага оролцож⁸⁹, 330 сая ам. доллар амласан байна. 1991 оноос хойшх 7 удаагийн уулзалтыг Токиод Японы Засгийн газар, Дэлхийн банк, ОУВС хамтран зохион байгуулж иржээ.

2003 онд Токиод зохиогдсон сүүлчийн X уулзалтаар Монголд 335 сая ам. доллар амлаж, шилжилтийн үе дууссаныг албан ёсоор зарлаж, хандивлагчдын бүлэг татан буугдав.

Нийт санхүүжилтийн 50-аас дээш хувийг Японы Засгийн газар дангаараа гаргаж байжээ. Нийт 12 жилийн хугацаанд Монгол Улс хөгжлийн нэн хөнгөлтэй зээл 1.1 тэрбум ам. доллар, буцалтгүй тусламж 1.3 тэрбум ам. доллар авч ашигласан нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд үлэмж чухал үүрэг гүйцэтгэсэн.

Дурьдсан үед ОХУ-ын нийгэм-эдийн засаг нэн хүндрэлтэй, БНХАУ-ын эдийн засаг хурдацтай хөгжлийнхөө үе шатанд явж байв. Үндсэндээ үсрэнгүй хөгжлийн оршил үедээ урагшилж байжээ. Монгол Улс 1993 онд ОХУ-тай⁹⁰, 1994 онд БНХАУ-тай “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ”⁹¹-г тус тус байгуулсан нь нэн чухал ач холбогдолтой байв.

Социализм нуран унаснаас хойших 1990-ээд онд АНУ дэлхий дээр жолоодогчийн үүрэг гүйцэтгэх тухай үзэл санаа бодлогын шинж чанартай болж байгаад (ОХУ, лалын ертөнц) ихээхэн эгдүүцэн дургүйцэж байгаа тухай судлаачид, улс төрийн тоймчид онцлон тэмдэглэж байв. Үүнийг зарим улс гүрэн ганцаараа жанжлах гэсэн эрмэлзлэл гэж ч шүүмжлэдэг. АНУ, түүний холбоотнууд хүйтэн дайнд ялалт байгуулсны дараах үед АНУ-ын гадаад бодлого нь дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг сэргээн баталгаажуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг түгээн дэлгэрүүлэх тухай хөтөлбөр байсан юм. Харин ийнхүү дурьдаж байгаа нь хүйтэн дайны дараа үүсэн бүрэлдэж буй олон туйлт бүтцийн үүргийг бодитой үнэлэх үндсэн дээр дэлхийд зохистой шинэ дэг журам тогтоох хэрэгт АНУ зонхилох үүрэг гүйцэтгэх чадавхтайг үгүйсгэж байгаа хэрэг биш гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Ямар ч тохиолдолд глобалчлалын эрин үед өрнө, дорно, лалын соёл иргэншлүүд тэвчээртэй байж, бие биеэ хүндэтгэн, энхтайвнаар зэрэгцэн орших нөхцөлд л худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёлын харилцаагаа өргөн дэлгэр хөгжүүлж, илүү аюулгүй олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцааны шинэ дэг журмыг тогтоох боломжтой.

⁸⁹ The Consultative Group meeting in Paris on May 15-16, 2001, was attended by delegations from 32 countries and international organizations. It was chaired by Ian Porter, World Bank Country Director for Mongolia. The Mongolian delegation to the meeting was led by the Minister of Finance and Economy, Chultemiin Ulaan. Countries and international organizations present were: Australia, Canada, China, Czech Republic, France, Germany, India, Japan, Korea, Kuwait, Luxembourg, The Netherlands, Russia, Sweden, Switzerland, Turkey, United Kingdom, United States, ADB, EC, EBRD, FAO, IFAD, ILO, IMF, NDF, OECD, Soros Foundation, UNDP, UNESCO, UNOPS, and WHO. Mongolian NGO and Private Sector representatives also attended the meeting.

⁹⁰ Монгол Улс, ОХУ-ын хоорондын Найрсан харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ. УБ., 1993

⁹¹ Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ. УБ., 1994

1945-1990 оны үе бол хүйтэн дайны үе буюу социализм, капитализм гэсэн хоёр туйлт (bipolarity) олон улсын харилцааны дэг журам үйлчилж байв. 1990-ээд он бол олон улсын харилцааны нэг туйлт (unipolarity) дэг журам буюу АНУ-ын оройлол (Pax Americana or American Primacy) онцгойрч байсан үе юм.

Харин 1994 оны “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д Монгол Улсын чухаг түнш их долоогийн бүлгийн гишүүн Их Британи, Франц, Итали, Канад болон Бельги, ЕХ-г огт дурьдалгүй орхигдуулсан атлаа, Энэтхэг, Өмнөд Солонгос, Тайланд, Сингапур, Түрк, Дани, Нидерланд, Финланд, Австри, Швед, Швейцари зэрэг улсуудыг оруулсан байсныг гадаадын судлаачид шүүмжилж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Хоёрдугаар үе шат бол A New Multi-Polar World буюу олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үе шат хэмээн тодорхойлж байгаа юм.⁹² Энэ үе бол ОХУ-ын эдийн засгийн сэргэлт, БНХАУ-ын эрчимтэй хөгжил, дурьдсан хоёр их гүрний стратегийн түншлэл, Орос, Хятадын оролцоотой олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвшин хөгжиж⁹³ байгаа үе юм. Энэ үед Монгол Улс Үндэсний аюулгүй байдал хийгээд Гадаад бодлогын шинэчилсэн үзэл баримтлалд “гуравдагч хөрш” бодлогыг анх удаа томъёолсон. Эдүгээ **Монгол Улс олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцын татах хүчний яг төвд нь оршиж байна гэж хэлж болохоор байна.** ОХУ, БНХАУ-ын оройлолтой олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцын татах хүчийг Монголыг тойрсон геополитикийн орчинд ШХАБ, БРИКС⁹⁴, ЕАЭЗХ, АДБХОБ, торгоны их замын дагуух “нэг зам, нэг бүслүүр” дэд бүтцийн мега санаачилга бүрдүүлж байна гэж үзэж болохоор байгаа юм.

Гэхдээ олон туйлт дэлхийн шинэ дэг журам гэдэг нь АНУ+ЕХ, Орос, Хятад+НҮБ гэж авч үзэх нь зүй. **Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шатанд хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах, гурвалсан хөршийн бодлого, “гуравдагч хөрш”-ийн бодлогын хооронд эрх ашгийн тэнцвэрийг зохист түвшинд барих үндсэн дээр ухаалаг тэнцвэрийн хүчийг олох явдал шинээр тавигдаж байна.** Украины хямралын үндсэн шалтгаан нь ОХУ, Өрнө дахины хооронд стратегийн тэнцвэр, эрх ашгийн тэнцвэрийг барьж чадаагүйд оршино. Тийнхүү бие биенийхээ эрх ашигт хэрхэн нөлөөлөхгүй байх тухай асуудал чухал болов.

Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцахуй

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын амжилттай хэрэгжих үндэс нь Монгол Улсын хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах бодлого ба «гуравдагч хөрш»-ын бодлогын хооронд зохист тэнцвэрийг барих (эсвэл хангагдахуйц нөхцөл бүрдсэн байдал) явдал гэж хэлж болох юм. Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улстөр-дипломатын аргаар хангахад юуны өмнө хоёр хөрш гүрэнтэйгээ тэнцвэртэй харилцах явдал нэн чухал билээ.

2011 оны 2 дугаар сард шинэчлэн батлагдсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ийн 14.1-т: **«ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ**

⁹² 2016 оны 10 дугаар сарын 16-нд Энэтхэгийн Гоа мужид зохиогдсон БРИКС-ийн дээд уулзалтаас гаргасан Гоагийн Тунхаглалд: “...зөвхөн олон улсын эрхзүйг дээдэлж, НҮБ-ын гол үүрэгт суурилсан олон туйлт олон улсын дэг журмыг цогцлоон байгуулах” тухай заасан байна.

⁹³ Энэ шинэ дэг тогтолцоо нь мэдээж АНУ, ЕХ, Энэтхэг, Япон, БНСУ зэрэг гүрнүүдээс ангид биш юм.

⁹⁴ Судлаачид Бразил, ӨАБНУ-ын эдийн засгийн хүндрэлтэй байдлаас БРИКС-ийн үүрэг бүдгэрч байна гэж үзэж байсан. Сьямань хотод зохиогдсон дээд уулзалтын дараа байр сууриа дахин сэргээсэн гэж хэлж болно.

тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ» гэж заасан нь 1994 оны заалтыг дахин нотолсон хэрэг юм. Харин «Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана»⁹⁵ гэсэн өмнөх баримтлалын заалтыг хэвээр үлдээсэн нь зарчмын ач холбогдолтой.

Тэнцвэртэй харилцах гэдэг нь улс төрийн чиг шугам юм. Өөрөөр хэлбэл, хойд хөрштэйгөө бүх салбарт ойртон нягтарч, өмнөд хөршийнхөө эсрэг бодлого, байр суурь баримталж байсан хуучин бодлогоо үндсээр нь өөрчилж, улс төрийн хувьд аль нэг хөршөө аялдан дагахгүй, тэнцвэртэй харилцах тухай л асуудал юм. Эдүгээ дэлхийн бараг бүх орон худалдаа-эдийн засгийн хувьд Хятадаас хамааралтай болсон. АНУ-ын гадаад худалдаанд гэхэд л Хятад маш өндөр хувь эзэлдэг. Гэтэл манайд 100 км төмөр замын 50 км-ыг өмнөд хөршөөр, үлдсэн 50-ыг нь хойд хөршөөр тавиулбал тэнцвэртэй харьцаж байгаа юм шигээр тайлбарлах нь буй. Хөрөнгө оруулалтын хувьд ч ялгаагүй. Хоёр хөрштэйгөө худалдаа-эдийн засгийн хувьд бараг л тавь тавин хувь л байгаа юм. Өргөн хэрэглээний барааны хувьд 85 хувь Хятадаас, түлш, шатахуун, эрчим хүчний хувьд 95 хувь Оросоос хамааралтай байгаа нь бараг л тэнцвэртэй гэж ойлгогдож байна. Даяаршлын эрин үед улс орнууд эдийн засгийн талаар тэнцвэртэй харьцах боломж хязгаарлагдмал. Дахин тэмдэглэхэд тэнцвэртэй харилцах гэдэг нь улс төрийн хувьд тэнцвэртэй харилцах гэсэн утга ажгуу.

Хамгийн сүүлд Монгол Улс 2002 онд ОХУ-тай 3543 км урт хилийг хамтран шалгаж эцэслэн тодотгосон бол, 2001-2004 онд БНХАУ-тай хилээ хоёрдахь удаагаа хамтран шалгаж, 4676.8 км урт хилийн шугамыг тогтоож, Монгол Улсын хилийн багануудыг анх удаа боржин чулуугаар шинэчлэн босгож, НҮБ-д бүртгүүлэв. Ийнхүү өнөөдөр Монгол Улсын хилийг эмжсэн 8219 км 895 м урт хил олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байна.

Чингэснээр Монгол Улс Зүүн хойд Азийн бүс нутагт хөрш орнуудтайгаа газар нутгийн аливаа маргаангүй цорын ганц улс болсон нь тус улсын нэр хүндийг өсгөж, байр суурийг бэхжүүлэв.

2003 оны эцэст Монгол Улс хуучнаар ЗХУ-д төлөх ёстой “*их өр*”-ийг тэглэсэн нь Монгол-ОХУ-ын цаашдын харилцаанд нэн таатай нөхцөл бололцоог бүрдүүлээд зогсохгүй Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулж, олон улсын тавцан дахь нэр хүндэд үлэмж сайнаар нөлөөлсөн хүчин зүйл болов. Үүгээр Монгол Улсын олон улсын зээлжих зэрэглэл эрс дээшилж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн юм. Энэ нь Оюутолгой, Тавантолгойд суурилсан үсрэнгүй хөгжлийн тухай ярихад хүргэсэн нь үнэн болой.

Халхын голын дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан 2014 оны 9 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал Монгол, Оросын харилцааны түвшинг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой болов. Айлчлалын хүрээнд “Иргэд харилцан визгүй зорчих тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр”-т гарын үсэг зурсан нь хоёр улсын иргэд 30 хүртэл хоногийн хугацаанд харилцан визгүй зорчих болон дамжин өнгөрөх эрхтэй болсон нь нэн чухал ач холбогдолтой байв. Хоёр тал мөн “Улаанбаатар төмөр зам”-д шинэчлэл хийх, хос төмөр зам барих, цахилгаанжуулах асуудлыг шийдвэрлэхээр харилцан тохиролцсон боловч

⁹⁵ Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном: 2007-2011, ГХЯ, УБ., 2011, 114 дэх тал

Монголын талын идэвхгүй байдлаас шалтгаалан өнөөдрийг хүртэл дорвитой ахиц гараагүй байна.

Хоёр хөрштэй тогтоосон харилцааны шинэ үе шат-Иж бүрэн стратегийн түншлэл

Өрнөдийн эдийн засгийн хориг арга хэмжээний дараа ОХУ-ын Алс Дорнодын бодлого эрс идэвхжиж, БНХАУ-тай “Иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл”-д шилжиж, Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн ач холбогдлыг өсгөж байгааг тууштай ашиглах шаардлагатай байна.

Гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн ажлын айлчлалын үр дүнгээр гаргасан Хамтарсан Албан мэдээнд: хоёр орны харилцааг *«сайн хөршийн уламжлалт түншлэл»* хэмээн тодорхойлсон юм.⁹⁶ 2006 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын айлчлалын үеэр *Стратегийн түншлэл байгуулах Москвагийн Тунхаглал*-д гарын үсэг зурав.⁹⁷ Үүгээр Монгол Улс стратегийн түншлэлийн харилцааг анх удаа хойд хөрш ОХУ-тай тогтоов.

2009 оны 8 дугаар сард Халх голын ялалтын 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр *“Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Улаанбаатарын Тунхаглал”*-д гарын үсэг зурсан нь⁹⁸ хоёр орны харилцааны түвшинг шат ахиулсан чухал ач холбогдолтой үйл явдал болов.

2016 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотноо хоёр улсын Гадаад хэргийн сайд нарын гарын үсэг зурсан *«Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Дунд хугацааны хөтөлбөр»*-т гарын үсэг зурсан⁹⁹ нь хамтын ажиллагааны *Замын зураг* болж байна. Мэдээж энэхүү баримт бичгийг шинэчлэн баяжуулах шаардлага буй.

2017 оноос хойш Владивосток хотноо уламжлал болон зохиогдож буй Дорнын эдийн засгийн форумд Монгол Улс Ерөнхийлөгчийн түвшинд биеэр болон цахим хэлбэрээр оролцож, ОХУ-ын Ерөнхийлөгчтэй уулзаж, яриа хэлэлцээ хийж байгаа нь хамтын ажиллагааны байнгын механизмын нэг хэлбэр болж байна.

Халхын голын ялалтын түүхт ялалтын 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2019 оны 9 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад албан ёсоор айлчилж, энэ үеэр *«Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын Гэрээ»*-г¹⁰⁰ (21 зүйл бүхий) хугацаагүй байгуулсан нь нэн чухал ач холбогдолтой үйл явдал болов. Гэрээг хугацаагүй байгуулсан нь хоёр улсын хооронд найрсаг харилцаа, итгэлцлийн түвшинг тод харуулсан нэн чухал үйл явдал болов.

⁹⁶ Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай Хамтарсан Албан мэдээ. М.: 2006.07.01

⁹⁷ Московская декларация о стратегическом партнерстве между Монголией и Россией. 8 декабря 2006 г.

⁹⁸ Декларацию о Развитии стратегического партнерства между Российской Федерацией и Монголией от 25 августа 2009 года. Уланбатор.: Монголия

⁹⁹ Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Дунд хугацааны хөтөлбөр» УБ., 2016.04.14

¹⁰⁰ «Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын Гэрээ» УБ., 2019.09.03

«Монгол Улс , ОХУ-ын хооронд Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн Гэрээ»-г УИХ 2019 оны 11 дүгээр сарын 29-нд, ОХУ-ын Холбооны Хурлын Доод танхим болох Төрийн Дум 2020 оны 6 дугаар сарын 23-нд, Дээд танхим буюу Холбооны Зөвлөл 7 дугаар сарын 8-нд соёрхон баталж,¹⁰¹ Ерөнхийлөгч В.Путин гэрээг соёрхон баталсан хуульд 7 дугаар сарын 13-нд гарын үсэг зурж, 2020 оны 9 дүгээр сард Монгол Улсын Гадаад хэргийн сайдын Москвад хийсэн айлчлалын үеэр батламж жуух бичигт гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.

2020 онд Монгол Улсаас ОХУ-д хийсэн экспорт 57 сая 273.8 мянган ам. доллар, импорт 1 тэрбум 399 сая 962.3 мянган ам. доллар¹⁰², 2021 онд Монголын экспорт 112.8 сая ам. доллар, импорт 1, 960.6 сая ам. доллар болж байгаа нь “Иргэд харилцан визгүй зорчих тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” амжилттай хэрэгжиж буй илрэл болж, тийнхүү хоёр улсын хил орчмын субъектүүдийн хоорондох худалдааны харилцаа мэдэгдэхүйц идэвхэжсэн, нөгөө талд Монголд импортоор орж ирж буй суудлын автомашины тоо ширхэг эрс өссөн нь шатахууны импорт өсөхөд голлон нөлөөлсөнтэй холбоотой. ОХУ, Монголын экспортын 1.2 хувь, импортын бүтээгдэхүүний 28.6 хувийг эзэлж, импортоор оруулсан барааны 51.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна.¹⁰³

2003 оны 6 дугаар сард БНХАУ-тай «*Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл*», 2011 оны 6 дугаар сард «*Стратегийн түншлэл*», 2014 оны 8 дугаар сард Монгол, Хятадын төрийн тэргүүн нар Улаанбаатар хотод хоёр орны харилцааг *Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүрсэн хэмээн дүгнэж*, уг харилцааг хөгжүүлэх Тунхаглалд гарын үсэг зурсан нь¹⁰⁴ чухал ач холбогдолтой үйл явдал болов.

2013 оны 10 дугаар сарын 25-нд Бээжинд хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан «*Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр*» нь хамтын ажиллагаагаа тодорхой салбаруудаар хэрэгжүүлэх *Замын зураглал* болж байгаа юм.¹⁰⁵

Статистикийн бодиттой тоо баримтаас үзэхэд, Хятадтай хийсэн гадаад худалдаанд Монгол Улс 2018 онд 4,548,011.1 ам. долларын ашигтай¹⁰⁶, 2019 онд 4,728,977.6 ам. долларын ашигтай,¹⁰⁷ 2020 онд 3,583,370.0 ам. доллар,¹⁰⁸ 2021 онд 5, 123,900.0 ам. долларын ашигтай¹⁰⁹ гарсан байхад Монгол Улс Хятадаас хараат байна гэж тайлбарлаж буй нь ихээхэн учир дутагдалтай. Дэлхийн эдийн засаг өөрөө Хятадаас хамааралтай байгаа билээ.

БНХАУ нь Монгол Улсын нийт экспортын 82.7, импортын 36.8 хувийг эзэлж байна. БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 32.3 хувийг чулуун нүүрс, 38.0 хувийг зэсийн баяжмал эзэлж байна. Импортолсон барааны 5.0 хувийг цахилгаан эрчим хүч, 11.3

¹⁰¹ ОХУ-ын Парламент болох Холбооны Хурал нь Доод танхим буюу Төрийн Дум, Дээд танхим буюу Холбооны Хурлаас тогтодог.

¹⁰² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2021.04.22

¹⁰³ Үндэсний Статистикийн хороо. Статистикийн мэдээ. 2022.01.12

¹⁰⁴ Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал. УБ.: 2014.08.21

¹⁰⁵ Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25

¹⁰⁶ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2019.01.25

¹⁰⁷ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2020.01.30

¹⁰⁸ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2021.06.30

¹⁰⁹ Үндэсний статистикийн хороо. Статистикийн мэдээ. 2022.01.12

хувийг ачааны тэрэг, 83.7 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.¹¹⁰

Хоёр хөрш Монгол, Хятадын харилцааны өндөр түвшинд хөгжиж буй таатай үндэс суурь болон бодит шаардлагад үндэслэн, хоёр улс, хоёр ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн стратегийн түншлэлийн харилцааг улам бүр гүнзгийрүүлэх хамтын хүсэл эрмэлзлэлийн дагуу мөнхөд итгэлтэй, хариуцлагатай сайн хөрш, сайн түнш, сайн анд байхын тулд Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны түвшинг дээшлүүлэн Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоохоор санал нэгтгэйгээр тийнхүү тохиролцов.

Хоёр улсын удирдагч нар янз бүрийн шугамаар уулзалдаж, стратегийн зохицуулалтыг эрчимжүүлж, улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлнэ гэж үзсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2021 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлал, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Бээжин-2022 өвлийн XXIV олимпын тоглолтын нээлтийн арга хэмжээнд оролцож, Хятадын удирдагуудтай ажил хэргийн уулзалт хийсэн нь нэн чухал ач холбогдолтой болсон юм.

Тийнхүү Монгол Улс хоёр их хөрштэйгөө иж бүрэн стратегийн түншлэлийн эрхзүйн үндсийг баттай тавьж, гурван хөршийн хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулан хөгжүүлж байна.

Түүнчлэн хоёр хөрштэйгээ хоёр талын харилцааг чанарын шинэ шатанд гаргасан нь *«гуравдагч хөрш»*-ийн бодлогыг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж болох байна. Гэхдээ хоёр хөрш, “гуравдагч хөрш”-үүдийн хооронд Шинэ хүйтэн дайн эхэлсэн гэдгийг анхааралдаа авах ёстой болов.

Гурван хөршийн саммитын шинэ парадигм

Монгол Улсын гадаад бодлогод гарсан шинэ парадигм бол гурван хөршийн дээд түвшний уулзалтын эрх зүйн үндэс тавигдаж, байнгын механизм буй болсон явдал юм.

Энд нэг баримтыг тэмдэглэхэд, БНМАУ-аас хөрш хоёр оронтой тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн төлөвийг нээсэн чухал үйл явдлын нэг нь ЗХУ, БНХАУ-ыг Монголын нутгаар холбосон төмөр зам тавьж, ашиглалтад оруулсан явдал байв. Төмөр зам тавих асуудлаар хэлэлцээр байгуулахаар гурван улсын удирдагчид 1952 оны 9 дүгээр сарын 15-нд Москвад хэлэлцээр байгуулсан юм. Энэхүү хэлэлцээрт БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай, ЗСБНХУ-ын СнЗ-ийн Нэгдүгээр орлогч дарга бөгөөд ГЯЯ-ны сайд А.Я.Вышинский нар гарын үсэг зурж, И.В.Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдагчид байлцжээ. Москвагийн энэхүү уулзалт гурван хөршийн удирдагчдын хамгийн анхны дээд түвшний уулзалт байв.

Уг хэлэлцээрийн үр дүнд Улаанбаатар-Замын-Үүд-Жинчиний хооронд төмөр зам барихаар тохиролцож, бүтээн байгуулалтын ажил амжилттай өрнөж эхэлжээ. 1955 оны 12 дугаар сарын 31-нд Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замыг нээх ёслолын үйл ажиллагаа Улаанбаатарт болж, 1956 оны 1 дүгээр сарын 1-ээс ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа нээсэн тухай дэлхийн улс орнуудад зарлан тунхагласан байна.

¹¹⁰ Мөн тэнд,

1956 оны 1 дүгээр сарын 3-нд Монгол, Хятадын хил дээр төмөр замыг холбосон мөнгөн хадаасыг хадах ёслолын ажиллагаа болж, БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, ЗСБНХУ-ын Зам харилцааны сайд Б.П.Бещев, БНХАУ-ын Зам харилцааны сайд Тэнь Дэюан нар оролцсон байна.

Монгол Улс гурвалсан яриа хэлэлцээний байнгын институцтэй болох чиглэлд анхны алхам хийсэн нь хөрш хоёр гүрний бодлого, байр суурийг илүү тодорхой ойлгож мэдэх, өөрийн улсын бодлого, байр суурийг илүү ойлгомжтой тайлбарлаж, дэмжлэг авахад нэн ач холбогдолтой байв. Хөрш гурван улсын ГХЯ-д хоорондын 8 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Улс төрийн газрын захирал нарын түвшинд 2012 оны 10 дугаар сард Москва хотноо болов. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны гурван талт зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Төгсбилгүүн, ОХУ-ын Гадаад хэргийн яамны Азийн Нэгдүгээр газрын захирал А.Б.Кулик, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны Азийн газрын захирал Луо Жаохуй нар төлөөлөгчдөө тэргүүлэн оролцсон бөгөөд ОХУ-ын Гадаад хэргийн дэд сайд И.В. Моргулов төлөөлөгчдийн тэргүүн нарыг хүлээн авч уулзаж, талуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, ойрын төлөв, уулзалтын үр дүнгийн талаар санал солилцжээ.

Анх удаагаа албан ёсны статустайгаар болсон гурван талын зөвлөлдөх уулзалт цаг хугацааны сорилтыг амжилттай давж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны харилцан сонирхсон асуудлыг хэлэлцэх зохистой талбар болсон хэмээн талууд санал нэгтгэж үзсэн юм. Монгол, Орос, Хятадын хооронд улс төрийн болон түүхийн аливаа шийдэгдээгүй асуудал байхгүйг талууд цохон дурдахын сацуу бие биенийхээ тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх нь зүйд нийцнэ хэмээн үзэв. Талууд гурван талт хамтын ажиллагааны хөгжлийг нааштайгаар үнэлж, Монгол, Орос, Хятадын харилцан ажиллагааны тэргүүлэх чиглэл, түүнчлэн бүс нутгийн болон олон улсын асуудлаар санал бодлоо нухацтай солилцсон байна.

Гурван талын зөвлөлдөх уулзалт уул уурхайн салбар, дамжин өнгөрөх тээврийн гурван улсын нөөцийг хамтран ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлал, байгаль орчин, хүмүүнлэгийн солилцоо зэргийг талуудын харилцан сонирхолд нийцсэн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл хэмээн тэмдэглэв. Үүн дээр хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан дипломат ажиллагаа, хямралын менежментийн асуудлыг нэмж оруулах нь зүйтэй хэмээн судлаачид тэмдэглэж байв¹¹¹.

Цаашдаа эхний үе шатанд гурван улсын Гадаад харилцааны сайд нарын уулзалтыг зохион байгуулж, үүний дараах үе шатанд ойрын ирээдүйд гурван хөршийн саммит зохион байгуулах гэсэн парадигмыг санаачлан хэрэгжүүлэх асуудал байсан юм. Өөрөөр хэлбэл, АСЕАН+3 шиг дээд уулзалтыг зохион байгуулж, хамтын ажиллагааны байнгын механизм буй болгох чиглэлээр ажиллаж болох санал байв. Мэдээж энэ бүгд идэвхтэй дипломат ажиллагаа, хүчин чармайлт, цаг хугацаа шаардаж байсан нь ойлгомжтой.

2013 оны 10 дугаар сарын 25-нд Бээжинд хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр»-ийн Тавын 5-д заахдаа: “Талууд Монгол, Хятад,

¹¹¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. (эрхэлсэн проф. Д.Уламбаяр) УБ., 2014, 12-13 дахь тал

Оросын гурван талын зөвлөлдөх уулзалтын механизмыг үргэлжлүүлэн бэхжүүлэх, дэд сайдын түвшний зөвлөлдөх уулзалтын механизмыг байгуулах асуудлыг урагшлуулахаар санал нэгтэй тохиролцов. Шаардлагатай тохиолдолд гурван талын өндөр түвшний уулзалт зохион байгуулж, Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг улам бүр урагшлуулна”¹¹² гэж заасан нь чухал ач холбогдолтой байв.

2014 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн «Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай Улаанбаатарын хамтарсан Тунхаглал»-ийн *дөрөвт* заахдаа: “Талууд Монголын талын санаачилсан Монгол, Хятад, Орос гурван улсын удирдагчдын уулзалтыг зохион байгуулах, гурван талын яриа хэлэлцээний механизмыг бэхжүүлэх, гурван талын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийг дэмжинэ” гэсэн байна.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын анхны гурван талт дээд хэмжээний уулзалт 2014 оны 9 дүгээр сард Тажикстаны нийслэл Душанбе хотноо амжилттай зохион байгуулагдав. Уулзалтаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нар уулзалтын агуулга, зарчмыг хэлэлцэж байх асуудлын тухай Монгол Улсын санаачилгын талаар тийнхүү хэлэлцэж, тодорхой ойлголцол, тохиролцоонд хүрэв. Энэ бол Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм байв.

ШХАБ-ын дээд уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путин, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар 2014 оны 9 дүгээр сарын 11-нд БН Тажикстан Улсын нийслэл Душанбе хотноо гурван талын түүхэн уулзалт хийж, гурван улсын дээд түвшний “Улаанбаатарын уулзалт”-ыг зохион байгуулах хугацаа, давтамж, зарчим, хэлэлцэх асуудлын хүрээг ярилцаж тохиролцов. Мөн “Улаанбаатарын уулзалт”-ыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор Гадаад хэргийн дэд сайд нарын түвшний уулзалтыг жил бүр зохион байгуулж байхаар болж, санал нэгдсэн байна. Эдгээр хүчин зүйлтэй уялдан Монгол Улс дараах гурван зарчмыг санал болгосон юм. Үүнд: *нэгд*, Гурван улсын дээд хэмжээний албан уулзалтыг байнга Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод, гурван жил тутам хийх, *хоёрт*, Энэ уулзалт нь олон нийтэд нээлттэй, гурван улсын хамтын ажиллагааны нийтлэг зарчимд нийцсэн байх, *гуравт*, Уг уулзалтаар талуудын сонирхсон асуудал, тэр дундаа гурван улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэр, дэд бүтцийн болон бүс нутгийн шинж чанартай асуудлыг ярилцаж шийдвэрлэж байх эдгээр байв.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд нарын түвшний анхдугаар зөвлөлдөх уулзалт 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдав. Зөвлөлдөх уулзалтад Монгол Улсын Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дэд сайд Д.Ганхуяг, БНХАУ-ын Гадаад хэргийн орлогч сайд Чөн Гуопин, ОХУ-ын Гадаад хэргийн орлогч сайд И.В.Моргулов нар гурван талыг тэргүүлэн оролцжээ. Мөн үеэр төлөөлөгчдийн тэргүүн нар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайдын үүргийг хариуцагч нарт тус тус бараалхсан байна.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд нарын түвшний II уулзалт 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Бээжин хотноо болжээ. Уулзалтад Монгол Улсын

¹¹² Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. Бээжин.: 2013.10.25

Гадаад хэргийн дэд сайд Н. Оюундарь, ОХУ-ын Гадаад хэргийн дэд сайд И.В.Моргулов, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Чөн Гуопин нар гурван талыг тэргүүлж оролцжээ. Гурван талт хамтын ажиллагааг худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, хүмүүнлэг зэрэг салбарт өргөжүүлэн хөгжүүлж, бодит агуулгаар баяжуулах нь зүйтэйг талууд онцлон тэмдэглэж, 2015 оны 7 дугаар сард ОХУ-ын Уфа хотноо болох гурван талт дээд хэмжээний уулзалтын үеэр гарын үсэг зурах баримт бичгүүдийн талаар санал солилцсон байна. Мөн өдөр БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайд Н.Оюундарь, ОХУ-ын Гадаад хэргийн дэд сайд И.В.Моргулов, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Чөн Гуопин тэргүүтэй гурван улсын төлөөлөгчдийг хүлээн авч, дэд сайд нарын түвшний II уулзалтын дүн болон гурван талт хамтын ажиллагааны тодорхой асуудлаар ярилцжээ. Тийнхүү гурван улсын Гадаад хэргийн дэд сайд нарын зөвлөлдөх уулзалт нь дээд уулзалтын бэлтгэлийг хангах чухал үйл явц болсон юм.

2015 оны 7 дугаар сард ОХУ-ын Башкирын нийслэл Уфа хотод зохиогдсон гурван хөршийн хоёрдахь дээд түвшний уулзалт хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд ач холбогдолтой болов. Тус уулзалтаар *“Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах тухай Санамж бичиг”*-т¹¹³ гарын үсэг зуржээ.

2016 оны 6 дугаар сард Узбекистаны нийслэл Ташкент хотноо зохиогдсон гурван хөршийн дээд түвшний уулзалтаар Орос, Монгол, Хятадыг дамнасан эдийн засгийн коридор байгуулах асуудлаар санал нэгдэж, 32 төсөл дээр тохиролцсон билээ. Гурван талт хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бүс нутаг, олон улсын харилцааны чиг хандлагыг тодорхойлсон *“Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааг Дунд хугацаанд хөгжүүлэх Замын зураглал”*¹¹⁴ болон хамтын ажиллагааны тодорхой 32 төслүүдийг тогтсон *“Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”*¹¹⁵ гэсэн хоёр чухал баримт бичгийг байгуулсан нь том амжилт мөн.

Замын зураглалд “ЕАЭЗХ”, “Торгоны замын эдийн засгийн бүс” болон “Талын зам” санаачилгыг нэгтгэн уялдуулах хэлбэрээр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн коридорт хамтран ажиллах хөтөлбөрийг боловсруулан байгуулах...Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу газрын тосны хоолой барих тухай тодорхой саналууд бүрдэж, энэхүү төслийг хэрэгжүүлэхийн ач холбогдлын талаар харилцан зөвшилцөлд хүрсэн тохиолдолд Талууд төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхэлнэ”¹¹⁶ гэж заасан байна.

2018 оны 6 дугаар сард БНХАУ-ын Чиндао хотноо зохиогдсон гурван хөршийн дээд түвшний уулзалт шинэ үе шат болов. Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан төслүүдийн нарийвчилсан судалгаа хийх, эдийн засгийн үндэслэлийг сайтар боловсруулах үүднээс Хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төвийг байгуулахыг яаравчлах нь зүйтэй гэж үзсэн юм. 2018 оны 8 дугаар сард Москвад чуулсан шинжээчдийн уулзалтаар батлагдсан 32 төслөөс эхний ээлжинд тэргүүлэх гурван чиглэл болох эрчим

¹¹³ “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах Санамж бичиг” ОХУ. 2015.07.09

¹¹⁴ “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааг Дунд хугацаанд хөгжүүлэх Замын зураглал”. 2016.06.23

¹¹⁵ “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах Хөтөлбөр” 2016.06.23

¹¹⁶ “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааг Дунд хугацаанд хөгжүүлэх Замын зураглал”. 2016.06.23

хүчний сүлжээ, төмөр замын коридор, автозамын коридор дээр төвлөрч, Монгол Улсын ГХЯ-нд гурван талын Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулахаар болсон юм.

2018 оны 9 дүгээр сард зохиогдсон Дорны эдийн засгийн форумын үеэр урагш алхсан нэг асуудал нь байнгын механизмтай болох тухайд гурван улсын холбогдох яамд “Хамтын ажиллагааны Санамж бичиг” байгуулсан явдал болно.

Энэхүү механизмын хүрээнд “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор бий болгох ажлыг хамтран урагшлуулах гурван талын ажлын хэсгийн шинжээчдийн түвшний зөвлөлдөх уулзалт 2018 оны 12 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдав. Уулзалтаар төмөр замын төв коридорыг үе шаттай шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг судлах хамтарсан ажлын хэсэг байгуулах, Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг идэвхжүүлэх, Улаанбаатар хотноо гурван талын Хөрөнгө оруулалтын зураг төслийн төв байгуулах ажлыг эрчимжүүлэхээр тохиролцжээ. Түүнчлэн төмөр замын хойд коридорын Эрдэнэт-Овоот чиглэлийн төслийг хэрэгжүүлэх, Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн дамжин өнгөрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарт хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцсон байна.

2019 оны 4 дүгээр сарын 25-28-нд Бээжинд зохиогдсон “Бүс ба зам” олон улсын хамтын ажиллагааны II форумын үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпин Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор байгуулах ажилд гаргаж буй хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийг уриалжээ. Тэрбээр Бээжин хотноо болсон Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгатай уулзахдаа ийм мэдэгдэл хийсэн юм. “Бүс ба зам” санаачилгыг Монголын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулах, мөн Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор байгуулах ажилд илүү их хүчин чармайлт тавих шаардлагатай байна”¹¹⁷ гэж Ши Жиньпин хэлсэн нь анхаарах асуудал байв. Уулзалтын үеэр талууд Хятадын Засгийн газрын санаачилгыг Монголын талын “Хөгжлийн хөтөлбөр”-тэй уялдуулах хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурсан юм.

2019 оны 5 дугаар сард Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад харилцааны дэд сайд нарын ээлжит уулзалт Бээжин хотноо болж, Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг, ОХУ-ын Гадаад хэргийн орлогч сайд И.В.Моргулов, БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Жан Ханьхуй нар гурван талын төлөөлөгчдийг тэргүүлсэн юм. Гадаад харилцааны дэд сайд нар гурван талын транзит тээвэр, гааль, аялал жуулчлал зэрэг салбарын хамтын ажиллагаанд тодорхой ахиц гарч буйг тэмдэглэхийн зэрэгцээ хамтын ажиллагааг цаашид худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлж, бодит агуулгаар баяжуулахын тулд салбарын яамд, байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллахаар болов. Мөн уулзалтаар 2019 оны 6 дугаар сард Киргизийн нийслэл Бишкек хотноо зохион байгуулахаар төлөвлөж буй Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтын бэлтгэл, тус уулзалтын үеэр гарын үсэг зурах боломжтой баримт бичгүүдийн талаар ярилцаж, тодорхой ойлголцолд хүрчээ.

¹¹⁷ “Си Цзиньпин призвал ускорить создание экономического коридора Китай - Монголия – Россия”-25 апрель 2019 <https://tass.ru/ekonomika/6376830>

2019 оны 6 дугаар сард Киргизийн нийслэл Бишкек хотноо ШХАБ-ын дээд түвшний уулзалтын хүрээнд ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын гурван талт дээд түвшний ээлжит уулзалт зохион байгуулагдав. Энэхүү уулзалтад Ерөнхийлөгч Х.Баттулга үг хэлэхдээ: “Талуудын хамтын хүчин чармайлтын дүнд сүүлийн жилүүдэд гурван талын хамтын ажиллагааны механизм бүрдэж, эрх зүйн үндэс бэхжиж, хамтын ажиллагааны салбар өргөжиж, зарим салбарт тодорхой ахиц гарч байна. Дамжин өнгөрөх тээврийн тухайд онцгой ахиц гарч, Хятадаас Орос болон Европын чиглэлд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрсөн чингэлгийн галт тэрэгний тоо 2016 оноос 2018 оны хооронд 500 хувиар нэмэгдсэн нь гурван талын зохицуулалтыг сайжруулснаас гарах хамтын ажиллагааны үр өгөөжийн тодорхой жишээ юм.

Гэхдээ гурван талын хамтын ажиллагааны ахиц, өрнөл бидний хүссэн хэмжээнд хүрэхгүй байна гэдэгтэй та бүхэн санал нийлэх болов уу. Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр байгуулснаас хойшхи 3 жилийн хугацаанд ард иргэдийн ахуй амьдрал, гурван улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц тодорхой төсөл хэрэгжиж эхлээгүй байгаа нь үнэхээр чамлалттай юм. Гурван талын аль аль нь хүлээн зөвшөөрөхүйц техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа нь бэлэн болсон төсөл ч байхгүй. Тиймээс энэ удаагийн уулзалтаас гурван талын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн тодорхой хариуцах эзэн, биелэлтийн хугацаатай чиглэлийг гурван улсын холбогдох байгууллагуудад өгөх шаардлагатай байна... Мөн гурван талын хооронд олон жил яригдаж ирсэн байгалийн хий дамжуулах хоолой барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг судлах Хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллан, тодорхой санал, дүгнэлт гаргуулах чиглэл өгөх саналтай байна. Зүүн хойд Азийн нэгдсэн эрчим хүчний сүлжээний олон талт байгууллага байгуулах саналыг манай тал дэвшүүлж байна”¹¹⁸ гэсэн юм.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар хэлсэн үгэндээ эрчим хүчний салбарт хамтран ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлсэн юм. Мөн Ерөнхийлөгч В.В.Путин Улаанбаатар төмөр замыг шинэчилж, дамжин өнгөрөх тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх сонирхолтой байгаа гэдгээ хэллээ. БНХАУ-ын хувьд ч гэсэн гурван улсын эдийн засгийн коридорыг хөгжүүлэх нь чухал гэдгийг БНХАУ-ын дарга Ши Жиньпин хэлж, төмөр замын шинэчлэл нь тэргүүлэх чиглэлийн төсөл хэмээв.

Ерөнхийлөгч В.В. Путин, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нарыг үг хэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол, Орос, Хятадын гурван талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал бодлоо хуваалцсанд талархал илэрхийлж, уулзалтыг ажил хэрэгч, бүтээлч болсон хэмээн дүгнэсэн юм.

Монгол Улсын санаачилгаар эхэлсэн ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын гурван хөршийн цуврал саммитын (2014 Душанбе, Тажикистан, 2015 Уфа, ОХУ, 2016 Ташкент, Узбекистан, 2018 Чиндао, БНХАУ, 2019 Бишкек, Киргизстан) агуулга нь цаашдаа зөвхөн хөрш хоёр гүрний худалдаа-эдийн засгийн бодлогод Монгол Улсыг хэрхэн яаж оролцуулах асуудлыг хэлэлцдэг механизм хоёр хөршийн худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зөвхөн коридор, суваг байж таарахгүй нь мэдээж төдийгүй, улам өргөн хүрээтэй асуудал хэлэлцдэг байх шаардлагатай нь харагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

¹¹⁸ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын тав дахь удаагийн дээд хэмжээний уулзалтыг даргалж, үг хэллээ 2019.06.14 <https://president.mn/9483/>

2019 оны 12 дугаар сард Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ОХУ-д хийсэн айлчлалын нэн чухал үр дүн нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтэй ОХУ-аас Монголын нутгаар дамжуулан Хятадад байгалийн хий нийлүүлэх хоолой тавих асуудлаар зарчмын хувьд тохиролцсон явдал байв.¹¹⁹

ОХУ-аас Монголын нутгаар дамжуулан БНХАУ-д жилд 50 тэрбум шоо метр байгалийн хий нийлүүлэх магистраль шугамын мега төсөл нь гурван улсын эдийн коридор хөтөлбөрийн нэн чухал хэсэг болох учиртай бөгөөд дурьдсан төсөл нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийг эдийн засгийн агуулгаар баяжуулах чухал хүчин зүйл болно.

Монгол Улсын хоёр хөрш, «гуравдагч хөрш»-үүдийн хооронд геополитикийн сөргөлдөөн гүнзгийрч, эдийн засгийн хориг арга хэмжээ өргөжиж, газар нутгийн маргаан, худалдаа, технологийн дайн үргэлжилсээр байна. Үүнийг Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогоо хэрэгжүүлж буй гадаад орчин 1990-ээд оноос мэдэгдэхүйц өөрчлөгдсөн гэдэгтэй уялдуулан онцлон тэмдэглэж байгаа юм. Энэхүү өөрчлөлтийн үйл явцад Монгол Улс хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах, гурван хөршийн хамтын ажиллагаа, «гуравдагч хөрш»-ийн бодлогын дунд ухаалаг тэнцвэрийн хүчинд суурилсан эрх ашгийн тэнцвэрийг зохист түвшинд зөв барих явдал чухал болсоор байгааг тэмдэглэх ёстой. Хувьсан өөрчлөгдсөөр буй сорилтод амжилттай, тогтвортой хариу барих арга барилаа олж чадах, өөрчлөлтөд бэлэн байх, дасан зохицох төдийгүй, өөрчлөлт хийх чадавхтай, цохилт даах, хүнд нөхцөл байдлаас нэр төртэй гарах явдал шийдвэрлэгч нөлөөтэй.

Зөөлөн тэнцвэржүүлэхүй

ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болж, шинээр стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон хэдий ч Монголын «буфер улс»-ын гүйцэтгэдэг геополитикийн “үүрэг хэвээр”, нөгөө талд ХХI зуунд Өмнөд хөршийн эдийн засаг эрчимтэй хөгжих болсон нь сайхь улс геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэх өргөн боломжтой болж байгааг Өрнөдийн судлаачид «хятадын аюул» хэмээн нэрлэдэг нь огт үндэслэлгүй зүйл биш юм. Бид Монгол Улсын гадаад бодлого, түүний шийдвэр гаргах ажиллагааны шинжлэх ухаан, онол арга зүйн үндсийг улам бүр боловсронгуй болгох шаардлагатай. Хөгжиж буй улсын үндэсний дэвшил, аюулгүй байдлын баталгаажилтын чухал эх сурвалж нь идэвхтэй бөгөөд оновчтой гадаад бодлого, дипломат ажиллагаа даруй мөн.

ХХ зууны сүүлчийн улирлаас улс гүрнүүдийн гадаад бодлогод “зөөлөн хүч” (Soft Power), “зөөлөн хүчний бодлого”-ын гүйцэтгэх үүрэг, түүний гадаад бодлогод эзлэх байр суурийн асуудал улам бүр анхаарал татах болов. Наполеон Бонапарт хэлэхдээ: “Дэлхий дахинд сэлэм илд, оюун ухаан хэмээх хоёр хүч оршсоор ирсэн. Цаг хугацаа өнгөрөхөд сэлэм илд оюун ухаанд ямагт дийлдсээр иржээ”¹²⁰ гэжээ.

Монголчууд гадаад бодлого, дипломат ажиллагаандаа зөөлөн хүчийг баримталж байсан түүхэн уламжлалтай бөлгөө.

¹¹⁹ Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн Хамтарсан Тунхаглал. Москва. ОХУ, 2021.12.16

¹²⁰ Napoleon Bonaparte: “There are but two powers in the world, the sword and the mind. In the long run the sword is always beaten by the mind” <https://www.forbes.com/quotes/author/napoleon-bonaparte/>

Чингис хаан бээр XIII зууны эхээр хаяа хаяагаа хатган оршсон Монгол угсааны олон ханлиг, аймгуудыг Мөнх тэнгэрийн хүчин дор, өөрийн авьяас билэг, их суу залиар нэгэн өрх гэрт нэгтгэж, эсгий туургатан улс энх шударга болсноор монголчууд дэлхийн түүхийн тавцанд бие даан гарч ирсэн нь Монгол ба хөрш орнуудын харилцааны шинж чанарыг хувиргасан төдийгүй Төв Ази, цаашлаад Дорно, Өрнийн олон улсын харилцаанд чанарын үндсэн өөрчлөлтийг оруулжээ. Чингис хааны их суу заль бол чухамдаа *зөөлөн хүч даруй мөн байв*. Чингис хаан бээр цэргийн гарамгай жанжин, стратегич байсан төдийгүй билгүүн дипломатч, хууль цаазаар төр улсыг засаглаж чадсан нэртэй улс төрийн зүтгэлтэн байжээ.

Монголын эзэнт гүрэн Дорно, Өрнийг холбож хангай, тал, элс манхан хосолсон Евразийн уудам нутагт оршин тогтнож байх цаг дор Чингис ба түүний дараах их хаад тэргүүлсэн Монголын тал нутгийн тэнгэрлэг заяат дээд язгууртнууд хол, ойрын хүчирхэг суурьшмал хөршүүдээр хүрээлэгдсэн өөрсдийн гал голомт, үндэсний аюулгүй байдлаа сахин хамгаалах, тэдгээрээр төр улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хүлээлгэн зөвшөөрүүлэхэд чиглэсэн *“хүчээр түрээ барих”, “тулган шаардах”*-аас эхлээд **зөөлөн хүчинд суурилсан** зохист *“дэлхийн шинэ дэг журам”*-ыг илбэн тохинуулах хүртэл гадаад бодлого, дипломат ажиллагааг тууштай баримтлан явуулж байжээ.

Евразийн өргөн уудам геополитикийн орон зайд тогтоосон Монголчуудын *“их амар амгалан”* буюу *La Paix Mongole*-д суурилсан дэлхийн шинэ дэг журмын чухамхүү уг сурвалж нь **зөөлөн хүчний бодлого байв**. Чингис хааны билиг сургаалд тэмдэглэхдээ:

*“Олон улсыг эзэлсү хэмээвээс биеийг нь хураахаас сэтгэлийг нь хураахтун Сэтгэлийг нь хурааваас бие нь хаа одох”*¹²¹ гэжээ.

Рашид-ад-Диний “Судрын чуулган”-д Чингис хааны Билиг сургаалаас гучаад зүйлийг перс хэлнээ хөрвүүлсэн байдаг. Чингис хаан өгүүлрүүн:

*“Омог хүчийг тарааж
Олныг аргаар барью
Олны эзэн болох буй
Арга билгийг сайтар мэдвэл
Аливаа хүчитнийг
Эрхээр болгох хялбар
Арга билэггүй бол
Алган дахийг ч
Тогтооход бэрх буюу
Биеийн бөхөөр ганцыг яльюу
Сэтгэлийн бөхөөр олныг яльюу”* гэжээ.

Их хаан Чингис бээр өөрийн үр хүүхэд, дүү нар хийгээд өрлөг сайд нартаа хандан сургаж хэлсэн үгийг Чингисийн билиг сургаал хэмээх бөгөөд “Монголын нууц товчоо”, “Эрдэнийн товч”, “Лу.Алтан товч”, “Судрын чуулган”, “Их засаг” хууль зэрэг шастир судраас эшилсэн 1000 гаруй билиг сургаалиас бүрдэг ажгуу.

¹²¹ Ц.Дамдинсүрэн. Чингис хааны билиг: Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. Дэвтэр 1, УБ., 2012; Лу. Алтан товч. “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан Товч хэмээх оршвой”. УБ., 1990

Их эрдэмтэн, доктор Л.Н.Гумилёв олон арван жилийн түүхийн судалгааныхаа үр дүнд Чингис хаан, түүний залгамжлагчдын Евразийн уудам орон зайд явуулсан илбэн тохинуулах ажиллагааны түүхэн учир нээн харуулсан билээ.¹²² “Монгол-татаарууд догшин ширүүн дайсантайгаа ердөө л илүү гарамгай байлдсан хэрэг байжээ. Чингэлээ гэж тэднийг ХХ зууны өндөрлөгөөс буруушаан зэмлэх нь шинжлэх ухаанд харш гэдэг нь өнөөдөр ойлгомжтой...Хүчгүй нь хүчтэйгээ ялж байсны шалтгааныг тодруулах нь хавьгүй чухал. Угсаатны ямар ч системийг хөдөлж байгаа биетэй адилтгаж болох бөгөөд түүний хөдөлгөөний шинжийг цул (хүний тоо), хүч (эрчим хүчний хуримтлал), бүрэлдэхүүн (системийн доторх элементүүдийн зохицол) гэсэн гурван хэмжигдэхүүнээр тодорхойлдог. Энэ утгаар нь авч үзвэл XIII зууны монголчууд ид өрнөлтийнхээ үед байсан залуу угсаатан байсанд тэдний амжилтын нууц оршино. Энэ нь мэдэгдэж байгаа бүх баримтад харшлахгүй...” гэж тэрбээр тайлбарласан юм.

Олон ханлиг аймгууд өөр хоорондоо уулгилан довтлох, бусад улс гүрэн лугаа дайтах зэрэг нь залуу угсаатнуудын өөрсдийн амьдрах орчин, аюулгүй байдлаа хамгаалах байгалиас заяасан зөн совин байсан байх бөгөөд үүнийг химийн урвалтай харьцуулж болох бөгөөд жишээ нь хөх өнгийн бодис дээр шар өнгийн бодис холиход ногоон болохтой адил тэдгээр нь аяндаа явагдаж буй байгалийн үйл явц, үүний буруутанг олох боломжгүй хэмээжээ. Доктор Л.Н.Гумилёв түүхийг үзэх үзэл, судалгааны аргазүйд шинэчлэл хийж, үндэстэн үүсч бүрэлдэн хүчирхэгжихэд угсаатны үйл явц буюу популяци, угсаа гарвал буюу этногенез, эрчим хүч, хэмнэл буюу биоритм, амь мандал буюу биосфери, түүхэн газарзүй буюу историческая география чухал болохыг онцлон тэмдэглээд түүхийг нийгмийн болон байгалийн шинжлэлийн талаас нь хамтад нь цогц авч судлахын чухлыг тэмдэглэжээ. Л.Н.Гумилёв бээр бичихдээ: Монголчууд эв найртай байхыг хүсэмжлэн *элчийг* довтолгож байсан гэж бичсэн нь *зөөлөн хүчний бодлого* барьж байсны тод илрэл юм.

Монголын Илхаадаас Өрнө дахины хаадад илгээж байсан бичгүүд дотроос Өлзийт султаны захидал¹²³ агуулгаараа онц сонирхолтой юм. Эл захидлыг Өлзийт хан 1304 оны 5 дугаар сард Илхан ах Газаныг таалал төгссөний дараа буюу 1304 оны 7 дугаар сарын 21-нд хаан ширээ залгамжлаад, хэдэн сарын дараа буюу 1305 онд Франкийн хаан үзэсгэлэнт гоо Филиппт (Philippe le Bel) илгээсэн ажээ. Захидалд өгүүлэхдээ: *«Эдүгээ, бидэнтэй ч та бүхэнтэй ч үл найрамдах этгээдтэй бид тэнгэрийн хүчин дор бүгдээрээ хамсран тэмцэхийг тэнгэр мэдтүгэй»* гэжээ.

¹²² Гумилёв Л.Н. *Апогрифический диалог*. Жур: “Нева”, 1988, №3-4, Этногенез и Биосфера земли.

Л.: 1989; География этноса в исторический период. М.: 1990; Ритмы Евразии. М.: 1993; Древняя Русь и Великая Степь. 2 томах. М.: 1997

¹²³ Эл дипломат захидлыг нэрт дорно дахинч эрдэмтэн Абел-Ремюза Францын үндэсний архиваас анх олж, 1824 онд өөрийн бүтээлдээ худам монгол бичигт буулгаж тайлбарлахын хамт, чулуун бараар хэвлүүлжээ. Сайхь захидал зөвхөн түүхийн хувьд бус, мөн хэл шинжлэлийн үүднээс ч чухал тул эрдмийн ертөнцөд ихэд шуугиан дэгдээжээ. Үүнээс үүдэн мөн онд Голландын эрдэмтэн И. Шмидт Санкт-Петербургт дурьдсан баримтын галиг, орчуулгыг хийж хэвлүүлсэн байна. Энэ судалгаа нь Абел-Ремюзаг бодвол илүү ахисан бөгөөд дараагийн зуун жилд олон монголч эрдэмтэд түүнд тулгуурлаж иржээ. Чингээд зөвхөн 1895 онд гүн Ролан Бонапартын бүтээл хэвлэгдсэнээр тод гэрэл зургийн хуулбартай болжээ. Нэрт дорно дахинч В.Котвич түүний бүтээл дэх хуулбаруудад тулгуурлан судалгаагаа гүнзгийрүүлэн хийсэн анхны эрдэмтэн бөгөөд энэ талаар 1925, 1933 онд дорвилог өгүүлэл нийтлүүлжээ. 1935 онд оросын эрдэмтэн С.А.Козин, 1949 онд германы эрдэмтэн Э.Хениш, 1950 онд М.Н.Поппе, улмаар 1962 онд Бельгийн эрдэмтэн А.Мостэрт, Ф.В.Кливи хоёр эцсийн бүрэн судалгааг хийсэн бүтээлээ хэвлүүлсэн байна.

«Харин эдүгээ Тэнгэрийн ивээлээр ах дүү бид бүгд зохилдож наран ургах Нанхиадуудын газраас Тагу тэнгис хүртэл (манай) улс гүрнүүд барилдаж харилцаагаа сэргээж (өртөө) замуудаа байгуулав. Бидний завсар хэн бус сэтгэвээс бүгдээрээ хамсарч тэдний дээр байя хэмээн үг барилдав. Эдүгээ манай сайн элэни, сайн өвөг, сайн эцэг, сайн ахтай найрамдаж харилцсаныг яахин бид огоорох билээ... Олон франкуудын вангууд хамт (хоорондоо) зохилдож амуй хэмээн (бидэнд) айлтгасан билээ. **Үнэнхүү зохилдохоос сайн юу байх билээ**»¹²⁴ хэмээсэн байх бөгөөд үүнийг «**хуучин ертөнцийн үлэмж их орон зайд энх амгалан тогтоох**» санаа сэтгэлийг монголчууд анх удаа үүсгэсэн болохыг нэрч монголч эрдэмтэн, судлаач В.Л.Котвич (1872-1944) олж ажиглаад «**XIII зууны эхэн үед Монголчууд дэлхий нийтийн энхтайвны санааг сэдэж үүсгэсэн болох нь**»¹²⁵ хэмээх өгүүлэл бичиж энэ нь түүний мэндэлсний 100 жилийн ойд зориулан 1970 онд “Түүхийн асуудлууд” хэмээх франц хэл дээр гардаг сэтгүүлийн дугаарт хэвлэгджээ. Өрнөд Европт тогтсон энх амгалан байдлыг монголчууд өөрсдөө зарлан мэдээлсээр байсан байх бөгөөд найртай сайхан байхыг ихэд эрхэмлэсэн «**үнэнхүү зохилдохоос сайхан юу байх билээ**» хэмээсэн монгол хүний санааг илэрхийлсэн зөөлөн хүчний гайхамшигтай үзэл санаа бүхий өгүүлбэрийг жуух захидалдаа шигтгэж өгчээ. Мөнх хааны хэлсэн **бүх ертөнц эв баясалд нэгдэхийн цагт бидний зорилго илт болно** гэсэн санаа ч үлэмжийн утга учиртай байжээ. Энэ бол дипломат арга ажиллагаан дахь зөөлөн хүчний бодлогын тод илрэл болсон юм.

Төр, шашныг хослон баригч хийгээд хоёр ёсны онолыг үндэслэгч Хубилай Их Хаанаас Японы ванд илгээсэн Жуух бичиг зөөлөн хүчний үзэл санаагаар нэвтэрхий байсан юм.¹²⁶

Тухайн үеийн дэлхий дахины нөлөө бүхий улс орнууд Монголын хаадтай харилцах болсон нь үнэн хэрэгтээ Монголын төрийг хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Нөгөө талаар Евразийн өргөн уудам нутгийн олон улс орныг эрхшээл, нөлөөндөө оруулж Дорно, Өрнийн хэрэгт үлэмж эрх мэдэл бүхий болсон Монгол гүрний оролцоогүйгээр олон улсын харилцааны аливаа нэгэн асуудлыг шийдвэрлэх, тэр зүгээс ямар хандлага байгааг харгалзан үзэхгүйгээр улс хоорондын яриа хэлэлцээр байгуулах нь бэрхтэй болсон явдал энэ үеийн олон улсын харилцааны үндсэн онцлог байсан нь тодорхой юм.

Их Монгол Улсын гадаад бодлогын номлол, дипломат ажиллагааны зорилго, чиглэл цаашид боловсрон хөгжихөд тухайн цаг үеийн олон улсын байдал, суурьшмал хөрш орнуудын зүгээс Монголын төр улсын талаар баримталж байсан ёсгүй авирласан бодлого, хандлага хүчтэй нөлөөлж байв. Тиймээс ч Монгол Улс хүчирхэгжин мандах цаг дор дэлхийг нийтээр нь нэг засаг, төрийн мэдэл дор илбэн тохинуулах бодлого явуулжээ. Япон тэнгис, Солонгосын хойгоос Ариун Ромын эзэнт улсын хил, Адриатик тэнгис хийгээд Ойрхи Дорнод, Египет хүртэл, Ява, Суматари арлаас Байгаль далай ба Саяны уулсыг өнгөртөл өргөн уудам газар орныг эрхэндээ оруулж, цаана нь үлдсэн хэсэгт үлэмж нөлөөтэй

¹²⁴ Уламбаяр Д. Монгол, Өрнөдийн орнуудын харилцаа: Эрт, эдүгээ. УБ., 2004, 53 дахь тал

¹²⁵ Котвич В.Л. “XIII зууны эхэн үед Монголчууд дэлхий нийтийн энхтайвны санааг сэдэж үүсгэсэн болох нь” (франц хэлнээс орч. Ц. Шагдарсүрэн). Хэл судлал. IX боть, 20 дугаар дэвтэр. УБ., 1972, 307 дахь тал, Kotwicz W. *Les Mongols promoteurs de l'id'ee de paix universelle au debut du XIII-e siecle*. Rocznik Orient.: XVI, 1953, pp. 428-434

¹²⁶ Сумьяабаатар Б. «Хубилай хаанаас Японы ванд илгээсэн Жуух бичиг»-“Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиумын эмхтгэл. УБ., 2003, 23-32 дахь тал

болсон тул эзэнт гүрний гадаад бодлого, дипломат ажиллагаа нийт Евразийн олон улсын харилцааны чиг хандлагыг тодорхойлох болж иржээ.

Монголчууд өөрсдөө хүн ам цөөн, Өрнө, Дорно этгээдэд эзэлсэн нь үлэмж өргөн уудам, хойч үедээ их амар амгаланг баримталж, Монгол үндэсний төр улсын алс хил хязгаарын аюулгүй байдлыг сэргийлэн засахад үнэхээр хялбаргүй байсан тул Өрнө зүгийн улс орныг Өрнө зүгт нь алс хол захируулан суулгасан нь чухамдаа Өрнө зүгийн аюулыг Өрнө зүгт нь сэргийлсэн хэрэг ба Нанхиадын аюулыг Нанхиад дотор сэргийлсэн хэрэг байсан бөгөөд, чухамдаа өөрийн язгуурын жинхэнэ гал голомт гурван голын монголчуудыг гадны ямарч аюул, занал учруулахгүйгээр сахин хамгаалах үндэсний аюулгүй байдлын цогц тогтолцоог буй болгосон ажгуу.

Чингисийн угсааныхан дотоодын зөрчил тэмцлээ эцэс болгож, эвлэлдэн XIV зууны эхээр санасандаа хүрчээ. Алтан ургийнхны тусгаар улсуудын дотоодод нэгдмэл байдал дахин тогтсон хэдий ч өмнөх үе шигээ Голын улсын захиргаанд бус, харин *Тусгаар улсуудын Федераци* (мөн *Commonwealth* гэж нэрлэж болмоор Д.У) буюу Хамтын Нөхөрлөл лугаа хэв шинж бүхий шинэ зарчимд тулгуурлах болсон байна. Монголын эзэнт гүрний Тусгаар улсуудын Холбоо нь Бат ханы Алтан Орд улс (1240-1502), Хубилайн Юань улс (1271-1368), Хүлэгүгийн Ил хант улс (1256-1353), Цагаадайн улс (1225-1358)-аас бүрдэж байсан бөгөөд тэднээс хамгийн өнө удаан оршин тогтносон нь Алтан Орд улс ажээ.

Холбооны улсууд дотооддоо их амар амгаланг цогцлоож, өвөр дотроо найртай харилцааг дахин тогтоох нь хамгаас чухал зүйл болоод байна гэж зөвшилцөн тогтжээ. Бас Монгол гүрний ивээлд ороогүй хаяа хатган хил нийлж, нутаг дэрлэсэн Өрнөдтэй хэлэлцэж хүчин түрэмгийлэхгүй, харин эе найртай байхуй дор гэрээ хэлэлцээ байгуулахыг хүсч байсан ажээ.

Харин 1990-ээд оны эхээр АНУ-ын Харвардын их сургуулийн профессор Жозеф С.Най (Joseph S.Nye) “Цаг хугацааны хувьслын явцад хүчний шинж чанарт өөрчлөлт орно” гэсэн утгаар анх “зөөлөн хүч”-ийг үзэл баримтлалын түвшинд хөндөж тавьсан байдаг. Өдгөө олон улсын улс төр, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн олон улсын харилцаанд цэрэг зэвсэг, эдийн засгийн хүчин чадалд суурилсан “хатуу хүч”-ний гүйцэтгэх үүрэг хэвээр байгаа боловч түүнийг өөрийн зорилгодоо ашиглах тухайд тийм ч амар асуудал биш болсон гэдэг нь нэн тодорхой байгаа билээ.

Зөөлөн хүч гэдэг нь хүсэж байгаа зүйлээ хүч, албадлагын аргаар бус, харин зөвшилцөл, итгэн үнэмшүүлэх, бишрүүлэн татах замаар олж авахыг хэлэх ажгуу. Энэхүү үзэл баримтлал Жозеф С. Най-ийн 1990 онд хэвлэгдсэн *“Bound to lead: The Changing Nature of American Power”* хэмээх бүтээлд анх дурдагдсан байдаг. Тэрбээр сайхь ухагдахууныг 2004 онд гаргасан *“Soft Power: The Means to Success in World Politics”*¹²⁷ хэмээх бүтээлдээ илүү тодорхой авч үзжээ.

Жозеф С.Най “зөөлөн хүчний бодлого гэдэг нь аливаа улс гүрний оюун санаа болон хэл соёлын үнэт зүйлсийн тусламжтайгаар бусад орны ашиг сонирхол, төлөв байдалд шууд бус замаар нөлөөлөх чадвар” гэж тодорхойлжээ. Соёлын татах хүч, үнэт зүйл, гадаад бодлого гэсэн гурван чиглэлээр зөөлөн хүчний бодлого хэрэгждэг гэж тэрбээр үзсэн юм.

¹²⁷ Joseph S.Nye. *Soft Power: The Means to Success in World Politics*. PublicAffairs.: 2004

Дэлхийн улс төрд улс гүрний зөөлөн хүч нь ерөнхийдөө дараах гурван тулгууртай байна: соёл иргэншил (бусдыг бишрүүлэн татах), улс төрийн нэр хүнд (дотооддоо болон хилийн чанадад санасандаа хүрэх), гадаад бодлого (хууль ёсонд нийцсэн хийгээд ёс суртахуунтай харагдахуйц) эдгээр болно.

Хүч чадал гэдгийн үндсэн ойлголт нь хүсэж буй зүйлдээ хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар гэдгийг тэмдэглэсэн. Үүнд гурван арга замаар буюу *нэгд*, албадлага, хүч түрэх (ташуур), *хоёрт*, мөнгө (авлига, шан харамж), *гуравт*, бусдыг бишрүүлэн дагуулах (элсүүлэх урвуулах) эдгээр ажээ.

Зөөлөн хүч нь дээрхийн гуравдахь арга бөгөөд хэрэв таны хүсэж буй зүйлийг бусад нь хүсэж, та бусдыг хүсүүлж чадахуйц нөлөөлж чадвал энэ нь албадлага заналхийлэл болон эдийн засгийн арга хэрэглэхээс илүү хямд бөгөөд эрсдэлгүй байх ажгуу.

Жозеф С.Най материаллаг бус нүдэнд үл харагдах эх үүсвэрээс бий болж буй хүч нөлөөнд илүү ач холбогдол өгсөн байдаг. Эерэг имиж нь тухайн улсын явуулж буй гадаад болон дотоод бодлого, үйл ажиллагаа болон тухайлсан бие даасан бодлого, жишээ нь соёлын бодлогоос бий болох бөгөөд энэхүү эерэг имиж нь хүндлэл бишрэлийг бий болгож байдаг. Энэхүү хүндлэл бишрэл нь маш хүчтэй байх тохиолдол байдаг бөгөөд энэ нь бусад улсууд тус улсын бодлого, үйл ажиллагааг даган дуурайх, үлгэр жишээ авах зэргээр илэрч байдаг байна.

Зөөлөн хүч нь хамтын ажиллагаа, эдийн засгийн тусламж дэмжлэг, соёлын солилцоо зэрэг олон нийтэд эерэг хандлагыг буй болгох үйл ажиллагаагаар дамжин улам бүр сайжралыг олсоор байна.

Олон улсын харилцааны онолын үүднээс авч үзвэл гадаад бодлогын хатуу хүчний чиг шугам нь *realism-д* тулгуурладаг бол гадаад бодлогын зөөлөн хүчний чиг шугам нь *idealism-д* тулгуурлана гэж үзэж болох юм.

Зөөлөн хүчний нэг онцлог нь үнэт зүйлсээрээ илүү өндөр байр суурьтай улс л түүнийг ашиглаж чаддаг ажгуу. Тухайлбал, Боливарын Бүгд Найрамдах Венесуэл улс зөөлөн хүчийг ашиглан АНУ-д нөлөөлнө гэж байхгүй, харин АНУ энэ хүчээ ашиглан Венесуэлийн олон нийтэд нөлөөлж, өөрт ашигтай шийдвэр гаргуулах боломжтой юм.

Жозеф С.Най энэ талаар бичихдээ “Бусад хүн таны биширдэг, шүтдэг зүйлсийг бахдан дээдэлж дагадаг, хүсч буй зүйлийг чинь адилхан хүсдэг болгож чадвал өөрийн хүссэн зүгт тэднийг чиглүүлэхийн тулд сүрдүүлж эсвэл аргадах шаардлагагүй болно” гэжээ. Улс үндэстний үнэт зүйлс харилцан адилгүй, ялгаатай болохоор зөөлөн хүчийг тухайн үнэт зүйлс бүхий хүнд ойлгомжтой байдлаар боловсруулж хүргэнэ гэсэн үг ажээ.

Зөөлөн хүчний үр дүн тухайн улсын мэдээллийн орон зайн нээлттэй байдлаас хамаардаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, даяаршлагдсан, ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн байх тусам зөөлөн хүч үр нөлөөтэй ажгуу. Тухайлбал, гучин жилийн өмнө монгол ба америк хүний хооронд соёлын асар их ялгаа байсан бол өнөөдөр энэ хоёр Hollywood-ийн кино адилхан үзэж, internet, youtube, facebook, iPhone, Galaxy ижил түвшинд хэрэглэж, CNN эсвэл BBC-гийн мэдээ үзэж, оддын дууг сонсох болжээ. Тэгэхээр зөөлөн хүчний нөлөөлөх боломж, хүч нэмэгдэнэ гэсэн үг ажгуу.

Харин Хойд Солонгос гадны мэдээ мэдээлэл нэвтрэх боломж багатай, хаалттай нийгэмд зөөлөн хүчний үзүүлэх нөлөө сул боловч энэ нь тэр зүгт зөөлөн хүчний бодлого явуулах шаардлагагүй гэсэн үг биш юм.

Гэхдээ “зөөлөн” гэхээр “хатуу”-гийн эсрэг зүйл гэж туйлын утгаар нь ойлгож болохгүй нь мэдээж билээ. Зөөлөн хүч хатуугийн эсрэг бус харин олон улсын тавцанд хатуу хүчний үйлчлэлийг илүү үр дүнтэй болгодог, ингэхлээрээ хатуу хүч нь зөөлөн хүчнийхээ хөрс нь болдог ажээ. Зөөлөн хүчийг хэрэгжүүлэхэд зарцуулсан нэг доллар болгон зэвсэглэлд зарцуулсан 10 доллароос илүү ашиг өгдөг гэсэн нэгэн зүйрлэл ч буй.

Өнөөгийн олон улсын харилцааны онцлогуудын нэг нь нийгэм-улс төр, эдийн засаг болон бусад олон шалтгаанаас үүдэн үндэсний төр улсад итгэх итгэл зарим талаар буурах хандлага ажиглагдаж байгаа боловч олон улсын харилцаан дахь улс гүрнүүдийн хүчээр түрээ барих хатуу бодлого суларч, соёл, үнэлэмжийн шинжтэй зөөлөн хүчний бодлого улс хоорондын харилцаанд хөгжих мэдэгдэхүйц таатай орчин бүрдсээр байна.

Өнөөгийн дэлхий дахинд мэдээ, мэдээлэл бол цэвэр хүч юм. Дижиталчлалын эрин үе дэлхийн хүн амын дийлэнхид энэ хүчийг эзэмших боломжийг олгож, чингэхлээрээ хүч чадлын тухай ойлголтод шинэ учирзүйг нээж байна.

Улс гүрнүүдийн гадаад бодлогын парадигм буюу хэв шинж чухал ач холбогдолтой. Идэвхтэй гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах хүч юм. Эрч хүчтэй, идэвхтэй, олон хэмжээст гадаад бодлого дэлхий нийтийг хамарч, холбоотнуудын дэмжлэгийг авч, бусдыг өөртөө татаж чаддаг. Хүйтэн дайны үед АНУ холбоотон улсуудаа талдаа татахдаа “ардчилал, хүний эрх, эрх чөлөө, эдийн засгийн либеральчилал” зэрэг нийтлэг үнэт зүйлсийг иш үндэс болгож байсан юм. 1988 оны Сөүлийн олимпын дараа тунхагласан БНСУ-ын «Умардын бодлого» холбоотнуудынхаа төдийгүй тухайн үеийн социалист орнуудын дэмжлэгийг хүлээж амжилттай хэрэгжсэн билээ.

XXI зууны эхний хоёр арван жилд их гүрнүүдийн гадаад бодлогод Мянганы зорилтуудыг хэрэгжүүлэх, олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг журмыг төлөвшүүлэх, цөмийн болон үй олноор хөнөөх зэвсгийг хориглох, баллистик пуужингийн туршилтыг хязгаарлах, олон улсын терроризм, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, худалдаа-эдийн засгийг либералчлах, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, ядууралтай тэмцэх, хүмүүнлэгийн тусламж, зээл тусламжийн бодлогыг хэрэгжүүлэх, глобалчлал, дижиталчлалын нөлөө, эцэст нь COVID-19 цар тахалтай тэмцэх гээд амин чухал асуудлууд тэргүүн зэрэгт тавигдсаар байна.

Дээрх зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд зөөлөн хүчний бодлого чухал ач холбогдолтой. Зөөлөн хүчийг *smart* бодлогоор хөхиүлэн дэмжсэнээр зорилгоо гүйцэлдүүлэх боломжтой ажгуу. Сэтгэл татам байдал гэдэг нь аяндаа зөөлөн хүчийг буй болгож үл чадна. Харин тэдгээрийг ашиглан бусдыг тодорхой чиглэлд хөдөлгөж чадаж байвал тэр нь зөөлөн хүч болж чадаж буй хэрэг бөлгөө. Зөөлөн хүч нь “нөлөөлж” чадах хүртлээ зөөлөн хүч биш ажгуу.

Аядуу буюу “өнгөт хувьсгал”-ыг заримдаа “зөөлөн хүчний хувьсгал” хэмээн тэмдэглэх нь буй. Энд Гүржийн 2003 оны 11 дүгээр сарын “сарнайн хувьсгал”, Киргизийн 2005 оны “Алтан зул” хувьсгал, 2004-2005 оны Украинд өрнөсөн “Жүржийн хувьсгал” зэргийг дурдаж болно. XX зууны сүүлийн хагаст өрнөсөн эсэргүүцлийн жагсаал,

хувьсгалыг судалж үзээд хүч хэрэглэсэн, үймээн дэгдээсэн жагсаал цуглаанаас илүүтэй тайван замаар тэмцэх нь зорилгодоо хүрэх магадлалыг хоёр дахин нэмдэг гэсэн судалгаа дүгнэлт гаргасан нь буй. Африк, америкчуудыг эвлэрүүлэгч Сожоурнер Трут, Энэтхэгийн тусгаар тогтнолын хөдөлгөөний нэр зүтгэлтэн хүч үл хэрэглэх үзлийн номлогч Махатма Ганди, АНУ-ын арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг тэмцэгч Мартин Лютер Кинг нар тайван замаар тэмцэх талыг тууштай баримталж байсан юм.

Ерөнхийдөө гаднын цэргийн хүч оруулж ирж, хувьсгал хийсэн тохиолдолд эцэстээ тухайн орон иргэний дайны хөлд нэрвэгдэж, дэд бүтэц нь устаж, дэлхийн хамгийн халуун цэгүүдийн нэг болж байгаа нь олон орны жишээн дээрээс харагддаг. Хүчирхийлэл, үймээн самуун дэгдээлгүй тайван замаар тэмцэхэд хүссэн үр дүндээ хүрэх магадлал 53 хувь байдаг бол хүч хэрэглэсэн буюу цэргийн хүчээр төрийн эрхэнд гарах гэж оролдох үед зорьсондоо хүрэх магадлал ердөө 26 хувь байдаг судалгаа гарчээ.

Бүр ХХ зууны эхээр Бүх холбоотын Коммунист (большевик) намын (БХК(б)Н) эх үндэс болж байгуулагдсан Оросын ажилчны социал-демократ нам (ОАСДН) большевик, меньшевик хэмээх хоёр урсгалд хуваагдсаны үндсэн шалтгаан нь хувьсгалын стратеги, тактик тухайлбал, хувьсгалын хөдөлгөгч хүч хэн байх, засгийн эрхийг хэн авах, ямар нийгмийн анги бүлэг эрх барих зэрэг асуудлуудад төвлөрч байсан юм. Большевикууд хувьсгалын гол хөдөлгөгч хүч нь тариачид, үгээгүй ядуу хоосон пролетари анги байж, хувьсгалын ялалтын үр дүнд тэд засгийн эрхийг гартаа авч пролетарийн диктатурыг хэрэгжүүлнэ гэж үзэж байв. Гэтэл меньшевикүүд хувьсгалын гол хөдөлгөгч хүч нь ажилчин-тариачин анги байж болох боловч засгийн эрхийг хотын жижиг хөрөнгөтнүүд, түшмэлүүд гартаа авч улс орныг удирдах ёстой, ажилчин-тариачид улс орныг удирдаж чадахгүй гэж учирлаж байв. Харин баруун, зүүн эсерүүд эзэн хаан, засгийн газрын тэргүүн нарыг устгаж, улс төрийн террор хийх замаар нийгмийг өөрчлөхийг оролдож байсан юм.

Дипломат ажиллагаа бол гадаад бодлогын зорилтыг хүч хэрэглэх замаар бус, харин олон улсын эрхзүйн зарчимд тулгуурлан яриа хэлэлцээ, энхийн арга замаар шийдвэрлэх урлаг, шинжлэх ухаан гэж мэргэд сургасан байдаг.

Большевикууд «хувьсгалт дипломат ажиллагаа»-гаар социалист хувьсгалыг дэлхий дахинд экспортлох тухай номлож байв. «Хувьсгалт дипломат ажиллагаа» гэдэг нь 1917 оны 11 дүгээр сард Орос оронд гарсан Октябрийн хувьсгалын дараа В.И.Лениний үндэслэн боловсруулсан социалист гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа байв. Үгээгүй ядуу ажилчин-тариачин ангийн эрх ашиг, пролетарийн диктатурыг туйлаас хамгаалах халхавч нэрийн дор дэлхий дахинд большевик үзэл санааг түгээн дэлгэрүүлж, Өрнөдийн орнуудад социалист хувьсгалын тохироо бүрдүүлэх, ажилчин ангийг хувьсгалын замаар засгийн эрхэнд гаргах, Дорно дахины ядуу буурай орнуудад үндэсний өөртөө засан тогтнох эрх олгох уриан дор *Коминтерн* (III Коммунист Интернационалийн товчилсон нэр Д.У) хэмээх хувьсгалт байгууллагын халхавчаар дамжуулан улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс шууд оролцох, тэдгээр орнуудыг өөрийн эрх ашгийн тусын тулд олон улсын харилцааны үйл хэрэгт татан оролцуулах, олон улсын хэмжээнд улс төрийн террорист халдлагыг дээрээс бодлогоор зохион байгуулах, Коммунист болон хувьсгалт намаар удирдуулсан холбоотон орнуудын геополитикийн нөлөөллийн хүрээллийг буй болгож, социалист хувьсгалын ололтыг тууштай хамгаалан бататгах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дипломатын ил, далд, хүчирхийлэл, аядуу бүх арга хэрэгслийг ажиглахад оршиж байв. Олон улсын эрхзүйн үндсэн зарчмаас ангид хүчирхийллийн арга хэрэгсэл, нууц яриа

хэлэлцээ, хуйвалдаан, нөлөөний хүрээ, хувьсгалт ашиг сонирхол, улс төрийн террортулгуурлаж байв. «Мэргэшсэн хувьсгалч» гэдэг нь мэргэжил байсан бөлгөө.

Шийдвэр гаргах үйл явц нь тагнуулын бүх арга хэрэгсэл, бусад сувгаар олж авсан мэдээ, мэдээлэлд үндэслэн Ленин, Сталин, тэднийг хамгийн ойр хүрээлэгсэд болох Гадаад хэргийн ардын комиссариат, Бүх Оросын онцгой комисс (ВЧК), Улс төрийг удирдах Ерөнхий газар (ОГПУ), Дотоод хэргийн ардын комиссариат, УАХБ, Коминтерний Төвийн Гүйцэтгэх хороо зэрэг цөөн байгууллагын удирдлагын явцуу хүрээлэлд тулгуурлаж байв. Декретъ о мир, Брестийн найрамдлын гэрээ, 1924 оны 5 дугаар сарын 31-нд Бээжинд гарын үсэг зурсан “Зөвлөлт-Хятадын хооронд асуудлыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай хэлэлцээр”, 1929 оны 6 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотод гарын үсэг зурсан “БНМАУ, ЗСБНХУ-ын харилцааны үндсэн зарчмуудыг тогтоосон Гэрээ бичиг”, 1939 оны “Зөвлөлт-Германы хооронд харилцан үл довтлох тухай пакт”, түүний нууц протокол зэрэг нь хувьсгалт дипломат ажиллагааны тодорхой жишээ байсан юм.

Хүйтэн дайны үед Зөвлөлтийн удирдагч Л.И.Брежнев ЗХУ бол цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүй гэж мэдэгдэж байсан. Харин ОХУ-ын 2016 оны стратегийн баримт бичгээр бол тус улс үндэсний аюулгүй байдлаа цөмийн зэвсэг ашиглан хамгаалах болно гэжээ. Гэхдээ цөмийн зэвсгийг цөмийн зэвсэггүй улсын эсрэг ашиглахгүй гэсэн байна.

2014 оны 3 дугаар сард ОХУ Украины нутаг дэвсгэр Крымын хойгийг өөртөө хүч түрэн нэгтгэж, үүнээс шалтгаалан Өрнөдийн эдийн засгийн хоригт орсоны дараа тус улсын гадаад бодлого *de facto* илүү их хатуу хүчинд тулгуурласан бодлого явуулах болсон гэж шинжээчид үзэх болсон юм. Харин 2022 оны 2 дугаар сарын сүүлчийн улиралд ОХУ-ын Украины тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдалд халдсан үйлдэл нь тус улсын хатуу хүчний бодлогыг *de jure* батлан харуулав.

Эцэст нь, Хатуу хүчинд суурилсан бодлого эрчимжиж байгаа хэдий ч бага жижиг улс зөөлөн хүч, зөөлөн хүчний нөөц чадавхдаа тулгуурласан стратегиа боловсруулж хэрэгжүүлэх нь нэн чухал болжээ. Тиймээс зөөлөн хүчинд суралцахуй чухал болой.

Монгол Улсын хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах бодлого, «гуравдагч хөрш»-ийн бодлого, гурвалсан хөршийн хамтын ажиллагаа, олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус нь тус тусдаа бие даасан бодлого биш, харин харилцан бие биеэсээ хамааралтай, шүтэн барилдлагатай байх ёстой гэдгийг онцлон тэмдэглэх ёстой. *Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн геополитик, геоэдийн засаг, стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, худалдаа-эдийн засаг, эрхзүйн орчинг бүрдүүлэхэд дээрхийн шүтэн барилдлага оршино. Монгол Улсын дээрх цогц бодлого бол газарзүйн онцлог байршилтай уялдан, их гүрнүүдийн дунд хүчний зохистой зөөлөн тэнцвэрийг барьж, үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломат болон эдийн засгийн аргаар цогц хангах Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгаас шууд урган гарсан геополитик, гео-эдийн засгийн бодлого мөн. Нөгөө талд хоёр хөршөөс Монголын тухайд явуулж буй геоэдийн засгийн бодлого нь «гуравдагч хөрш»-ийн эрх ашгийг ямар нэг хэмжээгээр давхар хөндөж байх явдал болно.*

Монгол Улсын «гуравдагч хөрш»-үүдийг бүсчлэн үзвэл Хойд Америкт: АНУ, Канад, Зүүн хойд Азид: Япон, БНСУ, Европ тивд ЕХ, түүний нөлөө бүхий гишүүн орнууд, лалын ертөнцөөс: түүх, хэл, соёлын эртний гүн хэлхээ холбоотой, олон намын тогтолцоотой ардчилсан, их 20 бүлгийн гишүүн, ЕХ-ны гишүүнчлэлд нэр дэвшээд удаж буй Түрк, «оюун санааны хөрш» хэмээн нэрлэдэг, түүх, соёл, шашин шүтлэгийн эртний уламжлалт гүн харилцаатай Энэтхэг улсыг хамруулж байна. Дэлхийн 6 дахь тив Австрали улсыг оруулж болох юм. Физик-газарзүйн талаасаа хамгийн ойр [жар орчим км-ын цаана] орших байгалийн «гуравдагч хөрш» бол 2007 онд “Өргөн хүрээтэй түншлэл”-ийн харилцаа тогтоосон Казахстан улс юм.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого бол зөөлөн тэнцвэржүүлэх (soft balancing) хийгээд зөөлөн хүчний бодлого бөгөөд онолын үндэс нь ухаалаг **тэнцвэрын хүчин** (power of smart balance)-д суурилсан **ашиг сонирхлын тэнцвэр** (balance of interests) болно. «Гуравдагч хөрш»-ийн бодлого нь ашиг сонирхолын тэнцвэрт суурилсан ухаалаг тэнцвэрийн хүч мөний буй учир олон улсын харилцааны идеалист онолд хамаарагдаж болохоор байгаа юм. Идэвхтэй гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл юм.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого бол хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого биш, харин хоёр хөрштэй тэнцвэртэй харилцах бодлогын логик үргэлжлэл юм. Монгол Улс хоёр хөрштэйгөө иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон бөгөөд урт хугацаанд найрсаг харилцаатай байх агуулгатай. Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангахаас гадна эдийн засгийн аргаар хангах чиглэлд хөгжингүй орнуудын *нэгд*, мөнгө санхүү, *хоёрт*, технологи, *гуравт*, хүний нөөц, *дөрөвт*, менежмент, *тавд*, маркетинг нэн чухал болно. Хоршин хөгжиж, хамтран ажиллаж, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх буюу win-win зарчим нь үйл ажиллагааны үндэс юм.

Үүнийг “зөөлөн тэнцвэржүүлэхүй” хэмээн тэмдэглэж байгаа юм. Хүйтэн дайны төгсгөл үед хүчний тэнцвэрийг цэрэг-зэвсгийн бус, эдийн засгийн аргаар хангах зорилгоор олон улсын харилцааны онол болон “ардчилсан энхтайвны онол”-д¹²⁸ “зөөлөн тэнцвэржүүлэх буюу *soft balancing*” хэмээх нэр томъёог гаргаж ирсэн байдаг. Зөөлөн тэнцвэржүүлэхүй нь ялангуяа 2003 оны Иракийн дайн, түүний дараах үед гарч ирсэн цэргийн бус замаар хүчийг тэнцвэржүүлж болохыг батлан харуулсан хүчний тэнцвэрийн онолд шинээр нэмэгдсэн ойлголт гэж Америкийн судлаачид тэмдэглэсэн байна. АНУ-ын аюулгүй байдлын судлаач проф. Роберт Пап¹²⁹, энэтхэгийн олон улсын харилцааны судлаач проф. Т. V Paul¹³⁰, америкийн олон улсын эдийн засагч проф. Стефен Ж. Брукс, Уильям С. Уольфорт¹³¹ болон бусад судлаачид¹³² өөрсдийн бүтээлдээ асуудлыг хөндөж тавьжээ.

¹²⁸ Michael Doyle's pioneering work "Kant, Liberal Legacies, and Foreign Affairs", *Philosophy and Public Affairs* (1983) 205, 207–208, initially applied this international relations paradigm to what he called "Liberal states" which are identified as entities "with some form of representative democracy, a market economy based on private property rights, and constitutional protections of civil and political rights." This theory has been alternately referred to as the "Liberal peace theory" For example, Clemens Jr., Walter C. Complexity Theory as a Tool for Understanding and Coping with Ethnic Conflict and Development Issues in Post-Soviet Eurasia. *International Journal of Peace Studies*.

¹²⁹ Robert Anthony Pape Jr. "Soft Balancing against the United States," *International Security*, 30/1, (Summer 2005): p 7-45.

¹³⁰ T.V. Paul. "Soft Balancing in the Age of US Primacy," *International Security*, 30/1, (Summer 2005): p 46-71.

¹³¹ Stephen G. Brooks & William C. Wohlforth, "Hard Times for Soft Balancing", *International Security*, 30/1, (Summer 2005): p 72–108.

¹³² Thomas S. Mowle & David H., Sacko, *The Unipolar World: An Unbalanced Future*, (New York: Macmillan, 2007), p 147.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого нь зөөлөн хүчний бодлого бөгөөд Жозеф С.Най судлаачийн тэмдэглэснээр: “зөөлөн хүч” гэдэг нь албадлага, “хүчээр түрээ барих” бодлогоо тулгахаас зайлсхийн, түүх, соёл, улс төрийн үнэт зүйлс, ёс зүйтэй гадаад бодлогын манлайллаар бусдын сэтгэлийг бишрүүлэн татах, улмаар хүссэн үр дүнд хүрэх улс төрийн бодлогын арга хэрэгсэл юм.¹³³

Жижиг бага улс уламжлалт “хатуу хүчний” бодлого, эсвэл дан гагц соёл хийгээд эдийн засгаар нөлөөлөх “зөөлөн хүчний” бодлогоор үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлээ хангах боломж хомс. Харин гадаад, дотоод хүчин зүйлсийг чадварлагаар зохицуулах, ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх “ухаалаг хүчний” буюу *smart power* бодлого баримтлах боломжтой. Үүнийг тэнцвэрийн хүч буюу *power of balance* хэмээх ажгуу.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого нь 1992 онд батлагдсан Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн нэгд: тус улсын гадаад бодлогын үндсийг «...олон улсын эрхзүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна»¹³⁴ хэмээн тодорхойлсонтой нийцэж байгаа юм.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого нь эдийн засгийн эрх ашгийн тухай асуудал гэж дээр тэмдэглэсэн. Хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж буй өнөө үед бага жижиг улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, хөгжил дэвшил гадаад эдийн засгийн харилцаа, түүнээс гарах үр өгөөжтэй амин чухал холбоотой.

Бусад улс гүрнүүдийн санаачлан хэрэгжүүлж байсан тухайлсан чиг бодлогыг харахад эхлэл, үйл явц, төгсгөл гэсэн үе шатуудыг дамжсан байдаг. Монгол Улсын хувьд «гуравдагч хөрш»-бодлогыг хэрэгжүүлээд, үр дүнг нь нэгтгэн дүгнээд “хавтаст хэрэг”-ийг нь хаачихад нэн учир дутагдалтай. Монгол Улс хоёр хөрштэйгээ мөнхөд хаяа дэрлэн орших нь тодорхой. Одоогийн үйл явцыг ажиглавал Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь урт удаан хугацаанд баримтлах стратегийн зорилт байх төлөвтэй байгаа тул залгамж шинэжтэй байх ёстой болов уу.

Үнэлгээ

Нэгд, Даяаршил, дижиталчлалын үед хамгийн хүчирхэг батлан хамгаалах чадавхтай, хамгийн хүчирхэг эдийн засагтай улс гүрэн ч өөрийн аюулгүй байдал, хөгжил дэвшлийг дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болсон. Энэ дүгнэлт АНУ, хоёр хөршид юуны өмнө хамаарна

Хоёрт, Хятадын эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц удааширч буй боловч үүнийгээ чанарт шилжиж буй үйл явц гэж онцолж байгаа нь¹³⁵ Монгол Улс хийгээд олон улсын харилцааны олон туйлт системийг бүрдүүлэхэд зохих нөлөө үзүүлж байна.

Гуравт, Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил нь тус орны глобал болон бүс нутгийн геополитикийн орчинд хөршүүдтэйгээ түншлэлийн шинэ харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зүй ёсоор шаардсаар байгаа юм.

¹³³ Joseph S. Nye. *Bound to Lead: The Changing Nature of American Power*, Basic Books.: 1990, Chapter II

¹³⁴ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992, 5 дахь тал

¹³⁵ “The Fourth Plenary Session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019

Дөрөвт, Монгол Улсын хоёр хөрш, “гуравдагч хөрш”-үүдийн хооронд өрнөж буй геополитикийн сөргөлдөөн Монгол Улсад таатай нөлөө үзүүлэхгүй.

Тавд, Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтэй холбоотойгоор Хятад нүүрсний хэрэглээгээ багасгах чиглэл барьж байгаа нь Монгол Улсын хувьд таатай биш.

Зургаад, Гурван хөршийн хамтын ажиллагааны шинэ механизм бүрэлдэн төлөвшиж буй нь Монгол Улсын хөгжил, үндэсний аюулгүй байдалд эерэг нөлөөтэй.

Долоод, Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгалж чадахгүй байх явдал ажиглагдаж буй нь хамтын ажиллагаанд зохих эрсдэлийг дагуулна.

Наймд, Монгол Улсын геополитикийн харьцангуй давуу талын хүчин зүйлийн ач холбогдол аажмаар буурах хандлага ажиглагдаж болзошгүйг тэмдэглэх хэрэгтэй. Хятадад эрчим хүчний нүүрс, кокс нийлүүлэх шинэ тоглогч Монголын хойд хөрш ОХУ гарч ирэв.

Ест, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: гадаадын нийт хөрөнгө оруулалтад нэг улсын эзлэх жин гуравны нэг хувиас хэтрэхгүй байх заалтын агуулга нь тэрхүү нэг хувийг танах биш, харин бусад улсын эзлэх хувийг өсгөх замаар тэнцвэржүүлэх утгатай гэдгийг байнга анхаарах,

Аравт, Хятадын удирдагч Си Зиньпин УИХ-д үг хэлэхдээ чухал зүйлийг онцлон тэмдэглэсэн. Тэрбээр “Олон улсын нөхцөл байдалд ямарч өөрчлөлт гарсан хоёр улсын харилцааны гол чиг шугамаа дагаж, стратегийн түншлэлийн өнцгөөс нөгөө талынхаа эрх ашгийг бодолцож байх ёстой. Нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал зэрэг гол асуудал болон нөгөө талынхаа анхаарлаа хандуулж буй томоохон асуудалд тууштай, харилцан дэмжлэг үзүүлж байх хэрэгтэй” гэж хэлсэн нь анхаарал татсан асуудал юм. Монгол Улс ч үндэсний эрх ашгаа дээдлэн Далай лам, монголчуудын хоорондын харилцааны асуудал нь цэвэр сүшиг бишрэлтэй холбоотой, улс төртэй огт холбогдолгүй гэдгийг хятадын талд ухуулан сэнхрүүлэх шаардлага байгаа юм. Монгол Улс шашны эрх чөлөөг дээдэлдэг улс болой.

Арваннэгд, Хятадын эдийн засаг асар хурдацтай дижиталчлагдаж байна. Монгол Улс эл үйл явцтай хөл нийлүүлж дасан зохицох, хөрвөх чадавхтай байх шаардлагатай, интернет худалдаа маш чухал бөгөөд дижитал дэд бүтцийг эрс сайжруулах ёстой.

Арванхоёрт, Хятадын эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ дэлхийн байгалийн баялаг, түүхий эдийг сорогч **black hole** байнга хэвээрээ байна гэсэн төсөөллөө өөрчлөх шаардлагатай.

Арвангуравт, Монгол Улсын геополитикийн хуучин статус өөрчлөгдөв. Монгол Улс хоёр их гүрний дунд хашигдсан, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, хөгжлийн тусламж гориллогч, буурай хөгжилтэй жижиг улс байсан бол гадаадын хэвлэлд тэмдэглэсэнчлэн **аварга баавгай, аварга лууны дунд жороолж буй pony** биш, харин **Asia's galloper** буюу **Азийн шандаст хүлэг улс** руу тэмүүлж буй гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутаг, зах зээлд хамгийн ойр орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, хөрш болон бусад их гүрнүүд, үндэстэн дамнасан нийгэмлэгүүдийн геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдэлийг дагуулж байгааг анхаарах хэрэгтэй болов уу.

Арвандөрөвт, Хятад, Америкийн геополитикийн сөргөлдөөн, худалдаа, технологийн дайны үр дагавар Хятадын эдийн засгийн хөгжилд, улмаар Монгол Улсын эдийн засаг, мөнгөний ханш, инфляцид сөрөг нөлөөтэй.

Арвантавд, Монгол Улс АДБХОБ-ны анхны үүсгэн байгуулагч 21 орон мөний хувьд гурван улсын авто замын коридор, эрчим хүчний супер сүлжээ, Замын-Үүд-Эрээний хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх хөтөлбөр, хийн хоолойн мега төслийн хүрээнд хөгжлийн зээл авах чиглэлээр ажиллах шаардлага байна.

Арванзургаад, 2012 оны 9 дүгээр сард НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг дэмжиж, улс төрийн баталгаа гаргасан Тунхаглалд гарын үсэг зурсан нь хоёр хөрш, “гуравдагч хөрш”-ийн хамтын ажиллагааны чухал үр дүн мөн гэж авч үзэх шаардлагатай.

Арвандолоод, АНУ-ын Мянганы хөгжлийн сорилтын компакт II гэрээний хүрээнд Улаанбаатар хотын ундны усны хангамжийг нэмэгдүүлэх, эрэлтийг бууруулах хоёр зорилтыг төслийн хүрээнд *нэгд*, Био комбинат, Шувуун фабрик орчмын гүний усыг гүн цэвэршүүлж, өдөрт 140 м³ цэвэршүүлсэн усаар Улаанбаатар хотын ундны усны хангамжийг нэмэгдүүлэх, *хоёрт*, Эрэлтийг бууруулах чиглэлд Улаанбаатар хотын ЦС-уудын усны хэрэглээг гүний цэнгэг усаар биш, дахин боловсруулсан саарал усаар орлуулахад чиглэгдэж байна. Энэ нь БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлттэй зээл 262.7 сая ам.долларын санхүүжилтээр барих Улаанбаатар хотын шинэ Төв Цэвэрлэх байгууламжийн төсөлтэй нэгдсэн цогц хөтөлбөр болж байгаа юм.

Арваннаймд, Монголын нутгаар дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий дамжуулах төсөл ажил хэрэг болж буй нь Монгол Улс дахь ОХУ-ын эдийн засгийн бодит ашиг сонирхол жинхэнэ ёсоор буй болж, энэ нь цаашдаа иж бүрэн стратегийн түншлэлийн цөм хэсэг болох боломжтой. Зарим хүмүүсийн хардаж байгаачлан Монголын нутгаар хий дамжуулах хоолой тавигдсанаар Монгол Улсын ОХУ-аас хараат байдал улам нэмэгдэх бус, харин ч Орос, Монгол, Хятад хоорондоо илүү харилцан хамааралтай болох юм. Дурьдсан төсөл нь зөвхөн эдийн засгийн үр ашигтай төсөл байх төдийгүй, улс төр-геополитикийн ач холбогдолтой гэдэг үүднээс давхар авч үзэх ёстой болов уу.

Арванест, Монгол Улсын “гуравдагч хөрш”, стратегийн түнш Энэтхэг улсын 1.2 тэрбум ам. долларын нэн хөнгөлттэй зээлээр Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах мега төсөл амжилттай хэрэгжиж байгаа нь “Оюутолгой”-н төсөлтэй шууд харьцуулахгүй ч өргөн утгаар нь авч үзвэл Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах стратегийн шинж чанартай бүтээн байгуулалт болно.

Эцэст нь, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого, гурван хөршийн харилцаа, хамтын ажиллагааны дунд эрх ашгийн тэнцвэрийг зөв барьж, тэнцвэрийн хүчийг (Power of Balance) урт удаан хугацаанд хадгалах явдал чухал болов.

Монголчуудын нэг том дутагдал бол Хятадаас хамааралгүй хөгжих гээд байдагт оршино. Мөн хоёр хөршөө гайхшируулсан үйл явдал бол хоёр хөрштэйгөө стратегийн түншлэлийн олон улсын эрхзүйн үндсийг баттай тавьсан атлаа байнга төвийг сахих санаачилга дэвшүүлж байсан явдал юм. Түүнчлэн ШХАБ-д Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал хөндөгдөх тухайд ямагт хоёр хөршөө муучилж, тэд юу юуны түрүүгүй Монголыг өөрийн урхинд оруулж авах юм шигээр тайлбарлаж байгаа явдал юм.

Бид Монгол Улсын гадаад бодлого, эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны механизм, түүний шийдвэр гаргах ажиллагааны шинжлэх ухаан-онол аргагүйн үндсийг улам бүр төгөлдөршүүлэх шаардлага буй. Хөгжиж буй улсын үндэсний хөгжил дэвшил, аюулгүй байдлын баталгаажилтын чухал эх сурвалж нь идэвхтэй бөгөөд оновчтой прагматик гадаад бодлого, олон хэмжээст дипломат ажиллагаа даруй мөн.

Нөгөө нэг үгүйсгэж үл болох хүчин зүйл бол Хятадын эдийн засгийн хөгжил Монгол Улсад эерэг нөлөө үзүүлж буй явдал юм.

Түүнчлэн *нэгд*, Өрнөдийн эдийн засгийн хоригийн дараа ОХУ, БНХАУ-ын улс төр-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа огцом эрчимжсэн нь Монгол Улсын геополитик, гео-эдийн ач холбогдлыг өсгөж байгааг тууштай ашиглах шаардлагатай, *хоёрт*, Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэлийн түвшинд хүрч, түүнчлэн БНХАУ-ын удирдлага Хятад-Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэж мэдэгдсэн. Иймд өнөө болон ойрх ирээдүйн Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн хамгийн ойр орчинд таатай нөхцөл бүрдээд байгааг аанай л үгүйсгэж үл болно.

Дүгнэлт

Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хоршин хөгжих, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх явдал мөн.

«Гуравдагч хөрш»-ийн тухай ойлголт нь шинэ тутам гарч ирсэн үзэл санаа биш юм. Монгол Улс түүхэндээ «гуравдагч хөрш»-өө эрж хайж байсан цаг үе ХХ зууны эхний хориод жилд холбогддог бөгөөд харин ингэж цэгцтэй ойлгох, бодлогын түвшинд томъёолох талаар оролдлого хийж байгаагүй нь мэдээж билээ. 1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын удирдагчид хоёр хөршөөсөө гадна «гуравдагч» гүрнүүдтэй харилцаа тогтоохыг чинхүү эрмэлзэж байсан нь гадаад улс төр, эдийн засгийн бодлогын чухал чиг шугам байжээ. Энэ нь юуны өмнө Өрнө, Дорны гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, улмаар тэдгээр орнуудтай худалдааны харилцаа холбоо тогтоох, Өвөрлөгч нутгийг Халхад нэгтгэх замаар Монгол үндэстний улс төрийн нэгдлийг хангах, түүнийгээ бататгах үндэсний эрх ашиг хийгээд аюулгүй байдалтай ямагт холбогдож байжээ.

«Гуравдагч хөрш»-бодлогын хүрээнд Өрнө, Дорны хөгжингүй, ардчилсан орнуудын Монгол дахь эдийн засгийн бодит сонирхолыг буй болгох чиг шугам тодорхой сорилтуудтай тулгарч байгааг тэмдэглэх ёстой. Тухайлбал Лондонд бүртгэлтэй АНУ-ын «*Soko International PLC*» компани Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул үнэлгээний ажил явуулахаар Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан ч тодорхой үр дүнд хүрсний дараа ашиглалтын лицензийг 2005 онд Хятадын төрийн өмчийн «Петро Чайна Дачин Тамсаг [Монгол]» компанид худалдсан. Цаашилбал Канадын Ванкувер хотноо бүртгэлтэй «*Western Prospector Group Ltd*», мөн Торонто хотод бүртгэлтэй «*Khan Resources Inc.*», Торонто, Нью-Йоркт бүртгэлтэй «*SouthGobi Resources Ltd.*» (толгой компани нь «*Turquoise Hill Resources Ltd*» буюу хуучнаар «*Ivanhoe Mines Ltd*»)-ийн салбар компани болох British Virginia-д бүртгэлтэй «*SouthGobi Sands LLC*»,

Лондон , Мельбурн хотноо бүртгэлтэй Британи-Австралийн үндэстэн дамнасан корпораци «Rio Tinto Group»-ын явуулж буй үйл ажиллагааг энд онцлон тэмдэглэж байгаа юм.

ОХУ-ын зарим судлаачдын зүгээс тэмдэглэхдээ: Монгол Улс 1990 оноос хойш «гуравдагч хөрш»-ийн бодлогыг эхлүүлсэн. Танай “гуравдагч хөрш”-үүд нэг лиценз дээр орж ирээд, хэсэг хугацааны дараа лицензээ Хятадын талд зарчхаад яваад өгдөг. БНХАУ-ын нөлөөлөл нь улам л нэмэгдэж байна. Монголчууд иймэрхүү л «гуравдагч хөрш»-тэй гэдэг зүйлийг тавлангуй бичсэн юм¹³⁶. Энэ бол оргүй ч зүйл биш. Ер нь бол хоёр хөрш 3/2, бусад нь 3/1 гэсэн харьцаа нь хамгийн боломжтой байж болох юм. БНХАУ-тай хамтарч байгаа одоогийн харьцаагаа хадгалж, бусад чиглэлд хөршүүдтэй хамтрах замаар явбал Монгол Улс эдийн засгаа гуч дахин өсгөх боломжтой.

Гэхдээ зарим улс төрчдийн хэлж буйчлан дээрх баримт нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-бодлогын нуралт биш бөгөөд «гуравдагч хөрш»-бодлогын эдийн засаг, улс төрийн чиг шугам хэвээр байгаа гэдгийг тэмдэглэх ёстой.

Оюутолгой төслийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь олон улсын шууд хөрөнгө оруулалт орох нэн чухал загвар болж өгөх ёстой байсан. Энэ бол маш чухал анхаарал татсан асуудал байв. Дэлхийн хамгийн том үндэстэн дамнасан Rio Tinto компани Монголын уул уурхайн салбарт олон арван тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн нь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд зохих нөлөө үзүүлсэн юм.

Гэхдээ олон улсын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн утгаар нь авч үзвэл Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлоготой шууд холбогдолгүй юм. Дэлхий дахинд нэрд гарсан улс, үндэстэй дамнасан корпорацууд нь тухайлбал, Rio Tinto групп Лондон, Мельбурн хотод бүртгэлтэй боловч, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ид хамаарах Британи, Австралийн Засгийн газрыг төлөөлөхгүй. Үндэстэн дамнасан корпорацуудын хөрөнгө оруулалт бол цэвэр бизнесийн эрх ашгийг илэрхийлнэ. Засгийн газар гадаадын шууд хөрөнгө оруулалт хийдэггүй. Тиймээс ч олон улсын худалдаанаас харьцангуй тусдаа асуудал юм. Худалдаа ч мөн хийдэггүй. Гэхдээ Засгийн газар худалдаа, хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх чиглэлд ажилладаг. Засгийн газрын чиг үүрэгт хөнгөлөлтэй зээл, буцалтгүй тусламж зэрэг хөгжлийн албан ёсны тусламж, худалдааны хөнгөлт зэрэг асуудал хамрагддаг. Тухайлбал, ЕХ-ны Худалдааны тарифын Хөнгөлөлтийн GSP+, Монгол Улсын Ази-Номхон далайн Худалдааны хэлэлцээрт нэгдэн орсон үйл явц, Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн Ерөнхий хэлэлцээр, АНУ-ын хууль тогтоогч зарим гишүүдийн Конгресст өргөн барьсан “Гуравдагч хөрш”-ийн худалдааны хууль”-ийн төсөл, ДХБ-тай тогтоосон хамтын ажиллагаа, хоёр талт “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр”, “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” зэргийг байгуулдаг.

Засгийн газрын чиг үүрэгт хөнгөлөлтэй зээл, буцалтгүй тусламж зэрэг хөгжлийн албан ёсны тусламж, худалдааны хөнгөлт зэрэг асуудал хамрагддаг.

¹³⁶ Родионов В.А. «Политический процесс в современной Монголии в контексте пост-социалистических трансформаций». Диссертация на соискание ученой степени доктора политических наук. Дипломатическая академия МИД РФ. М.: 2018, стр. 249-251

Бидний хувьд Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийг илүү өргөн утгаар нь авч үзвэл олон улсын энхтайван, аюулгүй байдлыг сахин хангах, нийт хүн төрөлхтний өмнө тулгамдсан нийтлэг асуудлыг авч хэлэлцдэг, хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой дэлхийн хамтын нийгэмлэг НҮБ ч орох учиртай. НҮБ бол хөгжиж буй улс орнуудын нийтлэг эрх ашгийг илэрхийлдэг, мөн хамгаалдаг, хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлдэг, Монгол Улс ч тэр, АНУ ч тэр хоёул адилхан нэг, нэг саналтай ийм түгээмэл байгууллага болой.

Монгол Улс «гуравдагч хөрш»-ийн бодлогын зорилго, мөн чанарыг НҮБ-ын хэмжээнд танилцуулж, Ерөнхий Ассамблейгаар дэмжүүлж, тогтоолын төслийг батлуулах хувилбар байж болох юм.

Одоогийн байдлыг ажиглавал Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь урт удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй бөгөөд, тиймээс залгамж шинжтэй байх ёстой.

АНУ-ын элчин сайд Жонатан Эдлтон *«Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол Улсын дипломат харилцаа, 1987-2012»* сонирхолтой бүтээлдээ: *«Дотоод асуудал дээр ам хэлээр тохиролцож, заримдаа ширүүн мэтгэлцдэг ч гадаад бодлогын асуудлаар дэлхий нийтэд нэгдмэл байр сууриа харуулахыг хүсч буй Монголын улс төрчид үндэсний хэмжээний зөвшилцөлтэй байх хүнд ачааг зайлшгүй үүрч байна. Монгол Улсын гадаад бодлого дахь одоогийн чиг хандлагаас харахад хөрш хоёр оронтойгоо бат бэх харилцааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинэ томъёолол болох «гуравдагч хөрш»-өө олон янзаар хайж байна. Монгол Улс үүнийг илүү амжилттай хийх тусам цаашид улам амаргүй болж болох юм. Олон улсын тавцанд Монгол Улс ерөнхийдөө нэр хүнд ихтэй байгаа нь энэ үйл явцыг илүү хялбар болгоход тус дөхөм болно»*¹³⁷ гэсэн анхаарал татсан дүгнэлт хийсэн байдаг.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүлээгдэж буй үр дүн бол нийт гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад хөгжингүй орнуудын эзлэх хувь 50-иас доошгүй хувийг эзэлж, тэдгээр орнуудын худалдаа-эдийн засгийн бодит ашиг сонирхол буй болсон байх явдал юм. Тиймээс л «гуравдагч хөрш»-ийн бодлого, гурван хөршийн бодлого нь тус тусдаа дангаар хэрэгжүүлэх болон бие даасан бодлого биш, харин хооронд нягт уялдаа холбоотой, тиймээс тэдгээрийн хоорондын *supply chain connectivity* буюу гинжин шүтэлцээний барилдлагыг тууштай хангах явдал чухал болно.

Даяаршлын үйл явц болгоомжтой, хариуцлагатай, мөн ухаалаг байхыг шаардаж байна. Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх, энх тайван болон хөгжил рүү тэмүүлсэн түүхэн хандлагад зохицох, өөр өөр иргэншил болон олон янзын соёлын уламжлал тээгч улс орнуудын хооронд харилцан хүндэтгэл, харилцан итгэлцлээр дамжин сайн хөршийн харилцаа, нэгдэл болон хамтын ажиллагааны үлэмж нөөц чадавхыг дэлгэрүүлэх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих явдал мөн.

¹³⁷ Addleton Jonathan S. A Most Helpful Factor: US-Mongolia Diplomatic Relations, 1987-2012. Weatherford Foundation, Ulaanbaatar.: 2012, p. 161

Геополитикийн гол элемент болох хүч чадалд хамаарах хүчин зүйл бол ардчилсан ухаалаг засаглал, түүний чанар хийгээд улс төрийн удирдагчийн *behavior*, ёсзүй, зөвшилцөх чадавх, шинжлэх ухаанч бодлого бөгөөд улс орны үндэсний аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлдэг. Энэ бол Монгол Улсад хамаарах магадгүй хамгийн гол хүчин зүйл мөн болой.

НОМЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
3. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011
4. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ., 2008
5. Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном: 2007-2011, ГХЯ, УБ., 2011
6. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай Хамтарсан Албан мэдээ. М.: 2006.07.01
7. Московская декларация о стратегическом партнерстве между Монголией и Россией. 8 декабря 2006 г.
8. Декларацию о Развитии стратегического партнерства между Российской Федерацией и Монголией от 25 августа 2009 года. Уланбатор.: Монголия
9. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Дунд хугацааны хөтөлбөр» УБ., 2016.04.14
10. «Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын Гэрээ» УБ., 2019.09.03
11. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал. УБ.: 2014.08.21
12. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25
13. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.
(эрхэлсэн проф. Д.Уламбаяр) УБ., 2014, 12-13 дахь тал
14. Олон улсын харилцаан дахь Зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс. (Эрхэлсэн др.проф. Д.Уламбаяр). УБ., 2021
15. “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах Санамж бичиг” ОХУ. 2015.07.09
16. “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааг Дунд хугацаанд хөгжүүлэх Замын зураглал”. 2016.06.23
17. “Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах Хөтөлбөр” 2016.06.23
18. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын тав дахь удаагийн дээд хэмжээний уулзалтыг даргалж, үг хэллээ 2019.06.14
19. Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн Хамтарсан Тунхаглал. Москва. ОХУ, 2021.12.16

20. Р.Болд. “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын зарим эргэцүүлэл”-*XX зууны Монгол: Түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд*. УБ., 2017, 286-304 дэх тал
21. Ж.Бор, Д.Уламбаяр. Монголын дипломын нэвтэрхий толь бичиг. Тэргүүн боть. А-И. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2016
22. Ж.Бор, Д.Уламбаяр. Монголын дипломын нэвтэрхий толь бичиг. Дэд боть. К-Р. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2016
23. Ж.Бор, Д.Уламбаяр. Монголын дипломын нэвтэрхий толь бичиг. Гутгаар боть. С-Я. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2016
24. Х.Бэхбат. “Гуравдагч хөршийн бодлогын тухайд...”-*Монгол Улсын “Гуравдагч хөршийн бодлогын тухай” судалгааны ажлын хүрээнд түүний онол-практикийн асуудлуудаар явуулах цахим хэлэлцүүлэг*. МУИС, ОУХНУС, 2020.04.15
25. Д.Уламбаяр. “Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын онолын үндэслэл”-*Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого: Гурвалсан хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж. Конрад Аденауерын сан. Монголын гадаад бодлогын лаборатори төсөл*. УБ., 2017.12.08, 19-45 дахь тал
26. Д.Уламбаяр. “Геополитикийн орон зай, цаг хугацаа, таталцлын хүч, гадаад бодлогын муруйлт ба олон хэмжээст дипломаси”-*Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд*”. МУИС, ОУХНУС. УБ., 2019, 243-264 дэх тал
27. Д.Уламбаяр. «Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого ба гурван хөршийн хамтын ажиллагааны шинэ парадигм: зөөлөн тэнцвэржүүлэхүй»- *Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд*. УБ., 2020, 169-201 дэх тал
28. Д.Уламбаяр. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын онол-практикийн асуудал- *Монгол Улсын “Гуравдагч хөршийн бодлогын тухай” судалгааны ажлын хүрээнд түүний онол-практикийн асуудлуудаар явуулах цахим хэлэлцүүлэг*. МУИС, ОУХНУС, 2020.04.15
29. Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Геополитик, аюулгүй байдал, дипломат ажиллагаа. *XX зууны сүүлийн хагаст*. Дэд боть. УБ., 2020
30. Д.Уламбаяр. “Монгол Улсын “гуравдагч хөршийн” бодлого: Онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудалд”-*Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ*. (Эрхэлсэн проф. Д.Уламбаяр) УБ., 2014, 88-117 дахь тал
31. Х.Олзвой. “Олон улсын харилцаан дахь гуравдахь түншлэлийн асуудалд”-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал ба гуравдахь түнш орнууд: Өнөө, ирээдүй. УБ., 2002
32. Alicia Campi. *Mongolia’s Foreign Policy: Navigating a Changing World*. Lynne Rienner Publishers Boulder, London.: 2019
33. “US Secretary of State John Kerry hails Mongolia as «oasis of democracy» in tough neighbourhood”-*The Straits Times*. Asia. June 5, 2016
34. Robert Anthony Pape Jr. “Soft Balancing against the United States,” *International Security*, 30/1, (Summer 2005)
35. T.V. Paul. “Soft Balancing in the Age of US Primacy,” *International Security*, 30/1, (Summer 2005) Stephen G. Brooks & William C. Wohlforth, “Hard Times for Soft Balancing”, *International Security*, 30/1, (Summer 2005)

36. Thomas S. Mowle & David H., Sacko, *The Unipolar World: An Unbalanced Future*, (New York: Macmillan, 2007)
37. Joseph S. Nye. *Bound to Lead: The Changing Nature of American Power*, Basic Books.: 1990, Chapter II
38. Zbigniew K. Brzezinski. *The Grand Chessboard: American Primacy and Its Geostrategic Imperatives*. Basic Books, N.Y.: 1997
39. Morgenthau Hans J. *Politics Among Nations: The Struggle for Power and Peace*. N.Y., *Seventh edition*. 2006
40. Addleton Jonathan S. *A Most Helpful Factor: US-Mongolia Diplomatic Relations, 1987-2012*. Weatherford Foundation, Ulaanbaatar.: 2012

2.2 Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: хоёр хөршийн судлаачдын судалгаа, дүн шинжилгээ

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын тухайд хоёр хөршийн судлаачид ямар байр суурь, хандлагатай байна гэдэг анхаарал татсан нэн чухал асуудал мөн. Өмнөд, Умард хөршүүд албан ёсны түвшинд дурдсан асуудалд тааламжгүй эсвэл бүр сөрөг байр суурь албан ёсоор илэрхийлж байгаагүй ч, олон улсын харилцаа, геополитик, стратеги судлаачид олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд үзэл бодол, байр сууриа чөлөөтэй илэрхийлж ирсэн байна.

БНХАУ-ын судлаачдын дүн шинжилгээ

Монгол Улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын асуудлаарх судалгаанд Хятадын Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн ухааны академи (НУА-Chinese Academy of Social Sciences) чухал байр эзэлдэг. АНУ-ын *Foreign Policy* сэтгүүл Хятадын Нийгмийн ухааны академийг Азийн шилдэг судалгааны *think tank* төв гэж тодорхойлсон байдаг.¹³⁸ 2020 оны 11 дүгээр сарын байдлаар Хятадын Нийгмийн ухааны академи нь 3200 гаруй үндсэн эрдэмтэн судлаачидтай,¹³⁹ бүрэлдэхүүний хувьд 6 их сургуулийн тэнхим, 42 судалгааны хүрээлэн, 6 чиг үүргийн хэлтэс, 5 шууд харьяа байгууллага, 3 шууд хамаарал бүхий компанитай ажээ.¹⁴⁰ Түүний функциональ хэлтсүүдээс тав нь судалгаанд чиглэгддэг байна.¹⁴¹

ХКН-ын хятад, англи хэлээр гардаг өдөр тутмын төв хэвлэл, Хятадын *Fox News* хэмээн нэрлэгддэг *Global Times* сонин нь Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар тогтмол тэргүүн өгүүлэл, нийтлэл гаргадаг. Тиймээс нийтлэлүүд нь ХКН-ын байр суурийг албан ёсоор илэрхийлдэг гэж үзэж болохоор байдаг.

БНХАУ-ын Бээжингийн Ардын их сургуулийн Олон улс судлалын сургууль, Бээжингийн Гадаад судлалын их сургууль, ӨМӨЗО-ын Нийгмийн ухааны академийн Орос, Монгол судлалын хүрээлэн, Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын салбар, Өвөр Монголын Багшийн их сургууль, Шанхайн Хуадун их сургуулийн Ойр орчны орнуудын судлалын хүрээлэнг онцлон дурдах хэрэгтэй.

2005 оны 11 дүгээр сард Ж. Буш АНУ-ын Ерөнхийлөгчийн хувиар анх удаа Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр Хятадын Коммунист Залуучуудын Эвлэлийн долоо хоног тутмын «*Qingnian Cankao*»¹⁴² сэтгүүлд бичихдээ: “АНУ Монголын “стратегийн байр суурь”-ийг олж харжээ. Чухамдаа Монгол том орнуудтай “зай барина” гэж байгаа бол Америк яагаад тэр “зайнд нь шургаж” болохгүй гэж, Америк Монголтой харилцах харилцаагаа идэвхийлэн хөгжүүлэх гээд байгаа нь Ази тивийн эх газар дахь стратегийн

¹³⁸ The Think Tank Index, *Foreign Policy*, archived from the original on 2009-01-19

¹³⁹ *Chinese Academy of Social Sciences*, archived from the original on 2012-07-22

¹⁴⁰ "组织机构". *cass.cssn.cn*. Retrieved 2020-11-26

¹⁴¹ Faligot, Roger (2019). *Chinese Spies: From Chairman Mao to Xi Jinping*. Oxford University Press. p. 280

¹⁴² ХКН-ын Коммунист Залуучуудын Эвлэлийн өдөр тутмын төв хэвлэл болох *Zhongguo Qingnian* Вао-тай холбоотой долоо хоног тутмын сэтгүүл юм. Тус сэтгүүл нь 1984 оны 7 дугаар сард үүсгэн байгуулагдсан бөгөөд Хятад, гадаадын мэргэжилтнүүд, албаны хүмүүс, *Zhongguo Qingnian* Вао-гийн сурвалжлагч, тоймчид, гадаадын зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон улсын улс төр, цэрэг, эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар тайлан, дүн шинжилгээ хийдэг. Тус сэтгүүл нь дээд боловсролтой, 20-45 насны мэргэжлийн боловсон хүчин гэж тодорхойлсон Хятадын “элит залуучууд”-д “дэлхийн ертөнцийг үзэх цонх” олгодог цорын ганц үндэсний долоо хоног тутмын иж бүрэн сэтгүүл гэж вэбсайтаа өөрийгөө тодорхойлсон байна. <http://www.qnck.net.cn>

ашиг хонжоо хайх гэснээс үүдэлтэй бөгөөд тэнд “ардчиллын тогтолцоог” өргөжүүлэхийг зорьж байгаа юм гэж Америкийн зарим стратегийн шинжээчид тэмдэглэж байна. Монгол бол 1 сая 560 мянган хавтгай дөрвөлжин км. нутаг дэвсгэртэй, Хятад, Орос хоёртой хэдэн мянган км газраар хиллэдэг, Хятад улс хөгжин бадарч, Орос сэргэн өндийж, Зүүн хойд Азийн аюулгүй байдлын төрх төлөв нарийн ээдрээтэй байгаа энэ нөхцөлд Монголын газар нутгийн стратегийн байрлал нь улам бүр чухал болж байгаа юм. Монгол Улс өнгөрсөн зууны 90-ээд оноос нээлттэй бодлого явуулж, Өрнөдийн соёлын нөлөөг улам ихээр авч байгаа болохоор Америкт “Азийн ардчиллын үлгэр жишээ” болж харагдаж байна. Америк, Монголын харилцаа улам гүнзгийрч байгаа нь Хятад, Орос хоёр хоршин ажиллаж байгааг саатуулж, Ази дахь АНУ-ын байр суурийг бэхжүүлж, ардчиллын үнэ өртгийг улам бүр гадагш тархааж нэг сумаар олон туулай буудаж болох юм гэгцгээж байна. Үүнээс гадна хүн амтай нь жишээд үзэхэд Монгол Иракт илгээсэн цэргийн тоогоороо 3 дугаар байранд орж байна. Энэ бол Ж.Буш Монголд айлчлах хамгийн шууд учир шалтгааны нэг болно. Тэрбээр Монголд хувь хүнийхээ хувьд талархлаа илэрхийлэх гэж байгаа хэрэг. Ийм дипломатын үзэл бодол нь дотооддоо улс төрийн талаар уналтад ороод байгаа Ж.Бушийн хувьд авч ярихад маш чухал зүйл гэдэг нь эргэлзээгүй юм”¹⁴³ гэсэн байна.

Хятадын судлаачид шинээр батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд “гуравдагч хөрш”-ийн тухай томъёоллыг оруулсан нь Монгол Улсын гадаад бодлогын нэгэн “инновац” болсон гэж үздэг.

Монгол Улсын ерөнхийлөгчөөр сонгогдсон Халтмаагийн Баттулга Ерөнхийлөгчийн тангараг өргөж, ард түмэндээ хандаж үг хэлснээс хойш 3 хоногийн дараа ХКН-ын англи хэл дээр гардаг өдөр тутмын төв хэвлэл *Global Times* сонинд “Монгол Улс үндсэрхэг үзлээр Хятадтай харилцах харилцааны ач холбогдлыг харалган болгож болохгүй” гэсэн гарчигтай тэргүүн өгүүлэл нийтлэгдсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хэлсэн үгэндээ: “Мөнхийн хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай найрамдалт сайн хөршийн харилцаагаа бүх талбарт тэлж, “**гуравдагч хөрш**”-ийн бодлого дээр **онцгой анхаарал хандуулна**”¹⁴⁴ (тодруулав Д.У) гэсэн юм.

Хятадын Minzu их сургуулийн проф. Шиiao Шин (Xiao Xin)-ийн бичсэн сайхь нийтлэлд 2017 оны 6 дугаар сард явагдсан ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгээс хамаарч Монгол Улсын гадаад бодлогод гарч болзошгүй өөрчлөлтийн талаар бичжээ. Нийтлэлийн эхэнд ерөнхийлөгчөөр сонгогдсон Халтмаагийн Баттулгын талаар бичихдээ: “АНУ-д Дональд Трамп ерөнхийлөгч болж байхад Монгол Улсын шинэ ерөнхийлөгчөөр Х.Баттулга сонгогдож байгаа нь гайхах зүйл биш юм. Хоёул амжилт гаргасан бизнесменүүд, өөрсдийгөө эх оронч гэж зарладаг хүмүүс. Хоёул улс орноо сэргээн босгох уриатайгаар сонгуульд өрсөлдөж ялсан. Хоёул гадаад эхнэртэй”¹⁴⁵ гэжээ.

Жүдогийн Холбоог тэргүүлдэг Х.Баттулгын хичээл зүтгэлээр Монгол Улс 2008 оны Бээжингийн Олимпоос анхны алтан медалиа зүүж байсныг дурдаад энэ нь түүний нэр хүндэд чухал нөлөө үзүүлснийг ч бас өгүүлсэн юм.

¹⁴³ М.Хурбетхан. Монгол Улс, АНУ-ын Иж бүрэн түншлэлийн эхэн. УБ., 2007, 72-73 дахь тал

¹⁴⁴ “Ерөнхийлөгчийн тангараг өргөж Халтмаагийн Баттулгын ард түмэндээ хандаж хэлсэн үг” 2017.07.10 <https://president.mn/2228/>

¹⁴⁵ “Mongolia should not let nationalism blind it to importance of relationship with China” By Xiao Xin 2017/7/13 <https://www.globaltimes.cn/content/1056265.shtml>

Зохиогч түүнийг сонгуулийнхаа сурталчилгааны үеэр Хятадад хатуу бодлого баримталж ажиллахаа амлаж байсныг дурдаад гэвч хөршүүдтэйгээ найрамдалт харилцаатай байх нь тус улсын тогтвортой байдал, хүн ардын сайн сайхан амьдралын баталгаа болдгийг Монгол Улсын сүүлийн 30 орчим жилийн түүх харуулж байна¹⁴⁶ гэжээ.

Монгол Улсын гадаад бодлогын талаар нийтлэлд бичихдээ: “Монгол Улсын геополитикийн байрлал нь Хятад, Оростой ухаалгаар хамтарч ажиллах ёстойг харуулдаг. Монгол Улсын Засгийн газар нэгэнтээ “гуравдагч хөрш”-ийн бодлого гэгчийг зарлаж Хятад, Оросоос хамааралгүй болох зорилт тавьж байсан. Гэвч энэ бодлого нь тус улсын нэр хүндийг өсгөхөд тус болоогүй юм”¹⁴⁷ гэжээ.

Харин ч Монгол Улс сүүлийн жилүүдэд “гуравдагч хөрш”-үүддээ ашиглуулж”, үр дүнд нь баян, хоосны ялгаа гүнзгийрч, бусдаас эдийн засгийн хамааралтай болж, доройтож байгааг өгүүлсэн байна.

Тиймээс “Монголын улс төрчид хөршөө солих мөрөөдлөөсөө салж, хөршүүдтэйгээ хэрхэн ухаалаг замаар хамтран ажиллах талаар бодох хэрэгтэй”¹⁴⁸ гэж зөвлөсөн байна. Монгол Улсын эдийн засгийн Хятадаас хамаарах хамаарал нь зах зээлийн хуулийн дагуу буй болсон үр дагавар гэдгийг ойлгож, Африк, Азийн олон улс орнуудын нэгэн адил прагматик, эрх тэгш замаар Хятадтай харилцан ашигтай хамтран ажиллаж, үр ашгийг нь хүртэхийн чухлыг онцолсон байна. Хятад улс дэлхийн аль ч улс орныг том, бага гэж ялгалгүй, эрх тэгш харьцаж, тусгаар тогтнол, үндэсний эрх ашгийг нь хүндэтгэж ирснийг дурдаад Монгол Улсыг шинэ ерөнхийлөгчийнхөө удирдлага дор өөрийн хүчээр хөгжин цэцэглэхийг хүсч байгаагаа мөн илэрхийлжээ. “Улс хоорондын эдийн засгийн хамаарал бол гарцаагүй үзэгдэл. Гадаад ертөнцөөс хамааралгүй болох гэсэн оролдлого зөвхөн ухрах алхам болно” гээд “Монгол Улс геополитикийн хувьд өөрийн гэсэн давуу талтай. Гэхдээ явуургүй үндсэрхэг үзэл хөгжилд нь саад болдог. Хөгжихийн тулд Хятад, Монгол хүмүүс энх тайвнаар зэрэгцэн оршиж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээс өөр замгүй гэдгийг ойлгох хэрэгтэй” хэмээн өгүүллээ төгсгөжээ.¹⁴⁹

2017 оны 7 дугаар сарын 10-нд Халтмаагийн Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөсний 2 хоногийн дараа ХКН-ын өдөр тутмын төв хэвлэл, Хятадын *Fox News* хэмээн нэрлэгддэг *Global Times* сонины редактор Ян Ян бээр: “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого бүс нутгийн эрх ашигт нийцсэн байх ёстой, харин геополитикийн өрсөлдөөн өдөөхүйц байх ёсгүй”¹⁵⁰ хэмээсэн нь чухамдаа Америк-Хятадын харилцаа, Зүүн хойд Ази дахь их гүрнүүдийн өрсөлдөөний тухай өгүүлсэн мэт байгаа юм.

Хятадын Нийгмийн ухааны академийн Америк судлалын хүрээлэнгийн дэд захирал проф. Ни Фен (Ni Feng) “АНУ-ын Батлан хамгаалахын сайд Монголд айлчилж Америк-Монголын бал сар эхэлж байна уу?” нэртэй нийтлэлдээ Монгол Улсын геостратегийн байршлын улмаас хүйтэн дайны дараа Америк Монголтой харилцаагаа гүнзгийрүүлж ирсэн.

¹⁴⁶ *Ibid*,

¹⁴⁷ *Ibid*,

¹⁴⁸ *Ibid*,

¹⁴⁹ “Mongolia should not let nationalism blind it to importance of relationship with China” By Xiao Xin 2017/7/13 <https://www.globaltimes.cn/content/1056265.shtml>

¹⁵⁰ 社评：“第三邻国”不应与蒙中俄友好对立 2017.07.12 <https://opinion.huanqiu.com/article/9CaKmK40R0>
Хэвлэлийн тайлбар: “Гуравдагч хөрш” Монгол, Хятад, Оростой найрсаг сөргөлдөөн байж болохгүй”

Гэвч Монгол Улсын Америктай хөгжүүлж буй “гуравдагч хөрш”-ийн харилцаа Орос, Хятадыг давах боломж хомс гэсэн байна.¹⁵¹

Монгол Улс АНУ-тай батлан хамгаалах салбарт хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагааны тухай 2016 онд Хятадын Батлан хамгаалах эрдэм шинжилгээний сэтгүүлд “Хятад улсын хуурай газар далайгаар хиллэдэг 24 хөрш улсаас Монгол Улстай хамгийн урт хуурай газраар хиллэдэг. Хойд хилийн аюулгүй байдал Монгол Улстай нягт холбоотой. Монгол Улсын байршил бол Хятадын стратегийн нуруунд, аюулгүй байдлын хоолойд байна хэмээгээд Монголын АНУ-тай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа гүнзгийрэх нь Хятадын аюулгүй байдалд учрах маш том эрсдэл байх болно” гэжээ.

Монгол Улсын “гуравдагч хөрш” хэн бэ? судалгаанд ашигласан судалгааны хэрэглэгдэхүүнд дурдагдаж буйгаар Хятадын судлаачид “гуравдагч хөрш”-ийн субъектийг дараах байдлаар тодорхойлсон байна. 2003-2007 онд БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдаар ажиллаж байсан Гао Шүмао “гуравдагч хөрш”-ийн бодлого нь Хятад, Орос, Америктай хэрхэн харилцах тухай, харин “гуравдагч хөрш”-ийн субъект нь Америк юм. Хожим энэ агуулга өргөжиж Америк болон Өрнөд Европын өндөр хөгжилтэй улсууд төдийгүй Монголд туслалцаа үзүүлсэн донор улс болох Япон, Солонгос, Энэтхэг зэрэг Азийн улсыг ч “гуравдагч хөрш” хэмээн нэрлэх болсон” гэжээ.¹⁵²

Хятадын Нийгмийн ухааны академийн Ази, Номхон далайн судлалын хүрээлэнгийн проф. Чэнь Шань “гуравдагч хөрш” гэдэгт Монгол Улстай үнэт зүйл нэгтэй орнууд, *хоёрт*, Монгол Улсын хөрш орнуудад нөлөөлж чадахуйц улс, олон улсын байгууллага болон улс төрийн хүчин орно гэжээ.

Мөн ялгаатай бүс нутаг, олон улсын байгууллагаар төлөөлүүлсэн ойлголт ч байна. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг их гүрнүүд соргогоор мэдэрч Монгол Улстай харилцаагаа гүнзгийрүүлэхийг хичээж ирсэн. Тухайлбал, АНУ, Япон, БНСУ зэрэг улс орнуудыг нэрлэж болно. Ялангуяа Зүүн хойд Азийн бүс нутагт ашиг сонирхол бүхий их гүрнүүдийн Монгол Улстай харилцах сонирхол нэмэгдсэн. Монгол Улс “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд АНУ, Канад, Герман, Австрали болон НАТО-ийн гишүүн улсуудтай эдийн засгийн харилцаагаа хөгжүүлж, эдгээр улсын Монгол дахь ашиг сонирхол өсөн нэмэгдэж байна¹⁵³ гэжээ.

Судлаачид цаашид “гуравдагч хөрш” гэдэгт Хятад, Орост нөлөөлж чадахуйц улс болох АНУ тэргүүтэй Өрнөдийн гүрнүүд, НАТО-ийн гишүүн улсууд болон Олон улсын байгууллага гэсэн бүлгээр төлөөлүүлжээ. Ерөнхийдөө дараах 2 чиглэлд хөгжиж байна гэж дүгнэсэн байна. Үүнд:

Нэгд, АНУ, Япон, ХБНГУ, БНСУ, Канад, Австрали, Энэтхэг зэрэг улстай,

¹⁵¹ 美国防长访问蒙古欲强化战略关系，美蒙进入“蜜月期” https://www.thepaper.cn/newsDetail_forward_4113454

“Стратегийн харилцаагаа бэхжүүлэх зорилгоор АНУ-ын Батлан хамгаалахын сайд Монголд айлчиллаа АНУ, Монгол хоёр “бал сар”-даа орж байна уу?” Др. Б.Отгонсүрэн. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухайд зарим улсын байр суурь” 2020

¹⁵² “<https://world.huanqiu.com/article/9CaKrnJslhV> 蒙古推行第三邻国政策 “Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжүүлж байна.”

¹⁵³ 亚洲 娜林, 蒙古与美国：成为第三邻国 “Ази сэтгүүл, На Лин, Монгол Улс ба АНУ: “Гуравдагч хөрш” болох нь”

Хоёрт, НҮБ, ЕХ, НАТО, ЕАБХАБ, ШХАБ, АПЕК зэрэг олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлдэг гэжээ¹⁵⁴.

БНХАУ-ын Бээжингийн Ардын их сургуулийн Олон улс судлалын сургуулийн орлогч захирал др.проф. Жинь Цанрун¹⁵⁵ (Jin Canrong (金灿荣) бээр их хан үндэсний дээрэнгүй шовинист үзлийг үе үе ноцтой цухалзуулж, олон нийтэд таалагдах өнгө аясыг илэрхийлдэг судлаач гэж хэлж болно. Тэрбээр Монгол Улс Хятадад эргэн ирэх нь зөвхөн цаг хугацааны асуудал гэж үздэг. Проф. Жинь Цанрун 2015 оны 11 дүгээр сард хэлэхдээ: Монгол Улс байнга төвийг сахих бодлогыг санаачилж байгаа нь “гуравдагч хөрш”-ийн бодлогын бүтэлгүйтэл, үүнийг Хятад эсэргүүцэхгүй, харин Орос эсэргүүцэж магад, учир нь монголчууд Оросоос салахын тулд төвийг сахих бодлого гаргаж ирсэн байж магадгүй юм гэсэн байна. Мөн оросуудаас алдсан нутгаа буцааж авна, Оросын Азийн хэсгийг Хятад хэзээ мөдгүй эзэлж авна гэх ч юм уу, эдгээр нь түүний тогтмол уншдаг 2-3 цагийн лекцийн дунд гардаг үг яриа юм. Тэрбээр ойрын ирээдүйд гол зөрчил Хятад, Америкийн дунд өрнөх агаад удахгүй БНХАУ нь АНУ-ыг гүйцнэ. Хятадын эдийн засаг эрчимтэй хөгжиж байна. Хятадын эргэн тойронд буй улс орнууд Монгол болон Төв Азийн орнууд Хятадыг л түшиглэнэ. Тэдний гол түшиг нь Хятад юм хэмээн мэдэгддэг.¹⁵⁶

Сүүлийн үед Хятадын судлаачид ОХУ-ыг олон улсын харилцааг, их гүрнүүдийн хоорондын харилцааг тэнцвэржүүлэгч гэсэн байр сууринаас хандах төлөв ажиглагдаж байна. Учир нь ОХУ-ын эдийн засаг бол Хятадын эдийн засгийн 10/1 хувь буюу Гуанжоугийн ДНБ-ээс ч доогуур байна гэж үзэх болсон.

Зарим судлаачид олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвшиж байна гэхээсээ илүүтэй Хятад төвтэй, АНУ төвтэй олон улсын харилцааны хоёр туйл бүрэлдэж байна гэж үзэх болсон нь ажиглагддаг.

2016 оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохиогдсон АСЕМ-ын дээд түвшний XI уулзалтаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн дэвшүүлсэн байнга төвийг сахих санаачилгыг дэмжээгүй билээ.¹⁵⁷

Тус уулзалтад ОХУ-ын Засгийн газрын тэргүүн Д.Медведев, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцян, Японы Ерөнхий сайд Шинзо Абэ, БНСУ-ын Ерөнхийлөгч асан Пак Гын Хэ, Энэтхэгийн дэд Ерөнхийлөгч Мохаммад Хамид Ансари, ЕХ-ны Зөвлөлийн Ерөнхийлөгч Дональд Туск, Еврокомиссын тэргүүн Жан Клоуд Юнкер, ЕХ-ны Аюулгүй байдал, гадаад бодлогын Дээд төлөөлөгч Федерика Могерини зэрэг нөлөө бүхий зүтгэлтнүүд оролцсоныг онцлон дурдах хэрэгтэй.

¹⁵⁴ 蒙古国外交政策的演进及对中蒙关系的影响，图门其其格，内蒙古大学，呼和浩特 010021 “Монгол Улсын гадаад бодлогын өөрчлөлт Монгол, Хятадын харилцаанд нөлөөлөх нь. Түмэнцэцэг. Өвөр Монголын их сургууль, Хөххот”

¹⁵⁵ Жинь Цанрун. Шанхайн Фудан их сургуулийг Улс төр судлалын В.А, Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академид М.А, Бээжингийн их сургуулийн Олон улс судлалын сургуульд докторын зэрэг (Ph.D) хамгаалсан. АНУ-ын Мичиганы их сургуулийн Жеральд Фордын нэрэмжит Төрийн удирлагын сургуульд зочин профессороор ажиллаж байсан.

¹⁵⁶ <http://en.ccg.org.cn/yjlist?fjcat=International%20Relations&zjcat=United%20States>

¹⁵⁷ 11th ASEM Summit “20 Year of ASEM5 Partnership for the Future through Connectivity”. CHAIR’S STATEMENT. Brussels, 5 July 2016 10689/16 p. 21 Draft

АСЕМ-ын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалт. “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоогоор өртөөлөн ирээдүйн түншлэлийн төлөө” УБ.: 2016, 9 дэх тал

2016 оны 8 дугаар сард зохиогдсон ОУМЭ-ийн XI их хурлын үеэр өмнөд хөршийн Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын хүрээлэнгийн профессор Э.На Лин бээр тавьсан илтгэлдээ: Монгол Улсын байнга төвийг сахих санаачилга нь АНУ-ын заавраар хийгдэж буй үйлдэл байж магад хэмээн болгоомжилсон дүгнэлт, саналыг хийж байсан нь анхаарах асуудал байв.¹⁵⁸ Гэтэл АНУ-ын байр суурь тэс өмнөө байв. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри 2016 оны 6 дугаар сард Монголд айлчлал хийх үеэр Шангри-Ла зочид буудалд монголын залуу манлайлагч нарын төлөөлөлтэй уулзаж харилцан ярилцахдаа төвийг сахихын эсрэг байр суурьтай байгаагаа маш тодорхой илэрхийлсэн юм.¹⁵⁹

Судлаач Э.На Лин “Монгол Улсын гадаад харилцаа ба ШХАБ-тай харилцах харилцаа” гэсэн өгүүлэлдээ: Монгол Улс ардчилсан хувьсгал хийснээс хойш “гуравдагч хөрш” улсыг хайх болсон юм, уг “гуравдагч хөрш” улс гэдэг нь газар нутгаар холбогдсон биш, харин улс төр, цэрэг, эдийн засгийн харилцаагаар холбогдсон бөгөөд “гуравдагч хөрш” оронтой болсноор Монгол Улс нь өөрийн олон улс дахь стратегийн тулгуурыг нэмэгдүүлж, аюулгүй байдал, тусгаар тогтнолыг баталгаажуулах юм... Үнэндээ Монгол Улс АНУ зэрэг “гуравдагч хөрш” улс орнуудтай ойртож, АНУ тэргүүтэй НАТО болон ЕАБХАБ-г элсэн орсноор НАТО-гийн шатрын хүү болж, Хятад, Оросыг хязгаарлаж тэнцвэржүүлнэ гэсэн үг биш юм... Монгол Улс Хятад, Орос, “гуравдагч хөрш” улсуудтай мөнхийн хөрш орон гэдгээ тодорхой мэдэж байгаа учраас Хятад, Орос, “гуравдагч хөрш” улсуудын дунд төвийг сахисан харилцааг баримтална. Тиймээс Монгол Улс холын хөршөө холбоотон болгож, ойрын хөршөө дайсан болгох алхам хийхгүй, харин хол хөрштэйгөө харилцаж, ойрын хөрштэйгөө дайсагнахгүй байх нь Монгол Улсын зайлшгүй баримтлах гадаад бодлого болно. Энэ бол жижиг улсын гадаад бодлогын ерөнхий хандлага билээ¹⁶⁰ гэж анхааруулсан байна.

ӨМИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн профессор Л.Түмэнцэцэг, Ш.Амжилт нар “Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого, түүний Хятад, Монголын харилцаанд үзүүлэх нөлөөг товч өгүүлэх нь” хэмээх өгүүлэлдээ: “Гуравдагч хөрш”-ийн бодлого гэдэг нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын нэг удаагийн “инновац” болно. “Гуравдагч хөрш”-ийн онгод бол нүүдлийн уламжлалт оюун ухаанаас эхлэлтэй, монголчууд тал нутагт тулга тулахдаа гурван чулуугаар тулдаг нь алгебрын “наад зах нь гурван цэг байж нэг хавтгай болдог” гэдэг энгийн санаа болно. Иймээс, гуравдахь этгээдэд элсвэл сая Монгол Улсын гадаад бодлогын тэнцвэрт байдлыг хадгалж, Монгол Улсын аюулгүй орчныг баталж чадна гэж Монгол Улс үздэг. Хятад, Орос хоёр улсын дунд хавчигдсан жижиг гүрэн, нэг талаар энэ хоёр том хөрштэйгөө найрамдалт харилцаа хөгжүүлж, нөгөө талаар АНУ, Япон, БНСУ, Энэтхэг зэрэг улстай “гуравдагч хөрш”-ийн гадаад харилцаагаа тэлэн өргөжүүлж, мөн ШХАБ, НАТО, Ази-Номхон далайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагыг “гуравдагч хөрш”-ийн гадаад харилцааг ахиулах гол чиглэл болгож,

¹⁵⁸ На Лин. “*Mongolia’s Permanent Neutrality*” Policy and Its Influence on China”-Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор “Тогтвортой хөгжил ба Монгол судлал” сэдэвт олон улсын монголч эрдэмтдийн их хурал. Илтгэлийн товчлолууд. УБ.: 2016, Э.Наран. *Монгол Улсын “байнга тавийг сахих” бодлого хийгээд түүний Хятад Улсад үзүүлэх нөлөө*”-*Pax Mongolica* сэтгүүл, ШУА, ОУХХ, Vol. 2 2016 №3 (4) 106-115 дахь тал

¹⁵⁹ Secretary Kerry’s Conversation With Young Leaders, Remarks John Kerry Secretary of State, Shangri La Hotel, Ulaanbaatar.: Mongolia, June 5, 2016, Embassy of the US, Ulaanbaatar.: Mongolia

¹⁶⁰ На Лин. “Монгол Улсын гадаад харилцаа ба ШХАБ-тай харилцах харилцаа”. ШУА, ОУСХ *Олон улс судлал* сэтгүүл. №1, 2015, 110-120 дахь тал

Хятад, Орос хоёр том гүрний харилцаагаа тэнцвэржүүлэхийн хамт, олон тулгуурт гадаад харилцаагаараа Хятад, Орос хоёр улстай харилцах гадаад харилцаагаа тэнцвэржүүлэх гэсэн байна. Монгол Улсын эдгээр бодлого нь том гүрнүүдийн тохиолыг амжуулан өөрийн нөлөөллөө өргөтгөн ахиулжээ. БНХАУ, ОХУ, АНУ, Япон, Монгол Улстай харилцаагаа чухалчилсан нь даруй Монгол Улсын “олон тулгуурт” гадаад харилцааны бодлогыг амжилттай хэрэгжүүлсэнтэй холбоотой мөртлөө бас шинэ зуунд Зүүн хойд Азийн аюулгүй байдлын дэглэмд Монгол Улсын стратегийн үнэ цэнэ дээшилсэнтэй холбоотой байж, холбогдох улсуудын ашиг сонирхол болон аюулгүй байдлын харилцааг харуулсан байна. Үүний зэрэгцээ, дэлхийн баялаг өдөр ирэхүйеэ хомсдож байгаа байдал дор, Монгол Улсын дэлхий дэх стратегийн байр суурь өдөр ирэхүйеэ дээшилж, НАТО-гийн улсууд, тухайлбал Канад, Герман, болон НАТО-гийн түнш улс Австрали, БНСУ-ын Монгол Улс дахь ашиг сонирхол өдөр ирэхүйеэ дээшилж байгаа нь НАТО-гийн улсууд Монгол Улстай цэргийн аюулгүй байдлын хамтын ажиллагаа өрнүүлэхэд эдийн засгийн суурь тавьж, Монгол Улс ч НАТО, Европын Аюулгүйн зөвлөл зэрэг олон улсын байгууллагын анхаарах этгээд болсон байна.

Олон улсын шинэ нөхцөл байдал дор, том гүрнүүдийн интерактив олширч, хамтын ажиллагаа болон маргаан тасрахгүй байна. АНУ, Японы холбоо шинээр орон байраа тогтоож, Хятад, Америкийн Ази-Номхон далайн бүс нутаг дахь өрсөлдөөн ив илхэн болж, Хятадын Өмнөд далайн болон түүний хөрш зэргэлдээ улсуудын аюулгүй байдлын тогтворгүй байдал даамжирч байна. Ялангуяа Украины асуудлын талаарх ОХУ болон АНУ-ын маргаан, Крым “ОХУ-д дахин нэгдэн орсон” зэрэг хүчин зүйл нь Монгол Улсыг өөрийнхөө “Аюулгүй байдлын асуудал”-ыг бодолхийлэхгүй байж чадахгүй хэмжээнд хүргэсэн байна”¹⁶¹ гэжээ. Хоёр судлаач цааш нь бичихдээ: “Өдгөө Монгол Улс бас түүхэн дэх Швейцарь, Туркменистан зэрэг хэдэн төвийг сахисан улсуудын үндэсний аюулгүй байдлаа хамгаалсан амжилттай туршлагаар лавлагаа болгож, ирээдүйд тулгарч болзошгүй олон улсын дарамтад чиглүүлж “Байнга төвийг сахих” бодлого дурдан гаргасан нь нэг цагийн хийрхэл огт биш...”¹⁶² гэсэн байна.

Хятадын Жилин их сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн Олон улсын харилцаа, дипломатын профессор Ван Лигийн бичсэн «Монгол Улсын “гуравдагч хөрш” -ийн бодлогын дүн шинжилгээ-Романтик уу, бодит байдал уу?»¹⁶³ өгүүлэл анхаарал татсан юм. Тэрбээр бичихдээ: Орос, Хятад нь Монгол Улс зөвхөн хил залгаа оршдог байгалийн хөршүүд байдаг бол “гуравдагч хөрш” -ийг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Жеймс Бейкер 1990 онд Монголын удирдагчидтай уулзах үеэр анх дэвшүүлж байжээ. Мэдээжийн хэрэг, энэ нь Монголчуудын ардчилал руу чиглэсэн анхны алхмыг батлах үүднээс АНУ-ыг “гуравдагч хөрш” гэж хэлж байгаа юм. Тэр үеэс хойш “гуравдагч хөршүүд” гэсэн санааг Монголын бодлого боловсруулагчид үе үе олж авч, улмаар гадаад бодлого, хууль тогтоомжоороо албан ёсоор батлах болжээ. Энэ нь АНУ, Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Турк зэрэг “гуравдагч хөршүүд” -тэй болох хүслийг илчилж байна.

¹⁶¹ Л.Түмэнцэцэг, Ш.Амжилт. “Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого, түүний Хятад, Монголын харилцаанд үзүүлэх нөлөөг товч өгүүлэх нь”-*Олон улсын харилцаа* сэтгүүл. МУИС, ОУХНУС, 2016 №1/32 (458) 7-13 дахь тал

¹⁶² *Мөн тэнд,*

¹⁶³ Wang Li. The ‘Third Neighbor Policy’ Of Mongolia: Romantic Or Realistic? – Analysis – Eurasia Review July 17, 2017 Modern Diplomacy

Чухамдаа энэ бол Монгол Улсын хувьд бэлгэдлийн дохио болохоос илүү 2003 оноос хойш АНУ болон НАТО-гийн бусад гишүүн орнуудтай цэргийн сургуулилтад оролцож байна. 2010 онд Монгол Улс НАТО-гийн удирдлага дор Афганистан руу цэргээ илгээсэн бөгөөд 2012 онд Чикаго хотод болсон НАТО-гийн дээд түвшний уулзалтад хувийн түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөрийн статустай оролцохыг урьсан юм. Үүний эсрэгээр, Монгол Улс 2004 онд ШХАБ-д ажиглагч гишүүний статустай болсон ч Энэтхэг, Пакистан, Иран шиг албан ёсны статустай болох хүсэлтээ хэзээ ч гаргаж байгаагүй.

Гэсэн хэдий ч энэ яриа нь практик дээр хэзээ ч бодитой байдаггүй. *Нэгдүгээрт*, Монгол Улс Орос, Хятадтай харилцаагаа бусад том гүрнүүдтэй харьцуулах гэж оролдсон нь Улаанбаатарын элитүүдийн хувьд амаргүй ажил юм. Энэ бол дипломат харилцааны шинэ тактик биш, гэхдээ аварга хөршүүд нь “гуравдагч хөрш” (үүд) -ийг өөрсдийн стратегийн ойр орчмын газар нутаг руу татан оролцуулахыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй гэсэн санааг Монгол Улс алдаад байгаа бололтой. Дараа нь Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь монголчуудын эрт дээр үеэс хоёр хөршөөс цааш харах гэсэн үзэл санааг цуурайтуулж, түүхэнд Энэтхэгээс Хятадын Күнз, Оросын славян шашнуудаас үүдэн Буддын шашныг нэвтрүүлж байсантай адилхан гэж үзэж байна. Гэсэн хэдий ч энэ нь тэдний соёл урлаг гэхээсээ илүү геополитикийг өргөнөөр харах тэдний ухамсрыг илэрхийлдэг. *Хоёрдугаарт*, ЗХУ-ын дараахь улс төрийн шинэчлэл, эрх мэдэл нэг намын засаглалаас либерал ардчилалд шилжихэд Хятад, Орос хоёрын аль аль нь Монголын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцоогүй. Үнэндээ Хятад, Орос улсууд Зөвлөлтийн хөрөнгө оруулалт, татаас гэнэт дууссаны дараа Монгол Улсыг эдийн засгийн хүнд хэцүү байдлаа даван туулахад нь тусалсан. 2012 онд Монгол Улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын гишүүн болсноор Москва, Бээжингийн зүгээс ямар ч бэрхшээл тулгараагүй. “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг байнга ашигладаг тул хоёр хөрштэйгөө буруу ойлголт төрүүлдэг. Эдийн засгийн хувьд Монголыг оруулаад аль ч улс бүх өндгөө нэг сагсанд хийх дургүй. Гэсэн хэдий ч Хятад, Орос улсууд Монголын эдийн засагт асар их нөлөө үзүүлж байна. Жишээлбэл, Ерөнхийлөгч В.Путин “Монгол, Орос, Хятад гурван улсын байгалийн газарзүйн хувьд ойрхон байгаа нь дэд бүтэц, эрчим хүчний салбар, уул уурхайн салбарт урт хугацааны сайн төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг бидэнд олгож байна. Бид хоорондоо ярилцах зүйл байна. Мэдээжийн хэрэг бид байнгын яриа хэлэлцээ эхлүүлэх нь чухал, ашигтай гэж үзэж байна”¹⁶⁴ гэжээ.

Үндсэндээ “гуравдагч хөрш”-ийн бодлого нь динамик боловч Монгол, Хятад, Оросын нөлөөг тэнцвэржүүлэх хүчин чармайлт юм. Үүний тулд Улаанбаатар дахь гадаад бодлого боловсруулагчид дэлхийн өнцөг булан бүрд Монгол, Орос, Хятадад геополитикийн нөлөө ихтэй гол тоглогчдыг хайж олохоор хичээн ажиллаж байна. Ирээдүйн сорилтууд маш их байгаа тул Монголын эрх баригч элитүүдэд хяналт тавих боломж байхгүй байна. Нэг талаар, экс Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн үед байсан Монгол Улс 2014 онд “Орос, Хятад, Монголын гурван талт хамтын ажиллагаа”-ны саналыг дэвшүүлж, Ши даргын дэмжлэг, В.Путины зөвшөөрснөөр гурван талт хамтын ажиллагаанд саад бэрхшээл бага байсан. Нөгөөтэйгөөр, дэлхийн өнцөг булан бүрд томоохон нээлт хийсэн ч Монгол Улс ОХУ-тай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж чадаагүй байна.

¹⁶⁴ *Ibid*,

Ний нуугүй хэлэхэд, байнгын төвийг сахисан гэж зарласан статус бол Монгол Улсын хувьд шинэ санаачилга бөгөөд үүнтэй адил “гуравдагч хөрш” бодлогын бодит ухралт биш харин логик үргэлжлэл болж байгаа юм. Геополитик, хууль эрх зүйн үүднээс авч үзвэл байнгын төвийг сахих нь виртуал хөршүүд рүү шилжиж, хэт давамгайлсан хоёр хөршөө тэнцвэржүүлэх урт хугацааны хүслийг шаарддаг.

Ц.Элбэгдоржийн “байнгын төвийг сахих” санал нь мэтгэлцээнийг төгсгөл, арга хэрэгслээр нь өдөөсөн юм...Хачирхалтай нь, одоо Ерөнхийлөгчөөр сонгогдсон Х.Баттулга “гуравдагч хөрш”-үүдийн бодлогыг сэргээх талаар маргалдав. Гэхдээ тэр чонотой романтик бүжиглэхийг хүсдэг үү, эсвэл олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүний хувьд Монгол Улсын зарчмыг бодитойгоор хүлээн авах уу гэдэг нь асуулт юм. Энэ бол бусдын гэхээсээ илүү Монголын ард түмний сонгосон зам юм”¹⁶⁵ гэжээ.

Харин Тайваний судлаач Лан Мей-Хуа тэмдэглэхдээ: “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын” мөн чанарыг “creative, clever and flexible” гэж үнэлэхийн хамт “Монгол Улс АНУ-ыг “гуравдагч хөрш”-өөрөө сонгохдоо юуны өмнө амь гарах, амиа авч явах (survival) шаардлагыг харгалзсан бөгөөд аюулгүй байдлын асуудал бол өөр хэрэг байсан. Монгол-АНУ-ын харилцаа нааштайгаар хөгжиж байгаа нь Хятад, Оросын нөлөөний хүрээнд Монгол Улс (бүрэн) орохоос сэргийлээд зогсохгүй АНУ болон Өрнөдийн бусад гүрнүүдээс улс төрийн дэмжлэг, цэргийн хамтын ажиллагаа, эдийн засгийн тусламж авч байх замыг нээж өгч байгаа юм. Түүнчлэн, олон улсын тавцанд Монголын эзлэх орон зайг өргөтгөж, түүний статус, нэр нөлөөг өсгөж байна” хэмээн уг бодлогын үүсэл гарал, үр дүнг нягтлан гаргахыг хичээсэн байна. Тэрбээр цааш өгүүлэхдээ: “Гуравдагч хөршүүд”, тухайлбал “АНУ стратегийн үүднээс Монголыг хэрхэн харж байгаа нь нэн тодорхой...АНУ-ын хувьд Монгол нь Хятадыг тогтоон барьж байх стратегийн бааз, Хятад дахь тайван хувьслыг өдөөгч, Хятадын хил хязгаарыг тохьгүй (uneasy) болгож тоглох хөзөр болж чадах юм” хэмээн тодорхойлох оролдлого хийжээ.¹⁶⁶

ОХУ-ын судлаачдын дүн шинжилгээ

ОХУ-д Монгол Улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын судалгаа ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн, Алс Дорнодын судлалын хүрээлэн, Москвагийн ОУХИС, Дипломатын академи, Олон улсын асуудлаарх Оросын Зөвлөл, Санкт-Петербургийн улсын их сургууль, Эрхүүгийн улсын их сургууль, Улаан-Үдийн их сургууль дээр гол төлөв төвлөрч байна.

Монгол Улсын гадаад бодлого, тухайлан “гуравдагч хөрш”-ийн бодлогын асуудлаар проф. В.В.Самойленко, проф. В.В.Грайворонский, дэд эрдэмтэн Е.Бойково, проф. С.Г.Лузянин, проф. А.С.Железняков, др. Ю.В.Кузмин¹⁶⁷ др. В.Родионов, др. А.Г.Дугин зэрэг судлаачдыг нэрлэж болохоор байна.

Монгол дахь АНУ-ын нөлөө нэмэгдэж байгаад таатай хандахгүй байгааг оросын судлаачдынх нь үзэл бодлоос ойлгомжтой харагддаг. Үүнийг ОХУ-ын анхны Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан А.Козыревын (1990-1996 онд Гадаад хэргийн сайдаар

¹⁶⁵ *Ibid*,

¹⁶⁶ Mei-Hua Lan. “The Way of Living of Modern Mongolia”- XX зууны Монгол: Түүх соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. УБ., 2017, 333 дахь тал, Associate professor, National Chengchi University, Taiwan.

¹⁶⁷ Кузьмин Ю.В. Байгалийн улсын их сургуулийн Дэлхийн эдийн засаг, олон улсын бизнесийн тэнхимийн доктор профессор.

ажиллаж байсан бөгөөд түүнийг Өрнөдөд «Mr. “Yes”»¹⁶⁸ хэмээн нэрлэж бичиж байсан юм Д.У) Өрнөдийг чиглэсэн атлантзмын бодлогын уршиг дагавар гэж нэрлэж байсан бөгөөд энэхүү хоосон орон зайд АНУ байр сууриа бэхжүүлж, Монгол дахь анхаарлаа сулруулсны хар гайгаар стратегийн чухал уулын баяжуулах орос-монголын хамтарсан «Эрдэнэт» үйлдвэр болон «МонРосцветмет» нэгдлийн 51 хувь нэг мэдэхэд монголчуудын мэдэлд шилжчихсэн байсан гэх мэтээр бичсэн байдаг. ОХУ-ын сүүлийн үеийн судлаачид Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогыг Өрнөдийн орнуудтай холбоотны харилцаа тогтоох бодлогын илрэл, Оросын эсрэг чиглэсэн бодлогын чиг хандлага хэмээн бичих явдал ажиглагдаж байсан бөгөөд одоо ч иймэрхүү үзэл санаа үе үе цухалздаг.

Монголд 30 гаруй жил ажиллаж, амьдарч, үүнээс 12 жилд дипломат алба хашсан монгол судлаач Ю.Н.Кручкин хэлэхдээ: “Ямар ч “гуравдагч хөрш”-тэй болсон оросууд хардахгүй. Гэхдээ бидний олон жилийн уламжлалт харилцааг зохих түвшинд хадгалах хэрэгтэй байх” Шуудхан хэлэхэд Монголд байгаа бүх ашигт малтмал Орост байгаа. Монголын зарим сэтгүүлчид, иргэд Оросыг харддаг. Үнэндээ Оросыг хардах юм байхгүй. Нөгөөтэйгөө ураныг эс тооцвол Монголын ашигт малтмалд Оросын сонирхол байхгүй гэж хэлж болно”¹⁶⁹ гэсэн юм.

1982-1988, 1996-2000 онд Монгол дахь ЗХУ, дараа нь ОХУ-ын ЭСЯ-нд дипломат алба хашсан, ОХУ-ын ШУА-ийн Дорон дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан монголч эрдэмтэн шинжлэх ухааны др. В.Грайворонский бичихдээ: “Цаг хугацаа өнгөрөхөд “гуравдагч хөрш”-ийн тухай ойлголт тодорхой хувирч, Монгол Улс гэдэг ойлголтыг тодорхой нэг улс биш, бүхэл бүтэн улс гүрэн гэж ойлгож эхэлсэн. Гадаад бодлогын зохицуулалтын тогтолцоог шинэчилснээр Монгол Улсын баримталж эхэлсэн шинэ зарчмууд, тэр дундаа дипломат харилцаа олон талт, нарийн төвөгтэй байдгийг дэлхий дахинд харуулах учиртай байсан. Ийнхүү “гуравдагч хөрш” хэмээх үзэл баримтлал нь нийгмийн бүхий л салбарт Орос, Хятадаас дээд зэргээр тусгаар тогтнох зорилго бүхий олон улсын тавцанд Монголын төрөөс бие даасан бодлого хэрэгжүүлэх хэрэгсэл юм”¹⁷⁰ гэжээ.

Тэрбээр өөр нэгэн өгүүлэлдээ: “Монголын “гуравдагч хөрш”-ийн бодлогод хэд хэдэн чухал аспект байгааг бид ялган харж болох байна. *Нэгдүгээрт*, Орос, Хятадын нөлөөний эсрэг жин дарж тодорхой үйлчилж чадахуйц ямар нэгэн гадны, томоохон бөгөөд нөлөөтэй гуравдагч хүчин, нэг улс ч юмуу, нэг бүлэг улс ч юмуу байх учиртай гэж бүр нэрнээс нь анхлан ойлгогдож байгаа юм. Энэ аспект нь, мэдээж хэрэг Орос болон Хятадын санаа бодлыг тодорхой хэмжээгээр чилээж, сөрдхийлгэхээс өөр аргагүй. Ялангуяа ОХУ-ын хувьд...”¹⁷¹ гээд эдийн засгийн хөгжлийн ач холбогдлыг нь онцолсон байдаг.

Доктор В.Грайворонский тэмдэглэхдээ: “Монголын томоохон гадаад түншүүдийн хүрээ нэлээд өргөжиж, Монголын гадаад бодлогын стратеги нь олон вектор (олон тулгуур) зарчимд суурилж эхэлсэн. Энэхүү стратегийн мөн чанар нь дэлхийн улс төрийн тэргүүлэх

¹⁶⁸ Өрнөд ЗХУ-ын ГЯЯ-ны сайдаар тасралтгүй 25 жил ажиллаж байсан А.А.Громыког «Mr. “No”» гэж нэрлэдэг байсан юм.

¹⁶⁹ Кручкин Ю.Н. *Ураныг эс тооцвол Оросын сонирхол байхгүй*. 2010.07.05 <https://news.mn/r/19153/>

¹⁷⁰ Грайворонский В. В. Концепция внешней политики Монголии // Проблемы Дальнего Востока. 2012. № 2. стр. 56–69

¹⁷¹ Грайворонский В.В. *“Концепция внешней политики Монголии в действии: отношения с Россией, КНР, США и Японией”*-XX зууны Монгол: Түүх соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. УБ., 2017, 231 дэх тал

хүчний бүх төвүүдтэй найрсаг түншлэлийн харилцаа тогтооход оршдог. Үүний үр дүнд Монголыг тойрон нэг төрлийн геополитикийн “гурвалжин” үүсч, түүний булангуудыг газарзүйн хөршүүд болох Орос, Хятад, мөн “гуравдагч хөрш” гэгддэг бүс нутгийн бус тоглогчид тус улсад өөрийн гэсэн ашиг сонирхол бий болгосон. Эдгээрт юуны түрүүнд АНУ, Япон, БНСУ, ЕХ-ны орнууд, Энэтхэг, Турк орно. “Бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд Зүүн хойд Азийн орнуудын шинжээчдийн хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтыг нэгтгэх зорилготой “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г 2014 оноос эхлэн төрийн тэргүүний ивээл дор жил бүр Монгол Улсын нийслэлд зохион байгуулж байна. Өөр нэг жишээ бол БНАСАУ-АНУ-ын яриа хэлэлцээний дараагийн шатыг Улаанбаатарт хийх талаар Монголын тал саяхан санаачилсан явдал юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс өөрийгөө олон улсын хэлэлцээний индэр хэмээн байр сууриа илэрхийлж, “Азийн Швейцарь” болж, улмаар дэлхийн улс төрд өөрийн жинг нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна” гэсэн юм.¹⁷²

ОХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын судлалын хүрээлэнгийн Зүүн хойд Ази, ШХАБ-ын Стратегийн судалгааны төвийн удирдагч шинжлэх ухааны др.проф. монгол судлаач Сергей Г. Лузянины <https://lenta.ru/> хэмээх цахим сайтад өгсөн түүний ярилцлагаас эш татмаар байна.¹⁷³ Тэрбээр хэлэхдээ: Монголын ардчилсан хувьсгалын дараа (1990-1991) тус улс гадаад эдийн засгийн харилцаагаа эрчимтэй хөгжүүлж, дэлхийн санхүүгийн байгууллагууд болох ОУВС, ДХБ, Азийн хөгжлийн банк зэрэгт нэгдсэн. Тийнхүү Улаанбаатар Орос, Хятад гэсэн уламжлалт түншүүдээс гадна өөртөө АНУ, Өрнөд болон, Япон, Өмнөд Солонгос гэсэн шинэ түншүүдийг бий болгосон. Үүнийг Монголд “гуравдагч хөрш” гэж нэрлэдэг. Өрнөдийн болон олон улсын тусламжийг Улаанбаатар бараг шинэ либерал эдийн засгийг бий болгоход нэлээд чадварлаг ашигласан. Тэнцвэртэй бодлогын үзэл баримтлал дипломат салбарт ч идэвхтэй хэрэгжсэн. Үүний нэг жишээ нь Улаанбаатар болон ЕАБХАБ-ын хоорондын харилцааг ойртуулж байна. Монгол Улс байнгын гишүүнчлэлийн статусаа дээшлүүлэхийн өмнө ЕАБХАБ-ын түнш, ажиглагч орон байсан. Улаанбаатарын хувьд ЕАБХАБ-д элссэн нь Монгол Улс ОХУ болон АНУ, ЕХ-той эрх тэгш хамтын ажиллагааг хөгжүүлэх бас нэгэн боломжийг нээж өгч байгаатай холбон тайлбарлаж байна. Ардчиллын институцийг бэхжүүлэх, улс орны хууль сахиулах тогтолцоонд европ стандартыг нэвтрүүлэх гэсэн Монголын удирдлагын хүсэл эрмэлзэл ч тодорхой үүрэг гүйцэтгэсэн. Гэсэн хэдий ч тэргүүлэх сэдэл нь тус улсын гадаад бодлогод шинэ дэмжлэг олох зорилготой байсан бөгөөд ЕАБХАБ энэ тохиолдолд “гуравдагч хөрш”-ийн үүрэг гүйцэтгэж байна гэжээ. *“Гуравдагч хөри” Монголын эдийн засагт хэр увдистай хөрөнгө оруулалт хийсэн бэ?* гэсэн асуултад проф. С.Г.Лузянин хариулахдаа: АНУ, ЕХ, Япон, БНСУ-аас Монгол Улсад 1.3 тэрбум ам.долларын буцалтгүй тусламж үзүүлсэн. Тус улс нэг тэрбум гаруй ам. долларын хөнгөлөлттэй зээл авсан. Одоогоор томоохон хөрөнгө оруулалт байхгүй байна. Түүгээр ч барахгүй энэ нь монголчуудын өөрсдийнх нь шийдвэрээр болсон байх, албан тушаалтнуудаа эх орноо худалдсан гэж олон удаа буруутгаж, гадаадын компаниудын ажлыг хүндрүүлсэн хууль тогтоомжийг баталсан. Мөн Хятадын бизнесменүүдтэй, тухайлбал нүүрсний салбарт маргаантай байсан. Хятадууд гоморхсондоо Монголын нүүрснээс нэг ч шуудай авахгүй гэдгээ ч зарлаж байсан гэжээ. *АНУ Монголыг их*

¹⁷² Грайвороновский В.В. Монголия стремится стать «Азиатской Швейцарией» 1 октября 2019 <https://russiancouncil.ru/analytics-and-comments/analytics/mongoliya-stremitsya-stat-aziatskoy-shveytsariey/>

¹⁷³ Лузянин С.Г. «Монгольская сторона не всегда выполняла свои обязательства» Эксперт рассказал «Ленте.ру» о взаимоотношениях в треугольнике Россия — КНР — Монголия <https://lenta.ru/articles/2014/08/28/mongolia/>

сонирхож байна. Бээжин үүнд атаархаж байгаа байх? гэсэн асуултад тэрбээр хариулахдаа: 1990-ээд онд “гуравдагч хөрш”-ийн онолын давалгаан дээр бий болсон Америкийг дэмжигч “эвсэл”-ээс Монгол Улсыг Хятад хөршөөс нь салгах гэсэн бодлого идэвхэжсэн геополитикийн тал тод харагддаг. “Талын бүгд найрамдах улс” хорин жилийн турш Америкийн идэвхтэй бодлогын объект, тэр дундаа цэрэг-улс төрийн хүрээний объект болжээ. Монголчууд АНУ-ын бүх “хүмүүнлэгийн” гэж нэрлэсэн цэргийн ажиллагаанд ч гэсэн оролцдог. Монгол-Америкийн хамтарсан *Khaan Quest* сургуулилт жил бүр болдог. Үүний зэрэгцээ Монголын удирдлага намуудын чиг хандлагаас үл хамааран өөрийн нутаг дэвсгэрт цэргийн баазын сүлжээ байгуулах Вашингтоны саналыг няцааж байгаа нь үнэн. Энэ нь “АНУ Ази руу буцах” үйл явцад бодитой саад учруулж буй төслүүдэд Улаанбаатарыг татан оролцуулах боломжгүй байна гэсэн үг. Монгол Улс БНХАУ, ОХУ-ын ШХАБ-д ажиглагчаар оролцож байгаа нь тогтвортой байдал, бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх нэмэлт эх үүсвэр болж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “ШХАБ-аас манай байгууллагын оролцооны түвшинг дээшлүүлэх саналыг хүндэтгэж байна” гэж тэмдэглэсэн. Ийм мэдэгдлийг Москвад ч, Бээжинд ч таатай хүлээж авах нь ойлгомжтой. Мөн Улаанбаатар хот Хятадын “Их торгоны замын эдийн засгийн бүслүүр” төсөлд нэгдэх хүсэл эрмэлзлэлээс бүсчлэх хандлага ажиглагдсан. Шанхайд болох АПЕК-ийн чуулга уулзалтад (2014 оны 11 дүгээр сард Д.У) монголчуудыг зочны статустай урьж, Монгол Улсыг тус форумд байнгын гишүүнээр элсүүлэхээр лоббидох амлалт өгсөн нь Бээжингийн еелдэг байдал юм. Дашрамд дурдахад, Владивосток дахь АПЕК-ийн дээд түвшний уулзалтын өмнөхөн ОХУ ч мөн адил монголчуудыг орж ирэхэд нь дэмжлэг үзүүлнэ гэж амлаж, тэднийг урамшуулж байсан. Гэвч энэ асуудал дипломат аргаар шийдэгдээгүй”¹⁷⁴ гэсэн юм.

ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн тэргүүлэх судлаач, Олон улсын асуудлаарх Оросын Зөвлөлийн (РСМД) шинжээч улс төрийн шинжлэх ухааны доктор Александр С.Железняков бичихдээ: “Газарзүйн болон геополитикийн аварга хөршүүд болох Орос, Хятад хоёрын дунд “хашигдсан” Монгол Улс стратегийн ашиг сонирхлынхоо огтлолцсон тойрог замуудын “ороомог”-оос гарах гарцыг олсон. Мөнх хөх тэнгэрийн орон “гуравдагч хөрш”-ийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр улс төр, эдийн засгийн бие даасан чиг хандлагаа хэрэгжүүлэхэд нүдэнд харагдахуйц ахиц дэвшил гаргасан. “Гуравдагч хөрш” гэдэг нь Монгол Улс улс төр, худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээ Орос, Хятад хоёрын эсрэг тэнцвэртэй байдлыг бий болгох тэргүүлэх чиглэл гэж тодорхойлсон АНУ тэргүүтэй хамтын нийгэмлэгийн ерөнхий нэр юм”¹⁷⁵ гэжээ. Тэрбээр өгүүлэхдээ: “Соёл иргэншлийн хувьд ойр, холын бүх орчноосоо эрс ялгарч, бие даасан бодлого явуулахыг эрмэлздэг Монгол Улс чухамдаа “гуравдагч хамтын хөрш”, тэр дундаа АНУ болон уламжлалт хөршүүд болох Орос, Хятад болон бусад томоохон улс орнуудтай хамтран ажилладаг нэг төрлийн «гурвалжин»-ын гол цөм болжээ. Бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ байгууллагыг бий болгох орон зайн контур тодорхой гарч ирж байгаа бөгөөд энэ нь дэлхийн улс төрийн хөгжлийн чухал сэдэв болох ноцтой боломж юм. Оролцогч орнуудын тууштай хөгжиж буй харилцан үйл ажиллагаа нь Евразийн төв дэх улс

¹⁷⁴ Там же,

¹⁷⁵ А.С.Железняков. Монгольская цивилизация: История и современность. М.: 2016, стр. 265

төрийн гол түншүүдийн үйл ажиллагаа, санаа зорилгын ил тод байдлыг хангах механизмыг аажмаар хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой”¹⁷⁶ гэсэн байна.

ОХУ-ын Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн судалгаа, таамаглалын төвийн (АНО) Ерөнхийлөгч, РСМД-ын шинжээч Сергей Ф.Санакоев CCTV “News-World Insight” нэвтрүүлэгт оролцож байр сууриа илэрхийлэхдээ: “ОХУ бол БНХАУ, Монгол Улс хоёрын харилцаан дахь чухал хүчин зүйл мөн. Монгол Улс бол өвөрмөц байршилтай орон, өмнө зүгт Хятад, умард зүгт Орос хэмээх хоёр л хөрштэй гэдгийг бид мэднэ. Одоо Монгол Улсын хувьд бүс нутгийн хөгжил юу юунаас илүү чухал, “гуравдагч хөрш”-өөс ч илүү чухал байгаа. Миний ойлгож байгаагаар энэ удаагийн айлчлалын үеэр (Бээжинд 2015 оны 11 дүгээр сард хийсэн ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн айлчлалыг хэлж байна. Д.У) болсон хамгийн чухал уулзалт нь Монгол Улс Хятад Улстай иж бүрэн стратегийн түншлэл байгуулах, эсвэл Америкийн Номхон далайн чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээрт нэгдэн орох эсэх талаар хийсэн уулзалт байлаа. Орос, Хятад хоёр энэ асуудлаар өөрсдийн байр суурьтай байгаа ба бүс нутгийн хөгжлийн түншлэлд нэгдэн орох нь Номхон далайн цаад эрэг дээр байгаа оронтой хэлэлцээрт нэгдэн орсноос дээр гэж үзэж байгаа юм.”¹⁷⁷ гэжээ. Энэ нэвтрүүлэгт оролцсон БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн ухааны академийн Глобал стратегийн үндэсний хүрээлэнгийн шинжээч Ей Хайпенг (Ye Haipeng) Аливаа улс олон улсын тавцанд нөлөө бүхий байр суурьтай байхыг эрмэлздэг тул Монголын хоёр хөрш Монгол Улсыг өөрийн хилээр давуулан бусад оронтой харилцахыг таатай хүлээн авна гэсэн үг биш”¹⁷⁸ гэсэн байна.

1994 оны Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улс монгол угсаатны төв болох санаа тусгасан байсныг хоёр хөршийн судлаачид улс орныг нь хагалган бутаргах үзэл санаа агуулсан байна гэж шүүмжлэн бичиж байсан юм.¹⁷⁹

1996 оны 1 дүгээр сарын 9-нд ОХУ-ын Гадаад хэргийн сайдад шинээр томилогдсон Евгений М.Примаков¹⁸⁰ атлантизмыг баримталсан Андрей В.Козыревын¹⁸¹ гадаад бодлогын нэг талыг барьсан чиг шугамыг өөрчилж, олон тулгуурт гадаад бодлогын шинэ зарчмыг тунхаглаж, ОХУ, Хятад, Энэтхэгтэй хамтын ажиллагааг бэхжүүлэхийн чухлыг онцолж, энэ нь өнөөгийн ШХАБ, БРИКС-ийн үндэс суурь болов. Үүнийг л «Примаковын номлол» хэмээн нэрлэж байгаа юм гэж ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров тэмдэглэсэн юм.¹⁸² Е.М.Примаковыг Гадаад хэргийн сайдаар ажиллаж байх цаг дор дээрх Тунхаглалд Орос, Хятадын удирдагчид Б.Ельцин, Зян Зэминь нар гарын үсэг зурсан билээ.

¹⁷⁶ Там же,

¹⁷⁷ CCTV News - World Insight. November 10, 2015 <http://cctv.cntv.cn/lm/worldinsight/video/index.shtml>

¹⁷⁸ Ibid,

¹⁷⁹ Зарубежные соседи: панмонголизм возвращается. Дата обращения: 23 мая 2011. Родионов В. *Национальная безопасность Монголии в контексте отношений с Россией*-Журнал “Власть” Институт Социологии РАН. 2013 №02 стр. 137-140

¹⁸⁰ Е.М.Примаков 1996-1998 онд ОХУ-ын Гадаад хэргийн сайд, 1998-1999 онд ОХУ-ын Засгийн газрын тэргүүн, 1991-1996 онд ОХУ-ын Гадаад тагнуулын албаны захирал, 1989-1990 онд ЗХУК-ын ТХ-ны УТТ-ны орлогч гишүүн, ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Холбооны Зөвлөлийн дарга, 1985-1990 онд ШУА-ийн Дэлхийн эдийн засаг, олон улсын харилцааны хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан, академич.

¹⁸¹ А.В.Козырев 1990-1996 он хүртэл ОХУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан.

¹⁸² Интервью Министра иностранных дел С. В. Лаврова телекомпании ВГТРК в связи с юбилеем Е. М. Примакова, Москва, 28 октября 2014 года

Харин Орос, Хятад “гуравдагч хөрш” гүрнүүдээс Монгол Улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт, тухайлбал, Британи, Австрали, Канадын хамтарсан “Оюутолгой” мега төсөлд сөрөг байр суурьтай хандаж байгаагүйг тэмдэглэх хэрэгтэй.

2009-2013 онд ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байсан, Москвагийн ОУХИС-ийн Дипломат ажиллагааны тэнхимийн профессор агсан, түүхийн ухааны доктор В.В.Самойленкогийн 2015 оны 11 дүгээр сарын 12-нд «Төвийг сахих нь: Тулгамдсан шаардлага уу, өнгөрсөн үеийн үлдэц үү»¹⁸³ нэртэй тун сонирхолтой өгүүлэл тус сургуулийн цахим хуудасны тусгай дугаарт нийтлэгдсэн юм. Тэрбээр бичихдээ: “...Орос, Хятадын дунд орших Монгол Улс гэнэт байнга төвийг сахих статустай болох талаар саяхнаас ярьж эхэллээ. Түүгээр ч барахгүй Монголын парламент буюу УИХ-аар холбогдох хуулийн төслийг хэлэлцэж эхлэв. Үүнийг юу гэж ойлгох вэ? шинэ чиг хандлага уу, «хуучин сэтгэлгээ»-ний ул мөр үү, эсвэл дотоод улс төрийн бодлогын тулгалтаас үүдэн гарсан хувийн чанартай учиг шалтгаан уу? «Байнга төвийг сахих» гэдэг нь, өөрөөр хэлбэл зөвхөн дайны нөхцөл байдалд төдийгүй мөн энхтайван цагт ч төвийг сахихыг хэлэх бөгөөд тус улс өөр дээрээ дараалсан багц үүрэг авахыг хүлээн зөвшөөрсөн байх ёстой байдаг...гадна, төвийг сахих бодлого баримтлахаар шийдсэн улс бие даасан хөгжил, эдийн засгийн бие даасан байдал болон батлан хамгаалах өөрийн чадавхтай, тогтвортой санхүүгийн тогтолцоо, хангалттай хөгжсөн эдийн засагтай байх ёстой. Өөрөөр хэлбэл, төвийг сахисан улс нь гадаадын санхүүгийн болон эдийн засгийн тусламж дэмжлэг, гадны цэргийн болон зэвсэг техникийн нийлүүлэлтээс хамааралгүй байх ёстой юм...Тиймээс тал нутгийн бүгд найрамдах улсын “байнга төвийг сахих” санаачилга нь Ази дахь хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлагаас гажсан байгаа нь гэнэт гарч ирсэн зүйл мэт харагдаж байна. Үүнтэй холбоотой тодорхой асуултууд гарч ирж байгаа ба үүнд хариулт олбол сайн байхсан. Тухайлбал, дэлхийн болон бүс нутагт юу өөрчлөгдөж, Монголд нэн таатай стратегийн тогтвортой байдлыг хангаж байгаа Ази дахь интеграцийн үйл явц яагаад эргэлзээ төрүүлэв? Улаанбаатар ямар шинэ аюул, дуудлага харав, хэн хэний хооронд төвийг сахин хамгаалах гэж байгаа юм бэ? Хоёр хөрштэйгөө итгэлцлийн түвшнийг буруулах тухай яриа биш л болов уу. Эсвэл магад, төвийг сахих нь «гуравдагч хөрш»-ийн бодлогын шаардлага, үр ашиг байхгүйн нотолгоо юу? Ерөнхийдөө, багагүй асуултууд гарч байна. Одоогоор хариултууд олдохгүй байна. Үүнтэй холбоотойгоор, Монгол Улсын төвийг сахих бодлого гаргах санаачилга нь гадаад бодлоготой холбоотой тодорхой зорилтуудыг шийдвэрлэх бус харин илүү өөрийн улс руу олон улсын хамтын нийгэмлэгийн анхаарлыг татах гэсэн түүний удирдлагын хүсэлтэй илүү холбоотой болов уу. Эдийн засгийн хүндрэлтэй байдал, нийгэм дэх шүүмжлэлтэй хандлага, дотоод улс төрийн хурц зөрчлийн улмаас Улаанбаатар эдгээр асуудлаас гарахын тулд идэвхтэй гадаад бодлогоо золиосолж байна. Улаанбаатарын найдвар нь төвийг сахих статустай болж гэмээнэ, Монгол Улс идэвхтэй гадаад бодлого явуулж буй мэт харагдсанаар анхаарлыг өөрлүүгээ татаж, олон улсын бодлого, дипломат үйл ажиллагааны төв болох, чуулган, бага хурал, яриа хэлэлцээний «Азийн Швейцарь» лугаа аятайхан газар болно хэмээн тооцоолж байна. Энэхүү тооцоогоор дурдсан статус нь тус улсад асар том гадаадын хөрөнгө оруулалтыг

¹⁸³ В.В. Самойленко. Нейтралитет: актуальная потребность или рудимент прошлого? 12.11.15
Эксклюзив. Эксперты МГИМО: Самойленко В.В. «Төвийг сахих нь: Тулгамдсан шаардлага уу, өнгөрсөн үеийн үлдэц үү» (орчуулсан проф. Д.Уламбаяр) Зууны Мэдээ сонин №30 (5216) 2016.02.16

татах, Монгол Улсын хурдацтай хөгжин цэцэглэх зам мөрийг нээх гэнэ»¹⁸⁴ гэсэн байна. Энэ бол бидний анхаарах асуудал байсан юм.

Дүгнэлт

Монгол Улсын гадаад бодлогын судалгаа Хятадын Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн ухааны академи, ХКН-ын хятад, англи хэлээр гардаг өдөр тутмын төв хэвлэл *Global Times* сонин, БНХАУ-ын Бээжингийн Ардын их сургуулийн Олон улс судлалын сургууль, Бээжингийн Гадаад судлалын их сургууль, ӨМӨЗО-ын Нийгмийн ухааны академийн Орос, Монгол судлалын хүрээлэн, Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын салбар, Өвөр Монголын Багшийн их сургууль, Шанхайн Хуадун их сургуулийн Ойр орчны орнуудын судлалын хүрээлэн зэрэгт төвлөрч буйг онцлон дурдах хэрэгтэй.

Тэгвэл ОХУ-ын тухайд ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн, Алс Дорнодын судлалын хүрээлэн, Москвагийн ОУХИС, Дипломатын академи, Олон улсын асуудлаарх Оросын Зөвлөл, Санкт-Петербургийн их сургууль, Эрхүүгийн их сургууль, Улаан-Үдийн их сургууль дээр гол төлөв төвлөрч байна.

Хятадын албан ёсны төв хэвлэлүүдэд Монгол Улсыг “жинхэнэ хөрш”-үүдтэйгээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийн чухлыг “зөвлөх” зарим тохиолдолд “сургах” шинж чанар ажиглагдаж байна. Тухайлбал, Монгол Улсын геополитикийн байрлал нь Хятад, Оростой ухаалгаар хамтарч ажиллах ёстойг харуулдаг. Монгол Улс сүүлийн жилүүдэд “гуравдагч хөрш”-үүддээ ашиглуулж”, үр дүнд нь баян, хоосны ялгаа гүнзгийрч, бусдаас эдийн засгийн хамааралтай болж, доройтож байгааг өгүүлдэг. Монголын улс төрчид “хөршөө солих” мөрөөдлөөсөө салж, байгалийн хөршүүдтэйгээ хэрхэн ухаалаг замаар хамтран ажиллах талаар бодох хэрэгтэй. Монгол Улс геостратегийн байршлын улмаас хүйтэн дайны дараа АНУ нь Монголтой харилцаагаа гүнзгийрүүлж ирсэн ч, Монгол Улсын АНУ-тай хөгжүүлж буй “гуравдагч хөрш”-ийн харилцаа нь Орос, Хятадыг давах боломж хомс хэмээн “сургадаг”.

Хятадын судлаачид Монгол Улсыг худалдаа-эдийн засгийн талаар Хятад руу хэлбийсэн байдаг бол, хөрөнгө оруулалт, шинэ техник, технологийн салбарт Япон, Канад, улс төрийн талаар АНУ-ын талыг баримталсан, цэрэг, батлан хамгаалах салбарт ОХУ-ыг түшиглэсэн шинжтэй байдаг. АНУ, Япон, Энэтхэг улстай «гуравдагч хөрш»-ийн хүрээнд стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоож байгаа нь **Хятадыг гурван талаас нь бүслэн хаах бодлогын тод илрэл** юм тэмдэглэсэн байдаг. Хятадын судлаачид ингэж үздэг нь түүхэн үндэстэй холбосон байдаг. 1980-аад оны туршид олон үе шаттай явагдсан Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр харилцааг сайжруулахад тээг болж байсан «гурван харш саад»-ыг арилгах болзлыг Хятадын талаас байнга тавьж байсан нь “ямар ч тохиолдолд аливаа улсын батлан хамгаалах хүчин гагцхүү өөрийн улсын хилийн дотор байрлах ёстой” гэдэгт үндэслэж байв. «Гурван харш саад»-ыг арилгах гэдэг нь нэгд. Монголоос зөвлөлтийн цэргийг гаргах, хоёрт, Кампучиас Зөвлөлтийн дэмжлэгтэй вьетнамын цэргийг гаргах, гуравт, Афганистанаас зөвлөлтийн цэргийг гаргах, эдгээр асуудлыг шийдвэрлэсэн тухайд л харилцааг хэвийн болгох боломжтойд оршиж байв.

¹⁸⁴ В.В. Самойленко. Нейтралитет: актуальная потребность или рудимент прошлого? 12.11.15
Эксклюзив. Эксперты МГИМО: Самойленко В.В. «Төвийг сахих нь: Тулгамдсан шаардлага уу, өнгөрсөн үеийн үлдэгч үү» (орчуулсан проф. Д.Уламбаяр) *Зууны Мэдээ* сонин №30 (5216) 2016.02.16

Тиймээс Бээжингийн удирдагчид *«гурван харш саад» гэдэг нь Хятадыг гурван талаас нь бүсэлсэн байдлыг хэлж буй юм* гэж Зөвлөлтийн талд тов тодорхой ойлгуулж байсан юм.

ОХУ-ын судлаачид Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь утоп буюу үйл гүйцэлдэх үзэл бодол хэмээн бичиж зарчимдаа “тавласан” шинж байдал ажиглагддаг. Сүүлийн үед хоёр хөрш болон “гуравдагч хөрш”-үүдийн хоорондын геополитикийн зөрчилдөөн гүнзгийрч буй нь хөрш орнуудын шүүмжлэл 1-р сувгийн түвшнээс 1.5-р сувгийн түвшинд шилжих төлөвтэй байгаа нь анхаарах асуудал мөн.

Монгол Улс 1990 онд нийт хүн төрөлхтний хамтын үнэт зүйлс болох хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг дээдлэх, зах зээлийн эдийн засгийг тууштай баримтлах сонголтоо эргэлт буцалтгүй хийсэн. 1990-ээд оны эхнээс Монгол Улсын гадаад бодлогод *«гуравдагч хөрш»*, *«гуравдагч хөрш»*-ийн бодлогын үзэл санаа буй болж, эдүгээ тухайлсан төрийн бодлого хийгээд онол-практикийн түвшний судалгааны шинэ чиглэл болов. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын утга чанар нь *нэгд, хөгжингүй, хоёрт*, ардчилсан орнуудтай хоёр болон олон талт түншлэлийг харилцааг бүх салбарт хөгжүүлэх явдал гэж Үндэсний аюулгүй байдал болон Гадаад бодлогын үзэл баримтлалд маш тодорхой тусгасан байдаг. Монгол Улсын *«гуравдагч хөрш»*-ийн бодлогын эрхэм зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах гадаад таатай нөхцлийг хангах, гадаад харилцаанд нээгдэж буй асар их боломжийг дээд зэргээр ашиглах үндсэн дээр үндэсний хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлэх, нийт хүн төрөлхтний хамтын үнэт зүйлсээс хуваалцах, олон улсын тавцанд Монгол Улсын байр суурь, нэр хүндийг бэхжүүлэх явдалд оршино. *Монгол Улсад нэгдүгээр хөрш гэж байхгүй, харин хоёр хөрш, «гуравдагч хөрш», бусад улс орнууд гэж буй.*

Монгол Улсын *«гуравдагч хөрш»*-ийн бодлого нь тус улс үндэсний язгуур эрх ашгийг дээдлэсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт хийгээд олон хэмжээст, нээлттэй, эвсэлд үл нэгдсэн, бие даасан гадаад бодлого явуулж буйн тод илрэл бөгөөд дурдсан бодлого нь цэргийн эвсэл, холбоотны бодлого биш, хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого ч биш, мөн зөвхөн энхтайван цагийн геополитик гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Идэвхтэй, олон хэмжээст гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл болдог.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангах бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

«Гуравдагч хөрш»-ийн бодлогын амжилттай хэрэгжих үндэс нь Монгол Улсын хоёр хөрштэй харилцах харилцаа ба «гуравдагч хөрш»-ын харилцаа, хамтын ажиллагааны зохист тэнцвэр хангагдсан байдал эсвэл хангагдахуйц нөхцөл бүрдсэн байдал гэж хэлж болох юм.

Монгол Улс “идэвхтэй гадаад бодлого явуулснаар бүс нутгийн төдийгүй дэлхийн энхтайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, тогтвортой хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлэх учиртай.

Монгол Улсын үндэсний эрх ашгийг хөндөөгүй хоёр хөрш хийгээд “гуравдагч хөрш”-үүдийн хоорондын геополитикийн сөргөлдөөнд Монгол Улс оролцохгүй. Их гүрнүүдийн аливаа геополитикийн сөргөлдөөнт хэрэг явдалд Монгол Улс голч, төвч байр суурь илэрхийлж буйг “төвийг сахих олон улсын эрхзүйн статус”-тэй хольж хутгаж үл болно.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь монголчуудын эртнээс инагш ахуй амьдрал, ажил үйлдээ баримталсаар ирсэн **“тулгын гурван чулуу”** хэмээх үзэл баримтлал бөгөөд орчин үеийн гурван тулгуурт хөгжлийн онолын баримтлал болно. Өөрөөр хэлбэл **«тогоо хоёроос дээш хөлтэй байж гэмээнэ сая бат тогтвортой байдаг»** хэмээх монголчуудын уламжлалт зарчим ажгуу.

Түүнчлэн «гуравдагч хөрш»-ийн бодлого нь *зөөлөн тэнцвэржүүлэх* (soft balancing) хийгээд *зөөлөн хүчний бодлого* бөгөөд онолын баримтлал нь *ухаалаг тэнцвэрын хүчин* (power of smart balance)-д суурилсан *ашиг сонирхлын тэнцвэр* (balance of interests) юм.

Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших чиг хандлага ажиглагдаж буй үе шатанд хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах, гурвалсан хөршийн хамтын ажиллагаа, «гуравдагч хөрш»-ийн бодлогын хооронд эрх ашгийн тэнцвэрийг зохист түвшинд барих үндсэн дээр ухаалаг тэнцвэрийн хүчийг олох явдал Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагаанд шинээр тавигдаж буй асуудал гэж хэлж болохоор байна.

Нөгөө талд өнөөгийн шатанд Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хамгийн том сорилт нь хоёр хөрш, “гуравдагч хөрш” гүрнүүдийн хоорондын геополитик, гео-эдийн засгийн сөргөлдөөн болж байна.

Бусад улс гүрнүүдийн санаачлан хэрэгжүүлж байсан гадаад бодлогыг харахад эхлэл, үйл явц, төгсгөл гэсэн үе шатуудыг дамжсан байдаг. Монгол Улсын хувьд «гуравдагч хөрш»-бодлогыг хэрэгжүүлээд, үр дүнг нь нэгтгэн дүгнээд “хавтаст хэрэг”-ийг нь хаах нь нэн учир дутагдалтай. Монгол Улс хоёр хөрштэйгээ мөнхөд хаяа дэрлэн орших нь тодорхой. Хоёр хөршийн дотоодод хүний эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдөж, чөлөөт хэвлэл хумигдаж, эрх мэдэл нэг хүний гарт төвлөрөх үйл явц улам бүр лавширч, гадаад бодлогын салбарт “хүчээр түрээ барих” чиглэлд илэрхий шилжиж байгаа нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь урт удаан хугацаанд тогтвортой баримтлах стратегийн зорилт байх төлөвтэй байгаа тул залгамж шинжтэй байх ёстой.

Монгол Улс геополитик, гео-эдийн засгийн орчинд далайд гарцгүй ч (*land-locked*) холболтын байршилтай (*land-linked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн ч (*nuclear-locked*), нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей түүнд хоёр жил тутамд үнэлгээ хийж тогтоолын төсөл баталдаг, Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүнээс улс төрийн баталгаа гаргасан, нөгөө талд хоёр их гүрний дунд хашигдсан ч (*power-locked*) монгол угсаатнаар хүрээлэгдсэн (*mongol ethno-locked*) онцлогтой хийгээд хоёр хөрштэйгээ “иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцааны эрхзүйн үндсийг баттай тавьж, Зүүн хойд Ази болон Төв Азид газар нутаг, улс төрийн аливаа маргаангүй цорын ганц улс байгаа нь аюулгүй байдлын маш чухал ололт мөн.

НОМЗҮЙ

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011
3. Д.Уламбаяр. “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн онол-практикийн асуудалд”- Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлогын тухай судалгаа” онол-практикийн асуудлуудаарх хэлэлцүүлэг. МУИС, ОУХНУС, 2020.04.15
4. Д.Уламбаяр. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: Хоёр болон олон талт хамтын ажиллагаа. Дэд боть. УБ., 2022

5. М.Хурбетхан. Монгол Улс, АНУ-ын Иж бүрэн түншлэлийн эхэн. УБ., 2007, 72-73 дахь тал
6. “Ерөнхийлөгчийн тангараг өргөж Халтмаагийн Баттулгын ард түмэндээ хандаж хэлсэн үг” 2017.07.10 <https://president.mn/2228/>
7. 11th ASEM Summit “20 Year of ASEM5 Partnership for the Future through Connectivity”. CHAIR’S STATEMENT. Brussels, 5 July 2016 10689/16 p. 21 Draft
8. АСЕМ-ын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалт. “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоогоор өртөөлөн ирээдүйн түншлэлийн төлөө” УБ.: 2016, 9 дэх тал
9. The Think Tank Index, *Foreign Policy*, archived from the original on 2009-01-19
10. *Chinese Academy of Social Sciences*, archived from the original on 2012-07-22
11. “组织机构”. *cass.cssn.cn*. Retrieved 2020-11-26
12. Faligot, Roger (2019). *Chinese Spies: From Chairman Mao to Xi Jinping*. Oxford University Press. p. 280
13. На Лин. “Mongolia’s Permanent Neutrality” Policy and Its Influence on China”- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор “Тогтвортой хөгжил ба Монгол судлал” сэдэвт олон улсын монголч эрдэмтдийн их хурал. Илтгэлийн товчлолууд. УБ.: 2016, Э.Наран. *Монгол Улсын “байнга тавийг сахих” бодлого хийгээд түүний Хятад Улсад үзүүлэх нөлөө*”-*Рах Mongolica* сэтгүүл, ШУА, ОУХХ, Vol. 2 2016 №3 (4) 106-115 дахь тал
14. На Лин. “Монгол Улсын гадаад харилцаа ба ШХАБ-тай харилцах харилцаа”. ШУА, ОУСХ *Олон улс судлал* сэтгүүл. №1, 2015, 110-120 дахь тал
15. Л.Түмэнцэцэг, Ш.Амжилт. “Монгол Улсын “Байнга төвийг сахих” бодлого, түүний Хятад, Монголын харилцаанд үзүүлэх нөлөөг товч өгүүлэх нь”-*Олон улсын харилцаа* сэтгүүл. МУИС, ОУХНУС, 2016 №1/32 (458) 7-13 дахь тал
16. Mei-Hua Lan. “The Way of Living of Modern Mongolia”- XX зууны Монгол: Түүх соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. УБ., 2017, 333 дахь тал,
17. Кручкин Ю.Н. *Ураныг эс тооцвол Оросын сонирхол байхгүй*. 2010.07.05 <https://news.mn/r/19153/>
18. Грайворонский В. В. Концепция внешней политики Монголии // Проблемы Дальнего Востока. 2012. № 2. стр. 56–69
19. Грайворонский В.В. “Концепция внешней политики Монголии в действии: отношения с Россией, КНР, США и Японией”-XX зууны Монгол: Түүх соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. УБ., 2017, 231 дэх тал
20. Грайвороновский В.В. Монголия стремится стать «Азиатской Швейцарией» 1 октября 2019. <https://russiancouncil.ru/analytics-and-comments/analytics/mongoliya-stremitsya-stat-aziatskoy-shveytsariy/>
21. Лузянин С.Г. «Монгольская сторона не всегда выполняла свои обязательства» Эксперт рассказал «Ленте.ру» о взаимоотношениях в треугольнике Россия — КНР — Монголия

<https://lenta.ru/articles/2014/08/28/mongolia/>

22. А.С.Железняков. Монгольская цивилизация: История и современность. М.: 2016, стр. 265
23. Родионов В.А. «Политический процесс в современной Монголии в контексте пост-социалистических трансформаций». Диссертация на соискание ученой степени доктора политических наук. Дипломатическая академия МИД РФ. М.: 2018, стр. 249-251
24. В.Родионов. “Третий сосед” Монголии: фактор идеологии”- XX зууны Монгол: Түүх соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. УБ., 2017, стр. 305-310
25. Зарубежные соседи: панмонголизм возвращается. Дата обращения: 23 мая 2011. Родионов В. *Национальная безопасность Монголии в контексте отношений с Россией*-Журнал “Власть” Институт Социологии РАН. 2013 №02 стр. 137-140
26. Интервью Министра иностранных дел С. В. Лаврова телекомпании ВГТРК в связи с юбилеем Е. М. Примакова, Москва, 28 октября 2014 года
27. В.В. Самойленко. Нейтралитет: актуальная потребность или рудимент прошлого? 12.11.15
Эксклюзив. Эксперты МГИМО: Самойленко В.В. «*Төвийг сахих нь: Тулгамдсан шаардлага уу, өнгөрсөн үеийн үлдэц үү*» (орчуулсан проф. Д.Уламбаяр) *Зууны Мэдээ сонин* №30 (5216) 2016.02.16
28. Wang Li. The ‘Third Neighbor Policy’ Of Mongolia: Romantic Or Realistic? – Analysis – Eurasia Review July 17, 2017 Modern Diplomacy
29. Secretary Kerry’s Conversation With Young Leaders, Remarks John Kerry Secretary of State, Shangri- La Hotel, Ulaanbaatar.: Mongolia, June 5, 2016, Embassy of the US, Ulaanbaatar.: Mongolia
30. 美国防长访问蒙古欲强化战略关系, 美蒙进入”蜜月期
https://www.thepaper.cn/newsDetail_forward_4113454
“Стратегийн харилцаагаа бэхжүүлэх зорилгоор АНУ-ын Батлан хамгаалахын сайд Монголд айлчиллаа АНУ, Монгол хоёр “бал сар”-даа орж байна уу?”
31. Б.Отгонсүрэн. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тухайд зарим улсын байр суурь” 2020
32. “<https://world.huanqiu.com/article/9CaKrnJslhV> 蒙古推行第三邻国政策 “Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжүүлж байна.”
33. 亚洲 娜林, 蒙古与美国 : 成为第三邻国 “Ази сэтгүүл, На Лин, Монгол Улс ба АНУ: “Гуравдагч хөрш” болох нь”
34. 蒙古国外交政策的演进及对中蒙关系的影响, 图门其其格, 内蒙古大学, 呼和浩特 010021 “Монгол Улсын гадаад бодлогын өөрчлөлт Монгол, Хятадын харилцаанд нөлөөлөх нь. Түмэнцэцэг. Өвөр Монголын их сургууль, Хөххот”
35. “Mongolia should not let nationalism blind it to importance of relationship with China” By Xiao Xin 2017/7/13 <https://www.globaltimes.cn/content/1056265.shtml>
36. 社评: ”第三邻国”不应与蒙中俄友好对立 2017.07.12
<https://opinion.huanqiu.com/article/9CaKrnK40R0>

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧИН, “ГУРАВДАГЧ ХӨРШ”-ИЙН ХАРИЛЦАА, ХЭТИЙН ТӨЛӨВ

Өнөөдөр хүн төрөлхтөн урьд хожид байгаагүй хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй орчинд амьдарч байгаа бөгөөд ирэх 15 жилд дэлхийд болох хувьсал өөрчлөлт нь хүн төрөлхтөн өнөөг хүртэлх түүхэндээ туулж өнгөрүүлснээс хавьгүй илүү тоо, хэмжээ, давтамжтай байх болно гэж ирээдүй судлаачид үзэж байгаа тухай судлаачид онцолсон байна.¹⁸⁵ Ирээдүйд болох магадлалтай өөр өөр сценарт илүү бэлтгэлтэй байх стратегийн алсын харааг урьдчилан таамаглаж стратегийн шийдвэр гаргахад ашиглах нь чухал болж байна.

3.1. Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хэтийн төлөв

АНУ ба ОХУ-ын харилцааны хэтийн төлөв

Оросын Украин дахь цэргийн тусгай ажиллагааны эхлэхээс өмнө АНУ ба ОХУ-ын цаашдын харилцааны хэтийн төлөвийн талаар геополитикийн стратегичид болон шинжлэх ухааны байгууллага дараах төсөөллийг дэвшүүлж байсан байна.

АНУ-ын талаар судалгаа хийдэг олон судлаачид АНУ болон ОХУ-ын харилцааны хэтийн төлөвийг холбоотон болж хамтрах боломжтой талаас нь тайлбарладаг. Тухайлбал, Ж.Миршаймер америкийн зүгээс хүчирхэгжин гарч ирж, жанжлагч байр суурьтай нь эргэлт буцалтгүйгээр өрсөлдөж эхлээд буй *Хятадыг эсэргүүцэхийн тулд Оростой холбоотон болж хамтрах өндөр магадлалтай гэж үздэг*. Тэрээр хэдийгээр өнөөдөр энэ хоёр гүрний харилцаа төдийлөн сайн биш байгаа ч, дэлхийн хоёрдугаар дайнд эдгээр хоёр улс холбоотон болж байсныг санах хэрэгтэй гэжээ. Түүнээс гадна *өнөөгийн Орос улсад дэлхийд дахин жанжлагч улс болон гарч ирэх потенциал байхгүй*. Харин, тэд бүс нутгийн нөлөө бүхий хүчин байхыг зорьж буй. Дэлхийн хамгийн том цөмийн зэвсэгтэй орны нэг энэ улсын хувьд бүс нутгийн жанжлагч гүрэн, дэлхийн хүчний туйлуудын нэг байх бүрэн потенциал бий гэж үзсэн. АНУ-ын улстөрийг сүүлийн 30 гаруй жил судалж буй, олон улсын харилцаа, геополитикийн судлаач, доктор Г.Фүжий “Америк, Хятадын сөргөлдөөн эхэлж буй энэ үед Орос улс ямар байр суурь баримтлах вэ гэсэн асуултад тэрээр *Оросын ерөнхийлөгч Владимир Путин хэзээ ч дайнд ялагдах талд орох тэнэг хүн биш, геополитикийн логик талаас авч үзсэн ч Орос Америктай хамтрах магадлал өндөр*. Түүхэн талаасаа ч Америк, Орос хоёр улс найрсаг хамтын ажиллагаатай явж ирсэн уламжлалтай. Хэдийгээр хүйтэн дайны цаг үед хоёр улсын хооронд урьд өмнөх дэлхийн түүхэнд байгаагүй дайсагнасан харилцаа үүсэж бараг хагас зуун жил үргэлжилсэн ч, тэдний хооронд тодорхой түвшний итгэлцэл бий болж чадсан байдаг. Ялангуяа, Америк, Оросын зэвсэгт хүчнийхний хувьд бие биеийн байдлыг маш сайн мэддэг, харилцан бие биеийнхээ үйл ажиллагааг тодорхой түвшинд таамаглаж ойлгож чаддаг болсон нь бодит байдал юм. Энэ байдал сүүлийн жилүүдэд Сирийн дайны талбарт хоёр улсын зэвсэгт хүчин хамтарч ажилласан байдлаас ч илэрхий харагдаж байгаа юм.

Тийм учраас Трампын зүгээс Оросын талаар баримталж буй бодлого Хятад руу чиглэсэн бодлогоос эрс ялгаатай. Хоёр улсын ерөнхийлөгч нар 2018 оны 7 сарын 16-нд Хельсинкт хийсэн дээд хэмжээний уулзалтаар стратегийн хамтын ажиллагааны томоохон

¹⁸⁵ Аюулгүй байдал, стратегийн орчныг тандахуй. Аюулгүй байдал, стратеги тойм. Дугаар №14 2023/02 т.2

тохиролцоонд хүрсэн байх магадлалтай. Сүүлийн арваны туршид, ялангуяа *Ши Жиньпиний засаглалын үед авч явуулсан геополитикийн хэт түрэмгий бодлогын үйл явцаас дүгнэхэд*, Америкийн засаг захиргаа цаашид Хятадын талаар маш хатуу бодлого явуулж, тэдний эдийн засгийн хүчийг сулруулж, Америкийн жанжлал доорх дэлхийн дэг журамд аюул занал учруулахгүй болох хүртэл дарамт шахалт үзүүлэх магадлалтай. *Хятадын эсрэг Америк, Орос хоёр хамтрах магадлал өндөр*. Үүний нэг шалтгаан бол Путины Орос улсад өнөөгийн дэлхийн дэг журмыг орвонгоор нь өөрчлөх санаархал байхгүй юм. Үүгээрээ Орос, Хятад хоёр эрс ялгагдана.¹⁸⁶ гэсэн байна.

Иймэрхүү төсөөллийн болзошгүй хувилбарын сценарыг ОХУ-ын шинжлэх ухааны байгууллагуудын хийсэн үнэлгээнд Орос болон АНУ-ын тэргүүлсэн орон нутгийн соёл иргэншлийн харилцааны өнцгөөс гаргасан байдаг.

ОХУ болон АНУ-ын тэргүүлсэн орон нутгийн соёл иргэншилүүдийн “холбоотны харилцааны” сценар: Ийм сценар хэд хэдэн хүчин зүйлсийн нөлөөн дор явагдаж болно:

- 1. Орос, Америкийн соёл иргэншлийн хоорондох өнөөгийн байгаа байдлаас илүүтэй гүнзгий сөргөлдөөн илрэх, жишээлбэл, исламын эсвэл хятадын соёл иргэншилүүдтэй сөргөлдөх.*
- 2. Оросын засагт АНУ руу оросын үндэсний эрх ашиг сонирхол ба орос соёл иргэншлийн үнэт зүйлсийн системд зөрчилдсөн (XX зууны 90-ээд оны эхний хагаст ийм явдал ороост үндсэндээ тохиолдсон) АНУ-ын аливаа нөхцөлүүдийн хараат хамтын ажиллагаанд бэлнээр нээлттэй хандсан эрх барих бүлгүүд гарах.*
- 3. Дэлхийн хүчний харилцаа бусад улс орнуудтай реалист, шударга харилцаа руу болон өөр (тэгш, шударга г.м) зарчмуудын үндсэн дээр олон улсын харилцааг бодитоор босгох бэлэн байдал руу өөрчлөгдөх нөлөөлөл дор АНУ-ын засгийн эрх баригчид аажим хувьсах.*

Гагцхүү олон улсын харилцааны, түүнчлэн XVIII зуунаас эхтэй Орос, АНУ-ын хоорондын харилцааны хөгжлийн түүх холбоотон болох зарим нөхцөлийг бүрдүүлж байсан ч хэзээ ч дараах шинжүүдийг агуулаагүй байсан:

- гүнзгий, олон талын, системийн шинж, өөрөөр хэлбэл нийтлэг соёл иргэншлийн, геополитикийн ашиг тустай байгаагүй. Харин эсрэгээр Орос, АНУ геополитик, соёл иргэншлийн хувьд үргэлж эсрэг зогсох хүчин, сайн тохиолдолд бие биедээ төвийг сахиж байсан. Бүр ЗХУ-ын үзэл суртал ба улс төрийн системийн өөрчлөлт өөртөө хүрэлцээтэй гүнзгий үндэс суурьтай “геополитик болон соёл иргэншлийн нийцгүй байдал”-ыг даван туулж чадаагүй. Орос ба АНУ-ын хоорондох геополитикийн сөргөлдөөн АНДБ-ийн хөгжил, нягтралын явцаар хүчтэй болж, Орос, АНУ-ын холбоог илүү бодит бус болгож хувиргана¹⁸⁷;*
- өчүүхэн төдий урт хугацааны шинж. Энэ нь АНУ-ын америкийн тэргүүллийг хадгалахад чиглэсэн, бусадтай харилцах харилцаа нь хараат, захирах шинжийг агуулсан орчин үеийн геополитикийн урт хугацааны стратегийн хувьд бүр боломжгүй юм. АНУ-ын энэ стратеги урт хугацааны хэтийн ирээдүйд, ялангуяа ойрын ирээдүйд өөрчлөгдөх магадлал туйлын бага. Урт хугацааны төлөвлөлтөд*

¹⁸⁶ С.Буянцогтоогийн Г.Фүжий доктортой уулзаж хийсэн хувийн ярилцлага, 2018.

¹⁸⁷ Бакланов П. Я., Романов М. Т. Стратегия развития Приморского региона: от прошлого к будущему. 2013.

байгалийн нөөцүүд, тээвэрлэлтийн коридорууд ба дэлхийн нөлөөллийн төлөөх орон нутгийн соёл иргэншлүүдийн хоорондох тэмцэлд АНУ улам илүү чиглэх болно. “Соёл иргэншлийн ирээдүй” гэсэн 2050 он хүртэлх дэлхий дахины прогнозын бүтээлд судлаачид “ойрын 20 жилд экологийн эрсдэлүүд зөвхөн дэлхийн дулаарлаар зогсохгүй. Дэлхийн дулаарал чухал, гэвч шийдвэрлэж болох асуудал. Дутагдалтай нөөцүүдийг, ялангуяа усны нөөцийг эзэмшихийн төлөөх эвлэршгүй өрсөлдөөн хамгийн аюултай. Тухайлбал, 2025 он гэхэд жилийн 8-10 хувийн эдийн засгийн өсөлтийн хурдац дэлхийн үйлдвэрлэлийг хоёр дахин ба дутагдалтай нөөцүүдийн ашиглалтыг хоёр дахин нэмэгдүүлэх болно”¹⁸⁸ гэсэн нь анхаарал татаж байна.

- *Орос ба АНУ-ын харилцааны бүрдлийн нөхцөлүүд хэзээ ч үнэт зүйлсийн, ертөнцийг үзэх, соёл иргэншлийн нийтлэг шинжийг агуулж байгаагүй. Энэ нь орос ба америкийн соёл иргэншлүүд бие биетэйгээ ойртохыг эрмэлзэж байгаагүйн илрэл юм.*

Ерөнхийлөгч Д:Трампын үед АНУ Хятадын цэргийн хүч чадал, ялангуяа пуужин цөмийн зэвсгийн хүч нөөц өсөн нэмэгдэж байгаад ихэд санаа зовниж байсан бөгөөд Хятадыг тогтоон барихын тулд ОХУ-ын нөлөө, хүчин зүйлийг ашиглах оролдлого хийж эхэлсэн. Тухайлбал, Ерөнхийлөгч Д.Трампын “Бага, дунд тусгалтай пуужингуудыг устгах тухай гэрээ”-нээс гарах тухай хийсэн мэдэгдлийн дараагаар Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын зөвлөх Ж.Болтон “Манай улс Хятадын дайсагнасан явуулгын талаар ОХУ-тай яриа хэлэлцээ хийхэд бэлэн байна. Хятадын пуужингуудын тусгалын бүсэд Орос ч өөрөө багтаж буй тул тэдний пуужингийн хүчин чадал Орост ч аюул занал учруулах болно”¹⁸⁹ гэж мэдэгдэж байсан.

Харин Ерөнхийлөгч Ж.Байданы үед Орос-Украины дайн болон Тайваны асуудалтай холбоотой их гүрнүүдийн геостратегийн сөргөлдөөн улам хурцдаж, тэдгээрийн болон өөрийн улсын эрх ашигт нийцүүлэн цэрэг-улс төрийн сонголт хийх сорилт бусад улсад тулгарч байна. Орос-Украины дайнаас үүдэн 8 сая орчим буюу Украины нийт хүн амын бараг 20 хувь нь эх орноо орхин гадагш дүрвэсэн бол дэлхий даяар нийт 32 гаруй сая хүн хавчлага, мөргөлдөөн, хүчирхийллийн улмаас эх орноосоо дайжин амь зууж байна.

Ийм цаг үед НАТО-ийн дээд хэмжээний уулзалт Мадрид хотноо 2022 оны зургаадугаар сард зохион байгуулагдаж, НАТО-ийн шинэ стратегийн үзэл баримтлал, түүний бэхжилт, тэлэлт, түншлэл, санхүүжилт, терроризмын эсрэг тэмцэл зэрэг асуудлыг хэлэлцсэн бөгөөд НАТО-ийн 2030 он хүртэл баримтлах стратегийн шинэ үзэл баримтлалыг баталсан. Тус баримт бичигт ОХУ-ыг эвслийн орнууд болон Европын энх тайван аюулгүй байдалд учирч буй гол аюул заналхийлэл, Хятадыг тэдэнд учирч буй сорилт хэмээн онцолсон нь ноцтой үр дагавар бүхий үйл явдал болсон.

АНУ, ОХУ-ын харилцааны зэрэг сценар: *Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, улсуудын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, олон улсын байгууллагуудын үүрэг ба бусад улс, үндэстнүүдийн эрх ашгийн үндсэн дээр “Дэлхийн дэг журмыг бататгах”.* Ийм сценаруудыг онолын боломжит, харин өнөө үед бага магадлалтай категориудад бүрэн хамруулж болно. АНУ, НАТО болон ЕХ-ны бодит бодлого энэ сценарыг илүү сайн

¹⁸⁸ Перспективы геополитической динамики и взаимодействия цивилизаций / Научные редакторы: Ю. В. Яковец, А. И. Агеев, Т. Т. Тимофеев. М.: МИСК, 2009. Ч. VII. С. 142–144.

¹⁸⁹ Закрытие Чимерики. К чему ведет противостояние США и Китая "Коммерсантъ" от 05.11.2018

тохиолдолд тунхаглал-зарлалын шинжтэй, харин илүү муу тохиолдолд үнэн зорилгуудаа далдлахад чиглэсэн зорилготой мэдээллийн бодлогын илрэл гэж авч үзэж болохыг баталж байна. Түүнчлэн ийм сценар магадлал багатай байж болохыг 2014 оны Минскийн гэрээ байгуулах үеийн АНУ-ын Украйныг бэхжүүлэх цаг хожих гэсэн зорилгын талаарх сүүлийн үеийн баримт болон НАТО-гийн хөгжлийн бодлогын шинэ стратегийн үзэл баримтлалын баримт харуулж байна.

АНУ, ОХУ-ын харилцааны сөрөг сценар: *Дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл эрчимжих.* Өнөө үетэй адил 2030, 2050 он хүртэл ч дэлхийн тээврийн коридоруудад хяналтаа тогтоох нь геополитикийн хувьд маш чухал ач холбогдолтой хэвээр байх болно. АНУ-д занарын хий ашиглаж буйн зорилго нь байгалийн хийн дотоодын хэрэгцээг хангахад болон ирэх арван жилийн экспортын чадамж бүрдүүлэхэд оршино. Хүрч очиход хүндрэлтэй газар орон дахь ордуудад нефтийн олборлолтыг нэмэгдүүлэх нь АНУ-д худалдааны орлого, зардлын тэнцвэрийн ялгааг мэдэгдэхүйц багасгах болон эдийн засгийн өсөлтийг хурдасгахад хүргэнэ. Энэ тохиолдолд дэлхийн нөөц 8 сая баррелд хүрэх магадлалтай бөгөөд хэзээ нэг цагт ОПЕК нефтийн үнэн дээрх хяналтаа алдана. Улмаар нефтийн үнэ эрс унаснаас ОХУ-ын нефтийн экспорт болон эдийн засагт нь ноцтой сөрөг үр дагавар гарна. АНУ бодлогоо нефтийн импортын татварыг нэмэх, дотооддоо нефть олборлоход тавьсан экологийн зарим хязгаарлалтыг цуцлах, Америкийн нутаг дэвсгэр дээр нефть, хий дамжуулах хоолой барьж байгуулахыг дэмжих, нефть, байгалийн хийн экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах зэргээр хэрэгжүүлэх боломжтой. АНУ-ын энэ бодлого хэрэгжвэл ОХУ-д томоохон цохилт болох магадлалтай. Мөн Персийн булангийн нефть Европ руу гарч эхэлбэл ОХУ Европын зах зээлд том өрсөлдөгчтэй болно¹⁹⁰. АНУ-ын ОХУ-ын эсрэг тавьсан хориг арга хэмжээ үндсэндээ өөрийн эрх ашгийг Европын холбооны ашиг сонирхлыг үл харгалзан хэрэгжүүлэх хэрэгсэл болж байна.

АНУ ба Хятадын харилцааны хэтийн төлөв

Сценар 1. Шинэтгэл-зарим талаар хоршсон, зарим талаар өрсөлдсөн-санал нийлэлт

Хоёр талын Хятад дахь эдийн засгийн өөрчлөлтийн үндсэн дээр:

- их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтуудын хувьд одоо хязгаарлалттай байгаа салбаруудад хятадын зах зээлийг нээх;
- улсын үйлдвэрүүдийн хувьд мөнгөн тусламжийг багасгах;
- АНУ болон ЕХ-той харилцан хөрөнгө оруулалтын баталгаатай хоёр талын хөрөнгө оруулалтын хэлэлцээр байгуулах;
- ӨЦЗ /Өндөр цэцтэй зэвсэг/-ийн худалдаа болон бусад технологийн хэлцлүүдийг дэмжих зэрэг хоршсон үйл явц энэхүү сценарт хамаарна..

Аюулгүй байдлын салбарт энэ сценар нь хамтын ажиллагаа болон 6 талт яриа хэлэлцээрийг сэргээх замаар Хойд Солонгосын цөмийн асуудлыг шийдвэрлэх, АНУ, БНХАУ, БНСУ ба БНАСАУ-ын хооронд зэвсэглэлийг хорогдуулах талаар зөвшилцөлд хүрэх ба дайн түр зогсоох тохироог энхийн гэрээ болгох ба хил залгаа улсууд (Хятад, Орос, Энэтхэг, Иран, Пакистан)-ын хооронд терроризм ба хар тамхины худалдаатай тэмцэх

¹⁹⁰ И.Рэнчинханд. Трамп та юу хийгээд байна. МН Өнөөдөр, 2017.02.06, №030

талаар тасралтгүй хамтын ажиллагааг хөгжүүлэх болно. Энэхүү сценарын дагуу Энэтхэг-Номхон далайн санаачилга нь хэлэлцүүлэг өрнөдөг зөвлөх үүрэгтэй механизм болно.

Урьд нь бий болсон байсан нөхцөлийн талаар: стратеги судлаач Э.Луттвак 2000-аад оны эхээр Хятад улсын хэрэгжүүлж байсан “Энх тайванч хөгжил цэцэглэлт” гэх стратегийг “Хятад 1.0” гэж нэрлэсэн бөгөөд Хятадын энэ бодлогыг дэлхий нийтээр ямар ч эргэлзээгүйгээр хүлээн авч, барууны ертөнц тэр чигээрээ энэ стратегийг идэвхтэй дэмжиж, харилцан ашигтай эдийн засгийн харилцааг үүсгэн хөгжүүлж ирсэн юм. Хятадын удирдагчид Хятадын хөгжил цэцэглэлт ирээдүйд ямар нэг хүч түрэмгийлэл, аюул заналыг огт авчрахгүй, олон улсын түвшинд харилцан ашигтай харилцааг бий болгож хөгжүүлнэ гэж үнэмшүүлж чадсан юм гэж тэмдэглэсэн байдаг.

Өнөө болон хэтийн дүр зургийн талаар: М.Пилсбүри¹⁹¹ 2015 онд хэвлүүлсэн “Зуун жилийн марафон” номондоо Америкийн дэлхийд жанжлагч байр суурийг булаан авах далд санааг Хятадын тал Мао Зэдуны үеэс авахуулаад олон жилийн туршид өвөрлөж ирсэн гээд Америк тэргүүтэй барууныхан хятадуудын тэрхүү далд стратегид хууртаж ирсэн гэж дүгнэсэн байдаг байна. Хятадын эрх баригчид 1949 онд өнөөгийн Хятад улс байгуулагдах хүртэлх түүхээ “дарлал доромжлолын доорх 100 жил” гэж нэрлэдэг бөгөөд тэр үеэс хойших 100 жил буюу 2049 он хүртэлх хугацаанд барууны орнуудын хөгжлийг гүйцэж дэлхийд тэргүүлэгч хөгжилтэй, жанжлагч гүрэн болох далд зорилгыг БНХАУ-ыг байгуулсан тэр мөчөөс эхлэн өмнөө тавьж ирсэн гэж М.Пилсбүри бичжээ¹⁹².

Хятад БНАСАУ-ын хамгийн ойрын холбоотон учир АНУ болон БНАСАУ-ын хоорондын харилцаа яаж өрнөх нь энэ сценарын өрнөлд, тухайлбал АНУ ба Хятадын хоорондын харилцаанд чухал ач холбогдолтой. БНАСАУ-ын тал цөмийн зэвсэг хураах асуудлаа гагцхүү АНУ-тай ярилцана гэсэн байр суурь баримталж байгаа. Учир нь тэдэнд аюулгүй байдлын баталгаа гаргах ёстой нэн тэргүүний орон нь АНУ юм. Цөмийн зэвсэг хураах асуудлын хувьд зарим улс төрчид, тэр дундаа АНУ-ын өндөр албан тушаалтнууд маш өөдрөгөөр хандаж байсан. Тухайлбал Д.Трамп, ТНБД М.Помпео нар 2020 оны сүүл, 2021 оны эхэн үе гэхэд цөмийн зэвсэг хураах үйл явцыг эцэслэх боломжтой гэж үзэж буйгаа илэрхийлж байсан байна. Гэвч бодит нөхцөл байдал дээр яриа хэлэлцээ гацаанд орсон нь талуудын хооронд олон жил бугшсан үл ойлголцол, үл итгэлцэл оршсоор байгааг харуулсан. Тиймээс талуудын хооронд итгэлцлийг бэхжүүлэхэд нэлээд цаг хугацаа шаардах тул шинжээчдийн үзэж буйгаар цөмийн зэвсэг хураах яриа хэлэлцээ үр дүнд хүрнэ гэхэд нэн бэрх, хүрлээ гэхэд дунджаар 10 орчим жилийн хугацаа шаардана гэж үзэж байна¹⁹³

Сценар 2. Хөдөлгөөнгүй, зогсонги байдал

Дорнод Хятадын болон Өмнөд Хятадын тэнгисүүдэд, Хятад ба Энэтхэгийн хоорондын харилцаанд зөрчилдөөн болон хурцадмал байдал тогтмол өссөөр байна. Хойд Солонгостой цөмийн хөтөлбөр ба тив хоорондын баллистик пуужин бүтээх

¹⁹¹ М.Пилсбүри бол АНУ-ын төрийн тусгай байгууллагуудад ажиллаж байсан, Хятадын гадаад бодлогыг олон жил судалж ирсэн, геополитик, стратегийн судалгаа хийдэг судлаач юм. Түүний “Зуун жилийн марафон” ном бол өнөөгийн Хятадын гадаад бодлогыг геополитикийн стратеги талаас нарийвчлан судалсан бүтээл ажээ.

¹⁹² Ц.Буянцогтоо. “Америк, Хятадын харилцаа: Дэлхийн шинэ хүйтэн дайн эхлэв үү?”. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. УБ., 2018. №26 (36), х.46-56

¹⁹³ <http://time.com/5306831/president-trump-wants-north-korea-to-give-up-nuclear-weapons-heres-just-how-hard-that-would-be/>

хөтөлбөрүүдийг багасгах тухай хэсэгчлэн устгах, хэсэгчлэн зогсоож болох завсрын шийдэлд хүргэх хязгаарлагдмал хамтын ажиллагаа ажиглагдана. Худалдаа болон технологи дамжуулалтын асуудлуудаар эдийн засгийн өрсөлдөөн улам эрчимжинэ. Ши Жиньпин Боагийн Азийн форумын¹⁹⁴ үеэр худалдаа, хөрөнгө оруулалтад илүү “норматив”-ыг баримтлахад түлхэц өгөхөө амласан бөгөөд АНУ ба тэдгээрийн түншүүд-санаа нэгтнүүд Хятадыг энэхүү амлалтаа хэрэгжүүлэхийг шахсаар байх болно. Энэтхэг-Номхон далайн түншлэл хэрэв мухардалд орвол Хятадыг саармагжуулах зорилгоор аюулгүй байдлын хүрээнд хамтран ажиллах боломжуудыг нэмэгдүүлэхэд төвлөрсөн зөвлөгөөнүүдийг гүнзгийрүүлнэ.

Сценар 3. Хурцадмал байдал ба сөргөлдөөнийг хүчтэй болгох

Энэ сценарын явцад АНУ ба Хятадын хоорондох худалдааны дайн гүнзгийрнэ, хоёр тал аль аль нь түүнд ялж гарч болно гэж тооцно. Худалдааны маргаанууд хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалд сөргөөр тусах бөгөөд бүс нутагт эдийн засгийн өсөлт удааширна. Үргэлжилсэн үе шатны дараа худалдааны мөргөлдөөнийг хэсэгчлэн шийдэхийн тулд зөөлөн алхмууд авагдана. Гималай дахь маргаантай асуудлаар Хятад болон Энэтхэгийн хооронд геополитикийн хурцадмал байдал өснө. Гвадард, Шри-Ланкид, Мальдивд, Бангладешд байгуулагдах Хятадын боомтуудын хүрээлэлд орохоос Энэтхэг болгоомжилж байна. Үүний зэрэгцээ Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх АНУ ба Хятадын олширч буй цэргийн ажиллагаануудын асуудлаас болж АНУ ба Хятадын хооронд хурцадмал байдал үүснэ. Хятадын зэвсэгт хүчний үйл хөдлөлийг америкчууд таамаглаж мэдэхгүй бөгөөд үндсэндээ “занг нь огт мэдэхгүй дайсан” болж таарч байгаа юм. Энэ байдал нь хоёр улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэх магадлалыг нэмэгдүүлж байна гэж Г.Фүжий доктор үзэж буйг судлаач Ц.Буянцогтоо өөрийн бүтээлд тэмдэглэсэн байдаг. Хойд Солонгосын асуудал дээр Хятад хоёр Солонгост цөмийн хөтөлбөрийг царцаахыг тулгана, түүнийг АНУ эсэргүүцнэ. Энэ сценар нь хүйтэн дайны утга агуулгатай шинэ хагарлыг зөгнөж байна.

Хятад эдүгээ дэлхийн аль ч улсаас илүү олон хөрштэй болжээ. Сүүлийн жилүүдэд тус улс Вьетнам, Энэтхэгтэй дайтаад амжсан ч одоо зөрчил мөргөлдөөнөөс аль болох зайлсхийж, нийлүүлэлтийн сувгийг хянан залах стратеги баримталж байна. Үүний дүнд долоон зууны тэртээ Евразийг атгаж асан Монголын эзэнт улсыг бий болгож чадсан шиг функциональ газрын зурагтай болох ажээ¹⁹⁵ гэсэн ирээдүйн төсөөлөл АНУ-тай улам хүчтэй сөргөлдөөн үүсгэхийг харуулж байна.

Худалдааны дайн улам хурцах төлөвтэй байна. Худалдааны дайныг өдөөгч тал нь АНУ гэж үзэж болох бөгөөд АНУ БНХАУ-аас импортоор орж ирдэг бараа бүтээгдэхүүнд импортын татвар тогтоохдоо хоёр шалтгааныг үндэслэдэг гэж тайлбарладаг. Үүнд:

1. АНУ, БНХАУ-ын худалдааны тэнцэл маш ихээр алдагдсан. Өөрөөр хэлвэл, АНУ-ын БНХАУ-аас худалдан авдаг бараа бүтээгдэхүүн БНХАУ-ын АНУ-аас худалдан авдаг бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулахад маш бага. Энэ нь АНУ-ын дотоодын

¹⁹⁴ Chu K. Ball in Donald Trump’s court as Xi Jinping champions free trade at Boao Forum // South China Morning Post. 2018. April 14. URL: <http://www.scmp.com/news/china/article/2141754/ball-donald-trumps-court-xi-jinping-champions-free-trade-boao-forum>

¹⁹⁵ ¹⁹⁵ Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018. 427 х.

үйлдвэрлэгчдийг илт доройтуулж байна. Тиймээс БНХАУ АНУ-аас худалдан авдаг бараа бүтээгдэхүүний хэмжээгээ нэмэгдүүлж, худалдааны тэнцлийг хангах ёстой

2. АНУ-ын дэлхий нийтэд танигдсан бренд бараа бүтээгдэхүүнийг Хятадын аж ахуйн нэгжүүд хэт их хэмжээгээр хуурамчаар үйлдвэрлэж, оюуны өмчийн хулгай хийж байгаа. Үүний эсрэг БНХАУ-ын засгийн газар хариу арга хэмжээ авдаггүй.

Тэгвэл АНУ-ын үндэслэл болгож буй хоёр шалтгаан нь аль аль нь урт хугацааны шинж чанартай байна. Худалдааны тэнцлийн асуудлыг хангахад БНХАУ-ын тал анхаарч ажиллаж, АНУ-аас авдаг бараа бүтээгдэхүүнээ зохион байгуулалттайгаар нэмэгдүүлэхээ мэдэгдсэн ч тэнцвэржүүлэх хэмжээнд аваачих бодит боломж байхгүй гэж шинжээчид үзэж байна. Мөн оюуны өмчтэй холбоотой маргаан ч маш удаан хугацаанд үргэлжилж буй бөгөөд цаашдаа ч Хятадын Засгийн газар оюуны өмчтэй шууд утгаараа хатуу тэмцэх боломжгүй, тэмцлээ ч гэсэн дотоодын олон аж ахуйн нэгжийг дампууралд хүргэж болзошгүй тул дорвитой хариу арга хэмжээ авна гэхэд эргэлзэхэд хүргэж байна. Иймд худалдааны дайныг өдөөж буй голлох хоёр хүчин зүйл нь харьцангуй урт хугацааны шинж чанартай байгаа нь худалдааны дайныг нэлээд удаан үргэлжилнэ гэж үзэхэд хүргэж байна.

АНУ-ын засаг захиргааны зүгээс худалдааны дайнд капитал дээр суурилсан эдийн засагтай АНУ хожно гэж байгаа бол БНХАУ-ын томоохон бизнес эрхлэгчид ажиллах хүчний маш их нөөцтэй, эдийн засаг, гадаад худалдаа нь хурдацтай өсч буй БНХАУ дайнд ялна гэж үзэж байна. Тэгвэл нөлөө бүхий эдийн засагчдын ихэнх нь урт хугацаанд бүх талууд хохирно гэж үзэж байна. Тухайлбал дайнд хэн ялах нь ердөө чухал асуудал биш. Харин урт хугацаандаа аль аль улсын эдийн засагт сөрөг нөлөө гарах нь тодорхой гэж дүгнэж байна.¹⁹⁶

Худалдааны дайны үргэлжлэх хугацааг шинжээчид харилцан адилгүйгээр тайлбарлаж байна. Нэн түрүүнд богино хугацаанд дайн жилээс жилд идэвхэжнэ гэж үзэх хандлага давамгайлж байна. Тухайлбал алдарт Стратфор байгууллага хоёр талын худалдааны дайныг 2019 онд улам идэвхэжнэ гэж үзэж байсан¹⁹⁷. Харин ковид 19 цар тахал энэ төсөөллийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх боломжийг хаасан.

Тэгвэл Тоглоомын онолын хувьд ч дайн маш удаан хугацаанд үргэлжилнэ гэж үзэх боломж буйг зарим шинжээчид илэрхийлж байна¹⁹⁸.

Тухайлбал тоглоомын онолд туссан байдаг хоёр хүчин зүйлээр худалдааны дайн удаан хугацаанд үргэлжилнэ гэж үзэж байна. Үүнд:

1. Талуудын итгэлцэл буурсан. Тоглоомын онолын дагуу итгэлцэл нэгэнт алдагдсан бол эргэн тогтооход маш бэрх гэж үздэг. Талууд өмнө нь бие биедээ итгэдэг байсан ч Трамп Хятадаас орж ирэх бараа бүтээгдэхүүнд татвар тогтоох болсон нь итгэлцлийг эрс бууруулсан. Цаашдаа итгэлцэл өмнө нь байсан шиг түвшинд хүрэхэд маш их хугацаа шаардана.

¹⁹⁶ <https://www.forbes.com/sites/johnmauldin/2018/10/01/why-who-will-win-doesnt-matter-in-this-trade-war/#79d0238980d6>

¹⁹⁷ Stratfor- “2019 Annual Forecast” <https://worldview.stratfor.com/article/2019-annual-forecast-geopolitics-intelligence-global-risk>

¹⁹⁸ Scott Tong- “Game theory suggests the trade war could last a long time” <https://www.marketplace.org/2018/10/25/economy/game-theory-suggests-trade-war-could-last-long-time>

2. Тоглоомын онолын үүднээс тайлбарлавал, Худалдааны дайн бол өдөөгч талын ашиг сонирхлыг илэрхийлсэн рациональ зүйл. Тэгэхээр АНУ-ын хувьд Хятадаас орж ирж буй бараанд импортын татвар тогтоох нь үндэсний эрх ашгийнх нь илрэл тул зайлшгүй үзэгдэл юм. Хятадын тал ямар ч хариу үйлдэл үзүүлээд АНУ-ын тал татвар тогтоохоо болихгүй гэсэн үг.

Тэгвэл зарим шинжээчдийн зүгээс Хятадтай хийдэг ашиггүй гадаад худалдаагаа протекционист хандлага гаргаж тэнцвэржүүлэх оролдлого хийх нь АНУ-ын хувьд цаг хугацааны асуудал байсан бөгөөд Трамп нэгэнт энэ үйл явцыг эхлүүлсэн тул дараа дараагийн засаг захиргаа үргэлжлүүлнэ гэж үзэж байсан.

*Хятадын зарим судлаачид ч худалдааны дайныг урт удаан хугацаанд үргэлжилнэ гэж үзэж буй бөгөөд Алибаба группын үүсгэн байгуулагч, бизнесмэн Жэки Ма л гэхэд худалдааны дайныг багаар бодоход 20 орчим жил үргэлжилнэ гэж үзэж байна*¹⁹⁹.

“АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын дарга Н.Пелосогийн Тайваньд хийсэн айлчлалтай холбогдуулан ХАЧА Тайванийн хоолойд төлөвлөгдөөгүй бүрэн хэмжээний цэргийн хээрийн сургуулилтыг 2022 оны наймдугаар сарын 3-10-ны өдрүүдэд явуулсан. Тус сургуулилт нь ХАЧА-гийн сүр хүчийг дэлхий дахинд харуулах, Тайваны арлыг цэргийн хүчээр авах хувилбрыг шалгах зорилготой байсан. Сургуулилтаар арлын агаарын орон зайг хаах, тэнгисийн цэргийн хүчээр Тайванийг 6 талаас нь бүслэх, байлдааны буудлага хийх, хэт авианы ДФ-17 буюу Dongfeng-17 пуужинг харваж турших зэрэг үйл ажиллагаа явуулсан нь байдлыг улам хурцатгаад байна. Энэ нь худалдааны дайн удаан үргэлжлэх магадлалтайн баримт болж байна. Түүнчлэн аливаа буруу тооцоо дээрх нөхцөл байдлуудын аль нэгэнд цэргийн тулгаралт болж хувирах боломжтой мөргөлдөөний галыг асааж **болохыг илтгэж байна..**

ОХУ ба БНХАУ-ын харилцааны хэтийн төлөв

Сценар 1. ОХУ ба Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны сценар

Ийм сценарт хамгийн их түлхэц өгч буй нөхцөл бол АНУ-ын Ази-Номхон далайн бүс нутаг, түүнчлэн Зүүн хойд Азид явуулж байгаа улс төр, эдийн засгийн болон цэргийн бодлого байсан бол сүүлийн үеийн АНУ тэргүүтэй НАТО-гийн Украйныг дэмжиж ОХУ-ын эсрэг барьж буй дайныг өдөөж, Оросыг унагаах болон Тайванийг дэмжих бодлого нь Хятад болон Орос улсыг идэвхтэй сөрөг ажиллагаа хамтран явуулахад хүргэж байгаа явдал юм.

ОХУ-ын Ерөнхийлөгч Путин БНХАУ-д төрийн айлчлал хийхдээ Хятадын төв хэвлэл болох "Рэнминь рибэо"-д өгсөн ярилцлагадаа дэлхий дахинаа явагдаж буй бүхий л үйл явцад ОХУ, БНХАУ чухал үүрэгтэйг онцлон тэмдэглээд, "Дэлхийн улс төр, эдийн засгийн амин чухал ямар ч асуудлыг тус хоёр орны ашиг сонирхлыг тооцохгүйгээр шийдвэрлэх боломжгүй"²⁰⁰ гэсэн нь үүнийг давхар нотолж байна.

ОХУ-ын ЕАЭЗХ, БНХАУ-ын “Бүс ба зам” стратегийн тухайд: “Бүс ба зам” болон ЕАЭЗХ-г нэгтгэх явдал Хятадын хувьд “Бүс ба зам” хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд Оросын нөлөө хэрэгтэй бол Оросын хувьд Төв Азийн улс орнуудад дэглэмийг

¹⁹⁹ Jack Ma: US-China trade war could last 20 years <https://money.cnn.com/2018/09/18/technology/jack-ma-trade-war/index.html>

²⁰⁰ <http://news.sina.com.cn/z/rputinvcvchina/> 俄罗斯总统普京访华。

хадгалж үлдэх, эдийн засгийг нь тогтворжуулахад БНХАУ-ын оролцоо ач холбогдолтой байна. Евразийн бус нутаг дахь Хятад, Оросын ашиг сонирхлын нэгдэл онцгой хяналттай геополитикийн орон зайг бий болгох суурийг тавьж байна. Ази, Номхон далайн бүсэд ч ялгаагүй Орос, Хятад харилцан бие биеэ дэмжиж байна. Орос-Хятадын энэхүү ойртолт цаашид олон улсын харилцааны одоогийн дэглэм тэсэж үлдэхэд ихээхэн сорилт учруулж болзошгүй байна.

АНУ ОХУ-тай байгуулсан БДТП-гийн гэрээнээс гарах мэдэгдэл хийхдээ Хятадыг буруутгасантай холбоотойгоор энэхүү гэрээг байгуулах үед Хятадад ийм төрлийн зэвсэглэл байгаагүй – гэсэн Хятадын байр суурийг ГХЯ-ны орлогч Чжан Ханьхуэй Оросын сэтгүүлчидтэй уулзах үеэрээ илэрхийлсэн. Тэрээр Трамп яагаад энэ талаарх мэдэгдэлдээ Хятадыг оролцуулаад байгаа нь бидэнд ойлгомжгүй байна. БДТПГ /Бага, дунд тусгалтай пуужингийн гэрээ/-нээс АНУ гарч байгаа нь угтаа бол гэрээг устгаад зогсохгүй дэлхийн энх тайвныг тогтоож буй үндсийг үгүй хийж байгаатай ижил юм. АНУ давших болон хориглох чиглэлийн бүх стратегийн зэвсэглэлд өөрийн давуу байдлыг бий болгохыг зорьсонтой холбоотой нь тодорхой байна. АНУ олон тооны пуужингийн довтолгооноос хамгаалах системийг үйлдвэрлэж, дэлгэн байршуулж байна. Тэд сансарт зэвсэглэл байршуулж, сансрын төрлийн зэвсэглэлийг хөгжүүлж байна. Тэгсэн мөртлөө Оросын зүгээс аюултай үйл ажиллагаа явуулж байна, энэ нь АНУ-д заналхийлж байна гэж мэдэгддэг. Нөгөө талаас АНУ өөрийн тэргүүн зорилтыг энх тайван гэж тунхагладаг атлаа, өөрийн хүсэл зоригийг бусдад тулгадаг. БДТПГ-ний тухайд бол Хятад үүнд ямар ч хамаагүй. Гэхдээ бид дэлхийн тогтвортой байдлыг алдагдуулах оролдлогын эсрэг байх ёстой. Үүний ч тулд батлан хамгаалах салбар харилцан ажиллагаа, технологийн тэр тундаа нисэх онгоцны үйлдвэрлэл, сансар судлалын чиглэлийн хамтын ажиллагааг Оростой бэхжүүлнэ» хэмээжээ.

Судлаач ОХУ ба Хятадын харилцааны энэ сценар хэврэг байж болох нэг онцлогийг “Хятад, Орос хоёр улс геополитикийн саад бэрхшээл үүсгэгч хоёр орон бус харин эрэлт, нийлүүлэлтийн түншүүд болжээ. Орост газар нутаг, байгалийн баялаг байгаа бол Хятадад хүн хүч, хөрөнгө мөнгө байна. Оросын дэд бүтэц муудаж доройтсон, харин Хятад түүнийг нь таван жилийн дотор шинээр бариад өгч чадна. Хятад-Оросын харилцааг барууны эсрэг хамтарсан холбоо гэж харах нь өрөөсгөл юм. Учир нь Орос улсын хувьд, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хадгалах тухайд, зүүн жигүүрээ тэр чигт нь Хятадад залгиуулахаас илүү урт хугацааны ноцтой заналхийлэл гэж үгүй. Энэ хоёр орны харилцаанаас харахад одоо цагт итгэлтэй харилцаа холбоо гэж үгүй болсныг, “найзаа өөртөө ойр байлга, дайснаа бүр ч ойр байлга” гэх дүрмийг дагасан нэг нь нөгөөгийнхөө дутууг нөхдөг харилцаа л гэж байх болсныг ойлгож болно.”²⁰¹ гэсэн байдгаас харж болно.

Сценар 2. ОХУ ба Хятад хоорондын зөрчилдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болзошгүй сценар

Ийм сценарт хүргэж болох нөхцөлийн талаар “... Энэ динамикийг хамгийн сайн харж болох газар бол Хятад, Орос гэсэн дэлхийн хоёр агуу гүрний хоорондын хилийн зурвас юм. Энэ хилийн зурвас дэлхийн хоёр дахь хамгийн урт зурвас билээ. Оросын өргөн уудам газар нутагтай, байгалийн баялаг ихтэй, хүн ам сийрэгтэй Алс Дорнод нутгийн нөөц баялгийг Хятад улс хэрхэн "колоничилж" буй тухай арваад жилийн өмнө анх бичихэд минь

²⁰¹ Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018. 427 х.

Москвагаас над руу дургүйцэж үзэн ядсан захидлуудыг ар араас нь илгээж байв. Тухайн үед хориотой байсан сэдэв одоо асуудал болоод гараад ирлээ. Энэ хоёр улсын заагладаг гурван мянган километр урт хөврөх Амар мөрөн нь хил зааг гэхээс илүүтэй Хятад төвтэй эрчим хүч, хүнс, усны экологийн гол шугам болно.

Угтаа бол хоёр янзын Орос улс бий: Нэг нь Уралын нуруунаас баруун тийших Европ руу хандсан хүн ам олноор төвлөрсөн хотууд; нөгөө нь Уралын нуруунаас зүүн тийших, "европжсон" Оросоосоо долоо дахин том, Сибирийн өргөн уудам тал нутгийн Орос орон юм. Энэ бүс нутагт Оросын нийт хүн амын аравны нэгд ч хүрэхгүй хэсэг нь амьдардаг. Гэхдээ Оросын зүүн бүс нутагт гуалин болон эрдэс баялгийг эцсийн бүтээгдэхүүн болгож хувиргах үйлдвэр ажиллуулж буй хятад иргэд болон зарим нь улирлын чанартай, зарим нь бүрмөсөн суурьшсан хятад худалдаачдын тоо хэр хэмжээнд хүрснийг газрын зургаас олж харах боломжгүй. Бараг тал хувь нь түрэг, эскимос зэрэг угсаатны цөөнхүүдээс бүрдсэн таван сая хүрэхтэй үгүйтэй тооны орос хүн амьдардаг энэ нутгийн иргэдтэй хятадууд гэр бүл болох явдал нэмэгдсээр тус бүс нутагт Хятад-Сибирь цус холилдсон эрлийз соёл иргэншил бүрэлдэх янзтай болжээ. Нэг л өдөр, магадгүй энэ бүхний гор нь гарах ч юм билүү: Орост амьдарч буй иргэдийнхээ аюулгүй байдал, иргэний эрхийг хамгаалах, чанартай үйлчилгээгээр хангах нэрийдлээр Хятад улс энэ оронд цэргээ илгээж, Алс Дорнод даяарх цус холилдсон, үндэстний цөөнх болсон хүмүүст паспорт олгож эхлэхийг үгүйсгэхгүй шүү дээ (яг л Абхаз, Крым зэрэг газруудад Оросын авсан арга хэмжээ шиг).²⁰² гэсэн таамаг дэвшүүлсэн бол Хантингтон "Дорнод Азид Хятад бүрэн давамгайлах болсон нь Москваг болгоомжлуулахад хүргэв. Оросууд Хятадын эсрэг хөдөлж, Сибирьт цэргээ бэхжүүлж эхэлмэгц энэ нь Сибирьт суурьшсан Хятадын олон иргэдийн эсэргүүцэлтэй тулгарлаа. Хятадын тал иргэдээ цэргийн хүчээр хамгаалахын тулд Владивосток, Амурын сав газар, дорнод Сибирийн бусад чухал хэсгийг эзлэн авав. Төв Сибирьт Хятад, Оросын цэргүүд байлдаж эхэлмэгц өмнө нь Хятад өөрийн "протекрат"-аа нэгэнт болгосон Монголд эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөв" гэж бичжээ.²⁰³ Энэ бол Хантингтон соёл иргэншлийн хэзээ нэгэн цагт болох ирээдүйн мөргөлдөөнийг зурагласан хэрэг. Энэхүү төсөөлөл нь далайн чанадад амьдардаг, өрнөдийн нэг л эрдэмтний хийсвэр бясалгал гэж үл хэрэгсэж болох ч Орос, Хятадын харилцааны түүхэн өрнөл, өнөөгийн болон хэтийн төлөвийг судалдаг газар газрын эрдэмтэд Орос-Хятад-Монголын харилцааны агуулга-төлөвийг дээрхээс онц ялгарахгүйгээр дүрсэлсээр байдаг нь хоосон бясалгал уу, хоцрогдсон үзэл бодол уу; эсвэл шинжлэх ухааны алсын хараатай дүгнэлт гэх үү?²⁰⁴ гэсэн эрдэмтний дүгнэлт энэхүү сценарын үүсэж болох агуулгатай шууд холбогдож байна.

Оросын судлаач Нартов Алс дорнодод Оросын геополитикийн дайсан бол Хятад мөн гэж үзээд "БНХАУ нь зээл, дэмжлэг авахын тулд ЗХУ-ын эсрэг өрнөдтэй холбоотон байсныг мартаж учиргүй, Хятадын хүн ам 2050 онд 1.5 тэрбумаас давж, тэдэнд шинэ газар нутаг хэрэгтэй болно, энэ нь зөвхөн умард зүгт л байна, Оростой найрсаг харилцаатайгаа ашиглан Хятад нь Монгол, Оросын Алс дорнод, Казахстанд чөлөөтэй маневр хийж байна, Мао Зэдун хан үндэстэн дөрвөн мянган жилийн өмнө бичиг үсэгтэй болсон байхад Оросууд

²⁰² Мөн тэнд.

²⁰³ Samuel P. Huntington "The Clash of Civilizations and the Remaking of World Order" Touchstone Book 1996, p.315

²⁰⁴ Р.Болд "Үндэсний аюулгүй байдал байдал: хэрэглэгчээс үйлдвэрлэгч болох замд" УБ 2012, т. 282

арьс нөмөрсөн зэрлэгүүд байсан гэж байсан нь их гүрний дээрэнгүй үзлийн илэрхийлэл мөн"²⁰⁵ гэж бичсэн нь мөн л мөргөлдөөн үүсэж болохын төсөөлөл юм.

Бидний дээр авч үзсэн АНУ болон Оросын “холбоотны сценар”-ын эхний хувилбарын Хятадын соёл иргэншилтэй холбоо бүхий үйл явц мөн энэ сценартай холбоотой нэг хувилбар юм.

Энэ хэсэгт үүсгэсэн сценарууд нь хамгийн муу сөрөг үр дагавартай хувилбараас хамгийн эерэг сайн үр дагавартай хувилбарыг хамарсан. Ийм сценаруудад хүргэж болзошгүй хэтийн төлөвийн үнэлгээг энэ чиглэлээр дагнасан судалгаа хийдэг эрдэмтэн судлаачдын үнэлэлт, дүгнэлт болон өнгөрсөн түүхэн үйл явц, өнөөгийн үүсээд буй нөхцөл байдлын шинжилгээн дээр тулгуурлан гаргасан ба сценарууд нь дараагийн хэсэгт Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвийн гадаад орчны нөлөөллийн шинжилгээг хийх суурь үндэс болсон.

НОМ ЗҮЙ

1. Аюулгүй байдал, стратегийн орчныг тандахуй. Аюулгүй байдал, стратеги тойм. Дугаар №14 2023/02 т.2
2. С.Буянцогтоогийн Г.Фүжий доктортой уулзаж хийсэн хувийн ярилцлага, 2018.
3. Бакланов П. Я., Романов М. Т. Стратегия развития Приморского региона: от прошлого к будущему. 2013.
4. Перспективы геополитической динамики и взаимодействия цивилизаций / Научные редакторы: Ю. В. Яковец, А. И. Агеев, Т. Т. Тимофеев. М.: МИСК, 2009. Ч. VII. .
5. Заккрытие Чимерики.К чему ведет противостояние США и Китая "Коммерсантъ" от 05.11.2018
6. И.Рэнчинханд. Трамп та юу хийгээд байна. MN Өнөөдөр, 2017.02.06, №030
7. Ц.Буянцогтоо. “Америк, Хятадын харилцаа: Дэлхийн шинэ хүйтэн дайн эхлэв үү?”. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл. УБ., 2018. №26 (36), х.46-56
8. <http://time.com/5306831/president-trump-wants-north-korea-to-give-up-nuclear-weapons-heres-just-how-hard-that-would-be/>
9. Chu K. Ball in Donald Trump’s court as Xi Jinping champions free trade at Boao Forum // South China Morning Post. 2018. April 14. URL: <http://www.scmp.com/news/china/article/2141754/ball-donald-trumps-court-xi-jinping-champions-free-trade-boao-forum>
10. Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018. 427 х.
11. <https://www.forbes.com/sites/johnmauldin/2018/10/01/why-who-will-win-doesnt-matter-in-this-trade-war/#79d0238980d6>
12. Stratfor- “2019 Annual Forecast” <https://worldview.stratfor.com/article/2019-annual-forecast-geopolitics-intelligence-global-risk>
13. Scott Tong- “Game theory suggests the trade war could last a long time” <https://www.marketplace.org/2018/10/25/economy/game-theory-suggests-trade-war-could-last-long-time>
14. Jack Ma: US-China trade war could last 20 years <https://money.cnn.com/2018/09/18/technology/jack-ma-trade-war/index.html>

²⁰⁵ Н.А.Нартов "Геополитика" Москва 2002, стр. 286

15. <http://news.sina.com.cn/z/rputinvcvchina/> 俄罗斯总统普京访华。
16. Samuel P.Huntington "The Clash of Civilizations and the Remaking of World Order"
Touchstone Book 1996, p.315
17. Р.Болд "Үндэсний аюулгүй байдал байдал: хэрэглэгчээс үйлдвэрлэгч болох замд"
УБ. 2012, т. 282
18. Н.А.Нартов "Геополитика" Москва 2002, стр. 286
19. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 2011.

3.2 Их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын хэтийн төлөв дэх Монгол Улсын аюулгүй байдлын болзошгүй хэтийн төлөв

Улс орны аюулгүй байдалд хамаарах геополитикийн хүчин зүйлст тухайн улс орны газар зүйн байршил болон эдийн засаг, улс төрийн хийгээд төр улс, нийгэм хүн ардын нууцлаг, хаалттай байх онцлог хүчин зүйлс хамаарах бөгөөд эдгээр нь тухайн улс орны аюулгүй байдлыг сэргийлэн хамгаалах нийгэм, улс орон, хүн амын эрх ашиг сонирхлыг тусган илэрхийлдэг болохыг бид нэгдүгээр бүлэгт онцлон тэмдэглэсэн билээ.

Газар зүйн байршил ба нөхцөл байдлаас шалтгаалах стратегийн хувьд:

Монгол Улс түүхийнхээ бүхий л үед өрнө, дорныг холбох гүүр, уулзвар зааг болсон өргөн уудам нутагтай (дэлхийн газар нутгийн 1-ээс илүү хувь) ч дэлхийн хоёр том гүрний завсар оршдог, далайд гарцгүй, газар зүйн байрлалаараа дэлхийн том гүрнүүдийн стратегийн сонирхлын онцгой объект болсоор ирсэн.

Ийм байршил нь бид хоёр хөршид нөлөө үзүүлж чадах гурав дахь орон зайг өөрийн оронд бий болгох зайлшгүй хэрэгцээг бий болгож байгаа юм. *Энэ нь үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлыг өвөрмөц байдлаар хөндөж, төрийн хар хайрцагны ухаалаг бодлогод тулгуурлан нөхцөл байдалтай уялдуулан стратегиа сонгохыг нөхцөлдүүлж байдаг.*


Манай улсын газар зүйн ийм өвөрмөц байршилтай холбоотой гуравдагч хөршийн талаарх бодлого, стратегийн онцлогийг эрдэмтэн “манай гуравдагч хөршийн бодлого бол мөнхийн хөршүүдийн дундах мөнхийн бодлого байх ёстой юм. Энэхүү бодлогод цаг хугацааны хязгаар тавих боломжгүй боловч ил гаргах, эрчимжүүлэх, эсвэл сааруулах, засварлах зэрэг ажлыг хийх боломжтой юм. Тэгвэл энэ бодлого ямар үед тодорч, ямар үед эрчимжиж, эсвэл саарч байх хязгаарыг бид тодорхойлох ёстой юм”²⁰⁶ гэж арга зүйн талаас нь тун оновчтой томъёолсон байдаг.

“Улсын тавилан байршлаасаа” хамаарах зүй тогтол нь стратегийн нэг чухал шинжийг байршил илэрхийлэхээс гадна байршил стратегийн нөхцөл болох бөгөөд нөхцөлөө дагаж стратегиа сонгож хэрэгжүүлэх ёстойг харуулж байна. Энэ хамаарлыг эрдэмтэн судлаачид зургаар харуулсныг зурагт үзүүлээ²⁰⁷.

Онцлон тэмдэглэхэд нөхцөлийг, ялангуяа цэрэг-стратегийн нөхцөлийг хүчирхэг улс холбоотнууд бүрдүүлж, стратегийн байршлаа тогтоодог бөгөөд зарим нь бүрдсэн нөхцөлийг ашиглаж стратегийн байршлыг эзэлдэг, нөгөө хэсэг нь нөхцөл өөрчлөгдөж боломж бүрдэхэд нь зохицох стратегийг сонгож болдог байна.

²⁰⁶ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2014. 142 х. Д.Мөнхтөрийн хэсэн үг: т. 92.

²⁰⁷ Ш.Паламдорж нарын Батлан хамгаалах стратеги. Онол, арга зүй, шинжилгээний бүтээл. УБ., 2017, 399 х., т.20



3.1 дүгээр зураг. Геостратегийн нөхцөл ба стратегийн байршилын хамаарал

Энэ нь манай улсын хувьд стратеги ихээхэн уян хатан шинж чанартай байх шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Эдгээр онцлогийг харгалзсан нэгдсэн бодлогыг Монгол Улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ”, “Туравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон бол Гадаад бодлогын үзэл баримтлалд "ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах”, “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улстай холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх”, “Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох”, “Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах”, “Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах” гэсэн нь “гуравдагч хөрш”-ийн бодлогоос гадна стратегийн шинжийг агуулсан хүрээг илэрхийлсэн байна.

Үндэсний тагнуулын академийн Тагнуул судлалын төвийн судалгаанаас харахад судалгаанд оролцсон иргэдийн 63 хувь нь Гадаад бодлогын үзэл баримтлалд “аль нэг улсыг тусгайлан нэрлэх нь зохимжгүй”, 21 хувь нь “маш зөв бодлого”, 16 хувь нь “манай улсад

ашиггүй бодлого” гэж хариулсан байна. Иргэд гуравдагч хөршийн бодлогыг дэмжиж байгаа ч зарим улсыг тусгайлан нэрлэсэн явдалд шүүмжлэлтэй ханддаг нь ажиглагдсан байна. Энэ нь нөхцөл, стратегийн байршилтай холбоотой дүгнэлт байна.

Аюулгүй байдлын гадаад орчны их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын хэтийн төлөвийн Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт үзүүлж болзошгүй нөлөөллийн төсөөлөл ба болзошгүй стратеги:

Геополитик нь орон зайд хяналтаа хэрхэн тогтоох талаарх мэдлэгийн тухай шинжлэх ухаан, энэ нь улс төрийн шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсэг гэж судлаачид нийтээр зөвшөөрөхийн зэрэгцээ харин түүний судлах зүйл болох "орон зай" гэдгийг хэрхэн авч үзэх талаар эдүгээ хүртэл мэтгэлцсээр байгаа юм. Ерөнхийдөө геополитикийг улс орны стратегийн чадавхад харилцан холбоотойгоор нөлөөлдөг газар зүй, түүх, улс төр болон бусад хүчин зүйлсийг судалдаг шинжлэх ухаан гэх болжээ.²⁰⁸ Геополитикийг зөвхөн том гүрний хувьд авч үзэх юм уу, тэгвэл жижиг, дунд улс гүрэнд геополитик ямар хамаатай юм, тэд ч бас амьдрах, оршин тогтнох орон зайн төлөө тэмцэлддэг нь зүй ёсны асуудал юм.

Монгол Улс геополитикийн аюулгүй байдлаа хангах аливаа тохиолдлын хувьд АНУ-ын Ази судлаач Скалапиногийн "Олон улсын харилцаанд Монголын хийх сонголт даан ч хязгаарлагдмал. Уудам газар нутаг, цөөн хүн амтай тус улс нь нэг бол Зөвлөлт нөгөө бол Хятадаас л хамаарна... Хятад нь нэг л өдөр тус улсыг дахин хяналтандаа авна гэдэг бодол Монголчуудын тархинд гүн суужээ. БНМАУ-ын удирдагчид хүчээр хятадчлагдсан БНМАУ-д буйгаас олон тооны монголчууд БНХАУ-д байдгийг мартагддаггүй байна. Гэхдээ Монгол нь үлдсэн бүхий л гүрнүүдтэй харилцах нь түүнд л ашигтай юм²⁰⁹ гэснийг санах ёстой юм.

Юуны өмнө дээр өгүүлсэнчлэн аливаа том сорилт тулгарахад Монгол Улс мөнхийн хоёр том хөршийнхөө хувьд нэг талыг дэмжсэн стратеги баримтлахгүй, гуравдагч хөршийн талаар зөв стратеги хэрэгжүүлэх шаардлага, нөхцөл бий болно. Бидний энэхүү бүлэгт авч үзсэн сценар бүхэн Монголд тулгарч болох хэтийн төлөвийн хувьд дотроо олон хувилбарт задарч болно.

А/. АНУ, Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн болзошгүй нөхцөлүүдийн хувилбарууд дахь Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөв ба гадаад бодлогын стратеги:

1. Энэ бүлгийн 3.1 зүйлийн АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын үед:

• *Хамгийн муу хувилбар нь Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх асуудлаас болж АНУ ба Хятадын хооронд хурцадмал байдал эрс нэмэгдэж, улмаар энэ нь зарим судлаачдын үзэж байгаагаар зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болно.* Олон улсын харилцааны хүндийн жин Азид, Евразид шилжих тусам Хятад-АНУ-ын харилцаа нь хүйтэн дайны үеийн Зөвлөлт-АНУ-ын харилцааг орлох төдийгүй хэтдээ олон улсын харилцааны хоёр туйл болох хувилбарыг зарим судлаач үгүйсгэхгүй байгаа юм. Кессинжер "БНХАУ хүчирхэгжихийн хэрээр АНУ-Хятад хоёр өрсөлдөх нь гарцаагүй гэхдээ энэхүү өрсөлдөөн хязгаартай гэдэг талаар хоёр тал тохиролцох хэрэгтэй" гэж байв.²¹⁰ Харин Хантингтон

²⁰⁸ Удирдлагын Академиас хэвлүүлсэн "Нээлттэй лекц: 2016-2017 оны хичээлийн жил", УБ ,2017 эмхтгэлд хэвлэгдсэн лекц

²⁰⁹ Robert Scalapino "Major Power Relations an Northeast Asia" The Asia Socierty 1987, p. 45-46

²¹⁰ "America's Role in Asia" The Asia Foundation 2015, p.112

үзэхдээ "өрнөдийн их зан, лалын тэвчээргүй байдал, хятадын ертөнц эдгээрийн харилцан үйлдлээс хамаатай аюултай мөргөлдөөн ирээдүйд гарах болов уу" гэжээ²¹¹.

Энэ тохиолдолд *Монгол Улс зэвсэгт мөргөлдөөн үүсгэсэн хоёр улсаас өөрсдийн байр суурийг дэмжихийг шаардсан дарамт шахалтад орох, түүнийг дагасан эдийн засаг, батлан хамгаалах тусламж, дэмжлэгийн хязгаарлалтад өртөх хэтийн төлөвийн магадлал өндөр байх болно. Түүнчлэн хоёр хөрш маань хэзээд бидний мөнхийн хөрш тэдгээртэй хүссэн хүсээгүй харилцаанд орохоос өөр аргагүй учир манай улсын аюулгүй байдлын хэтийн төлөв АНУ, Хятадын хоорондын зэвсэгт мөргөлдөөний үе дэх ОХУ-ын байр суурь болон мөн НҮБ-ын байр суурины хувилбараас шууд хамаарна. Үүнд:*

- Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа үргэлжилж, хэрэв НҮБ зэвсэгт мөргөлдөөнөөр бус, яриа хэлэлцээрээр асуудлыг шийдвэрлэх байр суурь баримтлах тохиолдолд *Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжих*, хэрэв НҮБ зэвсэгт мөргөлдөөнд Хятадыг буруутгасан байр суурь илэрхийлж, асуудлыг Хятадын талаас буулт хийж яриа хэлэлцээрээр шийдвэрлэхийг уриалах юм бол Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжвэл өмнөд хөршийнхөө зүгээс ноцтой дарамт шахалтад өртөх болно.
- Орос АНУ-тай түр холбоотны харилцаа тогтоох тохиолдолд Орос, Хятадын хоорондын харилцаа хурцдах ба *Монгол Улс НҮБ-ын байр суурь ямар байхаас хамаарахгүйгээр зэвсэгт мөргөлдөөнийг зөвтгөхгүй, аль нэгийг нь дэмжихгүй төвийг сахисан байр суурь илэрхийлэх.*
- Үүсэж болох хоёр стратегийн өрнөлийн үед зэвсэгт мөргөлдөөнд оролцогч хоёр гүрний аль алиных нь зүгээс өөрийгөө дэмжүүлэх шахалт, дарамт ирэх магадлал өндөр байх болно. Энэ тохиолдолд Монгол Улс НҮБ болон Орос, бусад орнуудын дэмжлэгт тулгуурлах.
- *Хоёрдахь хувилбар нь АНУ, Хятад хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэхгүйгээр худалдааны дайн улам гүнзгийрч, удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Монгол Улс аюулгүй байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, бүрэн эрхт байдлын хувьд том сорилттой нүүр тулгарна. Судлаачид чөлөөт эдийн засгийн онолын үүднээс худалдааны дайн аль аль талдаа ашиггүй. Тэр дундаа дэлхийн хоёр том гүрний хоорондын худалдааны дайн дэлхийн эдийн засгийг ч бүхэлд нь туйлдуулна. Ингэснээр гуравдагч орнууд ч хохирно гэж үзсэн байдаг. Тиймээс манай эдийн засгийн хөгжилд өндөр эрсдэл бий болно. Ийм нөхцөл үүсэхэд Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу ОХУ, Япон, Герман, Энэтхэг, БНСУ болон бусад улс оронтой тогтоосон нягт хамтын ажиллагаа, мөн хэрэв АПЕК-т элсэн орсон бол түүнтэй тогтоосон хамтын ажиллагаа худалдааны дайнаас ирэх геополитикийн дарамт, шахалтыг даван туулах гол стратеги байж болох талтай.*

2. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн *сценар 1 ба 2-ын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт дараах нөхцөлүүд бий болох магадлал өндөртэй.*

Нэг талаас Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулж, хоёр хөршийг төдийгүй Ази, Европыг холбох гүүр болох боломжтой байх. Үр дүнд нь эдийн засгийн зүүн коридор буюу Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам баригдснаар Монголын

²¹¹ Samuel P. Huntington "The Clash of Civilizations and the Remaking of World Order" Touchstone Book 1996, p.183

ашигт малтмал, ОХУ-ын бараа бүтээгдэхүүнийг БНХАУ-ын хамгийн том хоёр муж болох Ляонинг, Хэбэй мужийн зах зээлд богино хугацаанд хүргэх гарц бий болно²¹². Улмаар БНХАУ-ын Тяньжинь, ОХУ-ын Владивостокийн боомтоор дамжин далайд гарцтай болох буюу түүхий эдийг гуравдагч зах зээлд гаргах боломжтой болно. Хоёр хөршийн эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа тохиолдолд бүс нутгийн эдийн засгийн интеграцийн ард хоцрох, тээвэр, худалдаа, техник, технологийн хувьд хоцрогдмол байдалтай үлдэхгүйн тулд хоёр болон гурван талт урт хугацааны харилцан ашигтай хэлэлцээр байгуулах, экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд хүргэх тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх ачаа, тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх боломж байж болох юм.

Нөгөө талаас ухаалаг бодлого явуулахгүй бол Хятад улсын зүгээс өр зээлийн дарамтад орж болзошгүй хэтийн төлөв хүлээж буйг дараах баримтаас харж болно. “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд БНХАУ-аас их хэмжээний зээл авсан хөгжиж буй болон буурай хөгжилтэй улс орнууд зээлээ эргүүлэн төлж чадахгүйд хүрч “өрийн занга”-нд унах эрсдэл хүлээж байна. Вашингтоны Олон улсын хөгжлийн төвөөс (Center for Global Development) гаргасан судалгаагаар Монгол Улс Хятадын “өрийн занга”-нд унах өндөр магадлалтай 8 орны жагсаалтад Жибути, Малдив, Лаос, Монтенегро, Киргизстан, Пакистан, Тажикстан улсуудын хамтаар бичигдсэн байна²¹³. Мөн эрдэмтэн, доктор Р.Болд “Хэзээ ч юм ирээдүйд тохиох 1919 оныхтай адил хэрэг явдлын угтал нь Монгол, Орос, Хятадын 2015 оны “шинэ цагийн Хиагтын” гурвалсан тохиролцоо юм. Энэхүү тохиролцооны ойрын болон дунд хугацааны үр ашиг нь Монголын хөгжил, дэвшилд чухал ач холбогдолтой байж болно, харин хэтийн үр дагавар нь Монгол дахин “дагуул” улс болоход хүрнэ” гэсэн байна.

Б/. АНУ, Оросын хоорондын харилцааны хэтийн төлөвийн болзошгүй сөрөг сценар дахь Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөв ба гадаад бодлогын стратеги:

АНУ ба Оросын хоорондын харилцааны сөрөг сценар буюу “дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл хүчтэй болох” нөхцөлд АНУ өөрийн холбоотон Европын холбооны орнуудад Оросын нефть, байгалийн хийн экспортыг нь хязгаарлах бодлого явуулахаас гадна НАТО-гийн зүгээс Украйныг цэргийн гүрэн шиг болгох, цэргийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, түүний зэвсэгт хүчнийг өөрчлөн байгуулах ба сайжруулахад тусалж, Орос Украйны дайн улам сунжирч тэдний харилцаа улам хүйтэрнэ. Дайн Европын холбоог хамран өргөжих магадлал өндөр байгаа нь дэлхийн дайн гарах аюулыг бий болгож байна. Орос, Украйны асуудал яриа хэлэлцээрийн замаар шийдэгдсэн ч цаашид харилцаа хурцадмал хэвээр байх болно. Энэ сценартай холбоотой дараах таамаглалыг судлаач дайн эхлэхээс өмнө дэвшүүлсэн байдаг: “Украйны хямрал тэгэхээр XIX зууны нутаг дэвсгэрийн төлөөх дайралтаас илүүтэй XXI зууны нийлүүлэлтийн сувгийн геополитиктой холбоотой асуудал ажээ. *Урт хугацааны үр дагаврыг авч үзвэл Оросын азгүйдтэл холболт илүү сайтай барууны орнуудад ашигтай ч тусаж магадгүй. Ямагт мууг ёрлож, айдас хуруулж байдаг зарим сэтгүүлчид асуудлыг илүү гүн ухааж хардаггүй шүү дээ: Гэхдээ нутаг дэвсгэрийн “үрэлт” ч заримдаа шинэ урсгалыг бий болгодог. 1970-аад оны Хятад-Зөвлөлтийн “хагарал” Хүйтэн дайны үеийн*

²¹² Шинэ төмөр зам төсөл

²¹³ “Examining the debt implications from the Belt and Road Initiative <https://www.cgdev.org/publication/examining-debt-implications-belt-and-road-initiative-a-policyperspective>

хоёр том коммунист гүрний харилцааг царцааж орхисон ч энэ бүхний ачаар АНУ-ын хувьд Хятадтай харилцаа тогтоох үүд хаалга нээгдэж, энэ харилцаа нь хоёр орны тус тусдаа Оростой үүсгэсэн харилцаанаас хавьгүй давж гарсан билээ. Эдийн засаг нь муудаж явсан Крымыг (орлогыг нь нэмэгдүүлэхийн тулд Москвагаас мөрийтэй тоглоомын татваргүй бүс болгох шийдвэр гаргасан) эзэлж, Донбассын үйлдвэржилтийн үеэс балгас шахам болж үлдсэн газарт тулаан өрнүүлсэн үйлдлээрээ Орос нутаг дэвсгэрээ сөөмөөр ахиулж чадсан ч хэрэг дээрээ “жинхэнэ” Украйныг алдаж орхижээ. Учир нь энэ бүхний дараа Киев, баруунтай холбоо харилцаагаа улам бүр зузаатгаад байна. *Цаашилаад, Орос хийн нийлүүлэлтээ тасална гэж сүрдүүлж байгаа нь Европыг АНУ, Хойд Африкаас эрчим хүчний өөр эх үүсвэр хайхад хүргэж байна.* Украйн том тулаанд ялагдсан байж болох ч Европ хориод жилийн өмнөөс эхлээд байсан нийлүүлэлтийн сувгийн "олс татах тулаан"-д ялсан явдал боллоо шүү дээ.”²¹⁴ гэсэн нь Оросын байдал нилээд хүндэрч магадгүй төлөвийг илэрхийлж байсан байна.

Оросын зүгээс Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөтгөх магадлалтай. Энэ сценарт ОХУ ба АНУ-ын хоорондын зэвсэгт мөргөлдөөн үүсэх болзошгүй нөхцөлийг авч үзээгүй нь их гүрнүүдийн хоорондох тулгаралт бага магадлалтай гэж Америкийн судлаачид тооцсон байдгийг нэгдүгээр бүлэгт тэмдэглэсэн бөгөөд АНУ болон ОХУ-ын хооронд үнэний магадлал илүү өндөртэй, харин зарим судлаачид АНУ болон Хятадын хоорондын харилцааны хувьд Өмнөд Хятадын тэнгист зэвсэгт мөргөлдөөн гарна гэж таамагласнаас үзвэл энэ хоёр гүрний хувьд эргэлзээтэй төсөөлөл гэсэн дүгнэлт хийсэнтэй холбоотой.

Ийм нөхцөлд Монгол Улсад АНУ-ын зүгээс Оросын эсрэг хориг, хязгаарлалтын ажиллагаанд нэгдэх талаар шахалт үзүүлэх, манайд үзүүлж буй дэмжлэгээ зогсоох дарамт ирэх магадлал өндөр байх болно.

Монгол Улс Орос–Монгол–Хятад гэсэн эдийн засгийн коридороо хөгжүүлэх²¹⁵ талаар хоёр хөрштэйгөө хамтран ажиллахаас гадна гуравдагч хөршийнхөө бодлого, стратегид нөхцөл байдалтай нийцүүлэн тодотгол хийх нь зөв байж болох талтай.

²¹⁴ Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018. 427 х.

²¹⁵ 2014 онд Душенбед Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын Дээд хэмжээний уулзалтын үеэр 3 улсын тэргүүн нар анх удаа уулзаж Хятад-Орос, Монгол-Хятад, Монгол-Орос гэсэн хоёр талт хэлэлцээрүүд дээр үндэслэн Монгол-Орос-Хятадын гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хэлэлцээрт гарын үсэг зурсан. Тус уулзалтаар гурван талт хамтын ажиллагааны зарчим, чиглэл, хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойлсон. Тус хэлэлцээрээр 3 улсын төрийн тэргүүнүүд Хятадын Торгоны зам эдийн засгийн бүслүүр, Оросын Евразийн газрын гүүр, Монголын талын зам хөтөлбөрүүдийг харилцан уялдуулахаар тохиролцсон. 2015 оны 7 дугаар сард Төрийн тэргүүнүүд Оросын Уфа хотод хоёр дахь удаагаа уулзаж Орос-Монгол-Хятадын гурван талт хамтын ажиллагааны дунд хугацааны замын зураглалыг албан ёсоор баталгаажуулсан. “Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т 2016 оны 6 дугаар сард гарын үсэг зурсан нь “Нэг Бүс, нэг Зам”-ын хүрээнд байгуулсан анхны олон талт хамтын ажиллагааны хөтөлбөр болсон байна.²¹⁵ “Хөгжлийн зам” хөтөлбөр болон “Нэг бүс, нэг зам” санаачилгыг уялдуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг 2017 оны 5 дугаар сарын 11-нд байгуулсан. Монгол улсын засгийн газрын 2017 оны 5-р сарын 10-ний өдрийн 142-р тогтоолоор батлагдсан “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөрт:

- Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам барих
- Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45,3 км төмөр замыг барих
- Тавантолгой-Сайншанд-Хөөт чиглэлийн 892 км төмөр замын төслийг хэрэгжүүлэх
- Хөөт-Сүмбэр чиглэлийн 380 км төмөр замын төслийг эхлүүлэх
- Оюутолгой уурхайн салбарын 40,4 км төмөр замын төслийн эхлүүлэх

Олон улсын соёл иргэншил хоорондын харилцааны хэтийн төлөв дэх Монгол Улсын аюулгүй байдлын болзошгүй хэтийн төлөв, стратеги

Буддын шашинтай Монгол орон дэлхийн гурван том соёл иргэншлийн голд оршиж хойгуураа Христосын Ортодокс-Үнэн алдартны шашин бүхий Оростой, Өмнүүрээ Зүүн Азийн гол үзэл баримтлал болсон Күнзийн сургааль бүхий Хятадтай, баруунаараа исламын шашинт Казахстан, Хятадын Шинжаан уйгартай хиллэж байгаа нь *байршлын онцлогтой холбоотой манай улсын аюулгүй байдалд нөлөөлөгч бас нэг гол бөгөөд эмзэг хүчин зүйл болж байна.*

Энэхүү хүчин зүйлийн аюулгүй байдлын суурь өөрчлөлтөд нөлөөлөгч гол утга агуулга нь Америкийн нэрт улс төр судлаач С.Хантингтон "Иргэншил хоорондын мөргөлдөөн, шинэчлэгдэж буй дэлхийн дэг журам" гэсэн алдарт бүтээлээ 1996 онд хэвлүүлж, XXI зуун соёл иргэншилүүдийн мөргөлдөөний эрин болно хэмээсэн иргэншлийн зөрчлийн онолын дагуу улс үндэстнийг ойртуулах буюу эсрэгээр нь задрааж байдаг соёлын давуу байдлаар тодорхойлогдох болж, соёл иргэншил нь зөвхөн соёл түүхийн төдийгүй, мөн улс төрийн учир утгатай болж байгаад оршиж байна.

Хүн төрөлхтний хөгжлийн бүх үеийн турш улс түмэн бүр, түүнчлэн Монгол Улсын өөрийгөө тодорхойлох, мөн чанараа ойлгон тайлбарлахад соёл иргэншил гол хэрэглүүр болж ирсэн бөгөөд даяаршлын энэ эрин үед тусгаар тогтнолыг эмзэг болгох гол хүчин зүйл болж байна.

С.Хантингтоны бүтээлд соёл иргэншлийн талаар хэд хэдэн чухал санаа, зарчмын дүгнэлт агуулагдаж байгааг судлаач С.Одхүү өөрийн бүтээлд дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Түүхэнд анх удаа даяар бодлого нь олон туйлт болон янз бүрийн иргэншлийн хүрээг хамарч байна. Өрнөжих гэдэг нь орчин үежих гэдэг ойлголтоос өөр агуулгатай болохыг тэмдэглэсэн. Эдийн засгийн болон нийгмийн модернизаци нь өрнийн болон өрнийн бус нийгмүүдийг хослуулсан нэг нэгдмэл иргэншил болоход чиглэдэггүй.
- Иргэншил хоорондын харилцаа өөрчлөгдөж, өрнийнхөн давамгайл нөлөөгөө алдаж эхэллээ. Харин Азийн олон иргэншил эдийн засаг, цэрэг, улс төрийн хувьд улам хүчирхэгжиж байна. Өрнийн бус иргэншлүүд өөр өөрийн үнэлэмжээ хүчтэй ухамсарлан дээдлэх боллоо. Хүйтэн дайны дараах ертөнцөд соёл нь нэгдэх, туйлшрах аль аль хүчин зүйл болж байна. Үзэл суртлаараа зааглагдсан ч соёлоороо эргэж нэгдэж байгааг хоёр Германы нэгдэл, хоёр Солонгосын хамтын ажиллагаанаас харж болно.
- Иргэншлийн үнэлэмж дээр суурилсан дэлхийн дэг журам бүрэлдэж эхэллээ. Иргэншлийн нэг гарал үүслээр холбогдсон нийгмүүд хоорондоо нэгдэн нягтарч, харилцан хамтрах боллоо. Ийм нийгмийг нэг иргэншлийн хүрээнээс өөр хүрээнд оруулах оролдлого бүтэшгүй юм. Иргэншлийн хувьд гол цөм, хүчирхэг улсаа тойрон хүрээлсэн хамтлаг бий болж байна.
- Иргэншил хоорондын мөргөлдөөн нь улс орнуудыг үл ойлголцох байдалд хүргэж, энэ нь ялангуяа исламын болон Хятадын иргэншил дээр тодорхой ажиглагдах боллоо.

- Хөөт-Бичигт чиглэлийн 234 км төмөр замын төслийг барьж дуусгах ажлыг тус тус тусгасан.

- Өрнөдийнхөн өөрийн иргэншил нь давуу талтай ч нийтийг хамарсан шинжтэй биш гэдгээ хүлээн зөвшөөрч, өрнийн бус бусад иргэншлээс тулгарах саадыг хэрхэн давж гарахаас иргэншлүүдийн ирээдүй хамаарах болж байна. Хүчирхэг гүрнүүд дэлхийн бодлого тодорхойлохдоо янз бүрийн иргэншлийн үнэлэмжийг харгалзан үзэж, харилцан ойлголцож, хамтран ажилласан нөхцөлд л дэлхий дахиныг хамарсан даяар асуудлуудыг шийдвэрлэж чадах болно.

Дэлхийн улс орнуудын хөгжил, сөргөлдөөний ийм чиг хандлага тогтсон өнөө үед энэ нь гурван том соёл иргэншлийн дунд оршин тогтнож буй манай улс үндэснийхээ эрх ашгийн төлөө анхаарвал зохих бодлогын амин чухал асуудал юм. Тиймээс ч Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс амин чухал дархлаа мөн” болохыг заасан байна. Чухамхүү үндэсний хэл, соёл иргэншлийн хувьд уусахгүй, ухамсрын хэв шинж, түүний дотор сэтгэлгээ, хэл соёлын нэгдмэл байдлаа бэхжүүлэх нь Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа хангаж, даяаршлын энэ эрин үед оршин тогтнохын нэг үндэс юм.”

АНУ, Оросын соёл иргэншил хоорондын харилцааны хэтийн төлөвийн сценариуд дэх Монгол Улсын аюулгүй байдлын болзошгүй хэтийн төлөв стратеги:

А/. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Хятадын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцааны” сценар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд ихээхэн зөрчилтэй нөхцөл байдал үүснэ. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт нэгд, АНУ ба Оросын харилцаанаас хамаарахгүйгээр соёл иргэншлийн хувьд Хятадад уусаж устах аюул заналын эрсдэл, хоёрт, хоёр хөршийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй дарамт, шахалтууд илрэх болно.

*Аливаа улс орон дэлхийд байр сууриа эзлэхэд улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, батлан хамгаалах зэрэг хатуу хүч чухал байр суурийг эзлэх хэдий ч нөлөө бүхий зөөлөн хүчгүйгээр улсын нийт хүч буюу бусдыг дагуулах, өөртөө итгүүлэн үнэмшүүлэх хүч дутах юм. Энэ ойлголтыг хятадын нэрт сэтгэгчийн болоод одоог хүртэл олон мянган жил дагаж мөрдөж төрийн бодлогын суурь болгож байгаа уламжлалт арга барил нь аливаа зүйлийг хүчээр бус аль болох аядуу бусдыг дагуулах, түүнийг тухайн зүйлд итгүүлэн дагуулах нь хамгийн зөв зүйтэй гэж үздэг байжээ. *Эртний хятадын ойлголтоор хүмүүний ямар угсаатай, эсвэл хаана төрсөн зэрэг нь гол бус, харин уул хүмүүн хятад соёлыг хэр зэрэг өөртөө шингээж авсан гэдэг нь шийдвэрлэх зүйл юм. Хэн нэг харь хүмүүн хятадын соёл иргэншлийг хүлээн авч, өөрийн болгож, түүний дагуу амьдарч буй бол тэр хүмүүн хятад хүн болно.*”²¹⁶ хэмээжээ.*

Хятадын түүх шастирт “Аливаа нэг улсыг мөхөөсүгэй хэмээвээс анх түрүүнд түүхийг нь устгаваас зохилтой” хэмээн өгүүлсэн байдаг нь түүхийг нь устгахын тулд юуны өмнө түүнийг өртөөлөн тээгч болох хэл соёлыг устгах санааг агуулж буй юм.

Аливаа хүчирхэг гүрэн, дэлхийн бодлогыг тодорхойлогч их гүрнүүд түүхэн тодорхой үед олон улсын харилцааг тодорхойлж байхдаа өөрийн соёл иргэншлийн хэм хэмжээнд бусдыг тэнцүүлэх, бусад улс орныг уях бодлого явуулсаар ирсэн. Өнөө үед Хятадын хүн ам нутгаасаа хальж Ази, Европ, Америк тивийг дүүргэх хандлагатай байна.

²¹⁶ Конрад зайц” Хятад дэлхийн гүрэн эргэн ирж байна” УБ., 2009., 70х

Энэ нь Төв Азийн орнууд болон Оросоор дамжин Европод нөлөөлөх их гүрний бодлого хэрэгжиж байгаагийн илрэл юм. Түүнчлэн соёлд даяаршлын үзүүлэх нөлөөлөл нь улс төрийн явцуу утгаар үзвэл дэлхийн олон ард түмний үндэсний ухамсрыг соёл-оюуны довтолгоогоор дарах гэсэн алсын зорилготой их гүрний улс төрийн бодлого, үзэл суртлын зэвсэг болж байна.

Ийм хандлага, нөхцөл нь 1 тэрбум 292 сая хүн амтай Хятад улстай 4000 гаруй километр газраар хиллэдэг 3 сая хүн амтай Монгол Улсын хүн ам, удмын сан, соёл иргэний аюулгүй байдлын хэтийн төлөвийг ихээхэн эрсдэлтэй болгож байна.

Судалгаанаас үзэхэд үндэстэн мөхдөг нэг хүчин зүйл нь үндэстний хэл соёл мөхөх явдал юм. Шалтгаан нь “ихэнх цөөн харилцагчтай хэл нь өвөг дээдсийнхээ хэл соёлыг нийгэм, эдийн засгийн өнөөгийн байр суурьтай уялдуулан авч явж чаддаггүй, өөрсдийн хэлний хэрэгцээ, шаардлага, үнэ цэнийг ч төдийлөн сайн ойлгодоггүй эсвэл ялгаварлан гадуурхах үзлээс шалтгаалан үр хүүхдийнхээ амьжиргааг бэхжүүлэхийн тулд эх хэл, соёлоо алдаж, гадны халдлагад өртөх нь элбэг байдаг байна. Хэл нийгмийн асуудал учраас хэлний мөхөл ч мөн цэвэр нийгмийн асуудал гэж үзэх талтай ба хэлний даяаршил нь хэлний мөхлийг дагуулж байдаг учраас нийгмийн харилцаанд төдийлөн идэвхтэй оролцдоггүй жижиг хэлнүүд нь том хэлэндээ уусаж мөхдөг байна.”²¹⁷

Доктор Т.Өсөхжаргал монгол хэлний амьдрах чадварын шинжилгээг олон улсад хэрэглэдэг Фишмэн, ЮНЕСКО 2003, ЮНЕСКО 2009, Паул Левайс, Майкл Краус, Левайс, Саймон зэрэг 6 шалгуураар хийсний үндсэн дээр “Монгол хэл үндсэн хуулиар баталгаажсан нэгдүгээр түвшингийн, амьд хэл боловч амьдрах чадварын хувьд эрсдэлтэй” байгааг тогтоогоод “Монгол хэлний амьдрах чадвар эрсдэлтэй байгаа нь хэл соёлын аюулгүй байдлын дархлаа бүрэн бий болж чадаагүй, хэл соёлын бодлого, арга хэмжээ дутагдалтай байна.”²¹⁸ гэсэн дүгнэлт хийжээ. Хэл, соёлын шүтэлцээг харгалзан үзэх юм бол хэлний мөхөл соёлын мөхлийг дагуулж, хэл соёлын мөхлийг бий болгодог байна. Т.Өсөхжаргал энэ зүй тогтлын дагуу хэл соёлын аюулгүй байдлын дархлааны үнэлгээг зургаан гол үзүүлэлтээр хийснийг 6 дугаар хавсралтад үзүүлээ. Түүний судалгаа “манай улсад “гадны хэл соёлын түрэлтийн аюул “маш их”, хэл соёлын аюулгүй байдлын зорилтод үүргүүдийн хэрэгжилт бүгд эмзэг бөгөөд ихэнх нь “маш эмзэг” байгаа нь эрсдэл бол аюул, эмзэг байдал хоёрын харилцан үйлчлэлийн үр дүн байдаг зүй тогтлын дагуу “их аюул” ба “маш эмзэг” байдал хоёрын харилцан үйлчлэл хэл соёлын аюулгүй байдлын дарлааг “өндөр эрсдэлтэй” байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, манай улсын тогтвортой хөгжих оюуны суурь бөгөөд оюуны өв соёл, соёл ба үндэсний үнэт зүйлийг гадны хэл соёл нэвтрэн эзлэхээс сэргийлэх болон улс орны соёлын бат бэх байдал, уламжлах чанарыг хамгаалан авч үлдэх бодлого, үйл ажиллагааны үр дүн болох хэл соёлын аюулгүй байдлын дархлаа тогтоогүй “өндөр эрсдэлтэй” байгааг” харуулсан байна.

Эндээс манай улсын соёл иргэний аюулгүй байдлын хэтийн төлөвийн дархлаа цаашид гадны хэл соёл (ялангуяа хятад)-ын түрэлтийн талаар цогц бодлого авч хэрэгжүүлэхгүй бол улам доройтох дүр зураг харагдаж байна. Ийм нөхцөл байдал зөвхөн энэ сценарт хамаарах бус бүхий л сценарын үед ажиглагдах магадлал

²¹⁷ Ж.Бадамсүрэн “Монголчуудын нутгийн аялгуут хэл хамгаалах бодлогын хүрээнд судалсан нь”, УБ., 2014, 130 х., т. 17-18

²¹⁸ Т.Өсөхжаргал. “Монгол хэл соёлын дархлаа бий болгох зарим арга зам” сэдэвт аюулгүй байдлын ухааны докторын диссертац. УБ., 2016

өндөр байна. Харин энэ сценарын үед манай улс Орос, АНУ болон НҮБ-ын дэмжлэгтэйгээр төвч байр суурь баримталж болох таамаглал байна.

Гуравдагч орны хувьд: Хантингтон БНХАУ-ын нөлөө нэмэгдэхийн хэрээр Азийн улс орнууд түүнийг дагаж дараах байдлаар ханарах болно гэжээ. Үүнд:

- Хятадаас цагаачид ирэхийг нэг их хорихгүй;
- Хятадын эсрэг чиглэсэн хөдөлгөөнийг улс орондоо хориглох эсвэл дарах;
- Хятадын эсрэг чиглэсэн эвсэл, холбоонд нэгдэхгүй байх;
- Мандарин хэл хэрэглэхийг өргөтгөн улмаар англи хэлийг халж, дорнод Азид хэрэглэх үндсэн хэрэглүүр болгох;
- Өмнөд Хятадын тэнгис болон Монголд бүрэн эрхээ тогтоохыг дэмжих²¹⁹ гэсэн таамаглал дэвшүүлсэн байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Б/. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцааны” сценар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх магадлал өндөр байна. Монгол Улсын аюулгүй байдлын хувьд өөрийн үндэстний цөөнхийн талаар оновчтой бодлого явуулах, гаднаас дүрвэгсэд орж ирж болзошгүй нөхцөлд бэлэн байх, терроризмын аюул заналаас сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлага гарна. Хоёр хөрш гүрэн болон гуравдагч оронтой харилцах бодлого хэвийн үргэлжлэх болно. НҮБ-ын байр суурийг дэмжинэ. Гэхдээ ОХУ ба АНУ-ын Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн энэ холбоотны харилцааны зэрэгцээ АНУ Хятадын цэргийн хүч чадал, ялангуяа пуужин цөмийн зэвсгийн хүч нөөц өсөн буйг тогтоон барихын тулд ОХУ-ын нөлөө, хүчин зүйлийг ашиглах оролдлого хийж буйг Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх Ж.Болтоны 2018 оны 10 дугаар сард Москвад хэлэлцээ хийсний дараа “АНУ, ОХУ-тай Хятадын дайсагнасан явуулгын талаар стратегийн яриа хэлэлцээ хийх сонирхолтой байна. Хятадын пуужингуудын тусгалын бүсэд “Оросын цөм зүрх” багтаж буй тул тэдний пуужингийн потенциал Орост ч аюул занал учруулах болно.”²²⁰ гэж мэдэгдсэнээс харж болно. Хэрэв ийм байдал биеллээ олж эхэлбэл дээрх А болон ОХУ, Хятад хоорондын харилцааны Б сценарын нөхцөл Монголд тулгарах болно.

В/. Оросын засагт оросын үндэсний эрх ашиг сонирхол ба орос соёл иргэншлийн үнэт зүйлсийн системтэй зөрчилдсөн (XX зууны 90-ээд оны эхний хагаст ийм явдал Орост үндсэндээ тохиолдсон) АНУ-ын аливаа нөхцөлүүдийн хараат хамтын ажиллагаанд бэлнээр нээлттэй хандсан эрх барих бүлгүүд гарах. Ийм сценар үүсвэл *Орос, АНУ хоёр Хятадад хамтарч дарамт, шахалт үзүүлэх ба Орос, Хятадын хоорондын харилцаа эрс хүйтэрнэ. Стратегийн чухал байршилтай манай улсад аль аль талаас нь дарамт, шахалт ирнэ.*

Орос улсад Америкийн талыг баримтлагчдыг эсэргүүцсэн хүмүүс болон эрх баригч талын хоорондох дотоодын зөрчил хурцдаж болно. Мэдээжээр Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорын асуудал зогсонги байдалд орно.

Г/ Дэлхийн хүчний харилцаа бусад улс орнуудтай реалист, шударга харилцаа руу болон өөр (тэгш г.м) зарчмуудын үндсэн дээр олон улсын харилцааг бодитоор

²¹⁹ Samuel P. Huntington “The Clash of Civilizations and the Remaking of World Order” Touchstone Book 1996, p.183

²²⁰ Закрытие Чимерки. К чему ведет противостояние США и Китая “Коммерсант” от 05.11.2018

босгох бэлэн байдал руу өөрчлөгдөх нөлөөлөл дор АНУ-ын засгийн эрх баригчид аажим хувьсах. Ийм сценарын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт ихээхэн таатай нөхцөл байх болно. Улс орнуудтай өргөн хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэх, тогтвортой хөгжих хэтийн таатай нөхцөл бүрдэнэ.

Гэхдээ ийм сценарын үед ч барууны соёл иргэншилтэй бусад соёл иргэншлийн зөрчилдсөн үйл явц өрнөх магадлалтай. Тухайлбал, шинжээчдийн үнэлгээгээр: даяаршлын эрх ашгууд бараг бүх (Япон болон бусад соёл иргэншлийг тооцохгүйгээр) соёл иргэншлийн эрх ашигтай нийцэхгүй, ялангуяа исламын соёл иргэншилтэй 100 хувь, оросын соёл иргэншлийн эрх ашигтай 66,7 хувь давхцахгүй байгаа; барууны соёл иргэншилтэй Үндэстний эрх ашгууд ба үнэт зүйлсүүдийн хоорондын харьцаанууд ихээхэн нийцгүй, тухайлбал ислам, хятад, оросын соёл иргэншлүүдийн хувьд 100 хувь, энэтхэг, африкийн соёл иргэншлүүдийн хувьд 66,7 хувийн нийцгүй байна.

ОХУ, Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн сценарууд дахь Монгол Улсын аюулгүй байдлын болзошгүй хэтийн төлөв стратеги:

А/. ОХУ ба Хятад хоорондох иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хэвийн үргэлжлэх сценарын үед Монгол Улсад Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хоёр хөршийн болон “гуравдагч хөрш”-ийн талаар баримтлах ухаалаг бодлого явуулбал аюулгүй байдлын хэтийн төлөв ихээхэн эерэг төсөөлөлтэй байна.

Хятадын “Нэг бүс ба нэг зам” стратегийн хүрээнд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорыг төлөвлөлтийн дагуу хөгжүүлэх боломж байна.

Харин энэхүү хамтын ажиллагаа юунд хүргэж болзошгүй хэтийн төлөв байгаа талаар доктор Р.Болд “*Хэзээ ч юм ирээдүйд тохиох 1919 оныхтай адил хэрэг явдлын угтал нь Монгол, Орос, Хятадын 2015 оны “шинэ цагийн Хиагтын” гурвалсан тохиролцоо юм. Энэхүү тохиролцооны ойрын болон дунд хугацааны үр ашиг нь Монголын хөгжил, дэвшилд чухал ач холбогдолтой байж болно, харин хэтийн үр дагавар нь Монгол дахин “дагуул” улс болоход хүрнэ.*”²²¹ гэсэн таамаглал дэвшүүлсэн нь анхаарал татаж байна.

Ийм байдалд хүргэж болзошгүй төлөвийн талаар мөн гадны судлаач “Монголчууд бараг бүх түүхий эд материал нь Хятад руу явдгийг, улс төр эдийн засагт нь Хятадын нөлөө улам ихсэж байгааг мэддэг хэдий ч энэ талаар ямар дорвитой арга хэмжээ аваагүй ажээ. Хятадын компаниуд Монголын нөлөө бүхий албан тушаалтнуудыг авлигадаж, хайгуулын лицензээ нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн жижиг компаниудыг өч төчнөөнөөр нь худалдан авчээ. Ашигт малтмалын экспорт огцом өсөж байх үед Монгол улс дэд бүтцээ сайжруулах дорвитой алхмыг хийгээгүй бөгөөд тэрхүү өсөлтийн дараа түүхий эд, ашигт малтмалын үнэ Хятадын нөлөөгөөр навс унахад Монгол улс дэд бүтцийн төслүүддээ Хятадаас хөрөнгө оруулалт хайхаас аргагүйд хүрчээ. “Петро-Чайна” компани одоо Монголын газрын тосны хайгуулын салбарт тэргүүлж байгаа бол “Шэнхуа” хэмээх Хятадын нүүрсний томоохон компани төмөр замын төсөлд хөрөнгө оруулж байна. Энэ бүхэнтэй зэрэгцэн умард- өмнөдийг холбосон “Талын зам” нэртэй шинэ төслөөр Хятад-Оросыг холбох ажил ч ид яригдаж байна. Монгол улс гуравхан сая хүн амтай боловч энэ

²²¹ “XX зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд” УБ 2017 номонд хэвлэгдсэн өгүүлэл

орны уул уурхайн салбарт нь бараг зургаан мянган километр урт төмөр зам хэрэгтэй. Монгол улс хэдийгээр Зөвлөлтийн үеийн өргөн царигт төмөр зам ашиглахаар шийдээд байсан ч, 2014 онд Засгийн газраас гэнэт дэлхийн хамгийн том нүүрсний орд Тавантолгой болон шинээр баригдах бусад уурхай руу тавих шинэ төмөр замаа Хятадын нарийн царигаар тавина гэдгээ мэдэгджээ. Энэ бол улс орныг эзлэн түрэмгийлэхгүйгээр худалдан авах арга шүү дээ. Хятадын хөршүүд энэ үзэгдлийн гол бай нь болж байна. Далайд гарцгүй орнууд газарзүйн хувьд "хоригдол" шиг л байдаг, түүнээс мултрах ганц арга нь дэд бүтэц. Гэхдээ ийм орнуудын дэд бүтэц хөрштэйгөө хэр холбогдохоос хамаарах учир, ийм улсууд бүрэн хараат бус байх аргагүй. Тэгэхээр асуудлын гол нь түүнийг хэн эзэмшиж, хэн ашиг олох вэ гэдэгт оршдог.

Украин дахь Газпромын хийн хоолой шиг, Хятад өөрийн хилийн зурвасаас гадна дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэхдээ "бүрэн эрхт байдлаа тэлж байна" гэж үздэг. Өөр оронд хөрөнгө оруулагч, хөрөнгийн эзэн, нийлүүлэлтийн сувгийн гол тоглогч нь болсноороо Хятад улс тухайн улсын зах зээлд давуу эрхтэйгээр нэвтэрч, байгалийн баялгаа хэрхэн ашиглах талаарх стратегийн шийдвэр гаргах үйл явцад яалт ч үгүй харгалзах гол хүчин зүйл болно. Хятад үзэл суртлаа бусад улсад тулгахгүй ч дэд бүтцийн холболтоороо улс орнуудыг өөртөө чөдөрлөж байна.

Ер нь Хятад улсын зүгээс манайх руу хандаж буй хэтийн хандлагын ерөнхий зураглалыг БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Дэлхийн эдийн засаг, улс төрийн бодлогын хүрээлэнгийн олон улсын стратегийн тэнхимийн эрхлэгч Сун Ли "хөршүүдээ" ач холбогдлоор нь дөрөв ангилж, тэдэнтэй харилцан адилгүй харилцах зарчмыг тодорхойлноос харж болно. Үүнд:

нэгдүгээрт, салбар бүс нутгийн их гүрнүүдтэй (Орос, Австрали, Казакстан, Япон, Энэтхэг, Вьетнам, Индонез) "тэнцвэржүүлэх хамтын ажиллагаа явуулах" зарчмаар,

хоёрдугаарт, салбар бүс нутгийн хоёрдугаар зэргийн гүрнүүдтэй "чин сэтгэлийн гэхдээ хязгаарлагдмал дэмжлэг үзүүлэх" зарчмаар,

гуравдугаарт, Хятадтай нягт харилцаатай салбар бүс нутгийн жижиг, дунд улсуудтай (БНАСАУ) "баталгаа өгөхгүйгээр бүхий л дэмжлэг үзүүлэх" зарчмаар,

дөрөвдүгээрт, бусад жижиг, дунд улсууд (Монгол), эдгээртэй "тодорхой салбар, аргачлалаар хязгаарлагдсан хамтын ажиллагаа"-ны зарчмаар тус тус харилцана гэжээ.²²² Тэрээр Оросыг зөвхөн бүс нутгийн гүрэн гэж үзэн, төслийн хүрээнд Казакстан, Вьетнамд тэргүүлэх ач холбогдол өгөх, БНАСАУ-ыг Монголоос дээгүүр авч үзэх, харин Монголтой бол хязгаартай, үзэмжээрээ харилцах зарчмыг дэвшүүлсэн байгааг доктор Р.Болд онцолсон байна.

Иймэрхүү хэтийн төлөвөөс сэргийлэх бодлого талаас харвал философич, эрдэмтэн Б.Даш-Ёндон гуай бичихдээ "Монгол өөрийгөө оюуны хувьд оношилвол дараах дэвсгэрийг анзаарах ёстой, эдүгээ дэлхий дахинаа "цусгүй дайн" буюу ноцтой өрсөлдөөн болж байна, энэ өрсөлдөөнд дэлхийн бүх улс орон татагдан оров. Эл өрсөлдөөний гол агуулга нь:

а.) Цөөн хэдэн их гүрэн дэлхий дахинд манлайллаа тогтоох гэж хоорондоо алсын ухаангүй өрсөлдөж байгаа;

²²² Xue Li and Zheng Yuwen "A Blueprint for China's Neighborhood Diplomacy" The Diplomat March 30, 2016

б.) Жижиг буурай орнууд тэсэж үлдэхийн төлөө тэмцэлдэж байгаа;

с.) Дунд зиндааны улс орнууд чадвал их гүрэн болох, ядвал одоогийн хүч чадлаа хадгалж, доошоо орчихгүйн төлөө тэмцэж байгаа зэрэгт оршино. Ийм нөхцөлд монголчууд бид оршин тогтнохын төлөө, тэгэхээр хөгжихийн төлөө, ингэхлээр үндэсний аюулгүй, улс орныхоо тусгаар тогтнолыг бүх талаар хамгаалан бататгахын төлөө тодорхой ямар бодлого баримтлах ёстойгоо боловсруулах шаардлага тулгарч байна”²²³ гээд "Ер нь олон улсын тавцан дээр ч гэсэн зөвхөн дундаж бодлого л бие даасан бодлого болж чадна гэдгийг анхаарах нь зүйтэй. Дэлхийн их гүрнүүд, бусад томоохон гүрнүүдийн өрсөлдөөн дундаас Монгол Улс өөрийнхөө сонирхолд нийцэхийг нь судлан олж голлон харгалздаг байх нь нэн чухал юм”²²⁴ гэж онцолсоныг болон доктор, профессор У.Уламбаяр "гуравдагч хөрш"-ийн бодлогоо хэрэгжүүлэх гадаад орчин 1990-ээд оноос үндсээрээ өөрчлөгдсөнийг харгалзах ёстой гэсэн дүн шинжилгээ хийгээд “нэг туйлт дэлхийн дэг журам зонхилж байх үеийн "гуравдагч хөрш"-ийн бодлого бол нэг хэрэг, харин эдүгээ олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвшиж байгаа энэ үед "гурвалсан хөршийн" бодлого, "гуравдагч хөрш"-ийн бодлогын хоорондын тэнцвэрийг зөв барих явдал чухал”²²⁵ гэж үзсэн нь энэхүү сценар болон бусад сценарын үед бодолцох чухал санаа юм.

Эндээс хоёр хөрш гүрэн хоорондоо найрсаг хамтын ажиллагаа өрнүүлж байх таатай сценарын үед ч Монгол Улсын бүрэн эрхт байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх аюул занал (эрсдэл) оршин байхыг харуулж байна.

Мөн цэрэг-улс төрийн хувьд Ази, Номхон далайн бүс нутагт улам бүр өсөн нэмэгдэж буй АНУ-ын цэрэг-улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах үүднээс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин үүний үр дагавараар НАТО, АНУ болон ШХАБ-ын хооронд бие биеийн эсрэг хүчээр заналхийлсэн зөрчил, сөргөлдөөн үүсэж үүнд Монгол Улс татагдан орох аюул занал (эрсдэл) болзошгүй юм.

Б/ ОХУ ба Хятад хоорондын зөрчилдөөний зэвсэгт мөргөлдөөн хүргэж болзошгүй сценарын Монгол Улсад “хадны дунд хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий” гэдэг шиг хоёр хөршийн аль аль талаас нь өөрийн талд орохыг шаардсан хүнд дарамт, шахалт ирнэ.

Монгол нь том л газар нутагтай болохоос биш газар зүйн ашиггүй байрлалтай, стратегийн ач холбогдол нь хоёр хөршид л хэрэгтэй болохоос биш бусдад багахан үүний улмаас олон улсын бодлогод тоглолт явуулах сонголт нь ч хязгаарлагдмал болох нь энэ сценарын үед харагдана. Монгол Улс сөргөлдөгч хоёр талын аль нэгнийх нь талд татагдан орох аюул занал тулгарна. Ийм сценарын үед төвийг сахих оролдлого хийх нь хөрш хоёр гүрний зүгээс дэмжлэг авахгүй байх болно. Харин Д.Тренин "Монгол нь эдүгээ Орос, Хятадын хооронд төвийг сахисан буфер болжээ. Хятад нь бүс нутагтаа хүчирхэг гүрэн болох тусам Улаанбаатар нь Москва болон өөртэй нь улам ойртож буй Бээжингийн хооронд туйлын хянуур хөвөх шаардлагатай болно. Орос нь Алс дорнодод хилийн стратегиа

²²³ Б.Даш-Ёндон “Нийгмийг танихуй:түүх-хөгжлийн философи” УБ. 2014, т.224-226

²²⁴ Мөн тэнд, т.267

²²⁵ У.Уламбаяр "Монгол Улсын гадаад бодлогод "гуравдагч хөрш"-ийн бодлогын эзлэх орон зай, ач холбогдол"" "Монгол Улсын гадаад бодлогын лаборатори төсөл"-ийн хүрээнд болсон эрдэм шинжилгээний семинарт тавьсан илтгэл УБ. 2017.05.01

хөгжүүлэхдээ энэхүү байдлыг анхааралдаа авахад хүрнэ"²²⁶ гэсэн байдаг болон Дорнынхон ОХУ-ыг аюул заналхийлэл гэж нэг их үздэггүй логикоос харвал энэхүү сценарын үед Монгол нь ОХУ-тай цэргийн холбоотны харилцааг сэргээх магадлал байж болох талтай. Доктор Р.Болд ийм төлөв байж болох талаар тэмдэглэсэн байна.

Монгол Улсын гадаад орчны их гүрнүүдийн хоорондын харилцааны хэтийн төлөвтэй холбоотой эдгээр сценаруудаас гадна нэр хүнд бүхий геополитикийн онолчид олон янзын таамаглал дэвшүүлсэн байгааг манай улс “хар хайрцаг”-ныхаа бодлогод харгалзан үзэх шаардлага ч байж болох юм. Тухайлбал, 2020 онд бий болох манай эргэн тойрны төлөв байдал болон түүний үзүүлэх нөлөөллийн талаар АНУ-ын геополитикч З.Бжезинский:

ОХУ суларсаар доорх 3 холбооны улсуудын Холбооны шинэ улс болно:

- Европын хэсгийн Орос;
- Сибирийн БНУ;
- Алс Дорнотын БНУ.

Хятадын нөлөө тэлсээр түүний хилийн ойролцоох Монголыг оруулаад 20 улс хамарсан "Их Хятадын" орон зайг бий болно гэсэн таамаглал дэвшүүлсэн.

Үүнээс гадна тэрээр Евразид 2020 он гэхэд геополитикийн дараах 3 том цагариг үүснэ гэсэн байна. Үүнд:

- Их Хятадын;
- АНУ-Япон;
- Атлантист Европын гэж хуваасан байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2014. 142 х. Д.Мөнхтөрийн хэлсэн үг
2. Ш.Паламдорж нарын Батлан хамгаалах стратеги. Онол, арга зүй, шинжилгээний бүтээл. УБ., 2017.
3. Удирдлагын Академиас хэвлүүлсэн "Нээлттэй лекц: 2016-2017 оны хичээлийн жил", УБ, 2017 эмхтгэлд хэвлэгдсэн лекц
4. Robert Scalapino “Major Power Relations an Northeast Asia” The Asia Socierty 1987.¹
5. “America’s Role in Asia” The Asia Foundation 2015.
6. Samuel P.Huntington “The Clash of Civilizations and the Remaking of World Order” Touchstone Book 1996.
7. Шинэ төмөр зам төсөл
8. “Examining the debt implications from the Belt and Road Initiative <https://www.cgdev.org/publication/examining-debt-implications-belt-and-road-initiative-a-policyperspective>
9. Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018.
10. Конрад зайц” Хятад дэлхийн гүрэн эргэн ирж байна” УБ., 2009.

²²⁶ Dmitrii Trenin 2002 The End of Euroasia Russian on the Border Between Geopolitics and Globalization 2002, p.318

11. Ж.Бадамсүрэн “Монголчуудын нутгийн аялгууг хэл хамгаалах бодлогын хүрээнд судалсан нь”, УБ., 2014.
12. Т.Өсөхжаргал. “Монгол хэл соёлын дархлаа бий болгох зарим арга зам” сэдэвт аюулгүй байдлын ухааны докторын диссертац. УБ., 2016.
13. ¹ Samuel P.Huntington “The Clash of Civilizations and the Remaking of World Order” Touchstone Book 1996.
14. Закрытие Чимерки. К чему ведет противостояние США и Китая “Коммерсант” от 05.11.2018.
15. "XX зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд" УБ 2017 номонд хэвлэгдсэн өгүүллэг
16. Xue Li and Zheng Yuwen “A Blueprint for China’s Neighborhood Diplomacy” The Diplomat March 30, 2016
17. Б.Даш-Ёндон “Нийгмийг танихуй:түүх-хөгжлийн философи” УБ. 2014.
18. Д.Уламбаяр "Монгол Улсын гадаад бодлогод "гуравдагч хөрш"-ийн бодлогын эзлэх орон зай, ач холбогдол"" "Монгол Улсын гадаад бодлогын лаборатори төсөл"-ийн хүрээнд болсон эрдэм шинжилгээний семинарт тавьсан илтгэл УБ. 2017.05.01
19. Dmitrii Trenin 2002 The End of Euroasia Russian on the Border Between Geopolitics and Globalization 2002.

3.3 Монгол Улс, Япон Улсын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв

3.3.1 Харилцааны түүхэн болон өнөөгийн байдал

Улс төрийн харилцаа

Япон улстай 1972 онд дипломат харилцаа тогтоосон. БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай хамтарсан албан мэдээ тухайн үед Үнэн сонинд нийтлэгдэж, "...БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон нь хоёр орны эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэж байгаагаа хоёр тал илэрхийлэв"²²⁷ хэмээн тэмдэглэжээ.

Тухайн цаг үеийн Монгол Улс, Япон улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоо, болж өнгөрсөн түүхэн үйл явдлын үр нөлөө, дэлхий дахины олон улсын нөхцөл байдлын асуудал зэрэг хүчин зүйлээс улбаатай түвэг бэрхшээлийг даван туулж, Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосон нь тус хоёр орны үндэсний эрх ашигт бүрнээ нийцэж, хоёр орны харилцааны түүхэнд тохиосон онцгой чухал үйл явдал болсон юм.²²⁸

Япон улстай албан ёсны дипломат харилцаа тогтоосноор:

- Хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа цоо шинэ шатанд өргөжин хөгжих түүхэн таатай боломжийг анх удаа нээж өгсөн.
- Харилцаа хэвийн болсноор хоёр орны ард түмний хооронд оршсоор ирсэн харилцан үл итгэлцэх, үл ойлголцох байдал, Монголын нийгэмд бугшсан Японтой холбоотой түгшүүр, хардалтын уур амьсгал эрс намжихад чухал түлхэц үзүүлсэн.
- Өрнөдийн гүрнүүдээс зөвхөн Их Британи Улстай дипломат харилцаатай байсан манай улсын хувьд гадаад харилцаагаа тэлэх томоохон алхам болж, дэлхийн тавцанд Монгол Улсын гадаад бодлого, нэр хүнд өсч бэхжихэд тус болсон.²²⁹

Монгол Улс 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн замыг сонгон хөгжих болж, бие даасан, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж эхэлснээр Монгол, Японы хоёр талын харилцаа шинэ шатанд гарч хөгжих үндэс суурь тавигдсан билээ. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалдаа тодорхойлсны дагуу Япон улсыг "гуравдагч хөрш"-өө хэмээн үзэж, түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд онцгойлон анхаарч ирсэн.

Монгол Улс ардчилсан хөгжлийн замыг сонгосон гараан дээр буюу 1990 оны 2 дугаар сард БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Д.Содном Монгол Улсын Засгийн газрын тэргүүний хувиар анх удаа Япон улсад албан ёсоор айлчилсан. 1991 оны 8 дугаар сард дэлхийн өндөр хөгжилтэй том орны Засгийн газрын тэргүүн нараас хамгийн түрүүнд Япон улсын Засгийн газрын Ерөнхий сайд Кайфу Тошики Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь Монгол Японы харилцааны түүхэнд хоёр орны харилцааг цоо шинэ шатанд гаргаж, хамтын ажиллагаа тогтвортой хөгжүүлэх үндсийг тавих түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Японы тал 1996 онд Монгол, Японы харилцааг Иж бүрэн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх санал дэвшүүлсэн бөгөөд Ерөнхий сайд М.Энхсайхан 1997 онд, Ерөнхийлөгч Н.Багабанди 1998 онд Япон Улсад айлчлах үеэр *талууд хоёр орны харилцааг Иж бүрэн түншлэлийн зарчмаар хөгжүүлэх тохиролцоонд хүрч, харилцаа хамтын ажиллагаа улс*

²²⁷Үнэн сонин, Улаанбаатар 1972.02.19

²²⁸Б.Сэржав "Монгол, Японы дипломат харилцаа: гүнзгийрэл, чиг хандлага" Олон улс судлал №1 (107), 2017 он: 5-23 дугаар тал

²²⁹Мөн гэнд

төр, эдийн засаг, соёл, боловсрол зэрэг нийгмийн бүх салбарт эрчимтэй хөгжиж ирсэн. Энэ зарчим 1999, 2001 оны хоёр талын дээд, өндөр хэмжээний айлчлалуудын үеэр гаргасан Хамтарсан мэдэгдлүүдэд тусгалаа олсон.²³⁰

Хамтарсан мэдэгдлүүдээс гадна хоёр улсын харилцаа стратегийн түншлэлд дэвшихэд өмнө нь байгуулсан гэрээ, хэлэлцүүрүүд эрх зүйн үндэс болсон. Япон улстай 1990 оноос хойших хугацаанд байгуулсан эрх зүйн баримт бичгүүдийг дурдвал:

1. БНМАУ, Япон улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр (1990.03.20)
2. Японы Сайн дурынхныг хүлээн авах хэлэлцээр (1990.03.19)
3. Агаарын харилцааны Засгийн газар хоорондын хэлэлцээр (1993.11.25)
4. Япон улсын Ахмад сайн дурынхныг хүлээн авах тухай Засгийн газар хоорондын протокол, 1999 он
5. Хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих засгийн газар хоорондын хэлэлцээр (2001.02.15)
6. Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр (2003.12.05).

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2010 оны 11 дүгээр сарын 15-наас 19-ний өдөр Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр талууд хоёр талын харилцааны түвшинг ахиулж, стратегийн түншлэл байгуулахаар санал нэгдсэн юм. Энэхүү айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Япон улсын Ерөнхий сайд Наото Кан нар уулзалт, хэлэлцээ хийж, “2007 оны 2 дугаар сард төрийн тэргүүн нарын гарын үсэг зурсан “Монгол, Японы хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр”-ийн дагуу Иж бүрэн түншлэлийн харилцааг хөгжүүлж ирсэн хамтын хүчин чармайлт тодорхой үр дүнд хүрч, улмаар хоёр орны харилцааг дараагийн дээд шатанд дэвшүүлэн, харилцан ашигтай, бие биеэ нөхсөн харилцааг өргөн хүрээнд батжуулан хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн” талаар харилцан тэмдэглэсэн. *Хэлэлцээний үр дүнд хоёр тал “иж бүрэн түншлэл”-ийн харилцааг “стратегийн түншлэл”-ийн шатанд хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн “Стратегийн түншлэлийн харилцаа байгуулахад чиглэсэн Монгол Улс, Япон улсын хамтарсан мэдэгдэл”-ийг нийтэлж, стратегийн түншлэлийн шатанд хоёр улсын харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн.*

“Стратегийн түншлэлийн харилцаа байгуулахад чиглэсэн Монгол Улс, Япон улсын хамтарсан мэдэгдэл”-д дурдсанаар, хоёр тал дараах салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхээр тохиролцсон билээ. Үүнд:

1. Өндөр дэд хэмжээний яриа хэлэлцээг идэвхжүүлэх;
2. Эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
3. Хүн солилцоо, соёлын харилцаа идэвхжүүлэх;
4. Бүс нутаг, глобал асуудлаарх хамтын ажиллагааг бэхжүүлэх.²³¹

Стратегийн түншлэл хөгжүүлэх зорилтын хүрээнд тодорхой алхмууд хийгдээд байна. Тухайлбал, 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Япон улсын Ерөнхий сайд нар Монгол Улсад зургаан удаа айлчилсны дотор сүүлийн гурван айлчлал (Ерөнхий сайд Ш.Абэ 2013, 2015, 2016 онд Монгол Улсад айлчилсан) нь стратегийн түншлэл тогтоосноос хойш хийгдсэн. Харин манай улсаас Ерөнхий сайд С.Батболд 2012 онд,

²³⁰Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам “Монгол, Японы улс төрийн харилцааны тойм” <https://tokyo.embassy.mn/index1.php?moduls=12>

²³¹“Стратегийн түншлэлийн харилцаа байгуулахад чиглэсэн Монгол Улс, Япон улсын хамтарсан мэдэгдэл”, 2010.11.19

Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 онд, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 2015 онд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2016 онд, Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 онд²³², Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 онд²³³ Япон улсад тус тус айлчлав.

1974 онд парламентын түвшинд харилцаа тогтоосноос хойш тогтмол харилцаж, төлөөлөгчид жил бүр шахам харилцан айлчилж байна. Японы парламентын Зөвлөхүүдийн танхимын дарга Ю.Осада 1992 онд, Төлөөлөгчдийн танхимын дэд дарга К.Ватанабэ 1997 онд, Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Оошима 2017 онд тус тус манай улсад айлчилсан. Монгол Улсын Их хурлын дарга Н.Багабанди 1994 онд, Р.Гончигдорж 1999 онд, С.Төмөр-Очир 2002, Д.Лүндээжанцан 2008 онд, Д.Дэмбэрэл 2011 онд, З.Энхболд 2015, 2016 онуудад, М.Энхболд 2017 онд тус тус Япон Улсад айлчлав.²³⁴ Эдгээр айлчлалаас үзэхэд өндөр, дээд түвшний айлчлалын давтамж нэмэгдсэн болох нь харагдаж байна. 2015 онд гэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар 3 сарын дотор Японд айлчилсан нь хоёр талын улс төрийн харилцаа нягтарсныг харуулж байна.

2013 онд хоёр улсын харилцаанд чухал үйл явдлууд өрнөж, Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэ 3 дугаар сард Монгол Улсад, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 9 дүгээр сард Япон улсад харилцан айлчилсан нь Монгол Японы харилцааг эрчимжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, хоёр орны хамтын ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлоход шинэ түлхэц өгсөн. Японы Ерөнхий сайд Ш.Абэгийн айлчлалын үеэр талууд хоёр улсын улс төрийн харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, иргэдийн солилцоо, соёл боловсролын салбар, олон улс, бүс нутгийн хэмжээний өргөн хамтын ажиллагааны талаар харилцан солилцсон. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Япон улстай стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг юм. Иймд Монгол Японы стратегийн түншлэлийг нийгмийн бүх салбарт эрчимжүүлэн хөгжүүлэх, түүний дотор эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахад яриа хэлэлцээ чиглэгдлээ” хэмээн онцлон тэмдэглэсэн.

Японы ерөнхий сайд хоёр орны Стратегийн түншлэлийн харилцааг эрх чөлөө, ардчилал, энх тайван, бие биедээ харилцан туслах үзэл санааны дагуу бэхжүүлэн хөгжүүлэх санал гаргаж, улмаар Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн хоёр талын хамтын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн ажиллагааг эрчимжүүлэх зорилготой “Эрч” санаачилга дэвшүүлсэн. “Эрч” санаачилгад:

1. Хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах;
2. Манай улсын эдийн засгийн дунд болон урт хугацаанд тогтвортой хөгжлийг дэмжиж, тухайлбал Дулааны IV цахилгаан станцын чадавхыг дээшлүүлэх, Улаанбаатар зам тээврийн орчинг сайжруулах, гүүрэн гарц, метро байгуулах, хоёр улсын хүлэмжийн хийн ялгаралтыг дүйцүүлэн бууруулж кредит олгох шинэ механизм хэрэгжүүлэх, инженер техникийн хүний нөөцийг Япон улсад бэлтгэх, сургалтын зориулалтын шинэ эмнэлэг барих, Олон улсын шинэ нисэх онгоцны буудал, Дарханы нефть боловсруулах үйлдвэр байгуулах, Таван толгойн нүүрсний

²³² Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон улсад айлчилна” <https://zasag.mn/news/view/21371>

²³³ Өнөөдөр сонин “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Японд айлчилна” <https://unuudur.mn/?p=181237>

²³⁴ Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам “Монгол, Японы улс төрийн харилцааны тойм” <https://tokyo.embassy.mn/index1.php?moduls=12>

ордын ашиглалтын төсөлд хамтран ажиллах зэрэг олон хэлбэрийн хамтын ажиллагааны талаар тусгажээ.

Монгол Улсын Ерөнхий сайд Н. Алтанхуягийн Япон улсад хийсэн айлчлалын үед хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны ойрын жилүүдийн чиглэл хандлага, агуулгыг тодорхойлсон “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр” (2013-2017) байгууллаа. Энэ хөтөлбөрт хоёр орны стратегийн түншлэлийн тулгуур болох өргөн хүрээтэй хамтын ажиллагааны агуулгыг тусгасан. Үүнд:

1. Улс төр, аюулгүй байдлын салбарт өндөр дээд хэмжээний харилцан айлчлал, яриа хэлэлцээний давтамжийг нэмэгдүүлэх, Засгийн газар, Гадаад хэргийн сайд нарын уулзалт, стратегийн яриа хэлэлцээ, холбогдох яам, газрууд хоорондын бүхий л түвшний бодлогын зөвлөлдөх уулзалтууд бусад хэлбэрийн хамтын ажиллагааг тогтмолжуулах, мөн аюулгүй байдал, батлан хамгаалах салбар, бүс нутаг, олон улсын тавцанд өргөн хамтын ажиллагаа хэрэгжүүлэх;
2. Эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт Монгол, Японы стратегийн түншлэлийн зарчмууд, Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл, Япон улсын Засгийн газраас Монголд үзүүлэх тусламжийн дагуу төсөл хөтөлбөр, хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний нөөц ашиглалт, цэвэр бохир усны системийг сайжруулах, гамшгаас сэргийлэх, авран хамгаалах чадавхыг дээшлүүлэх, цөлжилттэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах; боловсон хүчин бэлтгэх чиглэлээр инженер техникийн дээд боловсрол олгох их сургуулийн чадавхыг бэхжүүлэх, аж үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг Японд бэлтгэх; суурь дэд бүтцийн хөгжил, бүтээн байгуулалтын чиглэлээр олон улсын шинэ нисэх онгоцны буудал байгуулах, Дулааны IV цахилгааны станцын үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, Улаанбаатарт метро, гүүрэн гарц байгуулах, гэр хорооллын “Гудамж” төсөл, сум хөгжүүлэх төсөлд хамтран ажиллах, экспортын зээлийн шугамын хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Дарханд нефть боловсруулах үйлдвэр байгуулах, сансрын технологийн төсөлд хамтран ажиллах, бага, дунд сургуулийн орчныг сайжруулах, боловсруулах, усалгаатай тариалан хөгжүүлэх зэрэг хөдөө аж ахуйн салбарт техникийн дэмжлэг үзүүлэх, Монголтой ойролцоо Японы хүйтэн бүс технологийг судлах, туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх, Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын талаар хувийн хэвшлийн салбарыг мэдээллээр хангах;
3. Соёл, иргэд хоорондын солилцооны салбарт хоёр улсын Засгийн газрын бүхий л түвшний яриа хэлэлцээ, Парламент болон Парламентын найрамдлын бүлгүүдийн солилцоо хамтын ажиллагааг дэмжих, хүүхэд залуучуудын солилцоог идэвхжүүлэх, хоёр орны түүх, соёл, улс төр, эдийн засаг, нийгмийн байдлыг харилцан сурталчлах, судлаач сэтгүүлчдийг харилцан солилцох, Монгол дахь Япон судлал, Япон дахь Монгол судлалыг хөгжүүлэхэд хамтарч ажиллах, соёл шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа, Монгол дахь япон хэлний сургалт, япон хэлний багш нарын үйл ажиллагааг дэмжих, Монгол Улсын хөгжилд чухал хэрэгцээтэй салбарт бэлтгэгдэх оюутнуудыг Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцуулах, хоёр улсын орон нутгийн засаг захиргаа болон хувийн хэвшил хоорондын хэлхээ холбоо, хамтын ажиллагааг дэмжих зэрэг заалт тусгажээ.

Эдийн засгийн харилцаа

Хоёр тал харилцааныхаа ойрын болон дунд хугацааны зорилтыг тодорхойлж, Монгол-Японы Стратегийн түншлэлийг 2017-2021 онд хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөрийг 2017 онд байгуулжээ.²³⁵ Энэ хөтөлбөрт хоёр улсын стратегийн түншлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн зорилтуудыг хамтын ажиллагааны салбарт тус бүрээр тодорхойлсны дотор эдийн засгийн харилцаа чухал суурийг эзэлнэ.

Хоёр улсын Засгийн газар Economic Partnership Agreement буюу Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ)-ийг 2015 оны 2 дугаар сард байгуулсан. 2016 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болсон Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд ХАА, аж үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, барилга, хот байгуулалт шинжлэх ухаан, технологи, оюуны өмч, санхүүгийн үйлчилгээ, боловсрол болон хүний нөөцийн хөгжил, аялал жуулчлал, байгаль орчин, уул уурхай болон эрчим хүч, эрүүл мэнд, мэдээлэл, харилцаа холбооны технологи зэрэг салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр ажиллаж байна.

Монгол-Японы ЭЗТХ нь 17 бүлэг, 193 зүйл болон 10 хавсралт бүхий иж бүрэн баримт бичиг юм. Манай улсын зүгээс бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, худалдааны түнш оронтой хийж буй худалдааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, тэргүүний технологи нэвтрүүлэх, дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах, худалдаанд саад болж буй хоригийг багасгах зорилгоор энэхүү анхны чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулсан билээ.

Япон, Монголын ЭЗТХ-ийн утга санааг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

- Хоёр орны гадаад худалдааг нэмэгдүүлэн эрчим хүч, уул уурхай зэрэг салбар дахь хөрөнгө оруулалтын орчинг сайжруулснаар Монгол Улстай “Стратегийн түншлэл”-ийг улам гүнзгийрүүлнэ.
- Монгол Улсаас эрчим хүч, ашигт малтмалыг тогтвортой нийлүүлэхэд хувь нэмрээ оруулна (Нүүрс, жонш, ховор метал импортолно. Монгол Улсад зэс, алт зэрэг ч олборлогдож буй).
- Ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжин, цаашид ч эдийн засгийн хувьд дунд, урт хугацаанд өндөр өсөлтөд хүрэх төлөвтэй Монгол Улсын эдийн засаг хөгжсөнөөр Япон улсын эдийн засаг өсөхөд хувь нэмэр оруулна.
- Бараа, бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, цахим худалдаа, өрсөлдөөн, оюуны өмч зэргийн эрх зүйн зохицуулалтыг агуулсан цогц гэрээ юм.

Япон, Монголын ЭЗТХ-т багтсан гол асуудлууд:

- *Бараа бүтээгдэхүүний ерөнхий дүрэм:* Гаалийн татвараас чөлөөлөх, бууруулах, Үндэсний нөхцөлөөр хангах үүрэг хүлээхээс гадна хоёр талын худалдааны Хамгаалалтын буюу импорт огцом нэмэгдэхэд авах арга хэмжээ (Bilateral Safeguard Measures)-нд нийцүүлэх дүрмийг тогтооно. Мөн эрчим хүч, ашигт малтмал, хүнс зэрэг бараа бүтээгдэхүүний экспорт, импортод тавих зохицуулалтын арга хэмжээг авах тохиолдолд мэдээлэл солилцоно.
- *Гаалийн үйл ажиллагаа:* Гадаад худалдааг саадгүй явуулах үүднээс үүсч болох асуудлыг урьдчилан таамаглахуйц, тууштай, ил тод гаалийн үйл ажиллагаа явуулж, гаалийн холбогдох хууль, дүрмийг зохистой ашиглах, мөн гаалиар түргэн шуурхай нэвтрэх боломжийг ханган, хамтран ажиллаж мэдээллийг харилцан солилцоно.

²³⁵Монгол Улсын Гадаад харилцааны яам “Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном 2017”, Улаанбаатар хот, 2018 он <http://mfa.gov.mn/wp-content/uploads/2021/01/blue-book-2017.pdf>

- *Хөрөнгө оруулалт:* Ашигт малтмал, эрчим хүч болоод бусад бүхий л салбарт хөрөнгө оруулалтын орчинг бүрдүүлнэ. Тухайлбал, хөрөнгө оруулалтын зөвшөөрөл хүсэх шатанд Үндэсний болоод нэн тааламжтай үндэстний нөхцөл, шударга, тэнцвэртэй нөхцөл, хөрөнгө оруулагч ба Засгийн газар хоорондын гэрээг чанд сахих үүрэг, технологийн лицензийн гэрээнд Засгийн газрын оролцоог хориглох, хөрөнгө оруулагч болон Засгийн газрын хооронд үүсэх маргаан шийдвэрлэх арга зам (ISDS) зэрэг заалтыг оруулан, хөрөнгө оруулалтын хамгаалалтыг бэхжүүлэхийн хамт хөрөнгө оруулалтыг улам бүр чөлөөтэй болгох бүтцийг бий болгоно.
- *Заавал мөрдөх болон сайн дурын (сонгон хэрэглэх) стандарт, тохирлын үнэлгээний журам:* Гадаад худалдааг хөгжүүлэхэд олон улсын стандартыг ашиглах, заавал мөрдөх стандартыг батлах, шаардлага хангасан эсэхийг тодорхойлох үйл ажиллагааны үр дүнг хүлээн зөвшөөрөх тухай заалтыг оруулна. Мөн түүнчлэн, харилцан мэдээлэл солилцох, хамтарсан зөвлөлдөх дэд хороо байгуулна.
- *Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээ:* Дэлхийн худалдааны байгууллагын “Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр” (SPS Agreement)-ийн дагуу SPS арга хэмжээг тогтоосон. Уг арга хэмжээтэй холбоотой мэдээллийг харилцан солилцох, мөн шинжлэх ухаанд үндэслэсэн холбогдох заалтыг тусган, техникийн хамтын ажиллагааны дэд хороо байгуулна. SPS-ийн арга хэмжээг мөрдөхдөө олон улсын стандартын хэв хэмжээнд нийцүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа, уг стандарттай адил тэнцүү байхыг хүлээн зөвшөөрөх заалтыг тусгана.
- *Үйлчилгээний худалдаа:* Зах зээлд нэвтрэх боломж, Үндэсний нөхцөл, нэн тааламжтай үндэстний нөхцөл, ил тод байдал зэрэг үйлчилгээний худалдааг хөгжүүлэх ДХБ-ын хэлэлцээрт зааснаас илүү өргөн хүрээтэй журам, механизмыг бий болгоно.
- *Хувь этгээдийн шилжилт хөдөлгөөн:* Худалдааны шугамаар богино хугацаанд саатах этгээд, байгууллага дотроо шилжин ажиллах ажилтан, хөрөнгө оруулагч, гэрээгээр үйлчилгээ үзүүлэх этгээд болоод тэдгээрийн гэр бүл, үр хүүхдийг улсын хилээр орох болон түр оршин суухад дэмжлэг үзүүлнэ. Мөн улсын хилээр орох болон түр оршин суухтай холбоотой бичиг баримтын бүрдүүлэлтийг ил тод болгох тухай заалт тусгана.
- *Оюуны өмч:* Ил тод байдал, дүрэм журам, олонд танигдсан худалдааны тэмдэг болон хаалттай мэдээллийг хамгаалах зэрэг оюуны өмчийн эрхийг хамгаалах болоод эдлэхтэй холбоо бүхий өргөн хүрээтэй заалтыг тусгана.
- *Цахим худалдаа:* Цахим худалдааг дэмжих үүднээс цахим системээр илгээсэн бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулахгүй байх, цахим бүтээгдэхүүнийг ялгаварлахгүй байх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг заалтыг тусгана.
- *Өрсөлдөөн:* Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хязгаарлах үүднээс хоёр орны холбогдох эрх бүхий байгууллага тус тусын хууль журамд үндэслэн ямар арга хэмжээ авах нь зохистойг тогтоох, мөн эрх бүхий байгууллагуудын хооронд бодитой хамтын ажиллагаа өрнүүлэх журмын талаарх заалтыг тусгана.
- *Бизнесийн орчин бүрдүүлэх:* Хоёр орны Засгийн газар, хувийн хэвшлийн болон бусад холбогдох байгууллагыг оролцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр орны

хувийн хэвшлийнхэнд зориулсан бизнесийн орчинг бүрдүүлэн, сайжруулах асуудлыг судлах дэд хороо байгуулна.

- *Хамтын ажиллагаа*: Хоёр орны эдийн засгийн харилцааг бэхжүүлэх зорилгоор ХАА, ой, усны аж ахуйн үйлдвэрлэл (үүнд хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээг бий болгохыг дэмжих асуудал багтана) жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлал, мэдээлэл, харилцаа холбооны технологи, байгаль орчин зэрэг олон салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна.

Монгол Улс Япон руу 9300 нэр төрлийн барааг хөнгөлттэй экспортлох бол Япон улсаас Монгол Улс руу 5700 нэр төрлийн бараа хөнгөлттэйгөөр импортлох ЭЗТХ-д тусгажээ.²³⁶ ЭЗТХ байгуулснаар хоёр орны хооронд худалдаа, хөрөнгө оруулалт цаашдаа өсөх хүлээлттэй байсан. Хоёр улсын хоорондын худалдаанд ЭЗТХ хэрхэн нөлөөлснийг гадаад худалдааны статистик мэдээлэл дээр дүн шинжилгээ хийж авч үзье (Хүснэгтийг үзнэ үү).

3.1 дүгээр хүснэгт

Хоёр талын бараа эргэлт (2016 онтой харьцуулсан байдал)

Жилийн эцсийн байдлаар	Экспорт (мян ам.доллар)	Импорт (мян ам.доллар)	Нийт эргэлт (мян ам.доллар)	Экспортыг 2016 оны дүнтэй харьцуулсан байдал	Импортыг 2016 оны дүнтэй харьцуулсан байдал
2016 он	14,031	330,618	344,649	-	-
2017 он	14,816	363,150	377,966	5.6% өссөн	9.9% өссөн
2018 он	26,468	561,042	587,510	88.6% өссөн	69.7% өссөн
2019 он	15,517	585,478	600,995	10.5% өссөн	77.1% өссөн
2020 он	9,628	406,712	416,340	31.4% буурсан	23.0% өссөн

Эх сурвалж: ГЕГ-аас гаргасан гадаад худалдааны статистик мэдээлэл

3.1 дүгээр хүснэгтээс үзэхэд, Монгол-Японы ЭЗТХ 2016 онд хүчин төгөлдөр болсноос хойш буюу 2017 оноос эхлэн хоёр талын худалдаа нэмэгдсэн байна. Тухайлбал, 2018 онд экспорт, импорт хоёулаа өндөр өсөлттэй гарсан бөгөөд манай улсаас Япон руу экспортлосон бараа бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн нь эдийн засаг, гадаад худалдаагаа солонгоруулахад чиглэсэн манай улсын бодлого, хөтөлбөртэй нийцэж байгаа сайн талтай байна. Хэдийгээр 2016 онтой харьцуулахад 2018 онд манай экспорт өссөн боловч өмнөх он буюу 2017 онтой харьцуулахад 41 хувиар буурсан нь анхаарал татаж байна. Үүнд дэлхий нийтийг хамарсан цар тахал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байж болох ч шалтгааныг тодруулах нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай. Түүнчлэн, 2020 онд 2016 онтой харьцуулахад хоёр талын бараа эргэлт экспорт, импортын аль алиных нь хувьд буурчээ. Энэ нь цар тахал манай улсын “гуравдагч хөрш”-ийн орнуудтай хийж буй худалдаанд сөргөөр нөлөөлснийг харуулж байна. Хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцаанд үзүүлэх ЭЗТХ-ийн үр нөлөөний тухайд дүгнэж хэлэхэд, тус хэлэлцээр нь хоёр талын бараа эргэлтэд эерэг нөлөөтэй байна.

Хоёр улсын хоорондох хөрөнгө оруулалт нь чамлалттай хэмжээнд байна. 2016 оныг хүртэл Япон улсаас манай улсад нийт 262 сая долларын хөрөнгө оруулалт хийгдэж,

²³⁶Засгийн газрын мэдээ, Улаанбаатар, 2015.03.25, № 053(077)

түүний ихэнх боловсрол, нийгмийн салбарт ногджээ. 2015 оны байдлаар Японы 551 компани Монгол Улсад бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байжээ.²³⁷

Японы Засгийн газар нь Монгол Улстай дипломат харилцаа тогтоосноос хойш өнөөг хүртэл олон салбарт эдийн засгийн тусламж, дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд 2017 оны 3 дугаар сарын сүүлийн байдлаар нийт тусламжийн хэмжээ 326.7 тэрбум хүрээд байна (Хүснэгтийг үзнэ үү). Япон улсын эдийн засгийн тусламж, дэмжлэг нь Монгол Улс ардчилсан нийгэмд шилжих явцад тулгарсан эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй он жилүүдийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

3.2 дугаар хүснэгт

Японы улсын үзүүлсэн зээл, тусламжийн хэмжээ (1977-2017 он)

Зээл тусламжийн төрөл	Хэмжээ (100 сая иен)
Буцалтгүй тусламж	1,191.35
Хөнгөлттэй зээл	1,579.44
Техникийн хамтын ажиллагаа	496.86
Нийт	3,267.65

Эх сурвалж: Япон улсын ЭСЯ (2018 оны 3 дугаар сарын байдлаар)

Өнгөрсөн хугацаанд олон төсөл хэрэгжсэний дотор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл”, “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл”, “Дулааны IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл” багтаж байна.

Соёл, боловсролын харилцаа

Монгол улс, Япон улстай оны Соёлын харилцааны хэлэлцээр байгуулж, 1976 онд анхны монгол оюутныг судлаач оюутнаар хүлээж авснаар Япон-Монголын оюутны солилцоо эхэлжээ. Дэлхий дахинд цар тахал дэгдэхээс өмнө буюу 2019 оны 12 дугаар сарын байдлаар 3124 монгол оюутан Япон улсад суралцаж байсан нь тус улсад суралцаж буй оюутны тоогоор бусад улс оронтой харьцуулахад 13 дугаар байрт орж байсан бөгөөд 10000 хүн тутамд ногдож буй суралцагсдын тоогоор эхний байр эзэлж байсан байна.²³⁸

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2007 оны 2 дугаар сард Япон улсад хийсэн төрийн айлчлалынхаа үеэр Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэгийн хамт Монгол, Японы Иж бүрэн түншлэлийн үндсэн хөтөлбөрт гарын үсэг зурсан бөгөөд иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дүгээрт “боловсрол, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ” хэмээн тунхагласан. Монгол, Японы харилцааны 50 жилийн түүхэн ойг тохиолдуулан 2022 оныг “Монгол, Японы хүүхэд, залуучуудын найрамдал, солилцооны жил”-ээр зарласан

2013 оны байдлаар Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр манай 216 оюутан хууль, эдийн засаг, мэдээллийн технологи, анагаах ухаан, соёлын чиглэлээр суралцаж байсан байна. Түүнээс гадна Японы Боловсролын яамны тэтгэлгээр жилд 70 орчим оюутан, “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр” (JDS)-ийн тэтгэлгээр 18 оюутан, түүнчлэн, JICA-гийн богино хугацааны сургалтад 10-20 хүн хамрагдаж байжээ. 2019 оны байдлаар

²³⁷Б.Сэржав “Монгол, Японы дипломат харилцаа: гүнзгийрэл, чиг хандлага” Олон улс судлал №1 (107), 2017 он: 5-23 дугаар тал

²³⁸Япон улсын ЭСЯ, Гадаад оюутны солилцоо <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/ryuugaku.htm>

магистрын сургалтад 38, докторантурт 4 хүн тус тус суралцаж байв.²³⁹ Мөн 2019 оны байдлаар Япон Улсад судалгаа хийж докторын зэрэг хамгаалсан, мөн докторын зэрэг горилон судалгаа хийж буй 200 гаруй оюутан байна.²⁴⁰

Япон улсад 1005 инженерийг бэлтгэх зорилготой “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг Монгол улс, Япон улсын засгийн газар 2014-2023 он хүртэл хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл нийт 75 сая долларын өртөгтэй бөгөөд механик, барилга, цахилгаан электроникийн хос хөтөлбөрт 320, магистрантурт 100, докторантурт 60, зэргийн бус сургалтад 325, мэргэжил олгох Коосэн сургалтад 200 гээд нийтдээ 1,005 хүн зам барилга, механик, нисэхийн инженер, үйлдвэрлэлийн инженер, цахилгаан электроникийн инженерээр суралцах юм. Гэхдээ уг хөтөлбөр нь буцалтгүй тусламж биш бөгөөд зээлийн гэрээний дагуу 75 сая долларыг Япон улсаас жилийн 0.2 хувийн хүүтэйгээр зээлж байгаа юм. Уг зээлийг 20 жилийн хугацаанд буцаан төлөх ёстой. Монгол улсад 30000 гаруй инженерийн хэрэгцээ бий гэсэн судалгааг Японы тал хийсэн байдаг. Энэ орон зайг нөхөхийн тулд энэхүү төслийн хүрээнд инженер технологийн чиглэлээр мэргэших сонирхолтой 40-50 оюутныг жил бүр Япон Улс руу илгээснээр 2023 он гэхэд 1000 гаруй инженер бэлтгэхээр төлөвлөж байгаа юм.²⁴¹

Хамгийн сүүлийн үеийн статистик мэдээллээр буюу 2019 оны байдлаар Монгол Улсад гурван “Косэн” загварын сургууль үйл ажиллагаа явуулж байна:

1. “Монгол Коосэн” Технологийн коллеж - нийт оюутны тоо 280
2. “Шинэ Монгол” Технологийн коллеж – нийт оюутны тоо 370
3. “ШУТИС-Коосэн” Технологийн коллеж – нийт оюутны тоо 166

Тус косэн сургуулиудад барилга, цахилгаан, механик, био-химийн инженерийн мэргэжлээр оюутнуудыг сургаж байна. “Косэн” загварын сургуулийг 2019 оны 6 дугаар сарын байдлаар нийт 141 оюутан төгссөн байна. Төгсөгчдийн 25 хувь нь японы компанид, 50 хувь нь монголын компаниудад ажилд орж, үлдсэн 25 хувь нь их дээд сургуульд дэвшин суралцаж байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд 2019 онд нийт 207 оюутан Японд суралцаж буйгаас үндсэн сургалтын хөтөлбөрт 81 хүн, хос хөтөлбөр (бакалаврын сургалт) 55, магистр 17, докторын сургалтын хөтөлбөрт 36, судлаач оюутан 3, зэргийн бус сургалтын хөтөлбөрт 17 хүн тус тус суралцаж байв.

МУИС болон Японы Токио, Осакагийн Гадаад хэлний дээд сургуулиуд хооронд 1975 оноос монгол, япон хэлний багш нарыг харилцан солилцож эхэлсэн. Манай их, дээд сургуулиуд 1975 оноос Япон улсаас оюутан элсүүлэн сургаж эхэлсэн бөгөөд одоо 7 япон оюутан монгол хэлний сургалтад хамрагдаж байна. Японы 10 гаруй их, дээд сургуульд монгол хэлний сургалт явуулж, монголын түүх, соёл, улс төр, эдийн засгийн судалгаа хийж байгаагийн зэрэгцээ эгнээндээ 300 гаруй судлаачдыг нэгтгэсэн “Монгол судлалын нийгэмлэг” үйл ажиллагаа явуулж байна. Япон улсад харьцангуй олон их дээд сургуульд монгол хэл зааж, монгол судлалыг амжилттай хөгжүүлж байгаа бөгөөд үүнд Осакагийн их сургууль, Токиогийн гадаад судлалын их сургууль, Тоохокү их сургууль, Васеда их сургууль, Оотани их сургууль зэргийг дурдаж болно.²⁴²

Мөн археологи, палеонтологи, угсаатны зүй, биохими зэрэг чиглэлээр эрдэмтдийн хамтарсан судалгаа хийгдэж, соёлын өвийг хамгаалах салбарт Монгол, Японы эрдэмтэн

²³⁹ Монголын докторууд Токиод чууллаа, <http://www.mfa.gov.mn/?p=40560>

²⁴⁰ Мөн тэнд

²⁴¹ Японд 1000 инженер бэлдэнэ, 2016-01-29. <http://news.num.edu.mn/?p=31949>

²⁴² Монгол судлалын мэдээллийн нэгдсэн сан. <http://www.mongolstudies.gov.mn/index.php/en/mongolia/asia/2015-11-15-06-50-52/2015-11-15-06-58-06>

судлаачид, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжин тэлж байна.²⁴³ Мөн сүүлийн үед японы гоо даам, “соробан” сампин, роботын чиглэлээр сонирхон суралцаж буй монголын хүүхэд залуусын тоо ихсэх хандлагатай байна.

Монгол, Япон Улс 1991 оноос эхлэн соёлын өдрүүд, кино үзлэг тогтмол зохион байгуулж, үзэсгэлэн гаргаж, урлагийн хэсгүүд харилцан айлчлан тоглолт хийх болсон. Монгол, Японы Соёлын анхдугаар форумыг 1999 онд Токио хотод, улмаар ээлжит форумуудыг 2000, 2007, 2010 онд Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан.²⁴⁴ Япон улсын иргэн, дуучин Яширо Аки, зураач Шингэцү Шикандай, Монгол улсын Өргөмжит консул асан Сато Норико нар 2016 оноос Монгол улсын Соёлын элчээр томилогдон ажиллаж байна.²⁴⁵

Япон улсын засгийн газрын Соёлын Ерөнхий буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол Улсад 2014 оны санхүүгийн жил хүртэл нийт 24 төсөлд 1 тэрбум 556 сая 300 мянган иений хамтын ажиллагаа хэрэгжээд байна.²⁴⁶ Соёлын Ерөнхий Буцалтгүй Тусламж нь хөгжиж буй орнуудын соёл, дээд боловсролыг хөгжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга байгууламжийг сайжруулах (шинээр барих, засварлах) зэрэгт шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангадаг тусламж юм.

“Соёлын өвсний үндэс” буцалтгүй тусламж нь орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага зэрэг хөгжиж буй орны ард иргэдийн түвшинд шууд тусламж үзүүлэхийг зорьдог хөтөлбөр бөгөөд 2015 он хүртэл Монгол улсад нийт 412,580 ам.долларын өртөг бүхий 6 төсөл хэрэгжүүлээд байна.²⁴⁷

Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв нь 2002 оноос эхлэн Монгол, Япон хоёр орны харилцааг бэхжүүлэх, Монгол улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэхэд туслах, зорилготойгоор үйл ажиллагаа явуулсаар ирсэн бөгөөд 2009 оны 7 дугаар сард тус төвөөр үйлчлүүлэгчдийн тоо 1 саяд, 2016 оны 4 дүгээр сард 2 саяд хүрчээ.²⁴⁸

Орон нутгийн шууд хамтын ажиллагааны хүрээнд 1990-ээд оноос Төв аймаг Тоттори мужтай, Өвөрхангай аймгийн Хужирт сум Нагано мужийн Маруко хоттой, Баянхонгор аймаг Ойта мужтай, Налайх дүүрэг Хоккайдо мужийн Ниикаппү хоттой, Улаанбаатар хот Миязаки мужийн Мияконожёо хот, Хоккайдо мужийн Саппоро хотуудтай харилцаа тогтоож, шууд хамтран ажиллаж байна. 2008 оноос Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг Нагано мужийн Сакү хоттой, Өвөрхангай аймгийн Хархорин хот Канагава мужийн Камакүра хоттой тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. 2011 оны 7 дугаар сард Дорноговь аймаг Шизүока мужтай, 2012 онд Өвөрхангай аймаг Гүнма мужтай, 2014 онд Хөвсгөл аймаг, Нийгата мужтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан бөгөөд Ховд аймаг Вакаяма мужтай, Дорнод аймаг Фүкүока

²⁴³Монгол улсаас Япон улсад суугаа ЭСЯ <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=17>

²⁴⁴Мөн тэнд.

²⁴⁵ГХЯ, Монгол, Японы харилцааны товч лавлах. http://www.mfa.gov.mn/?page_id=14886#1489665313491-046e3cfb-6626

²⁴⁶ Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ, Соёлын Ерөнхий Буцалтгүй Тусламж. <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/bunkamusyoku.htm>


²⁴⁷ Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ, Соёлын Өвсний Үндэс Буцалтгүй Тусламж. <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/kusanone.htm>

²⁴⁸ Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв, <http://www.japan-center.mn/home.shtml;jsessionid=C400ED1CA382D0979038D8846C0351C8>

мужтай, Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүрэг Шизүока мужийн Изүнокүни хоттой орон нутгийн шууд хамтын ажиллагаа хөгжүүлэх эхлэл тавигдаад байна.²⁴⁹

2017 оны байдлаар 7154 монгол иргэн Япон улсад оршин сууж байгаа ба 1996 онд байгуулагдсан “Япон дахь Монгол оюутны холбоо”, 2016 онд байгуулагдсан “Япон дахь монгол иргэдийн нэгдсэн холбоо” гэсэн монгол иргэдийн хоёр холбоо тус улсад үйл ажиллагаа явуулж байна.²⁵⁰

Монгол Улсад жуучлах япон иргэдийн тоо 2011 оноос тогтмол өсч, 2019 онд 24,419-д хүрч байсан боловч цар тахлын улмаас япон жуулчдын тоо огцом буураад байна (Зургийг үзнэ үү). Япон улс Монгол Улсад ирсэн нийт жуулчдын тоогоор 4 дүгээр байр эзэлж байв.²⁵¹



3.2 дугаар зураг . Монгол Улсад жуулчилсан япон иргэдийн тоо (2011-2021 он)

Эх сурвалж: ҮСХ

Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа

Япон улсын Засгийн газраас 2000 оны 4 дүгээр сард Монгол Улстай батлан хамгаалах салбарт албан ёсны харилцаа тогтоохоор шийдвэрлэж тус улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх Батлан хамгаалахын атташег Монгол Улсад хавсран суулгахаар болж, Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлээр Японтой батлан хамгаалах салбарт харилцаа тогтоохоор шийдвэрлэсэн. Мөн 2012 онд хоёр улсын Батлан хамгаалах яам хоорондын “Харилцан ойлголцох санамж бичиг”-т гарын үсэг зурснаар хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа шинэ түвшинд гарч, эрчимтэй хөгжих үндэс тавигдсан юм.

Монгол Улс, Япон Улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нэлээд идэвхжих хандлагатай байна. Энэ нь хоёр улсаас бүс нутагт

²⁴⁹Монгол улсаас Япон улсад суугаа ЭСЯ <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=17>

²⁵⁰ГХЯ, Монгол, Японы харилцааны товч лавлах. http://www.mfa.gov.mn/?page_id=14886#1489665313491-046e3cfb-6626

²⁵¹ БОАЖЯ, 2016 оны жилийн эцсийн мэдээг 2015 оны мөн үетэй харьцуулсан мэдээ<http://tourism.ub.gov.mn/wp-content/uploads/2017/01/2016-onii-jiliin-etses.pdf>

явуулж буй дипломат бодлого, үйл ажиллагаатай нягт уялдаатай. Бүх түвшний харилцан айлчлал, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх уулзалт, цэргийн боловсон хүчний сургалт, цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чиглэлээр хамтран ажиллах зэрэг олон хэлбэрээр хамтын ажиллагаа явуулж байна. Ялангуяа хоёр орны батлан хамгаалах хамтын ажиллагаанд цэргийн инженер, цэргийн эмнэлэг гэсэн үндсэн 2 чиглэлийг тодорхойлон амжилттай хэрэгжүүлж байна.²⁵²

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2019 оны 12 дугаар сарын 1-4-ний өдрүүдэд Япон Улсад 5 жил хагасын дараа албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд хоёр улсын Батлан хамгаалахын сайд нар албан ёсны хэлэлцээ хийсэн бөгөөд Япон Улсын Батлан хамгаалахын сайд Т.Коно хүндэтгэлийн зоог барив. Мөн айлчлалын үеэр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Гадаад хэргийн сайд Т.Мотэги, Парламент дахь Төлөөлөгчдийн танхимын Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга М.Хаяши нартай тус тус уулзав.

Батлан хамгаалахын сайд нарын албан ёсны хэлэлцээгээр талууд хоёр улсын батлан хамгаалах харилцаа шинэ агуулгаар баяжин өргөжиж, хоёр талдаа харилцан цэргийн атташе суулгаад буйг сайшаан тэмдэглэв. Түүнчлэн цаашид цэргийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, цэргийн инженер, түүний дотор цэргийн эмнэлгийн салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, Монголд техник, тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулах зэрэг чиглэлд хамтран ажиллахаар тогтов. Японы тал өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын Зэвсэгт хүчин ЭСА-ны газар оронд өндөр түвшний ус зайлуулах байгууламж бүхий автозамыг барих чадвартай болсныг өндрөөр үнэлэв. Монголын тал “Гадаад харилцаа, Батлан хамгаалахын сайд нарын зөвлөлдөх уулзалт”-ын механизмыг цаашид хоёр талын харилцаанд нэвтрүүлж тогтмолжуулах нь ач холбогдолтой гэж үзэж буй гэсний хариуд японы тал уг асуудлаар ажил хэргийн түвшинд үргэлжлүүлэн санал солилцож ажиллахаа илэрхийлэв.

Албан ёсны айлчлалын үеэр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд дагалдан яваа төлөөлөгчдийн хамтаар Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургуульд зочлон, тус сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, уг сургуульд суралцаж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 офицер, сонсогч нартай уулзав. Түүнчлэн Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Эрүүл мэндийн сургууль, Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлэгт тус тус зочилж, үйл ажиллагаатай нь танилцаж, хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.

Хоёр улсын Засгийн газар гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын зөвлөлдөх уулзалтууд үргэлжлэн тогтмол зохион байгуулагдаж байна.

- Монгол Улс, Япон Улсын ГХЯ хоорондын Стратегийн II зөвлөлдөх уулзалт 2017 оны 2 дугаар сард Улаанбаатар хотноо, III уулзалт 2018 оны 4 дүгээр сард Токио хотноо тус тус болов.
- Монгол Улс, Япон Улсын гадаад харилцаа, аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын IV зөвлөлдөх уулзалт 2017 онд Улаанбаатар хотноо, 8 дугаар V зөвлөлдөх уулзалт 2019 оны 4 сард Токио хотноо болов.

²⁵²VIP76 “Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ Японы Батлан хамгаалах яамны бодлогын газрын захирал Омасу Изавага хүлээн авч уулзлаа” (2017 оны 8 дугаар сарын 29) <http://vip76.mn/content/47939>

- Монгол Улс, Япон Улсын Батлан хамгаалах яамд хоорондын V зөвлөлдөх уулзалт 2019 оны 4 дүгээр сард Токио хотноо болов.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Японы Өөрийгөө хамгаалах хүчний Хуурай замын цэргийн инженерийн сургалтын багтай хамтран “Зам” сургалтыг 2014 оноос 3 үе шаттай хэрэгжүүлж байна. 2017 оны 8 дугаар сарын 22-30 өдөр зохион байгуулсан “Зам-2017” сургалтын онцлог нь авто замын ус зайлуулах байгууламжийг барихад чиглэсэн. 2018 оны 7-8 дугаар сар, 2019 оны 4,5 дугаар сард, 2019 оны 8,9 дүгээр сард Монголын цэргийн инженерийн нэгжийн зам, барилгын салбар дахь хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт хэрэгжүүлэв. Японы талтай ийнхүү хамтран ажилласнаар Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх “Барилга, инженерийн рот”-ын бэлтгэлийг хангах боломжтой болж байна.²⁵³

Япон улс 2012 оноос эхлэн гадаадын улс орнуудын батлан хамгаалах салбарт тусламж үзүүлдэг болсон бөгөөд боловсрол, хүний нөөцийн чиглэлээр өөрсдийн туршлагыг хуваалцах, тусламжийг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж, Япон улсын Батлан хамгаалах яамнаас “Чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг гадаад улс орнуудад хэрэгжүүлж байна. “Монгол-Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-т тусгагдсан Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх хамтын ажиллагаа болон энэхүү хөтөлбөрийн хүрээнд манай улстай хамтран цэргийн эмнэлгийн чиглэлээр 2014-2016 онд дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн.²⁵⁴

Хүмүүнлэгийн тусламж, үр дагаврыг арилгах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалтын хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Япон улсаас Монгол Улсад суугаа Бүрэн эрхт Элчин сайд Т.Шимизү нар 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдөр гарын үсэг зурав. Хэлэлцээрийн зорилго нь хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах боломжийг бий болгох, энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.²⁵⁵

Япон улсын Өөрийгөө хамгаалах хүчнээс манай улсад зохион байгуулдаг “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуульд ажиглагчаа байнга илгээн оролцуулж байна. Тухайлбал, Японы Хуурай замын Өөрийгөө хамгаалах хүчнээс 2017 оны 7-8 дугаар сар, 2018 оны 6 дугаар сард тус тус оролцож, 2019 оны 6 дугаар сард хамгийн өргөн буюу 60 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцов.²⁵⁶

Монгол Улсын цэргийн эмч нарыг онцгой байдлын үеэрх эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх сургалтад 2018 оны 2 дугаар сар, 2019 оны 3 дугаар сард хамруулав. Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах академи, Батлан хамгаалах судалгааны хүрээлэн, Хуурай замын ӨХХ-ний команд штабын сургалтад 2018 онд 4 сонсогч суралцахаар ирсэн бол 2019 оны хичээлийн жилд 2 сонсогч, 3 офицер суралцахаар ирсэн. 2019 оны байдлаар

²⁵³ Дэслэгч Д.Мөнхзориг, Соёмбо сонин “Япон улсын туршлагыг монголын хөрснөө ...” (2017 оны 08 дугаар сарын 25) <http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1489>

²⁵⁴ Монгол Улсын Батлан хамгаалах яам “Монгол, Японы Засгийн газар хооронд энхийг сахиулах ажиллагаанд хамтран ажиллах гэрээ байгууллаа” (2015 оны 06 дугаар сарын 2) <http://mod.gov.mn/index.php?com=news&id=700>

²⁵⁵ Мөн тэнд

²⁵⁶ Монгол Улсаас Японы улсын Осака хот дахь Консулын газар “Монгол, Японы батлан хамгаалах салбарын харилцаа” <https://osaka.consul.mn/index1.php?moduls=13>

Монгол Улсын Зэвсэгт хүчний 57 офицер Япон улсад суралцаад байна. Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг саадгүй хэрэгжүүлэхэд Японд суралцсан оюутнууд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Цаашид хамтын ажиллагааг төгөлдөржүүлэх чиглэл, боломж:

Нэг. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Япон улстай батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг төгөлдөржүүлэх боломж

Зүүн хойд Азийн бүс нутгийн нөлөө бүхий, аж үйлдвэр өндөр хөгжсөн, хүчирхэг зэвсэгт хүчинтэй орон болох Япон Улстай батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, цэргийн эмнэлэг, цэргийн инженерийн чиглэлд харилцан туршлага судлах, энхийг сахиулах, тусгай хүчин, цэргийн алба хаагчдыг сургах зэрэг чиглэлээр идэвхжүүлэн хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Гамшигт ихээхэн өртдөг бүс нутаг бол Ази, Номхон далай юм. 1970-аас 2014 онд 11,985 удаа байгалийн гамшиг болсны 5,139 нь Ази, Номхон далайн бүс нутагт тохиолдсон байна. Ази, Номхон далайн бүс нутагт хамгийн их давтамжтай тохиолддог байгалийн гамшиг (нийт болсон гамшгийн 64 хувь) нь үер, хар салхи бөгөөд тэдгээрийн дараа газар хөдлөлт (12 хувь), цунами (6.9 хувь) аж.

Ази, Номхон далайг дэд бүсүүдээр нь авч үзвэл Зүүн болон ЗХА нь байгалийн гамшиг хамгийн их тохиолддог дэд бүс нутгийн 3 дугаарт орж байна. Түүнчлэн Зүүн болон ЗХА байгалийн гамшгийн улмаас хамгийн их эдийн засгийн хохирол амссан бүс нутаг болж байна. Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд байгалийн гамшгийн улмаас учирсан нийт хохирлын 68.9 хувь нь уг дэд бүс нутагт ноогдож байна.²⁵⁷ НҮБ-ын Дэлхийн Ш бага хурлаар 2015 онд баталсан 2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн баримт бичигт зааснаар гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдол өгч, үүний тулд улс орнууд бүс нутгийн болон дэд бүс нутгийн хүрээнд хамтын ажиллагааны механизм бий болгохыг үйл ажиллагааныхаа 4 үндсэн зорилго болгосон байна. Үүнээс үзэхэд ЗХА-д гамшигтай тэмцэх, түүний хор хохирлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны механизмыг Монгол Улсад боломжтой.

Бусад бүс нутагтай харьцуулахад ЗХА-д аюулгүй байдлыг хангах механизм байдаггүй. Энэ нь “хүйтэн дайн”-ы үед бүс нутгийн орнуудын хооронд үүссэн газар нутаг, улс төр, түүхийн маргаан шийдэгдээгүйтэй холбоотой. Нөгөө талаар, Умард Солонгосын цөмийн болон пуужингийн хөтөлбөр ЗХА-ийн аюулгүй байдлын орчныг тогтворгүй, эмзэг болгож байна. ЗХА-д гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бүсийн төвийг Монгол Улсын оролцоотой байгуулснаар энэ бүс нутагт тулгамдаад байгаа уламжлалт аюулгүй байдлын сорилтуудыг шийдвэрлэх механизм үүсгэхэд түлхэц үзүүлж, итгэлцлийг бэхжүүлнэ.

Хэдийгээр гамшгийн удирдлага, зохицуулалтын асуудал онцгой байдлын байгууллагын ажил боловч гамшиг тохиолдоход батлан хамгаалах, цэргийн байгууллагууд эн тэргүүнд дайчлагдан, ард иргэдийг авран хамгаалах үүрэг хүлээдэг. НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах газар (UNOHCA)-аас 1994 онд гаргасан “Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд цэрэг, иргэний батлан хамгаалах хөрөнгийг

²⁵⁷ ESCAP Technical Paper Information and Communications Technology and Disaster Risk Reduction Division “Overview of Natural Disasters and their Impacts in Asia and the Pacific, 1970 – 2014” (March, 2017) http://www.unescap.org/sites/default/files/Technical%20paper-Overview%20of%20natural%20hazards%20and%20their%20impacts_final.pdf

ашиглах тухай удирдамж” (Ослогийн удирдамж)-нд цэргийн байгууламж, гадаадын цэргийн чадавхыг “эцсийн арга” болгон ашиглана хэмээн заасныг баримтлан зэвсэгт хүчнийг зөвхөн гамшгийн бэлэн байдлыг хангахад оролцуулах боломжтой.

Хоёр. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Япон улстай эдийн засгийн хамтын ажиллагааг төгөлдөржүүлэх арга зам

Японтой хөрөнгө оруулалт, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд тааламжтай тохиролцоонд хүрэхэд анхаарч, Давхар татвараас зайлсхийх хэлэлцээр байгуулах шаардлагатай байна. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дээр дурдсан хэлэлцээрийг байгуулах юм. Үр дүнд нь, хоёр улсын худалдааны эргэлтийн хэмжээ өснө. Өнөөгийн байдлаар 416 сая ам.доллараар хэмжигдэж буй худалдааны эргэлт нэмэгдэн, хэт өрөөсгөл худалдааны бүтэц тэнцвэржин, алдагдал багасах боломжтой. Түүнчлэн, талуудын хооронд урт хугацааны, тогтвортой үргэлжлэх эдийн засгийн харилцааг бий болгохын зэрэгцээ хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэнэ.

Монгол Улс давхар татварын гэрээг 35 улстай байгуулсан. Үүнээс 26 гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ба эдгээр гэрээний 74 хувийг 1999 оноос өмнө байгуулжээ. Олон улсын жишгээс харахад давхар татварын гэрээнээс хөгжилтэй улс нь илүү ашиг хүртдэгийг шинжээчид онцолдог. Мөн бидний байгуулсан давхар татварын гэрээ, хэлцлүүдэд харилцан мэдээлэл солилцоно гэсэн болохоос ямар мэдээллийг хэдий хугацаанд хэрхэн солилцох, татварын хяналт шалгалтыг улс хооронд яаж хэрэгжүүлэх талаар, хувьцаа борлуулсны ашгаас Монгол Улс татвар авах зохицуулалт зэргийг огт тусгаагүй орхигдуулсан байдгийг цаашид анхаарах шаардлагатай.

Түүнчлэн, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Япон улстай эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх зорилгоор Монгол Улсын нүүрс, зэс, бусад байгалийн эрдэс баялгийг Япон Улсад урт хугацааны турш тогтвортой нийлүүлэх чиглэлд хамтран ажиллах саналтай байна.

Монголын эдийн засаг 2011 онд 17 хувиар өссөнөөс хойш уруудсаар 2016 онд бүр зогсов. Шалтгаан нь гадаадын хөрөнгө оруулалт буурсан, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний үнэ унасан, Хятадын эдийн засгийн өсөлт суларсантай холбоотой. Бүтцийн хувьд уул уурхайн салбар 2005 оноос хойш эдийн засгийн 1/5 нь буюу хамгийн гол хөдөлгүүр болтлоо тэлсэн бөгөөд түүний араас нь худалдаа (17 хувь), ХАА (13), аж үйлдвэрлэл (10) жагсаж байна. Монгол Улсын эдийн засагт гадаадаас нийтдээ 14.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсны 1/4 нь Хятад улсынх, тал нь оффшор бүсийнх аж. Үүний ихэнхийг нь (3/4) уул уурхайн салбар дангаараа бүрдүүлж байна. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2013 он хүртэл алдагдалтай, түүнээс хойш эерэг гарсан нь нийт импорт огцом багасаж, газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах үнэ буурсантай холбоотой. Экспортын 84 хувь нь Хятад руу гардаг бөгөөд бараг бүхэлд нь уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Тиймээс экспортын ганц зах зээлээс хараат байдлыг буруулж, орлогын тогтвортой байдлыг хангах шаардлага бидэнд тулгарч байна. 2004 онтой харьцуулахад л 2012 онд манай нийт экспортод Хятадад ноогдох хувь бараг 2 дахин нэмэгдсэн²⁵⁸ байна. Энэ нь худалдах үнэ, хэмжээ зэргийг тогтоох тухайд тухайн улсын “аманд багтах” эрсдэл учруулж байгаа хэрэг юм.

²⁵⁸ “Mongolia’s Foreign Trade Review”.

<https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2014/201408e.pdf>

Япон улс бол дэлхийн томоохон үйлдвэрлэгч, үүнийгээ дагаад томоохон эрчим хүчний түүхий эдийн хэрэглэгч юм. Харин бидэнд худалдах нөөц нь байна. Талууд өөрсдийн эрэлт хэрэгцээнд суурилан хамтран ажиллах нь чухал юм. Бидний зүгээс дамжин өнгөрөх тээвэр, үнэ ханш зэрэг асуудлаар хоёр хөрштэйгөө тохиролцож чадвал Зүүн Ази руу томоохон зах зээлтэй холбогдох боломжтой.

Тээвэр, ложистикийн хүндрэлээс шалтгаалан манай экспортын бүтээгдэхүүн үнийн хувьд олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвар дутаж байгаа юм. Нүүрсний тухайд гэхэд л одоогийн байдлаар зардлынхаа тал хувийг тээвэрлэлтэд зарцуулж байгаа билээ. Тиймээс цаашид тээвэрлэлтийн хүндрэлийг бууруулах замаар өрсөлдөх чадвараа нэмэхэд анхаарч, дамжин өнгөрөх хоёр хөрштэйгөө улс төр, бизнесийн өргөн хүрээнд яриа хэлэлцээ өрнүүлэх хэрэгтэй. Энэ чиглэлд Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридорын хүрээнд яригдах 32 төслийн нэлээд нь дамжин өнгөрөх тээвэртэй холбоотой ажлууд байгаад үндэслэн ажиллавал зохино.

Японтой уламжлалт эх үүсвэрээс гарган авсан эрчим хүч үйлдвэрлэх чиглэлд хамтрах боломжтой. Дэлхийн нийт эрчим хүчний тавны нэгийг дангаар хэрэглэдэг БНХАУ хэдий сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлээрээ дэлхийд эхний тавд багтдаг ч дотоод хэрэгцээгээ бүрэн дүүрэн хангаж чадахгүй байгаа юм. Энэ нь хил залгаа манай улсын хувьд нэг талаар эрчим хүчээ экспортлох зах зээл дэргэд байгааг илтгэнэ. Уламжлалт буюу нүүрснээс эрчим хүч гарган авах чиглэлд өндөр хөгжилтэй оронд хэрэглэгдэж буй орчин үеийн технологи нэвтрүүлэх боломж бүрдэнэ. Ирэх жилүүдэд Япон улс нүүрснээс эрчим хүч гарган авах 45 цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа²⁵⁹ ба цэвэр нүүрсний технологи нь Монгол Улсын нүүрсний эрчим хүчний станцуудад нэвтрэх боломжтой болно.

Нүүрсний хэрэглээг хязгаарлах, сэргээгдэх эрчим хүчийг өргөн ашиглах, цахилгааны хэрэглээг хэмнэх шаардлага дэлхий нийтийн өмнө урган гарч байна. Дэлхийн дулааралд нөлөө үзүүлж буй компанид хөрөнгө оруулалт, хувьцааг нь авахаас хөрөнгө оруулагчид татгалзаж эхэлнэ. Энэ нь олон улсын эдийн засагт онцгой нөлөө үзүүлж, нүүрсний салбарын хэтийн төлөвийг тун бүрхэг болгох юм. Хэдийгээр нүүрсний эрэлт, хэрэгцээ богино болон дунд хугацаанд байсаар байх ч цаашдаа нүүрсээ шингэрүүлэх, хийжүүлэх талаар бодож, нүүрсний салбараа эл нөхцөлд дасан зохицуулах талаар төлөвлөхгүй бол томоохон эрсдэл үүрч болзошгүй.

Улаанбаатар хотын V дулааны цахилгаан станцыг барьж байгуулах төсөлд оролцох хүсэлтээ илэрхийлсэн Японы хувийн хэвшил, олон улсын консорциумын өнөөг хүртэл явуулж ирсэн үйл ажиллагаанд анхаарч, шийдвэрлэх шаардлагатай байна.

2013 онд Францын Жи ди Эф Суэз, Япон улсын Сожитц корпораци, БНӨСУ Поско энерги, Монголын Ньюком ХХК зэрэг компаниас бүрдсэн түншлэл Vдулааны цахилгаан станцыг барих гүйцэтгэгчээр шалгарсан²⁶⁰. Гүйцэтгэгч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, техник эдийн засгийн үндэслэлийн өөрчлөлт, төмөр замын байгууламж, нүүрсний чанарын болон бусад нарийвчилсан судалгааг өөрийн зардлаар цаг хугацаа алдахгүй хийж, гүйцэтгэх юм. Төсөл нь Монгол Улсын эрчим хүчний салбар дахь Төр-хувийн хэвшлийн анхны түншлэл болж буйгаараа онцлог бөгөөд 1984 оноос хойш Монгол Улсад баригдах гэж буй анхны том хэмжээний дулаан, цахилгааныг

²⁵⁹ “Japanese government planning to build 45 new coal fired power stations to diversify supply”.,<http://www.abc.net.au/news/rural/2017-01-31/japan-coal-power-plants/8224302>

²⁶⁰“ДЦС-5”-ыг барих компаниуд тодров”., <http://vip76.mn/content/19111>

хослон үйлдвэрлэдэг станц болох юм. Тус төслийг 25 жилийн хугацаатай концессын гэрээний дагуу *барих-эзэмших-ашиглах-шилжүүлэх* нөхцөлөөр хэрэгжүүлэх юм.

Гүйцэтгэгч нь 450 МВт цахилгаан, 587 МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэх станцыг барьж байгуулан ажиллуулах юм. Барилга угсралтын ажлын хугацаанд ДЦС-5 төсөлд 2,700 хүртэл ажлын байрыг шууд бий болгож, олон тооны дотоодын туслан гүйцэтгэгч компанийг ажиллуулах боломж бүрдэнэ. Тус станц нь агаарт хаягдах нүүрсхүчлийн хий, азотын ялгарлыг ихээхэн бууруулах, мөн ялгарлын хэмжээнд олон улсын стандартад нийцүүлэн хяналт тавих удирдлага хяналтын систем байрлуулах юм. Үүний зэрэгцээ станцад агаарын хөргөлттэй конденсаторын төхөөрөмж суурилуулснаар хомсдолтой нөөцөд тооцогддог усны хэрэглээг маш их хэмжээгээр бууруулах аж. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурсан байгууллагууд нь уг гэрээний дагуу ДЦС-5-ын үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг бүрэн хэмжээгээр худалдаж авах бөгөөд станцаас нийлүүлэх дулааны эрчим хүчээр Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй дулааны эрэлт хэрэгцээг хангана. Шинэ станц нь хүн амын өсөлт болон уул уурхайн салбараас шалтгаалан өсөн нэмэгдэж буй цахилгааны хэрэглээг хангахад хувь нэмрээ оруулах юм.

ДЦС-5 төсөл нь Монгол Улс дахь тасралтгүй өсөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны хэрэгцээг найдвартай, тогтвортой хангаж, байгаль орчинд ээлтэй, улсын төсөвт үзүүлэх ачаалал дарамтгүй, нийгэмд үр өгөөжтэйгөөс гадна тэргүүний дэвшилтэт технологийг Монголд нутагшуулах юм.

Нэгдүгээрт, ДЦС-5 станцаас агаар мандалд ялгарах утааны хий, азотын исэл, хүхрийн исэл, үнсний ялгарлын хэмжээ нь олон улсын шаардлагын түвшинд байх бөгөөд тоосонцрын жижиг хэсгүүдийн ялгарал нь одоогийнхоос даруй 550 дахин бага байна. Түүнчлэн, дулааны өнөөгийн хэрэглээний түвшний 60 гаруй хувийн өсөлтийг бүрэн хангах хүчин чадлыг бий болгосноор гэр хорооллын айл өрхийн тоог огцом бууруулах нөхцөлийг бий болгож Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад онцгой үүрэг гүйцэтгэнэ.

Хоёрдугаарт, агаарын хөргөлтийн технологи ашиглах тул станцын усны хэрэглээг бусад ДЦС-4-тэй харьцуулахад 7.3 дахин бага хэмжээнд байлгах бололцоог бүрдүүлснээр хотын хамгийн тулгамдсан асуудал болох гүний усыг хэмнэх ач холбогдолтой.

Гурав. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Япон улстай соёлын хамтын ажиллагааг сайжруулах арга зам

Япон улс шинжлэх ухаан, технологийн хөгжлөөрөө дэлхийн тэргүүлэгч орнуудын нэг юм. Тус улс хэдийгээр байгалийн баялаг багатай боловч шинэ технологийг байнга санал болгож, хөгжүүлж чадсанаараа дэлхийд эдийн засгийн хөгжлөөрөө манлайлж байна. Япон цахилгаан автомашин, дижитал камер, оптик утас, хиймэл зүрх зэрэг хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухаан, технологи, анагаах ухааныг ашигласан олон бүтээгдэхүүнийг зохион бүтээж, дэлхийн зах зээлд нийлүүлсэн. Тус улс шинжлэх ухааны хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж байгаагийн гол нууц нь өндөр чанартай боловсрол юм.

Монгол улс, Япон улсын засгийн газар Япон улсад 1005 инженерийг бэлтгэх зорилготой “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг 2014-2023 он хүртэл хамтран хэрэгжүүлж байгаа нь хамтын ажиллагааны нүдээ олсон чиглэл болж байна. Цаашид энэ хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт

бичигт нийцүүлэн инженер бэлтгэх сургалтын чиглэлийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Тус хөтөлбөрийг Япон улсаас олгож буй зээлээр хэрэгжүүлж байгаа учраас зээлийн үр өгөөжийг өндөр байлгахад анхаарч, бэлтгэгдсэн инженерүүд мэргэжлийн дагуу ажиллаж, Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулж буй эсэхэд хяналт тавихад анхаарах нь чухал юм.

Монгол Улсад жүдо бөхийг хөгжүүлэх, энэ спортоор тив, дэлхий, олимпын аваргуудыг төрүүлэхэд жүдо бөхийн өлгий нутаг болох Японтой хамтран ажиллах боломж харагдаж байна. Монголоос 1960-аад оны сүүлээр Бүгд Найрамдах Чех улсад суралцаж байсан оюутнууд жүдо бөхөөр хичээллэж, эх орондоо ирээд жүдогийн дугуйлан байгуулан залуусыг сургах болжээ. Тэд бол Карлын Их сургуулийн оюутан асан Л.Батмөнх, С.Цэвэгжав нар юм. Удалгүй тэдэнтэй герман, чех улсад суралцаж, жүдогоор хичээллэж байсан О.Лодон, Л.Нямцэрэн нар хүч нэмснээр Хөдөлмөр нийгэмлэг дээр Монголын жүдогийн эхлэл тавигдсан билээ. Анхны жүдоч Ч.Машбатын санаачилгаар Японы Кодоканы их сургуультай холбоо тогтоож, 1969 онд Олон улсын жүдо бөхийн холбоо, Японы жүдо бөхийн холбоонд хандан монгол улсад жүдо бөхийг хөгжүүлэх үйлсэд туслахыг хүссэн захидлыг илгээж байжээ.

Албан ёсоор жүдо бөхийг хөгжүүлэх шийдвэр 1971 оны 1 дүгээр сарын 13-нд Сайд нарын Зөвлөлөөс гарч, Биеийн тамир спорт хороонд Жүдо бөхийн шигшээ баг байгуулахаар шийдвэрлэсэн байна. Ингэснээр Монголын жүдочид олон улсын тэмцээнд орох үүд хаалга нээгдсэн юм. Монголын жүдочид Мюнхений олимпын тоглолтод 1972 онд оролцож, тэр жилдээ Азийн болон Олон улсын жүдогийн Холбооны гишүүнчлэлтэй болжээ.

Ази, Номхон далайн бүс нутагт Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөө Японы хувьд аюулгүй байдлын томоохон сорилт бэрхшээл болж байгаа билээ. Хятад энэ бүс нутагт нөлөөгөө тэлэх зорилгоор ширээний теннисийг “зөөлөн хүч”-ний хэрэгсэл болгон ашиглаж байгаа бол Япон улс Хятадыг сэргүүлэн, Ази, Номхон далайн бүс нутагт жүдо бөхөд тулгуурласан дипломат ажиллагаа эрчимтэй явуулж байна.²⁶¹ Японы дипломат бодлогод жүдо бөх чухал байр суурьтай болсныг ашиглан манай улс жүдогийн спортын хөгжлийг урагшлуулахад зохих хэмжээний тусламж, дэмжлэг авахад хамтран ажиллах боломжтой юм.

Хүн амын тоо нь 2010 онд оргил цэгтээ хүрч, 128.5 сая болоод байсан Японы хүн ам энэ зууны эцсээр ердөө 75 сая байна хэмээн НҮБ-ын судалгаанд дурдсан байна. Ингэснээр үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хумигдаж, улсын ДНБ-ий хэмжээ буурч, эдийн засаг царцах эрсдэл хүлээж байгаа юм. Иймд 2019 онд Японы засгийн газар хөдөө аж ахуй, нийгмийн халамж, барилга, зочид буудал, хөлөг онгоцны үйлдвэрлэл зэрэг 5 салбарт 2025 он гэхэд хагас сая ажиллах хүч гаднаас авахаар шийдвэрлэсэн билээ. Тус хуулийн дагуу ур чадвар багатай гадаадын иргэд 5 жилийн хугацаанд Япон улсад амьдрах боломжтой бол нарийн мэргэжилтэй гадаадын иргэд тодорхойгүй хугацаагаар амьдрах нөхцөлийг нь бүрдүүлсэн.²⁶² Мөн хуулийн дагуу 14 мэргэжлээр 9 орноос ажиллах хүч авна гэдгээ тогтоосон.

²⁶¹ Jonathan Barrett “Judo helps Japan get to grips with China’s expansion in Pacific” (Aug 8, 2019) <https://www.reuters.com/article/us-pacific-samoa-judo-idUSKCN1UY01N>

²⁶² Foreign Policy “Japan Radically Increased Immigration- and No one protested” <https://foreignpolicy.com/2020/06/23/japan-immigration-policy-xenophobia-migration/>

Хүн ам нь буурч байгаатай холбогдуулан Япон улс гадаадаас ажиллах хүч авахад нээлттэй хандах болсон нь тус улсад ажиллаж, амьдрах сонирхолтой манай иргэдэд боломж нээж өгч байгаа юм. Япон улсад ажиллах боломжтой болсноор манай иргэд өндөр цалин авч, амьдрал ахуйгаа дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ өндөр хөгжилтэй энэ орны но-хау-гаас суралцах үүд хаалга нээгдэнэ хэмээн үзэж байна. Япон бол техник, технологийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлдэг орнуудын нэг. Ялангуяа, үйлдвэрлэл, бизнесийн салбарын ашгийг огцом нэмж буй хиймэл оюун ухааны салбар нь өндөр хөгжсөн. Ер нь энэ улсын аль ч салбарт ажилласан Монголд нутагшуулахаар шинэ санаа, шинэ технологид суралцах бүрэн боломжтой.

3.3.2 Харилцааны хэтийн төлөв

Хоёр улсын харилцааны хэтийн төлөв дэлхийн дэг журам болон их гүрнүүдийн хоорондын харилцааны өөрчлөлтөөс шууд хамаарах болно.

Харилцааны хэтийн төлөвийг 3.1 болон 3.2 дугаар зүйлүүдэд үүсгэсэн их гүрнүүдийн хоорондын харилцааны сценарууд, тэдгээрийн үүсэж болох хувилбарууд, тэдгээрт Монгол Улсын болон “гуравдагч хөрш” Японы баримталж болох магадлалт байр сууриар тодорхойллоо.

Нэг. АНУ, ОХУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол ба Японы харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ, ОХУ-ын харилцааны эерэг сценар:

- 1. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, улсуудын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, олон улсын байгууллагуудын үүрэг ба бусад улс, үндэстнүүдийн эрх ашгийн үндсэн дээр “Дэлхийн олон туйлт дэг журмыг бататгах”.**

Ийм сценарын үед ОХУ болон Хятадын байр суурь нэгдмэл байх магадлалтай. Монгол Улс Орос–Монгол–Хятад гэсэн эдийн засгийн коридороо хөгжүүлэх талаар хоёр хөрштэйгөө хамтран ажиллахаас гадна “гуравдагч хөрш”-ийн стратегийн түншлэлийн бодлогоо АНУ болон Япон улстай хэвийн үргэлжлүүлэх боломжтой байна. Тиймээс 3.3.1-д санал болгосон батлан хамгаалахын, эдийн засгийн, соёлын хамтын ажиллагааг төгөлдөржүүлэх асуудлыг ажил хэрэг болгох нь Монгол Улсын хөгжилд чухал ач холбогдолтой байх болно. Тухайлбал, Япон улс бол дэлхийн томоохон үйлдвэрлэгч, үүнийгээ дагаад томоохон эрчим хүчний түүхий эдийн хэрэглэгч юм. Харин бидэнд худалдах нөөц нь байна. Талууд өөрсдийн эрэлт хэрэгцээнд суурилан хамтран ажиллаж, манай зүгээс дамжин өнгөрөх тээвэр, үнэ ханш зэрэг асуудлаар хоёр хөрштэйгөө тохиролцож чадвал Зүүн Ази руу томоохон зах зээлтэй холбогдох боломжтой. Энэ нь тээвэр, ложистикийн хүндрэлээс шалтгаалан манай экспортын бүтээгдэхүүн үнийн хувьд олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвар дутаж байгаа болон нүүрсний тухайд гэхэд л одоогийн байдлаар зардлынхаа тал хувийг тээвэрлэлтэд зарцуулж байгаа бэрхшээлээс гарах боломж олгоно.

- 2. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Хятадын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох**

Ийм хувилбар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд ихээхэн зөрчилтэй нөхцөл байдал үүснэ. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт нэгд, АНУ ба Оросын харилцаанаас хамаарахгүйгээр соёл иргэншлийн хувьд Хятадад уусаж устах аюул

заналын эрсдэл, хоёрт, хоёр хөршийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй дарамт, шахалтууд илрэх болно.

Эндээс манай улсын соёл иргэншлийн, улмаар оршин тогтнохуй аюулгүй байдлын хэтийн төлөвийн дархлаа цаашид гадны хэл соёл (ялангуяа хятад)-ын түрэлтийн талаар цогц бодлого авч хэрэгжүүлэхгүй бол улам доройтох дүр зураг харагдаж байна. Ийм нөхцөл байдал зөвхөн энэ сценарт хамаарах бус бүхий л сценарын үед ажиглагдах магадлал өндөр байна. Харин энэ сценарын үед манай улс “гуравдагч хөрш” болон НҮБ-ын дэмжлэгтэйгээр төвч байр суурь баримталж болох таамаглал байна. Ялангуяа “гуравдагч хөрш” Япон улстай соёлын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх замаар Осоакагийн их сургууль, Токиогийн гадаад судлалын их сургууль, Тоохоку их сургууль, Васеда их сургууль, Оотани их сургууль болон олон их дээд сургуульд монгол хэл зааж, монгол судлалыг амжилттай хөгжүүлж байгааг улам бэхжүүлэх боломж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс амин чухал дархлаа мөн” болохыг заасан байна. Чухамхүү үндэсний хэл, соёл иргэншлийн хувьд уусахгүй, ухамсрын хэв шинж, түүний дотор сэтгэлгээ, хэл соёлын нэгдмэл байдлаа бэхжүүлэх нь Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа хангаж, даяаршлын энэ эрин үед оршин тогтнохын нэг үндэс юм.”

3. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Энэ хувилбарын үед манай хоёр том хөршийн хооронд хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх магадлал өндөр байна. Монгол Улсын аюулгүй байдлын хувьд өөрийн үндэстний цөөнхийн талаар оновчтой бодлого явуулах, гаднаас дүрвэгсэд орж ирж болзошгүй нөхцөлд бэлэн байх, терроризмын аюул заналаас сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлага гарна. Хоёр хөрш гүрэн болон “гуравдагч хөрш” Японтой харилцах бодлого хэвийн үргэлжлэх болно. НҮБ-ын байр суурийг дэмжинэ.

4. Оросын засагт оросын үндэсний эрх ашиг сонирхол ба орос соёл иргэншлийн үнэт зүйлсийн системтэй зөрчилдсөн (XX зууны 90-ээд оны эхний хагаст ийм явдал Орост үндсэндээ тохиолдсон) АНУ-ын аливаа нөхцөлүүдийн хараат хамтын ажиллагаанд бэлнээр нээлттэй хандсан эрх барих бүлгүүд гарах.

Ийм сценар үүсвэл Орос, АНУ хоёр Хятадад хамтарч дарамт, шахалт үзүүлэх ба Орос, Хятадын хоорондын харилцаа эрс хүйтэрнэ. Стратегийн чухал байришилтай манай улсад аль аль талаас нь дарамт, шахалт ирнэ. Орос улсад Америкийн талыг баримтлагчдыг эсэргүүцсэн хүмүүс болон эрх баригч талын хоорондох дотоодын зөрчил хурцдаж болно. Мэдээжээр Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорын асуудал зогсонги байдалд орно. Ийм тохиолдолд “гуравдагч хөрш” Японы дэмжлэг чухал ач холбогдолтой болох бөгөөд хамтын ажиллагаа хэвийн хөгжүүлэхэд Хятадын зүгээс ямар нэгэн хэмжээгээр саад учруулна.

5. Дэлхийн хүчний харилцаа бусад улс орнуудтай реалист, шударга харилцаа руу болон өөр (тэгш г.м) зарчмуудын үндсэн дээр олон улсын харилцааг бодитоор босгох бэлэн байдал руу өөрчлөгдөх нөлөөлөл дор АНУ-ын засгийн эрх баригчид аажим хувьсах.

Ийм сценарын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт ихээхэн таатай нөхцөл байх болно. Улс орнуудтай тухайлбал, “гуравдагч хөрш” Японтой өргөн

хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэх, тогтвортой хөгжих хэтийн таатай нөхцөл бүрдэнэ.

Хоёрт. АНУ, ОХУ-ын харилцааны сөрөг сценар:

1. Дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл эрчимжих.

• Оросын зүгээс Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөтгөх магадлалтай. Ийм хувилбар ОХУ ба АНУ-ын хоорондын зэвсэгт мөргөлдөөн үүсэх тулгаралт бага магадлалтай ч өнөөгийн Украины эсрэг Оросын цэргийн тусгай ажиллагаа, Барууныхны Украинд үзүүлж буй дайныг өдөөсөн зэвсгийн тусламж байдлыг бүр хурцатгаж, АНУ болон Хятадын хооронд Өмнөд Хятадын тэнгист зэвсэгт мөргөлдөөн гарна гэсэн зарим судлаачдын таамаглал байгаа бөгөөд АНУ-ын Тайваньд явуулж буй бодлого, Хятадын Тайваны эсрэг шаардлагатай бол зэвсэгт хүчнээ хэрэглэхээ илэрхийлсэн байдал зэрэг нь Орос, Хятад хоёрыг улам нэгдэн нягтрахад хүргэж байна. Ийм тохиолдолд Монгол Улсад АНУ-ын зүгээс Оросын эсрэг хориг, хязгаарлалтын ажиллагаанд нэгдэх талаар шахалт үзүүлэх, манайд үзүүлж буй дэмжлэгээ зогсоох дарамт ирэх магадлал өндөр байх ба Япон улс ч нэгдэх магадлалтай.

Хоёр. АНУ, БНХАУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол болон Японы харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн Шинэтгэл-зарим талаар хоршсон, зарим талаар өрсөлдсөн-санал нийлэлтийн сценар 1 болон Хөдөлгөөнгүй, зогсонги байдлын сценар 2:

1. Эдгээр сценарын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт: нэгд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулж, хоёр хөршийг төдийгүй Ази, Европыг холбох гүүр болох боломжтой байх. нөхцөлүүд бий болох боломж, хоёрт., Хятад улсын зүгээс өр зээлийн дарамтад орж болзошгүй байх эрсдэл гэсэн хоёр зам хүлээж байна.

Боломжийн хувьд БНХАУ-ын Тяньжинь, ОХУ-ын Владивостокийн боомтоор дамжин далайд гарцтай болох буюу түүхий эдийг гуравдагч зах зээлд гаргах нөхцөл бүрдэх бөгөөд “гуравдагч хөрш” Японтой хамтран ажиллах боломж нэмэгдэнэ. Японы Засгийн газар БНХАУ-ын "Бүс ба зам" санаачилгад өсөн нэмэгдэж буй бүс нутаг дахь нөлөө, орон зайг тэнцвэржүүлэх зорилгоор хандаж, бүс нутгийн орнууд БНХАУ-ын нөлөөг тэнцвэржүүлэх тал дээр хамтран ажиллах шаардлагатайг онцолсон байдаг бөгөөд Япон улс цаашид "Бус ба зам" санаачилгын хүрээнд хамтран ажиллах хүсэлтэй байдаг талаар Японы судлаачид тэмдэглэгдэж байгаа нь ийм боломж бий гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Харин эрсдэлийн хувьд зөөлөн хүчний бодлогод автах бус ухаалаг хандаж, Япон улстай хамтран эрсдэлийг үнэлж, бууруулах арга замыг эрэлхийлэх боломжтой. Японы Ерөнхий сайд Шинзо Абэ “Бүс ба зам” санаачилгын талаар "Дэлхийн өөр хоорондоо ялгаатай бүс нутгуудыг холбох бололцоотой бүтэц" хэмээн тодорхойлж, хамтран ажиллах боломжтойгоо илэрхийлсэн байдаг бөгөөд Япон улс стратегийн түншлэлийн хүрээнд манайд өндөр мэргэшсэн инженерүүд бэлтгэхэд тусалж байна..

Хоёрт. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хурцадмал байдал ба сөргөлдөөн хүчтэй болох сценар:

1. 3.2 дугаар зүйлд авч үзсэн АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын хамгийн муу хувилбар Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх асуудлаас болж АНУ ба Хятадын хооронд хурцадмал байдал эрс нэмэгдэж, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн тохиолдолд:

- Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа үргэлжилж, НҮБ зэвсэгт мөргөлдөөнд Хятадыг буруутгасан байр суурь илэрхийлж, асуудлыг Хятадын талаас буулт хийж яриа хэлэлцээрээр шийдвэрлэхийг уриалж, Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжвэл өмнөд хөршийнхөө зүгээс ноцтой дарамт шахалтад өртөх ба эс дэмжвэл Япон улсын зүгээс стратегийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, дэмжлэг зогсонги байдалд орох магадлал өндөр байх болно.

Түүнчлэн Япон улсаас Монголыг шилжилтийн хүнд хэцүү үеийг даван туулахад эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлээд зогсохгүй манай улсын олон улсын механизмд нэгдэн ороход дараах улс төрийн дэмжлэг үзүүлсээр ирсэнтэй ижил төстэй дэмжлэг авах хэрэгцээ гарахад болон өмнөх дэмжлэгийг шат ахиулан гүнзгийрүүлэхэд бэрхшээл үүснэ:

- 1991 оноос Дэлхийн банктэй хамтран Монголд хандивлагчдын уулзалтыг Токио хотноо 10 удаа зохион байгуулсан.
- Япон Улс “Их 7”-гийн дээд хэмжээний 1991, 1992, 1993 оны уулзалтуудын төгсгөлийн баримт бичгүүдэд Монголын ардчиллыг улс төр, эдийн засгийн талаар дэмжих тухай заалтуудыг оруулж байсан.
- Манай улсыг КОКОМ-ын хязгаарлалтаас чөлөөлөх, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн худалдааны байгууллагад элсэхэд дэмжсэн.
- Монгол Улс АСЕМ, АРФ, ПЕКК-ийн гишүүн болох, АПЕК-ийн 4 ажлын хэсэгт ажиглагчаар элсэхэд дэмжлэг үзүүлсэн.
- Монгол Улс ERIA-д оролцоход, улмаар элсэхэд дэмжлэг үзүүлж байна.

Ийм байдалд ороход *нэгд*, Япон нь АНУ-ын холбоотон улс, тиймээс АНУ өөрийн бодлогыг дэмжихийг шаардах, *хоёрт*, Япон бүр эртнээс АНУ-ын Еврази руу чиглэсэн бодлогоо хэрэгжүүлэх тавцан байсан, байсаар ч байх /зургийг хар/, *гуравт*, Япон, Хятадын газар нутгийн маргаан, *дөрөвт*, Япон улсын иргэдийн БНХАУ-ын талаарх сөрөг байр суурь, тухайлбал, 2018 оны 11-р сард Японы Засгийн газраас ард иргэдийнхээ дунд явуулсан "Гадаад бодлогын талаарх санал асуулга"-нд оролцсон нийт иргэдээс "БНХАУ-ыг дэмждэггүй" гэж хариулсан хүний тоо 78.5 хувийг эзэлж байсан бол 2019 оны 9-р сард хийгдсэн судалгаагаар Япон иргэдийн 84.7 хувь нь дээрх хариултыг өгчээ. Түүнчлэн 2018 онд хийгдсэн хоёр улсын хамтарсан санал асуулгын дүнгээс үзвэл Японы иргэдийн 86.3 хувь нь "БНХАУ-д сайнгүй ханддаг" гэж хариулсан байгаа зэрэг хүчин зүйлс түлхэц өгөх болно.



3.3 дугаар зураг. АНУ-ын Еврази руу чиглэсэн эрхшээх бодлого

Эх сурвалж: Фүжий Гэнки. Хамгийн хүчирхэг зэвсэг Геополитик²⁶³

- Орос АНУ-тай түр холбоотны харилцаа тогтоох тохиолдолд Орос, Хятадын хоорондын харилцаа хурцдах ба Монгол Улс НҮБ-ын байр суурь ямар байхаас хамаарахгүйгээр зэвсэгт мөргөлдөөнийг зөвтгөхгүй, аль нэгийг нь дэмжихгүй төвийг сахисан байр суурь илэрхийлбэл Японтой тогтоосон стратегийн түншлэлийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүд хэвийн үргэлжлэх магадлалтай байх болно.

2. АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын АНУ, Хятад хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэхгүйгээр худалдааны дайн улам гүнзгийрч, удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Монгол Улс аюулгүй байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, бүрэн эрхт байдлын хувьд том сорилттой нүүр тулгарна.

- Худалдааны дайн дэлхийн эдийн засгийг ч бүхэлд нь туйлдуулж, гуравдагч орнууд ч хохирох учир манай улс болон Японы эдийн засгийн хөгжилд эрсдэл бий болно. Ийм нөхцөл үүсэхэд стратегийн түншлэлийн гэрээний дагуу Японтой тогтоосон нягт хамтын ажиллагаа худалдааны дайнаас ирэх геополитикийн дарамт, шахалтыг даван туулах гол стратеги байж болох талтай. Япон улсын зүгээс зарим дэмжлэг, тусламж багасах магадлалтай.

Гурав. ОХУ ба БНХАУ-ын улсын харилцааны хэтийн төлөв

Нэгд. ОХУ ба Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны сценар.

1. Монгол Улсад Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хоёр хөршийн болон “гуравдагч хөрш”-ийн, ялангуяа Японы талаар ухаалаг бодлого баримталбал аюулгүй байдлын хэтийн төлөв ихээхэн эерэг төсөөлөлтэй байна.

Япон ч манай улстай өнөөгийн харилцаагаа улам бэхжүүлэхэд чиглэсэн бодлого явуулах магадлалтай. Хятадын “Нэг бүс ба нэг зам” стратегийн хүрээнд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорыг төлөвлөлтийн дагуу хөгжүүлэх боломж байна. Чингэхдээ үндэсний аюулгүй байдлаа хангаж тогтвортой хөгжих үүднээс гадны судлаач “Монголчууд бараг бүх түүхий эд материал нь Хятад руу явдгийг, улс төр эдийн засагт нь Хятадын нөлөө улам ихсэж байгааг мэддэг хэдий ч энэ талаар ямар дорвитой арга хэмжээ аваагүй ажээ. Хятадын компаниуд Монголын нөлөө бүхий албан тушаалтнуудыг авлигадаж, хайгуулын лицензээ нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн жижиг компаниудыг өч төчнөөнөөр нь худалдан авчээ...” гэж анхааруулсныг санах хэрэгтэй.

²⁶³ Г.Фүжий. Хамгийн хүчирхэг зэвсэг геополитик /Ц.Буянцогтоогийн орчуулга/. МУИС-ын ОУХНУС, Еврази ССХ, 2022, 248 х., т.

Хоёрт. ОХУ ба Хятад хоорондын зөрчилдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болзошгүй сценар:

1. Хоёр хөршийн аль аль талаас нь өөрийн талд орохыг шаардсан хүнд дарамт, шахалт ирэх.

Монгол Улс сөргөлдөгч хоёр талын аль нэгнийх нь талд татагдан орох аюул занал тулгарна. Ийм сценарын үед хоёр зам байна. *Нэгд*, төвийг сахих. Гэхдээ ийм оролдлого хийх нь хөрш хоёр гүрний зүгээс дэмжлэг авахгүй байх болно. *Хоёрт*, хоёр хөршийн хэн нэгний нь холбоотон болох. Энэ тохиолдолд Дорнынхон ОХУ-ыг аюул заналхийлэл гэж нэг их үздэггүй логикоос харвал Монгол нь ОХУ-тай цэргийн холбоотны харилцааг сэргээх магадлал байж болох талтай. Доктор Р.Болд ийм төлөв байж болох талаар тэмдэглэсэн байна. Мөн “гуравдагч хөрш”-үүдээс, түүнчлэн Япон улсаас болон НҮБ-аас улс төрийн дэмжлэг хүсэх болно.

“Бие биеэ гол өрсөлдөгчөөрөө зарлаад байгаа АНУ, БНХАУ, ОХУ-ын хоорондын харилцаа эрс хурцдах, дайны байдалд хүрэх тохиолдолд "гуравдагч хөрш"-ийн бодлого бодит эрсдэлд орох магадлалтай. Монгол Улс хаалттай бодлого баримтлах, аль нэг хөршөө дагаж бусдаас нь хөндийрэх туйлшралд автвал "гуравдагч хөрш"-ийн бодлого эрсдэлд орох болно.” гэсэн судлаачдын дүгнэлт энэ сценарын үед үүсэх эрсдэлийг бодитой илэрхийлж байна.

НОМ ЗҮЙ

1. Үнэн сонин, Улаанбаатар 1972.02.19
2. Б.Сэржав “Монгол, Японы дипломат харилцаа: гүнзгийрэл, чиг хандлага” Олон улс судлал №1 (107), 2017 он. 5-23 дугаар тал
3. Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам “Монгол, Японы улс төрийн харилцааны тойм” <https://tokyo.embassy.mn/index1.php?moduls=12>
4. “Стратегийн түншлэлийн харилцаа байгуулахад чиглэсэн Монгол Улс, Япон улсын хамтарсан мэдэгдэл”, 2010.11.19
5. Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон улсад айлчилна” <https://zasag.mn/news/view/21371>
6. Өнөөдөр сонин “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Японд айлчилна” <https://unuudur.mn/?p=181237>
7. Монгол Улсын Гадаад харилцааны яам “Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном 2017”, Улаанбаатар хот, 2018 он <http://mfa.gov.mn/wp-content/uploads/2021/01/blue-book-2017.pdf>
8. Засгийн газрын мэдээ, Улаанбаатар, 2015.03.25, № 053(077)
9. Япон улсын ЭСЯ, Гадаад оюутны солилцоо. <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/gyuugaku.htm>
10. Монголын докторууд Токиод чууллаа, <http://www.mfa.gov.mn/?p=40560>
11. Японд 1000 инженер бэлдэнэ, 2016-01-29. <http://news.num.edu.mn/?p=31949>
12. Монгол судлалын мэдээллийн нэгдсэн сан. <http://www.mongolstudies.gov.mn/index.php/en/mongolia/asia/2015-11-15-06-50-52/2015-11-15-06-58-06>

13. ГХЯ, Монгол, Японы харилцааны товч лавлах.
http://www.mfa.gov.mn/?page_id=14886#1489665313491-046e3cfb-6626
14. Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ, Соёлын Ерөнхий Буцалтгүй Тусламж.
<http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/bunkamusyou.htm>
15. Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ, Соёлын Өвсний Үндэс Буцалтгүй Тусламж.
<http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/kusanone.htm>
16. Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв, <http://www.japan-center.mn/home.shtml;jsessionid=C400ED1CA382D0979038D8846C0351C8>
17. Монгол улсаас Япон улсад суугаа ЭСЯ
<http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=17>
18. БОАЖЯ, 2016 оны жилийн эцсийн мэдээг 2015 оны мөн үетэй харьцуулсан мэдээ<http://tourism.ub.gov.mn/wp-content/uploads/2017/01/2016-onii-jiliin-etses.pdf>
19. VIP76 “Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ Японы Батлан хамгаалах яамны бодлогын газрын захирал Омасу Изаваг хүлээн авч уулзлаа” (2017 оны 8 дугаар сарын 29) <http://vip76.mn/content/47939>
20. Дэслэгч Д.Мөнхзориг, Соёмбо сонин “Япон улсын туршлагыг монголын хөрснөө” (2017 оны 08 дугаар сарын 25)<http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1489>
21. Монгол Улсын Батлан хамгаалах яам “Монгол, Японы Засгийн газар хооронд энхийг сахиулах ажиллагаанд хамтран ажиллах гэрээ байгууллаа” (2015 оны 06 дугаар сарын 2)<http://mod.gov.mn/index.php?com=news&id=700>
22. Монгол Улсаас Японы улсын Осака хот дахь Консулын газар “Монгол, Японы батлан хамгаалах салбарын харилцаа” <https://osaka.consul.mn/index1.php?moduls=13>
23. ESCAP Technical Paper Information and Communications Technology and Disaster Risk Reduction Division “Overview of Natural Disasters and their Impacts in Asia and the Pacific, 1970 – 2014” (March, 2017)
http://www.unescap.org/sites/default/files/Technical%20paper-Overview%20of%20natural%20hazards%20and%20their%20impacts_final.pdf
24. “Mongolia’s Foreign Trade Review”.,
<https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2014/201408e.pdf>
25. “Japanese government planning to build 45 new coal fired power stations to diversify supply”.,<http://www.abc.net.au/news/rural/2017-01-31/japan-coal-power-plants/8224302>
26. “ДЦС-5”-ыг барих компаниуд тодров”., <http://vip76.mn/content/19111>
27. Jonathan Barrett “Judo helps Japan get to grips with China's expansion in Pacific” (Aug 8, 2019) <https://www.reuters.com/article/us-pacific-samoa-judo-idUSKCN1UY01N>
28. Foreign Policy “Japan Radically Increased Immigration- and No one protested” <https://foreignpolicy.com/2020/06/23/japan-immigration-policy-xenophobia-migration/>
29. Г.Фүжий. Хамгийн хүчирхэг зэвсэг геополитик /Ц.Буянцогиигийн орчуулга/. МУИС-ын ОУХНУС, Еврази ССХ, 2022.

3.4 Монгол, БНСУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв

3.4.1 Харилцааны түүхэн болон өнөөгийн байдал

Улс төрийн харилцаа

Монгол Улс 1990 онд ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн сонголтыг хийсэн даруйдаа тэр үеийн Азийн социалист орнуудаас БНСУ-тай хамгийн түрүүнд 1990 оны 3-р сарын 26-нд дипломат харилцаа тогтоосон билээ.²⁶⁴ Өнгөрсөн хугацаанд хоёр орны харилцаа улс төр, аюулгүй байдал, худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагаа, соёл боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэг, аялал жуулчлал, мон иргэд хоорондын харилцаа гээд бүхий л талаар тасралтгүй хөгжиж ирсэн билээ. Богино хугацаанд харилцаа, хамтын ажиллагаа хөгжин тэлсэн цаад суурь хөрс нь Монгол, Солонгосын түүхэн харилцааны уламжлал, ялангуяа Монголын эзэнт гүрний үеийн найрсаг харилцаа байсан гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, энэ бүхний суурь нь бидний түүх, угсаа гарал, соёлын ижил төстэй байдал байсан юм. Тиймээс дипломат харилцаа тогтоосон даруйд хамгийн түрүүнд хамтран ажилласан салбар нь түүх, археологийн салбар байлаа. Хоёр орны ШУ-ны хамтын ажиллагааны эхлэлийг тавигчид нь түүхчид, археологичид байсан бөгөөд энэ үйлсэд Монголын талаас ШУ-ны академийн Түүхийн хүрээлэнгийн судлаачид анхдагч, чухал үүрэг гүйцэтгэсэн юм.²⁶⁵

Монгол Улс, БНСУ газар зүйн байрлалын хувьд нэг бүс нутагт оршдог, улс төрийн системийн хувьд ардчилсан засаглал, зах зээлийн тогтолцооны хувьд чөлөөт зах зээлийн эдийн засагтай, аль аль нь хөрш зэргэлдээ их гүрнүүдийн стратегийн ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалж, жийргэвч улсын үүрэг гүйцэтгэж байх геополитикийн эмзэг орчинд оршдог.

Хоёр улсын хооронд цэрэг улс төр, аюулгүй байдлын бодит аюул занал, түүхийн болон газар нутгийн аливаа маргаан, гажуудал, шашны болон соёлын үл ойлголцол зэрэг уламжлалт болон уламжлалт бус тогтворгүй байдалтай холбоотой асуудал байхгүй. Тиймээс хоёр тал бие биеэ тусгаар тогтнол, эрх ашигт аюул занал учруулах улс гэж үздэггүй. Эдгээр нийтлэг талууд, ижил төстэй байдал нь хоёр улсын хооронд итгэлцлийг бий болгож, хамтран ажиллахад нь эергээр нөлөөлж ирсэн. Үүнээс гадна бас хоёр улсын аюулгүй байдал, гадаад бодлогод нөлөөлөх ижил төстэй, нийтлэг хэд хэдэн хүчин зүйл ажиглагдаж байна. *Нэгдүгээрт*, аль аль нь их гүрнүүдийн хүрээлэл дунд оршиж байна, *хоёрт*, тийм болохоор хүрээлэн байгаа их гүрнүүдийн нөлөөлөл, стратегийн шууд болон дам ашиг сонирхлын объект болж байдаг, *гуравт*, гадаад бодлого нь тэдгээр их гүрнүүдээс хамаарал ихтэй, тэр хамаарал нь нэг орноор зогсохгүй хэд хэдэн орны эрх ашгийн солбицол болдог, *дөрөвт*, ийм нөхцөлд үндэсний аюулгүй байдлынхаа таатай гадаад орчинг бүрдүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт өөрийн гэсэн орон зай, байр сууриа эзэлж, бататгах адилхан зорилт тавигдаж байна. Хүрээлэл дунд байгаа энэ байдал нь нэг талаар эерэг, нөгөө талаар сөрөг үр дагавартай. Өөрөөр хэлбэл бодлого зөв явуулж чадвал боломж, эс чадвал үндэсний аюулгүй байдалд нь хохирол учрах эмзэг шинжтэй. Энэ боломж, эс боломжийн ижил төстэй тал нь Монгол, Солонгос хоёр улс энэ олон талын эрх ашиг солбилцсон харилцаан дотор хоёр талынхаа харилцаа, хамтын ажиллагааг дээд зэргээр эрчимжүүлж, ойрхон нягтрахыг шаардаж байна. Энэ бол үндэсний аюулгүй байдал, оршин тогтнохынх нь баталгааг хангах нэг гарц болж өгнө. Иймээс энэ бүс

²⁶⁴ Г.Мөнхсайхан. Зүүн хойд Азийн эрин үе ба Монголын эдийн засаг. 2010 он.Шим И. Соб, т.31

²⁶⁵ Монгол-Солонгосын харилцаа. 2015 он. т.3

нутгийн тогтвортой байдлыг хангахын төлөөх тус хоёр улсын улс төрийн хамтын ажиллагаа ойртон нягтрах ёстой. Үүнд Солонгосын Хойгт бат бэх энх тайван тогтоох, Умард Солонгосын цөмийн зэвсгийн асуудлыг шийдвэрлэж, улмаар Солонгосын Хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох зорилт хамрагдана.²⁶⁶

1990 онд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр улсын Төрийн тэргүүн нарын удаа дараа явуулсан харилцан айлчлалын үр дүнд хоёр талын харилцаа бодитоор хөгжиж эхэлсэн. 1991 онд БНМАУ-ын анхны Ерөнхийлөгч П.Очирбатын БНСУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр агаарын тээврийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрээс эхлээд олон тооны хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрүүдийг үзэглэсэн нь хоёр орны иргэд хооронд худалдаа эдийн засаг, соёл, боловсрол, иргэд хоорондын харилцаа бодитоор хөгжих эрх зүйн үндсийг тавьж өгсөн юм.

Хоёр тал 1999 онд Ерөнхийлөгч Ким Дэ Жүний айлчлалын үеэр “21-р зуунд чиглэсэн харилцан нөхсөн хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа”-г хөгжүүлэхээр тунхагласан. 2006 оны Ну Мү /Хёний айлчлалаар “Сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа”-нд хүргэж нэг шат ахиулсан бол 2011 оны, И Мён Пакийн айлчлалын үр дүнд хоёр орны харилцааг “иж бүрэн түншлэлийн харилцаа”-ны зарчимд тулгуурлан бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэхээр тогтсон юм. Хоёр тал дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тохиолдуулан хоёр улсын харилцааг дахин нэг шат ахиулан “стратегийн түншлэлийн харилцаа 7-нд хүргэхээр тохиролцсон боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлын уршгаар уулзалт хэлэлцээр хойшлогдоод байна. Өнгөрсөн хугацаанд хоёр талын хооронд төрийн айлчлал 6 удаа, дээд хэмжээний албан айлчлал 2 удаа, төрийн өндөр албан тушаалтнуудын айлчлал 29 удаа явагдаж, Засгийн газар хоорондын 32 гэрээ хэлэлцээр үзэглэжээ²⁶⁷.

1996 онд атташегийн түвшинд эхэлсэн хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа 1999 онд “Цэргийн салбарт хамтран ажиллах тухай батлан хамгаалах яам хоорондын хэлэлцээр” байгуулагдсанаар хоёр талын итгэлцлийг бэхжүүлэх, цэргийн харилцаа, Хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндэс тавигдаж, цэргийн бүх түвшинд төлөөлөгчид солилцох, яам хоорондын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, боловсон хүчин сургах, энхийг сахиулах чиглэлээр хамтарсан сургууль хийх зэргээр харилцаа хөгжиж байна. Монгол Улсад жил бүр зохион байгуулдаг “Хааны эрэлд” олон улсын хамтарсан сургуулилалтад БНСУ-ын Зэвсэгт хүчний баг 2006 "оноос хойш тасралтгүй оролцож байна.²⁶⁸

БНСУ-ын гадаад бодлогод баримтлах үндсэн баримт бичгийн тухайд, 5 жил тутамд буюу шинэ газар бүрэлдмэгц ерөнхийлөгчийн шууд харьяаны байгууллага болох Үндэсний Аюулгүйн Зөвлөл (Office of National Security)-өөс гадаад бодлого, аюулгүй байдал, батлан хамгаалах, үндэстний нэгдлийн бодлогын үндсэн чиг баримтлал болгож “Засгийн газрын баримтлах аюулгүй байдлын стратеги (National Security Strategy)” хэмээх зөвлөмж бичиг буюу үзэл баримтлалыг гаргадаг байна. Ну Мү Хёны засгийн газар (2004 он) Солонгосын хойг болон Зүүн Хойд Азийн хамтын хөгжил цэцэглэлтийг онцлон авч үзсэн “Энхтайван, хөгжил цэцэглэлт ба аюулгүй байдал” баримт бичгийг гаргасан бол И

²⁶⁶ Б.Лхагва. Зүүн хойд Азийн эрин үе ба Монголын эдийн засаг. ЗХА-ийн интеграци: Монгол, БНСУ-ын харилцаа. т.35

²⁶⁷ 대한민국 외무부. 국가정보 http://www.mofa.go.kr/www/nation/m_3458/view.do?seq=5

²⁶⁸ Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого: Гурвалсан хамтын ажиллагааг хөгжүүлжүүлэх бодлого” судалгааны тайлан. 2017 он хуудас 142-143.

Мён Падын засгийн газар (2009 он) Өмнөд, Умард Солонгосын харилцаанд зэрэгцэн оршиж, хамтдаа хөгжих бодит үр ашигтай гадаад бодлогыг баримталсан “төгөлдөршсөн дэлхийн улс” байхыг эрмэлзэнэ хэмээн зарлаж байжээ. Ерөнхийлөгч Пак Гын Хэ (2014 он) Солонгосын хойгийн энхтайвны үйл явц ба нэгдлийн эрин үед бэлэн байхыг зорилго болгосон “Хүсэл эрмэлзэл дүүрэн шинэ үеийн аюулгүй байдлын стратеги” хэмээх баримт бичгийг тунхагласан. “Мүн Жэ Ины Засгийн газрын баримтлах аюулгүй байдлын стратеги” хэмээх баримт бичгийг тунхагласан. “Мүн Жэ Ины Засгийн газрыг баримтлах аюулгүй байдлын стратеги” бодлогын баримт бичиг Засгийн газар гараагаа эхэлснээс хойш жил хагасын дараа буюу 2018 оны 12-р сарын 20-ний өдөр эцсийн байдлаар батлагдан гарсан нь Умард, Өмнөд Солонгосын дээд хэмжээний уулзалт 3 удаа, Умард Солонгос, АНУ-ын дээд хэмжээний уулзалт анх удаа зохион байгуулагдсан зэрэг аюулгүй байдлын орчин, нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой юм.²⁶⁹

“Мүн Жэ Ины Засгийн газрын баримтлах аюулгүй байдлын стратеги” бодлогын баримт бичигт төрийн үндсэн бодлого болох “Солонгосын хойгийн энх тайван, хөгжил цэцэглэлт”-ийн төлөө Умард Солонгосын цөмийн асуудлыг энх тайванчаар шийдвэрлэх, үүрдийн энх тайвныг тогтоох, Зүүн Хойд Азийн бүс нутаг болон дэлхий дахины энх тайван, хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, ард иргэдийнхээ аюулгүй байдал, амь насыг хамгаалах, амар амгалан нийгмийг цогцлоон бүтээх гэсэн аюулгүй байдал, гадаад бодлогын зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх стратеги зэргийг тодорхойлсон. Солонгосын хойгт энх тайвныг тогтоох үйлсэд БНСУ-ын тэргүүлэх үүрэг ролийг онцлон, Өмнөд, Умард Солонгосын харилцаа, хамтын хөгжил цэцэглэлтийг бодитоор хэрэгжүүлэхийн төлөө хоёр талын яриа хэлэлцээрийг тогтмолжуулах, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, Солонгосын хойгт эдийн засгийн хөтөлбөр явуулах зэрэг стратеги зорилтуудыг нэг бүрчлэн заажээ. Түүнчлэн БНСУ, АНУ-ын холбоотны харилцаа, дөрвөн их хөрштэйгөө явуулах тэнцвэрт гадаад бодлого, бүс нутгийн хүрээнд явуулах олон талт гадаад бодлогуудын талаар тодорхой заасан байна.²⁷⁰

Энэхүү аюулгүй байдлын үзэл баримтлалын 6.2-т БНСУ-ын гадаад бодлогын хүрээнд Монгол Улстай хамтран ажиллах чиг баримжааг дараах байдлаар дурдсан байна. Уг баримт бичигт:

“Шинэ умардын бодлого” нь ОХУ, БНХАУ, Монгол, Төв Азийн орнууд зэрэг Евроазийн орнуудтай зам тээвэр, тээвэр зууч, эрчим хүчний дэд бүтцийг холбосноор, өөрийн орны эдийн засгийн хөгжлийн шинэ хөдөлгөх хүчийг бий болгох, Солонгосын хойг болон Евразийн эх газрын энх тайван, хөгжил цэцэглэлтийг цогцлоон бүтээхийн төлөөх бодлого юм. Иймд эдгээр улс орнуудын бүс нутаг дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх санаачилгуудтай “Шинэ умардын бодлого”-ыг холбон, Евразийн бүс нутагтай эрчим хүч, тээвэр зуучийн сүлжээг байгуулж, эдийн засгийн үр ашгийг бүтээхийн төлөө хичээнэ. Евразийн орнуудтай хамтын ажиллагаа, түншлэлийн харилцаагаа бататгаж Солонгосын хойгоос эхлэн Төв Азийг хөндлөн туулж, Европ тивд Евразийн эх газрын

²⁶⁹ 연합뉴스, 문정부 국가안보전략 지침서 나왔다. . “평화 만들기 주도적 역할”, 2018 년 12 월 20 일, <https://www.yna.co.kr/view/AKR20181220114100001> -대한민국 통일부, -국가안보 최성위 지침서, 문재인 정부의 국가안보전략' 발간, 2018 년 12 월 21 일.

https://www.unikorea.go.kr/unikorea/policy/koreapolicy/berlin/?boardId=bbs_0000000000000063&mode=view&cntId=54379&category=&pageIdx=

²⁷⁰대한민국 국가안보실, “문재인 정부의 국가안보전략” 지침서, 2018 년. 7.93-94

энхтайван, хөгжил цэцэглэлтийн бүсийг байгуулах болно" хэмээн заасан байна. Үүгээр Монгол Улстай бүс нутгийн түвшинд хамтран ажиллах чиг баримжааг тодорхойлж, тус улсын гадаад бодлого дахь Монголын байр суурь, оролцоог илэрхийлсэн болно.

БНСУ-ын Гадаад Хэргийн Яамны “Гадаад бодлогын цагаан ном 2019” тайлан бичгийн II бүлэгт Солонгосын хойгийн энх тайван ба бүс нутгийн хамтын ажиллагааг ахиулах талаар авч явуулсан гадаад бодлогынхоо талаар тайлагнахдаа Монгол Улс, БНСУ-ын улс төрийн харилцааны хүрээнд явагдсан дээд хэмжээний айлчлал, уулзалтууд, түүнчлэн “Шинэ умардын бодлого”-ын хүрээнд 2017 оноос хойш тогтмол зохион байгуулсан “Зүүн Хойд Азийн энх тайвны хамтын ажиллагааны форум” бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны яриа хэлэлцээрийн нэг хэсэг болж, Сэжун судалгааны хүрээлэн болон Монгол Улсын Стратеги Судлалын Хүрээлэнгийн хооронд удаа дараа явагдсан уулзалтуудыг онцлон дурдсан байна.²⁷¹

Сүүлийн 10 жилийн гадаад бодлогын зорилтуудаас харахад БНСУ-ын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар эрэмбэлж болно. Үүнд:

- Солонгосын хойгийн аюулгүй байдал, энхтайван, тогтвортой байдлыг хангах (Умард Солонгостой харилцаагаа сэргээх).
- Дөрвөн их хөрштэйгөө хамтын ажиллагаагаа бэхжүүлэх.
- Бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх.
- Олон улсын хамтын нийгэмлэгт чиглэсэн хамтын ажиллагаа.
- Өөрийн орны ард иргэдэд чиглэсэн гадаад бодлого.

Ерөнхийлөгч Мүн Жэ Иний (2017 оноос хойш өнөөг хүртэл) хувьд Солонгосын хойгийн энхтайвны үйл явцыг урагшлуулах, дөрвөн их хөрш болох АНУ, БНХАУ, Япон, ОХУ-тай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, олон талт гадаад бодлого явуулж, олон улсад үүрэг ролио өргөжүүлж, нэр хүндээ өсгөх, гадаад бодлогод ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн гадаад бодлогын зорилтуудыг тавин ажиллаж байна. Ерөнхийлөгч Пак Гын Хэгийн “Зүүн Хойд Азийн энхтайвны хамтын ажиллагаа” хөтөлбөр, “Евразийн санаачилга” зэрэг нь өнөөдөр Мүн Жэ Ин ерөнхийлөгчийн Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааны орчинг бүрдүүлэх зорилгын хүрээнд “Зүүн Хойд Азийн хамтын нийгэмлэг” төсөл, “Шинэ умардын бодлого” нэрээр хэрэгжсээр байна.

Мүн Жэ Ины Засгийн Газраас явуулж эхэлсэн “Зүүн Хойд Ази нэмэх нь” хамтын нийгэмлэг төсөл нь бүс нутгийн олон талт хамтын ажиллагааг явуулах зорилго бүхий “Зүүн Хойд Азийн энхтайван, хамтын ажиллагааны хөтөлбөр”, өмнөд, умард бүс нутгийг “хөгжил цэцэглэлтийн гол шугам” болгон хөгжүүлэх “Шинэ өмнөдийн бодлого” болон “Шинэ умардын бодлого” гэсэн 3 үндсэн хөтөлбөрөөс бүрдэж байна.

Бүс нутгийн талаарх БНСУ-ын гадаад бодлогын зорилттой Монгол улсын бодлого, үйл ажиллагаа олон талаар уялдаж байна.²⁷² Үүний баталгаа нь хоёр улсын тэргүүн нарын цахим уулзалтын хэлэлцээрт тусгагдсан байдаг. Хоёр улсын төрийн тэргүүн нар бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагааг бэхжүүлж, НҮБ болон бусад олон улсын байгууллагын хүрээнд хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхээр тогтов. Үүнд:

- Хоёр улсын батлан хамгаалах салбарт өндөр түвшний айлчлал, яриа хэлэлцээг тогтмолжуулах, цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ хамтарсан

²⁷¹ 대한민국 외교부, “2019 외교백서“, 2019 년. p2.63-65.

²⁷² Нэгдсэн Солонгос улс айсуу. Б.Лхагва. 2015 он 155-159 тал

хээрийн сургууль зохион байгуулах, боловсон хүчин бэлтгэх чиглэлд хамтын ажиллагааг бэхжүүлэх;

- Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгаж, энх тайвныг мөнхөд цогцлоох асуудлыг эв зүйгээр, яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх хэрэгтэй гэдэгт санал нэгдэв. Талууд хоёр Солонгосын яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны чухлыг онцолж, Зүүн хойд Ази, Солонгосын хойгийн харилцан сонирхсон асуудлаар тогтмол санал солилцож, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтэд хамтран хувь нэмэр оруулахын төлөө байгааг санал нэгтэй илэрхийлэв.
- Монгол Улсын “Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг БНСУ дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч тус санаачилгын хүрээнд идэвхтэй хамтран ажиллах;
- БНСУ-ын дэвшүүлсэн “Шинэ Умардын бодлого”, “Халдварт өвчнийг хянах, эрүүл мэндийг хамгаалах Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны санаачилга”, “Зүүн хойд Азийн энх тайван, хамтын ажиллагааны платформ” санаачилгыг Монгол Улс дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч эдгээр санаачилгын хүрээнд идэвхтэй хамтран ажиллах;
- Хоёр улс Зүүн хойд Азийн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт санал нэгдэхийн сацуу цаашид бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаарх хоёр улсын хүчин чармайлтын уялдаа холбоог хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- “Халдварт өвчнийг хянах, эрүүл мэндийг хамгаалах Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны санаачилга”-ын бодит үр дүн гаргахын тулд хоёр улсын эрүүл мэнд, халдвараас сэргийлэх хэрэгслийн хамтын нөөцийг бүрдүүлэх ажлыг туршилтаар хэрэгжүүлснийг үнэлэв.
- НҮБ болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд олон улс, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, ардчилал, хүний эрх, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, дэвшилтэд технологи зэрэг өргөн хүрээнд хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх;
- Бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграцид нэгдэх санаачилгыг харилцан дэмжиж ажиллахаа нотлов. Энэ хүрээнд солонгосын тал Монгол Улсын Зүүн Азийн дээд түвшний уулзалт (EAS)-д оролцох болон Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны механизм дахь оролцоог өргөжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг анхааралдаа авч, Монгол Улстай нягт хамтран ажиллахаа илэрхийлсэн байдаг.

Хоёр улсын төрийн тэргүүн нарын энэ удаагийн дээд түвшний уулзалт нь Монгол Улс, БНСУ-ын харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд дэвшүүлэн хөгжүүлэх, хоёр улсын харилцааны шинэ түүхэн үеийг нээж буй чухал ач холбогдолтой үйл явдал болсон.²⁷³

Эдийн засгийн харилцаа

²⁷³ Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин нар 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр дээд түвшний цахим уулзалт

Монгол улсын гадаад худалдааны бүтэц нь сүүлийн жилүүдэд нилээд өөрчлөгдөж өндөр хөгжилтэй орнууд болон зүүн хойд азийн орнууд руу чиглэн, одоо дэлхийн 15 орчим улс орнуудтай гадаад худалдаа хийж байна. Монгол-Солонгос улсын гадаад худалдааны хамтын ажиллагаа нь 1985 оноос эхэлсэн гэж үзэж болох бөгөөд 1991 он хүртэл маш бага хэмжээний бүтээгдэхүүнийг манай улс экспортолж байсан байна. Хоёр улсын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаа голлох байр суурь эзэлж ирсэн.

1991 онд Засгийн газар хооронд “Худалдааны хэлэлцээр”, “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамгаалах тухай хэлэлцээр”, 1992 онд “Орлогын татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай конвенц”, “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээр” байгуулагдсанаар хоёр улсын хооронд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн юм.

2015 оноос хоёр улсын түншлэлийн харилцааг шат ахиулахад эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зээл тусламжийн төслүүдийн хэрэгжилтийг урагшлуулах, цаашлаад чөлөөт худалдааны хэлэлцээрт бэлтгэх зорилгоор Засгийн газар хоорондын хамтарсан хороог байгуулан ажиллаж байна. Юуны өмнө Монголын эдийн засгийн хөгжилд БНСУ-тай хөгжүүлж буй түншлэлийн харилцаа чухал ач холбогдолтойг онцлон дурдах нь зүйтэй.

БНСУ-тай хийсэн манай улсын нийт худалдааны эргэлт 1990-2015 оны хооронд 100 дахин нэмэгдсэн хэдий ч өнөөгийн байдлаар талуудын эдийн засгийн хамтын ажиллагаа хүсэн хүлээсэн түвшинд хүрээгүй байна.

Хоёр орны худалдааны эргэлт 2012 онд оргил цэгт буюу 480 сая ам.доллар хүрч байсан хэдий ч 2017 оны эцсийн байдлаар 209 сая ам.доллар болж буурсан. Хоёр орны нийт худалдаанд БНСУ-аас импортоор авдаг бараа бүтээгдэхүүний хувь хэмжээ дийлэнх хэсгийг эзэлж байгаад анхаарч, цаашид худалдааны тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, Монголын экспортыг нэмэгдүүлэх нь манай улсын хувьд чухал зорилт болж байна.

Монгол Улс БНСУ-тай улс төр, эдийн засаг, нийгэм, соёл зэрэг бүхий л салбарт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлсээр ирсэн. Дэлхийд тэргүүлэх технологи үйлдвэрлэлтэй, дэлхийн худалдаа, эдийн засгийн томоохон тоглогчдын нэг, гадаадын хөрөнгө оруулалтын чухал эх үүсвэр болох БНСУ-тай худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх арга замын нэг нь хоёр улсын хооронд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” (цаашид ЭЗТХ) байгуулах явдал юм. Монгол Улсын хувьд БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулснаар уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай, түүхий эдийн үнийн савлагаанд өртөмтгий эмзэг эдийн засгийг төрөлжүүлэх, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, экспортын нэр төрлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Монгол - Солонгосын Хөдөө аж ахуйн яам хоорондын хамтарсан хорооны 7 дугаар хуралдааныг 2018 оны 01 дүгээр сарын 12-нд зохион байгуулав. Хуралдааны протоколд мал аж ахуй, газар тариалангийн салбарт хамтран ажиллах санал, хамтран хэрэгжүүлэх төсөл, “Халх Гол бүтээн байгуулалтын бүс нутаг”-г хамтран ажиллах мөн КОПИА байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт Солонгос улсад боловсон хүчнийг мэргэшүүлэх зэрэг нийт 9 санал тусгагдав. Сүүлийн жилүүдэд хүнс, хөдөө аж ахуйн салбар дахь яам хоорондын шууд хамтын ажиллагаа өргөжихийн зэрэгцээ

аймаг, мужийн хооронд харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжүүлэхэд тус яамнаас байнга дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

ХАА-н “Халх гол” Үндэсний бүтээн байгуулалтын хамтын ажиллагаа: Солонгосын хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хэрэгжүүлдэг КАРЕХ (Korean Agricultural Policy Experiences for Food Security) хөтөлбөрийн 2018 оны үйл ажиллагаанд хамрагдаж, “Монгол улсын зүүн бүсийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэмүү өртгийг дээшлүүлж, экспортын чадавхыг бэхжүүлэх” төслийн сэдвийн хүрээнд хоёр удаагийн уулзалт, хоёр удаагийн сургалт, Дорнод аймгийн мах, махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний талаар хамтарсан судалгааг амжилттай хэрэгжүүлсэн.

БНСУ-ын Засгийн газраас үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламж нь дэд бүтэц, цахим засаглал, цахилгаан холбоо гэх мэт мэдээлэл технологийн салбарт голчлон хэрэгжиж ирсэн нь улс орны эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж чадсан юм. Сүүлийн жилүүдэд хөнгөлөлттэй зээл, хөгжлийн албан ёсны тусламжаа “Шинэ умардын бодлого”-тойгоо уялдуулан Монгол Улсын авто зам, төмөр зам, агаарын зам, зам тээвэр, ложистикийн мастер төлөвлөгөө боловсруулах, нэгдсэн удирдлагын систем шинэчлэх, техник эдийн засгийн үзүүлэлт гаргах зэрэг дэд бүтэц, хот байгуулалтын салбар болон ус хангамж, усны эрүүл ахуй, газар тариалан, мал аж ахуйн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөхөн сэргээх, хүнсний аюулгүй байдлыг хангах гэх мэт хөдөө аж ахуйн салбаруудад хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь²⁷⁴ манай улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй зарим талаараа нийцэж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 2-р сард баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”,²⁷⁵ 2020 оны 5-р сард баталсан “Алсын хараа 2050”²⁷⁶ зэрэг бодлогын баримт бичгүүдийн үндсэн хэсэг болох эдийн засгийн хөгжлийн бодлогод хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, хариуцлагатай уур уурхайг хөгжүүлэх, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үндэсний болон орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх болон бүтээлч аж үйлдвэрлэл болон мэдээлэл технологийн салбарыг дэмжин хөгжүүлэх тухай голлон заасан байна.

Цаашид БНСУ-ын Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж болон хөрөнгө оруулалтыг Монгол Улсын хөгжлийн бодлоготой аль болох уялдаатай төлөвлөж, хөдөө аж ахуй, уул уурхай, зам тээвэр гэх мэт тодорхой салбарын техник технологи, дэд бүтцийг хангах төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд чиглүүлэх нь эргээд БНСУ-ын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчинг хангахад дэмжлэг болох юм. Өөрөөр хэлбэл, хөгжлийн тусламжийг хоёр талын хамтын ажиллагаанд зориулснаар үр өгөөжийг хоёр тал зэрэг хүртэнэ гэсэн үг. Нөгөө талаар, улс орны эдийн засгийн хөгжлөөс гадна хувь хүний хөгжлийн хүрээнд чанартай боловсрол, эрүүл мэнд, баталгаатай амьдрах орчинг хангах үүднээс Монголын тал БНСУ-аас үзүүлж буй албан ёсны тусламжийг эрүүл

²⁷⁴ КОЙКА-гийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө, 2019 он.

²⁷⁵ МУ-ын Засгийн Газрын “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”

²⁷⁶ 95 МУ-ын Засгийн Г: азрын “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2016 оны 2-р сарын 5-нд батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийг УИХ-ын 2020 оны 5 сарын 13-ны 52 тоот тогтоолоор хүчингүй болгож, шинээр баталсан уг бодлогын баримт бичгийн дагалдах хөтөлбөрүүд хараахан батлагдан гараагүй байна.

<https://www.legalinfo.mn/law/details/15406?lawid=15406>

<http://cabinet.gov.mn/userfiles/file/£0500d038c9227b38d180766d7dfb841.pdf>

мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин гэх мэт иргэд, хувь хүнд хүрсэн, үр өгөөжтэй, өргөн хүрээг хамрахуйц, бодит үр дүнтэй төслүүдэд олгуулах тал дээр ихээхэн бодолцож, төслийн саналуудыг оруулж хэрэгжүүлэх нь олон нийтийн дунд Солонгосын талаарх ойлголтыг эергээр төлөвшүүлэх, нэр хүндээ өсгөхөд эерэг нөлөө үзүүлэх болно.

Хэрэв дараагийн Засгийн газар “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын хэрэгжих хугацааг сунган үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бол, эсвэл “Алсын хараа 2050” бодлогын дагалдах хөтөлбөрүүдийг боловсруулахдаа БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн туршлага, тэргүүлэх технологи, бүтээлч үйлдвэрлэл буюу соёлын үйлдвэрлэлүүдийн амжилтыг тусгасан хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг нарийвчлан тусгах аваас цаашид хоёр улсын эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, ялангуяа хөрөнгө оруулалтыг татахад Монголын талаас барих бодлогын баримт бичиг болгон баримтлах боломжтой гэж үзэж байна.

Монгол дахь БНСУ-ын хөрөнгө оруулалтын хамгийн өндөр хувийг эзлэх уул уурхайн салбарт нийт 69 төсөл эхэлснээс 37 нь хаагдаж, анхаарал татахуйц амжилт олсон нь цөөн. Иймд уул уурхайгаас хэт хамаарал бүхий эдийн засгийн бүтэцтэй манай улсын хувьд тус улсын хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс уул уурхайн мега төслүүдэд БНСУ-ыг оролцох боломж олгоход бодлогоор анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн худалдааны харилцааг өргөжүүлэх, хууль эрхзүйн орчинг сайжруулахын тулд хоёр улсын хооронд ЧХХ-ийг байгуулах үйл явцыг түргэтгэх шаардлагатай байна.²⁷⁷ Энэхүү хэлэлцээр байгуулагдсанаар хоёр орны худалдаа 6.1 дахин өсөх боломжтой гэсэн судалгаа гарчээ. Сүүлийн жилүүдэд БНСУ-ын талаас уул уурхай, худалдаа, үйлчилгээний салбараас гадна барилга, эрүүл мэнд, эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, гоо сайхны бараа бүтээгдэхүүний зах зээлийг онцгойлон анхаарч байна.²⁷⁸ БНСУ-ын ГХХОК-ийн Монголын зах зээлд хийсэн судалгаагаар, далайд гарцгүйн дээр дэд бүтцийн хөгжил муутайн улмаас гадаад, дотоодын тээвэрлэлтийн зардал өндөр тусдаг сул талтай хэдий ч Монгол бол залуу улс, залуус голлосон үндсэн хэрэглэгчид нь Өмнөд Солонгосын талаар эерэг ойлголттой, солонгос бараа бүтээгдэхүүний талаар таатай сэтгэгдэлтэй байдаг зэрэг нь зах зээлийн давуу тал болно гэж дүгнээд Өмнөд Солонгосын нэртэй брэндүүдийг франчайз хэлбэрээр Монголын зах зээлд оруулах замаар эдийн засгийн харилцааг өргөжүүлэх боломжтой гэж үзсэн байна.²⁷⁹

2018 онд БНСУ-ын Засгийн газраас 500 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх төслийг санхүүжүүлэхэд олгохоороо байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд талууд “Солонго 1”, “Солонго 2”, “Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол” төслүүдийг хэрэгжүүлэхээр тохиролцож, техник эдийн засгийн үндэслэл судалгааг эхлүүлээд байна.²⁸⁰ Үүний зэрэгцээ 2010 оноос БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн

²⁷⁷ Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах саналыг 2011 онд Монголын талаас тавьж, 2016 онд Пак Гын Хэ ерөнхийлөгчийн Монголд хийсэн албан ёсны айлчлалын үеэр ЧХХ байгуулах хамтарсан судалгаа хийх тухай санамж бичигт гарын үсэг зурснаар судалгаа эхэлж, 2017 оны 9 сард дууссан.

²⁷⁸ 2018 оны байдлаар БНСУ-ын эм, эмнэлгийн бүтээгдэхүүний импорт 2017 онтой харьцуулахад 44,3%-р өсөж, нийт импортын 6,990-ийг эзэлж байна. Солонгосын гоо сайхны бүтээгдэхүүний импорт сүүлийн 5 жилд тогтмол өссөн байна.

²⁷⁹ 대한민국무역투자진흥공사<0714>2017 몽골 진출 보고서. p.29.

²⁸⁰ Санамж бичигт гарын үсэг зурлаа. МУ-ын Сангийн Яамны цахим хуудас. 2019 оны 4-р сарын 4 өдөр <https://mof.gov.mn/article/entry/sanamj-bichigt-gariin-useg-zurlaa>

туршлага хуваалцах хөтөлбөр (Knowledge Sharing Program)-ийн хүрээнд 3,15 тэрбум воны бодлогын зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.²⁸¹

3.3 дугаар хүснэгт

БНСУ-ын хөгжлийн албан ёсны тусламж үзүүлсэн байдал ²⁸²

		1987-2010	2011-2018
Хөгжлийн албан ёсны тусламжийн нийт хэмжээ (сая ам.доллар)		162.24	306.09
Үүнд	Буцалтгүй тусламж (сая ам.доллар)	96.98	222.48
	Зээл тусламж (сая ам.доллар)	65,26	83,61
Хөнгөлттэй зээл (сая ам.доллар)		60.0	107.7
2018-2019 онуудад батлагдсан хөнгөлөлттэй зээл			242.4

3.4 дүгээр хүснэгт

Худалдаа, хөрөнгө оруулалтын байдал ²⁸³

		1994-2010	2011-2018
Худалдааны нийт эргэлт (сая ам.доллар)		1724.52	2782.38
Үүнд	Импорт (сая ам.доллар)	1543.36	2519.99
	Экспорт (сая ам.доллар)	181.16	262.39
БНСУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ (сая ам.доллар)		205.71	255.86
Шинээр бүртгүүлсэн хөрөнгө оруулагч (аж ахуйн нэгжийн тоо)		333	283

Судалгаанаас харахад хоёр улсын хоорондох гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, ажиллах хүчний хамтын ажиллагаа, аялал жуулчлал зэрэг нь тасралтгүй өсч байгаа бөгөөд одоо тулгарч байгаа хамтын ажиллагаанд дурдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Уг асуудлуудад манай улсын эдийн засгийн хүчин чадал бага, экспортод гаргах барааны нэр төрөл, тоо хэмжээ бага байгаа, үйлдвэрлэл сайн хөгжөөгүй зэрэг нь нөлөөлж байна.

Солонгосын соёл Монголд ихээр тархсан явдал нь Солонгост ээлтэй зах зээлийг нээж өгсөн билээ. Солонгос бараа бүтээгдэхүүний борлуулалт өсөж, Солонгосын хөрөнгө оруулалттай хоол, үйлчилгээний газрууд нэмэгдэх болсон. 2004 онд “Тэ Жан Гым” олон ангит цуврал Монголын телевизээр цацагдсанаас хойш олноор нээгдсэн солонгос хоолны газрууд солонгос хоолны соёлыг таниулан сурталчлахаас гадна хоол үйлчилгээний салбарт хятад хоолны газрууд олноор орж ирэхээс хамгаалах, хоол үйлчилгээний зах

²⁸¹대한민국무역투자진흥공사 01 ~ 02020 몽골진출 보고서, p.60

²⁸² БНСУ-ын ГХХО дэмжих корпораци

²⁸³대한민국무역투자진흥공사(KOTRA)2020 몽골진출 보고서, p.26

зээлийг тэнцвэржүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг анхаарч, бодлогын хүрээнд дэмжих нь зүйтэй.

Хоёр улсын төрийн тэргүүн нар эдийн засгийн хамтын ажиллагааны талаар дараах асуудалд санал нэгдсэн нь цаашдын хамтын ажиллагааны чиглэл болж байна. Үүнд:

- БНСУ-ын тэргүүний технологи, Монголын байгалийн арвин нөөц зэрэг хоёр улсын давуу тал, хөгжлийн нөөц бололцоог ашиглан харилцан ашигтай, бие биеэ нөхсөн эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхээр тогтов. БНСУ нь “Шинэ Умардын бодлого”-ын чухал түнш улс болох Монгол Улстай олон төрлийн хамтын ажиллагааны төслийг үргэлжлүүлэн эрэлхийлж, Хөгжлийн албан ёсны тусламж үзүүлэх зэргээр цар тахлын дараах Монгол Улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхийн сацуу “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хамтран ажиллах;
- Хоёр улсын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны хуралдааныг үргэлжлүүлэн зохион байгуулж, хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагаа, иргэдийн солилцоо, бүс нутаг болон олон улсын хамтын ажиллагаа зэрэг өргөн цар хүрээтэй асуудлаарх яриа хэлэлцээг бэхжүүлж, шаардлагатай тохиолдолд тодорхой салбарын хоёр талын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах;
- Харилцан ашигтай, бие биеэ нөхсөн эдийн засгийн харилцааг улам өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд хамтын ажиллагааны эрх зүйн үндэс суурийг бэхжүүлэхээр ярилцав. Үүний тулд 2017 оны болон 2021 онд шинэчилсэн хамтарсан судалгааны үр дүнд суурилан “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА)”-ийн яриа хэлэлцээг ойрын хугацаанд эхлүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг үргэлжлүүлж, хоёр улсын хооронд хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхийн төлөө “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах явцыг эрчимжүүлэхээр болов. Түүнчлэн 2020 онд Монгол Улс “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АРТА)”-т нэгдэн орсон нь хоёр улс худалдаанд харилцан хөнгөлөлт үзүүлэх анхны хэлэлцээрийн хувьд хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал түлхэц үзүүлнэ гэдэгт хоёр тал санал нэгдэв.
- БНСУ-ын дэвшүүлсэн “Зүүн Азийн төмөр замын хамтын нийгэмлэг” санаачилга болон НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос хэрэгжүүлж буй “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний сүлжээ” санаачилгыг уялдуулан хөгжүүлж, “Шинэ Умардын бүс нутаг” дахь хэлхээ холбоог бэхжүүлэхэд чиглэсэн хоёр талын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Монголын тал БНСУ-ын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламж дэмжлэг тус улсын хөгжилд чухал хувь нэмэр оруулж ирснийг өндрөөр үнэлж, гүн талархал илэрхийлэв. Ялангуяа, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих”, “10 аймгийн төвийн дулааны станц барих” төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлд идэвхтэй хамтран ажиллаж байгааг сайшаав. Цаашид Монгол Улсын Хөгжлийн банк, БНСУ-ын ЭКСИМ банк хоорондын Эдийн засгийн хамтын ажиллагааны сан (EDCF)-гийн шугамаарх хамтын ажиллагааг мөн дэмжиж ажиллах;

- БНСУ-ын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй “Байгаль орчинд ээлтэй эрчим хүчний эко хотхон байгуулах” төслийг энэ онд багтаан дуусгавар болгож, хоёр улсын хооронд байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааны үлгэр жишээ төсөл болохуйц хамтын ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих;
- Ногоон эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, газрын тосны чанарыг сайжруулах, орон нутгийн дулааны хангамж, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэхэд тууштай хамтран ажиллах;
- “Улаанбаатар ба дагуул хот” бодлогын хүрээнд БНСУ-ын ухаалаг хот, Эдийн засгийн чөлөөт бүс байгуулсан туршлага зэргийг судалж, монголын тал ухаалаг хот байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлд БНСУ-тай хамтран ажиллахаар тогтов. Үүнтэй холбогдуулан монголын тал дэд бүтцийн салбарт БНСУ-ын Хөгжлийн албан ёсны тусламж, хөрөнгө оруулалтыг түлхүү татах чиглэлд хамтран ажиллах;
- Логистикийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, тус салбарын боловсон хүчинг бэлтгэх сургалт, тогтолцоог сайжруулах болон логистикийн шинэ технологи нутагшуулах зэрэг хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг эрэлхийлэх;
- Ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүний мэдээлэл солилцох, мэргэжилтэн бэлтгэх зэрэг хөдөө аж ахуйн шинэ технологийн салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Монголд үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг БНСУ-д экспортлох хорио цээрийн стандартыг тохирох чиглэлд хамтын ажиллагааны боломжийг эрэлхийлэн ажиллах;
- 2021 онд байгуулсан Монгол Улс, БНСУ-ын Жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг тууштай хэрэгжүүлж, экспортыг дэмжих, ЖДҮ болон гарааны бизнесийн чиглэлээр мэргэжилтэн солилцох, технологи нэвтрүүлэх зэрэг хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллахад гарын үсэг зурсан нь хоёр улсын харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаанд маш чухал түлхэц болно.

Соёл, боловсролын харилцаа

Аливаа хоёр улсын гүн бат найрамдлын харилцааны суурь нь соёл байдаг. Соёлын харилцаа нь ард түмэн хоорондын итгэлцэл дээр тогтдог тул аливаа улс төрийн маргаан, шашны мөргөлдөөн, цөмийн зэвсэг, худалдааны дайн зэргийг зөөллөж өгдөг төдийгүй салбарын харилцааг бодвол удаан үргэлжилдэг. Олон улсын харилцааны хамгийн үнэт зүйл нь итгэлцэл юм.²⁸⁴ Судлаач И.Энхболд, манай хоёр улсын харилцааг модтой зүйрлэвэл соёлын харилцаа нь модны үндэс юм гэж онцолсон байдаг.²⁸⁵ Солонгос үндэстний хувьд манай улстай найрсаг харилцаатай ард түмэн юм.

Улс хоорондын соёлын гадаад бодлого, соёлын харилцааны үүрэг роль бол өөрийн улсын талаарх эерэг дүр (имиж), ойлголт төрүүлж, нэр хүндээ өсгөх явдал юм. Өнөөдөр хоёр орны хооронд явагдаж буй харилцаанууд дотроос хамгийн идэвхтэй явагдаж байгаа,

²⁸⁴ И.Энхболд, “Зүүн хойд ази дахь Монгол Улс, БНСУ-ын харилцааны зураглал”, Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил. 2020 он 359 тал

²⁸⁵ И.Энхболд, “Зүүн Хойд Ази дахь Монгол улс, БНСУ-ын харилцааны зураглал”, Олон улсын харилцаа, дугаар 1/39, 2019 он, 38 тал.

жинхэнэ утгаараа хүндээ хүрсэн, бодитоор үүргээ гүйцэтгэсэн гэж хэлж болох харилцаа бол соёлын харилцаа юм. Аливаа улсын соёлд татагдан, түүнийг хүлээн авч, түгээн дэлгэрүүлнэ гэдэг хүний сэтгэл зүйтэй холбоотой гэдэг утгаараа соёлын харилцаа бол улс хоорондын харилцаан дотроос хамгийн чухал харилцаа. Гэвч яг үнэндээ цаг үеийн урсгалаараа явж ирсэн энэ харилцаа нэгдсэн бодлого байхгүйн улмаас хоёр талын харилцаа гэхээсээ илүү Солонгосын соёл Монголд давамгайлсан нэг чиглэлт харилцаа болж хувирсан. 1990 оны 3-р сарын 28-ны өдөр, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны дараа хоёр улсын Засгийн газар хооронд байгуулагдсан “Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр” нь хоёр орны соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын харилцаанд баримтлах үндсэн баримт бичиг болдог.

1991 онд элчин сайд Квон Ён Сүн Засгийн газартаа хүсэлт гаргаж, 660 компьютер, 125 хэвлэгч болон хувилагч машиныг буцалтгүй тусламжаар авч их дээд сургууль, засгийн газрын байгууллага, орон нутгийн 99 сургуульд тарааж байсан нь боловсрол шинжлэх ухааны салбар дахь харилцааны эхлэл болсон юм.²⁸⁶ Боловсрол, шинжлэх ухааны салбар дахь харилцаа энэ мэтчилэн эд материалын тусламж юм уу эсвэл боловсон хүчин бэлдэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, тэтгэлгийн хэлбэрээр голдуу БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA)-ийн шугамаар өнөөг хүртэл тасралтгүй үргэлжилж ирсэн. Эхний жилүүдэд Монгол дахь солонгос судлалыг дэмжих, солонгос хэлийг түгээн дэлгэрүүлэхэд голлон анхаарч, шинжлэх ухааны байгууллагууд болон их дээд сургуулиудын хамтын ажиллагааг дэмжихэд чиглэж байв.

БНСУ-ын Засгийн газрын тэтгэлэгт 2015 оныг хүртэл нийт 178 оюутан хамрагдаж, БНСУ-д доктор, магистр, бакалаврын зэргээр суралцаж төгссөн байна. БНСУ-нд суралцаж буй монгол оюутны тоо 2008 оноос эрс өсөж, 2017 оны байдлаар 7784-д хүрсэн байна. Манайх тус улсад суралцаж буй оюутныхаа тоогоор хоёроос гуравдугаар байранд бичигдэж ирсэн нь хүн амныхаа тоотой харьцуулахад асар өндөр үзүүлэлт юм.²⁸⁷ 2016 оны байдлаар солонгос хэл, солонгос судлалын тэнхимтэй улсын 7 их сургууль, хувийн 13 их сургуульд 2000 гаруй оюутан, 13 дунд сургуульд 2523 сурагч суралцаж байна.²⁸⁸ Шинжлэх ухааны салбарт 2006 оноос эхлэн БНСУ-ын Соёлын өвийн судалгааны төв, Зүүн Хойд Азийн түүхийн сан, Монгол талаас Шинжлэх Ухааны Академи, Үндэсний түүхийн музей хамтран түүх, археологийн чиглэлээр дунд, урт хугацааны судалгаа, хайгуул, малгалт, үзэсгэлэн, хурал симпозиум зэргээс багтсан цогц, цуврал хамтарсан төслүүдийг тууштай явуулж ирсэн. 2016 оны 7 сард Ерөнхийлөгч Пак Гын Хэ Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалынхаа үеэр Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Байгалийн түүхийн музей” барих төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон.

БНСУ-ын Засгийн газраас дипломат харилцаа тогтоосон улстайгаа хамтран дипломат харилцаа тогтоосны тэмдэглэлт ойн нэгдсэн цогц арга хэмжээг 10 жил тутамд зохион байгуулж ирсэн. 2010 онд хоёр орны дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойг

²⁸⁶ Ж.Ломбо, “Монгол улс, БНСУ-ын харилцаа: Өчигдөр, өнөөдөр, маргааш”, 2011, Сөүл хот, 92-94.

²⁸⁷ 대한민국 출입국 외국인 정책 본부, 출입국 외국인 정책 통계 연보, 2017. 2018 년 <http://www.immigration.go.kr/immigration/index.do>

²⁸⁸ 주몽골 대한민국 대사관, 2016 몽골개황 자료, p142-143. http://www.mofa.go.kr/_www/brd/m4099/view.do?seq=360992&srchFr=&srchTo=&srchWord=&srchTp=&multi_itm_seq=0&itm_seq_1=0&itm_seq_2=0&company*cd=&company_nm=&page=4

тохиолдуулан, 2010 оныг “Монгол дахь Солонгосын жил”, 2011 оныг “Солонгос дахь Монголын жил” болгохоор тогтож, бүтэн жилийн турш хоёр улсад төрөл бүрийн монгол, солонгос судлалын эрдэм шинжилгээний хурал, хамтарсан тоглолт, кино өдрүүд, үзэсгэлэн, спортын тэмцээн, хандивын үйл ажиллагаа зэргийг зохион байгуулсан юм. Монгол Улсад суугаа БНСУ-ын Элчин Сайдын Яамнаас 2012 оноос эхлэн Солонгосын соёлыг сурталчлах, иргэд хоорондын харилцааг хөгжүүлэх зорилгоор “Солонгосын 7 хоног” арга хэмжээг жил тутам явуулж эхэлсэн. Тус арга хэмжээний хүрээнд “Солонгосыг хэн сайн мэдэх вэ? (Quiz Korea)”, “Солонгос хоолны өдөрлөг (K- Food Word Festival)”, “K- поп дуу, бүжгийн тэмцээн (K-POP World Festival)”, Солонгос киноны наадам, Солонгос үндэсний болон орчин үеийн тоглолт, уран зургийн болон гэрэл зургийн үзэсгэлэн зэргийг тогтмол зохион байгуулж байна.

Харин Телевизийн салбарын алдаа завхрал, 20, 30 жилийн турш эрхзүйн орчин хангагдаагүй байсантай²⁸⁹ холбоотойгоор өөрийн үйлдвэрлэл явуулах чадваргүй студийн чанартай телевизүүд хэт олширч, гадаадын контентоос хамааралтай болсон тэдгээр телевизүүд оршин тогтнохын тулд зохиогчийн эрхийг үл ойшоон солонгосын олон ангит цувралыг хэт ихээр гаргах болж, нэг ёсондоо Монголын телевизүүдийг Солонгосын соёлыг таниулах олон нийтийн дипломат ажиллагааны үүргийг гүйцэтгэхэд хүргэсэн. Бодлого хяналтгүй явсан энэ харилцаа эргээд Солонгос орон, солонгос хүн, солонгосын соёлын талаарх сөрөг ойлголт, эсэргүүцэл, үзэн ядалт нийгэмд тарах, солонгосын соёлд хүүхэд залуучууд хэт автаж байгаа явдал нийгэмд зөрчил үүсгэх нуугдмал аюулыг агуулж байгааг социал орчин дахь Солонгосын соёлын талаарх зарим хандлагууд харуулж байгааг анхаарах шаардлагатай.

Иймд БНСУ-ын Элчин сайдын яам “Солонгосын өдрүүд” гэх мэт арга хэмжээгээр соёлын харилцааны үйл ажиллагааг хязгаарлахгүй, бодлогын түвшинд идэвхтэй ажиллах, контент нийлүүлэх хөтөлбөр зэргийг санаачлан тэмдэглэлт ойн хүрээнд зохиогчийн эрх бүхий шилдэг кино, олон ангит цуврал, баримтат кино нийлүүлэх, зохиогчийн эрхийн зөрчлийн талаар дуу хоолойгоо хүргэх зэргээр Монголын талтай хамтран ажиллах хэрэгтэй байна.

2011, 2015 онуудад МУИС-ийн Социологийн тэнхимээс явуулсан “Солонгосын талаарх монголчуудын ойлголт” цуврал судалгаагаар Солонгосын талаарх монголчуудын ойлголт солонгос соёлын контент, бараа бүтээгдэхүүний хэрэглээ, Солонгост айлчилсан, ажилласан, суралцсан зэрэг бодит туршлага дээр үндэслэн төлөвшсөн бөгөөд ихэнхдээ эерэг хандлагатай болохыг нотолжээ.²⁹⁰ Нөгөө талаар, 2008, 2009 оноос эхлэн цахим орчинд Солонгосыг үзэн ядах хандлага ажиглагдах болж, 2013 онд Солонгосын олон ангит цувралыг телевизээр гаргахыг эсэргүүцсэн цахим жагсаал социал ертөнцөд өрнөж, нэртэй залуу зохиолч, найруулагчид хүүхэд залуусыг Солонгосын соёлд хэт автаж байна хэмээн буруушаан шүүмжлэх болсон билээ.²⁹¹

²⁸⁹ Телевизийн салбарын үйл ажиллагааг зохицуулах “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль” 2019 оны 12 сард батлагдсан.

²⁹⁰ О.Мөнхбат, Д.Сайнбилэгт, “БНСУ болон солонгосчуудын талаарх монголчуудын санал бодол”, МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн, Солонгос судлалын тэнхим, Социологийн тэнхим хамтран гүйцэтгэсэн судалгааны тайлан. 2011 он, MAGIKO Олон улсын эрдэм шинжилгээний II хурлын эмхэтгэл, хуудас 11-44, “БНСУ болон солонгосчуудын талаарх монголчуудын санал бодол” судалгааны тайлан, МУИС-ийн Социологийн тэнхим, 2015 он.

²⁹¹ П.Батхуяг, Сайтар угагдсан тархинууд буюу савангийн дууриудын гавьяа, 20141215,

Хамгийн ихээр тулгамдаж буй асуудал бол БНСУ-д хууль бусаар ажиллаж, амьдарч буй иргэдийн эрх бүхий л талаар зөрчигдөж байгаатай холбоотой хууль бус иргэдийг хууль ёсны болгох тухай асуудал юм. БНСУ 2003 онд “Гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль” баталж, 2003 оны 3-р сарын 31-ний байдлаар тус улсад 4 жилээс доош хугацаагаар хууль бусаар оршин суугаа гадаадын иргэдийг хууль ёсны болгох тусгай арга хэмжээ авч, гадаадын 184199 иргэнд 2 жилийн хугацаатайгаар хөдөлмөр эрхлэх эрх олгосноор тухайн үед хууль бусаар оршин сууж байсан 13220 монгол иргэний 5687 нь хууль ёсны бүртгэлтэй болсон.²⁹² Түүний дараа 2006 онд хүүхэд нь бага сургуульд хууль бус оршин суугч эцэг эхчүүдэд тодорхой хугацаанд албан ёсоор хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход манай иргэд хамрагдсан байдаг. Түүнээс хойш зөвхөн солонгос гаралтай гадаадын хууль бус иргэдийг хууль ёсны болгох эсвэл хууль бус гадаад иргэдийг торгуульгүй гаргах, хүчээр гаргах арга хэмжээг удаа дараа авч явуулсан байна.²⁹³ БНСУ-ын “Гадаадын иргэний харьяатын тухай хууль”, “Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль”- д гадаадын иргэн хууль бусаар оршин суух, зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлэх, эрхлүүлэхийг хатуу хориглосон байдаг бөгөөд хууль бус иргэнийг хууль ёсны болгох тухай тусгайлан заасан зүйл, заалтууд байхгүй. Хөдөлмөрийн яам хооронд байгуулсан “БНСУ-д гэрээт ажилчин ажиллуулах тухай” санамж бичиг болон холбогдох хэлэлцээрүүдэд хууль бус иргэдийг хууль ёсны болгох тухай заалтууд огт тусгагдаагүй болно.²⁹⁴

Иймд тус улсын Засгийн газраас хэрэгжүүлэх тусгай арга хэмжээ зарлахаас нааш эсвэл хоёр тал харилцан тохиролцож, тодорхой гэрээ хэлэлцээрээр зохицуулахаас өөрөөр хууль бусаар оршин сууж буй иргэдийг хууль ёсны болгох боломжгүй юм. Хууль бусаар оршин сууж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, БНСУ-д хууль бусаар оршин сууж, хөдөлмөр эрхэлж буй Монгол иргэдийн визний асуудлыг дипломат аргаар шийдвэрлэх боломжийг судлах, тодорхой арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар, Гадаад Хэргийн яаманд санал болгож байна.

3.4.2 Харилцааны хэтийн төлөв

Монгол улс, БНСУ хоёр улсын харилцааны хэтийн төлөв 3.3.2 зүйлд авч үзсэн Монгол, Япон улсын харилцааны хэтийн төлөвийн адил дэлхийн дэг журам болон их гүрнүүдийн хоорондын харилцааны өөрчлөлтөөс ихээхэн хамаарах болно.

Тиймээс харилцааны хэтийн төлөвийг Монгол, БНСУ-ын өнөөгийн хоорондын харилцааны болон их гүрнүүдтэй харилцаж буй онцлогийг тооцон, аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйд тулгуурлан 3.1 болон 3.2 дугаар зүйлүүдэд үүсгэсэн их

<http://bathuyag.essay.time.mn/content/485|.shtml#sthash.yOKU8dAD.dpuf>; Н.Наранбаатар, Солонгос кино харилцааны эвдрэлийг харуулдаг, 20140205, http://www.mglradio.com/main/index.php?document_srl=881713; Р.Эмүжин, Монголчуудын солонгос солилго, 20091201, <http://ordinary.blog.gogo.mn/read/entry59064>; Солонгос сериалуудын эсрэг суулт хийнэ, 20181016, <https://news.mn/r/645944/>; Солонгос киноны дам хордолт илэрчээ, 20170324, <http://ikon.mn/n/yw0>;

²⁹²대한민국 출입국 외국인 정책 본부, 출입국 외국인 정책통계연보, 1990년-2017년.

²⁹³대한민국 이민정책연구원, · 국제비교를 통한 국내 외국인 불법체류 관리정책 개선방안 연구'. 2014년. p.84-87. 대한민국고용노동부. 고용허가제정보. <https://www.eps.go.kr/eo/EmployPerSystem.eco2natNm=kr&tabGb=01>

²⁹⁴ БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт судалгааны тайлан”, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2007 он. http://www.nhrem.gov.mn/media/documents/1431398063_2007-bnsu-dah-mongol-azhilchdyn-erhiyn-.pdf

гүрнүүдийн хоорондын харилцааны сценарууд, тэдгээрийн үүсэж болох хувилбарууд, тэдгээрт Монгол Улсын болон “гуравдагч хөрш” БНСУ-ын баримталж болох магадлалт байр сууриар тодорхойллоо.

Нэг. АНУ, ОХУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол ба БНСУ-ын харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ, ОХУ-ын харилцааны эерэг сценар:

- 1. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, улсуудын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, олон улсын байгууллагуудын үүрэг ба бусад улс, үндэстнүүдийн эрх ашгийн үндсэн дээр “Дэлхийн олон туйлт дэг журмыг бататгах”.**

Ийм сценарын үед ОХУ болон Хятадын байр суурь нэгдмэл байх магадлалтай. Монгол Улс Орос–Монгол–Хятад гэсэн эдийн засгийн коридороо хөгжүүлэх талаар хоёр хөрштэйгөө хамтран ажиллахаас гадна “гуравдагч хөрш”-ийн стратегийн түншлэлийн бодлогоо АНУ болон БНСУ-тай хэвийн үргэлжлүүлэх боломжтой байна. Тиймээс 3.4.1-д онцлон тэмдэглэсэн хоёр орны төрийн тэргүүн нарын хамтын ажиллагааг өргөжүүлэх олон талт асуудлыг ажил хэрэг болгох нь Монгол Улсын хөгжилд чухал ач холбогдолтой байх болно. Ялангуяа БНСУ-ын дэвшүүлсэн “Зүүн Азийн төмөр замын хамтын нийгэмлэг” санаачилга болон НҮБ-ын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос хэрэгжүүлж буй “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний сүлжээ” санаачилгыг уялдуулан хөгжүүлж, “Шинэ Умардын бүс нутаг” дахь хэлхээ холбоог бэхжүүлэхэд чиглэсэн хоёр талын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах боломж байгаа нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.8-д заасан “Ази, Номхон далайн бүс нутаг, Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжин оролцох” зорилтоо “гуравдагч хөрш” БНСУ-ын санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх чухал алхам юм. Ийм боломж хоёр хөршийн зүгээс ч дэмжлэг авах магадлал өндөр байх болно.

Түүнчлэн 2021 онд байгуулсан Монгол Улс, БНСУ-ын Жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг тууштай хэрэгжүүлж, экспортыг дэмжих, ЖДҮ болон гарааны бизнесийн чиглэлээр мэргэжилтэн солилцох, технологи нэвтрүүлэх зэрэг хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллахад гарын үсэг зурсан нь хоёр улсын харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаанд маш чухал ач холбогдолтой байх болно. Судлаачид “Монголчууд "хүслээ дарж" бодит байдалд нийцүүлэх, мөн "гуравдагч хөршүүдийнхээ хүсэл, боломж, анхаарлыг нэмэгдүүлэх оролдлого чармайлтыг манай талаас идэвхтэй хийж байх хэрэгтэй болж байна. Манайхны зарим хүмүүсийн хүслээр монголчууд анхдагч хөршүүдээсээ хөндийрч, зарим талаар үзэн ядаж, дайсагнаж, харилцаагаа муутгаж байдаг, харин "гуравдагч хөрш"-үүд монголчуудыг өмөөрч манай анхдагч хөршүүдийг "цээрлүүлээд" биднийг ивээлдээ аваад, улс орныг нь хөгжүүлээд," явах ёстой мэтээр төсөөлөх туйлшрал бас бий. Гэтэл "гуравдагч хөрш"-үүд бидний ажлыг хийж өгөх бодлого явуулаагүй, тийм

амлалт аваагүй нь ойлгомжтой.” гэж онцлон тэмдэглэснийг энд сануулахад илүүдэхгүй юм.

2. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Хятадын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Ийм хувилбар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд ихээхэн зөрчилтэй нөхцөл байдал үүснэ. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт *нэгд*, АНУ ба Оросын харилцаанаас хамаарахгүйгээр соёл иргэншлийн хувьд Хятадад уусаж устах аюул заналын эрсдэл, *хоёрт*, хоёр хөршийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй дарамт, шахалтууд илрэх болно. Үүний зэрэгцээ “гуравдагч хөрш” БНСУ-ын хувьд бодлого хяналтгүй явсан соёлын харилцаа эргээд Солонгос орон, солонгос хүн, солонгосын соёлын талаарх сөрөг ойлголт, эсэргүүцэл, үзэн ядалт нийгэмд тарах, солонгосын соёлд хүүхэд залуучууд хэт автаж байгаа явдал нийгэмд зөрчил үүсгэх нуугдмал аюулыг агуулж байгааг социал орчин дахь Солонгосын соёлын талаарх зарим хандлагууд харуулж байгааг 3.4.1 зүйлд тэмдэглэснийг анхаарч хамтын ажиллагааныхаа бодлогод тусгайлан авч үзэх шаардлагатай юм.

Зөөлөн хүчгүйгээр улсын нийт хүч буюу бусдыг дагуулах, өөртөө итгүүлэн үнэмшүүлэх хүч дутах тухай ойлголтыг хятадын нэрт сэтгэгчийн болоод одоог хүртэл олон мянган жил дагаж мөрдөж төрийн бодлогын суурь болгож байгаа уламжлалт арга барил нь аливаа зүйлийг хүчээр бус аль болох аядуу бусдыг дагуулах, түүнийг тухайн зүйлд итгүүлэн дагуулах нь хамгийн зөв зүйтэй гэж үздэг байна. Эртний хятадын ойлголтоор “хүмүүний ямар угсаатай, эсвэл хаана төрсөн зэрэг нь гол бус, харин уул хүмүүн хятад соёлыг хэр зэрэг өөртөө шингээж авсан гэдэг нь шийдвэрлэх зүйл юм. Хэн нэг харь хүмүүн хятадын соёл иргэншлийг хүлээн авч, өөрийн болгож, түүний дагуу амьдарч буй бол тэр хүмүүн хятад хүн болно.” хэмээсэн байдаг. Тиймээс ч Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн” болохыг заасан байна

Эндээс манай улсын соёл иргэншлийн, улмаар оршин тогтнохуй аюулгүй байдлын хэтийн төлөвийн дархлаа цаашид гадны хэл соёл (ялангуяа хятад)-ын түрэлтийн талаар цогц бодлого авч хэрэгжүүлэхгүй бол улам доройтох дүр зураг харагдаж байна. Ийм нөхцөл байдал зөвхөн энэ сценарт хамаарах бус бүхий л сценарын үед ажиглагдах магадлал өндөр байна. Харин энэ сценарын үед манай улс “гуравдагч хөрш” болон НҮБ-ын дэмжлэгтэйгээр төвч байр суурь баримталж болох таамаглал байна.

3. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Энэ хувилбарын үед манай хоёр том хөршийн хооронд хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх магадлал өндөр байна. Монгол Улсын аюулгүй байдлын хувьд өөрийн үндэстний цөөнхийн талаар оновчтой бодлого явуулах, гаднаас дүрвэгсэд орж ирж болзошгүй нөхцөлд бэлэн байх, терроризмын аюул заналаас сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлага гарна. Хоёр хөрш гүрэн болон “гуравдагч хөрш” БНСУ-тай харилцах бодлого хэвийн үргэлжлэх болно. НҮБ-ын байр суурийг дэмжинэ.

4. Оросын засагт оросын үндэсний эрх ашиг сонирхол ба орос соёл иргэншлийн үнэт зүйлсийн системтэй зөрчилдсөн (XX зууны 90-ээд оны эхний хагаст ийм явдал Орост үндсэндээ тохиолдсон) АНУ-ын аливаа нөхцөлүүдийн хараат хамтын ажиллагаанд бэлнээр нээлттэй хандсан эрх барих бүлгүүд гарах.

Ийм сценар үүсвэл *Орос, АНУ хоёр Хятадад хамтарч дарамт, шахалт үзүүлэх ба Орос, Хятадын хоорондын харилцаа эрс хүйтэрнэ. Стратегийн чухал байришилтай манай улсад аль аль талаас нь дарамт, шахалт ирнэ.* Орос улсад Америкийн талыг баримтлагчдыг эсэргүүцсэн хүмүүс болон эрх баригч талын хоорондох дотоодын зөрчил хурцдаж болно. Мэдээжээр Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорын асуудал зогсонги байдалд орно. Ийм тохиолдолд “гуравдагч хөрш” БНСУ-ын дэмжлэг чухал ач холбогдолтой болох бөгөөд хамтын ажиллагаа хэвийн хөгжүүлэхэд Хятадын зүгээс ямар нэгэн хэмжээгээр саад учруулна. Ялангуяа ТНААД байршуулахтай холбоотой асуудал засгийн газар төдийгүй иргэд хоорондын харилцаанд ан цав үүсгэсэн бөгөөд АНУ-ын Өмнөд Хятадын тэнгист хийх цэргийн сургуулилтад оролцох асуудал, Хонконг, Шинжаан, Уйгар болон Түвэдийн хүний эрх, ардчилал, эрх чөлөөний асуудлаарх байр сууриа илэрхийлэх явдал зэрэг БНСУ-ын сонголтоос шалтгаалан БНХАУ-ын зүгээс ирэх шахалт хамаарна.

БНСУ, ОХУ хоёр улс “Шинэ Умардын бодлого” болон Алс дорнодыг хөгжүүлэх “Шинэ дорнын бодлого”-ын хүрээнд хамтын ажиллагаагаа улам бүр хөгжүүлж, стратегийн хамтын ажиллагааны түншлэлийн харилцаагаа бодитоор өргөжүүлж байгаад тодорхой саад гарах магадлалтай ба энэ нь манай улсын оролцоонд сөрөг нөлөөлнө.

5. Дэлхийн хүчний харилцаа бусад улс орнуудтай реалист, шударга харилцаа руу болон өөр (тэгш г.м) зарчмуудын үндсэн дээр олон улсын харилцааг бодитоор босгох бэлэн байдал руу өөрчлөгдөх нөлөөлөл дор АНУ-ын засгийн эрх баригчид аажим хувьсах.

Ийм сценарын үед хоёр хөршийн харилцаа стратегийн иж бүрэн түншлэлийн хүрээнд өрнөж, Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт ихээхэн таатай нөхцөл байх болно. Улс орнуудтай тухайлбал, “гуравдагч хөрш” БНСУ-тай өргөн хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэх, тогтвортой хөгжих хэтийн таатай нөхцөл бүрдэнэ. Гагцхүү манай улс “"Гуравдагч хөрш"-үүдээс гуйлга гуйх сэтгэлгээ Монгол талаас давамгайлж, харин ардчилсан, өндөр хөгжилтэй орнуудад энэ нь таалагддаггүй, тэд харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхолтой байдаг. Энэ нь "гуравдагч хөрш"-ийн бодлогод учирч байгаа гол зөрчлийн нэг юм. Гуйлгачин сэтгэлгээнээсээ татгалзаж, харилцан ашигтай хамтын ажиллагаанд бүрэн шилжиж байж "гуравдагч хөрш"-ийн бодлого тодорхой үр дүн өгөх болно.” гэсэн судлаачдын зөвлөмжийг анхаарах хэрэгтэй юм.

Хоёрт. АНУ, ОХУ-ын харилцааны сөрөг сценар:

1. Дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл эрчимжих.

- Оросын зүгээс Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөтгөх магадлалтай. Ийм хувилбар ОХУ ба АНУ-ын хоорондын зэвсэгт мөргөлдөөн үүсэх тулгаралт бага магадлалтай ч өнөөгийн Украйны эсрэг Оросын цэргийн тусгай ажиллагаа, Барууныхны Украйнд үзүүлж буй дайныг өдөөсөн зэвсгийн тусламж байдлыг бүр хурцатгаж, АНУ болон Хятадын хооронд Өмнөд Хятадын тэнгист зэвсэгт мөргөлдөөн гарна гэсэн зарим судлаачдын таамаглал байгаа бөгөөд АНУ-ын Тайваньд явуулж буй бодлого, Хятадын Тайваны эсрэг шаардлагатай бол зэвсэгт хүчнээ хэрэглэхээ илэрхийлсэн байдал зэрэг нь Орос, Хятад хоёрыг улам нэгдэн нягтрахад хүргэж байна. Ийм тохиолдолд Монгол Улсад АНУ-ын зүгээс Оросын эсрэг хориг, хязгаарлалтын ажиллагаанд нэгдэх талаар шахалт

үзүүлэх, манайд үзүүлж буй дэмжлэгээ зогсоох дарамт ирэх магадлал өндөр байх ба БНСУ АНУ-ын холбоотны хувьд энэ ажиллагаанд нэгдэх магадлалтай.

Хоёр. АНУ, БНХАУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол болон БНСУ-ын харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв:

Нэгд. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн Шинэтгэл-зарим талаар хоршсон, зарим талаар өрсөлдсөн-санал нийлэлтийн сценар 1 болон Хөдөлгөөнгүй, зогсонги байдлын сценар 2:

Эдгээр сценарын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт: нэгд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулж, хоёр хөршийг төдийгүй Ази, Европыг холбох гүүр болох боломжтой байх. нөхцөлүүд бий болох боломж, хоёрт, Хятад улсын зүгээс өр зээлийн дарамтад орж болзошгүй байх эрсдэл гэсэн хоёр зам хүлээж байна.

Монгол Улсын боломжийн хувьд БНХАУ-ын Тяньжинь, ОХУ-ын Владивостокийн боомтоор дамжин далайд гарцтай болох буюу түүхий эдийг гуравдагч зах зээлд гаргах нөхцөл бүрдэх бөгөөд “гуравдагч хөрш” БНСУ-тай хамтран ажиллах боломж нэмэгдэнэ. Болзошгүй эрсдэлээс зайлсхийхэд БНСУ-ын тэргүүний технологи, Монголын байгалийн арвин нөөц зэрэг хоёр улсын давуу тал, хөгжлийн нөөц бололцоог ашиглан харилцан ашигтай, бие биеэ нөхсөн эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхээр тогтсоны дагуу Монгол Улс БНСУ-ын “Шинэ Умардын бодлого”-ын чухал түнш улс болох, олон төрлийн хамтын ажиллагааны төслийг үргэлжлүүлэн эрэлхийлэх, Хөгжлийн албан ёсны тусламж авах зэргээр цар тахлын дараах эдийн засгаа сэргээх, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцдаа хамтран ажиллах зэрэг нь чухал ач холбогдолтой байх болно.

Хоёрт. АНУ ба БНХАУ-ын хоорондын харилцааны хурцадмал байдал ба сөргөлдөөн хүчтэй болох сценар:

1. 3.2 дугаар зүйлд авч үзсэн АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын хамгийн муу хувилбар Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх асуудлаас болж АНУ ба Хятадын хооронд хурцадмал байдал эрс нэмэгдэж, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн тохиолдолд:

- Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа үргэлжилж, НҮБ зэвсэгт мөргөлдөөнд Хятадыг буруутгасан байр суурь илэрхийлж, асуудлыг Хятадын талаас буулт хийж яриа хэлэлцээрээр шийдвэрлэхийг уриалж, Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжвэл өмнөд хөршийнхөө зүгээс ноцтой дарамт шахалтад өртөх ба эс дэмжвэл БНСУ-ын улсын зүгээс стратегийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, дэмжлэг зогсонги байдалд орох магадлал өндөр байх болно. Харин НҮБ хоёр талыг хурцадмал байдал, зэвсэгт мөргөлдөөнөө яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг чиглэл болгосон тохиолдолд Монгол Улс НҮБ-ын шийдвэрийг дэмжинэ. Энэ тохиолдолд БНСУ-тай тогтоосон стратегийн түншлэл, түүний хүрээнд төлөвлөсөн төсөл, хөтөлбөр хэвийн хэрэгжих боломж бий болно.

- Орос АНУ-тай түр холбоотны харилцаа тогтоох тохиолдолд Орос, Хятадын хоорондын харилцаа хурцдах ба Монгол Улс НҮБ-ын байр суурь ямар байхаас хамаарахгүйгээр зэвсэгт мөргөлдөөнийг зөвтгөхгүй, аль нэгийг нь дэмжихгүй төвийг

сахисан байр суурь илэрхийлбэл БНСУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүд хэвийн үргэлжлэх магадлалтай байх болно.

2. АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын АНУ, Хятад хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэхгүйгээр худалдааны дайн улам гүнзгийрч, удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Монгол Улс аюулгүй байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, бүрэн эрхт байдлын хувьд том сорилттой нүүр тулгарна.

• Худалдааны дайн дэлхийн эдийн засгийг ч бүхэлд нь туйлдуулж, гуравдагч орнууд ч хохирох учир манай улс болон БНСУ-ын эдийн засгийн хөгжилд эрсдэл бий болно. Ийм нөхцөл үүсэхэд стратегийн түншлэлийн гэрээний дагуу БНСУ-тай тогтоосон нягт хамтын ажиллагаа худалдааны дайнаас ирэх геополитикийн дарамт, шахалтыг даван туулах гол стратеги байж болох талтай. БНСУ-ын зүгээс зарим дэмжлэг, тусламж багасах магадлалтай.

Гурав. ОХУ ба БНХАУ-ын харилцааны хэтийн төлөв

Нэгд. ОХУ ба Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны сценар.

1. Монгол Улсад Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хоёр хөршийн болон “гуравдагч хөрш”-ийн, ялангуяа БНСУ-ын талаар ухаалаг бодлого баримталбал аюулгүй байдлын хэтийн төлөв ихээхэн эерэг төсөөлөлтэй байна.

• БНСУ ч манай улстай өнөөгийн харилцаагаа улам бэхжүүлэхэд чиглэсэн бодлого явуулах магадлалтай. Хятадын “Нэг бүс ба нэг зам” стратегийн хүрээнд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорыг төлөвлөлтийн дагуу хөгжүүлэх боломж байна. Чингэхдээ үндэсний аюулгүй байдлаа хангаж тогтвортой хөгжих үүднээс гадны судлаач “Монголчууд бараг бүх түүхий эд материал нь Хятад руу явдгийг, улс төр эдийн засагт нь Хятадын нөлөө улам ихсэж байгааг мэддэг хэдий ч энэ талаар ямар дорвитой арга хэмжээ аваагүй ажээ. Хятадын компаниуд Монголын нөлөө бүхий албан тушаалтнуудыг авлигадаж, хайгуулын лицензээ нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн жижиг компаниудыг өч төчнөөнөөр нь худалдан авчээ...” гэж анхааруулсныг санах хэрэгтэй.

• Хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх боломж байна. Энэ хүрээнд БНСУ-ын талаас Монголын байгалийн баялаг, хямд ажиллах хүчийг давуу тал хэмээн харж, Өмнөд Солонгосын технологийн хөгжлийг хослуулсан үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх боломжтой гэсэн зөвлөмж гаргасан.²⁹⁵ Манай зүгээс “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд боловсруулах эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүддээ Монголын байгалийн баялаг, хямд ажиллах хүчийг өмнөд Солонгосын технологийн хөгжилтэй хослуулсан хөдөө аж ахуй, уул уурхай, аж үйлдвэрлэлийн төслүүдийг хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжих, хэрэгжүүлэх, цаашлаад Монголыг шинэ технологи бүхий аж үйлдвэрлэлийн бүс, Зүүн Өмнөд Азийн орнуудын Евроази руу гарах эдийн засгийн түшиц цэг болгон хөгжүүлэх зэргийг тусгах нь зүйтэй. Энэхүү боломж бололцоог бодит болгохын төлөөх эрхзүйн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн хамтарсан судалгаа хийхээс хамтын ажиллагаа эхлэх боломжтой.

²⁹⁵대한민국무역투자진흥공사<0714>2017 몽골진출 보고서. p.29.

Хоёрт. ОХУ ба БНХАУ хоорондын зөрчилдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болзошгүй сценар:

1. Хоёр хөршийн аль аль талаас нь өөрийн талд орохыг шаардсан хүнд дарамт, шахалт ирэх.

Монгол Улс сөргөлдөгч хоёр талын аль нэгнийх нь талд татагдан орох аюул занал тулгарна. Ийм сценарын үед хоёр зам байна. *Нэгд*, төвийг сахих. Гэхдээ ийм оролдлого хийх нь хөрш хоёр гүрний зүгээс дэмжлэг авахгүй байх болно. *Хоёрт*, хоёр хөршийн хэн нэгний нь холбоотон болох. Энэ тохиолдолд Дорнынхон ОХУ-ыг аюул заналхийлэл гэж нэг их үздэггүй логикоос харвал Монгол нь ОХУ-тай цэргийн холбоотны харилцааг сэргээх магадлал байж болох талтай. Доктор Р.Болд ийм төлөв байж болох талаар тэмдэглэсэн байна. Мөн “гуравдагч хөрш”-үүдээс, түүнчлэн БНСУ-аас болон НҮБ-аас улс төрийн дэмжлэг хүсэх болно.

НОМ ЗҮЙ

1. Г.Мөнхсайхан. Зүүн хойд Азийн эрин үе ба Монголын эдийн засаг. 2010 он.Шим И. Соб.
2. Монгол-Солонгосын харилцаа. 2015 он.
3. Б.Лхагва. Зүүн хойд Азийн эрин үе ба Монголын эдийн засаг. ЗХА-ийн интеграци: Монгол, БНСУ-ын харилцаа.
4. 대한민국 외무부. 국가정보
http://www.mofa.go.kr/www/nation/m_3458/view.do?seq=5
5. Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого: Гурвалсан хамтын ажиллагааг хөгжүүлжүүлэх бодлого” судалгааны тайлан. 2017 он.
6. 연합뉴스, 문정부 국가안보전략 지침서 나왔다. . “평화 만들기 주도적 역할”, 2018년 12월 20일,
7. <https://www.yna.co.kr/view/AKR20181220114100001> -대한민국 통일부, -국가안보 최성위 지침서,
8. 문재인 정부의 국가안보전략' 발간, 2018년 12월 21일.
9. https://www.unikorea.go.kr/unikorea/policy/koreapolicy/berlin/?boardId=bbs_0000000000000063&mode=view&cntId=54379&category=&pageIdx=
10. 대한민국 국가안보실, “문재인 정부의 국가안보전략" 지침서, 2018년. 7.93-94
11. 대한민국 외교부, “2019 외교백서“, 2019년.
12. Нэгдсэн Солонгос улс айсуй. Б.Лхагва. 2015он.
13. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин нар 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр дээд түвшний цахим уулзалт
14. КОЙКА-гийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө, 2019 он.
15. МУ-ын Засгийн Газрын “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”
16. “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. 2020 он.
17. Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах саналыг 2011 онд Монголын талаас тавьж, 2016 онд

18. 대한민국무역투자진흥공사<0714>2017 몽골진출 보고서. p.29.
19. Санамж бичигт гарын үсэг зурлаа. МУ-ын Сангийн Яамны цахим хуудас. 2019 оны 4-р сарын 4 өдөр
<https://mof.gov.mn/article/entry/sanamj-bichigt-gariin-useg-zurlaa>
20. 대한민국무역투자진흥공사 01 ~ 02020 몽골진출 보고서.
21. 대한민국무역투자진흥공사(KOTRA)2020 몽골진출 보고서.
22. И.Энхболд, “Зүүн хойд ази дахь Монгол Улс, БНСУ-ын харилцааны зураглал”, Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 30 жил. 2020 он
23. Ж.Ломбо, “Монгол улс, БНСУ-ын харилцаа: Өчигдөр, өнөөдөр, маргааш”, 2011, Сөүл хот.
24. 대한민국 출입국 외국인 정책 본부, 출입국 외국인 정책 통계 연보, 2017. 2018 년
<http://www.immigration.go.kr/immigration/index.do>
25. 주몽골 대한민국 대사관, 2016 몽골개황 자료, p142-143. http://www.mofa.go.kr/_www/brd/m4099/view.do?seq=360992&srchFr=&srchTo=&srchWord=&srchTp=&multi_itm_seq=0&itm_seq1=0&itm_seq_2=0&company*cd=&company_nm=&page=4
26. О.Мөнхбат, Д.Сайнбилэгт, “БНСУ болон солонгосчуудын талаарх монголчуудын санал бодол”, МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн, Солонгос судлалын тэнхим, Социологийн тэнхим хамтран гүйцэтгэсэн судалгааны тайлан. 2011 он, MAGIKO Олон улсын эрдэм шинжилгээний II хурлын эмхэтгэл, хуудас 11-44, “БНСУ болон солонгосчуудын талаарх монголчуудын санал бодол” судалгааны тайлан, МУИС-ийн Социологийн тэнхим, 2015 он.
27. П.Батхуяг, Сайтар угаагдсан тархинууд буюу савангийн дууриудын гавьяа, 20141215,
28. 대한민국 출입국 외국인 정책 본부, 출입국 외국인 정책통계연보, 1990 년-2017 년.
29. 대한민국 이민정책연구원, ‘국제비교를 통한 국내 외국인 불법체류 관리정책 개선방안 연구’. 2014 년. p.84-87. 대한민국고용노동부. 고용허가제정보.
<https://www.eps.go.kr/eo/EmployPerSystem.eco2natNm=kr&tabGb=01>
30. БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт судалгааны тайлан”, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2007 он.
31. http://www.nhrem.gov.mn/media/documents/143_1_398063_2007-bnsu-dah-mongol-azhilchdyn-erhiyn-.pdf
32. ¹대한민국무역투자진흥공사<0714>2017 몽골진출 보고서.

3.5. Монгол, Энэтхэг улсын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв

3.5.1 Харилцааны түүхэн болон өнөөгийн байдал

Түүхэн талаас, Монгол Улс Энэтхэг улсын харилцааны талаарх түүхэн эх сурвалжуудын эхнийх нь Хүн гүрний үе буюу МЭӨ 209 оны үед хамаарна. Хожим буддын шашны нөлөөгөөр хоёр ард түмэнд нийтлэг соёлууд бий болсон юм. Харин орчин үеийн харилцааг 1955 онд дипломат харилцаа тогтоосноос хойш тооцдог. Социалист бус улс орнуудаас хамгийн анх Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн улс нь Энэтхэг. Түүнээс хойш хоёр улс олон улсын тавцанд нэг бус удаа бие, биеэ түшиж тулсан түүх бий. Монгол Улсыг НҮБ болон бусад олон улсын байгууллагад гишүүнчлэлтэй болгохыг Энэтхэг улс тууштай дэмжсэн. Харин Энэтхэг 1971 онд Бангладештай дайтахад нь Монгол Улс Энэтхэгийн талд бат зогсжээ. Улмаар 1972 онд Энэтхэг улс Монгол болон Бутантай хамтран шинээр тусгаар тогтнож буй Бангладешийг хүлээн зөвшөөрөх НҮБ-ын тогтоолыг санаачилж байв²⁹⁶.

Улс төрийн харилцаа

Хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх анхны санамж бичгээ 1973 онд байгуулсан бөгөөд шашин соёлын салбарт л хамаатай мэт байсан энэ баримт бичиг 1994 онд Ерөнхийлөгч П.Очирбатын Шинэ Делид хийсэн айлчлалаар агуулга хэлбэрээ “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай санамж бичиг” болгон тэлж, 2001, 2004, 2009 онуудад шинэчлэгдсээр 2015 онтой золгосон. 2011 онд Энэтхэгийн Ерөнхийлөгч Сингх Патил Монгол Улсад айлчлах үеэр Мэдээллийн технологийн төв байгуулахад 20 сая ам.долларын зээл өгөхөө мэдэгдэж байв. 2015 онд уг төв Атал Бихари Важпайн нэрэмжит болов. Мөн 2016 онд 2,8 сая ам.доллароор хуучин хүүхдийн урлан бүтээх төвийг Мэдээллийн технологийн боловсрол олгох төв болгосон.

Нарендра Моди 2015 оны 5 дугаар сард Монгол Улсад Энэтхэгийн Ерөнхий сайдын хувиар түүхэндээ анх удаа айлчилсан нь хоёр орны харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэж, харилцааны цар хүрээг тэлэхэд томоохон түлхэц болсон. Айлчлалын үеэр талууд Монгол, Энэтхэгийн харилцааг худалдаа, эдийн засгийн салбарт чанарын шинэ түвшинд гаргаж хөгжүүлэхээр тохиролцож, Энэтхэгийн тал Монгол Улсад 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн шугам нээхээр шийдвэрлэсэн нь түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2019 оны 09 дугаар сарын 19- ноос 23-ны өдрүүдэд Энэтхэгт төрийн айлчлал хийсэн ба энэхүү айлчлалын хүрээнд Монгол-Энэтхэгийн харилцааг Стратегийн түншлэлийн түвшинд хүргэхээр тохирсныг талууд тэмдэглэв. Энэхүү стратегийн түншлэлийн хүрээнд хоёр улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон хил хамгаалах салбарын хамтын ажиллагаа улам өргөжиж, “Нүүдэлчин заан”, “Хааны эрэлд” зэрэг цэргийн хамтарсан сургуулилтад хоёр орны зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг тогтмол оролцуулах, кибер аюулгүй байдлын салбарт чадавхыг бэхжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд Монголын талд дэмжлэг үзүүлэхээр тусгасан нь Монголын хувьд чухал байв. Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал болон эдийн засгийн өсөлтийг хангахад томоохон хувь нэмэр оруулахаар уг төсөлд 236 сая ам.долларын зээлийг нэмэлтээр олгох тухай Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийг

²⁹⁶ Narayani Basu, *Mondi in Mongolia: Cultural Crossroads in the Far East*, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>

хүлээн авав. Сэргээгдэх эрчим хүчний талаар хамтран ажиллахаар тохиролцов. Буддын шашны түүхэн уламжлалт харилцаа нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны үнэт зүйл болохыг тэмдэглэж, цаашид бэхжүүлэн хөгжүүлэхээр тохиролцсон нь чухал ач холбогдолтой байна²⁹⁷.

Энэтхэгийн судлаачдын үзэж байгаагаар Монгол Улс хоёр хөршийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа үйл ажиллагаа явуулахгүй байхыг хичээж “Стратегийн автономийг” хадгалж байна гэж үзжээ. Энэ утгаараа “гуравдагч хөрш”-ийн хүрээнд Герман, Европ, Япон, Солонгостой идэвхтэй хамтран ажиллаж байна.²⁹⁸

Монгол-Энэтхэгийн харилцаа үндсэндээ онцын өөрчлөлтгүй 2015 он хүртэл явж иржээ. Харин сүүлийн үед Энэтхэгийн гадаад бодлогод гарч буй өөрчлөлтөөр Энэтхэгийн тал харьцангуй идэвхтэй болж ирж байна. Н.Модигийн айлчлал Монголтой хил залгаа, хүчирхэг өрсөлдөгч, болзошгүй дайсан БНХАУ-ыг хазаарлахын тулд Энэтхэг улс онцгой хүчин чармайлт гаргаж эхэлсэн үетэй давхцаж байна.

Монгол Улс нь хоёр их гүрний дунд оршдогийн хувьд стратегийн хүчний тэнцвэрийг хангаж, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, хоёр хөршийн бодлогод нэрвэгдчихгүй байх нь чухал байна.²⁹⁹ Монгол Улсын хувьд Хятадын орчин тойронд байгаа бусад жижиг улсуудын нэгэн адил дефакто Хятадаас хамааралтай болж байгаа ба үүнтэй хэн ч маргахгүй, түүнд хэн ч туслахгүй³⁰⁰. Хятадын эдийн засгийн болон цэргийн хүч нэмэгдэхийн хэрээр Монгол Улс тэрхүү хүчнийх нь тэнцвэрийг хангах хэмжээний улс орнуудтай харилцах шаардлагатай болж байна. Энэ үүднээс ч том хүчтэй гүрний ард орших, хамгийн урт хилийн шугамтай, эдийн засгийн хувьд Хятадаас бараг бүрэн хараат жижиг улс ямар алхам хийх нь их сонирхолтой байна. Чухам энэ талаасаа Монгол Улс дэлхийн анхаарлыг татаж байна.

Эдийн засгийн харилцаа

Хятадын нэгэн адил Энэтхэг эрчим хүчний том хэрэглэгч орон болоод байна. Энэтхэгийн дотоодын эрчим хүчний нөөц хүрэлцэхгүй байгаа учраас эрчим хүчний 70 хувь нь импортын газрын тосноос хамааралтай байгаа ба 2020 онд 85 хувьд хүрчээ³⁰¹. Газар зүйн хувьд Монгол Улс нь ЗХА, Төв Азид оршиж байхад Энэтхэг өмнөд Азид оршиж байна. Улаанбаатар-Шинэ Дэли хооронд 3330 км-ын зайтай, гэхдээ бараа бүтээгдэхүүнээ далайгаар тээвэрлэнэ гэж үзвэл 7000 орчим км замыг туулах болно. Энэ байдал нь Монгол, Энэтхэгийн хоорондын худалдаа эдийн засгийн харилцааны өрсөлдөх чадвар сул байх нөхцөл болж байгаа юм³⁰². Монголоос гарсан бараа Энэтхэгт 45 өдрийн дараа очдог байна.

²⁹⁷ MoHro.i-3H3TX3rwnH CTparerwnH TyHnun/miir ynaM foxjKyujrjx хухаи хаMхарсан Majpmsji, Faraaa харmmaanbi saM. 2019.09.20 <http://w3V'w.mfa.gov.mn/?p=52581>

²⁹⁸ Narayani Basu, Modi in Mongolia: Cultural Crossroads in the Far East, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>

²⁹⁹ Patrick Mendis, Mongolia is seeking greener pastures with the US and India to balance China's influence, South China Morning Post, 2019.11.17, <https://www.scmp.com/comment/opinion/article/3037785/mongolia-seeking-greener-pastures-us-and-india-balanc-chinas>

³⁰⁰ James Crabtree, Mongolia needs allies to withstand China's looming threat, 2019.10.09, <https://asia.nikkei.com/Opinion/Mongolia-needs-allies-to-withstand-China-s-looming-threat>

³⁰¹ Taylan Ozgur Kaya, Sino-Indian Strategic Rivalry in the Indian Ocean Region. The Journal of Humanity and Society. 2017. p. 158

³⁰² Prabir De, Sreya Pan, India-Mongolia Economic Relations: Current Status and Future Prospect, The Northeast Asian Economic Review, Vol 5, No.2, 2017

Монгол, Энэтхэгийн худалдаа дээд тал нь 60 сая ам.доллар хүрч байсан нь БНХАУ-тай хийх худалдааны 1 хувьд ч хүрэхгүй. Гэвч бидэнд байгалийн баялаг, стратегийн ашигт малтмал болох нүүрс, зэс, уран бий. Монголоос Энэтхэг рүү голдуу малын гаралтай бүтээгдэхүүн болох ноос, ноолуур экспортолдог, харин Энэтхэгээс эм, ХАА-н бүтээгдэхүүн, халуун ногоо, цай, кофе, уул уурхайн механизм, машины сэлбэг зэргийг импортоор авдаг байна. Зарим судлаачийн үзэж байгаагаар одоо Монголын хувьд Энэтхэг нь шашин нэгтэй оюун санааны хөрш төдийгүй, бизнесийн түнш, холбоотон, маш чухал "гуравдагч хөрш" болсон байна.^{303 304}

3.5 дугаар хүснэгт.

Монгол-Энэтхэгийн худалдааны эргэлт (сая ам.доллараар)²⁹

Импорт/экспорт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Монголоос Энэтхэг руу экспорт	1,4	6,0	0,8	3,0	3,7	2,2	1,7	1,0	1,2
Энэтхэгээс Монгол руу импорт	45,3	54,2	34,2	12,7	16,8	24,7	35,8	51,6	37,1
Нийт худалдаа эргэлт	46,7	60,2	35,0	15,7	20,5	26,9	37,5	52,6	38,3

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гаргасан энэхүү хүснэгтээс үзэхэд хоёр орны худалдаа тэнцвэргүй байгаа нь харагдаж байна. Үүний зэрэгцээ Монголыг нүүрс, зэс, алт, уран болон газрын ховор элементээр баян орон гэж Энэтхэг үздэг.

Энэтхэгийн “Зүүн зүг хэрэгжүүлэх” бодлого Монголын “Гуравдагч хөрш”-ийн бодлоготой нийцэж, уялдаж байгаа. 2009 оноос Монгол Энэтхэгтэй цөмийн материалыг энхийн зорилгоор ашиглах тухай гэрээ байгуулсан³⁰⁵. Энэтхэг уран авах талаар Австрали, Канад, АНУ-тай яриа хэлэлцээ явуулж байгаа. Хэрвээ яриа хэлэлцээ тодорхой үр дүнд хүрэхгүй бол эсвэл хангалттай хэмжээнд хүрэхгүй бол Монголоос уран авах сонирхолтой байна.

Энэтхэгийн талаас үзвэл Н.Модигийн амласан 1 тэрбум ам.доллар монголчуудад БНХАУ-ын нөлөөг бууруулах, сөрөн зогсох шинэ хүч өгөх учиртай аж. Энэ бол Энэтхэгийн хувьд БНХАУ-ын “арын хаалга”-н дээр түшиц байршуулах сайхан боломж юм. Энэтхэгийн үзэж байгаагаар хэрвээ Хятад Зүүн өмнөд Азид нөлөөгөө ихэсгээд байвал Энэтхэг Хятадын ар дагзанд геополитикийн тоглолт хийж болох дохиог Хятадад өгч байна гэжээ³⁰⁶.

Харин Монголын зүгээс Энэтхэг улсыг ОХУ, БНХАУ-ын Монгол дахь ашиг сонирхлын тэнцвэрийг бий болгох “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд авч үзэж байгаа.

Монгол Улсын хувьд хоёр их хөрштэйгөө харилцахад илүүтэй анхаарлаа хандуулах нь тодорхой. Үүнд Энэтхэг ямар нэгэн нөлөө байхгүй, гэхдээ Монгол Улс Энэтхэгтэй харилцаагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа нь гадаад харилцаагаа илүү өргөн хүрээнд, илүү олон салбарлуулахыг хүсэж байгаатай холбоотой. Өмнө нь дурдсан Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд Монгол Улс Энэтхэгтэй худалдаа, хөрөнгө оруулалт,

³⁰³ Х.Батсайхан, Энэтхэгийн гадаад бодлогын шатрын хелег дээрх Монгол, 2019.10.10, <http://eagle.mn/r/63798>

³⁰⁴ Монгол дахь Энэтхэгийн элчин сайдын яам. <https://eoi.gov.in/ulaanbaaiar/7pdf43467000>

³⁰⁵ Balaji Chandramohan, India and Mongolia: Uranium and Beyond, Future Directions International, 2015, <http://www.futuredirections.org.au/publication/india-and-mongolia-uranium-and-beyond/>

³⁰⁶ Prabir De, Sreya Pan, India-Mongolia Economic Relations: Current Status and Future Prospect, The Northeast Asian Economic Review, Vol 5, No.2, 2017

буцалтгүй болон хөнгөлөлттэй зээл авах замаар хамтын ажиллагаагаа хөгжүүлэх боломжтой юм. Хэдийгээр энэхүү стратегийг АНУ тэргүүлэн явуулж байгаа ч Энэтхэг анх санаачилсан байдаг ба хувийн хэвшил дээр тулгуурласан нээлттэй эдийн засгийн бодлогыг явуулах нь чухал байгаа юм. АНУ-ын зүгээс Энэтхэг-Номхон далайн стратегийн бодлогын нэг хэрэгжилт нь Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр Улаанбаатар хотын тодорхой дэд бүтцийн байгууламжуудад хөрөнгө оруулж тусламж үзүүлэх замаар явж байна². Үүний адилаар Энэтхэгтэй худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламж авах замаар стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтад хамтран ажиллаж болох юм. Харин Энэтхэгийн хувьд Монголтой батлан хамгаалах салбарт хамтран ажиллах нь “зүүн зүг хэрэгжүүлэх” бодлогын нэг хэсэг нь юм³.

Батлан хамгаалах салбарын харилцаа

Энэтхэг Монголтой нэгэн адил Хятадын нөлөөг тогтоон барихыг хүсэж байгаа ба үүнд ЗХА, Төв Азийн бус нутагт Монголтой харилцах замаар тэнцвэрт байдал бий болгохыг эрмэлзэж байна. Энэтхэг Монгол Улстай харилцаагаа бэхжүүлж байгаа нь Энэтхэг, Хятадын бус нутаг дахь геополитикийн өрсөлдөөндөө хөрш зэргэлдээ болон энэхүү хүрээнд багтаж байгаа жижиг, дунд хэмжээний бусад орнуудын дэмжлэгийг авах замаар тэнцвэрт байдлыг хангахыг оролдож байна^{307 308 309}.

Батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагаа нь Энэтхэгийн байр сууринаас бол Хятадыг тогтоон барьж, хүчийг тэнцвэржүүлэх Н.Модийн Зүүн зүг хэрэгжүүлж буй бодлогын нэг хэсэг юм³¹⁰. Энэтхэгийн Ерөнхийлөгч Патил 2011 онд Монгол Улсад айлчлах үеэрээ “Нүүдэлчин заан” нэртэй хамтарсан цэргийн хээрийн сургууль хийхээр тохирсон нь уламжлал болоод явж байгаа. Монголоос зохион байгуулдаг “Хааны эрэлд” олон улсын цэргийн хээрийн сургуулилалтад Энэтхэг улс байнга оролцож ирсэн. Энэхүү Цэргийн хамтарсан сургуулилт 2018, 2019 онуудад болсон. Үүний зэрэгцээ хил хамгаалах асуудлаар ч харилцаа өргөжиж байгаа.

Батлан хамгаалахын салбарт Монгол, Энэтхэгийн хамтын ажиллагаа ялангуяа Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд АНУ-тай хамтран цааш үргэлжлэх нь илүү бодитой харагддаг. Монгол улс 2000 оноос батлан хамгаалах болон хил хамгаалах салбарт АНУ, Европын улс орнууд болон НАТО-той хамтран ажиллаж ирсэн. Энэ хүрээнд Энэтхэгийн зэвсэгт хүчин “Хааны эрэлд” хээрийн сургуулилалтад оролцож ирсэн байдаг. Энэ уламжлалаа үргэлжлүүлэх нь тодорхой. Батлан хамгаалах салбарын хүрээнд мөн хил хамгаалах салбарт ч АНУ, Орос, НАТО-той хамтын ажиллагаатай байх нь илүү дээр болохыг цаг хугацаа харуулж байна.

Аюулгүй байдлын салбарт Энэтхэгийн талаас Монголын цэргүүдийг кибер аюулгүй байдалд бэлдэх нь чухал гэж үзэж байна. Ялангуяа мэдээллийн эрин зууны үед Хятадаас ирэх кибер аюулгүй байдлын асуудалд сүлжээний аюулгүй байдал үл хайхран

³⁰⁷ Remarks by Charge d'affaires a.i. Manuel P. Micaller at the AmCham Annual General Meeting Regarding the Indo-Pacific Strategy and Mongolia, <https://mn.usembassy.gov/2018-amcham-agm-cda-remarks/>

³⁰⁸ Ankit Panda, India offers Defense Assistance to Mongolia, 2014.12.23, <https://thediomat.com/2014/12/india-offers-defense-assistance-to-mongolia/>

³⁰⁹ ‘India-Mongolia cooperation signals to Beijing that India can play the geopolitical game in China’s backyard’. The Times of India, 2017.07.24, <https://timesofindia.indiatimes.com/blogs/the-interviews-blog/india-mongolia-cooperation-signals-to-beijing-that-india-can-play-the-geopolitical-game-in-chinas-backyard/>

³¹⁰ ‘India-Mongolia cooperation signals to Beijing that India can play the geopolitical game in China’s backyard’, The Times of India, 2017.07.24, <https://timesofindia.indiatimes.com/blogs/the-interviews-blog/india-mongolia-cooperation-signals-to-beijing-that-india-can-play-the-geopolitical-game-in-chinas-backyard/>

өнгөрч болохгүй цаг үе юм⁶. Энэтхэг үүнийг маш зөв, бодит дэмжлэг гэж үзэж байна. Монгол Улсын хувьд байгуулагдаад удаагүй байгаа кибер дайн, кибер терроризмтой тэмцэх зэвсэгт хүчний анги нэгтгэлийн ур чадварыг сайжруулах. техник, тоног төхөөрөмжөөр хангахад энэ салбарын үйл ажиллагаа нь хөгжсөн Энэтхэгтэй хамтран ажиллах нь чухал юм.

Зүүн зүг хэрэгжүүлэх Н.Модигийн гадаад бодлогын тулгуур нь амархан ойлголцож болох буддын соёлтой орнуудтай харилцаа тогтоохыг чухалчилж буй явдал юм. Монгол Улсыг “буддизмын хойд туйл” гэж Энэтхэг үздэг”. Н.Моди Монголын “гуравдагч хөрш”-ийн бодлогын зэрэгцээ “оюун санааны” хөрш болохыг дэмжиж Энэтхэгийн талаас хоёр орны харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор “буддизм ба ардчилал” гэх бодлогыг явуулж байна. Энэтхэг өөрийгөө хамгийн их хун амтай, хамгийн том ардчилсан улс гэж нэрлэх дуртай ба дэлхийд ч үүнийг хүлээн зөвшөөрүүлэхийг хүсдэг.

“Буддизм ба ардчиллын” хүрээнд Н.Моди шашны уламжлал дээр суурилсан хоёр орны харилцааг бэхжүүлэхийг хүсэж байна. Энэ нь зөвхөн^{311 312} Монголтой харилцахад бус Зуун болон Зуун өмнөд азиар айлчлахдаа буддын шашинд тулгуурлан харилцаагаа зузаатгах бодлого хэрэгжүүлж байна. Буддын шашинтай улсууд нь харилцахад илүү амар, дөхөмтэй юм.

Н.Моди Монголд айлчлах үеэрээ энэхүү үзэл санаагаа суурь болгосон бөгөөд Монголыг Алс Дорнод, ЗХА дахь буддизм болон Энэтхэгийн соёлыг түгээх боломжтой төв, түшиц газар байж болох юм гэсэн санааг гаргажээ. Гэхдээ энэхүү асуудал нь нилээд геополитикийн шинжтэй болохыг Монгол Улсад болсон үйл явдлууд харуулсан билээ. Тухайлбал 2016 оны сүүлээр Далай ламын Улаанбаатарт хийсэн дөрвөн өдрийн айлчлалыг Шинэ Дели дэмжсэн. Далай лам өмнө нь Монголд найман удаа айлчилсан байдаг. Харин ес дэх удаагийн айлчлалыг Бээжин хүндээр хүлээж авч, Улаанбаатарын эсрэг хориг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Бээжин Улаанбаатартай хийх худалдаа эдийн засгийн харилцааныхаа дүрэм журам, үнэ тарифыг шинэчилж эхэлсэн. Тухайлбал, хилээр нэвтэрч байгаа ачааны машин болгоноос 10 юанийн татвар нэмж авах болсныг энд дурдаж болох юм. Ийм тохиолдлуудад Монгол урьдынх шигээ Оросоос тусламж авах боломжтой юу? гэсэн асуулт гарч ирнэ. Орчин үед цаг, нөхцөл байдал өөр болж, Москва Бээжинтэй хэтэрхий ойр хамтарч ажиллаж байгаа учраас хойд хөршөөсөө тусламж гуйгаад бүтэхгүй. Тиймээс монголчууд бусад эх үүсвэрүүдийг хайж шаардлагатай болно. Эндээс урган гарч буй санаа нь Монгол Улс “гуравдагч хөрш” болох Энэтхэгт хандаж болох юм. Монгол Энэтхэг аль, аль нь харилцаандаа маш их ач холбогдол өгч байгаа нь төрийн тэргүүн нарын айлчлалаас харагдаж байгаа юм .

“Буддизм ба ардчилал” бодлогын хүрээнд анхаарлаа хандуулах өөр нэг зүйл бол буддын шашны соёлтой Монголчуудын эв нэгдлийн асуудал юм. Монголд Ардчилсан хувьсгал ялж, шүтэн бишрэх эрх чөлөө сэргэсэн үед Энэтхэгээс Монголд суух Элчин сайдаараа Бакула Ренбучи хэмээх Ладакийн хувилгааныг томилсон нь 10 жил Монголд суусан билээ. Тэрбээр устаж үгүй болсон шарын шашныг Монголд сэргээсэн. Өдгөө Улаанбаатарт Ладак мужийн харьяаны Бэтуб хийд үйл ажиллагаа явуулж байгаа. Монгол Улсын эв нэгдэл, тусгаар тогтнолын асуудал болон түүнийг хүрээлэн оршиж буй

³¹¹ Ankit Panda, India Prime Minister Narendra Modi s tour of East Asia, 2015.05.20, <https://thediplomat.com/2015/05/india-acts-east-understanding-modis-tour-of-china-mongolia-and-south-korea/>

³¹² Владислав Гулевич, Монгольско-индийское сотрудничество с оглядкой на Китай, 2018.01.02, <https://interaffairs.ru/news/show/19095>

геополитикийн асуудлыг ерөнхийд нь авч үзвэл XIV Далай ламын хойд дүр хаанаас тодрохоос эхлээд Хятад өөрийн Далай ламыг тодруулсан зэрэг асуудлууд яригдана. Энэ нь Монголчуудын сүсэг бишрэлийн асуудалд багагүй нөлөөтэй.

Ганц Монгол гэлтгүй бусад газарт ч XIV Далай ламыг хил тавиулахыг Хятад хорьж, виз олгохгүй, урьж хүлээн авсан улсуудад Хятадын дотоод хэрэгт оролцож, дайсагнасан хандлага гаргаж байгаа талаар эрс эсэргүүцлээ^{313 314} илэрхийлж байна. Хятад хүчтэй гүрэн учраас түүнтэй эн тэнцэхүйц өрнөдийн орнуудаас бусад нь Хятадаас болгоомжлон Далай ламыг хүлээн авахаас татгалзаж эхэлсэн. Эдгээр орнуудын тоо улам нэмэгдсээр байгаа. Монголчууд XIV Далай ламыг шашны хувилгаан гэдэг утгаар хүлээн авч сүсэглэдэг боловч туунд 1990 онд Нобелийн Энхтайвны шагнал олгосон нь шашны тэргүүн гэхээсээ улс төрийн зүтгэлтэн болгон харагдуулж байна. Энэ нь Хятад байр сууриа зөвтгөх шалтгаан болж байна.

Гол асуудал нь шарын шашин өнөөдрийн хувьд Монголын ард түмний сүсэг бишрэл гэхээсээ илүү Монголын соёлыг тээгч болж байгаа, мөн дэлхийгээр тархсан элэг нэгт Монгол угсаатнуудыг нэгтгэж байгаа үзэл санаа гэдэг утгаараа Далай лам шашин, үзэл санааны талаасаа чухал ач холбогдолтой юм. Хятадтай зөрчилтэй байгаа Энэтхэгийн хувьд Далай лам бас л нэг шийдэх шаардлагатай асуудлын нэг болоод байна. Далай лам 2001 онд төрийн эрхээсээ хагас татгалзаж, 2011 онд улс төрийн эрхээсээ бүрэн татгалзсан. Чингэхдээ ардчилсан үзэл бодолтой хүнд эрхээ шилжүүлсэн байна^{315 316}.

Энэтхэгийн хувьд 1990 онд Монгол Улс ардчилал шинэчлэлийн замд орсон нь зүгээр ч нэг тохиолдлын асуудал биш ба буддын шашны сэргээн хөгжүүлсэн нь Энэтхэгийн бодлоготой нийцэж байгаа юм. Энэ суурин дээр хоёр улс терроризм болон хэт даврах үзлийн эсрэг хамтран тэмцэх хэрэгтэй гэсэн байр суурийг П.Стобдан дэвшүүлж байгаа юм. Үүний тулд шашин, соёлын асуудлыг тодорхой бөгөөд зөвөөр ойлгуулах нь чухал болж байна⁴¹.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэхэд Монгол Улсын гадаад бодлого ерөнхийдөө ЗХА-ын бус нутаг руу чиглэж байгаа. Монгол Улс Энэтхэгийг "гуравдагч хөрш", ялангуяа оюун санааны хөрш гэж үзэж байгаа.

Энэтхэгийн гадаад бодлогын алсын хараа нь Хятадтай эн зэрэгцэхүйц дэлхийн их гүрэн болох явдал юм. Үүний тулд хамгийн их хүн амтай ардчилсан орны хувьд Энэтхэг зах зээлээ тэлэн эдийн засгаа босгож, хөрш орнуудад хөрөнгө оруулалт, зээл, тусламж үзүүлэх замаар Хятадын зөөлөн хүчний бодлогыг Энэтхэгийн далай болон Номхон далай руу тэлэхгүй байлгах бодлого явуулж байна. Ингэхдээ Хятадтай хилийн маргаан болон бусад асуудалтай байгаа учраас аливаа зөрчилд хүргэхгүй байх; зөрчил маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг хичээж байна.

1991 оноос хойш Энэтхэг улс Зүүн зүг рүү харсан бодлого явуулж ирсэн, гэвч Энэтхэгийг тойроод Хятадын нөлөө ихсэж, Энэтхэгийн хөрш орнуудад Хятад зээл тусламж өгч, боомтуудыг нь түрээслэн авч, цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлж,

³⁸Narayani Basu. *Mondi in Mongolia: Cultural Crossroads in the Far East*, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>

³⁹Narayani Basu, *Mondi in Mongolia: Cultural Crossroads in the Far East*, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>

³¹⁵ Далай лам, Ванчин богдын талаар илуу судлах хэрэгтэй, 2015.09.15, <https://news.mn/r/222261/>

³¹⁶ P.Stobdan, *India and Mongolia: Modi on Ashoka's Path*, https://idsa.in/idsacomments/IndiaandMongolia_pstobdan_130515

Энэтхэгийг бараг боож байгаа нь Энэтхэгийн гадаад бодлогыг эрчимжүүлэхэд хүргэж байна. Энэ бүх нөхцөл байдлаас үүдэн Н.Моди Зүүн зүг харах бодлогыг өөрчилж Зүүн зүг хэрэгжүүлж эхлэв. Энэ бодлогын хүрээнд харьцангуй зогсонги байсан Монгол-Энэтхэгийн харилцаа Энэтхэгийн санаачилгаар алхам алхмаар идэвхжиж эхэлжээ.

Н.Модийн зүүн зүг рүү хэрэгжүүлж байгаа бодлого нь 1-рт, тус бус нутагт стратегийн тэнцвэрт байдлыг бий болгох, 2-рт, АНУ-ын Энэтхэг- Номхон далайн стратегитай нийцэж байгаа юм. Эдгээр бодлогууд нь Хятадын нөлөөг тогтоон барихад чиглэж байна.

Зүүн зүг хэрэгжүүлэх бодлогод Монгол Улс хамаардаг. Хятадын нөлөөг тогтоон барихад Хятадын хойд талд орших буддын шашинтай, ардчилсан Монгол Улс чухал гэж Энэтхэг хардаг. Харин Монголын зүгээс Оросоос гадна Хятадыг тэнцвэржүүлэх боломжтой "гуравдагч хөрш" нь Энэтхэг байж болох талтай.

АНУ-ын хувьд Энэтхэг-Номхон далайн стратегийг хэрэгжүүлж, Хятадын хүчирхэгжилтийг тогтоон барихад Энэтхэг чухал ач холбогдолтой. Мөн хоёр том авторитар дэглэмтэй их гүрнүүдийн дүнд орших Монгол Улс АНУ болон Энэтхэгийн аль алиных нь ашиг сонирхолд нийцэж байна. Иймээс ч тус хоёр улстай байгуулсан стратегийн түншлэлийн баримт бичигт Энэтхэг- Номхон далайн стратегийн талаар тусгасан байдаг.

Монгол-Энэтхэгийн харилцаа оюун санааны хөрш гэдэг утгаараа Монголын түүх, соёлын сурталчлах хүрээнд хөгжих боломжтой. Шинжлэх ухаан, технологийн салбар дахь хамтын ажиллагаа тэр дундаа эрүүл мэнд болон кибер аюулгүй байдлаар сургах, мэргэжилтэн солилцох бүрэн боломжтой.

Эдийн засгийн салбарт Энэтхэгийн эрчим хүчний хэрэгцээг харгалзан нүүрс, уран экспортлох боломжтой ба цөмийн гэхээсээ сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллавал илүү боломжтой.

Батлан хамгаалах салбарын хувьд “Нүүдэлчин заан” цэргийн сургуулилыг тогтмолжуулах боломжтой. Мөн Энэтхэгтэй гамшгийн үеийн үйл ажиллагаа болон кибер аюулгүй байдлын салбарт харилцаагаа хөгжүүлэх нь илүү үр дүнтэй.

Энэтхэг Улс эдүгээ эрчимтэй хөгжиж, дэлхийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг роль нь өсөн нэмэгдэж, гадаад улс орнуудтай хөгжүүлж буй хамтын ажиллагаа нь өргөжсөөр байна. Энэ хүрээнд хөгжиж буй улс орнуудад зээл, тусламж олгох явдал ч нэмэгдсээр байгаа юм. Энэтхэг Улсын энэхүү бодлого, дэмжлэгт Монгол Улс тэргүүн эгнээнд хамрагдаж, эдүгээ Монгол, Энэтхэгийн эдийн засгийн харилцааны бэлгэ тэмдэг болсон мега төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ.

3.5.2 Харилцааны хэтийн төлөв

Монгол улс, БНЭУ хоёр улсын харилцааны хэтийн төлөв дэлхийн дэг журам болон их гүрнүүдийн хоорондын харилцааны өөрчлөлтөөс мөн л хамаарах боловч Энэтхэг улс тэдгээртээ харилцах харилцааны алсын харааг улс төр, дипломатын бодлогоор хязгаарлагдахгүй эдийн засаг, шинжлэх ухаан, соёл, аюулгүй байдлын ашиг сонирхлоо бүс нутгийн төдийгүй дэлхийн хэмжээнд тавьж, харилцан эрх тэгш зарчим дээр тулгуурласан хүчтэй эдийн засагтай Энэтхэг орныг бий болгоход чиглүүлж байна. Тиймээс харилцааны хэтийн төлөвийг Монгол, БНЭУ-ын өнөөгийн харилцааны болон их гүрнүүдтэй харилцаж буй онцлогийг тооцон, аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйд тулгуурлан 3.1 болон 3.2 дугаар зүйлүүдэд үүсгэсэн их гүрнүүдийн хоорондын

харилцааны сценарууд, тэдгээрийн үүсэж болох хувилбарууд, тэдгээрт Монгол Улсын болон “гуравдагч хөрш” БНЭУ-ын баримталж болох боломжит байр сууриар тодорхойллоо.

Чингэхдээ БНЭУ-ын их гүрнүүдтэй харилцах харилцааны онцлогийн хувьд геополитикийн үүднээс авч үзвэл: *нэгд*, Энэтхэгийн далайд ноёрхлоо тогтоох стратегийн өрсөлдөөн Энэтхэг, АНУ, Хятадын хооронд ширүүн өрнөж байгаа бөгөөд энэ өрсөлдөөнийг Энэтхэг байгаагаар нь өрсөлдөөн гэж үздэг, харин АНУ Энэтхэгийн далай дахь аюулгүй байдлыг хангаж байна, Хятад эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна гэж зөөлөн хүчний бодлогоор тайлбарладаг байна., *хоёрт*, Энэтхэг “Нэг бүс ба нэг зам” төслийн дэмжихгүй байгаа бөгөөд гол үндэслэл, шалтгаан нь Энэтхэг, Пакистаны хоорондын маргаантай газар нутаг дээгүүр дамнуулан байгуулах Хятад-Пакистаны эдийн засгийн коридорын асуудал байна., *гуравт*, Энэтхэг “Бүс ба зам” төслийг олон талт санал санаачилга нь ил тод, харилцан тохиролцсон шинжтэй байх ёстой атал Хятадын зүгээс эдийн засгийн давуу байдалдаа дулдуйдан хэрэгжүүлж байгаа төсөл хэмээн үзэж байна, *дөрөвт*, Энэтхэг, Оросын харилцаа “Онцгой эрхтэй стратегийн түнш” гэж тодорхойлдог бөгөөд уламжлалт сайн харилцаа нь үргэлжилж, батлан хамгаалахын харилцаандаа голлон анхаарч, зэвсэг техник, цөмийн салбар, сансар судлал, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж байгаа., *тавд*, БНЭУ Ази, Номхон далай, Зүүн өмнөд Ази руу хандсан тус бүс нутаг дахь ашиг сонирхлын тэнцвэрийг бий болгох, Хятадын нөлөөний хүрээгээ тэлэх бодлогыг сөрж зогсох гол зорилготой Зүүн Өмнөд Азид олон туйлт харилцаа үүсгэхийг эрмэлзсэн Act East бодлого хэрэгжүүлж байна., *зургаад*, Энэтхэг АНУ-ыг зүгээс хэрэгжүүлж байгаа Энэтхэг-Номхон далайн стратегийг дэмжиж байгаа зэрэг асуудлыг доорх болзошгүй бүх хувилбаруудын үеийн Монгол, Энэтхэгийн хамтын ажиллагаа, харилцааны талаар баримтлах хэтийг харсан бодлого, стратегитээ харгалзан үзэж байх шаардлагатай.

Нэг. АНУ, ОХУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол ба БНЭУ-ын харилцаанд түлгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ, ОХУ-ын харилцааны эерэг сценар:

1. *Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, улсуудын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, олон улсын байгууллагуудын үүрэг ба бусад улс, үндэстнүүдийн эрх ашгийн үндсэн дээр “Дэлхийн олон туйлт дэг журмыг бататгах”.*

Ийм сценарын үед ОХУ болон Хятадын байр суурь нэгдмэл байх магадлалтай. Монгол Улс Орос–Монгол–Хятад гэсэн эдийн засгийн коридороо хөгжүүлэх талаар хоёр хөрштэйгөө хамтран ажиллахаас гадна “гуравдагч хөрш”-ийн стратегийн түншлэлийн бодлогоо АНУ болон БНЭУ-тай хэвийн үргэлжлүүлэх боломжтой байна. Монгол, Энэтхэгийн стратегийн түншлэл нь Энэтхэгийн Хятадтай тэнцвэржүүлэх стратеги, Монголын хоёр хүчирхэг хөрш болох БНХАУ, ОХУ-ын эсрэг "зөөлөн тэнцвэржүүлэх" стратегийн аль алинд нь үйлчилнэ.

БНЭУ "Хөршүүд нэн түрүүнд" бодлогынхоо хүрээнд Хятадтай олон чиглэлээр, олон түвшний хөршийн харилцааг хөгжүүлэхэд анхаарахын зэрэгцээ Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал, эдийн засгийн өсөлтийг хангахад томоохон хувь нэмэр оруулсаар байх болно. Мөн стратегийн түншлэлийн хүрээнд хоёр улсын үндэсний

аюулгүй байдал, батлан хамгаалах болон хил хамгаалах салбарын хамтын ажиллагаа үргэлжлэн хөгжинө.

Түүнчлэн Монгол ШХАБ-ын гишүүн болсон тохиолдолд ШХАБ-ын хүрээн дэх эдийн засгийн хөгжлийг дэмжих санаачилгуудад хамтран ажиллах боломж нээгдэх магадлал өндөр байна. Энэ чиглэлд *нэгд*, Энэтхэг Төв Азийн бүс нутгийн улсуудтай харилцаагаа улс төр, эдийн засгийн санаачилга, төслүүдийн хүрээнд өргөжүүлж, тэдэнтэй “Энэтхэг –Төв Азийн бүлэг” байгуулаад байна, *хоёрт*, Монгол Төв Азийн төвд оршдог учир газар зүйн хувьд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа ойртох боломжтой, *гуравт*, хоёр хөршийн зүгээс манай улсыг ШХАБ-д жинхэнэ гишүүн болгох сонирхолтой байдаг. Энэтхэг улс ШХАБ-ын гишүүнд элссэн нь манай улс ШХАБ-д элссэн тохиолдолд хоёр хөршөөс ирж болох ямар нэгэн тулгалт, шахалтад тэнцвэржүүлэх нөлөө бүхий гуравдагч хүчин бий болсон.

2. АНУ ба ОХУ хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Хятадын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Ийм хувилбар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд ихээхэн зөрчилтэй нөхцөл байдал үүснэ. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт *нэгд*, АНУ ба Оросын манайтай харилцах харилцааны онцлогоос үл хамааран соёл иргэншлийн хувьд Хятадад уусаж устах аюул заналын эрсдэл нэмэгдэх, *хоёрт*, хоёр хөршийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй дарамт, шахалтууд эрчимжих зэрэг хоёр хувилбар тулгарч болно.

Энэ тохиолдолд БНЭУ-тай хамтран ажиллаж Эртний хятадын ойлголтоор “хүмүүний ямар угсаатай, эсвэл хаана төрсөн зэрэг нь гол бус, харин уул хүмүүн хятад соёлыг хэр зэрэг өөртөө шингээж авсан гэдэг нь шийдвэрлэх зүйл юм. Хэн нэг харь хүмүүн хятадын соёл иргэншлийг хүлээн авч, өөрийн болгож, түүний дагуу амьдарч байгаа бол тэр хүмүүн хятад хүн болно” хэмээсэн сургаалын хэрэгжилтийн эсрэг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасанчлан Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх замаар монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлааг байвал зохих хэмжээнд авч явахад тустай хоёр орны ард түмний соёлын олон талын үйл ажиллагааг түүхэн баримтад тулгуурлан хөгжүүлэх боломжийг бүрэн ашиглах шаардлагатай.

Ийм боломж: *нэгд*, Энэтхэг улс гадаад бодлогоо илүү сайн явуулахын тулд буддын соёлтой орнуудтай харилцаа тогтоохыг чухалчилдаг, *хоёрт*, Энэтхэг Монголыг “буддизмын хойд туйл” гэж үздэг, *гуравт*, Энэтхэгийн талаас Монголтой “оюун санааны хөрш” болохыг дэмжиж харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор “буддизм ба ардчилал” гэсэн бодлогыг явуулж байгаа зэрэгт агуулагдаж байна. Түүнчлэн Монгол-Энэтхэгийн харилцааг Стратегийн түншлэлийн түвшинд хүргэхээр тохирох үед 2019 онд Буддын шашны түүхэн уламжлалт харилцаа нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны үнэт зүйл болохыг тэмдэглэж, цаашид бэхжүүлэн хөгжүүлэхээр тохиролцсон нь боломжийг нэмэгдүүлсэн чухал алхам юм.

3. АНУ ба ОХУ хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Энэ хувилбарын үед манай хоёр том хөршийн хооронд хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх магадлал өндөр байна. Монгол Улсын аюулгүй байдлын хувьд өөрийн үндэстний цөөнхийн талаар оновчтой бодлого явуулах, гаднаас дүрвэгсэд орж ирж болзошгүй нөхцөлд бэлэн байх, терроризмын аюул заналаас сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлага гарна. Хоёр хөрш гүрэнтэй харилцах бодлого хэвийн үргэлжлэх

бөгөөд “гуравдагч хөрш” БНЭУ болон НҮБ-ын байр суурийг дэмжиж, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал байх болно..

4. *Оросын засагт оросын үндэсний эрх ашиг сонирхол ба орос соёл иргэнийн үнэт зүйлсийн системтэй зөрчилдсөн (XX зууны 90-ээд оны эхний хагаст ийм явдал Орост үндсэндээ тохиолдсон) АНУ-ын аливаа нөхцөлүүдийн хараат хамтын ажиллагаанд бэлнээр нээлттэй хандсан эрх барих бүлгүүд гарах.*

Ийм хувилбар үүсвэл Орос, АНУ хоёр хамтарч Хятадад дарамт, шахалт үзүүлэх ба Орос, Хятадын хоорондын харилцаа эрс хүйтэрнэ. Эдгээр хоёр улсын хувьд стратегийн чухал байршилтай манай улсад аль аль талаас нь дарамт, шахалт ирнэ.

Орос улсад Америкийн талыг баримтлагчдыг эсэргүүцсэн хүмүүс болон эрх баригч талын хоорондох дотоодын зөрчил хурцдаж болно. Мэдээжээр Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорын асуудал зогсонги байдалд орно. Оросын дотоодын үймээнээс дайжсан дүрвэгсдийн асуудал гарна. Энэтхэг Орос болон АНУ-тай батлан хамгаалах эрх ашгийн хүрээнд харилцаатай учир Оростой уламжлалт сайн харилцаагаа үргэлжлүүлэхийг эрмэлзэх магадлал өндөр байна.

БНЭУ Энэтхэг Номхон далайн стратегитай нийцүүлэн Зүүн зүг хэрэгжүүлэх бодлогоо эрчимжүүлэх бөгөөд энэ бодлогодоо монголын оролцоог нэмэгдүүлэхийг эрмэлзэнэ. Монголын хувьд Орос, Хятадыг тэнцвэржүүлэх боломжтой “гуравдагч хөрш” нь Энэтхэг байсаар байх болно. Батлан хамгаалах бодлогын хүрээнд дүрвэгсдийн үеийн үйл ажиллагаа болон кибер аюулгүй байдлын салбарт харилцаагаа илүүтэй бэхжүүлэхэд анхаарах нь чухал байх болно. Орос болон Хятад хоорондын харилцааны талаарх НҮБ-ын байр суурийг ажиглаж, төвийг сахисан байр суурь баримтлах явдал зөв байж болно.

5. *Дэлхийн хүчний харилцаа бусад улс орнуудтай реалист, шударга харилцаа руу болон өөр (тэгш г.м) зарчмуудын үндсэн дээр олон улсын харилцааг бодитоор босгох бэлэн байдал руу өөрчлөгдөх нөлөөлөл дор АНУ-ын засгийн эрх баригчид аажим хувьсах.*

Ийм сценарын үед хоёр хөршийн харилцаа стратегийн иж бүрэн түншлэлийн хүрээнд өрнөж, Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт ихээхэн таатай нөхцөл бий болно. Улс орнуудтай тухайлбал, “гуравдагч хөрш” БНЭУ-тай стратегийн түншлэлийн өргөн хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэх, тогтвортой хөгжих боломж байна. Гагцхүү Энэтхэг улстай харилцахдаа ““Гуравдагч хөрш”-үүдээс гуйлга гуйх сэтгэлгээ Монгол талаас давамгайлж, харин ардчилсан, өндөр хөгжилтэй орнуудад энэ нь таалагддаггүй, тэд харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхолтой байдаг. Энэ нь "гуравдагч хөрш"-ийн бодлогод учирч байгаа гол зөрчлийн нэг юм. Гуйлгачин сэтгэлгээнээсээ татгалзаж, харилцан ашигтай хамтын ажиллагаанд бүрэн шилжиж байж "гуравдагч хөрш"-ийн бодлого тодорхой үр дүн өгөх болно.” гэсэн судлаачдын зөвлөмжийг анхаарах хэрэгтэй юм. НҮБ, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, Ази-Европын дээд хэмжээний уулзалт, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын тавцанд Монгол-Энэтхэгийн стратегийн түншлэлийн харилцаа өмнөх шигээ бат бэх хэвээр байх болно. Хэрэв Хятад, Энэтхэгийн харилцаа муудвал Монгол шинэ сорилттой тулгарах болно. Гэсэн хэдий ч Монгол Улсын стратегийн түншлэл оюун санааны хүрээнд улам эрчимжих боломжтой.

Хоёрт. АНУ, ОХУ-ын харилцааны сөрөг сценар:

1. *Дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл эрчимжих.*

Оросын зүгээс Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөтгөх магадлалтай. ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд БНЭУ идэвхтэй оролцоно. ОХУ ба АНУ-ын хоорондын зэвсэгт мөргөлдөөн үүсэх тулгаралт бага магадлалтай ч өнөөгийн Украйны эсрэг Оросын цэргийн тусгай ажиллагаа, Барууныхны Украйнд үзүүлж буй дайныг өдөөсөн зэвсгийн тусламж байдлыг бүр хурцатгах болно. АНУ болон Хятадын хооронд Өмнөд Хятадын тэнгист зэвсэгт мөргөлдөөн гарна гэсэн зарим судлаачдын таамаглал байгаа бөгөөд АНУ-ын Тайваньд явуулж буй бодлого, Хятадын Тайваны эсрэг шаардлагатай бол зэвсэгт хүчнээ хэрэглэхээ илэрхийлсэн байдал цаашид гүнзгийрэн үргэлжилбэл Орос, Хятад хоёрыг улам нэгдэн нягтрахад хүргэнэ. Ийм тохиолдолд Монгол Улсад АНУ-ын зүгээс Оросын эсрэг хориг, хязгаарлалтын ажиллагаанд нэгдэх талаар шахалт үзүүлэх, манайд үзүүлж буй дэмжлэгээ зогсоох дарамт ирэх магадлал өндөр байх болно. БНЭУ Өрнөдийн орнууд, тэр дундаа АНУ-ын байр суурийг үл харгалзан Зүүн Өмнөд Азид болон Төв Азид чиглэсэн ашиг сонирхол, нөлөөгөө бэхжүүлэх эрмэлзлээр Оростой харилцаагаа, ялангуяа батлан хамгаалах, эрчим хүчний салбарт сайн байлгах алхмуудыг хийх болно. Монгол Улстай тогтоосон стратегийн түншлэлийн харилцаагаа энэ бүс нутагт бэхжүүлэх болно.

Хоёр. АНУ, Хятадын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол болон Энэтхэгийн харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн Шинэтгэл-зарим талаар хоршсон, зарим талаар өрсөлдсөн-санал нийлэлтийн сценар 1 болон Хөдөлгөөнгүй, зогсонги байдлын сценар 2:

Эдгээр сценарын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт: нэгд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулж, хоёр хөршийг төдийгүй Ази, Европыг холбох гүүр болох боломж, хоёрт,. Хятад улсын зүгээс өр зээлийн дарамтад орж болзошгүй байх эрсдэл гэсэн хоёр зам хүлээж байна.

Монгол улсын боломжийн хувьд БНХАУ-ын Тяньжинь, ОХУ-ын Владивостокийн боомтоор дамжин далайд гарцтай болох буюу түүхий эдийг гуравдагч зах зээлд гаргах нөхцөл бүрдэх бөгөөд “гуравдагч хөрш” БНЭУ–тай Зүүн зүгт хэрэгжүүлэх бодлогынх хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж байна. Энэ зүгт хэрэгжүүлэх идэвхтэй үйл ажиллагаанд оролцох нь Зүүн хойд болон Төв Азийн бүс нутагт Хятадын нөлөөний хүрээг тогтоон барьж, өр зээлийн дарамтад орох эрсдэлийг бууруулахад тустай байх болно.

Хоёрт. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хурцадмал байдал ба сөргөлдөөн хүчтэй болох сценар:

1. 3.2 дугаар зүйлд авч үзсэн АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын хамгийн муу хувилбар Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх асуудлаас болж АНУ ба Хятадын хооронд хурцадмал байдал эрс нэмэгдэж, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн тохиолдолд:

- Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа үргэлжилж, НҮБ АНУ ба Хятадын хоорондын зэвсэгт мөргөлдөөнд Хятадыг буруутгасан байр суурь илэрхийлж, асуудлыг Хятадын талаас буулт хийж яриа хэлэлцээрээр шийдвэрлэхийг уриалж, Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжвэл өмнөд хөршийнхөө зүгээс ноцтой дарамт шахалтад өртөх ба эс дэмжвэл БНХАУ-тай

байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх боломж үлдэнэ. Монгол Улсын БНЭУ-тай хамтран ажиллах асуудал Энэтхэгийн зүгээс зэвсэгт мөргөлдөөний талаар баримтлах байр сууринаас шалтгаална. Энэтхэгийн зүгээс Хятадтай аливаа зэвсэгт мөргөлдөөнд орохоос аль болох зайлсхийдэг байр суурь болон ШХАБ, БРИКС-ын гишүүнчлэл Монгол Ултай ижил байр суурь баримтлах магадлалыг нэмэгдүүлж байна.

Харин НҮБ хоёр талыг хурцадмал байдал, зэвсэгт мөргөлдөөнөө яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг чиглэл болгосон тохиолдолд Монгол Улс НҮБ-ын шийдвэрийг дэмжинэ. Энэтхэг улс ч дэмжих магадлал өндөр байна. Энэ тохиолдолд БНЭУ-тай тогтоосон стратегийн түншлэл, түүний хүрээнд төлөвлөсөн төсөл, хөтөлбөр хэвийн хэрэгжих боломжтой байх болно.

- Орос АНУ-тай түр холбоотны харилцаа тогтоох тохиолдолд Орос, Хятадын хоорондын харилцаа хурцдах ба Монгол Улс НҮБ-ын байр суурь ямар байхаас хамаарахгүйгээр тэдгээртэй байгуулсан стратегийн баримт бичгийнхээ заалтын дагуу зэвсэгт мөргөлдөөнийг зөвтгөхгүй, аль нэгийг нь дэмжихгүй төвийг сахисан байр суурь илэрхийлнэ. Энэ тохиолдолд БНЭУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүд хэвийн үргэлжлэх магадлалтай байх болно.

2. АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын АНУ, Хятад хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэхгүйгээр худалдааны дайн улам гүнзгийрч, удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Монгол Улс аюулгүй байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, бүрэн эрхт байдлын хувьд том сорилттой нүүр тулгарна.

Худалдааны дайн дэлхийн эдийн засгийг ч бүхэлд нь туйлдуулж, гуравдагч орнууд ч хохирох учир манай улс болон БНЭУ-ын эдийн засгийн хөгжилд ч эрсдэл бий болно. Ийм нөхцөл үүсэхэд манай улсын хувьд стратегийн түншлэлийн гэрээний дагуу ОХУ, БНХАУ болон БНЭУ-тай тогтоосон нягт хамтын ажиллагаа худалдааны дайнаас ирэх геополитикийн дарамт, шахалтыг даван туулах гол стратеги байх болно. БНЭУ-ын худалдааны дайнаас хүлээх эрсдэлээс шалтгаалан түүний зүгээс үзүүлэх зарим дэмжлэг, тусламж багасах магадлалтай.

Энэтхэг, ОХУ-ын хоорондын хамтын ажиллагаа улам өргөжих боломжтой, харин Энэтхэг, БНХАУ хоёр харилцаа, хамтын ажиллагаагаа "стратегийн болон хамтын ажиллагааны түншлэл рүү чиглүүлэн хөгжүүлэх болно" гэж тодорхойлж байсан боловч Энэтхэгийн цөмийн зэвсэгтэй улсын статус, өсөж байгаа эдийн засаг, Энэтхэг-АНУ-ын харилцаанд гарч байгаа өөрчлөлтүүд, Пакистаны асуудал, Өмнөд Хятадын тэнгис дэх усан хилийн маргаан зэрэг асуудлууд нь хоёр улсын хооронд стратегийн харилцаа тогтооход сөргөөр нөлөөлсөөр байсан байдал хэвээр үргэлжлэх магадлалтай.

Гурав. ОХУ ба Хятад улсын харилцааны хэтийн төлөв

Нэгд. ОХУ ба Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны сценар.

1. Монгол Улсад Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хоёр хөршийн болон “гуравдагч хөри” БНЭУ-ын талаар ухаалаг бодлого баримталбал аюулгүй байдлын хэтийн төлөв ихээхэн эерэг төсөөлөлтэй байна.

Хятадын “Нэг бүс ба нэг зам” стратегийн хүрээнд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорыг төлөвлөлтийн дагуу хөгжүүлэх боломж байна. “Нэг бүс ба нэг зам”

стратегийн хүрээнд БНЭУ-ын зүгээс манай улстай хамтран ажиллахад чиглэсэн бодлого явуулах боломж хязгаарлагдмал байх магадлал өндөр байна. Ийм төлөвтэй байх шалтгаан нь *нэг талаас*, Хятадын санаачилсан "Бүс ба Зам санаачилга" нь ил тод болон тогтвортой байдлын зөрчилтэй учир дэмжих боломжгүй гэж Энэтхэгийн тал үзэж Хятадын бүс ба зам санаачилгад ордоггүй бөгөөд дэмждэггүй. Түүгээр ч зогсохгүй Хятад зөөлөн хүчний бодлогоо эдийн засгийн хөшүүргээр зүтгүүлж байна гэж үздэг үзэл санаа нь үргэлжилнэ гэдэгт, *нөгөө талаас* Энэтхэг Австрали, Япон, АНУ-тай шинээр байгуулагдсан аюулгүй байдлын Чөлөөт ба Нээлттэй Энэтхэг - Номхон далай зохицуулалтад нэгдсэн явдалд Хятадын зүгээс таагүй хандаж байгаа явдалд орших болно.

Харин манай улс Энэтхэг улстай түүний Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо (АСЕАН)-ын орнуудтай түншлэлийн харилцаагаа нэмэгдүүлэх зорилгоор дэвшүүлсэн Зүүний талаар баримтлах бодлогын хүрээнд болон хоёр талын бусад хамтын ажиллагаагаар үргэлжлүүлэх боломж байна. Ийм боломж байгааг энэтхэгийн гадаад бодлогын мэргэжилтнүүд Монголыг өөрийн орны гадаад бодлогын чухал улсуудын нэг гэж *нэгд*, хоёр том хөршөөс гадна нөлөө бүхий орнуудтай харилцаа холбоогоо бэхжүүлэх, *хоёрт*, Хятадаас эдийн засгийн хараат байдлыг багасгах гэсэн Монгол Улсын гадаад бодлогын зорилтуудад үндэслэн дүгнэснээс харж болно..

Тиймээс Монголын зүгээс БНЭУ-ыг ОХУ, БНХАУ-ын монгол дахь ашиг сонирхлын тэнцвэрийг бий болгох "гуравдагч хөрш"-ийн хүрээнд авч үзэж харилцаагаа бэхжүүлэх нь зөв юм.

БНЭУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд тэдний бусдын зөөлөн хүчний бодлогоос болгоомжилдог туршлагаас суралцах хэрэгтэй юм. Тухайлбал, Энэтхэг БНХАУ-ыг улс төр, эдийн засаг, цэрэг зэвсэг зэрэг олон салбарт хүчтэй улс гэж үнэлэхийн сацуу "зөөлөн жанжлах" (soft hegemony) бодлогоос нь болгоомжилж байна. Үүний нэг тод жишээ нь Хятад улс Шри Ланкад усан боомт түрээслэн авсан явдал юм. Хэдийгээр энэхүү боомтыг түрээслэн авсан ч ашиглахгүй нэлээд хугацаа өнгөрч байгаа нь цаашдаа цэргийн зорилгоор ашиглах вий гэж Энэтхэгийн тал болгоомжилж байна. Учир нь Шри Ланкийн боомт байршлын хувьд яг далайн тээврийн зам дээр оршдог.

Монгол Улсын хувьд Хятадын зөөлөн хүчний бодлого, эдийн засгийн хэт хамаарлаас болгоомжилж байхад Энэтхэг улс хилийн маргааныг хурцатгахгүй байх асуудлыг гол болгож байна.

Хоёрт. ОХУ ба Хятад хоорондын зөрчилдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болзошгүй сценар:

1. Хоёр хөршийн аль аль талаас нь өөрийн талд орохыг шаардсан хүнд дарамт, шахалт ирэх.

Монгол Улс сөргөлдөгч хоёр талын аль нэгнийх нь талд татагдан орох аюул занал тулгарна. Ийм сценарын үед хоёр зам байна. *Нэгд*, төвийг сахих. Гэхдээ ийм оролдлого хийх нь хөрш хоёр гүрний зүгээс дэмжлэг авахгүй байх магадлал өндөр байх болно. *Хоёрт*, хоёр хөршийн хэн нэгний нь холбоотон болох.

Монгол Улсын ОХУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн баримт бичигт "Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх ашигт харшилсан ямарваа нэгэн гэрээг гуравдагч улстай байгуулахгүй болон нөгөө талын эсрэг чиглэсэн аливаа үйлдэлд оролцох, эсхүл ийм төрлийн үйлдлийг дэмжихээс түдгэлзэнэ. Аль ч тал өөрийн нутаг дэвсгэрээ нөгөө талын эсрэг түрэмгийлэл буюу аливаа хүчирхийлэл үйлдэх зорилгоор

гуравдагч улсад ашиглуулахгүй, гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг Оросын холбооны улс хүндэтгэнэ." хэмээн зааж өгсөн бол БНХАУ-тай "Талууд нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй, аливаа гэрээ байгуулахгүй, аливаа эвсэл, бүлэглэлд нэгдэхгүй, тэдгээрийн нөгөө улсын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанд оролцохгүй, нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулах үйл ажиллагаа өөрийн улсын нутаг дэвсгэрт явуулахыг аль нэг гуравдагч улс, байгууллага, бүлэглэлд зөвшөөрөхгүй байхыг онцлон тэмдэглэсэн байна. Ийм заалтууд тухайн сценар үүссэн тохиолдолд хоёр хөршөөс төвийг сахисан байр суурь баримтлахад дэмжлэг хүсэх үндэс болно.

Түүнчлэн манай улс “гуравдагч хөрш”-үүдээс, түүнчлэн БНЭУ-аас болон НҮБ-аас улс төрийн дэмжлэг хүсэх болно.

Төвийг сахих оролдлого бүтэлгүй болсон тохиолдолд Р.Болдын дэвшүүлсэн Дорнынхон ОХУ-ыг аюул заналхийлэл гэж нэг их үздэггүй логигоос харвал Монгол нь ОХУ-тай цэргийн холбоотны харилцааг сэргээх магадлал байж болох талтай гэсэн таамаглал хэрэгжих магадлал өндөртэй байх болно.

НОМЗҮЙ

1. Narayani Basu, *Mondi in Mongolia: Cultural Crossroads in the Far East*, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>
2. Narayani Basu, *Mondi in Mongolia: Cultural Crossroads in the Far East*, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>
3. Patrick Mendis, *Mongolia is seeking greener pastures with the US and India to balance China's influence*, South China Morning Post, 2019.11.17, <https://www.scmp.com/comment/opinion/article/3037785/mongolia-seeking-greener-pastures-us-and-india-balance-chinas>
4. James Crabtree, *Mongolia needs allies to withstand China's looming threat*, 2019.10.09, <https://asia.nikkei.com/Opinion/Mongolia-needs-allies-to-withstand-China-s-looming-threat>
5. Taylan Ozgur Kaya, *Sino-Indian Strategic Rivalry in the Indian Ocean Region*. The Journal of Humanity and Society. 2017. p. 158
6. Prabir De, Sreya Pan, *India-Mongolia Economic Relations: Current Status and Future Prospect*, The Northeast Asian Economic Review, Vol 5, No.2, 2017
7. Х.Батсайхан, *Энэтхэгийн гадаад бодлогын шатрын хөлөг дээрх Монгол*, 2019.10.10, <http://eagle.mn/r/63798>
8. Монгол дахь Энэтхэгийн элчин сайдын яам. <https://eoi.gov.in/ulaanbaaiar/7pdf43467000>
9. Balaji Chandramohan, *India and Mongolia: Uranium and Beyond*, Future Directions International, 2015, <http://www.futuredirections.org.au/publication/india-and-mongolia-uranium-and-beyond/>

10. Prabir De, Sreya Pan, India-Mongolia Economic Relations: Current Status and Future Prospect, The Northeast Asian Economic Review, Vol 5, No.2, 2017
11. Remarks by Charge d'affaires a.i. Manuel P. Micaller at the AmCham Annual General Meeting Regarding the Indo-Pacific Strategy and Mongolia, <https://mn.usembassy.gov/2018-amcham-agm-cda-remarks/>
12. Ankit Panda, India offers Defense Assistance to Mongolia, 2014.12.23, <https://thediplomat.com/2014/12/india-offers-defense-assistance-to-mongolia/>
13. 'India-Mongolia cooperation signals to Beijing that India can play the geopolitical game in China's backyard'. The Times of India, 2017.07.24, <https://timesofindia.indiatimes.com/blogs/the-interviews-blog/india-mongolia-cooperation-signals-to-beijing-that-india-can-play-the-geopolitical-game-in-chinas-backyard/>
14. 'India-Mongolia cooperation signals to Beijing that India can play the geopolitical game in China's backyard', The Times of India, 2017.07.24, <https://timesofindia.indiatimes.com/blogs/the-interviews-blog/india-mongolia-cooperation-signals-to-bcijing-that-india-can-play-the-geopolitical-game-in-chinas-backyard/>
15. Ankit Panda, India Prime Minister Narendra Modi s tour of East Asia, 2015.05.20, <https://thediplomat.com/2015/05/india-acts-east-understanding-modis-tour-of-china-mongolia-and-south-korea/>
16. Владислав Гулевич, Монгольско-индийское сотрудничество с оглядкой на Китай, 2018.01.02, <https://interaffairs.ru/news/show/19095>
17. Narayani Basu. Modi in Mongolia: Cultural Crossroads in the Far East, the Diplomat, 2015.05.16, <https://thediplomat.com/2015/05/modi-in-mongolia-cultural-crossroads-in-the-far-east/>
18. Далай лам, Ванчин богдын талаар илуу судлах хэрэгтэй, 2015.09.15, <https://news.mn/r/222261/>
19. P.Stobdan, India and Mongolia: Modi on Ashoka's Path, https://idsa.in/idsacomments/IndiaandMongolia_pstobdan_130515
20. Монгол Улсын гадаад харилцааны яамны мэдээлэл, 2020 оны 1 сар
21. Монгол Улсын гадаад бодлогын хөх ном, УБ, 2018
22. Монгол-Энэтхэгийн Стратегийн түншлэлийг улам бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл, Гадаад харилцааны яам, 2019.09.20 <http://www.mfa.gov.mn/?p=52581>
23. Монгол дахь Энэтхэгийн элчин сайдын яам, <https://eoi.gov.in/ulaanbaatar/?pdf4346?000>
24. XX зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд, УБ, 2017
25. The Modi Doctrine: New Paradigm in India's Foreign Policy, New Delhi, 2016.

3.6 Монгол, БНТУ-ын түншлэлийн харилцаа, болзошгүй хэтийн төлөв

3.6.1 Харилцааны түүхэн болон өнөөгийн байдал

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүн улс болсноор манай гадаад харилцаанд нэг шинэ үе эхлэхийн зэрэгцээ гадаад бодлогын агуулга, цар хүрээ тэлж, дипломат алба идэвхжиж, бүтэц, зохион байгуулалт боловсронгуй болж, боловсон хүчний хувьд цаашид бэхэжсэн юм. Иймээс Монгол Улс нь 1969 онд Турктэй дипломат харилцаа тогтоосноор хоёр улсын орчин үеийн харилцааны эхлэл тавигдсан байдаг ч 1990 он хүртэл харилцаа төдийлөн идэвхтэй байгаагүй.

1990-ээд оноос хагас зуун жил үргэлжилсэн “хүйтэн дайн” дуусгавар болж Монгол Улсын гадаад орчин өөрчлөгдсөн төдийгүй дотоод орчин ч асар их өөрчлөгдсөн. Ингэж Монгол Улс энэ үеэс улс төрийн тогтолцоог ардчилах, зах зээлийн эдийн засагт шилжих ардчиллын замыг сонгосон бие даасан гадаад бодлогоо хэрэгжүүлж эхэлсэн юм. Улмаар 1992 онд Монгол Улс шинэ үндсэн хуулиа баталж ардчилал, зах зээлийн эдийн засгийн хөгжлийн замд эргэлт буцалтгүй орсон билээ. Шинэ үндсэн хуульд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” хэмээн гадаад бодлогын үндсийг тодорхойлсон бол 1994 оны Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна” гэж зааж өгсөн. Энэ үеэс манай улсын гадаад бодлого нээлттэй, бие даасан, олон тулгуурт шинжтэй болсон бөгөөд хоёр хөрштэйгөө сайн хөршийн харилцааг шинэ нөхцөлд өргөтгөн гүнзгийрүүлэх, мөн өндөр хөгжилтэй орнуудын бодит сонирхлыг Монголд бий болгох, тэдэнтэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, олон улсын тавцанд дуу хоолойгоо сонсгож, байр сууриа бэхжүүлэхэд чиглэсэн идэвхтэй гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ.

Турк улсын хувьд ардчилсан өөрчлөлтийн жилүүдэд Төв Азийн бүгд найрамдах улсууд болон бус нутгийн бусад улс орнуудтай харилцаагаа хөгжүүлэхэд чиглэсэн гадаад бодлогын хүрээнд 1990-ээд оноос эхлэн Монгол улстай улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын салбарт харилцаа хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлсэн юм.

Туркийн Засгийн газрын урилгаар Монгол Улсын Гадаад харилцааны сайдын 1992 онд Турк улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”, “Худалдаа эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Дипломат болон албан паспорттай иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр” тус тус байгуулж цаашид нэн шаардлагатай хэлэлцээр, протоколуудын талаарх тохиролцоонд хүрсэн нь манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх хууль, эрх зүйн гол үндэс суурийг тавьсан.

Улмаар БНТУ-ын Ерөнхийлөгч Сулейман Демирелийн 1995 оны Монгол улс дахь албан ёсны айлчлалын үеэр “Монгол улс, БНТУ хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан нь хоёр улсын цаашдын харилцааны үндэс болсон юм.

Тус гэрээнд “Монгол улс, Бүгд Найрамдах Турк улс нь бие биенийхээ тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш шударга, харилцан ашигтай байх зэрэг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудын үндсэн дээр харилцаагаа хөгжүүлнэ”³¹⁷ гэсэн байдаг. Ийнхүү БНТУ 1996 онд Монголд, Монгол улс 1997 онд БНТУ-д тус тус ЭСЯ нээснээр харилцаа улам гүнзгийрсэн юм.

³¹⁷ www.mfa.gov.mn

Манай улс 2007 онд ЮНЕСКО-гийн Гүйцэтгэх товчоонд, 2009 онд НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд сонгогдоход Турк улс дэмжсэн. 2008 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын бус гишүүний сонгуульд Туркийг дэмжсэн. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын бус гишүүний 2015-2016 оны сонгуульд Монгол Туркийг, 2023-2024 оны сонгуульд Турк Монголыг харилцан дэмжих тохиролцоог хоёр тал 2012 онд байгуулсан. Хоёр улсын харилцаа олон улсын тавцанд ч бие биеэ дэмжиж ирэв.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрэн дэх Стратегийн түншлэл

1990-ээд оны үеэс гадаад бодлогыг идэвхжүүлэхэд чиглэсэн Монголийн ардчилал, хөгжлийг тууштай дэмжигч, дорвитой хандивлагч улс орнуудыг тодотгосон "гуравдагч хөрш"-ийн тухай шинэ ойлголт ч гарч ирсэн байдаг. Энэхүү гадаад бодлогын нэгэн шинэ хандлага нь бодит байдлаар хөгжих явцдаа газар зүйн бус, улс төр, эдийн засаг, гадаад бодлогын хүрээнд өөрийн улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангахад болон ардчиллын үнэт зүйлсийг нэвтрүүлэхэд дэмжлэг авах өрнө, дорнын нөлөө бүхий улс оронтой хамтын ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлэхэд чиглэж хэрэгжиж ирсэн байдаг.

Иймээс ч 2011 онд шинэчлэн баталсан гадаад бодлогын үзэл баримтлалд “АНУ, Япон, Европын холбоо. Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж зааж өгсөн байна. Ийнхүү манай улс Монгол-Туркийн харилцаанд өндөр ач холбогдол өгч хөгжүүлэхдээ:

- Монгол, Турк нь эртний харилцаа холбоотой, өв, соёлын хамааралтай;
- Манай улсыг ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явцыг эхнээс нь дэмжиж, улс төр, эдийн засаг, техникийн тусламж үзүүлж ирсэн;
- Эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд 17-д ордог бөгөөд 2023 он гэхэд эхний 10-т орох зорилт тавьж буй Турк улстай эдийн засаг болон бусад салбарт хамтран ажиллах нь манай үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой;
- Манай улс Туркээр дамжин Европ, Америк, Африк хүрэх агаарын замын гуравдагч гарцыг нээж ашиглаж эхэлсэн, цаашдаа төмөр замын гарцтай болох боломжтой;
- Турк улс нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, НАТО, ШХАБ, ЕАБХАБ-ын хүрээнд манай үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, гадаад таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой;
- Суулийн жилүүдэд манай иргэд Туркт олноор зорчин, ажиллаж, суралцах болсон зэрэг хүчин зүйлсэд тулгуурлан БНТУ-тай гуравдагч хөршийн хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх шаардлага гарч ирж байгаа билээ.

БНТУ-ын Ерөнхийлөгч Р.Т.Эрдоганы 2013 онд Ерөнхий сайд байхдаа Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хоёр улсын Ерөнхий сайд нарын хамтарсан мэдэгдэлд “Хоёр тал Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 онд БНТУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хамтарсан мэдэгдэлд дэвшүүлсэн "Иж бүрэн түншлэлийн харилцаа" нь тодорхой зорилго, зарчмын хүрээнд амжилттай хэрэгжиж буйд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд цаашид харилцааны түвшинг ахиулж “стратегийн түншлэл”-д хүргэх хэтийн зорилготой байгааг талууд санал нэгтэй тэмдэглэсэн” нь манай улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг улам бататгаж өгсөн билээ. Иймээс хоёр улсын харилцааны өнөөгийн байдлыг дэлгэрэнгүй авч үзэж дүн шинжилгээ хийх нь чухал юм.

Улс төрийн харилцаа

Сүүлийн жилүүдэд хоёр улсын хооронд өндөр, дээд хэмжээний айлчлалуудын тоо нэмэгдэж байгаа бөгөөд тэдгээрээс Монгол Улсын Их хурлын даргын 2013, 2018 онд БНТУ-д хийсэн айлчлал, БНТУ-ын Үндэсний Их хурлын даргын 2014, 2019 онд МУ-д хийсэн айлчлал, БНТУ-ын Ерөнхий сайдын 2018 онд Монгол улсад хийсэн албан ёсны айлчлал зэрэг нь хоёр улсын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Тухайлбал, 2018 оны Монгол Улсын Их хурлын даргын айлчлалын үеэр Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсан бол тухайн оны Бүгд Найрамдах Турк улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр талууд хөдөө аж ахуй, тээвэр, харилцаа, онцгой байдлын салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан нь Монгол, Туркийн дээд, өндөр түвшний улс төрийн харилцан ойлголцлыг бэхжүүлэх, хоёр талын хууль тогтоох дээд байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдаа, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх ач холбогдолтой болсон.

Харин БНТУ-ын Үндэсний Их хурлын даргын 2019 онд Монгол Улсад хийсэн айлчлал нь дээд, өндөр түвшний яриа хэлэлцээний давтамжийг хадгалах, хөдөө аж ахуй, арьс, ширний үйлдвэрлэлийн чиглэлээр Туркийн технологи нэвтрүүлэх, бүтээгдэхүүнийг Турк болон гуравдагч орнуудын зах зээлд нийлүүлэх, боловсон хүчин сургах, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг хамтын ажиллагааны бодит хэрэгжилтийг урагшлуулсан бөгөөд ойрын үед хоёр улсын тэргүүн нарын айлчлалыг зохион байгуулж хоёр улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтыг дэвшүүлэх нь зүйтэй юм.

Батлан хамгаалах, аюулгүй байдлын хүрээнд олон улсын аюулгүй байдлын тулгамдсан асуудлаар манай хоёр улс эв эеийг сахисан энх тайванч хандлагыг баримталж ирсэн. Улмаар хоёр улс аюулгүй байдлын салбарт, түүний дотор цэрэг, хууль сахиулах, төрийн удирдлагын салбарт бүрэн харилцан ойлголцсон. идэвхтэй хамтын ажиллагаа, солилцоог хөгжүүлсээр байна. Хоёр орны батлан хамгаалах салбар дахь айлчлал 2000 оноос эхлэн эрчимтэй хөгжин Турк улс 2003 оноос жил бүр 300 мянган ам.долларын цэргийн салбарын тусламж үзүүлж байсан. 2011 онд Турк улсад хийсэн Батлан хамгаалахын сайдын айлчлалын үеэр хоёр улсын засгийн газрын хоорондын цэргийн салбарын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж тусламжийн хэмжээг 1 сая орчим лирад хүргэхээр болсон байдаг. Манай улс нь Туркийн цэргийн сургуульд болон богино хугацааны цэргийн сургалт, энхийг сахиулах хүчний сургалтад тогтмол хамрагддаг.

Манай Улс “гуравдагч хөршийн бодлогын хүрээнд аюулгүй байдлын асуудлыг чухалчлан авч үзэхдээ улс төдийгүй олон улсын байгууллагуудыг ч нэр заан оруулсан байдаг.

НҮБ, НАТО. ШХАБ. ЕАБХАБ гэсэн олон улсын байгууллагын хүрээнд хоёр улсын харилцааг улам хөгжүүлж стратегийн түвшний хамтын ажиллагаа өрнүүлэх бүрэн боломжтой юм. Тодруулбал, Монгол, Турк хоёул НҮБ болон ЕАБХАБ-ын бүрэн эрхт гишүүн улсууд, Турк НАТО-ийн гишүүн бол Монгол Улс тус эвслийн “дэлхий даяарын түнш”-ийн статустай, түүнчлэн ШХАБ-д Монгол Улс ажиглагчаар оролцдог бол Турк тус байгууллагын "яриа хэлэлцээний түнш"-ийн статустай юм. Эдгээр байгууллагын хүрээнд юуны түрүүнд ОХУ, БНХАУ болон АНУ болоод бүс нутгийн олон улс оронтой улс төр, эдийн засгийн аюулгүй байдлын голлох асуудлуудаар хоёр улс санал солилцож, байр сууриа харилцан танин мэдэж, уялдуулж байх нь стратегийн түншлэлийн харилцааны

нэгэн шалгуур үзүүлэлт болох юм.

Эдийн засгийн харилцаа

Монгол Улс нь “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг идэвхжүүлэн өргөжүүлж стратегийн түншлэлд хүрэхийг зорьж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк улсын Засгийн газар хоорондын Хөгжлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг 2016 онд шинэчлэн байгуулсан байдаг.

Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Туркийн талын харилцагч байгууллагууд нь БНТУ-ын Эдийн засгийн яам, БНТУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ, БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг зэрэг юм.

Мөн хөгжлийн хамтын ажиллагааны механизм болох эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хороо 2018 оны наймдугаар хуралдаанаараа цаашдын хамтын ажиллагааны чиглэл, хоёр орны эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааны нөөц бололцоог бүрэн ашиглах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар санал солилцож холбогдох протоколыг байгуулсны үр дүнд мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах салбарт Туркийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, экспортын чиг баримжаатай хамтарсан компани байгуулах асуудлыг судлах, чөлөөт бүсийн чиглэлээр мэргэжилтэн сургах, туршлага судлах зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, протоколд заасны дагуу манай чөлөөт худалдааны хэлэлцээ хийх багийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор Гадаад харилцааны яамнаас Бүгд Найрамдах Турк улсын Эдийн засгийн яамтай хамтран 2018 ондоо “Чөлөөт худалдааны хэлэлцээр ба Туркийн чөлөөт худалдааны хэлэлцээр, Турк-Европын Холбооны гаалийн байгууллага” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулсан. Монгол-Туркийн Бизнесийн зөвлөл ч хоёр орны ажил хэрэгч хүмүүсийг холбох, хөрөнгө оруулалтыг Монголд оруулах зэрэг зохих хэмжээний дэмжлэг туслалцаа үзүүлсээр байгаа юм.

Худалдаа, хөрөнгө оруулалт

Хоёр улсын эдийн засгийн харилцааны хамгийн чухал хэсэг худалдааны салбарт ахиц гарч худалдааны бүтээгдэхүүний нийт эргэлтийн хэмжээ 2018 онд хамгийн өндөр түвшин буюу 44 сая ам.доллар, 2019 онд 43,1 сая ам.долларт хүрсэн ч Туркийн экспортын хэмжээ 40,6 сая ам.доллар буюу 94 орчим хувийг эзэлж байна³¹⁸. Туркээс чихэр, гурилан бүтээгдэхүүн, гутал хувцас, савхин болон нэхий эдлэл, ахуйн цахилгаан хэрэгсэл, бүрэн шаталттай зуух, насос, мебель тавилга, гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж зэрэг зүйлсийг импортоор оруулж ирэхийн зэрэгцээ манай иргэд Туркээс гаальд бүртгэлгүйгээр нилээд хэмжээний бараа, бүтээгдэхүүн “Ганзагын наймаа” хэлбэрээр зөөвөрлөдөг учир худалдааны хэмжээний бодит үзүүлэлтийг бууруулдаг байна. Ийнхүү Турк Улс нь манай улсын нийт гадаад худалдааны 0.31 хувийг эзэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Сүүлийн жилүүдэд Туркийн компаниудын Монголд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт 20 сая ам. долларын хөрөнгө оруулалттай ус цэвэрлэх байгууламжийг Туркийн компани барьж байгаа бол Туркийн “Аусайпер” компани Чойрт салхин цахилгаан станц барихад 95 сая.ам.долларын хөрөнгө оруулах бөгөөд энэхүү станц барих ажил хэрэгжээд явж байна.

³¹⁸ МУ-ын ГХЯ. Монгол Улсын гадаад бодлогын хөх ном (B1 Bluebook). УБ.. 2019.

Мөн Баян-өлгий аймгийн Ховд гол дээр 90 мвт хүчин чадалтай усан цахилгаан станц барих ажлыг Туркийн компани гүйцэтгэж эхлэхэд бэлэн болоод байна.

Тээвэр

“Туркиш Эйрлайнс” компани 2012 оноос Истанбул-Бишкек- Улаанбаатарын хооронд, 2020 оны оноос Истанбул-Улаанбаатар хоорондын шууд нислэг үйлдэх болсон нь хоёр орны хооронд бизнес, аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэд харилцан зорчих явдалд ихээхэн хувь нэмрээ оруулж байна.

“Туркиш Эйрлайнс” компаний нислэгийн тоо болон зорчигчийн тоог нэмэгдүүлэх, хоёр улсын хооронд том оврын ачаа тээвэрлэлтийн онгоц нисгэх, Истанбул-Улаанбаатар-Сөүл чиглэлд агаарын ачаа тээврийн зам нээх зэрэг нь манай хоёр улсын худалдааг нэмэгдүүлдэг зогсохгүй Европ, Азийг холбосон агаарын ачаа тээврийн төв болох боломжтой юм. Мөн “Нэг бус, нэг зам” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Туркийн санаачилсан Хятад-Төв Ази-Европыг холбосон төмөр замын төслүүд, ялангуяа дунд коридор төслийн хэрэгжилт нь манай улс ч түүнд нэгдэх нөхцөлийг бий болгож байгаа юм.

Туркийн тал хоёр улсын худалдааны хэмжээг өргөтгөх сонирхол их байгааг харгалзан цаашид худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл; хот суурин газрын хөгжлийн төлөвлөлт; ус, ус цэвэрлэх байгууламж, ойжуулалт; жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил; дэд бүтэц; эрчим хүч; тээвэр; боловсрол, соёл, шинжлэх ухаан. аялал жуулчлал; эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн идэвхтэй хөгжүүлж ажиллах нь чухал юм.

Буцалтгүй тусламж:

БНТУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт Туркийн олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ТИКА)-ийн үйл ажиллагааны хүрээнд 40 гаруй сая ам. долларын буцалтгүй тусламж олгоод байна. ТИКА нь Монголд төсөл хөтөлбөрөө 1994 оноос “Соёлын өв”-ийг хойч үедээ уламжлуулах зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Хашаат суманд хэрэгжүүлсэн Монгол нутаг дахь Түрэгийн үеийн хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах төслийн хүрээнд хийгдсэн археологийн малтлага, судалгаа хийх, Хөшөө цайдам музейг барьж байгуулах, Билгэ хааны автозам барих зэрэг ажлуудаар хэрэгжүүлж ирсэн.³¹⁹ 2004 онд Улаанбаатар дахь ТИКА-гийн хөтөлбөр зохицуулалтын суурин төлөөлөгчийн газар байгуулагдсан бөгөөд одоог хүртэл олон салбарт төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлж байна. Тухайлбал, Хархорин-Хөшөө цайдмын 46 км авто зам барих; Түрэгийн хөшөө дурсгалыг сэргээн хамгаалах; Орхоны хөндийд Дэлхийн соёлын өвийн музей байгуулах; Улсын клиникийн төв эмнэлгийн дэргэд цусны төв байгуулах; МУИС-д Турк судлалын тэнхим байгуулах; Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим архив төсөл; Монгол, Туркийн найрамдлын цэцэрлэгт хүрээлэн төсөл; бог малыг ээмэгжүүлэх “Хас цахим” төсөл; Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс Эрдэнэзуу хийд хүртэл 2.4 км хатуу хучилттай зам тавих төсөл; ерөнхий боловсролын дунд сургуулиудад сургалтын тоног төхөөрөмж өгөх; Туркийн Засгийн газар хүнсний тусламж зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

Соёл, боловсролын харилцаа

Туркийн Засгийн газар Монголын оюутнуудыг өөрийн зардал болон Туркийн

³¹⁹ ТИКА ile 20 yil /ТИКА-тай 20 жил/ УБ 2014 он.

Засгийн газрын тэтгэлгээр суралцах нөхцөл боломжоор хангаснаар эдүгээ 2500 гаруй иргэн Туркийн их, дээд сургуульд дээд боловсрол эзэмшин эх орныхоо янз бүрийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа билээ. Мөн Туркийн Засгийн газрын тэтгэлгээр жил бүр тус улсын их дээд сургуульд Монголын 50-70 оюутан суралцахаар элсэж байгаа бөгөөд одоогоор Монголын 260 орчим оюутан суралцаж байгаа бол Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дархан, Эрдэнэт хотуудад Монгол-Туркийн хамтарсан ахлах сургуулиуд сургалт хичээлүүдээ Монгол, Турк, Англи хэл дээр явуулдаг бөгөөд төгсөгчид нь гадаадын их, дээд сургуулиудад /АНУ, Турк, Их Британи, ОХУ зэрэг улсуудад/ олноороо үргэлжлүүлэн суралцаж байна.²⁴

Монгол, Туркийн ШУА хоорондын хамтын ажиллагаа олон төрлийн салбарт хөгжиж ирсэн байдаг. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2010 онд Түрэгийн хаант улсын түүх соёлтой холбогдол бүхий хосгүй үнэт эд өлгийн зүйл, олдворыг хадгалж хамгаалах, судлах, сурталчлах үүрэг бүхий Хөшөө Цайдам музей Архангай аймгийн Хашаат сумын нутагт байгуулагдсан. Монгол дахь түрэг, Турк судлал болоод Турк улс дахь монгол судлал ч хөгжиж ирсэн байдаг. БНТУ-ын нийслэл Анкара хот дахь Хажэтэпэ их сургууль дээр Монгол (хэл, соёл) судлалын анхны төв байгуулагдан Монголын түүх, соёлтой холбоотой өв дурсгалыг тодруулах зэрэг ажлуудыг Монголын ЭСЯ-тай хамтран хийж байгаа билээ. Харин Монгол улсын Их сургууль дээр Түрэг судлалын салбар нь бакалаврын түвшний сургалт явуулж байгаагийн зэрэгцээ Түрэг судлалын хүрээлэн мөн үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын харьяа Турк судлалын сектор болон МУИС-ийн ОУХНУС-ийн эрдэмтэн судлаачид Турк судлалыг зохих түвшинд хөгжүүлсээр ирсэн.

Хоёр орны ард түмэн соёлын олон талын үйл ажиллагааг ч идэвхтэй хөгжүүлж ирсэн билээ. Тухайлбал, Орхоны хөндийн Түрэгийн үеийн хөшөө дурсгалуудад археологийн малтлагаа судалгаа хийх, сэргээн засварлах, олдворуудыг хамгаалалтад авах, музейн үзмэр болгох зэрэг чухал ажлуудыг хийхийн зэрэгцээ Анкара болон Улаанбаатар хотын найрсаг харилцаанд тулгуурлан Анкарагийн гудамжийг нээн тохижуулах хүрээнд АтаТуркийн нэрэмжит 5 дугаар сургуулийн өмнө талбайд усан оргилуур, Мэвлана хөшөөг байрлуулах зэрэг ажлуудыг санаачлан хийсээр байгаа билээ. Одоогоор Монгол

²⁴ www.monturk.edu.nm/about-us/ - Монгол-Туркийн хамтарсан ахлах сургуулийн албан ёсны вэб хуудас турк улсын соёлын элчийн үүрэг гүйцэтгэж байгаа Турк улсын иргэн Энвэр Ючел³²⁰ нь Монгол, Туркийн соёлын харилцаа, хамтын ажиллагаа болоод хоёр орны иргэд хоорондын харилцааг хөгжүүлэх. Монгол улсыг дэлхий дахинд идэвхтэй сурталчлан таниулах чиглэлээр хичээнгүйлэн ажиллаж байна. Ийнхүү боловсрол, соёлын салбарт гарч буй дэвшил нь Монгол-Туркийн харилцан ойлголцлыг улам гүнзгийрүүлэн бүх салбарын харилцааг өндөр түвшинд хүргэхэд ихээхэн чухал юм.

БНТУ руу дипломат албан паспорттай иргэд визгүй зорчих хэлэлцээр (1992.05.29), манай улсын энгийн паспорттай иргэд Турк улсад 30 хүртэл хоногоор визгүй зорчих Туркийн засгийн газрын шийдвэр (2007.07.19-ний 12441 дүгээр тогтоол) болон 2014 оны “Иргэд харилцан зорчих тухай Монгол Улсын Засгийн газар, БНТУ Засгийн газар хоорондын хэлэлцээр” гэсэн шат дараалалтай арга хэмжээний үр дүнд сүүлийн жилүүдэд Туркт ажиллаж амьдрах, сурах, ажиллах, худалдаа наймаа хийх, эмчлүүлэх зорилгоор

³²⁰ Энвэр Ючел нь “БНТУ-Глобал Нетворк” олон улсын боловсролын байгууллагын Ерөнхийлөгчийн албыг хашдаг бөгөөд түүний үүсгэн байгуулсан энэхүү боловсролын байгууллагын харьяанд 8 их сургууль, 4 хүрээлэн үйл ажиллагаа эрхэлж, 17 мянган оюутан одоогоор суралцаж байна.

Турк улсыг зорих Монгол иргэдийн тоо нэмэгдсээр байна. Одоогоор 6500 орчим Монголчууд³²¹ Туркт улсад байна.

3.6.2 Харилцааны хэтийн төлөв

Монгол улс, БНТУ хоёр улсын харилцааны хэтийн төлөв дэлхийн дэг журам болон их гүрнүүдийн хоорондын харилцааны өөрчлөлтөөс мөн л хамаарах боловч тэдгээртээ харилцах харилцаагаа дотоод, гадаад хүчин зүйлстэй уялдуулсан харилцан ашиг сонирхлын үндсэн дээр явуулж ирсэн байна.

Тиймээс харилцааны хэтийн төлөвийг Монгол, БНТУ-ын өнөөгийн хоорондын харилцааны болон их гүрнүүдтэй харилцаж буй онцлогийг тооцон, аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйд тулгуурлан 3.1 болон 3.2 дугаар зүйлүүдэд үүсгэсэн их гүрнүүдийн хоорондын харилцааны сценарууд, тэдгээрийн үүсэж болох хувилбарууд, тэдгээрт Монгол Улсын болон “гуравдагч хөрш” БНТУ-ын баримталж болох магадлалт байр сууриар тодорхойллоо.

Нэг. АНУ, ОХУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол ба БНТУ-ын харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ, ОХУ-ын харилцааны эерэг сценар:

1. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, улсуудын тусгаар тогтнолыг бэхжүүлэх, олон улсын байгууллагуудын үүрэг ба бусад улс, үндэстнүүдийн эрх ашгийн үндсэн дээр “Дэлхийн олон туйлт дэг журмыг бататгах”

Ийм сценарын үед ОХУ болон Хятадын байр суурь нэгдмэл байх магадлалтай. Монгол Улс Орос–Монгол–Хятад гэсэн эдийн засгийн коридороо хөгжүүлэх талаар хоёр хөрштэйгөө хамтран ажиллахаас гадна “гуравдагч хөрш”-ийн стратегийн түншлэлийн бодлогоо АНУ болон БНТУ-тай хэвийн үргэлжлүүлэх боломжтой байна. Энэ тохиолдолд эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд 17-д ордог бөгөөд энэ 2023 онд эхний 10-д орох зорилт тавьж эрчимтэй хөгжиж байгаа Турк улстай улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд хамтран ажиллах нь тодорхой үр дүн авчрах болно.

Түүнчлэн БНТУ нь эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, НАТО, ШХАБ, ЕАБХАБ-ын хүрээнд манай үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх гадаад таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой байх болно. Турк нь НАТО-гийн гишүүн, ШХАБ-д “яриа хэлэлцээний түнш” –ийн статустай, ЕАБХАБ-ын бүрэн эрхт гишүүн бол манай улс НАТО-гийн эвслийн “дэлхий даяарын түнш”-ийн статустай, ШХАБ-ын ажиглагч гишүүн, ЕАБХАБ-ын гишүүн байгаа нь ийм боломжийг бүрдүүлэх чухал нөхцөл болж байна.

2. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Хятадын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Ийм хувилбар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд ихээхэн зөрчилтэй нөхцөл байдал үүснэ. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт *нэгд*, АНУ ба Оросын харилцаанаас хамаарахгүйгээр соёл иргэншлийн хувьд Хятадад уусаж устгах аюул заналын эрсдэл, хоёрт, хоёр хөршийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй дарамт, шахалтууд илрэх болно.

³²¹ МУ-ын ГХЯ. Монгол Улсын гадаад бодлогын хөх ном (Diplomatic Bluebook). УБ., 2019.

Эртний хятадын ойлголтоор “хүмүүний ямар угсаатай, эсвэл хаана төрсөн зэрэг нь гол бус, харин уул хүмүүн хятад соёлыг хэр зэрэг өөртөө шингээж авсан гэдэг нь шийдвэрлэх зүйл юм. Хэн нэг харь хүмүүн хятадын соёл иргэншлийг хүлээн авч, өөрийн болгож, түүний дагуу амьдарч буй бол тэр хүмүүн хятад хүн болно.” хэмээсэн сургаалын эсрэг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасанчлан Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх замаар монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлааг байвал зохих хэмжээнд авч явахад БНТУ-тай хамтран ажиллаж, хоёр орны ард түмний соёлын олон талын үйл ажиллагааг түүхэн баримтад тулгуурлан хөгжүүлэх боломж бий. Тухайлбал, Орхоны хөндийн Түрэгийн үеийн хөшөө дурсгалуудад археологийн малтлагаа судалгаа хийх, сэргээн засварлах, олдворуудыг хамгаалалтад авах, музейн үзмэр болгох зэрэг чухал ажлыг хамтран гүйцэтгэх, Монгол Улсын соёлын элчийн үүрэг гүйцэтгэгч ажиллуулах замаар Туркийн соёлын харилцаа, хамтын ажиллагаа, хоёр орны иргэд хоорондын харилцааг хөгжүүлэх нь манай улсын соёл иргэншлийн, улмаар оршин тогтнохуй аюулгүй байдлын хэтийн төлөвийн дархлаа цаашид гадны хэл соёл (ялангуяа хятад)-ын түрэлтэд автагдахаас урьдчилан сэргийлэхэд тодорхой хувь нэмэр оруулна. Түүнчлэн энэ сценарын үед манай улс “гуравдагч хөрш” болон НҮБ-ын дэмжлэгтэйгээр төвч байр суурь баримталж болох тал байна.

3. АНУ ба Орос хоёрын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн “холбоотны харилцаа” тогтох

Энэ хувилбарын үед манай хоёр том хөршийн хооронд хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх магадлал өндөр байна. Монгол Улсын аюулгүй байдлын хувьд өөрийн үндэстний цөөнхийн талаар оновчтой бодлого явуулах, гаднаас дүрвэгсэд орж ирж болзошгүй нөхцөлд бэлэн байх, терроризмын аюул заналаас сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлага гарна. Хоёр хөрш гүрэнтэй харилцах бодлого хэвийн үргэлжлэх боловч “гуравдагч хөрш” БНТУ-тай НҮБ-ын байр суурь, түүнд Турк улсын хандлагыг харгалзан хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал байх болно..

4. Оросын засагт оросын үндэсний эрх ашиг сонирхол ба орос соёл иргэншлийн үнэт зүйлсийн системтэй зөрчилдсөн (XX зууны 90-ээд оны эхний хагаст ийм явдал Орост үндсэндээ тохиолдсон) АНУ-ын аливаа нөхцөлүүдийн хараат хамтын ажиллагаанд бэлнээр нээлттэй хандсан эрх барих бүлгүүд гарах.

Ийм сценар үүсвэл Орос, АНУ хоёр хамтарч Хятадад дарамт, шахалт үзүүлэх ба Орос, Хятадын хоорондын харилцаа эрс хүйтэрнэ. Стратегийн чухал байршилтай манай улсад аль аль талаас нь дарамт, шахалт ирнэ. Орос улсад Америкийн талыг баримтлагчдыг эсэргүүцсэн хүмүүс болон эрх баригч талын хоорондох дотоодын зөрчил хурцдаж болно. Мэдээжээр Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорын асуудал зогсонги байдалд орно. Оросын дотоодын үймээнээс дайжсан дүрвэгсдийн асуудал гарна. БНТУ нь Хятад улстай стратегийн түншлэлийн харилцаатай, олон улсын тавцанд НҮБ, G20, СІСА, ШХАБ, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк зэрэг олон талт хамтын ажиллагааны байгууллагуудын хамтран ажиллаж байна. Түүнчлэн БНТУ АНУ-ын шахалтад төдийлөн орохгүй байх магадлалтай. Ийм тохиолдолд БНТУ-ын баримтлах байр суурь ямар байх нь тодорхойгүй, НҮБ-ын байр суурь, Туркийн удирдлагад ямар хүчин гарснаас ихээхэн хамаарах магадлалтай. Манай улс төвийг сахисан байр суурь баримталж, БНТУ-тай харилцаагаа хэвийн үргэлжлүүлэх санаачилга гаргаж ажиллах нь зүйтэй байж болох юм.

5. Дэлхийн хүчний харилцаа бусад улс орнуудтай реалист, шударга харилцаа руу болон өөр (тэгш г.м) зарчмуудын үндсэн дээр олон улсын харилцааг бодитоор босгох бэлэн байдал руу өөрчлөгдөх нөлөөлөл дор АНУ-ын засгийн эрх баригчид аажим хувьсах.

Ийм сценарын үед хоёр хөршийн харилцаа стратегийн иж бүрэн түншлэлийн хүрээнд өрнөж, Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт ихээхэн таатай нөхцөл байх болно. Улс орнуудтай тухайлбал, “гуравдагч хөрш” БНТУ-тай стратегийн түншлэлийн өргөн хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэх, тогтвортой хөгжих хэтийн таатай нөхцөл бүрдэнэ. Гагцхүү манай улс “Гуравдагч хөрш”-үүдээс гуйлга гуйх сэтгэлгээ Монгол талаас давамгайлж, харин ардчилсан, өндөр хөгжилтэй орнуудад энэ нь таалагддаггүй, тэд харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхолтой байдаг. Энэ нь "гуравдагч хөрш"-ийн бодлогод учирч байгаа гол зөрчлийн нэг юм. Гуйлгачин сэтгэлгээнээсээ татгалзаж, харилцан ашигтай хамтын ажиллагаанд бүрэн шилжиж байж "гуравдагч хөрш"-ийн бодлого тодорхой үр дүн өгөх болно.” гэсэн судлаачдын зөвлөмжийг анхаарах хэрэгтэй юм.

Хоёрт. АНУ, ОХУ-ын харилцааны сөрөг сценар:

1. Дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл эрчимжих.

Оросын зүгээс Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөтгөх магадлалтай. Ийм хувилбар ОХУ ба АНУ-ын хоорондын зэвсэгт мөргөлдөөн үүсэх тулгаралт бага магадлалтай ч өнөөгийн Украйны эсрэг Оросын цэргийн тусгай ажиллагаа, Барууныхны Украйнд үзүүлж буй дайныг өдөөсөн зэвсгийн тусламж байдлыг бүр хурцатгаж, АНУ болон Хятадын хооронд Өмнөд Хятадын тэнгист зэвсэгт мөргөлдөөн гарна гэсэн зарим судлаачдын таамаглал байгаа бөгөөд АНУ-ын Тайваньд явуулж буй бодлого, Хятадын Тайваны эсрэг шаардлагатай бол зэвсэгт хүчнээ хэрэглэхээ илэрхийлсэн байдал зэрэг нь Орос, Хятад хоёрыг улам нэгдэн нягтрахад хүргэж байна. Ийм тохиолдолд Монгол Улсад АНУ-ын зүгээс Оросын эсрэг хориг, хязгаарлалтын ажиллагаанд нэгдэх талаар шахалт үзүүлэх, манайд үзүүлж буй дэмжлэгээ зогсоох дарамт ирэх магадлал өндөр байх ба БНТУ НАТО-гийн гишүүн орон боловч 2016 оноос Өрнөдийн орнууд, тэр дундаа АНУ-ын байр суурийг үл харгалзан дээрх бүс нутагт ашиг сонирхол, нөлөөгөө хуваах эрмэлзлээр Оростой харилцаагаа сайжруулах алхмуудыг хийсээр ирсэн. Ялангуяа батлан хамгаалах болон эрчим хүчний салбарт харилцаагаар түлхүү хөгжүүлэх болсон нь Америк болон барууны улсуудын шахалт, дарамтыг харгалзахгүйгээр Монгол Улстай тогтоосон стратегийн харилцаагаа бэхжүүлж болох талтай.

Хоёр. АНУ, БНХАУ-ын харилцааны болзошгүй сценар, үүсэж болох хувилбаруудын үед Монгол болон Түркийн харилцаанд тулгарч болзошгүй хэтийн төлөв

Нэгд. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хэтийн төлөвийн Шинэтгэл-зарим талаар хорисон, зарим талаар өрсөлдсөн-санал нийлэлтийн сценар 1 болон Хөдөлгөөнгүй, зогсонги байдлын сценар 2:

1. Эдгээр сценарын үед Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт: нэгд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулж, хоёр хөршийг төдийгүй Ази, Европыг холбох гүүр болох боломжтой байх.нөхцөлүүд бий

болох боломж, хоёрт, Хятад улсын зүгээс өр зээлийн дарамтад орж болзошгүй байх эрсдэл гэсэн хоёр зам хүлээж байна.

Монгол Улсын боломжийн хувьд БНХАУ-ын Тяньжинь, ОХУ-ын Владивостокийн боомтоор дамжин далайд гарцтай болох буюу түүхий эдийг гуравдагч зах зээлд гаргах нөхцөл бүрдэх бөгөөд “гуравдагч хөрш” БНТУ–тай “Нэг бүс ба нэг зам” төслийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж байна. Тухайлбал, БНТУ шинэ торгоны зам төслийн хүрээнд Хятад, Ойрх Дорнодын улс орнуудын ард иргэдийн амьдралын түвшин сайжирна гэж үзэхийн зэрэгцээ 1990 оноос л Ази, Европын холбооны торгоны замыг амьдралд шинээр нэвтрүүлэхийг дэмжиж ирсэн байна. Энэ нь ийм боломж байгааг харуулж байна. Гагцхүү идэвх санаачилга л чухал байх болно.

Хоёрт. АНУ ба Хятадын хоорондын харилцааны хурцадмал байдал ба сөргөлдөөн хүчтэй болох сценар:

1. 3.2 дугаар зүйлд авч үзсэн АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын хамгийн муу хувилбар Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх асуудлаас болж АНУ ба Хятадын хооронд хурцадмал байдал эрс нэмэгдэж, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн тохиолдолд:

- Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа үргэлжилж, НҮБ зэвсэгт мөргөлдөөнд Хятадыг буруутгасан байр суурь илэрхийлж, асуудлыг Хятадын талаас буулт хийж яриа хэлэлцээрээр шийдвэрлэхийг уриалж, Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжвэл өмнөд хөршийнхөө зүгээс ноцтой дарамт шахалтад өртөх ба эс дэмжвэл БНХАУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх боломж үлдэнэ. Монгол Улсын БНТУ-тай хамтран ажиллах асуудал Турк АНУ болон НАТО-гийн байр суурийг дэмжих тохиолдолд хүндрэх, дэмжихгүй тохиолдолд хэвийн үргэлжлэх магадлалтай.

Харин НҮБ хоёр талыг хурцадмал байдал, зэвсэгт мөргөлдөөнөө яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг чиглэл болгосон тохиолдолд Монгол Улс НҮБ-ын шийдвэрийг дэмжинэ. Энэ тохиолдолд БНТУ-тай тогтоосон стратегийн түншлэл, түүний хүрээнд төлөвлөсөн төсөл, хөтөлбөр хэвийн хэрэгжих боломжтой байх болно.

- Орос АНУ-тай түр холбоотны харилцаа тогтоох тохиолдолд Орос, Хятадын хоорондын харилцаа хурцдах ба Монгол Улс НҮБ-ын байр суурь ямар байхаас хамаарахгүйгээр тэдгээртэй байгуулсан стратегийн баримт бичгийнхээ заалтын дагуу зэвсэгт мөргөлдөөнийг зөвтгөхгүй, аль нэгийг нь дэмжихгүй төвийг сахисан байр суурь илэрхийлнэ. Энэ тохиолдолд БНТУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүд хэвийн үргэлжлэх магадлалтай байх болно.

2. АНУ, Хятадын болзошгүй сөргөлдөөнт сценар 3-ын АНУ, Хятад хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэхгүйгээр худалдааны дайн улам гүнзгийрч, удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Монгол Улс аюулгүй байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, бүрэн эрхт байдлын хувьд том сорилттой нүүр тулгарна.

Худалдааны дайн дэлхийн эдийн засгийг ч бүхэлд нь туйлдуулж, гуравдагч орнууд ч хохирох учир манай улс болон БНТУ-ын эдийн засгийн хөгжилд эрсдэл бий болно. Ийм нөхцөл үүсэхэд стратегийн түншлэлийн гэрээний дагуу ОХУ болон БНТУ-тай тогтоосон нягт хамтын ажиллагаа худалдааны дайнаас ирэх геополитикийн дарамт, шахалтыг даван туулах гол стратеги байж болох талтай. БНТУ-ын зүгээс зарим дэмжлэг, тусламж багасах магадлалтай.

Гурав. ОХУ ба БНХАУ-ын харилцааны хэтийн төлөв

Нэгд. ОХУ ба Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны сценар.

1. Монгол Улсад Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хоёр хөршийн болон “гуравдагч хөрш” БНТУ-ын талаар ухаалаг бодлого баримталбал аюулгүй байдлын хэтийн төлөв ихээхэн эерэг төсөөлөлтэй байна.

Хятадын “Нэг бүс ба нэг зам” стратегийн хүрээнд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорыг төлөвлөлтийн дагуу хөгжүүлэх боломж байна. Энэ хүрээнд БНТУ ч манай улстай өнөөгийн харилцаагаа улам бэхжүүлэхэд чиглэсэн бодлого явуулах боломжтой. Ийм харилцааны холбогч сонирхол нь “Нэг бүс, нэг зам” төслийн хүрээнд Туркийн санаачилгаар хэрэгжиж буй Ази, Европыг холбох Дунд коридор нь 2017 онд ашиглалтад орсон Баку-Тбилиси-Карс /БТК/ гэсэн гол чиглэлийн төмөр замд суурилсан бөгөөд 2034 он гэхэд жилдээ тээвэрлэх зоригч 3 сая, ачаа 17 сая тонн болж, өнөөгийн үзүүлэлтээс зоригч тээвэр 2 сая хүнээр, ачаа 10.5 сая тонноор нэмэгдэх хүлээлт байгаа зэрэг хөгжлийн ерөнхий хандлага байна. Чингэхдээ үндэсний аюулгүй байдлаа хангаж тогтвортой хөгжих үүднээс гадны судлаач “Монголчууд бараг бүх түүхий эд материал нь Хятад руу явдгийг, улс төр эдийн засагт нь Хятадын нөлөө улам ихсэж байгааг мэддэг хэдий ч энэ талаар ямар дорвитой арга хэмжээ аваагүй ажээ. Хятадын компаниуд Монголын нөлөө бүхий албан тушаалтнуудыг авлигадаж, хайгуулын лицензээ нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн жижиг компаниудыг өч төчнөөнөөр нь худалдан авчээ...” гэж анхааруулсныг санаж эдийн засгаа солонгоруулах ажлыг БНТУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд санаачлан хэрэгжүүлэх нь зүйтэй байх болно..

Хоёрт. ОХУ ба Хятад хоорондын зөрчилдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болзошгүй сценар:

1. Хоёр хөршийн аль аль талаас нь өөрийн талд орохыг шаардсан хүнд дарамт, шахалт ирэх.

Монгол Улс сөргөлдөгч хоёр талын аль нэгнийх нь талд татагдан орох аюул занал тулгарна. Ийм сценарын үед хоёр зам байна. *Нэгд*, төвийг сахих. Гэхдээ ийм оролдлого хийх нь хөрш хоёр гүрний зүгээс дэмжлэг авахгүй байх болно. *Хоёрт*, хоёр хөршийн хэн нэгний нь холбоотон болох. Энэ тохиолдолд Дорнынхон ОХУ-ыг аюул заналхийлэл гэж нэг их үздэггүй логикоос харвал Монгол нь ОХУ-тай цэргийн холбоотны харилцааг сэргээх магадлал байж болох талтай. Доктор Р.Болд ийм төлөв байж болох талаар тэмдэглэсэн байна.

Монгол Улсын ОХУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн баримт бичигт "Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх ашигт харшилсан ямарваа нэгэн гэрээг гуравдагч улстай байгуулахгүй болон нөгөө талын эсрэг чиглэсэн аливаа үйлдэлд оролцох, эсхүл ийм төрлийн үйлдлийг дэмжихээс түдгэлзэнэ. Аль ч тал өөрийн нутаг дэвсгэрээ нөгөө талын эсрэг түрэмгийлэл буюу аливаа хүчирхийлэл үйлдэх зорилгоор гуравдагч улсад ашиглуулахгүй, гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг Оросын холбооны улс хүндэтгэнэ." хэмээн зааж өгсөн бол БНХАУ-тай "Талууд нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулах аливаа үйл ажиллагаа

явуулахгүй, аливаа гэрээ байгуулахгүй, аливаа эвсэл, бүлэглэлд нэгдэхгүй, тэдгээрийн нөгөө улсын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанд оролцохгүй, нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулах үйл ажиллагаа өөрийн улсын нутаг дэвсгэрт явуулахыг аль нэг гуравдагч улс, байгууллага, бүлэглэлд зөвшөөрөхгүй байхыг онцлон тэмдэглэсэн байна.

Энэ бүгдээс дүгнэлт хийхэд энэхүү сценарын үед манай улс төвийг сахих бодлого барьж “гуравдагч хөрш”-үүдээс, түүнчлэн БНТУ-аас болон НҮБ-аас улс төрийн дэмжлэг хүсэх болно. Ийм оролдлого бүтэлгүй болсон тохиолдолд Р.Болдын дэвшүүлсэн таамаглал хэрэгжих магадлал өндөртэй байх болно.

Дүгнэлт

Хоёр улсын түүхэн харилцаа, идэвхжин хөгжиж байгаа өнөөгийн хамтын ажиллагаанд үндэслэн Монгол Улс 2011 онд Гадаад бодлогын үзэл баримтлалд Турк улсыг “гуравдагч хөрш” хэмээн тодорхойлсон байдаг. Монгол Улс 2004 оноос Бүгд Найрамдах Турк улстай Иж бүрэн түншлэлийн харилцаа хөгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид харилцаагаа улам ахиулж, стратегийн түншлэлд хүргэх хэтийн зорилго тавьж байна. Хоёр орны харилцаа нь улс төр, ялангуяа соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарт эрчимтэй хөгжиж байгаа ч эдийн засаг, худалдааны салбарт хамтын ажиллагаа хангалтгүй байна. Тухайлбал, худалдааны бүтээгдэхүүний нийт эргэлтийн хэмжээ, 2019 онд 43,1 сая ам.долларт хүрсэн ч Туркийн экспортын хэмжээ 40,6 сая ам.доллар буюу 94 орчим хувийг эзэлж байна.

НҮБ болон НАТО, ШХАБ, ЕАБХАБ-ын хүрээнд манай хоёр улс зохих хэмжээгээр хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн байна.

БНТУ-ын Ерөнхийлөгч Р.Т.Эрдоганы 2013 онд ерөнхий сайд байхдаа Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хоёр улсын ерөнхий сайд нарын хамтарсан мэдэгдэлд “Хоёр тал Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 онд БНТУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хамтарсан мэдэгдэлд дэвшүүлсэн “иж бүрэн түншлэлийн харилцаа” нь тодорхой зорилго, зарчмын хүрээнд амжилттай хэрэгжиж сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд цаашид харилцааны түвшинг ахиулж “стратегийн түншлэл”-д хүргэх хэтийн зорилготой байгааг талууд санал нэгтэй тэмдэглэсэн” нь манай улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг улам бататгаж өгсөн гэж болно.

Цаашид:

- Түүхэн үеийн харилцаан дахь үе үеийн хоёр үндэстний эвлэрэл, зөрчил болон улс орнуудын харилцааны нөлөөгөөр улс үндэстний соёл хэрхэн бүрэлдэн өөрчлөгдсөн зэрэгт үндэслэн түүхэн харилцааг хэрхэн зааглах зэрэгт анхааран, тухайн улсын манай улсад хэрэгжүүлж буй бодлогын стратеги ямагт дүн шинжилгээ хийж байх;
- Турк улстай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, НАТО, ШХАБ, ЕАБХАБ-ын хүрээнд улсынхаа үндэстний аюулгүй байдлыг бэхжүүлэх, гадаад таатай орчин бүрдүүлэх чиглэлд идэвхтэй хамтран ажиллах;
- Ойрын үед хоёр улсын тэргүүн нарын айлчлалыг зохион байгуулж, хоёр улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн зорилгыг дэвшүүлэх;
- “Туркиш Эйрлайнс” компанийн нислэгийн тоо болон зорчигчийн тоог нэмэгдүүлэх, хоёр улсын хоорондын том оврын ачаа тээвэрлэлтийн онгоц нисгэх, Истанбул-Улаанбаатар-Сөүл чиглэлд агаарын ачаа тээврийн зам нээх;
- Мөн “Бүс ба зам” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Туркийн санаачилсан Хятад-

Төв Ази-Европ холбосон төмөр замын төслийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж оролцох тал дээр анхаарч ажиллах;

Орхоны хөндий дэх аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Турк, Монголын оролцоог тэнцвэржүүлэх;

Өнөөгийн Туркийн газар нутагт байгаа Ил Хаант улсын үеийн соёлын өвийг олж илрүүлэх, сурталчлах;

Монголыг Турк нь Төв Азийн улсуудад хамруулан авч үздэг бөгөөд зөөлөн хүчний бодлого тэр дундаа шашны бодлогоо казах ард түмний дунд түлхүү явуулах боломжтойг харгалзан улсынхаа аюулгүй байдалд анхаарах;

Хоёр талын эдийн засгийн харилцаа дутмаг байгаад анхааран өргөмжлүүлэх;

Тухайн улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар худалдааг хөнгөвчлөх, худалдааны тарифын болон тарифын бус тогторыг бууруулах;

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн тогтвортой, тааламжтай орчин бүрдүүлэх, олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын болон бусад бүх салбарт тухайн улсын хөрөнгө оруулалтыг татах;

Тухайн улсын боломж бололцоог ашиглан олон улс, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграци болон дэд бүтцийн сүлжээнд хамрагдахыг хичээх;

Тухайн улсын зах зээлд экспортлох боломжтой, тэргүүлэх ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжих “Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Экспо үзэсгэлэн яармаг арга хэмжээг тогтмол зохион байгуулах зэрэгт ач холбогдол өгч ажиллах нь чухал байна.

НОМЗҮЙ

1. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 1994, 2011
2. МУ-ын ГХЯ. Монгол Улсын гадаад бодлогын хөх ном (B1 Bluebook). УБ.. 2019.
3. ТИКА ile 20 yil /ТИКА-тай 20 жил/ УБ 2014 он.
4. “Монгол Улс, БНТУ-ын хоорондын Хамтын ажиллагааны тухай Хамтарсан Мэдэгдэл”. 2004.04.29 Анкара хот. БИТУ
5. Ерөнхий сайд нарын Хамтарсан Мэдэгдэл. УБ., 2013.04.12 https://www.mongolianembassy.com.tr/pg_16_bilateral-relations
6. “Хагас зууны түүх ба хөгжлийн чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (МУ, БНТУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийг ойд зориулсан), УБ., 2019.
7. Yohanan Benhanm and Kerem Uktern, The rise and fall of Turkey’s soft power discourse: Discourse in foreign policy under Davutoglu and Erdogan, European Journal of Turkish Studies, Social Sciences on Contemporary Turkey, 21 | 2015 Beyond Soft Power
8. Congressional Research Sendee, <https://fas.org/sgp/crs/mideast/R44000.pdf>
9. Монгол Улсын Гадаад харилцааны яам. www.mfa.gov.tr
10. Цэрэннадмид Ч. Монгол Улсын “гуравдагч херш”-ийн бодлого: Туршлага ба асуудал-Монгол, Туркийн харилцаа. УБ., 2020
11. Ulambayar D. “Mongolian-Turkish Relations: From De facto till De jure ”-“Mogolistan ve Turkiye Ilişkileri: De Facto’dan De Jiire’ye. Dogu Asya Araştırmaları DergisiC-Journal of East Asian Studies in Turkiye. DAAD GUZ/FALL 2020. pp. 131-147. impact factor journal, (in Turkish, English and Chinese)

АРГА ЗҮЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг. Үндэсний аюулгүй байдлыг хангах “Гуравдагч хөрш”-ийн бодлогын удирдлага зохицуулалтыг сайжруулах чиглэлд:

1. *“Гуравдагч хөрш”-ийн бодлого, түүний хэрэгжилтийн асуудал үндэсний аюулгүй байдлыг хангах системийн дотоод аюулгүй байдлыг хангах дэд системийн бодлого, шийдвэрийн хүрээнд гадаад аюулгүй байдлын өөрчлөлтийн динамиктай уялдан зохицуулагдаж байх удирдлага зохицуулалтын асуудал гэдгийг Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл анхааралдаа авах. Үүний тулд:*

- “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг улс орон даяар уялдуулан зохицуулах чиг үүргийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хариуцна.”, “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны тодорхой стратеги, тактикийг уялдуулан зохицуулж, холбогдох дүрэм журмыг баталж хэрэгжүүлнэ.” гэсэн үзэл баримтлалын зохицуулалтын хүрээнд “гуравдагч хөрш”-ийн асуудлыг авч үзэх шаардлагатай. Чингэхдээ юуны өмнө Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 5.1-д “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд дараах арга зүйг удирдлага болгох. Үүнд:

- Шатлан захирагдах зарчмын дагуу аливаа салбарын бодлого үндэсний аюулгүй байдлыг хангах системийн эрх ашигтай нийцэж байх нь дараах харилцан уялдаа бүхий дөрвөн тулгуур баримт бичгийн агуулга дээр үндэслэн боловсруулагдсанаар илэрдэг зүй тогтлыг ажил хэрэг болгох: *нэгд*, Үндсэн хуулийн заалтад нийцэж байх; *хоёрт*, Үндсэн хуулийн заалтуудын утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох заалтуудтай нийцэж байх; *гуравт*, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтуудын утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын холбогдох заалтуудтай нийцэж байх; *дөрөвт*, эдгээр гурван баримт бичгийн утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан “Батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн холбогдох заалтуудтай нийцэж байх явдал юм.

- Үндэсний аюулгүй байдлын системийн шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын суурь баазыг бүрдүүлэх. Чингэхдээ үндэсний аюулгүй байдлыг хангах системийн нэгдмэл чанарыг олон шинжлэх ухааны хоорондын нийтлэг зүй тогтол дээр тулгуурлан илрүүлэхэд шинжлэх ухааны ололт амжилт, эрдэмтэд мэргэдийн мэдлэг авьяас, оюуны чадавхыг чиглүүлэх шаардлагатай байна.

- “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт, дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл боловсруулна.”, “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавьж, үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгнө.” гэсэн үзэл баримтлалын зохицуулалтын хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлэх. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа “гуравдагч хөрш”-ийн бодлого, түүний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гаргах.

- “Гуравдагч хөрш”-ийн бодлого, түүний хэрэгжилтийн эрсдэлийн үнэлгээг нэгд, аюул, хоёрт, өртөх байдал, гуравт, эмзэг байдал, дөрөвт, чадавх, тавд, хүрээлэн буй орчин гэсэн таван хэмжээсний хүрээнд хийлгэж, холбогдох шийд чиглэл өгч байх.
- Аюулгүй байдлын орчны цогц үнэлгээг ажлын хэсэг байгуулах замаар, эсвэл төслийн ажлын хүрээнд гүйцэтгэх бус тодорхой үечлэлтэйгээр тогтмол хийж, тодотгох үүрэг бүхий аюулгүй байдлын судалгааны нэгжтэй болох. Ийм үнэлгээнд үндэслэн “гуравдагч хөрш”-ийн бодлогын талаар баримтлах стратегиа тодотгож байх нь зүйтэй байна.

2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд, түүний дотор “гуравдагч хөрш”-ийн бодлого, түүний хэрэгжилтэд тулгарах аюул занал (эрсдэл)-ын эх үүсвэр засаглалын сул, дорой байдал, авлигын сүлжээ газар авсантай холбоотой байгааг анхааралдаа авч дараах хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн удирдлага зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх:

- **Хууль тогтоох байгууллага:** Авлигад “ээлтэй” бодлого, хууль эрх зүйн орчин “бүрдүүлэх”, халдашгүй байдал гэх мэт “хамгаалалтын” нөхцөл бий болгох зэргээр үйлчилдгийг зогсоох;
- **Гүйцэтгэх байгууллага:** Хуулийн хэрэгжилтийг гажуудуулан завхруулах, хууль бус давуу байдал олгох зэргээр үйлчилдгийг эцэс болгох;
- **Шүүх байгууллага:** Хуулийн өмнө тэгш байх зарчим, шударга ёсыг алдагдуулж, “дуулгаваргүй”-г номхотгох, “халдашгүй”-г хамгаалах зэргээр үйлчилдгийг болиулах;
- **Улс төрийн нам:** Сонгуулийн дэмжлэгийн хариу барих, бодлого боловсруулах, томилгоо зэрэгт “эргэдэг хаалга”-ны зарчмаар үйлчилдгийг зогсоох;
- **Бизнесийн бүлэглэл:** Улс төртэй хутгалдах замаар олигарх бүлэглэл үүсгэх, улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хохироосон бизнес төслийг хэрэгжүүлж, том хөрөнгө оруулалтыг хяналтдаа авах, байлгах зэргээр үйлчилдгийг болиулах;
- **Хэвлэл мэдээлэл:** Олон нийтийн “тархи угаалт”-ыг явуулж, “Хаалтын гэрээ” байгуулах зэргээр авлигачдыг хаацайлах үйлчилгээ үзүүлдгийг таслан зогсоох зэрэг болно.

Манай оронд авлига нь улс төр, эдийн засаг, хууль зүй, оюун санааны зэрэг нийгмийн бүхий л салбарт нэвчин тархаж, тогтолцооны шинжтэй болж, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгааны дархлааг сулруулах аюул заналыг бий болгоод байгаа бөгөөд цаашид 30 гаруй жилийн түүхэн замналаараа үргэлжилбэл улс төрийн тогтворгүй байдал удаан хугацаагаар үргэлжлэх, хүн амын зүгээс төр засаг, хууль сахиулах байгууллагад итгэх итгэл алдрах, үүнээс үүдэн гадны зөөлөн хүчний бодлого хэрэгжих суурь нөхцөл улам таатай болж, төр суларч, нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, ард түмний чөлөөт сонголтоор байгуулагдсан төр, засгийг Үндсэн хуулийн бус аргаар огцуулахыг хүсэмжлэх үзэгдэл газар авах, үүнийг дэмжих, дэвэргэх улс төрийн болон цэргийн хүч гарч ирэх хэтийн төлөв оршоор байх болно.

Хоёр. “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг үндэсний аюулгүй байдлын эрх ашигтай нийцүүлэх чиглэлд

1. Аюулгүй байдлын ерөнхий онолд тулгуурлан “Үндэсний аюулгүй байдал” ойлголтыг танин мэдэхүйн хувьд хоёр хүчин зүйлсийн агуулгаар тодорхойлох:

- Гадаад, дотоод аюул заналаас Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг сонирхол хамгаалагдсан байх.

- Монгол Улсын тогтвортой хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн байх.

“Үндэсний аюулгүй байдал” ойлголтыг ийм хоёр хүчин зүйлсийн агуулгаар тодорхойлох нь “Туравдагч хөрш”-ийн бодлогын агуулгыг учирч болох эрсдэл, түүнийг бууруулах арга замтай уялдуулан тодорхойлсон боломж бүрдүүлнэ..

2. Үндэсний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсгийг боловсруулахад дараах арга зүйг харгалзан үзэх.

- Үндэсний аюулгүй байдал нь гадаад аюулгүй байдал ба дотоод аюулгүй байдал гэсэн хоёр талтай бөгөөд тэдгээрийн харилцан хамаарлын цогц систем болох зүй тогтлыг үндэс болгох. Энэ зүй тогтол нь өнөөгийн үзэл баримтлалд байгаа “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” гэсэн бүлгийг “Үндэсний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” болгон өөрчлөх шаардлагыг нөхцөлдүүлнэ.

- Үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсэгт дотоод аюулгүй байдлыг зургаан бүрэлдэхүүн хэсгийн нэг болгосон нь үндэсний аюулгүй байдлыг хангах бүх бүрэлдэхүүн хэсэгт дотоод аюул занал (хүчин зүйлс, эрсдэл)-ын оролцоо байх бөгөөд түүнтэй тэмцэх явдал цогц үйл явц болох зүй тогтлыг алдагдуулж байгааг арилгах. Энэ үүднээс үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг үйл ажиллагааны систем гэдгээр томъёолох. Энэ тохиолдолд “туравдагч хөрш”-ийн бодлого үндэсний аюулгүй байдлыг хангах системийн хүрээнд шийдэгдэх боломж бүрдэнэ.

3. Үндэсний аюулгүй байдлын асуудлаар зарим хуульд зарчмын чанартай өөрчлөлт оруулах. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн гаргах. Энэ нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хууль хоорондын ойлголт, агуулгын зөрүүтэй байдлыг арилгаж, “туравдагч хөрш”-ийн бодлогод “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилах” зарчмыг баримтлах боломж бүрдүүлнэ.

- Хилийн тухай хуульд хилийн аюулгүй байдлын томъёоллыг хил орчмын сумдад гадаад, дотоод аюул заналаас Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол хамгаалагдсан байх болон сумдын тогтвортой хөгжих нөхцөл бүрдсэн байх агуулгаар оруулах.

- Монгол Улсын Үндсэн хууль, Сонгуулийн багц хууль, Улс төрийн намын тухай хуулиудад улс төрийн авлигын хамгийн түгээмэл хэлбэр болох нэр дэвшихийн тулд намд хандив өгөх; сонгогчдын саналыг худалдан авах; сонгуульд нэр дэвшигчид шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх зэргийг хаах чиглэлээр өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүний тулд: нам, төрийн бус байгууллага, иргэд аливаа сонгуульд мөнгөтэйг нь биш шударга иргэнийг нэр дэвшүүлэх бөгөөд сонгуульдаа бүх нэр дэвшигч адил хэмжээний зардал гаргаж тэнцвэртэй байдлыг ханган хэвлэл мэдээлэл сурталчилгааг яг адил нөхцөлд зохион байгуулж, хамтдаа сонгогчдын өмнө мэтгэлцэх нөхцөлийг бүрдүүлэх; өндөр түвшний авлигыг өдөөгч эрх зүйн орчинд нухацтай дүн шинжилгээ хийж, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод, хөндлөнгийн хяналттай болгох. хэвлэл мэдээллийн хэрэгслүүд худалдагдахгүй байх чиглэлээр өөрчлөлт оруулах; нэг нам гарахад бүх хууль, шүүх нь солигддог томилгооны авлигыг зогсоох; төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын талаарх хуулийн зохицуулалтыг өөрчлөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх замаар Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд зэрэг төрийн өндөр албан тушаалтан бусад төрийн албан тушаалтай нэгэн адил хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг хэрэгжүүлэх; хоёр шатны парламенттай байх нь улс төрд хууль, шударга ёсыг

хангах баталгаа болох магадлалтайг тооцох; хууль тогтоох дээд байгууллага нь бусдын нөлөөнд орохгүй дан хууль тогтоох ажлаа эрхэлж авлига, тендер зэрэг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг хуульчлах хэрэгтэй юм.

Гурав. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, арга зүйн суурь ойлголтын нэгдсэн хандлагыг бий болгох чиглэлд:

1. Доктор Д.Уламбаярын энэхүү судалгааны ажилд дэвшүүлж, төслийн бусад гишүүдийн саналаа нэгтгэсэн ойлголтын хүрээнд:

- «Гуравдагч хөрш»-ийн бодлого нь их гүрнүүдийн геополитикийн орчинд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгаа дээдлэн зөөлөн хүчээр тэнцвэрийн хүчийг барих буюу зөөлөн тэнцвэржүүлэхүйн цогц бодлого.

- Гуравдагч хөрш”-ийн бодлого нь газарзүйн хязгаарлагдмал байдлаа даван туулж, нэмэлт шинэ боломжийг нээж, хөгжингүй, ардчилсан улс гүрнүүдтэй нээлттэй түншлэлийн харилцааг хөгжүүлснээр үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгийн аргаар баталгаажуулах бодлого.

- Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь эвсэл, холбоотны бодлого биш, хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого ч биш, мөн зөвхөн энхтайван цагийн геополитик, .

- «Гуравдагч хөрш»-ийн бодлогын онолын үндэс нь монголчуудын эртнээс инагш ахуй амьдрал, үйл ажиллагаандаа тууштай баримталсаар ирсэн “тулгын гурван чулуу” хэмээх үзэл баримтлал бөгөөд орчин үеийн гурван тулгуурт хөгжлийн онолын баримтлал.

2. Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн ”гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлэх арга зүйн хувьд:

- “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг гадаад бодлогын Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашгийг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр –дипломатын аргаар хангах чухал хэрэглүүр, өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах системийн системийн орчинтойгоо зохицох нэг механизм болгон авч үзэх. Энэ тохиолдолд үзэл баримтлалын “Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг тууштай хэрэгжүүлэх” зорилт “гуравдагч хөрш”-ийн бодлогын хувьд улс орны тогтвортой хөгжлийг хангах эрх ашигтай нийцэн хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

- “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг үр өгөөж, үр дүнгийн үнэлгээг дотоод аюулгүй байдлыг хангах дэд системийн хүрээнд оршин буй эдийн засгийн уналт доройтол; дэд бүтцийн хөгжилгүй байдал; гадаад өр, төлбөр, санхүүгийн доройтол; үндэсний эв нэгдэлгүй байдал, улс төрийн дотоод тэмцэл; гадаад түншдээ олзлогддог сул тал, авлига хээл хахууль амь бөхтэй оршиж буй байдал; санхүүгийн сахилга батгүй байдал зэрэг нөхцөл байдлын шалтгааныг тогтоох холбон аюулгүй байдлын цогц үнэлгээний хүрээнд гүйцэтгэх.

- Системийн хандлагын арга зүйтэй нийцсэн чухал шийдлийн үүднээс “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлэх талаар эрдэмтэн судлаачдын зүгээс³²² өөрсдийн бүтээлд онцолсон зөрчилтэй болон эрсдэлтэй асуудлуудыг анхааралдаа авч, арилгах, бууруулах арга хэмжээ авах, чухал саналыг ажил хэрэг болгох, эргэлзээтэй саналд өөрсдийн үндэслэлийг гаргах Үүнд:

³²² С.Баттулга нарын “Монгол Улсын гуравдагч хөрш”. УБ., 2021, 339 х.

- Монголд засгийн газар ойр ойрхон солигдож, тохиролцсон төсөл хөтөлбөр цуцлагдах, авлигын байдал хэт эрсдэлтэй байгаа нь "гуравдагч хөрш"-үүдийн бизнесийн төлөөлөл Монголд ирж ажиллах хүсэл эрмэлзлэлийг хааж байгаа зөрчлийг арилгах.
- Анхдагч хөршүүд үгсэн Монголыг эдийн засгийн хувьд блоклон хаавал "гуравдагч хөрш"-ийн бодлого бодит үр дүн муутай болох эрсдэлийг бууруулахын тулд "гуравдагч хөрш"-тэй явуулж буй хамтын ажиллагааны томоохон төслүүдэд хоёр хөршийг оролцуулах, ШХАБ-д элсэж тэдэнтэй итгэлцлээ нэмэгдүүлэх арга зам байж болохыг анхааралдаа авах.
- Монголын "гуравдагч хөрш"-үүд гэсэн олон талт зөвлөлдөөн, хэлэлцүүлэг, эдийн засгийн хамтын ажиллагааны талбар бий болгох ажлыг Монголын талаас санаачлан хэрэгжүүлэх, "гуравдагч хөрш"-ийн олон талт хамтын ажиллагааны эхлэл болох АНУ, Япон, Монголын гурван талт уулзалтыг идэвхтэй үргэлжлүүлж, цаашид бусад орнуудыг оролцуулж, "гуравдагч хөрш"-үүдийн олон талт хамтын ажиллагааны механизм болгон хэвшүүлж болох юм гэсэн судлаачдын санал хамтын ажиллагааны чухал хөшүүрэг болох талтай.
- “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг албан ёсоор зарласнаас хойшхи 2011- 2020 оны эхний арван жилийг улс төрийн харилцааны суурийг бэхжүүлсэн гэж дүгнээд "гуравдагч хөрш"-үүдийн эдийн засгийн түрлэг”-ийн шинэ арван жил, 2021-2030 оныг "гуравдагч хөрш"-үүдийн хамтын ажиллагаагаар Монголын эдийн засгийн гол үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ-ээр хоёр хөршөөс илүү гарсан байх зорилтыг хэрэгжүүлж энэхүү бодлогыг бодит үр дүнд хүргэхийг санал болгож байна. Ерөнхий сайдын дэргэд шинэ бүтцийг үүсгэн арван жилийн ажлыг хариуцаж бүх салбаруудыг хамарсан зохицуулалт хийх нь зүйтэй байна. “ГУРАВДАГЧ ХӨРШ”-нд "гуравдагч хөрш"-ийн бодлогын асуудлыг хариуцсан нэгжийг бий болгож ажиллуулах хэрэгтэй байна” гэсэн саналын хувьд: *нэгд*, эхний арван жилийн бодлого, түүний хэрэгжилтийг дүгнээд дараагийн арван жилийн бодлогоо тодорхойлох үнэхээр чухал ач холбогдолтой алхам байх болно, *хоёрт*, 2021-2030 оныг "гуравдагч хөрш"-үүдийн хамтын ажиллагаагаар Монголын эдийн засгийн гол үзүүлэлт болох нэг хүнд ногдох ДНБ-ээр хоёр хөршөөс илүү гарсан байх зорилтыг хэрэгжүүлж энэхүү бодлогыг бодит үр дүнд хүргэх санал нь нэгдүгээрт, зөвхөн зорилгын хандлагад тулгуурласан шинжтэй байгаа учраас судалгааны хандлагатай хослуулж байж стратегийг тодорхой болгох, *гуравт*, “Ерөнхий сайдын дэргэд шинэ бүтцийг үүсгэн арван жилийн ажлыг хариуцаж бүх салбаруудыг хамарсан зохицуулалт хийх нь зүйтэй байна. “ГУРАВДАГЧ ХӨРШ”-нд "гуравдагч хөрш"-ийн бодлогын асуудлыг хариуцсан нэгжийг бий болгож ажиллуулах хэрэгтэй байна” гэсэн санал нь үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлага зохицуулалтын системд харшлах магадлалтай байгааг тооцох хэрэгтэй байх болно.
- "Гуравдагч хөрш"-ийн бодлогыг нарийвчлан боловсруулж хөгжүүлэхдээ улс бүртэй өөрийнх нь онцлогт тохируулан хандах. Тухайлбал, АНУ энэ концепцийн хүрээнд улс төр, стратегийн талыг нь чухалчлан, эдийн засгийн харилцаанд бага анхаарч байгаа бол Энэтхэг соёл, эдийн засгийн чиглэлээр идэвхтэй болох хандлагатай, Япон, Өмнөд Солонгос, Турк улсууд албан баримт бичгүүддээ "гуравдагч хөрш" гэдгийг тодотгохоос зайлсхийж байх жишээтэй.